График 9: Хүүгийн бус зардал (сая ₮)



Болзошгүй эрсдэлийн зардал: 2021 оноос эхлэн үнэт цаас гаргагчийн зээлийн багц нэмэгдсэнтэй холбоотойгоор болзошгүй эрсдэлийн сангийн зардал нэмэгдсэн ба 2022 оны жилийн эцсийн байдлаар 6.1 тэрбум төгрөгийн зардал бүртгэсэн байна. Эрсдэлийн сангийн зардал нь хүүгийн орлогын 17.7 хувь, хүүгийн зардлын 49 хувьтай тус тус тэнцэж байна. Харин 2023 оны 2 дугаар улиралд 3.8 тэрбум төгрөгөөр эрсдэлийн зардал бүртгэжээ. Энэ нь хүүгийн орлогын 19.4 хувьтай тэнцэж байна.

Цэвэр ашиг: Үнэт цаас гаргагч нь 2020 онд алдагдалтай ажилласан бол 2021 оноос үндсэн үйл ажиллагаа тэлж ашигтай ажиллаж эхэлсэн ба 2022 оны тайлангаар 8.5 тэрбум төгрөгийн цэвэр ашиг, 2023 оны 2 дугаар улирлын байдлаар 5.9 тэрбум төгрөгийн цэвэр ашиг тус тус бүртгэжээ. Үйл ажиллагаа 2022 оноос хойш тогтворжиж ашигт ажиллагааны харьцаанууд тогтвортой болсон байна.

График 10: Цэвэр ашиг (сая ₮)





График 11: Ашигт ажиллагааны харьцаа





2023.08.18



Хүснэгт 9. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан

Санхүүгийн байдлын тайлан (сая төгрөгөөр)	2020 аудит	2021 аудит	2022 аудит	2023Q2 аудит
Бэлэн мөнгө	31,095.3	11,933.0	28,531.6	13,716.8
Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	-	95.2	3,000.0	5,000.0
Зээл /цэврээр/	6,393.4	114,662.0	137,694.4	131,130.4
Нийт зээл	6,499.1	116,088.5	145,232.0	142,456.8
Хэвийн зээл	6,252.5	111,041.2	127,267.5	120,740.8
Хугацаа хэтэрсэн зээл	226.3	2,909.7	5,046.6	5,730.3
Чанаргүй зээл	20.4	2,137.6	12,917.8	15,985.7
Хэвийн бус зээл	20.4	-	3,229.5	3,162.8
Эргэлзээтэй зээл	-	-	6,420.9	5,150.5
Муу зээл	-	-	3,267.4	7,672.5
(Зээлийн эрсдэлийн сан)	105.8	1,426.5	7,537.6	11,326.4
Бусад авлагууд	142.8	1,338.6	1,891.8	3,252.4
Бусад хөрөнгө	41.3	627.4	291.7	846.4
Эргэлтийн хөрөнгийн нийт дүн	37,672.7	128,656.1	171,409.5	153,946.1
Үндсэн болон биет бус хөрөнгө	626.3	599.2	762.0	1,242.1
Ашиглах эрхтэй хөрөнгө	-	-	-	692.9
Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	112.2	334.5	1.0	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	205.1	165.1	-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	943.6	1,098.8	763.0	1,935.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	38,616.4	129,754.9	172,172.5	155,881.2
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, өрийн бичиг	-	-	49,947.9	24,988.3
Худалдааны ба бусад өглөг	377.4	1,068.0	10,054.8	6,832.2
Санхүүгийн түрээсийн өр төлбөр	65.5	343.9	-	-
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	-	-	-	6,076.3
Орлогын албан татварын өр төлбөр	7.8	37.3	360.0	231.9
Бусад өр төлбөр	-	-	-	-
Богино хугацаат өр төлбөрийн дүн	450.8	1,449.2	60,362.7	38,128.7
Санхүүгийн түрээсийн өр төлбөр	48.3	-	-	-
Хоёрдогч өглөг	-	74,964.5	50,000.0	50,000.0
Урт хугацаат өр төлбөрийн дүн	48.3	74,964.5	50,000.0	50,000.0
Нийт өр төлбөрийн дүн	499.1	76,413.8	110,362.7	88,128.7
Хувьцаат капиталын дүн	40,000.0	55,000.0	55,000.0	55,000.0
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	(1,882.7)	(1,658.8)	6,809.8	12,752.5
Эзэмшигчдийн өмчийн дүн	38,117.3	53,341.2	61,809.8	67,752.5
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	38,616.4	129,754.9	172,172.5	155,881.2

Активын бүтэц: Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө 2022 оны байдлаар 172.2 тэрбум төгрөг байсан ба 2023 оны 2 дугаар улирлын байдлаар 2020 оны дүнгээс 4.0 дахин өсөж 155.9 тэрбум төгрөгт хүрчээ. Энэ оны гэхний хагас жилийн байдлаар нийт хөрөнгийн 84 хувийг цэврээр зээл, 2 хувийг бусад авлага, 9 хувийг мөнгөн хөрөнгө, 3



2023.08.18



Хувийг богино хугацаат хөрөнгө оруулалт, 1 хувийг үндсэн болон биет бус хөрөнгө, үлдсэн 1 хувийг бусад хөрөнгө бүрдүүлж байна.

График 12: Нийт хөрөнгө (сая ₮)





График 13: Нийт хөрөнгийн бүтэц (сая ₮)



Зээлийн багц: Ашид капитал ББСБ-ийн зээлийн багц 2021 онд эрчимтэй өсөж 2022 оны тайлангаар цэвэр зээлийн багц 137.7 тэрбум төгрөгт хүрчээ. Харин 2023 оны 2 дугаар улирлаар нийт зээлийн багц 142.5 тэрбум төгрөг, цэвэр зээлийн багц 131.1 тэрбум төгрөгт тус тус хүрсэн байна.

График 14: Цэвэр зээл (сая ₮)






График 15: Зээлийн багцын чанар



2022 онд нийт 374 мянган удаагийн зээлээр нийт 443.6 тэрбум төгрөгийн зээл олголт хийж 341 мянган удаагийн эргэн төлөлтөөр 414.5 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөлт хийгджээ. Өөрөөр хэлбэл нийт зээлийн багц 29.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.


2023 оны 2 дугаар улиралд нийт 163.8 мянган удаагийн зээл олголтоор 202.4 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Түүнчлэн нийт олгосон болон төлөгдсөн зээлийн дийлэнх хэсгийг 6 сар-12 сар, мөн 1-2.5 жилийн хугацаатай зээлүүд бүрдүүлж байна.



Handwritten signatures.

2023.08.18

График 16: Зээл олголт, төлөлтийн харьцаа, 2023Q2



2023 оны 2 дугаар улирлын байдлаар олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2.6 хувь байгаа бөгөөд зээлийн дээд хүү 3.4 хувь, доод хүү 0.0 хувь (худалдан авалтын зээл) байна. Зээл олголтод эзлэх хэрэглээний зээл буюу аппликэйшнээр дамжуулан олгосон зээлийн хэмжээ 81.8 хувь.

График 17. Зээлийн багцын төрөлжилтийн мэдээлэл



Хүснэгт 10: Зээлийн багцын чанар

	2020	2021	2022	2023Q2	2023Q1 market
Хэвийн зээл	99.8%	97.2%	87.6%	84.8%	87.6%
Анхаарал хандуулах	0.2%	1.6%	3.5%	4.0%	4.4%
Чанаргүй зээл	0.0%	1.2%	8.9%	11.2%	8.0%

2021 оноос зээлийн багц нэмэгдсэнтэй уялдан чанаргүй зээлийн хувь хэмжээ нэмэгдсэн. Гэвч үнэт цаас гаргалчийн 2023 оны 2 дугаар улирлын байдлаарх чанаргүй зээлийн хэмжээ салбарын дундаж үзүүлэлтээс өндөр болох нь харагдаж байна. Үнэт цаас гаргалч нь СЗХ-ноос тогтоосон журмын дагуу зээлийн эрсдэлийн сан байгуулан

БСБС ХХК
ATA6582-Y 6105572
907707156

MANDAL CAPITAL
MARKETS SC
LLC
37
ШТК0102 9021070414 5213487

Go!

2023.08.18



simple


ажиллаж байгаа ба энэ улирлын байдлаар 11.3 тэрбум төгрөгийн эрсдэлийн сантай байгаа нь нийт зээлийн багцын 7.9 хувьтай тэнцүү байна.

Үнэт цаас гаргагч нь 2022 онд Симпл ХБҮЦ гаргаж хэвийн зээлийн багц тусгаарласан нь тусдаа санхүүгийн тайлангийн чанаргүй зээлийн хэмжээг нэмэгдүүлж байна.

Эх үүсвэрийн бүтэц: 2023 оны 2 дугаар улирлын байдлаар эх үүсвэрийн 56.5 хувь нь өр төлбөр, 43.5 хувь нь өөрийн хөрөнгөөр санхүүжиж байна. Өнгөрсөн жилүүдэд хаалттай бонд, ХБҮЦ, банк санхүүгийн байгууллагаас авсан зээлийн санхүүжилтээр зээлийн багцаа тэлэх бодлого баримталснаар эх үүсвэрийн бүтцэд эзлэх өр төлбөрийн хэмжээ нэмэгджээ.

“Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ийн дагуу толгой компаниас авсан 50.0 тэрбум төгрөгийн хоёрдогч өглөгийг хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөд тооцох ба ингэснээр эх үүсвэрийн **75.5 хувь нь өөрийн хөрөнгө болно.**

График 18. Эздийн өмч болон өр төлбөр, сая ₮



- Үнэт цаас гаргагч нь 2022 онд биржийн бус зах зээл дээр Өлзий энд Ко Капитал ҮЦК-аар дамжуулан нийт 35.0 тэрбум төгрөгийн бонд гаргасан ба тус бондыг 2023 онд эргэн төлөх хуваарьтай. Бондын хүүгийн хуваарьт төлөлт амжилттай төлөгдөж байна. Уг хаалттай бондыг хамааралтай этгээд М-Си-Эс Проперти ХХК худалдан авсан ба хуваарийн дагуу төлөгдөж одоо 24.9 тэрбум төгрөгийн үлдэгдэл хагас жилийн тайланд тусгагдсан. Үүнээс 8.0 тэрбум төгрөгийн транч нь 2023 оны 08 дугаар сарын 08-ны өдөр төлөгдөж хаагдсан байна.
- 2021 онд толгой компани болох М-Си-Эс Холдинг ХХК-аас нийт 50.0 тэрбум төгрөгийн хоёрдогч өглөгийг жилийн 13 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай авсан. Журмын дагуу 5 жилийн дараа нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөд шилжиж тооцогдоно.
- 2023 оны хагас жилийн тайлант хугацааны дараа үнэт цаас гаргагч нь 20.0 тэрбум төгрөгийн **Simple I** нээлттэй бондыг МХБ дээр санал болгон арилжаалсан, 2023 оны 08 дугаар сарын 08-ны өдөр 8.0 тэрбум төгрөгийн хаалттай бонд эргэн төлсөн тул бодитоор өрийн бичгийн дүн **36.9 тэрбум төгрөг** гэж тооцвол зохино.
- Үнэт цаас гаргагч нь арилжааны банканд бизнесийн зээл болон зээлийн шугамгүй.
- 2023 оны 2 дугаар улирлаас эхлэн итгэлцэл татаж эхэлсэн.



Хүснэгт 11: ББ33 дээр гаргасан одоогоор үлдэгдэлтэй өрийн бичгийн мэдээлэл

	Дүн	Хугацаа	Гаргасан огноо	Дуусгавар болох	Хүү
1	9.0 тэрбум төгрөг	18 сар	2022.04	2023.10	13%
2	8.0 тэрбум төгрөг	18 сар	2022.02	2023.09	13%

Хүснэгт 12: Үнэт цаас гаргагчийн мөнгөн гүйлгээний тайлан

Мөнгөн гүйлгээний тайлан (сая төгрөгөөр)	2020 Аудит	2021 Аудит	2022 Аудит
Татварын өмнөх ашиг	(2,073.3)	360.4	9,342.0
<i>Тохируулга</i>			
Үндсэн хөрөнгийн элэгдэл	0.5	9.8	21.5
Биет бус хөрөнгийн хорогдуулга	5.1	62.3	63.2
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл, хорогдуулга	16.8	351.9	630.2
Худалдааны болон бусад авлагын үнэ цэнийн бууралтын гарз, олзын буцаалт	105.8	1,370.6	6,111.1
Санхүүгийн зардал, цэвэр дүнгээр	(138.5)	2,984.2	(10.4)
Валютын ханшийн цэвэр олз, гарз	(265.8)	17.2	(10.6)
Актлагдсан бараа материал	18.1	29.2	37.9
Ажлын капиталын өөрчлөлтөөс өмнөх үйл ажиллагааны ашиг	(2,331.4)	5,185.7	16,184.9
Ажлын капиталын өөрчлөлт	-	-	-
Худалдааны болон бусад авлагын өсөлт	(94.8)	803.4	(1,862.5)
Бараа материалын бууралт	(21.9)	(52.9)	(24.8)
Хойшлуулсан орлогын өсөлт	-	-	7.3
Худалдааны болон бусад өглөгийн өсөлт, бууралт	377.4	605.3	294.7
Үйл ажиллагаанаас олсон мөнгө	(2,070.8)	6,541.5	14,599.6
<i>Орлогын албан татвар</i>	<i>(6.6)</i>	<i>(67.0)</i>	<i>(392.8)</i>
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(2,077.4)	6,474.5	14,206.8
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Үндсэн хөрөнгө худалдан авалт	(8.4)	(41.4)	(96.6)
Биет бус хөрөнгө худалдан авалт	(623.8)	-	(154.3)
Охин компани дахь хөрөнгө оруулалтын худалдан авалт	-	-	(1.0)
Бусад хөрөнгө оруулалтын бууралт, өсөлт	-	(95.2)	(2,904.8)
Хүлээн авсан хүү	59.8	(611.3)	-
Санхүүгийн авлагын бууралт, өсөлт	(11,216.8)	(234,057.2)	(386,620.4)
Санхүүгийн авлагаас эргэн төлөгдсөн	4,717.7	123,097.2	379,220.9
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	(7,071.6)	(111,707.8)	(10,556.3)
Санхүүжилтийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Шинээр гаргасан хувьцаа	40,000.0	15,000.0	-
Авсан зээл	-	75,000.0	26,500.0
Зээлийн эргэн төлөлт	-	-	(1,500.0)
Санхүүгийн түрээсийн өглөгийн эргэн төлөлт	(15.2)	(344.1)	(639.6)
Төлсөн хүү	(6.4)	(3,567.6)	(11,422.8)



Санхүүжилтийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	39,978.3	86,088.3	12,937.6
Цэвэр мөнгөн гүйлгээ	30,829.4	(19,145.1)	16,588.1
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл, С1	0.05	31,095.3	11,933.0
Мөнгөн хөрөнгөн дэх гадаад валютын нөлөөлөл	265.8	(17.2)	10.6
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл, С2	31,095.3	11,933.0	28,531.6

2020-2022 оны мөнгөн гүйлгээний тайлан аудитын тайлангийн дагуу шууд бус аргаар бэлтгэгдэж байсан бол 2023 оны 2 дугаар улирлын мөнгөн гүйлгээний тайлан шууд аргаар бэлтгэгдсэн бөгөөд тус тайлангийн голлох үзүүлэлтүүд дараах байдалтай байна:

Мөнгөн гүйлгээний тайлан (сая төгрөгөөр)	2023Q2 Аудит
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	260,312.1
Зээлийн хүүгийн орлого	15,970.6
Харилцах дансны хүүгийн орлого	12.3
Банкин дахь хадгаламжийн хүүгийн орлого	588
Итгэлцлийн үйлчилгээний орлого	6,030.3
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	482.7
Бусад үйлчилгээний орлого	237,228.0
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	275,103.6
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(14,791.5)
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого	0.5
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага	23.8
Үндсэн бус үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(23.3)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(14,814.8)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	28,531.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,716.8

1.3.3 САНХҮҮГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД



Хүснэгт 13. Харьцаа үзүүлэлтийн шинжилгээ

	2020	2021	2022	2023Q2
Төлбөрийн чадварын харьцаа				
Өрийн харьцаа	0.01	0.59	0.64	0.56*
Өр/Эздийн өмчийн харьцаа	0.01	1.43	1.79	1.3
Хүү төлөх чадварын харьцаа	(321.99)	1.10	1.75	2.05

Аудитын тайланд үндэслэн хоёрдогч өглөгийг өр төлбөрт оруулж тооцсон дүн.

Ашигт ажиллагааны харьцаа				
Цэвэр хүүгийн орлогын ахиуц	98.7%	72.0%	63.9%	69.6%
Үйл ажиллагааны ахиуц	-428.2%	2.8%	27.1%	50.8%
Цэвэр ашгийн ахиуц	-389.7%	1.7%	24.5%	28.7%
Нийт хөрөнгийн өгөөж	10.3%	0.3%	5.6%	3.8%
Эздийн өмчийн өгөөж	10.3%	0.3%	7.9%	5.3%

Эх сурвалж: Компанийн аудитлагдсан жилийн тайлан, Голомт капитал ҮЦК тооцоолол



Signature

Signature

Signature

2023.08.18



Зээлийн багцын өсөлтийг Үнэт цаас гаргагч нь өрийн санхүүжилт ашиглан нэмэгдүүлж эхэлснээр 2021 оноос эхлэн Үнэт цаас гаргагчийн өр/ээдийн өмчийн харьцаа өссөн. Гэхдээ 2023 онд өрийн бичгүүд нэлээдгүй эргэн төлөгдсөнөөр өрийн харьцаа буурч хүү төлөх чадварын харьцаа эргэн сайжирсан байна. 2023 оны 2 дугаар улирлын байдлаар өрийн харьцаа 0.56 байгаа бөгөөд хоёрдогч өглөгийг өөрийн хөрөнгөд оруулан тооцвол уг үзүүлэлт 0.24 болно.

Ашигт ажиллагаа

Үнэт цаас гаргагчийн 2020, 2021 оны үзүүлэлтүүд өндөр өөрчлөлттэй байгаа ба 2022 оны үзүүлэлт тогтворжиж компанийн одоогийн ерөнхий үзүүлэлтийг илэрхийлж чадахуйц болжээ. Энэ оны эхний хагас жилийн байдлаар нийт хөрөнгийн өгөөж 3.8%, өөрийн хөрөнгийн өгөөж 5.3% болж тус тус өмнөх оны дүнгээс буурсан байна.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн шинжилгээ

Хүснэгт 14: Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

		2020	2021	2022	2023Q2
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	30% <	277.5%	44.4%	40.6%	43.0%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	20% <	277.5%	86.0%	73.4%	74.8%
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө нийт активын харьцаа	30% <	98.7%	41.1%	35.9%	43.5%
Нэг зээлдэгч, холбоотой этгээдэд олгосон зээлийн зохистой харьцаа	30% >	0.1%	0.5%	0.9%	0.8%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8% <	6248.4%	45.6%	47.3%	36.0%
Итгэлцлийн үйлчилгээний өглөгийн зохистой харьцаа	80% >	0.0%	0.0%	0.0%	5.2%
Өрийн бичгийн зохистой харьцаа	50% >	0.0%	24.2%	44.7%	21.2%*
Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	15% >	0.1%	0.3%	0.1%	0.9%



Эх сурвалж: Компанийн СЗХ-ны тайлан



2023.08.18


- 2023.07 сард 20.0 тэрбум төгрөгийн нээлттэй бонд МХБ дээр гаргасан
- 2023.08.08-нд Симпл хаалттай бондын 8.0 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдсэн
- Эдгээр хэлцэл хийгдсэний дараа өрийн бичгийн зохистой харьцаа **31.4%** болж байна
- Санал болгож буй Симпл II нээлттэй бондын дараа уг харьцаа **44.2%** болно.

Үнэт цаас гаргагч нь үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон ББСБ-ын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг амжилттай биелүүлж ирсэн. Харин итгэлцлийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл 2023 оны 05 дугаар сарын 22-нд авснаар итгэлцлийн эх үүсвэр шинээр татаж эхлээд байна.

График 19: Зохистой харьцаан үзүүлэлт



График 20: Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, итгэлцлийн зохистой харьцаа



СЗХ нь “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ын дагуу хоёрдогч өглөгийг өөрийн хөрөнгөд тооцдог бөгөөд үнэт цаас гаргагч нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүгдийг ханган ажиллаж байна.

1.3.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС

Үнэт цаас гаргагч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зориулалтаар “Симпл ассет ТЗК” ХХК-г 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр үүсгэн байгуулж улсын бүртгэлд бүртгүүлсэн. Түүнчлэн 50 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий Симпл ассет ХБҮЦ-ийг 2022 оны 6 дугаар сарын 16-нд Монголын хөрөнгийн биржид бүртгүүлж арилжсан байна.

ХБҮЦ-ийн тухай мэдээлэл

1	Байгууллагын нэр	Симпл Ассет ТЗК ХХК
2	Толгой компани	Ашид капитал ББСБ
3	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	1,000,000 төгрөг (1,000,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1 ширхэг хувьцаа)
4	ХБҮЦ-ийн дүн	50.0 тэрбум төгрөг
5	Хүү	Жилийн 15%
6	Нэрлэсэн үнэ	100,000 төгрөг (2023/06/23-ны өдөр SMPL-ийн нэрлэсэн үнэ 50'000 болж өөрчлөгдсөн)
7	Багцалсан хөрөнгө	10,236 зээлдэгчийн 50.0 тэрбум төгрөгийн үлдэгдэл бүхий зээлийн багц
8	Жигнэсэн дундаж зээлийн хүү	2.03%
9	Жигнэсэн дундаж зээлийн хугацаа	23.3 сар
10	Багцын зээлийн чанар	100% энгийн зээл Хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш
11	Эргэн төлөлт	12 дахь сард үндсэн төлбөрийн 50% (2023.06) 18 дахь сард үндсэн төлбөрийн 50% (2023.12)
12	2023.08.18 өдрөөрх үлдэгдэл	25.0 тэрбум төгрөг

2022 оны 6 дугаар сараас эхлэн арилжаалагдсан ХБҮЦ-ийн мэдээлэл:

- 52 долоо хоног: 48,470-100,000 төгрөг
- 2023.08.08-ны өдрийн хаалтын ханш 48,470 төгрөг

“Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль”-ийн дагуу ТЗК нь 2023 оны 12 дугаар сард татан буугдаж, үнэт цаас гаргагч нь охин компанид оруулсан 1.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хасаж бүртгэнэ. ТЗК-ийн тооцооллыг санхүүгийн тайлангийн тооцоололд тусгасан болно.

Үнэт цаас гаргагч нь охин компани буюу Симпл ассет ТЗК ХХК-г 2022 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайландаа “Кэй Пи Эм Жи Аудит” ХХК (KPMG аудит)-аар хөндлөнгийн аудит хийлгэсэн ба нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, орлогын тайлан, мөнгөн гүйлгээний тайлан нь IFRS стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна гэж дүгнэжээ. Симпл ассет ТЗК ХХК нь 2022 онд байгуулагдсан тул 2021 оны эхний үлдэгдэл нь Ашид капитал ББСБ-ийн тусдаа санхүүгийн тайлангийн дүнгээр орсон байна.

Хүснэгт 16: ТЗК-г нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

Санхүүгийн байдлын тайлан (сая төгрөгөөр)	2021	2022 Нэгтгэсэн тайлан
Мөнгөн хөрөнгө / cash and cash equivalents	11,933.0	29,017.4
Богино хугацаат хөрөнгө оруулалт / Short-term investments	95.2	3,088.2
Харилцагчдад олгосон зээл урьдчилгаа төлбөр / Loans and advances to customers	115,988.3	180,421.0
Бусад хөрөнгө / Other assets	639.7	321.0
Эргэлтийн хөрөнгийн нийт дүн / Total current assets	128,656.1	212,847.6

АШИД КАПИТАЛ
ББСБ ХХК

АТАГСЭГ - 100552
962376633

MANDAL CAPITAL
MARKETS SC
LLC

43

ШТК0162 9021070414 5213487

Gold Capital

111-220111-4-015509


Улаанбаатар хот

2023.08.18

Үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмж / Property, plant and equipment	42.8	
Биет бус хөрөнгө / Intangible assets	556.4	647.4
Ашиглах эрхтэй хөрөнгө / Right-of-use assets	334.5	-
Хойшлогдсон татварын хөрөнгө / Deferred tax assets	165.1	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн / Total non-current assets	1,098.8	762.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН / Total assets	129,754.9	213,609.7
Богино хугацаат өр төлбөр / Current liabilities	-	-
Зээллэг / Borrowings	46.5	100,795.1
Бусад өр төлбөр / Other liabilities	1,365.4	631.1
Орлогын албан татварын өр төлбөр / Income tax payables	37.3	424.3
Богино хугацаат өр төлбөрийн дүн / Total current liabilities	1,449.2	101,850.5
Зээллэг / Borrowings	74,964.5	50,000.0
Нийт өр төлбөрийн дүн / Total liabilities	76,413.8	151,850.5
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ / Equity		
Хувьцаат капиталын дүн / Share capital	55,000.0	55,000.0
Хуримтлагдсан ашиг (алдагдал) / Retained earnings (Accumulated losses)	(1,658.8)	6,759.2
Эзэмшигчдийн өмчийн дүн / Total equity	53,341.2	61,759.2
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН / Total liabilities and equity	129,754.9	213,609.7

Хүснэгт 17: ТЗК-г нэгтгэсэн орлого, үр дүнгийн тайлан

Орлого, үр дүнгийн тайлан (сая төгрөгөөр)	2021	2022 Нэгтгэсэн тайлан
Хүүгийн орлого (үр ашигт хүүгийн аргаар) / Interest income from financial assets using the effective interest method	12,754.3	39,152.4
Хүүгийн зардал / Interest expense	3,614.1	16,620.5
Цэвэр хүүгийн орлого / Net interest income	9,140.1	22,532.0
Хураамж, шимтгэлийн орлого / Fee and commission income	172.8	647.1
Бусад орлого (зардал) / Other income (expense)	(16.3)	11.0
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэний бууралт / Impairment losses on financial assets	(1,370.6)	(7,038.5)
Үйл ажиллагааны зардал / Operating expenses	(7,564.7)	(6,775.3)
Үйл ажиллагааны бус зардал / Non-operating expenses	(1.0)	(5.5)
Татварын өмнөх ашиг / Profit before tax	360.4	9,370.8
Орлогын албан татвар / Income tax expense	(136.5)	(952.8)
Цэвэр ашиг / Profit for the year	223.8	8,418.0



Мөнгөн гүйлгээний тайлан (сая төгрөгөөр)	2021	2022 Нэгтгэсэн тайлан
Татварын дараах ашиг / Profit after tax	223.85	8,418.01
Тохируулга / Adjustment for:		
Үндсэн хөрөнгийн элэгдэл / Depreciation of property, plant and equipment	9.85	21.52
Биет бус хөрөнгийн хорогдуулга / Amortization of intangible assets	62.34	63.23
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл / Depreciation of ROU	351.94	630.16
Зээлийн эрсдэлийн сан / Impairment losses on loans and advances to customers	1,370.56	7,038.46
Цэвэр хүүгийн орлого / Net interest income	(9,140.14)	(22,531.97)
Гадаад валютын цэвэр олз, гарз / Net foreign exchange (gain), losses	17.24	(10.56)
Бараа материал данснаас хассаны гарз / Inventories written down losses	29.19	37.89
Орлогын татварын зардал / income tax expenses	136.50	952.75
Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлт / Changes in assets and liabilities		
Харилцагчид олгосон зээлийн өсөлт / Increase in loans and advances to customers	(109,589.36)	(70,515.06)
Бусад хөрөнгийн бууралт / Decrease in other assets	750.51	280.79
Бусад өр төлбөрийн өсөлт, (бууралт) / (Decrease), increase in other liabilities	605.29	(772.13)
	-	-
Хүлээн авсан хүү / Interest received	(3,567.64)	(15,285.68)
Төлсөн хүү / Interest paid	10,142.47	38,037.68
Төлсөн татвар / Income tax paid	(67.05)	(400.69)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(108,664.45)	(54,035.59)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ / Cash flows from investing activities		
Үндсэн хөрөнгө худалдан авсан / Purchase of property, plant and equipment	(41.38)	(96.65)
Биет бус хөрөнгө худалдан авсан / Purchases of intangible assets	-	(154.29)
Богино хугацаат хөрөнгө оруулалт эзэмшихэд төлсөн / Acquisition of short-term investments	(95.16)	(3,000.00)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ / Net cash used in investing activities	(136.53)	(3,250.93)
Санхүүжилтийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ / Cash flows from financing activities		
Хувьцаат капиталаас орж ирсэн / Proceeds from issue of share capital	15,000.00	-
Зээллэгээр орж ирсэн / Proceeds from borrowings	75,000.00	76,500.00
Зээл эргэн төлөлт / Repayment of borrowings	-	(1,500.00)



Санхүүгийн түрээсийн өглөг төлөлт / Payment of finance lease liabilities	(344.09)	(639.60)
Санхүүжилтийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ / Net cash used in financing activities	89,655.92	74,360.40
Цэвэр мөнгөн гүйлгээ / Net change in cash and cash equivalents	(19,145.07)	17,073.88
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл / Cash and cash equivalents at 1 January	31,095.26	11,932.96
Мөнгөн хөрөнгөн дэх гадаад валютын нөлөөлөл / Effect of foreign exchange rate changes on cash hold	(17.24)	10.56
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл / Cash and cash equivalents at 31 December	11,932.96	29,017.40

Хүснэгт 19: ТЗК-г нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Өмчийн өөрчлөлт (сая төгрөгөөр)	Хувьцаат капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт өөрийн хөрөнгө
2020 оны эхний үлдэгдэл /Balance as at 1 January 2020	40,000.0	(1,882.7)	38,117.3
Нийт дэлгэрэнгүй орлого/ Total comprehensive income		223.8	223.8
Гаргасан хувьцаа/Shares issued	15,000.0		15,000.0
2021 оны эцсийн үлдэгдэл/Balance as at 31 December 2021	55,000.0	(1,658.8)	53,341.2
2022 оны эхний үлдэгдэл/Balance as at 1 January 2022	55,000.0	(1,658.8)	53,341.2
Тайлант жилийн ашиг/Profit for the year		8,418.0	8,418.0
2022 оны эцсийн үлдэгдэл /Balance as at 31 December 2022	55,000.0	6,759.2	61,759.2

1.4 ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧИН, НИЙЦЭЛ

1.4.1 Үнэт цаас гаргагчийн их хэмжээний хэлцэл

Их хэмжээний хэлцэл гэдэг нь Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлд заасны дагуу хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/ юм.

Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК нь сүүлийн 3 жилийн хугацаанд дээрх шалгуурыг хангасан их хэмжээний 3 хэлцэл байгуулсан байна.

№	Гэрээлэгч тал	Огноо	Гэрээний гол нөхцөлүүд	Шаардлага хангасан эсэх
1	М-Си-Эс ХХК	Холдинг 2021.06.02	Зээлдүүлэгч М-Си-Эс Холдинг ХХК нь Зээлдэгч Ашид Капитал ББСБ ХХК-ийн хүсэлтийг үндэслэн 30,000,000,000 (Гучин тэрбум) хүртэл төгрөгийн хувьцаа эзэмшигчийн хоёрдогч өглөгийг Зээлдэгч Ашид Капитал ББСБ	Хангасан



ХХК-д байршуулах, Зээлдэгч Ашид Капитал ББСБ ХХК нь хугацааны эцэст Хоёрдогч өглөгийг өөрийн энгийн хувьцаанд хөрвүүлж Зээлдүүлэгч М-Си-Эс Холдинг ХХК-дээ эзэмшүүлэх талаарх харилцаа

2	М-Си-Эс Холдинг ХХК	2021.09.17	Хоёрдогч өглөг байршуулах	Хангасан
	Симпл Ассет ТЗК ХХК	2022.06.23	Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ	Хангасан
3	Симпл Ассет ТЗК ХХК, Юнайтед Айр Файнэнс ХХК	2022.06.23	Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ	Хангасан

Эдгээр хэлцлүүд нь сонирхлын зөрчилтэй хэлцлийн шалгуур мөн хангах бөгөөд үнэт цаасны танилцуулгын 1.4.2 хэсэгт мөн адил тусгагдсан болно. Хуулийн фирмийн зүгээс тус хэлцлүүд нь ТУЗ-ийн зөвшөөрлийн дагуу Компанийн тухай хуульд заасан журмын дагуу хийгдсэн байна гэж дүгнэсэн байна. Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт хэсэг дэх хуулийн дүгнэлтээс харна уу.

1.4.2 Сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээлэл

Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн дагуу Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно:

- ✓ Хэлцлийн нөгөө тал, эсхүл хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа;
- ✓ Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20-оос дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
- ✓ Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл уг компанийн энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
- ✓ Хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа.

Үнэт цаас гаргагчийн хувьд сүүлийн 3 жилийн хугацаанд байгуулагдсан тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа нийт 10 сонирхлын зөрчилтэй хэлцлүүд байгаа ба тус гэрээнүүдийн мэдээлэл дараах байдалтай байна:





simple

Хүснэгт 20. Сонирхлын зөрчилтэй хэлцлүүд

2023-03-18
БҮРТГЭВ-02

№	Гэрээлэгч тал	Огноо	Гэрээний утга	Шаардлага хангасан эсэх
1	М-Си-Эс Холдинг ХХК	2021.06.02	Зээлдүүлэгч М-Си-Эс Холдинг ХХК нь Зээлдэгч Ашид Капитал ББСБ ХХК-ийн хүсэлтийг үндэслэн 30,000,000,000 (Гучин тэрбум) хүртэл төгрөгийн хувьцаа эзэмшигчийн хоёрдогч өглөгийг Зээлдэгч Ашид Капитал ББСБ ХХК-д байршуулах, Зээлдэгч Ашид Капитал ББСБ ХХК нь хугацааны эцэст Хоёрдогч өглөгийг өөрийн энгийн хувьцаанд хөрвүүлж Зээлдүүлэгч М-Си-Эс Холдинг ХХК-дээ эзэмшүүлэх талаарх харилцаа	Хангасан
2	Юнител ХХК	2021.06.18	Гар утас борлуулахад ББСБ-аар дамжуулан зээл гаргах тухай	Хангасан
3	М-Си-Эс Холдинг ХХК	2021.09.17	Хоёрдогч өглөг байршуулах	Хангасан
4	Симпл Ассет ТЗК ХХК	2022.06.23	Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ	Хангасан
4	Симпл Ассет ТЗК ХХК, Юнайтед Айр Файнэнс ХХК	2022.06.23	Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ	Хангасан
5	М-Армор ХХК	2022.08.15	Харуул хамгаалалтын үйлчилгээ авах	Хангасан
6	М-Си-Эс Холдинг ХХК	2023.01.31	Санхүү бүртгэлийн абакус системийн үйлчилгээ авах	Хангасан
7	Шангри-ла улаанбаатар ХХК	2023.01.09	Оффисын түрээсийн гэрээ	Хангасан
8	М Банк ХХК	2023.03.21	Энгийн долларын хугацаатай хадгаламж	Хангасан
9	М-Си-Эс Холдинг ХХК	2023.07.26	Хоёрдогч өглөг байршуулах гэрээний нэмэлт гэрээ	Хангасан
10	М Банк ХХК	2023.07.26	Энгийн төгрөгийн хугацаатай хадгаламж	Хангасан

Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн хугацаанд нэгдмэл сонирхолтой этгээдтэй байгуулсан тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж буй 10 сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулсан ба Хуулийн фирмийн зүгээс тус хэлцлүүд нь ТУЗ-ийн зөвшөөрлийн дагуу Компанийн тухай хуульд заасан журмын дагуу хийгдсэн байна гэж дүгнэсэн байна. Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт хэсэг дэх хуулийн дүгнэлтээс харна уу.

1.4.3 Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ хэлцэл



48



2023.08.18

Хуулийн дүгнэлтийн дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн 3 гэрээний мэдээллийг тайлагнасан байна. Тус гэрээ нь хаалттай бондын үйлчилгээ үзүүлэх гэрээ болон түүний үүргийн гүйцэтгэл хангуулахтай холбоотой гэрээ бөгөөд гэрээний мэдээлэл дараах байдалтай байна:

Хүснэгт 21. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэлцлүүд

№	Гэрээлэгч тал	Огноо	Гэрээний гол нөхцөлүүд	Шаардлага хангасан эсэх
1	Өлзий энд ко капитал ҮЦК ХХК	2021.10.29	18 сарын хугацаатай 35 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүн бүхий хаалттай бонд гаргах үйлчилгээ авах	Хангасан
	Өлзий энд ко капитал ҮЦК ХХК	2021.12.07	Хаалттай бондын үүргийн гүйцэтгэл хангуулах тухай	Хангасан
2	Голомт Капитал ҮЦК ХХК	2023.06.07	12 сарын хугацаатай 20 тэрбум төгрөгийн үнийн дү бүхий нээлттэй бонд гаргах үйлчилгээ авах	Хангасан
3	-	2023.06.08	Итгэлцлийн дагуу байршуулсан мөнгөн хөрөнгийг итгэмжлэн удирдах	Хангасан


Хуулийн фирмийн зүгээс тус хэлцэл нь хуулийн шаардлага хангасан хүчин төгөлдөр гэж дүгнэсэн байна. Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт хэсэг дэх хуулийн дүгнэлтээс харна уу.

1.4.4 Хууль зүй, комплайнс

Ашид Капитал ББСБ нь Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай /МУТСТ/ хууль, тогтоомж, бусад дотоодын эрх бүхий байгууллагуудын зохицуулалт, ФАТФ болон бусад олон улсын зохицуулагч байгууллагаас гаргасан дүрэм журам, зөвлөмж, стандартыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж мөрдөн ажиллаж байна.

Үнэт цаас гаргагч нь эдгээр хууль тогтоомж, дүрэм журмууд, стандартын нийцэл, мөрдлөгийг хангах, хяналт тавих зорилгоор хууль эрхзүй, комплаенсийн нэгжийг байгуулсан ба тус нэгж нь дараах чиг үүрэгтэй байна:

- ❖ Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
- ❖ Компани нь үйл ажиллагаандаа Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, хууль, эрх зүйн акт, дотоод дүрэм, журам, ёс зүйн хэм хэмжээг зохих ёсоор мөрдүүлж ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих;
- ❖ Харилцагчийг таньж мэдэх ажиллагааг олон улсын стандарт, дотоодын эрх бүхий байгууллагын журамд нийцүүлэн эрсдэл суурилсан аргачлалаар хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлого, журам боловсруулах, нийт ажилтнуудад дэмжлэг туслалцаа үзүүлэх;





- ❖ Санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх;
- ❖ Шүгэл үлээх буюу ашиг сонирхлын зөрчил, ажилтны ёс зүйн зөрчилтэй холбоотой мэдээллийг хүлээн авч холбогдох шалгалтыг хэрэгжүүлэх,

Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа /KYC/

- ❖ Компани нь харилцагчтай санхүүгийн харилцаа үүсгэхээс өмнө харилцагчийн ерөнхий мэдээлэлд тулгуурлан харилцагчийн эрсдэлийн зэргийг тодорхойлон харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг стандарт болон нарийвчилсан гэсэн 2 төрлөөр хэрэгжүүлдэг. Бага болон дунд эрсдэлтэй харилцагчийг стандарт аргачлалаар таньж мэдэх ба өндөр эрсдэлтэй харилцагчийг нарийвчилсан аргаар таньж мэднэ.
- ❖ ББСБ нь Нэгдсэн Үндэсний байгууллагын хориг арга хэмжээнд орсон хувь хүн хуулийн этгээдтэй санхүүгийн харилцаа үүсгэхийг хориглодог.
- ❖ ББСБ нь зөвхөн хүчин төгөлдөр бичиг баримтад үндэслэн санхүүгийн харилцаа үүсгэдэг ба харилцагч бүртгэх үйл ажиллагааг 3 шатлалт баталгаажуулах хяналтын тогтолцоогоор хэрэгжүүлдэг.
- ❖ Харилцагч нь ББСБ-ээс шаардсан харилцагч таньж мэдэх үйл ажиллагаатай холбогдох мэдээллийг гаргаж өгөхөөс татгалзсан тохиолдолд бид Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд зааснаар үйлчилгээ үзүүлэхээс татгалзах үүрэгтэй.

Санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх

- ❖ ББСБ нь Нэгдсэн Үндэсний Байгууллагын Аюулгүйн Зөвлөл(UNSCR)-өөс гаргасан хориг, АНУ-ын Сангийн яамны Гадаадын хөрөнгийн хяналтын газар (OFAC) болон Европын Холбоо (EU)-ны хориг зэрэг бусад холбогдох хоригийг дагаж мөрддөг ба харилцагч бүртгэл үүсгэх үед харилцагчийн мэдээлэл, түүний эцсийн өмчлөгчийг болон холбоо хамааралтай этгээдүүдийн мэдээллийг холбогдох хоригтой тулгаж шалгадаг болно.

Ёс зүйн дүрэм:

ББСБ-ийн нийт ажилтнууд нь ашиг сонирхлын зөрчилд үл автагдах, үүсэж болохуйц нөхцөл байдлаас зайлсхийх, ББСБ-ын эрх ашигт аливаа сөрөг үр дагавар бий болгохгүй байх, хөндлөнгийн нөлөөлөлд үл автан шийдвэр гаргах байгууллагын болон харилцагчийн эрх ашгийг хамгаалах ёс зүйн өндөр хэмжээ хэмжээг дагаж мөрдөх үүрэгтэй.

1.4.5 Компанийн засаглалын кодекс

Ашид Капитал ББСБ ХХК нь Хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-ийг тусгайлан баталж мөрддөггүй боловч үйл ажиллагааны бодлого, журмын дагуу засаглалын кодексийн зарчмуудын хэм хэмжээг мөрдлөг болгон ажиллахыг зорьж байна. Үнэт цаас гаргагчийн засаглалын кодексийн зарчмуудын биелэлт, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалт, хэрэгжүүлэх төлөвлөгөө дараах байдалтай байна:

Кодексийн 1-р зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2021 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн №01 тоот тогтоолын хавсралтаар ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг баталсан бөгөөд чиг үүрэг, хариуцлага, ТУЗ-ийн бүтэц бүрэлдэхүүн тэдгээрийн мэргэжил, ур чадварын талаар тус журамд тусгасан байна.



Кодексийн 2-р зарчим: Компани нь ТУЗ-ийн гишүүдийн олонхыг хараат бус гишүүн байхыг зорин ажилладаг ба ТУЗ-ийн 2020 оны бодлогын баримт бичиг батлах тухай №02 дугаар тогтоолоор Дотоод аудитын үйл ажиллагааны журам, аудитын бодлогыг баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Компани нь 2023 оны 5 дугаар сарын 12-ны өдөр итгэлцлийн үйл ажиллагааны зөвшөөрлийг авч улсын бүртгэлд 5 дугаар сарын 21-ний өдөр бүртгүүлсэн ба үүнтэй холбоотойгоор Компанийн засаглалын кодексст заасан цалин урамшууллын хороо, нэр дэвшүүлэх хороодыг бий болгох эсэх асуудлыг Эрх мэдэл хуваарилалтын журамд заасны дагуу дээд удирдлагуудаар шийдвэрлүүлэхээр бэлдэж байна. Компанийн хувьд ТУЗ-с шаардлагатай гэж үзвэл бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулах бүрэн эрхтэй юм.

Кодексийн 3-р зарчим: ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам батлаагүй боловч Банк бус санхүүгийн байгууллагын тухай хууль, Компанийн тухай хууль, зохицуулагч байгууллагаас гаргасан холбогдох дүрэм журамд заасны дагуу шаардлагатай мэдээллийг нийтэд ил тод тайлагнаж, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг тогтмол өөрийн цахим хуудсанд байршуулан ажиллаж байна.

Кодексийн 4-р зарчим: Компани нь Дотоод аудитын нэгжийн бүтэц зохион байгуулалтыг гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар зохион байгуулж, ТУЗ-ийн удирдлага дор үйл ажиллагаагаа тайлагнан ажиллаж байна. Мөн хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл болон аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгөх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Кодексийн 5-р зарчим: ТУЗ-ийн 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн бодлогын баримт бичиг батлах №02 дугаар тогтоолоор Эрсдэлийн удирдлагын бодлогыг баталсан ба эрсдэлийн удирдлагын тогтолцоо, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдлыг тодорхойлж, тэдгээрт ТУЗ-с хяналт тавих зохицуулалтыг тусгасан. Мөн комплаенсийн хяналтыг хэрэгжүүлэхийн тулд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам болон дотоод хяналтын хөтөлбөрийг хэрэгжүүлж ажилладаг. Компани нь ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн удирдлага хариуцсан хороо бий болгох эсэх асуудлыг Эрх мэдэл хуваарилалтын журамд заасны дагуу дээд удирдлагуудаар шийдвэрлүүлэхээр бэлдэж байна.

Кодексийн 6-р зарчим: Толгой компаниас баталсан Цалин хөлсний журмыг охин компаниуд өөрийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг ба уг журамд цалин хөлс, урамшуулал олгох хэмжээг тогтоох үндэслэл, ажил үүргийн бүрдэл хэсэг, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг тусгасан. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллыг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр баталдаг.

Кодексийн 7-р зарчим: Толгой компаниас баталсан Худалдан авалт, Тендер шалгаруулалтын журам, Ашиг сонирхлын зөрчлийг мэдүүлэх журмыг охин компаниуд үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг. Эдгээр журмуудад харилцагч, бэлтгэн нийлүүлэгч болон охин компани болон ажилтнуудын хооронд үүсэж болзошгүй ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бизнесийн харилцаанд талуудын эрх ашгийг хүндэтгэн, бизнесийн нэр хүн, алдар хүндийг хамгаалж, харилцан ашигтай хамтран ажиллах талаар зохицуулсан байна.

Кодексийн 8-р зарчим: Толгой компаниас баталсан Ёс зүйн дүрмийг охин компаниуд нь үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг ба ёс зүйн дүрмийг үндсэн болон гэрээт ажилтнууд, бэлтгэн нийлүүлэгчдийн харилцаанд дагаж мөрддөг. Гүйцэтгэх удирдлагын дэргэд Ёс зүйн хороо ажилладаг. Аливаа хууль ёс үйлдэл болон ёс зүйн зөрчлийг толгой компаниас баталсан Ёс зүйн дүрэм болон Гүйцэтгэх захирлын 2020



оны №055/А/22 дугаар тушаалаар батлагдсан Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх журамд заасны дагуу Гүйцэтгэх удирдлагын дэргэдэх ёс зүйн хороонд шүгэл үлээх сувгаар дамжуулан, хараат бусаар шийдвэрлүүлэх тогтолцоог нэвтрүүлэн ажилладаг. Толгой компаниас баталсан Ёс зүйн дүрмийн 7, 8 дугаар зүйлд Авлига, хээл хахуулиас ангид байж, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх, Компанийн хувьд улс төрийн аливаа үйл ажиллагаанаас ангид байж, Монгол Улсын хууль тогтоомжоос гадуур аль нэг улс төрч, улс төрийн хүчинд хандив өргөхийг тус тус хориглосон.

Кодексийн 9-р зарчим: Толгой компаниас баталсан Эрх мэдэл хуваарилалтын журам, Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журам, Компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд тус тус заасны дагуу хувьцаа эзэмшигчийн хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэн ажилладаг. Компани нь сонирхлын зөрчилтэй хэлцлийг Компанийн тухай хуульд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэх журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг.

1.5 ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Үнэт цаас гаргагч нь эрсдэлийн удирдлага болон хяналтын зохистой засаглалын тогтолцоог бий болгож ажиллах бөгөөд энэхүү тогтолцоо нь бизнест ээлтэй эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, эрсдэлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих, түүнийг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хангуулах хяналт, тайлагналтын тэнцвэртэй байдлыг бий болгоход чиглэсэн байдаг.

1.5.1 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлүүд

Үнэт гаргагчийн үйл ажиллагаа болон бизнесийн орчноос шалтгаалан учирч болзошгүй эрсдэлүүд дараах байдалтай байна:

Зээлийн эрсдэл

Эрсдэл: Зээлдэгч хүлээсэн гэрээний үүргээ цаг тухайд нь биелүүлж чадахгүйн улмаас Үнэт цаас гаргагчид учирч болох алдагдлын хэмжээгээр тодорхойлогдоно. 2021 оны эцэст Үнэт цаас гаргагчийн чанаргүй зээлийн хэмжээ 1.2 хувь байсан бол 2023 оны 2 дугаар улирлын байдлаар 11.2 хувь байна. Энэ нь салбарын дундаж үзүүлэлттэй харьцуулахад 3.6 хувиар өндөр үзүүлэлт юм. Чанаргүй зээлийн хувь нэмэгдэж байгаа нь ирээдүйд зээлийн хүлээгдэж буй алдагдал нэмэгдэж болзошгүйг илэрхийлж байна.

Эрсдэлийн удирдлага: Үнэт цаас гаргагч нь тус эрсдэлийг удирдахын тулд зээлийн эрсдэлтэй холбоотой зохистой түвшинг тодорхойлон түүнд нийцүүлэн ажиллах бодлогыг баримталж байна. Тус бодлогын хүрээнд чанаргүй зээлийн хэмжээг 10 хувиас хэтрүүлэхгүй байх, бизнес болон автомашины зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувь 50 хувиас ихгүй, цалингийн зээлийн нийт зээлд эзлэх хувь 45 хувиас дээш байлгах зорилт тавин ажиллаж байна. Үнэт цаас гаргагч зээлийн скоринг хийхдээ БНСУ-ын CrePass системийг ашигладаг ба тус системийн тусламжтайгаар харилцагчийг хүлээн зөвшөөрөх, тэдэнд олгож буй зээлийн хэмжээг оновчтой тодорхойлох зэргээр чанаргүй зээлийн хэмжээг бууруулахаар ажиллаж байна.

Зээл болон актив хөрөнгийн төвлөрлийн эрсдэл

Эрсдэл: Хэт их зээлийн хөрөнгийн төвлөрлийн улмаас үүсэж болзошгүй алдагдлын хэмжээгээр тодорхойлогдоно. Зээлийн багцыг цөөн харилцагчдад өндөр дүнгээр олгосноос шалтгаалан үнэт цаас гаргагчийн зээлийн багцын төвлөрөл нэмэгдэх ба үүнээс шалтгаалан зээлдэгч нарын төлбөрийн чадварт эрсдэл үүссэн тохиолдолд үнэт

цаас гаргагч нь материаллаг хэмжээний алдагдал хүлээх эрсдэлтэй юм. 2023 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар үнэт цаас гаргагч нь 47.5 мянган харилцагчдад олгосон нийт 142.5 тэрбум төгрөгийн зээлтэй байгаа бөгөөд Топ-40 харилцагчдад олгосон зээл нийт зээлийн 12.3 хувийг эзэлж байна.

Эрсдэлийн удирдлага: Үнэт цаас гаргагч нь эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд зээлийн багцын төвлөрлийг хянахын тулд Топ-20 харилцагчдад олгон зээлийг нийт зээлийн 14 хувиас ихгүй байлгах бодлого баримталж байна. 2023 оны 2 дугаар улирлын байдлаар үнэт цаас гаргагчийн зээлийн төвлөрөл нь хэвийн түвшинд байна.

Зах зээлийн эрсдэл / Гадаад валютын ханшийн эрсдэл

Эрсдэл: Зах зээлийн хүчин зүйлийн сөрөг нөлөөллийн улмаас орлого болон хөрөнгийн хэмжээнд хүлээж болзошгүй алдагдлын хэмжээгээр тодорхойлогдоно. 2020 оны эцэст инфляцын түвшин 2 хувь байсан бол 2022 эцэст 13.2 хувь болж өссөн бөгөөд 2023 оны 8 сарын байдлаар 9.2 хувь болж оны эцсээс буурсан үзүүлэлттэй байна. Түүнчлэн Олон Улсын Валютын Сангаас Монгол улсын инфляцын түвшинг 2023 онд 12.1 хувь, 2024 онд 9.5 хувь байхаар төсөөлсөн байна. Мөн Монгол улсад ашиглагдаж буй голлох валют болох ам.долларын төгрөгтэй харьцах ханш 2021 оны эцэст 2,849.34 төгрөг байсан бол 2023 оны 8 дугаар сарын эхний байдлаар 3,458.91 болж энэ хугацаанд төгрөгийн ханш 21.4 хувиар суларсан байна. Үүнээс харахад сүүлийн жилүүдийн эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийн өөрчлөлт нь дотоодын эдийн засагт сөрөг нөлөөллийг үзүүлж байгаа нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, бизнесийн орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүйг илэрхийлж байна.

Эрсдэлийн удирдлага: Үнэт цаас гаргагч нь гадаад валютын нээлттэй позицийн өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцааг хамгийн ихдээ 15 хувь байлгах бодлого баримталж байгаа ба ингэснээр ханшийн болзошгүй эрсдэлээс үүсэх алдагдлыг хязгаарлах боломжтой юм.

Хүүгийн эрсдэл

Эрсдэл: Зах зээлийн хүүгийн төвшний өөрчлөлт болон тогтворгүй байдлын улмаас ББСБ-д үүсэж болзошгүй алдагдлын хэмжээгээр тодорхойлогдоно. Монгол улсын хувьд зах зээлийн хүүгийн түвшин сүүлийн жилүүдэд тасралтгүй өсөж байгаа ба 2022 оны 1 дүгээр сард Монгол Банкнаас зарласан бодлогын хүүгийн түвшин 6 хувь байсан бол 2023 оны 8 дугаар сарын байдлаар 13 хувь болж 2.2 дахин өссөн байна. Зах зээлийн хүүгийн түвшний өсөлт нь компанийн санхүүжилтийн өртгийг нэмэгдүүлэх бөгөөд мөн харилцагчдад санал болгож буй зээлийн бүтээгдэхүүний эрэлтийг бууруулах эрсдэлтэй юм.

Эрсдэлийн удирдлага: Үнэт цаас гаргагч нь зээлийн бүтээгдэхүүний эрэлт болон өрийн хэрэгслийн өртгийг удирдахын тулд зах зээлийн мэдээлэлд тогтмол шинжилгээ хийж, хүүгийн түвшинг зах зээлийн нөхцөл байдал, компанийн эрсдэлийн хүчин зүйлтэй уялдуулан тогтоох замаар тус эрсдэлийг удирдаж байна.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээний эрсдэл

Эрсдэл: Хязгаарлагдмал өөрийн хөрөнгийн улмаас бизнесийн хэвийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх чадваргүй болох эсхүл зохицуулагч байгууллагын өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлагыг хангаж чадахгүй болох эрсдэл юм. Үнэт цаас гаргагч нь 2023 оны 2 дугаар улирлын байдлаар 117.7 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгөтэй, мөн 24.9 тэрбум төгрөгийн өрийн бичгийн үлдэгдэлтэй тайлагнасан. Харин тайлант хугацааны дараа буюу 2023 он 7 дугаар сард үнэт цаас гаргагч нь 20.0 тэрбум төгрөгийн Симпл I бондыг МХБ-ээр дамжуулан татан төвлөрүүлсэн. СЗХ-ноос баталсан журмын дагуу ББСБ-ын өрийн бичгийн үлдэгдлийг өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцаа 50 хувиас



дээшгүй байх шаардлагатай бөгөөд тус харьцаа Үнэт цаас гаргагчийн хувьд 38.2 хувь байна. Одоо санал болгож буй Симпл II бондыг гаргасны дараа харьцаан үзүүлэлт 44 хувь болно.

Эрсдэлийн удирдлага: Тус эрсдэлийг удирдахын тулд үнэт цаас гаргагч нь нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээг 10 хувиас дээш, нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээг 20 хувиас дээш байлгах бодлого баримталж байгаа ба 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар тус харьцаа хэвийн түвшинд байна.

Хөрвөх чадварын эрсдэл

Эрсдэл: Өөрийн хөрөнгө хүрэлцээтэй боловч хөрөнгийн өсөлтийг санхүүжүүлэх эх үүсвэрийн дутагдалд орох болон харилцагчийн өмнө хүлээсэн үүргээ цаг хугацаанд нь биелүүлэх чадваргүй болох, эсхүл тухайн үүргийг биелүүлэхэд ихээхэн хэмжээний зардал гарах нөхцөл байдал үүсэх эрсдэл юм.

Эрсдэлийн удирдлага: Компанийн богино хугацааны мөнгөн урсгалын хэрэгцээ шаардлагыг санхүү удирдлагын алба урьдчилан тооцоолдог ба түүнд тохирсон мөнгөн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлдэг. Эргэлтийн хөрөнгийн материаллаг хэсгийг зээлийн багц эзлэх бөгөөд олгосон зээлүүд нь ихэвчлэн 6-12 сарын хугацаатай байдаг учир богино хугацааны мөнгөн урсгалыг төлөвлөж, хөрвөх чадварыг хангах боломжтой байдаг.

Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл


Эрсдэл: Мэдээлэл алдагдах, мэдээллийн системд халдлага хийсний улмаас үүсэх алдагдлын хэмжээгээр тодорхойлогдоно. Үнэт цаас гаргагч нь харилцагчдад зээл олгохдоо зөвхөн гар утасны аппликэйшнээр дамжуулан дижитал сувгаар олгож байгаа ба компанийн гол мэдээлэл, өгөгдлүүд нь цахим хэлбэрээр хадгалагдаж байна. Дижитал шилжилт нь бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмж, ажлын үр ашигт байдал зэргийг нэмэгдүүлж байгаа ч үүнийг дагаад мэдээлэл нь гаднын халдлагад өртөх эрсдэл мөн адил нэмэгдэж байна.

Эрсдэлийн удирдлага: Компанийн мэдээллийн аюулгүй байдлын алба нь мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллах, холбогдох эрсдэлд үнэлэлт өгөх зэрэг чиг үүргүүдийг хүлээдэг. Тус алба нь эрсдэлийг үнэлэх, удирдахын тулд гадны халдлага болон систем дэх засварлаагүй эмзэг байдлын тоог харгалзан үздэг ба гаднаас хандалтгүй программ хангамж, мэдээллийн системд өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн, засварлаагүй эмзэг байдлын тоог сард 30-с дээшгүй байлгах, амжилттай хийгдсэн кибер халдлагын тоог жилд 2-с дээшгүй байлгахгаар системийн найдвартай байдлыг ханган ажиллаж байна.

Хянан нийцүүлэлтийн эрсдэл

Эрсдэл: Хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт болон байгууллагын ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллаагүйн улмаас үүсэх алдагдлын хэмжээгээр тодорхойлогдоно. Компани нь хууль тогтоомж, дүрэм журмыг санаатай болон болгоомжгүй зөрчсөн тохиолдолд алданги торгууль ногдох, үйл ажиллагааны цар хүрээнд тодорхой хязгаарлалтууд тавигдах зэргээр компанийн үндсэн үйл ажиллагаанд сөрөг нөлөөллүүд бий болох эрсдэлтэй.

Эрсдэлийн удирдлага: Үнэт цаас гаргагчийн хууль эрхзүй комплаенсийн хэлтэс нь хууль, дүрэм журмын мөрдлөгийг хэрэгжүүлэн ажилладаг ба холбогдох эрсдэлийг үнэлэхдээ хууль, дүрмийн зөрчил, эрх бүхий байгууллагаас хариуцлага хүлээлгэсэн тохиолдлын тоо зэргийг харгалзан үздэг. 2022 оны гүйцэтгэлд хийсэн эрсдэлийн үнэлгээний тайлангийн дагуу хууль, дүрэм зөрчсөн тохиолдол болон эрх бүхий байгууллагаас хариуцлага хүлээлгэсэн тохиолдол гараагүй байна.



Эрсдэл: Үнэт цаас гаргагчийн өмнө гаргасан 20 тэрбум төгрөгийн бонд болон одоо гаргахаар төлөвлөж буй 15 тэрбум төгрөгийн бонд нь тусгайлсан барьцаа хөрөнгөөр баталгаажуулагдахгүй. Компанийн үйл ажиллагаа тасалдаж төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд барьцаа хөрөнгөөр баталгаажсан өр төлбөрүүд нь тухайн барьцаанд буй хөрөнгөөр түрүүлж төлөгдөх бөгөөд барьцаагүй өр төлбөрүүдийг компанийн үлдэгдэл хөрөнгөөр барагдуулах юм. Хэрэв үлдэгдэл хөрөнгө нь өр төлбөрүүдийг барагдуулж хүрэлцэхгүй тохиолдолд бондын эргэн төлөлт хийгдэхгүй байх эрсдэл үүсэж болзошгүй юм.

Эрсдэлийн удирдлага: Үнэт цаас гаргагч нь санхүү, төлбөрийн чадавхыг үнэлүүлэхийн тулд Монголын хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси ХХК-аар зээлжих зэрэглэлийн үнэлгээ хийлгэсэн бөгөөд тус эжинси нь үнэт цаас гаргагчийн зээлжих зэрэглэлийн бондын хугацаанд улирал тутам шинэчилж, үнэт цаас гаргагчид тайлагнах үүрэг хүлээсэн. Ингэснээр үнэт цаас гаргагч нь санхүү, төлбөрийн чадвартай холбоотой эрсдэл үүссэн тохиолдолд мэргэжлийн зөвлөгөө авч, тус эрсдэлд цаг алдалгүй хариу үйлдэл үзүүлэх боломжтой юм.

1.5.2 Эрсдэлийн удирдлагын бодлого

Ашид Капитал ББСБ-ын эрсдэлийн удирдлага болон хяналтын тогтолцоонд хамгаалалтын гурван бүсийн зарчмыг мөрдлөг болгон ажиллах бөгөөд энэ нь эрсдэлийн удирдлага, түүний хэрэгжилтэд хараат болон хараат бусаар хяналт тавих чиг үүргүүдийг тодорхойлоход оршино. Үүнд:

Хүснэгт 22. Хамгаалалтын гурван бүсийн зарчим

	Хамаарах нэгж	Чиг үүрэг
1	Хамгаалалтын нэгдүгээр бүс Бизнесийн нэгжүүд	<ul style="list-style-type: none"> Үйл ажиллагааны холбогдох бодлого, журмуудыг хэрэгжүүлэх, Эрсдэлийг үнэлэх, хянах, тайлагнах, Эрсдэлийг бууруулж ажиллах
2	Хамгаалалтын хоёрдугаар бүс Эрсдэлийн удирдлагын нэгж	<ul style="list-style-type: none"> Эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоог тодорхойлох, Болзошгүй эрсдэлийн төрлүүдийг тодорхойлох, Эрсдэлийн аппетитийг тогтоож хэрэгжилтийг хангуулж, хяналт тавих,
3	Хамгаалалтын гуравдугаар бүс Дотоод хяналтын нэгж	<ul style="list-style-type: none"> Нэг болон хоёрдугаар бүсийн эрсдэлийн удирдлагын үр дүнд хараат бус дүгнэлт өгөх, ТУЗ-д үр дүнг тайлагнах

Хамгаалалтын нэгдүгээр бүс эрсдэлийн аппетитийг хангаж ажиллах бөгөөд эрсдэлийн удирдлагын нэгж нь батлагдсан эрсдэлийн аппетитийн хэрэгжилтэд тогтмол хяналтыг хэрэгжүүлж, доорх байдлаар эрсдэлийн үзүүлэлт бүрийн эрсдэлийн түвшинг тайлагнаж ажиллана. Үүнд:





simple

Хүснэгт 23. Эрсдэлийн түвшин



Ногоон буюу хэвийн эрсдэлийн түвшин	Шар буюу дунд эрсдэлийн түвшин	Улаан буюу өндөр эрсдэлийн түвшин
Тухайн эрсдэлийн үзүүлэлтийн биелэлтэд холбогдох эрсдэлийн аппетитээс 10 нэгж хувиар доош байх үед	Тухайн эрсдэлийн үзүүлэлтийн биелэлт холбогдох эрсдэлийн аппетитээс доош байх үед	Тухайн эрсдэлийн үзүүлэлтийн биелэлт холбогдох эрсдэлийн аппетитийг давсан үед

Эрсдэлийн аппетит

ББСБ нь үйл ажиллагаандаа учирч болох эрсдэлийг удирдах, сэргийлэх, бууруулах, эрсдэлийн түвшинг доод буюу зохистой түвшинд байлгах, түүнийг хянах үүднээс эрсдэлийн аппетит буюу эрсдэлийг хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг тогтоон ажиллаж байна. 1.5.1 хэсэгт тодорхойлсон болзошгүй эрсдэлийн хувьд эрсдэлийн аппетит нь дараах байдалтай байна:

Хүснэгт 24. Эрсдэлийн аппетит

Эрсдэлийн төрөл	Эрсдэлийн үзүүлэлт	Эрсдэлийн аппетит [2023]
Зээлийн эрсдэл	Чанаргүй зээлийн багцад эзлэх хувь	< 10.0%
	60-аас дээш хоног хугацаа хэтэрсэн зээлийн багцад эзлэх хувь	< 11.5%
	30-аас дээш хоног хугацаа хэтэрсэн зээлийн багцад эзлэх хувь	< 13.0%
	Чанаргүй зээлд байгуулсан сангийн хувь	> 60%
Зээлийн төвлөрлийн эрсдэл	Нэг харилцагчид олгосон зээл	< 1bln
	Топ 20 зээлдэгчид олгосон зээл	< 14%
	Нэг холбогдох этгээдэд олгосон зээл	< 1bln
	Нийт холбогдох этгээдэд олгосон зээл	< 10%
	Бизнес, болон автомашины зээлийн нийт дүн зээлийн багцад эзлэх хувь	< 50%
	Цалингийн зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувь	> 45%
Гадаад валютын эрсдэл	Нэг этгээдэд байршуулсан эх үүсвэр	< 5bln
	Нийт гадаад валютын нээлттэй позиц өөрийн хөрөнгөнд харьцуулсан хувь	< ±15%
	Нэгж гадаад валютын нээлттэй позиц өөрийн хөрөнгөнд харьцуулсан хувь	< ±15%
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ	> 10%
	Нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээ	> 20%
Хөрвөх чадварын эрсдэл	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт	> 10%
Үйл ажиллагааны эрсдэл	Аудитаас өгсөн үнэлгээгээр дотоод хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой эрсдэл өндөр зөрчлийн тоо	< 25х/Жилд



	CBS, CSS, DMS, EP системүүдийн тасралтгүй ажилласан байх дундаж хувь	> 99.7%
	(Гадаад болон дотоод) Ашиглалтаас үүдэж учирсан шууд хохирлын дүн	< 10 сая төгрөг
	Үндсэн систем болон дэд системүүдийн хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөх алдаа	< 30х/Жилд
Мэдээллийн аюулгүй байдал	Гаднаас хандалттай программ хангамжид өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн, засварлагдаагүй эмзэг байдлын тоо	< 5х/Сард
	Гаднаас хандалттай мэдээллийн системд өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн, засварлагдаагүй эмзэг байдлын тоо	< 5х/Сард
	Гаднаас хандалтгүй программ хангамж, мэдээллийн системд өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн, засварлагдаагүй эмзэг байдлын тоо	< 30х/Сард
	Амжилттай хийгдсэн кибер халдлагын тоо	< 2х/Жилд
Ёс зүйн эрсдэл	Засаглалын үнэлгээний оноо	> 80
	Ёс зүйн асуудлаар аудитаас гаргасан дүгнэлтийн тоо	< 15/Жилд
	Өндөр эрсдэлийн зэрэглэлтэй харилцагчийн гомдлын тоо	< 5х/Сард
Хянан нийцүүлэлтийн эрсдэл	Холбогдох хууль, дүрэм зөрчсөн тохиолдлын тоо	< 1х/Жилд
	Эрх бүхий байгууллагаас хариуцлага хүлээлгэсэн тохиолдлын тоо	< 5х/Жилд

Стресс тест

Үнэт цаас гаргагч нь стресс тестийг урьдчилж тодорхойлогдсон цочролын сценариудад байгууллагын эрсдэл даах чадварыг үнэлж, хүлээж болзошгүй хохирлыг тодорхойлж, авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж ажиллана.

Цочролын сценариудыг хөнгөн болон хүнд уналтын гэсэн хоёр түвшинд авч үзэх бөгөөд сценари тус бүрд хүлээгдэж буй стресс тестийн үр дүнг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

- Хөнгөн уналтын цочролын сценарид байгууллагын эрсдэлийн аппитет зөрчигдөхгүй бөгөөд ашигт ажиллагаа эерэг байх;
- Хүнд уналтын цочролын сценарид зохицуулагч байгууллагын хязгаарлалт буюу эрсдэл даах чадвар зөрчигдөхгүй байх

Эрсдэлийн тайлагналт нь байгууллагын эрсдэлийн удирдлага, зохистой хяналтын тогтолцоо зохих ёсоор ажиллаж буй эсэхэд хяналт тавьж ажиллах бөгөөд эрсдэлийн удирдлагын нэгж нь эрсдэлийн тайланг бэлдэж, ТУЗ болон шаардлагатай бизнесийн нэгжүүдэд цаг алдалгүй тайлагнаж ажиллана.

СХУ
БҮРТГЭВ
№ 11

ХОЁР. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2.1.1 ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, НӨХЦӨЛ БАЙДАЛ

2022 он гарснаар Монгол Улсын эдийн засгийн гол түнш орон болох БНХАУ-д Тэг-Ковидын бодлогыг хэрэгжүүлж эхэлснээр том хот, мужуудад хөл хорио тогтоосон нь үйлдвэрлэл, худалдааны эргэлтийг бууруулах хөшүүрэг болсон. Энэ нь уул уурхайн экспортоос ихээхэн хамааралтай манай улсын өсөлтийг бууруулах үйл явдал болов. Түүнчлэн 2022 оны 2 дугаар сард гарсан ОХУ, Украйны дайны асуудлаар нийлүүлэлтийн тасалдал үүсэж, инфляцын түвшин нэмэгдэж, эдийн засгийн өсөлт удааширсан. Үүнтэй холбоотойгоор 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Монголбанкнаас бодлогын хүүг 13 хувь болгож шинэчилсэн ба 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдөр бодлогын хүүг 13 хувьд хэвээр хадгалах шийдвэр гарсан.


2022 оны 4 дүгээр улиралд ДНБ 17.6 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 29.4 хувиар өссөн үзүүлэлт юм. Цаашид уул уурхайн салбарын олборлолт болон экспорт тэлж, цар тахлын дараа үйлчилгээний салбар үргэлжлэн сэргэснээр 2023 онд 5.0 (хүснэгт 6) хувиар өсөх төлөвтэй байна.

Хүснэгт 25. Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Нэгж	2019	2020	2021	2022	2023-II
Бодит сектор						
ДНБ, оны үнээр	тэрбум төг.	36,898	36,958	43,555	52,867	30,496
ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр	тэрбум төг.	27,928	26,655	27,092	28,405	13,631
ДНБ-ний бодит өсөлт	хувь	5.1%	-5.3%	1.6%	4.8%	6.4%
Нэг хүнд ногдох ДНБ, оны үнээр	сая төг	11.8	11.6	13.3	16.1	
Мөнгөний сектор						
Мөнгө M1	тэрбум төг.	3,911	4,212	6,507	7,201.3	8,281.3
Мөнгө M2	тэрбум төг.	21,063.6	24,480.7	27,863.5	29,658.8	31,438.5
Төсвийн сектор						
Нэгдсэн төсвийн орлого	тэрбум төг.	10,905	9,421	12,689	18,600	11,059.3
Нэгдсэн төсвийн тэнцэл	тэрбум төг.	-756	-4,539	-2,908	-979.3	4,690
Гадаад валютын албан нөөц	сая ам.дол.	4,349	4,774	4,366	3,399	21,792
Засгийн газрын гадаад өр	сая ам.дол.	7,806	8,653	8,454	8,012	
Гадаад сектор						
Экспорт	сая ам.дол.	7,619	7,576	9,247	12,540	7,564
Импорт	сая ам.дол.	6,128	5,299	6,849	8,704	4,273
Төлбөрийн тэнцэл	сая ам.дол.	1,492	2,277	2,398	3,836	3,291
Гадаадын шууд хөрөнгө оруулалт	сая ам.дол.	3,131	2,560	2,714	2,544	
Хүүний түвшин						
Бодлогын хүү	%	11.0%	6.0%	6.0%	13.0%	13.0%
Инфляцын түвшин	%	5.2%	2.3%	13.4%	13.2%	10.6%
Хадгаламжийн хүү, жилээр	%	13.17%	12.2%	8.99%	12.43%	12.68%
Зээлийн хүү, жилээр	%	16.9%	16.9%	15.8%	15.7%	16.2%
Төгрөг ам.долларын албан ханш	төг.	2,734	2,849	2,849	3,444	3,432.6

Эх сурвалж: УСХ, Монголбанк

2022 онд эдийн засаг 4.8 хувиар өссөн нь салбарын тэгш бус өсөлт байсан буюу уул уурхай, олборлолтын салбар 11.9 хувиар буурч байхад зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ 33.8 хувиар өссөн.



2023.08.18

Гадаад худалдаа сэргэж байгаатай холбогдуулан Монгол улсын экспорт, импорт, төлбөрийн тэнцлийн хэмжээ жил бүр өсөн нэмэгдэж байгаа бөгөөд 2023 оны 2 дугаар улирал гэхэд экспортын хэмжээ 7,564 сая ам.долларт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.42 дахин өссөн ба БНХАУ-руу ачаа тээвэр саадгүй нэвтрэх болсонтой холбоотой.

График 21. Монгол Улсын нэрлэсэн ДНБ (их наяд төгрөгөөр) болон бодит ДНБ-ний өсөлт, хувиар



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Дэлхийн банк, ОУВС, АХБ-ны шинжээчид Монгол Улсын эдийн засгийг 2023 онд дунджаар 5 хувь, 2024 онд 6 хувиар сэргэнэ гэж таамаглаж байна.

Хүснэгт 26. Бодит ДНБ-ий өсөлтийн төсөөлөл, хувиар


	2023Т	2024Т
Дэлхийн банк	5.3%	6.4%
АХБ	5.4%	6.1%
ОУВС	4.5%	5.5%
Дундаж	5%	6%

Эх сурвалж: Дэлхийн банк, АХБ, ОУВС

Дунд хугацаанд инфляцыг 6 хувийн зорилтод түвшинд барина

2022 оны ОХУ, Украины дайн, эрчим хүчний үнийн өсөлт зэрэг асуудлаас үүдэн дэлхий даяар инфляцын түвшин өсөж, улмаар Монгол Улсын инфляцын түвшин дунджаар 14.6 хувь, Улаанбаатар хотын инфляцын түвшин дунджаар 15.2 хувьд хүрч байсан бол 2023 оны 2 дугаар улирлын байдлаар 10 хувьтай байна.

График 22. Инфляцын түвшин, хувиар



МОНГОЛЫН АЖ АХУЙН
БОНСОН ХАМГААГАХ
МОНГОЛЫН АЖ АХУЙН
2023-08-18

МОНГОЛЫН АЖ АХУЙН
БОНСОН ХАМГААГАХ
МОНГОЛЫН АЖ АХУЙН
2023-08-18

МОНГОЛЫН АЖ АХУЙН
БОНСОН ХАМГААГАХ
МОНГОЛЫН АЖ АХУЙН
2023-08-18

Эх сурвалж: Монгол Банк

2023.08.18

Монголбанк нь 2023 онд мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлж, инфляцын түвшнийг 6 хувийн зорилтод түвшинд тогтвортой барих бодлоготой байна. Инфляцын түвшин таамаглаж байснаас өндөр болсонтой холбогдуулан Монголбанкнаас мөнгөний хатуу бодлогыг үргэлжлүүлэн барих болно. Энэ нь эдийн засгийн удаашралтыг бий болгох тул хөрөнгө оруулагчид мөнгөний тогтвортой өсөлтийг бий болгох санхүүгийн хэрэгслийг илүүчлэх болно.

Монголбанк, ОУВС, АХБ-ны шинжээчид инфляцын түвшнийг 2023 онд дунджаар 10 хувь, 2024 онд дунджаар 8 хувьд хүрнэ гэж таамаглаж байгаа нь богино хугацаанд инфляцын түвшин буурах магадлалтайг харуулж байна.


Хүснэгт 27. Инфляцын төсөөлөл, хувиар

	2023Т	2024Т
Монгол Банк	7.8%	6.3%
АХБ	10.9%	8.7%
ОУВС	11.2%	8.8%
Дундаж	10%	8%

Эх сурвалж: Дэлхийн банк, Азийн Хөгжлийн Банк, Олон Улсын Валютын Сан

2023 оны эхний 6 сарын урьдчилсан гүйцэтгэлээр Монгол Улсын төсвийн орлого 11,059 тэрбум төгрөгт, төсвийн зарлага 9,034 тэрбум төгрөгт тус тус хүрч, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1,547.5 тэрбум төгрөг гарлаа. Нэгдсэн төсвийн орлого өсөлттэй байгаа нь засгийн газраас эдийн засгийг танах үйл ажиллагаа хийж байгаатай холбоотой.

График 23. Төсвийн тэнцэл, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

2023 оны 2 дугаар улирлын байдлаар Монгол Улсын нийт экспорт 7,564 сая ам.доллар, нийт импорт 14,274 сая ам.доллар байснаар гадаад худалдааны тэнцэл 3,291 сая ам.доллар байна.

График 24. Гадаад худалдааны тэнцэл, сая ам.доллаароор



2023.08.18



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо


Мөнгөний хатуу бодлогыг баримталж байна

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо мөнгөний бодлогын хүүг 2023 онд 13 хувьд барих төлөвлөгөөтэй байгаа нь инфляцын түвшнийг тогтворжуулж, зорилтод түвшинд авчрах юм. Энэ нь хадгаламжийн хүү нэмэгдэх суурь болж байгаа ба арилжааны банкнуудын хадгаламжийн дундаж хүү 12.3 хувьд хүрсэн нь мөнгөний нийлүүлэлт харилцах данснаас хадгаламж руу шилжих хүлээлтийг бий болгоод байна.

Долларын ханшийн нийлүүлэлтийн гаралтай өсөлт бий болоод байгаа нь 2020 оны 12 сараас хойших хамгийн өндөр үзүүлэлт юм. 2022 онд долларын ханш эрчтэй өсөж 1 ам.доллар 2,849.34 төгрөгөөс 3,444.6 төгрөгтэй тэнцэх болсон нь ойролцоогоор 20 хувийн өсөлт юм. АНУ-аас мөнгөний хатуу бодлого баримталж байгаа нь ам.долларын нийлүүлэлтийг бууруулж цаашид мөнгөний нийлүүлэлт дэх долларжилт нэмэгдэх хүлээлт үүсээд байна.

2022 онд мөнгөний нийлүүлэлт 29.7 их наяд төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 6.6 хувиар өссөн дүн буюу өнгөрсөн жилүүдийн өсөлтийн хувьтай харьцуулахад харьцангуй бага дүн юм. 2023 оны 2 дугаар улирлын байдлаар мөнгөний нийлүүлэлт 31.44 их наяд төгрөгт хүрч 2023 он гарснаас хойш 5 хувиар өссөн байна.

График 25. М2 мөнгөний нийлүүлэлт, их наяд төгрөгөөр



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо


2.1.2 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2018 оноос 2022 оны хооронд жилд дунджаар 28.7 хувиар өсжээ. 2022 оны жилийн эцсээр хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 6,890.4 тэрбум төгрөг хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 16.9 хувиар өссөн үзүүлэлт юм.

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2021 онд ДНБ-ий 13.9 хувьтай тэнцүү байсан бол 2022 оны жилийн эцсийн байдлаар 14.3 хувь болж өссөн.

ТОП-20 индекс 2018 оноос 2022 оны хооронд жилд дунджаар 15 хувиар өсөж, 2021 онд оройн цэг болох 49,252 нэгжид хүрсэн бол 2022 онд 37,566 нэгж болон буурч хаагджээ.


График 26. Зах зээлийн үнэлгээ болон Топ-20 индекс



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороо

Зах зээлийн үнэлгээ 2022 онд 6,890 тэрбум төгрөг болж өссөн хэдий ч хөрвөх чадвар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.8 хувиас 2.4 хувь болж буурсан байна. Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа буурснаар хөрвөх чадварын хувь мөн даган буурчээ.

График 27. Зах зээлийн үнэлгээ болон хөрвөх чадвар



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороо

2018 оноос 2022 оны хооронд Монгол улсын арилжааны идэвх жилд дунджаар 24 хувиар өсжээ. 2022 оны жилийн эцсээр арилжааны идэвх 580.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 59 хувиар буурсан үзүүлэлт юм.

График 28. Арилжааны идэвх



Handwritten signatures

2023.08.18



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороо

2.2 ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

2.2.1 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАХ ЗЭЭЛ

2022 оны байдлаар нийт санхүүгийн зах зээлийн нийт хөрөнгийн хэмжээ ойролцоогоор 57 их наяд төгрөгт хүрсэн. Үүнээс банкны салбарын хөрөнгө 46 их наяд төгрөг буюу 80.6 хувийг, хөрөнгийн зах зээл 6.9 их наяд төгрөг буюу 12.1 хувийг, ББСБ салбар 3.5 их наяд төгрөг буюу нийт зах зээлийн 6.1 хувийг, даатгалын салбар 474.9 тэрбум төгрөг буюу 0.8 хувийг, үлдсэн 187.5 тэрбум төгрөг буюу 0.3 хувийг хадгаламж зээлийн хоршооны салбар бүрдүүлсэн.

График 29. Санхүүгийн салбарын бүтэц (2022 он)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, Санхүүгийн Зохицуулах Хороо


ББСБ-ын салбар нь 2013 оноос эхлэн хурдацтай хөгжиж байна. 2015-2022 онуудад Монгол Улсын эдийн засгийн жигнэсэн нийлмэл өсөлт дунджаар 12.7 хувийн өсөлт үзүүлсэн бол ББСБ салбарын дунджаар 31.9 хувь өсөж бодит эдийн засгаас өндөр өсөлт үзүүлсэн байна.

Харин 2023 оны 2 дугаар улирлын байдлаар СЗХ-оос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр нийт 522 ББСБ үйл ажиллагаагаа явуулж байгаа ба энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5 хувиар буурсан үзүүлэлт юм. Харин харилцагчдын тоо давхардсан байдлаар 3.9 саяд хүрсэн нь өнгөрсөн жилээс 18 хувиар буурсан үзүүлэлт байна.

График 30: ББСБ салбарын тоо, харилцагчдын тоо



2023.08.18



Эх сурвалж: СЗХ, ББСБ салбарын тайлан 2022

Активын бүтэц: 2022 онд ББСБ салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 30 хувь өсөж, 3.5 их наяд төгрөгт хүрсэн. Хөрөнгийн дүнд цэвэр зээл 73%, мөнгөн хөрөнгө 13.9 хувь, эргэлтийн бус хөрөнгө 3.2 хувь, бусад хөрөнгө 10 хувь тус тус бүрдүүлжээ. Мөн хамгийн өндөр активтай 20 ББСБ нь салбарын нийт активын 51.1 хувь, нийт зээлийн 52.8 хувь бүрдүүлж байгаа нь томоохон хэмжээтэй ББСБ-ууд салбарын дийлэнх үзүүлэлтийг бүрдүүлж байгааг илтгэж байгаа юм.


График 31: ББСБ салбарын хөрөнгийн бүтэц, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: СЗХ, ББСБ салбарын тайлан 2022

ББСБ-ын салбарын нийт зээлийн үлдэгдэл 2022 оны эцэст өмнөх оны дүнгээс 35 хувь өсөж 2.7 их наяд төгрөгт хүрсэн нь нийт хөрөнгийн 77 хувьтай тэнцэж байна. Харин цэвэр зээлийн хэмжээ 2.57 их наяд төгрөг юм. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ эдийн засгийн уналттай он жилүүд болох 2015-2016 онуудад өсөж хамгийн өндөр түвшин буюу 15 хувь хүрч байсан бол 2017-2018 онуудын эдийн засгийн сэргэлтийн үеүдэд буурч, 2019 онд 9 хувь болсон. 2020 онд эдийн засгийн хүндрэл, иргэдийн зээл төлөх, худалдан авах чадвар буурснаар чанаргүй зээлийн хувь эргэн өсөж 10% давсан юм.


Харин 2021 оны эцэст чанаргүй зээлийн хэмжээ 7 хувь, нийт чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ 9.5 хувь болоод байсан. 2022 оны дүнгээр чанаргүй зээлийн хэмжээ 7.6 хувь, нийт чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ 11.5 хувь



2023.08.18

болоод байна. 2023 оны 2 дугаар улирлын байдлаар чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хэмжээ 7.6 хувь хэвээр байна.

График 32: ББСБ салбарын нийт зээл, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: УЦХ, СЗХ

Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх зээлдэгчдийн ангиллыг авч үзвэл 88.2 хувь нь иргэд, 11.8 хувь нь хуулийн этгээдэд олгосон зээл байна. Зээлийн зориулалтын хувьд томоохон салбарууд нь 7.7 хувийн барилга, 12.1 хувийн бөөний болон жижиглэн худалдаа, 3.4 хувийн байр сууц, хоол хүнсээр үйлчлэх үйлчилгээ, 3.5 хувь нь машин мотоциклын засвар үйлчилгээнд олгогдсон байна.

График 33: ББСБ салбарт олгогдсон зээлийн хугацаа, сараар




Эх сурвалж: СЗХ, ББСБ салбарын тайлан 2022

Тайлант хугацаанд олгогдсон зээлүүдийг хугацаагаар нь харвал 1-2.5 жилийн хугацаатай олгогдсон зээл хамгийн их хувийг эзэлж байна. Мөн 1 сар хүртэл хугацаатай зээл нийт олгогдсон зээлийн 28 хувийг бүрдүүлж байгаа бол 5-аас дээш жил буюу урт хугацаатай зээлүүд бага байна.

Пассивын бүтэц: ББСБ-ын салбарын өөрийн хөрөнгийн хэмжээ 2016-2021 оны хооронд жилд дунджаар 30 хувийн өсөлтийг үзүүлж, 2022 оны эцэст 2.19 их наяд төгрөгт хүрсэн байна. Нийт салбарын хөрөнгийн эх үүсвэрийн 62.1 хувийг эздийн өмч, 37.9 хувийг өр төлбөр бүрдүүлж байна.

График 34: ББСБ салбарын эх үүсвэрийн бүтэц, тэрбум төгрөгөөр





Эх сурвалж: СЗХ, ҮСХ

Итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн болон дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан өр төлбөр нийт хөрөнгийн 22 хувьтай тэнцэж байна. Харин өрийн бичиг 6.5 хувь байна.

Дотоодын байгууллагаас авсан санхүүжилт 79.4 хувь, гаднын байгууллагаас татсан санхүүжилт 20.6 хувь. Мөн санхүүжилтийн дийлэнх нь буюу 77 хувь нь төгрөгөөр, үлдсэн нь гадаад валютын санхүүжилт байна. Хугацааны хувьд урт хугацаат санхүүжилт 58.4 хувь байна.

2.2.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

2023 оны 2 дүгээр улирлын байдлаар ББСБ-уудын нийт хөрөнгийн хэмжээ 3,945.9 тэрбум төгрөг хүрсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 24 хувиар, нийт өөрийн хөрөнгийн хэмжээ 2,316.3 тэрбум төгрөг хүрч 24.2 хувиар, нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 2,468.1 тэрбум төгрөг хүрч 25.8 хувиар, нийт зээл 3,107.5 тэрбум төгрөг хүрч 24.4 хувиар өсжээ. Харин нийт орлогын хэмжээ 520.2 тэрбум төгрөг хүрч 32.7 хувиар, нийт зарлагын хэмжээ 331.1 тэрбум төгрөг хүрч 36.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 28. Салбарын санхүүгийн үзүүлэлтүүд, 2023 оны 2 дугаар улирлын байдлаар

	Салбар	Ашид Капитал ББСБ ХХК
Ашигт ажиллагаа		
Цэвэр ашгийн маржин	36.4%	44.88%
Өөрийн хөрөнгийн өгөөж	8.5%	5.05%
Зээлийн багцын чанар		
Хэвийн зээл	89.2%	84.76%
Хугацаа хэтэрсэн зээл	3.3%	4.02%
Чанаргүй зээл	7.6%	11.22%
Зээлийн эрсдэлийн сан/Нийт зээл	5.9%	7.95%
Хөрвөх чадвар		
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	258%	404%
Өрийн харьцаа		
Өр хөрөнгийн харьцаа	24.5%	24.46%
Өр өөрийн хөрөнгийн харьцаа	32.3%	32.38%

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо



2023.08.18

2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 3.2 их наяд төгрөгийн олгосон зээл, 2.8 их наяд төгрөгийн төлөгдсөн зээл, 3,107.5 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 24.4% буюу 609.7 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй байна.

Олгосон нийт зээлийн 90.4 хувийг иргэдэд, 9.6 хувийг хуулийн этгээдэд олгосон бол 90.8 хувь нь иргэдээс, 9.2 хувь нь хуулийн этгээдээс эргэн төлөгдсөн.

Хүснэгт 29. Олгосон болон төлөгдсөн зээл, тэрбум төгрөгөөр

Зээлийн ангилал	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
Иргэнд олгосон зээл	2.89	90.4%	2.54	90.8%	2.73	88.2%
Хуулийн этгээдэд олгосон зээл	0.31	9.6%	0.26	9.2%	0.37	11.8%
Нийт	3.2	100%	2.8	100%	3.1	100%

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

2023 оны 2 дугаар улирлын байдлаар нийт иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 2.89 их наяд төгрөг байснаас 64 хувь нь хэрэглээнд зориулсан зээл, 36.4 хувийг бусад зээл эзэлж байна.

График 35. Иргэнд олгосон зээлийн үлдэгдлийн ангилал




Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

Үнэт цаас гаргагч нь голчлон онлайнаар хэрэглээний, бизнесийн, болон автомашины зээл олгодог. Онлайн зээл нь уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож, техник технологийн шинэчлэлийг авчирсан. 2023 оны 2 дугаар улирлын байдлаар онлайн зээлийн үйлчилгээ үзүүлдэг 42 ББСБ-ууд байна. Эдгээрээс 6 ББСБ-ууд нь зөвхөн технологид суурилсан бол 36 ББСБ-ууд нь технологи болон уламжлалт зээл олгох үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 30. Цахим зээл олгодог ББСБ-уудын жагсаалт

Финтек	Аппликэйшн нэр
1 Ашид капитал	Simple, Simple-Agent
2 Соно финтек	Sono Mongolia
3 Мобифинанс	Monpay
4 Тус финтек	TUS Fintech
5 Инвескор хэтэвч	Pocket
6 Кэйш Флов финанс	tugrug app

ATAARB2 X 6105572
9022010567



2023.08.18

7	Смарткапитал фонд	My Credit
8	Лэндмн	LendMN
9	Инвексор	Pocket
10	Сэндли	Hi-PayMerchant, Hipay, Sendly
11	Нөмөр кредит	numur
12	Таван богд финанс	PayOn.mn
13	Ард кредит	Ard
14	Нэт капитал финанс корпораци	Net app
15	Омни капитал	Moni Digital
16	Бизнес-Инвест девелопмент	БИД app
17	Хатан суудал инвест	Zeely
18	Ньюстар финанс	Nsf.mn, Lite+
19	Очир ундраа ОМЗ	Opay
20	ТОКИ	Toki
21	Энт кредит инвестмент	EntcreditMN
22	Гэрэлфинанс	Gerel
23	Говьфинанс	CashOne Lite, CashOne
24	Цогзолфинанс	Pocket
25	Мөнгөнзоос кредит	Pocket
26	Грийн финтек	t finance, green fintech
27	Централ капитал	kmobi
28	Жи Эс Би Капитал	GSB Prime, Mongolchat
29	Грийн-Инвестмент	Gate.mn
30	Зээл Эм Эн платформ	Zeel.mn
31	Хас хаан	ХАСХААН
32	Нанокапитал	Nano Capital
33	Монголиа импакт финанс	Qmoni
34	Начин заан финанс	Naizly
35	Фин экспресс	Finex
36	Өсөх ундарга финанс	ufinance
37	Нэмэх төгрөг	Most Money
38	Онч-Энх	Ugloo
39	Жи Би Си Си	E-zeel

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

2023 оны 2 дугаар улирлын байдлаар нийт ББСБ-уудын олгосон цахим зээлийн үлдэгдэл 515.2 тэрбум төгрөг байна. Цахим зээлийн үлдэгдэл нийт зээлийн үлдэгдлийн 16.6 хувьтай тэнцэж байгаа нь бага дүн хэдий ч цахим зээл авч буй зээлдэгчийн тоо хэмжээг харвал тус зээлийн эргэлт өндөр байгааг илэрхийлж байна.

Хүснэгт 31. Зээлийн ангилал

	Зээлийн дүн /тэрбум төгрөг/	Эзлэх хувь	Зээлдэгчийн тоо	Эзлэх хувь	Дундаж зээл /мян.төгрөг/
Уламжлалт	2,592.3	83.4%	300,650	22.7%	8,622.1
Цахим зээл	515.2	16.6%	1,021,676	77.3%	504.3
Нийт зээл	3,107.5	100.0%	1,322,326	100%	2,350.0



Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

Нийт цахимаар олгосон зээлийн 90 хувь нь хэвийн зээл, 3.1 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 6.9 хувь нь чанаргүй зээл байна.

График 36. Цахимаар олгосон зээлийн багцын ангилал



2023.08.18



- Хэвийн зээл
- Хугацаа хэтэрсэн зээл
- Чанаргүй зээл

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо



Handwritten signatures

СЭХ
БҮРТГЭЭ
№ 01

ГУРАВ. БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

Бүтээгдэхүүн
Төрөл
Төрөл
Төрөл

3.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ДУНД ХУГАЦААНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

Үнэт цаас гаргагч нь хэрэглээний шинжтэй санхүүгийн хэрэгцээг хангах бичил зээлийг, тодорхой үе шаттайгаар дэвшилтэт технологи дээр суурилж, хууль эрх зүйн хүрээнд нэвтрүүлж, иргэдийн санхүүгийн харилцааг хялбарчлах, хүртээмжтэй болгох зорилготойгоор ажилладаг. Ирээдүйд үйл ажиллагаагаа улам тэлж, финтекийн дэвшилтэд шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг Монгол улсад нэвтрүүлэн санхүүгийн салбарт хувь нэмрээ оруулан ажиллах төлөвлөгөөтэй байна.

Бүтээгдэхүүн, үйл ажиллагааны төлөвлөгөө

Ашид Капитал ББСБ ХХК нь эдүгээ дижитал зээл, иргэдийн цалингийн зээл, жижиг дунд бизнесийн зээл, автомашины зээл, худалдан авалтын зээл зэрэг зээлийн бүтээгдэхүүнүүдийг хэрэглэгчдэд санал болгож байна. Цаашид эдгээр бүтээгдэхүүн үйлчилгээнүүдээ улам төгөлдөржүүлж, автоматжуулах бөгөөд шинээр итгэлцэл, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнийг Монгол Улсын санхүүгийн зах зээлд нэвтрүүлэх стратегийн зорилттой.



График 37. Зээлийн үйлчилгээний төрөл



Маркетингийн төлөвлөгөө

Үнэт цаас гаргагч нь зах зээл дээрх байр сууриа нэмэгдүүлэх зорилготойгоор маркетинг, менежментээ сайжруулж харилцагчдынхаа итгэл даасан эрхэм сонголт байхыг зорино. Мөн харилцагчийн эрэлт хэрэгцээнд нь нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэхээс гадна санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд анхаарна.

График 38. Маркетингийн стратеги





Менежментийн төлөвлөгөө



Ажилчдын ажлын байранд хэрэглэгдэх ур чадварууд болох өөрчлөлтөд дасан зохицох, гүйцэтгэлийг удирдах, манлайлах, үр дүнтэй харилцаа холбоо тогтоох, харилцааны ур чадвар, мэргэжлийн ур чадвар, төлөвлөх зохион байгуулах чадвар, асуудлыг шийдэх болон дүгнэлт хийх чадвар, шийдвэр гаргах чадвар, стратеги сэтгэлгээний чадвар, байгууллагыг манлайлах чадвар зэргийг хөгжүүлэх зорилт тавьсан ба байгууллагын зүгээс ажлын байранд болон танхимын тасралтгүй сургалт, хөгжлийн үйл ажиллагааг зохион байгуулж хувь хүний болон хамт олны хувьд өөрийгөө хөгжүүлэх, сурч боловсрох боломжийг бүрдүүлэхэд анхаарч ажиллана.

Хөрөнгө оруулалт, системийн төлөвлөгөө

Ашид Капитал ББСБ ХХК нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд заасан шаардлагуудыг бүрэн хангаж ажиллах чадамж, олон улсын шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлж үйл ажиллагаандаа БНЭУ-ын Infosys компанийн Finacle банкны суурь бүртгэлийн систем, БНСУ-ын Lenddo компанийн зээлийн үнэлгээний систем, БНЭУ-ын Ameyo харилцагчийн дуудлагын үйлчилгээний систем, Alfresco бичиг баримт хөтлөлтийн системийг тохируулж, нэвтрүүлэн ажиллаж байна.

Үйл ажиллагааны суурь бүртгэлд ашиглаж буй Finacle систем нь санхүүгийн байгууллагын хэрэгцээ шаардлагатай уялдуулан нэмэлт модуль, боломжуудыг тохируулан, өргөтгөх боломжтой, банк санхүүгийн үйлчилгээг өөрийн салбараар болон бусад систем, сувгуудтай холбох, нэгтгэх замаар харилцагчдад хүргэх боломжтой дэлхийн зах зээл дээр тэргүүлэгч банкны суурь систем юм.


Finacle системийг одоогоор 94 гаруй улсын 450 гаруй банк, санхүүгийн байгууллагууд суурилуулан ашиглаж байна. Дээрх системийг суулгаж ажиллуулах сервер (Hyperconverged Infrastructure буюу HCI), нөөцлөлт (Dell EMC - Data Domain), сүлжээ (Cisco), нууцлал хамгааллын (Fortinet) хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт шийдэл, тоног төхөөрөмжүүдийг ашиглаж байгаа бөгөөд олон улсын Telecommunications Industry Association (TIA) 942 стандартын Tier 3 түвшний шаардлагыг хангасан Юнител ХХК-ийн дата төв дээр байршуулан ажиллуулж байна. Уг төв нь тасралтгүй ажиллах горимтой ба цахилгаан, агааржуулалт, хөргөлт, харилцан холболтын үндсэн болон нөөц эх үүсвэр, хуурай аргаар гал унтраах автомат систем болон гал, ус, шилэн кабель, IT тоног төхөөрөмжийн 24x7x365 хяналтын систем бүхий сүүлийн үеийн дата төв юм.

3.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТӨСӨӨЛӨЛ

Андеррайтер нь үнэт цаас гаргагчийн түүхэн санхүүгийн үзүүлэлт, үнэт цаас гаргагчийн өөрсдийн төсөөллийг авч үзсэний үндсэн дээр доорх санхүүгийн байдлын төсөөллийг хийсэн болно.

Активын төсөөлөлд ашигласан таамаглалууд:

- ❖ Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тодорхойлохын тулд "төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаан үзүүлэлт 8 хувиас багагүй байх шалгуурыг баримталсан ба, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл болон зээлийн багцын өсөлт нь хоорондоо урвуу хамааралтай юм. Үнэт цаас гаргагч нь мөнгөн хөрөнгө шаардлагатай болсон үеүдэд зээл олголтыг танах, итгэлцлийн үйлчилгээг татах зэргээр мөнгөн хөрөнгийн зөв менежментийг тасралтгүй хийх шаардлагатай.
- ❖ Богино хугацаат хөрөнгө оруулалт: Үнэт цаас гаргагч нь биржийн бус зах зээлийн бондуудад хөрөнгө оруулалт хийсэн байгаа ба 2023 онд 4.2 тэрбум төгрөг, түүнээс цааш 10 хувиар өсөхөөр таамаглав. Богино хугацаат хөрөнгө оруулалтыг "төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаан" үзүүлэлтийг тооцоход оруулж тооцоогүй.





- ❖ Зээлийн багц нь органик өсөлтөөр өсөхөөс гадна тухайн жилд татан төвлөрүүлсэн бондыг зээлийн багц болгон гаргаж зээлийн үйл ажиллагааг тэлэхээр тооцоолсон. Харин бонд эргүүлэн төлөх шаардлагатай үеүдэд зээлийн багцыг танах шаардлагатай. Зээлийн багцын ангиллыг 2023 оны 1 дүгээр улирлын өгөгдөлд үндэслэн:
 - Энгийн зээл 85 хувь
 - Хугацаа хэтэрсэн зээл 4 хувь
 - Чанаргүй зээл 11 хувь байхаар тооцоолсон.
 Түүнчлэн үнэт цаас гаргагчийн тооцоогоор 2023 оны эцэст Симтп ассет ТЗК татан буугдахад ойролцоогоор 525 сая төгрөгийн зээлийн багц балансад шилжиж ирэхээр таамаглагдаж байна.
- ❖ Бусад авлагыг өнгөрсөн үеийн дунджаар буюу тайлант үеийн хүүгийн орлогын 15.1 хувь байхаар тооцоолсон.
- ❖ Бусад хөрөнгийг өнгөрсөн үеийн дунджаар буюу тайлант үеийн хүүгийн орлогын 4.75 хувь байхаар тооцоолов.
- ❖ 2023 оны төгсгөлд ТЗК татан буугдах үед охин компанид оруулсан хөрөнгө оруулалт буюу 1.0 сая төгрөгийг балансаас хасна. ТЗК-аас 525 сая төгрөгийн зээлийн багц шилжиж ирнэ. Гэвч ТЗК нь 1.28 тэрбум төгрөгийн хуримтлагдсан алдагдалтай хаагдахаар хүлээгдэж байгаа тул эдгээрийн цэвэр зөрүү буюу 756.5 сая төгрөгөөр орлогын тайлан дээр охин компани татан буулгасны гарз бүртгэгдэх юм.
- ❖ Уг тооцооллоор 2023 онд үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө өмнөх оноос 22.7 хувиар өсөж 211.3 тэрбум төгрөг болно.
- ❖ Голлох үзүүлэлтүүд:

	2023F	2024F	2025F	2026F
Цэвэр зээлийн өсөлт	35.5%	15.5%	10.4%	-10.9%
Нийт хөрөнгийн өсөлт	22.7%	15.6%	10.8%	-10.5%
Цэвэр зээлийн нийт хөрөнгөд эзлэх хувь	88.32%	88.27%	87.94%	87.60%
Чанаргүй зээлийн хувь	10.97%	11.00%	11.00%	11.00%

Хүснэгт 32. Санхүүгийн тайлангийн төсөөлөл, актив

Хөрөнгө (сая төгрөгөөр)	2022 бодит	2023F	2024F	2025F	2026F
Мөнгөн хөрөнгө	28,531.6	8,832.0	10,003.7	11,071.8	7,510.8
Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	3,000.0	4,200.0	4,620.0	5,082.0	5,590.2
Зээл /цэврээр/	137,694.4	186,583.3	215,472.9	237,856.8	212,031.9
Нийт зээл	145,232.0	202,209.3	241,988.4	278,286.6	267,155.2
Хэвийн зээл	127,267.5	171,956.6	205,690.1	236,543.6	227,081.9
Хугацаа хэтэрсэн зээл	5,046.6	8,067.4	9,679.5	11,131.5	10,686.2
Чанаргүй зээл	12,917.8	22,185.3	26,618.7	30,611.5	29,387.1
Хэвийн бус зээл	3,229.5	5,546.3	6,654.7	7,652.9	7,346.8
Эргэлзээтэй зээл	6,420.9	11,092.6	13,309.4	15,305.8	14,693.5
Муу зээл	3,267.4	5,546.3	6,654.7	7,652.9	7,346.8
(Зээлийн эрсдэлийн сан)	7,537.6	15,626.0	26,515.4	40,429.8	55,123.3

(Зээлийн эрсдэлийн сан)



Бусад авлагууд	1,891.8	7,468.5	8,994.4	10,437.1	10,253.3
Бусад хөрөнгө	291.7	2,344.8	2,823.9	3,276.8	3,219.1
Эргэлтийн хөрөнгийн нийт дүн	171,409.5	209,428.7	241,914.9	267,724.6	238,605.2
Үндсэн болон биет бус хөрөнгө	762.0	1,831.6	2,197.9	2,747.3	3,434.2
Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	1.0	-	-	-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	763.0	1,831.6	2,197.9	2,747.3	3,434.2
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	172,172.5	211,260.2	244,112.8	270,471.9	242,039.3

Эх үүсвэрийн төсөөлөлд ашигласан таамаглалууд:

- ❖ Өрийн бичиг: Үнэт цаас гаргагч нь одоогоор 35.0 тэрбум төгрөгийн ББЗЗ дээр гаргасан өрийн бичигтэй ба эдгээр бонд нь 2023 онд багтаж дараах хуваариар төлөгдөнө. Эдгээрийг төлсний дараа өөрийн хөрөнгийн багтаамжид үндэслэн шинээр бонд татан төвлөрүүлснээр жилийн эцэст 55.0 тэрбум төгрөгийн нээлттэй бондын үлдэгдэлтэй байхаар тооцоолж байна.

	2023.06	2023.08	2023.09	2023.10
Хуучин бонд эргүүлэн төлөх	10,000.0	8,000.0	8,000.0	9,000.0
Шинээр бонд татах	20,000.0	13,000.0		22,000.0

Харин 2023 онд татан төвлөрүүлсэн нийт 55.0 тэрбум төгрөгийн бондыг 2024 онд эргүүлэн төлснөөр 60.0 тэрбум төгрөгийн бонд дахин татан төвлөрүүлэхээр төсөөллөө. Уг 60.0 тэрбум төгрөгийн бондыг 2 жилийн хугацаатай гаргаж 2026 онд эргүүлэн төлөх ба үүний тулд зээл олголтыг бууруулах, итгэлцлээр эх үүсвэр татах шаардлагатай байна.

- ❖ Үнэт цаас гаргагч нь 2023 оны 5 дугаар сард итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл авсан ба 2023 оны сүүлийн хагас жилээс эхлэн итгэлцэл татан төвлөрүүлэхээр тооцооллоо. Итгэлцлийн үйлчилгээний өөрийн хөрөнгөд эзлэх хувийг эхний жилүүдэд харьцангуй багаар тооцоолсон ба жил бүр өссөөр 2027 онд өөрийн хөрөнгийн 80 хувьд хүрнэ гэж тооцоолж байна.
- ❖ Үнэт цаас гаргагч нь толгой компани болох М-Си-Эс Холдинг ХХК-иас 50.0 тэрбум төгрөгийн хоёрдогч өглөг авч ашигласан ба уг өглөг нь 2027 оноос эхлэн нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөд хөрвөнө. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмын дагуу бонд болон итгэлцлийн зохистой харьцааг тооцохдоо уг дүнг өөрийн хөрөнгөд оруулж тооцно.
- ❖ Богино хугацаат зээлийг өөрийн хөрөнгийн 3 хувиар тооцов.
- ❖ Орлогын албан татварын өрийг түүхэн үзүүлэлтэд үндэслэн хүүгийн орлогын 0.99 хувиар тооцов.



2023.08.18

Хүснэгт 33. Санхүүгийн тайлангийн төсөөлөл, пассив

Эх үүсвэр (сая төгрөгөөр)	2022 Бодит	2023F	2024F	2025F	2026F
Нээлтэй болон хаалттай өрийн бичиг	49,947.9	55,000.0	60,000.0	60,000.0	-
Худалдааны ба бусад өглөг	10,054.8	2,074.0	2,430.1	2,820.5	3,190.5
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	-	34,566.7	50,221.4	62,991.1	81,890.2
Орлогын албан татварын өглөг	360.0	486.2	459.1	643.9	607.8
Богино хугацаат өр төлбөрийн дүн	60,362.7	92,126.9	113,110.5	126,455.4	85,688.5
Хоёрдогч өглөг	50,000.0	50,000.0	50,000.0	50,000.0	50,000.0
Урт хугацаат өр төлбөрийн дүн	50,000.0	50,000.0	50,000.0	50,000.0	50,000.0
Нийт өр төлбөрийн дүн	110,362.7	142,126.9	163,110.5	176,455.4	135,688.5
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ					
Хувьцаат капиталын дүн	55,000.0	55,000.0	55,000.0	55,000.0	55,000.0
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	6,809.8	14,133.3	26,002.2	39,016.5	51,350.9
Эзэмшигчдийн өмчийн дүн	61,809.8	69,133.3	81,002.2	94,016.5	106,350.9
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	172,172.5	211,260.2	244,112.8	270,471.9	242,039.3



График 39. Харьцаа үзүүлэлт

Орлого, үр дүнгийн тайланд ашигласан таамаглалууд:

Хүүгийн орлого нь банк санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламжийн хүү, зээлийн хүү, зээл судалсны шимтгэлээс бүрдэх ба орлогын дийлэнх нь зээлийн хүүгээс орж ирдэг. Зээлийн хүүгийн орлогыг 2022 оны үзүүлэлтэд үндэслэн нийт зээлийн багцын 22.2 хувьтай тэнцүү дүнгээр тооцлоо. Үнэт цаас гаргагчийн 2023 оны 1 дүгээр улирлын мэдээгээр

ATA6284 6105572
902201062

MANDAL CAPITAL
LLC
ШТК0162 9021070414 76

Golo Capital
Dedicated diversity

2023.08.18

зээлийн жигнэсэн дундаж сарын хүү 2.4 хувь бөгөөд зээлийн хүүг нэмэгдүүлснээр хүүгийн орлогоо нэмэгдүүлэх боломжтой.

- ❖ 2023 онд шинээр гаргах 55.0 тэрбум төгрөгийн өрийн бичгийн хүүг жилийн 18 хувиар, 2023 онд төлөгдөх 35.0 тэрбум төгрөгийн хаалттай бондын хүүг жилийн 13 хувиар тооцов.
- ❖ Хоёрдогч өглөгт жилийн 13 хувь хүүгийн зардал төлнө.
- ❖ Арилжааны орлогыг богино хугацаат хөрөнгө оруулалтын балансын үлдэгдэл дүнгийн 20 хувиар (20 хувь өгөөжтэй хөрөнгө оруулалт) тооцсон.
- ❖ Боловсон хүчний зардлыг хүүгийн орлогын 7-9 хувь байхаар тооцсон бол бусад зардлыг хүүгийн орлогын 10-12 хувь байхаар тооцоолов.

Хүснэгт 34. Орлогын тайлангийн төсөөлөл

Орлогын тайлангийн төсөөлөл (сая төгрөгөөр)	2022 Бодит	2023F	2024F	2025F	2026F
Хүүгийн орлого	34,521.2	49,363.8	59,449.4	68,984.7	67,769.8
Банк санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламжийн хүү	969.1	2,455.4	3,192.0	4,149.6	5,394.5
Харилцагчид олгосон зээлийн хүү	32,175.3	44,890.5	53,721.4	61,779.6	59,308.4
Зээл судалсны шимтгэл	1,376.8	2,018.0	2,536.0	3,055.5	3,066.9
Хүүгийн зардал	12,451.8	23,366.6	23,404.9	25,803.8	24,365.2
Богино хугацаат зээлийн хүүгийн зардал	3.7	-	-	-	-
Өрийн бичгийн хүүгийн зардал	12,425.0	13,883.3	10,125.0	10,800.0	6,810.0
Хоёрдогч өглөгийн хүүгийн зардал	23.1	6,500.0	6,500.0	6,500.0	6,500.0
Компани хоорондын өглөгийн зардал	-	650.0	-	-	-
Итгэлцлийн хүүгийн зардал	-	2,333.2	6,779.9	8,503.8	11,055.2
Цэвэр хүүгийн орлого	22,069.4	25,997.3	36,044.5	43,180.9	43,404.6
Цэвэр хүүгийн орлогын ахиуц	64%	53%	61%	63%	64%
Хүүгийн бус орлого	10.6	1,086.8	1,221.2	1,361.3	1,456.9
Арилжааны цэвэр орлого	-	840.0	924.0	1,016.4	1,118.0
Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого	10.6	246.8	297.2	344.9	338.8
Санхүүгийн үйлчилгээний шимтгэл	-	-	-	-	-
Хүүгийн бус зардал	6,621.7	8,391.9	10,451.2	13,162.3	13,608.2
Арилжаа болон ханшийн тэгшитгэлийн зардал	-	-	47.6	55.2	54.2
Боловсон хүчний холбогдолтой зардал	2,764.7	3,455.5	4,458.7	5,518.8	5,760.4
Бусад зардал	3,857.0	4,936.4	5,944.9	7,588.3	7,793.5
Валютын ханшийн зөрүүний (гарз) олз	-	-	-	-	-
Цэвэр хүүгийн орлого/зардлын дүн	(6,611.1)	(7,305.0)	(9,230.0)	(11,801.0)	(12,151.3)

ATAA882 4 810357
05225018

77


МАНДАЛ КЭПИТАЛ
MARKETS YUK ХХА
БУСАЛ КЭПИТАЛ
MARKETS YUK
LLC

Голм Кэпитал Маркетс ХХА

2023.08.18

Сан байгуулахаас өмнөх үйл ажиллагааны ашиг/алдагдал	5,458.3	18,692.2	26,814.5	31,380.0	31,253.3
Үйл ажиллагааны ашгийн ахиуц	45%	38%	45%	45%	46%
Болзошгүй эрсдэлийн сангийн зардал	6,111.1	8,088.4	10,889.5	13,914.3	14,693.5
Үндсэн үйл ажиллагааны ашиг/алдагдал	9,347.2	10,603.8	15,925.1	17,465.6	16,559.8
Үндсэн бус үйл ажиллагааны орлого, олз	0.4	31.0	37.3	46.0	42.5
Үндсэн бус үйл ажиллагааны зардал, гарз	5.5	871.4	138.3	160.5	157.7
Ердийн үйл ажиллагааны ашиг/алдагдал/	9,342.0	9,763.5	15,824.0	17,351.2	16,444.6
Орлогын татварын зардал	873.4	2,440.0	3,955.1	4,336.9	4,110.3
Цэвэр ашиг	8,468.7	7,323.5	11,868.9	13,014.3	12,334.4

График 40. Хүүгийн орлого болон цэвэр ашгийн өсөлт



Хүснэгт 35. Мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөлөл:

Мөнгөн гүйлгээний тайлан (сая төгрөг)	2023F	2024F	2025F	2026F
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ				
Цэвэр ашиг	7,323.5	11,868.9	13,014.3	12,334.4
Нийт зээлийн өсөлт	56,977.3	39,779.1	36,298.3	(11,131.5)
Эрсдэлийн сангийн өөрчлөлт	8,088.4	10,889.5	13,914.3	14,693.5
Бусад авлагын өөрчлөлт	5,576.7	1,525.9	1,442.7	(183.8)
Бусад хөрөнгийн өөрчлөлт	2,053.2	479.1	452.9	(57.7)
Хүүгийн зардал	23,366.5	23,404.9	25,803.8	24,365.2

БСДС ХХК
АТАСНБХ 519572

MANDAL CAPITAL MARKETS SC LLC
ШТК0162 9021070414 5213421

Delivering diversity

Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(25,828.8)	4,379.2	14,538.5	62,766.1
Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгэ				
Үндсэн хөрөнгө худалдан авалт	1,069.5	366.3	549.5	686.8
Богино хугацаат хөрөнгө оруулалт	1,200.0	420.0	462.0	508.2
Охин компанид оруулсан ХО	(1.0)	-	-	-
Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ	2,268.5	786.3	1,011.5	1,195.0
Санхүүгийн мөнгөн гүйлгээ				
Цэвэр зээллэг	16,252.1	(2,750.2)	(13,034.1)	(65,466.1)
Эх үүсвэр буцаан төлөлт	(73,314.5)	(78,404.9)	(25,803.8)	(84,365.2)
Бондын төлөлт	49,947.9	55,000.0	-	60,000.0
Хүүгийн төлөлт	23,366.6	23,404.9	25,803.8	24,365.2
Эх үүсвэр татан төвлөрүүлэлт	89,566.7	75,654.7	12,769.7	18,899.1
Бонд татан төвлөрүүлсэн дүн	55,000.0	60,000.0	-	-
Хоёрдогч өглөг	-	-	-	-
Итгэлцэл	34,566.7	15,654.7	12,769.7	18,899.1
Бусад өр төлбөрийн өөрчлөлт	(7,854.5)	328.9	575.2	334.0
Ногдол ашгийн төлөлт				
Бусад өр төлбөрийн өөрчлөлт				
Дүрмийн сангийн өөрчлөлт	-	-	-	-
Санхүүгийн мөнгөн гүйлгээ	8,397.6	(2,421.3)	(12,458.9)	(65,132.1)
Мөнгөн хөрөнгийн өөрчлөлт	(19,699.6)	1,171.7	1,068.2	(3,561.1)
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	28,531.6	8,832.0	10,003.7	11,071.8
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,832.0	10,003.7	11,071.8	7,510.8

Хүснэгт 36. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн төсөөлөл:

Зохистой харьцаа үзүүлэлтүүд	Шалгуур	2023F	2024F	2025F	2026F
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-аас доошгүй	33.9%	34.3%	35.9%	45%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-аас доошгүй	33.9%	34.3%	35.9%	45%
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-аас доошгүй	32.7%	33.2%	34.8%	44%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-аас дээш	9.6%	8.8%	8.8%	8.8%
Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-аас хэтрэхгүй	50.0%	62.0%	67.0%	77%
Өөрийн бичгийн зохистой харьцаа	50%-аас хэтрэхгүй	46.2%	45.8%	41.7%	0.0%
Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	15%-аас хэтрэхгүй	0.9%	0.9%	1.0%	1%




2023.08.18

График 41. Зохистой харьцааны үзүүлэлт



График 42. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа



УЛААНБААТАР ХОТ
 АШИД КАПИТАЛ
 ББСБ ХХК
 АТА6882 / 6105972
 90220-056 /

МАНДАЛ КАПИТАЛ
 MARKETS SC
 LLC
 ШТКО162 9021070414 5213487

Голомт Капитал ҮЦК ХХК
 Golomt
 Capital
 Дели

Handwritten signatures

СЭХ
№ 1009
БҮРТГЭЭ
№ 01

**ДӨРӨВ. ҮНЭТ ЦААСНЫ
ТУХАЙ**



simple



4.1 НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭТ ЦААСНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НӨХЦӨЛ

Хүснэгт 37. Үнэт цаасны товч танилцуулга

Үнэт цаас гаргагч	АШИД КАПИТАЛ ББСБ ХХК
Үнэт цаасны нэр	Симпл II бонд
Үнэт цаасны төрөл	Энгийн хүүтэй бонд
Бондын арилжаа	Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй хүрээнд
Бондын тоо ширхэг	150,000 (зуун тавин мянга) ширхэг
Бондын нэрлэсэн үнэ, (ширхэг)	100,000 (нэг зуун мянга) төгрөг
Бондын хөтөлбөрийн нийт дүн	15,000,000,000 (арван таван тэрбум) төгрөг
Бондын хугацаа	12 сар
Бондын хүү	17.5 хувь, жилийн
Хүүгийн төлөлт	Сар тутам
Үндсэн төлбөр төлөлт	Хугацааны эцэст
Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулах зориулалт	Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт, зээлийн багцыг нэмэгдүүлэх
Үнэт цаасны хүүгийн орлогын татвар	5.0 хувь Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны эргэн төлөлтийг харилцагчдад олгосон зээлийн багцаас бий болох хүүгийн орлого, үндсэн төлбөрийн эргэн төлөлтөөр санхүүжүүлнэ.
Бондын эргэн төлөлт	Барьцаа болон баталгаагүй, зээлжих зэрэглэл тогтоолгосон.
Бондын барьцаа	Монголын хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси ХХК /Mongolian Investment Rating Agency "BBB+ (хувьсах)"
Бондын зэрэглэл	Бондын хүүг хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс эхлэн жилийн хүүг 365 хоногоор тооцно. Хэрэв хүү төлөх өдөр амралтын өдөр таарвал дараагийн ажлын өдөр төлөх ба энэ тохиолдолд амралтын өдрүүдэд хүүг нэмж тооцохгүй.
Хүүгийн төлбөр	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
Бондын хадгалалт, төлбөр тооцоо	2023 оны 9 сар
Нийтэд санал болгохоор төлөвлөж буй хугацаа	



4.2 ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН ХҮҮ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ

Үнэт цаас гаргагч нь бондын хүүгийн түвшнийг тодорхойлохдоо Монголбанкнаас зарласан бодлогын хүү, зах зээлийн дэх ижил төстэй өрийн хэрэгслийн хүүгийн түвшин, үнэт цаас гаргагчийн санал болгож буй үнэт цаасны эрсдэлийн хүчин зүйл зэрэгт үндэслэж тооцсон.

2023 оны 8 дугаар сарын байдлаар Монголбанкнаас зарласан бодлогын хүү 13 хувь, инфляцын түвшин улсын хэмжээнд 9.2 хувь байна. Харин 2023 оны 8 дугаар сарын байдлаар системийн топ-5 банкны 12 сарын хугацаатай төгрөгийн хадгаламжийн дундаж хүү 12.2 хувь буюу хадгаламжийн бодит өгөөж 3.0 хувь байна. Үнэт цаас гаргагчийн санал болгож буй бондын бодит өгөөж 8.3 хувь, системийн Топ-5 банкны хадгаламжийн хүүгээс 1.43 дахин өндөр байна.

График 43. Хүүгийн харьцуулалт



4.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Хөрөнгө Оруулалтын Зэрэглэлийн Эжинси ХХК нь үнэт цаас гаргагчийн зээлжих зэрэглэлийг байгууллагын болон үнэт цаасны түвшинд тогтоосон байна. Зээлжих зэрэглэлийн үнэлгээ нь дараах байдалтай байна:

Зэрэглэлийн төрөл	Үнэт цаасны төрөл	Үнэт цаасны нэр	Үнэт цаасны дүн	Зэрэглэлийн ҮА	Хүчинтэй огноо	Зэрэглэл & Төлөв байдал
Байгууллагын зэрэглэл	n/a	n/a	n/a	Хянасан	6/6/2024	BBB+ хувьсах
Үнэт цаас	Энгийн бонд	Симпл I бонд	20.0 тэрбум төгрөг	Хянасан	Бондын хугацаа дуустал	BBB+ хувьсах
Үнэт цаас	Энгийн бонд	Симпл II бонд	15.0 тэрбум төгрөг	Тогтоосон	Бондын хугацаа дуустал	BBB+ хувьсах

Тус эжинси нь 2023 оны 7 дугаар сард татан төвлөрүүлсэн Симпл I бонд болон байгууллагын зээлжих зэрэглэлийг 2023 оны 6 сарын 6-ны Зэрэглэлийн хорооны шийдвэрээр BBB+ (хувьсах) гэж тодорхойлсон байна. Харин 2023 оны 8 сарын 11-ний өдрийн Зэрэглэлийн хорооны хурлаар байгууллагын болон Симпл I бондын зэрэглэлийг дахин хянаж үзээд зэрэглэл болон төлөвийг хэвээр үлдээсэн бөгөөд нэмэлтээр гаргахаар төлөвлөж буй 15 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий Симпл II бондын зэрэглэлийг мөн адил BBB+ (хувьсах) гэж тодорхойлсон байна.



Зээлжих зэрэглэлийн эжинси нь зээлжих зэрэглэлийн шатлалыг мөн тодорхойлсон бөгөөд тус шатлалын дагуу BBB+ (хувьсах) үнэлгээ нь хөрөнгө оруулалтын ангилалд багтах ба дунд зэргийн эрсдэлтэй, хөрөнгө оруулалтын дундаж зэрэглэл гэж тодорхойлсон байна. Харин хувьсах төлөв нь компани зээлийн багцаа нэмэгдүүлэх, төрөлжүүлэх стратеги, санхүүжилтийн эх үүсвэр татах төлөвлөгөө болон толгой компанийн дэмжлэгийг харгалзан үзсэн зээлжих зэрэглэлийн богино хугацааны төлөв юм.

4.4 ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Үнэт цаас гаргагч нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 150,000 ширхэг өрийн хэрэгслийг нээлттэй хүрээнд олон нийтэд санал болгон арилжаалахаар төлөвлөж байгаа бөгөөд татан төвлөрүүлэх хөрөнгийг эргэлтийн хөрөнгийн санхүүжилт буюу зээлийн багцыг нэмэгдүүлэхэд зарцуулна.

Үнэт цаас гаргагч нь үнэт цаас гаргахтай холбоотой зардлыг татан төвлөрүүлэх хөрөнгөөс зарцуулахгүй бөгөөд өөрийн өөрийн үндсэн үйл ажиллагааны мөнгөн хөрөнгөөс зарцуулна.


4.5 ӨРИЙН БИЧГЭЭР ГЭРЧЛЭГДЭХ ЭРХ, ҮҮРЭГ

Үнэт цаас гаргагч болон үнэт цаас эзэмшигч нь холбогдох хууль, тогтоомж, дүрэм журмууд, Андеррайтер болон үнэт цаас гаргагч нарын хооронд байгуулсан Бондын гэрээний дагуу дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

Үнэт цаас эзэмшигч нь дараах эрх, үүрэгтэй байна:

- ✓ Үнэт цаасыг худалдан авах, хөрөнгө оруулалт хийх шийдвэрийг бие даан гаргах эрхтэй;
- ✓ Үнэт цаасыг МХБ-ийн арилжааны журмын дагуу худалдан авснаар үнэт цаасыг эзэмшилдээ шилжүүлэн авах, түүнийг шаардах эрхтэй;
- ✓ Эзэмшиж буй үнэт цаасыг чөлөөтэй арилжих, захиран зарцуулах;
- ✓ Үнэт цаасны хүү болон үндсэн төлбөрийг хуваарийн дагуу хүлээн авах, төлбөрийг хуваарийн дагуу төлөхийг үнэт цаас гаргагчаас шаардах;
- ✓ Үнэт цаас эзэмших эрхээ чөлөөтэй арилжаалах, захиран зарцуулах;
- ✓ Үнэт цаас эзэмшиж буй хугацаанд Үнэт цаас гаргагчийн санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээллийг хүлээн авах, шаардах, танилцах;
- ✓ Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулгад тусгасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол биелүүлэхийг шаардах;
- ✓ Монгол Улсын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу бондын хүүгийн орлогоос татвар төлөх;
- ✓ Хууль тогтоомжид заасан бусад.

Үнэт цаас гаргагч нь дараах үүрэгтэй байна:



- ✓ Андеррайтер, бонд эзэмшигчээс хуул тогтоомж болон энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах;
- ✓ Үнэт цаас эзэмшигчдийг компанийн үйл ажиллагаа, санхүү, бусад шаардлагатай зүйлсийн талаар үнэн зөв, хоёрдмол утгагүй, бодит мэдээллээр хангах;
- ✓ Үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг хуваарийн дагуу үнэт цаас эзэмшигчдэд төлөх;
- ✓ Татан төвлөрүүлсэн хөрөнгийг Үнэт цаасны танилцуулгад тусгасны дагуу зориулалтын дагуу зарцуулах;
- ✓ Үнэт цаас гаргагч нь холбогдох гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас үнэт цаас эзэмшигчид учруулсан аливаа хохирлыг төлж барагдуулах;
- ✓ Үнэт цаас гаргагч нь үндсэн болон хүүгийн төлбөрийг төлбөр хийгдэх өдрөөс ажлын 3 хоногийн өмнө ҮЦТХТ-д байрших өөрийн дансанд байршуулах;
- ✓ Үнэт цаасны ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлж болох нөхцөл байдал үүсмэгц энэ тухай нийтэд олон нийтэд болон эрх бүхий байгууллагуудад нэн даруй мэдээлэх;
- ✓ Бондыг бүртгүүлэхтэй холбоотойгоор СЗХ-нд хүргүүлсэн баримт бичиг, түүнд хавсаргасан баримт бичгийг бондын хугацаа дуусаж, үндсэн болон хүүгийн төлбөрийг бүрэн төлж дуусах хүртэлх хугацаанд компанийн байранд, цаашид хуульд заасан хугацаанд хадгалах;
- ✓ Хууль тогтоомжид заасан бусад.


4.6 ҮНЭТ ЦААС АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛ

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа нь МХБ-ийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн №2018/01 дугаар тогтоолоор баталсан Үнэт цаасны бүртгэлийн журам, СЗХ-ны 2021 оны 6 дугаар сарын 11-ны өдрийн 226 дугаар тогтоолоор батлагдсан Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам, МХБ-ийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам болон 2012 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн №02 тоот тогтоолоор баталсан Арилжааны журмын дагуу явагдана.

Үнэт цаас гаргагч нь 2023 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын №04 тоот тогтоолын дагуу 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 150,000 ширхэг өрийн хэрэгслийг нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн.

Үнэт цаас гаргагчийн олон нийтэд санал болгож буй үнэт цаасыг олон нийтэд танилцуулах үйл ажиллагааг МХБ болон СЗХ үнэт цаасыг бүртгэсэн өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор, анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг ажлын 5 хоногийн дотор хүлээн авна.





Бүртгүүлэх	· МХБ,СЗХ-оос үнэт цаасыг бүртгэх шийдвэр гаргах
Roadshow /Нийтэд мэдээлэх аян/	· Олон нийтэд үнэт цаас, үнэт цаас гаргагчийг танилцуулах
Book building /Захиалга авах	· Олон нийтээс захиалга авах, захиалгын санг бүрдүүлэх
Хуваарилалт	· Үнэт цаасны нийлүүлэлт хийж анхдагч зах зээлийн арилжааг хаах
Төлбөр тооцоо	· Арилжааны журмын дагуу арилжааны төлбөр тооцоог гүйцэтгэх

Анхдагч зах зээлийн арилжих арга

Монголын хөрөнгийн биржийн 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-д заасны дагуу үнэт цаас гаргагчийн тогтоосон тодорхой үнэ (өгөөж)-ээр санал болгох ба захиалга 100 хувь биелсэн тохиолдолд анхдагч зах зээлийн арилжааг хаана.

Үнэт цаасыг бүртгүүлж, холбогдох зөвшөөрөл авах

Үнэт цаас гаргагч нь нийтэд санал болгох үнэт цаасыг бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг СЗХ болон МХБ-д гаргах бөгөөд эдгээр эрх бүхий байгууллагуудаас үнэт цаасыг бүртгэхийг зөвшөөрснөөр үнэт цаасыг нийтэд санал болгон арилжаалах боломжтой болно.

Олон нийтэд танилцуулах

Үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох тухай мэдэгдлийг СЗХ-нд хүргүүлснээс хойш 3-аас доошгүй өдрийн дараа үнэт цаасыг нийтэд санал болгон танилцуулах аяныг зохион байгуулна. Үүнд хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогч, олон нийт болон стратегийн хөрөнгө оруулагчдад зориулсан танилцуулга уулзалт болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр үнэт цаасыг танилцуулах мэдээ мэдээлэл зэрэг нь багтана.

Анхдагч зах зээлийн арилжааны захиалга хүлээн авах

Үнэт цаас гаргагч нь анхдагч зах зээлийн захиалга авч эхлэхээс ажлын 3-аас доошгүй хоногийн өмнө анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх мэдэгдлийг СЗХ-нд хүргүүлснээр анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг хүлээн авах болно. Анхдагч зах зээлийн захиалгыг Биржийн гишүүн бүх үнэт цаасны компаниар дамжуулан авна.

График 45. Үнэт цаасны арилжаанд оролцох, захиалга авах заавар



Үнэт цаас худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нь анхдагч зах зээлийн арилжаанд дараах зааврын дагуу оролцоно.

Мөнгөн хөрөнгө байршуулах заавар

Үнэт цаас худалдан авах хүсэлтэй хөрөнгө оруулагч нь өөрийн хүссэн Үнэт цаасны компанийн номинал дансанд мөнгө байршуулна.

Хүснэгт 38. Мөнгөн хөрөнгө байршуулах мэдээлэл

Дансны нэр:	ҮЦК-ийн нэр
Дансны дугаар:	ҮЦК-ийн номинал дансны дугаар /Брокероос авах/
Банкны нэр:	Брокероос авах
Гүйлгээний утга:	Нэр, Регистр

Арилжааны шимтгэл

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч нь гүйлгээний үнийн дүнгийн тодорхой хувиар тооцсон үйлчилгээний хөлс буюу шимтгэлийг өөрийн сонгосон үнэт цаасны компанид төлөх ба уг шимтгэлд зохицуулагч байгууллагуудын болон үнэт цаасны компаниудын шимтгэлийн нийт дүн багтсан байна. Үнэт цаасны компаниудын шимтгэл нь харилцан адилгүй болохыг анхаарна уу.

Албан татвар

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч буюу Монгол Улсад байрладаг хувь хүн нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16.1.4-т заасан орлого (хүүгийн орлого)-ын нийт дүнгээс тус хуулийн 21.5-т заасан 5 хувийн хэмжээгээр татвар суутгана.

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч Монгол Улсад байрладаг хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.6.3-т заасан (хүүгийн орлого) нийт дүнгээс тус хуулийн 20.2.5-т заасан 5 хувийн хэмжээгээр татвар суутгана.

Гадаад улсын иргэн, хуулийн этгээд нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу татвар төлөх үүрэг хүлээх бөгөөд тухайн харьяаллын улстай давхар татварын гэрээ байгуулсан эсэх болон гэрээний нөхцөлийг судлан үзсэний үндсэн дээр хөрөнгө оруулахыг зөвлөж байна.

Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

Үнэт цаасыг анх удаа нийтэд санал болгох ажиллагаа амжилттай болсон тохиолдолд МХБ-ийн журмын дагуу СЗХ-ны зөвшөөрлөөр үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээр хувьцааг анхдагч зах зээлээс худалдан авсан хөрөнгө оруулагчид хувьцаагаа бусдад худалдаалах эрх нээлттэй болно.

Үнэт цаасны арилжаа, хүүгийн төлбөр

Үнэт цаасны эргэн төлөлтийн эх үүсвэр нь харилцагчдад олгосон зээдийн багцаас бий болох хүүгийн орлого, үндсэн төлбөрийн эргэн төлөлтөөс бүрдэнэ.



2023.08.18

СЭХ
№ 1000
Б. БУУЗ
№ 1

**ТАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАХ
АЖИЛЛАГААНД
ОРОЛЦОГЧИД**

5.1 ҮНДСЭН АНДЕРРАЙТЕРИЙН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Голомт Капитал ҮЦК нь 2011 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооноос брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх, гадаад арилжааны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авч, санхүүгийн зуучлалын цогц үйлчилгээ үзүүлэн ажиллаж байгаа компани юм.

Хүснэгт 39. Үндсэн андеррайтерийн компанийн мэдээлэл

	Улсын бүртгэлийн дугаар	9011287134
	Регистрийн дугаар	5481589
	Үйл ажиллагааны чиглэл	Брокер, Дилер, Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, номинал данс эзэмших
	Хаяг	Монгол улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 24, Парк плэйс оффис, 403 тоот;
	Утас	7012-1530
	Веб хуудас	www.golomtcapital.com
	Цахим хаяг	info@golomtcapital.com

Хүснэгт 40. Үндсэн андеррайтерийн эрхэм зорилго, үнэт зүйлс, уриа

<p>АЛСЫН ХАРАА</p> <p>Хөрөнгийн шинэ соёлыг бүтээнэ</p>	<p>ЭРХЭМ ЗОРИЛГО</p> <p>Хөрөнгийн хуваарилалтаар баялгийг бүтээнэ</p>	<p>УРИА</p> <p>Боломжийг нээнэ</p>
----------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------	-------------------------------------------

Үндсэн андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай

Голомт Капитал ҮЦК нь 2023 оны 5 дугаар сарын 19-ны өдрийн №23/44 тоот Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээг Үнэт цаас гаргагчтай байгуулсан байна. Тус андеррайтерийн гэрээний хүрээнд Андеррайтер нь Үнэт цаас гаргагчид хөрөнгийн зах зээлд нээлттэй хүрээнд өрийн хэрэгслийг СЗХ, МХБ-ээс зөвшөөрөл авч, олон нийтэд нээлттэй санал болгон хөрөнгө татахад Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх, шаардагдах тооцоолол, судалгаа, бэлтгэл ажлуудыг гүйцэтгэх, зөвлөгөө өгөх, хөрөнгө оруулагч нарт Компанийг танилцуулах, санал болгох, санхүүжилт татаж өгнө.

Үнэт цаас гаргагч нь Андеррайтерийг гэрээгээр хүлээсэн ажлаа гүйцэтгэхэд нь дэмжин ажиллаж шаардлагатай мэдээлэл, материалыг гарган өгч гэрээний чөлөөт байдлын зарчимд үндэслэн хамтран ажиллахаар харилцан тохиролцсонтой холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Гэрээний зорилгоо хэрэгжүүлэх явцад бие биеийнхээ хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх, хамгаалах болон шударга байх зарчмыг баримтлан ажиллана.


5.2 ТУСЛАХ АНДЕРРАЙТЕРИЙН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК нь Мандал Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн охин компани бөгөөд 2021 оны 4 дүгээр сард шинээр хөрөнгө оруулагч удирдлага, бүтцийн шинэчлэлт хийн ажиллаж байна. Тус компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооны



үнэт цаасны үйл ажиллагаа эрхлэх брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зовлөхийн тусгай зөвшөөрөлтэй, Монголын Хөрөнгийн Бирж болон Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны гишүүн байгууллага юм.

Хүснэгт 41. Туслах андеррайтерийн компанийн мэдээлэл

 MANDAL CAPITAL	Улсын бүртгэлийн дугаар	901145061
	Регистрийн дугаар	5213487
	Үйл ажиллагааны чиглэл	Брокер, Дилер, Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, номинал данс эзэмших
	Хаяг	602тоот, Мөрү Тауэр, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар, Монгол улс
	Утас	75753399
	Веб хуудас	mandalcapital.com
	Цахим хаяг	info@mandal.capital

Хүснэгт 42. Туслах андеррайтерийн эрхэм зорилго, үнэт зүйлс, уриа

АЛСЫН ХАРАА

Технологид суурилсан хөрөнгө оруулалтын банк

ЭРХЭМ ЗОРИЛГО

Танд үнэ цэн өгөх хувийн хөрөнгө оруулалтын банкир

Хамтран ажиллах гэрээний тухай

Үндсэн андеррайтер болох Голомт Капитал ҮЦК нь туслах андеррайтер болох Мандал Капитал Маркетс ҮЦК-тай 2023 оны 5 дугаар 24-ны өдөр хамтран ажиллах гэрээ байгуулсан ба үүгээр үндсэн андеррайтер нь үнэт цаас гаргагчийн өрийн хэрэгсэл гаргах хөтөлбөрийг СЭХ, МХБ-ээс зөвшөөрөл авч, олон нийтэд нээлттэй санал болгон хөрөнгө татахад Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх, шаардагдах тооцоолол, судалгаа, бэлтгэл ажлуудыг гүйцэтгэх, зөвлөгөө өгөх, хөрөнгө оруулагч нарт компанийг танилцуулах, санал болгох, санхүүжилт татаж өгөх ажлыг туслах андеррайтертай хамтран зохион байгуулахтай холбогдуулан талуудын эрх, үүрэг, хариуцлага, төлбөрийн нөхцөлийг тодорхойлохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Туслах андеррайтер нь үнэт цаас гаргагчид шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүжилтийг татан төвлөрүүлэхэд шаардлагатай бүхий л хүчин чармайлтыг гарган ажиллана. Талууд үнэт цаас гаргагчид үйлчилгээг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4.3 дахь заалтын дагуу хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүхий л хүчин чармайлтыг гаргана.

5.3 ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙН ЧАДАВХЫН ҮНЭЛГЭЭНИЙ КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Монголын хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси ХХК нь 2021 оны 1 дүгээр сард үүсгэн байгуулагдсан ба "Санхүүгийн чадавхын зэрэглэл тогтоох" тусгай зөвшөөрлийг 2022 оны 6 дугаар сард авсан.

Хүснэгт 43. Зээлжих зэрэглэлийн компанийн мэдээлэл





**Mongolian Investment
Rating Agency**

Улсын бүртгэлийн дугаар	9011824434
Регистрийн дугаар	6659659
Үйл ажиллагааны чиглэл	Санхүүгийн чадавхын зэрэглэл тогтоох, санхүүгийн тайлан баланс гаргах, зөвлөгөө өгөх, менежментийн зөвлөгөө өгөх
Хаяг	Монгол улс, Улаанбаатар, Чингэлтэй, 1-р хороо, жигжиджавын гудамж, Жи И Би ХХК-ийн байр 306 тоот
Утас	7774-7700
Веб хуудас	mira.mn
Цахим хаяг	info@mira.mn

Монголын хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси ХХК нь салбарын эрсдэл, бизнесийн эрсдэл, бизнесийн орчин, стратеги ба санхүүгийн бодлого, аюулгүй байдлын эрсдэл, удирдлагын үнэлгээ, компанийн засаглал, үйл ажиллагааны гүйцэтгэл, санхүүгийн чадавх, хамаарлын эрсдэл, ерөнхий үнэлгээний хүчин зүйлсийг харгалзан үзэн байгууллауудад зэрэглэл тогтоож үздэг.

Зээлжих зэрэглэл тогтоох үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай

Үнэт цаас гаргагч нь "Монголын хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси" ХХК-тай 2023 оны 5 дугаар сарын 12-ны өдөр АС_31_01_23_708 тоот "Зээлжих зэрэглэл тогтоох үйлчилгээ үзүүлэх гэрээ" байгуулсан бөгөөд гэрээнд зааснаар хуулийн этгээдийн санхүүжих чадавхын зэрэглэлийг тусгайлан боловсруулсан аргачлалд үндэслэн тогтоох хөндлөнгийн, хараат бус үйл ажиллагаа юм.

Гэрээний дагуу ажил гүйцэтгэгч нь Захиалагчийн зэрэглэлийг тогтоох, шинэчлэх үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний төлбөр тооцоог гүйцэтгэх, гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой Талуудын эрх, үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулна. Ажил гүйцэтгэгч нь Захиалагчийн дотоодын зах зээлд бонд гаргахад зориулан зэрэглэл тогтооно.

Үнэт цаас гаргагч нь шаардсан аливаа материал, баримт бичгийг гарган өгч, мэдээллээр хангах үүрэгтэй. Өгсөн санхүүгийн болон бусад мэдээлэлд материаллаг өөрчлөлт орсон тохиолдолд тухай бүрд нь мэдэгдэнэ. Бодит баримтын талаар худал мэдэгдэл агуулаагүй, мөн ийм мэдээллийг гаргахад шаардлагатай материаллаг баримтыг орхигдуулаагүй, гуравдагч этгээдийн оюуны өмчийн болон бусад эрхийг зөрчөөгүй, бусад хууль, журмыг зөрчөөгүй мэдээллийг гаргаж өгнө.


5.4 АУДИТЫН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Мэжик групп нь одоогоор Мэжик Консалтинг Аудит ХХК, Мэжик Клауд ХХК гэсэн компаниудыг нэгтгэн санхүүгийн үйлчилгээний салбарт /Аудит баталгаажуулах үйлчилгээ, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ, Санхүү НББ-ийн сургалт, Програм хангамж, Хөрөнгийн үнэлгээ/ өөрийн өнгө төрхийг бүрдүүлэн амжилттай ажиллаж байна.

Хүснэгт 44. Аудитын компанийн мэдээлэл

		Улсын бүртгэлийн дугаар Регистрийн дугаар	9018001045 5354595
		Уйл ажиллагааны чиглэл	Аудитын үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн анхан, дунд шатны мэдлэг олгох, мэргэжил дээшлүүлэх сургалт явуулах, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ

2023.08.18



Хаяг
Утас
Веб хуудас
Цахим хаяг

Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 25-р хороо, UB Tower, 15-р давхарт
1502 тоот
7013-1044
<http://www.magicgroup.mn/mn>
info@magicgroup.mn



Хүснэгт 45. Аудитын компанийн үнэт зүйлс

АЛСЫН ХАРАА

Санхүүгийн үйлчилгээний стандартаар тэргүүлэгч байгууллага байх

ЭРХЭМ ЗОРИЛГО

Дэвшилтэд технологи ашиглан, мэдлэгт суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээгээр монгол улсын хөгжилд хувь нэмрээ оруулах

УРИА

Хэмжиж үл чадвал удирдаж үл чадна

Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай

Мэжик Консалтинг Аудит ХХК нь "Аудитын үйлчилгээний гэрээ"-г Үнэт цаас гаргагчтай байгуулсан ба Аудит нь тус гэрээний хүрээнд 2023 оны 6 дугаар сарын 30-ний өдрийн байдлаарх санхүүгийн мэдээллүүд Монгол Улсын Үнэт Цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журам, МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журам болон бусад холбогдох журамд заасны дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд аудитын дүгнэлт гаргах үйлчилгээг гүйцэтгэсэн.


Аудитын зүгээс ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс гаргасан Мэргэжлийн нягтлан Бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын Аудитын тухай хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагуудын дагуу хууль болон холбогдох ёс зүйн шаардлагуудын дагуу үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлж, үнэт цаас гаргагчийн 2023 оны 6 дугаар сарын 30-ний өдрөөрх тасалбар болгосон санхүүгийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д нийцүүлэн дүгнэв.

5.5 ХУУЛИЙН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА, ДҮГНЭЛТ



Өмгөөллийн "Батбаяр энд Партнэрс" ХХН нь Монгол Улсын Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль (2012) батлагдсанаар өөрчлөн байгуулагдсан, Монголын Хуульчдын Холбооны гишүүн хуульч, өмгөөлөгчдийн үүсгэн байгуулсан хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос Үнэт цаасны зах зээлийн оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх зөвшөөрлөө 2014 онд авсан.

Өмгөөллийн "Батбаяр энд Партнэрс" ХХН нь байгууллага төвтэй бизнесийн эрх зүйн мэргэжлийн хуулийн фирм бөгөөд гадаадын хөрөнгө оруулагч, төсөл хэрэгжүүлэгч, бизнес эрхлэгчдэд болон бизнесийн байгууллагуудад бизнесийн эрсдэлийг бууруулахад мэргэжлийн дэмжлэг, хууль зүйн мэргэжлийн зөвлөх үйлчилгээг үзүүлэн ажилладаг.

Хүснэгт 46. Хуулийн компанийн мэдээлэл



2023.08.18



Улсын бүртгэлийн дугаар	9022001074
Регистрийн дугаар	5722292
Үйл ажиллагааны чиглэл	Хууль зүйн зөвлөгөө өгөх
Хаяг	Монгол улс, Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, Монгол ТВ тауэр оффисийн 10 давхар, 1001-1003
Утас	7711 9008
Веб хуудас	bnp.mn
Цахим хаяг	contact@bnp.mn

Хүснэгт 47. Хуулийн компанийн үйл ажиллагаа



Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай

Үнэт цаас гаргагч нь 2023 оны 5 дугаар сарын 19-ны өдөр Өмгөөллийн "Батбаяр энд Партнэрс" ХХН-тэй 23/06 тоот "Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ" байгуулсан ба гэрээний дагуу Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ны өдрийн №225 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн №226 тоот тогтоолоор батлагдсан "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам", Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн №2018/01 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэгт заасан асуудлыг хамруулсан хуулийн дүгнэлт бэлтгэх ажлыг гүйцэтгэнэ.

Үнэт цаас гаргагч нь Хуулийн фирмийг Компанийн байранд нэвтрэх, уулзалт хийхэд шаардлагатай холбогдох мэдээллийг авах, шалгах ажлыг гүйцэтгэх орчноор хангах, тухайн мэдээлэл, баримтыг хариуцсан ажилтнуудыг томилж ажиллуулах, мэдээ, материал, түүний агуулгыг тодорхойлоход туслах, зэрэг Ажлыг үнэн зөв, цаг хугацаанд нь гүйцэтгэхэд шаардлагатай бусад ажлыг зохион байгуулах, эрх бүхий байгууллагаас лавлагаа, тодорхойлолт, тодруулга авч өгөх үүрэгтэй.

5.4 ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Хөрөнгө оруулалт, банк санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр мэргэшсэн чадварлаг баг олон улсын стандартын дагуу хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ, санхүүгийн болон нягтлан бодох бүртгэлийн зөвлөх үйлчилгээг 2014 оноос эхлэн үзүүлж байна. СЗХ-ны Үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй. Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Институт (ММҮИ)-ийн гишүүн, Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо (МУЦАЭХ)-ны хамтрагч гишүүн компани юм.



Handwritten signatures

2023.08.18



Хүснэгт 48. Хөрөнгийн үнэлгээний компанийн товч танилцуулга



Улсын бүртгэлийн дугаар	9011478051
Регистрийн дугаар	5829879
Үйл ажиллагааны чиглэл	Бизнесийн зөвлөгөө, хөрөнгийн үнэлгээ хийх, Санхүү, нягтлан бодох бүртгэлийн зөвлөх үйлчилгээ
Хаяг	Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, Бизнес тауэр 908 тоот
Утас	8800 8922
Цахим хаяг	mbvcapital@gmail.com



Хүснэгт 49. Хөрөнгийн үнэлгээний компанийн үйл ажиллагааны чиглэл

Бизнесийн үнэлгээ

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн зөвлөх үйлчилгээ

Хөрөнгийн үнэлгээ

Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай

Үнэт цаас гаргагч нь 2023 оны 8 дугаар сарын 17-ны өдөр "Эм Би Ви Си" ХХК-тэй №АС_31-01_23_781 тоот "Хөрөнгийн үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээ" байгуулсан ба гэрээний дагуу үнэлгээний байгууллага үйлчлүүлэгчийн захиалгаар компанийн үнэлгээг хийж гүйцэтгэх харилцааг зохицуулахад оршино.

Үнэлгээний байгууллага нь гэрээнд холбогдох үйл ажиллагааны үйл явц, хэрэгжилтэд Үйлчлүүлэгч талаас хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах, шаардлагатай мэдээлэл бичиг баримтыг гаргуулах, төлбөрийг заасан хугацаанд шаардаж авах эрхтэй ба үнэлгээний тайланг үйлчлүүлэгч талд хүлээлгэн өгөх үүрэгтэй. Үйлчлүүлэгч нь гэрээнд холбогдох үйл ажиллагааны үйл явц, хэрэгжилтэд үнэлгээний байгууллагаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй, бөгөөд үнэлгээний байгууллагад шаардлагатай бичиг баримт мэдээллийг гаргаж өгөх, үйлчилгээний төлбөр тооцоог барагдуулах үүрэгтэй.




2023.08.18

СЭХ
БҮРТГЭВ
№ 31

ЗУРГАА. ХАВСРАЛТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 31



simple



VI. ХАВСРАЛТ

6.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Хууль зүйн байдал 2016 оны
12 сарын 31-ийн үзүүлэлтээр

МОНГОЛ УЛС
ХУУЛЬ ЗҮЙН БАЙДАЛ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
001000000


<u>2016.09.09</u> <i>/Бүртгэсэн өдөр/</i>	<u>3075002118</u> <i>/Хувийн зэргийн дугаар/</i>	
Ашид капитал ББСБ <i>/Хуульч зөвлөлийн нэр, хариуцаж буй хэлбэр/</i>	Хязгаарлагдмал хариуцлагатай компани <i>/Хуульч зөвлөлийн нэр, хариуцаж буй хэлбэр/</i>	
Дүрэм <i>/Үүсгэн байгуулагч бичигт бичье/</i>		
Шийдвэр <i>/Шийдвэрийн нэр/</i>	1 <i>/Дугаар/</i>	2016.09.06 <i>/Он, сар, өдөр/</i>
64920 66300 66110 <i>/Код/</i>	Зээлийн үйл ажиллагаа эрхлэх Факторингийн үйлчилгээ Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах <i>/Үйл ажиллагааны нэвтрэл/</i>	
Хугацаагүй <i>/Хугацаа/</i>	1 <i>/Хувиудын тоо/</i>	10,000,050.00 <i>/Хөрөнгийн хэмжээ, илчилж төгрөгөөр/</i>
Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, Сантрал тауэр 15 давхарт, Утас1: 77112828, Утас2: , Факс: <i>/Хуулийн этгээдийн албан ёсны хаяг/</i>		
		Улсын бүртгэлийн ерөнхий газар Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар <i>/Бүртгэсэн байгууллагын нэр/</i>
Гэрчилгээ дахин олгосон		2020.08.02 сар, 27 өдөр




2023.08.18

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Гүрээлэнхөй Өвчтэнгийн Гүйцэтгэх захирал-р сонгох(томилсон)-ийн бүртгэл	2019.07.16	Д.Гандамсүрэн
2	Дэлгэрэнгүй ажлаа	2020.02.27	Г.Сэнкээ
3	Эцсийн амилсан 1 үргэн бүртгэл	2020.08.19	Б.Мөнхбаатар
4	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 29999950 мян.төг-р нэмэгдэж нийт 40000000 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэл	2020.12.30	Д.Гандамсүрэн
5	Балтмагч овогтой Тэмүүлэн-а Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ийн бүртгэл	2020.12.30	Д.Гандамсүрэн
6	Дургийн б 4-т оруулсан өөрчлөлтийг бүртгэл	2021.07.27	Н.Энхцэцэг
7	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 15000000 мян.төг-р нэмэгдэж нийт 55000000 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэл	2021.09.21	С.Сүхбаатар
9	66190 Базинг хувиарант санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйл амилгаагаа шинхэлэ бүртгэл	2022.10.04	Б.Сүхбаатар
10	Батболд овогтой Билэгүүн-а Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга-р сонгосон(томилсон)-ийн бүртгэл	2022.10.11	Л.Хишигбаяр
11	Гүрээлэнхөй овогтой Балжаргал-а Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ийн бүртгэл	2022.10.11	Л.Хишигбаяр
12	Шинэчилсэн дүрэм бүртгэл	2022.12.26	Н.Энхцэцэг
13	Шинэчилсэн дүрэм бүртгэл	2023.03.30	С.Сэнкээ
14	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн 2 хэмээгээр Төлөөлөн удирдах зөвлөлийн амилдун тла нийт 5 болж өөрчлөгдсөнийг бүртгэл	2023.03.30	Г.Сэнкээ
15	66210 Санхүүгийн итгэлийн үйлчилгээ эрхлэх үйл амилгаагаа шинхээр бүртгэл	2023.05.21	Г.Сэнкээ



2023.08.18




6.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ДҮРЭМ

Ашид Капитал ББСБ ХХК-ийн Хувьцаа Эзэмшигчийн 2023 оны 7-р сарын 13-ний өдрийн 13 дүгээр шийдвэрийн хавсралт

“АШИД КАПИТАЛ ББСБ” ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндсэлэл



- 1.1. Компанийн оноосон нэр
 - а) Бүрэн нэр (монголоор): “Ашид капитал ББСБ” ХХК-ийнхэн энхүү дүрэм “Компани” гэх/
 - б) Бүрэн нэр (англиар): “Ashid Capital BBSB” LLC
- 1.2. Компанийн орпиня байгаа газар:
 - Улсын нэр: Монгол Улс
 - Аймаг, нийслэлийн нэр: Улаанбаатар хот
 - Сум, дүүргийн нэр: Сүхбаатар дүүрэг
 - Баг, хороо: 8-р хороо
 - Байшин, хаалганы дугаар: Сентрал Тауэр 15 давхар
 - Харилцах утасны дугаар: 77112828

1.3. Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн нэр

- Хуулийн этгээдийн нэр, хэлбэр: “М Си Эс Холдинг” ХХК
- Регистрийн дугаар: 2628236
- Улсын бүртгэлийн дугаар: 9011704011
- Хаяг: Шангри-Ла Оффис, 24 давхар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж 19А, Улаанбаатар хот, Монгол Улс
- Утасны дугаар: 77778833

1.4. Компани нь бие даасан тайлан тэнцэлтэй, харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг, хариуцлага хүлээх, нэг хувьцаа эзэмшигчтэй, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр ажиллана.


1.5. Компани нь орлого ашгаа арвижуулах замаар хувьцаа эзэмшигчдийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх явдлыг үндсэн зорилгоо болгон “Санхүүгийн зохицуулах хорооны Эрх зүйн байдалын тухай хууль”, “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль”, “Иргэний хууль”, “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль”, “Компанийн тухай хууль”, “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль” “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам” болов хойболдох бусад хууль, тогтоомжоор зөвшөөрөгдсөн дараах ажил, үйлчилгээг эрхэлнэ. Үүнд:

- 1.5.1. Зээл;
- 1.5.2. Факторингийн үйлчилгээ;
- 1.5.3. Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах;
- 1.5.4. Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх
- 1.5.5. Итгэлцлийн үйлчилгээ



Handwritten signature





1.6. Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг хуульд заасны дагуу холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрлийг бичгээр авч, энэхүү дүрэмдээ өөрчлөлт оруулан бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

1.7. Компанийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа: Хугацаагүй

1.8. Компани нь Монгол Улсад болон гадаад улсад өөрийн салбар, төлөөлөгчийн газартай байж болно. Компанийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу салбар, төлөөлөгчийн газраа байгуулан, бүртгэх байгууллагад бүртгүүлж, үйл ажиллагаагаа явуулна.

1.9. Компани нь үүсгэн байгуулах баримт бичигт болон улсын бүртгэлийн жагсаалтад агуулагдаж байгаа бусад мэдээлэлд оруулсан өөрчлөлтүүдээ хуульд заасан хугацаанд бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

Хоёр. Компанийн эрх

2.1. Компанийн иргэний эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ.

2.2. Компани нь өөрийн бэлэгдэл (эмблем), албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг хэрэглэнэ.

2.3. Компани нь Компанийн тухай хуульд заасны дагуу хараат компани байгуулж болох бөгөөд үүнийгээ бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

2.4. Компани нь өөрийн үйл ажиллагаагаа бие даасан байдлаар, эсхүл бусад хуулийн этгээдтэй хамтран Монгол Улсын хуулийн хүрээнд эрхлэн явуулна.

2.5. Компани нь үндсэн ба туслах үйл ажиллагаагаа хэвийн явуулах зорилгоор мэргэжил, ур чадвар, дадлага туршлагатай хүмүүсийг хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулах, тэдгээрийн ажиллах нөхцөл, цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтооно.

Гурав. Компанийн үүрэг

3.1. Компани нь энэхүү дүрмийн 1.5, 1.6-д заасан үйл ажиллагааг Монгол Улсын хуульд заасны дагуу эрхлэнэ.

3.2. Компани нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль болон Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргана.

3.3. Компани нь Монгол Улсын албан татварын хуулийн дагуу орлоо, татвараа өөрөө тодорхойлж, албан татвараа сайн дураар төлнө.


3.4. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай мэдээ, мэдээллийг тухай бүр эрх бүхий байгууллагуудад гаргаж өгнө.

3.5. Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсадын өмнө хуулиар өгөгдсөн үүргүүдийг биелүүлнэ.

3.6. Компанийн тухай хуулийн 84.1, 84.2 дахь хэсэгт заасны дагуу Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч нь компанийн эрх бүхий албан тушаалтан байх бөгөөд



2023.08.18



тэдгээр нь өөрийн хууль бус үйл ажиллагаанаас компанид учруулсан хохирлыг өөрийн эд хоронгөөр хариуцна.

3.7. Компани нь Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан баримт бичгийг хадгалах, байнга хадгалах, хувьцаа эзэмшигчийн шаардлагаар танилцуулах, тэдгээрийг архивт шилжүүлнэ.

Дөрөв. Компанийн хариуцлага

4.1. Компани нь Компанийн тухай хуулийн 9.1 дэх хэсэгт заасан хариуцлага хүлээнэ.

4.2. Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын эрхийг зорчсон тохиолдолд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээнэ.

4.3. Компани нь улсын бүртгэлд бүртгүүлэхээс өмнө иргэний эрх зүйн харилцаанд бие даан оролцохыг хориглоно. Энэхүү заалтыг зөрчсөний улмаас бусад гэм хор учруулсан бол буруутай этгээд гэм хорыг арилгана.

4.4. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуулийн 84, 85 дугаар зүйлд заасан хариуцлагыг хүлээнэ.

4.5. Компани нь Монгол Улсын хуульд заасан бусад хариуцлагыг хүлээнэ.

Тав. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон өөрийн хөрөнгө

5.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хуулийн 30.1 дэх хэсэгт зааснаар тодорхойлно. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 55,000,000,000 (тавин таван тэрбум) төгрөг байна.

5.2. Компанийн зарласан болон гаргасан хувьцаа нь нэг бүр нь 1,000 (нэг мянга) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 55,000,000 (тавин таван сая) ширхэг энгийн хувьцаа байна.

5.3. Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хуулийн 30.2 дахь хэсэгт зааснаар тодорхойлно.

5.4. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь компанийн өөрийн хөрөнгийн хэмжээнээс илүүгүй байна.

5.5. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөхдөө Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасныг баримтлана.

Зургаа. Компанийн удирдлага

6.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрхийг компанийн хувьцаа эзэмшигч болох "М-Си-Эс Холдинг" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл эдэлнэ.

6.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрхийг эдлэх "М-Си-Эс Холдинг" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас шийдвэрлэсэн бүх асуудлаар тогтоол гаргана. Тогтоолд "М-Си-Эс Холдинг" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга гарын үсэг зурна. Хурлын явц, хэлэлцсэн асуудлын талаар дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлнө. Хэлэлцсэн



2023.08.18

асуудал, гэмдэглэл, тогтоолуудыг "М-Си-Эс Холдинг" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга бүртгэж хадгална.

6.3 "М-Си-Эс Холдинг" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөр хэлэлцэхээр товлөөгүй асуудлыг хуралд оролцож буй Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар хэлэлцэж болно.

6.4 Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийн эрх барих дээд байгууллага нь "Ашид Капитал" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх) байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрхийг эдлэх "М-Си-Эс Холдинг" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь ТУЗ-ийг 5 хүртэл гишүүнтэйгээр томилно.

6.5 ТУЗ нь зөвхөн дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:

- 6.5.1 Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох;
- 6.5.2 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
- 6.5.3 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, хурлыг хуралдуулахтай холбогдолтой асуудлыг шийдвэрлэх;
- 6.5.4 Компанийн жилийн төсөв, бизнес төлөвлөгөө батлах;
- 6.5.5 Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг "М-Си-Эс Холдинг" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хуралд танилцуулж батлуулах;
- 6.5.6 Компанийн бодлого, тухайн жилийн бизнес төлөвлөгөө, төсөв, үйл ажиллагаанд мөрдөх журмын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэлийн хөтөлөлт, санхүүгийн тайлан зөв эсэхэд хяналт тавьж, актив хөрөнгийг хамгаалан үр ашгийг дээшлүүлэх чиг үүрэгтэйгээр ТУЗ-д ажлаа тайлагнах зарчмаар ажиллах Дотоод аудитын нэгжийг томилж ажиллуулах;
- 6.5.7 Компанийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
- 6.5.8 Компанийн салбар болон төлөөлөгчийн газар байгуулах;
- 6.5.9 Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;
- 6.5.10 Компанийн тухай хуулийн 12-р бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- 6.5.11 Компанийн тухай хуулийн 12-р бүлэгт заасан их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- 6.5.12 Эрсдэлийн сан байгуулах, хорин таван сая төгрөг ба түүнээс дээш дүнгэй активыг эрсдэлийн саягаас хорогдуулах шийдвэр гаргах;
- 6.5.13 Хуульд заасан бусад.

6.6 ТУЗ-ийн шийдвэр хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхийн саналаар хүчин төгөлдөр болох бөгөөд тогтоол хэлбэрээр гаргана. Тогтоол ТУЗ-ийн дарга гарын үсэг зурна. Хурлын явц, хэлэлцсэн асуудлын талаар дэлгэрэнгүй протокол хөтөлвө. Хэлэлцсэн асуудал, протокол, тогтоолуудыг компани бүртгэж хадгална.

6.7 Компанийг өөрчлөн байгуулсантай холбогдуулан хувьцаа эзэмшигч Компанийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан эрхийг эдэлнэ.

Долоо. Гүйцэтгэх удирдлага

7.1. Компанийн гүйцэтгэх удирдлагыг компанийн Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.



2023.08.18

7.2. ТУЗ-ийн дарга нь Гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулан захирлын эрх, үүрэг, хариуцлагын хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэргийг тогтоож өгнө.

7.3. Компанийн Гүйцэтгэх захирал нь дор дурдсан үүрэг хүлээж эрх эдэлнэ.

- 7.3.1. Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, тухайн жилийн бизнес төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;
- 7.3.2. Компанийн нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;
- 7.3.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан зардлын хэмжээнд багтаан компанийн ажилтнуудын орон тоо, үндсэн болон нэмэгдэл цалин, тэтгэмж, хөнгөлөлт, урамшууллын хэмжээг тогтоох;
- 7.3.4. Ажилтнуудын ажил үүргийн хуваарийг тогтоох, ажилтныг ажилд томилох, гэдэлтэй хөдөлдмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх;
- 7.3.5. ТУЗ-аас олгогдсон эрх хэмжээний хүрээнд компанийн нэрийн өмнөөс баталгаа гаргах, гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурах;
- 7.3.6. Компанийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах;
- 7.3.7. Энэхүү дүрэмд болон ТУЗ-тай байгуулсан гэрээнд заасан үүргээ биечлэн гүйцэтгэх;
- 7.3.8. Компанид учруулсан хохирлыг төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах, компанид холбогдох иргэний хэрэгт нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилон оролцуулах;
- 7.3.9. Компанийн дотоод журамд заасан эрх хэмжээний хүрээнд Компанийн эд хөрөнгийг захиран зарцуулах төлбөрийн баримтад гарын үсэг зурах, арилжааны банкинд харилцах данс нээх, хаах, дансаар гадаад болон дотоод бэлэн болон бэлэн бус гүйлгээ хийх, интернет банк ашиглах, банкинд гаргаж өгсөн өөрийн гарын үсгийн баталгааг сольж өөрчлөх, нэг болон хоёрдугаар гарын үсэг зурах эрх бүхий этгээдийг томилох, чөлөөлөх, Компанийн өлөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотойгоор банкны бусад үйлчилгээг авах;
- 7.3.10. Компанийн санхүүгийн тайлан тэнцэлд хөндлөнгийн хяналт хийж байгууллагыг сонгон гэрээ байгуулах, хяналт хийлгэх, тайланг хэлэлцэж дүгнэлт гаргах;
- 7.3.11. Хорин таван сая төгрөгөөс доош дүнтэй активыг эрсдэлийн сангаас хорогдуулах шийдвэр гаргах;
- 7.3.12. Гэрээнд заасан бусад эрх, үүрэг.

7.4. Гүйцэтгэх захирал ээлжийн амралт эдлэх, гадаад дотоодод албан томилолтоор ажиллах, удаан хугацаагаар өвчлөх тохиолдолд өөрийн эрх, үүргийг өөрийн томилсон этгээдэд шилжүүлднэ. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Найм. Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих хяналт

8.1. Компанийн хувьцаа эзэмшигч Компанийн тухай хуулийн 94.1 дэх хэсэгт зааснаар гэрээний үндсэн дээр аудитын байгууллагыг томилон ажиллуулж болно.

8.2. Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудитын байгууллагын шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна.



8.3. Компанийн жилийн санхүүгийн тайланг баталгаажуулахын тулд хийсэн аудитын байгууллагын шалгалт нь ээлжит байна.

8.4. Аудитын байгууллагын шалгалтын хөлсийг Компанийн тухай хуулийн 94.8 дахь хэсэгт заасны дагуу компани болон хувьцаа эзэмшигч хариуцан төлнө.

8.5. Компани нь санхүүгийн тайлангаа эрх бүхий этгээдэд танилцуулна.

8.6. Компанийн санхүүгийн жил 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно.

8.7. Компани нь компанийн санхүүгийн тайланд Компанийн тухай хуулийн 96.1 дэх хэсэгт заасан зүйлийг тусгана.

8.8. Компани нь Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан баримт бичгийг хадгалах, байнга хадгалах, эрх бүхий этгээдийн шаардлагаар танилцуулах, хуульд заасан хугацаа дууссаны дараа архивт шилжүүлнэ.

Ес. Компанийг өөрчлөн байгуулах

9.1. Компанийн хувьцаа эзэмшигч нь компанийг өөрчлөн байгуулахдаа Компанийн тухай хуулийн 18-23 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэх бөгөөд зохих журмын дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авна.

Арав. Компанийг татан буулгах

10.1. Компанийг Компанийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан үндэслэлээр татан буулгана.

10.2. Компанийг татан буулгах шийдвэр гаргасан эрх бүхий этгээд татан буулгах комиссыг томилно.

10.3. Компанийг татан буулгах шийдвэр гаргасан эрх бүхий этгээд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 24.1 дэх хэсэгт заасан хугацаанд бүртгэх байгууллагад бичгээр мэдэгдэж, холбогдох баримт бичгийг хавсаргасан байна.

10.4. Татан буулгах комисс Иргэний хуулийн 32.2-32.10 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 26, 27, 28 дугаар зүйлд заасны дагуу компанийг татан буулгах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.

10.5. Компани татан буутдсаныг улсын бүртгэлд бүртгүүлэхдээ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан баримт бичгийг бүрдүүлж бүртгэх байгууллагад өрүүлнэ.

Арван нэг. Бусад

11.1. Энэхүү дүрмийг монгол хэлээр 2 хувь үйлдэж, нэг хувийг хуулийн этгээдийн бүртгэлийн байгууллагад, нэг хувийг Компани хадгална.

2023 он 08 сар 18 өдөр Компанийн дүрэм нь
НИЙСЛИЙН ТЭЙЛЭЭР БАЙСОМЛ ДООМГОНО.
Ц.Одонтулгалаг бичгээр хуулбарын
үнд 4 зөвшилцөжээ.
Нотариатч

хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлснээр

-oOo-



2023.08.18

СЭХ
2023.08.02 өдөр
БҮРТГЭЭ
№01

simple

МОНГОЛЫН ХЭРГЭҮҮГИЙН ГИШЖ
MONGOLIAN CAPITAL MARKETS SC

VI. ХАВСРАЛТ

БҮРТГЭЭ-02

6.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ



МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ТЗ 101/663

2020 оны 02 сарын 12 өдөр

Монгол улсын "Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль", "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль", бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 02 сарын 12 өдрийн 68 дугаар тогтоолоор "АШИД КАПИТАЛ ББСБ" ХХК

Банк бус санхүүгийн

үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.



ДАРГА
"тамга"

Д БАЯРСАЙХАН

Энэхүү гэрчилгээ нь
хавсралтын хамт
хүчинтэй

УЛААНБААТАР ХОТ
АШИД КАПИТАЛ
ББСБ ХХК
АТ 6887 1101572
8411058

МАНДАЛ КАПИТАЛ
МАРКЕТС ҮЦК ХХК
MANDAL CAPITAL
MARKETS SC
LLC 104
№162 9021070414 9218487

2023.08.18
111 111 111 5461519
УЛААНБААТАР ХОТ

(Энэхүү хавсралт нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хамт хүчинтэй)



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ТЗ 101/663 ТООТ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ

"Тэмдэг"

Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээлд зориулсан тэмдэглэлүүд

НЭС Хуулийн этгээдийн оноосон нэр: "АШИД КАПИТАЛ ББСБ" ХХК

ХОЕР Хуулийн этгээдийн ангилал: БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ГУРАВ Үйл ажиллагааны төрөл, хэлбэрийн тэмдэглэл

Д/д	Үйл ажиллагааны төрөл, хэлбэр	Олгосон огноо	Олгосон шийдвэрийн дугаар	Тусгай зөвшөөрлийг гүдгэлзүүлсэн, сэргээсэн, султасан хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар
1.	Зээл	2020.02.12	№68 тогтоол	
2.	Факторинг	2020.02.12	№68 тогтоол	
3.	Төлбөр тооцооны хэргэсэл	2020.02.12	№68 тогтоол	
4.	Богши хугацаат санхүүгийн зүрхсэлд хөрөнгө оруулалт хийх	2022.09.21	№456 тогтоол	
5.	Итгэлшлэл	2023.05.12	№155 тогтоол	


УЛААНБААТАР ХОУ
АШИД КАПИТАЛ
ББСБ ХХК
ATTACHED & SIGNED
2023.08.18

Handwritten signature

МАНДАЛ КАПИТАЛ
MARKETS SC
LLC 105
100162 9021070414 527347

Handwritten signature
УЛААНБААТАР ХОУ

2023.08.18



ДОРӨВ. Хуулийн этгээдийн хаяг, хэргийн өөрилөлтийн тэмдэглэл:

Д/д	Хаяг	Утас	Тэмдэглэл хийсэн өгнөө, тэмдэг
1.	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сенгэл талуур, 15 давхарг.	77112828	

ТАВ. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлийн тэмдэглэл:

Д.д	Хувь нийлүүлсэн хөрөнгийн нэмэгдүүлсэн, хорогдуулсан хэмжээ	Зөвшөөрөл олгосон өгнөө	Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ
1.		2020.02.12	№68	10,000,050,000
2.	29,999,950,000 /нэмэгдүүлсэн/	2020.12.04	№369	40,000,000,000
3.	15,000,000,000 /нэмэгдүүлсэн/	2021.09.14	№237	55,000,000,000



ЗУРГАА Хувьцаа эзэмшигчийн талаар

Д/д	Огноо нэр /Хуулийн эгзэлтийн нэр	Регистрийн дугаар	Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн	Хувь	Зөвшөөрөл олгосон огноо	Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар, тэмдэг
1.	"М Си Эс Холдинг" ХХК	2628236	10,000,050,000	100%	2020.02.12	№68 тогтоол
1.	"М Си Эс Холдинг" ХХК	2628236	10,000,000,000	100%	2020.12.04	№369 тогтоол
1.	"М Си Эс Холдинг" ХХК	2628236	55,000,000,000	100%	2021.09.24	№237 тушаал





simple



VI. ХАВСРАЛТ

ДОЛОО. Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын гэмдэнэл

Д.д	Нэр, дугаар	Хаяг, хаягийн өөрчлөлт	Зөвшөөрөл олгосон огноо	Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар	Зөвшөөрлийг гүйдэгжүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон огноо шийдвэрийн дугаар



Handwritten signature



2023.08.18

МОНГОЛ УЛС
2023
БҮГД





УБХ
04028 рвр. 02 өдөр
У. ХАВСРАЛТ
№ 01

6.4 ТОЛГОЙ КОМПАНИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав

**МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ**
000150484


2006.11.22 <i>/ Бүртгэсэн өн. сар, өдөр /</i>	9011704011 <i>/ Хувийн хэрэйдийн дугаар /</i>	
	2628236 <i>/ Реестрийн дугаар /</i>	
М Си Эс холдинг <i>/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /</i>	Хязгаарлагдмал хариуцлагатай компани <i>/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /</i>	
Дүрэм <i>/ Үүсгэн байгуулах баримт бичиг /</i>		
Тушаал <i>/ шийдвэрийн нэр /</i>	A4763 <i>/ дугаар /</i>	2011.12.20 <i>/ он, сар, өдөр /</i>
4610 <i>/ код /</i>	Гадгаад худалдаа <i>/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /</i>	
4610 7020	Худалдааны зуучлал Менеджментийн зөвлөгөө өгөх	
	<i>/ код /</i>	
	<i>/ Үүсгэх эрхлэх үйл ажиллагааны чиглэл /</i>	
Хугацаагүй <i>/ хугацаа /</i>	1 <i>/ ашиггүйн тоо /</i>	2,238,035.7 <i>/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /</i>
Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, Сентрал тауэр 15 давхарт. Утас1: 312625, Утас2: 77212625. Факс: 312175 <i>/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /</i>		
	 Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар Хуулийн этгээдийн бүртгэлийн газар <i>/ бүртгэсэн байгууллагын нэр /</i>	
Гэрчилгээ дахин олосон 2017 он 10 сар 3 өдөр		

УЛААНБААТАР ХОТ
**АНД КАПИТАЛ
ББСБ ХХК**
ATA686C...


МАНДАЛ КАПИТАЛ
MARKETS YЦХ ХХК
**MANDAL CAPITAL
MARKETS SC
LLC** 109
11760142 90210704 4 921348

Гол...

2023.08.18



VI. ХАВСРАЛТ

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан / Тэмдэг
1	Лингов овогтой Гантөмөр-е Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2015.09.17	Н.Цэцэгшүрэн
2	Дахин гэрчилгээ өгэв.	2017.10.03	С.Мөнхсайхандорж
3	Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, , олимпын, 19а, Шанари Лв оффис 24 дөвхөрт тоот: Утас1 777 78833, Утас2 , Факс хэлгийг шинээр бүртгэв.	2019.08.27	Э.Эрдэмболзол
4	6590489 тоот регистрийн дугаартай Норд стар хөлдийн монголи-г, 6591019 тоот регистрийн дугаартай Номадком монголи-г тусгаарласныг бүртгэв.	2020.07.01	Ж.Нямдорж
5	Эцсийн нэмэлтэгч 1 ирэн бүртгэв.	2022.04.14	Н.Энхтуяа
6	1610 Гавсанд худалдаа үйл ажиллагааг хассаныг бүртгэв. 1610Х Тинбэр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа үйл ажиллагааг шинээр бүртгэв. 10100 Аж ахуйн нэгжийн удирдах дээд байгууллагын төлөөлөгчид үйл ажиллагааг үйл ажиллагааг шинээр бүртгэв.	2022.04.14	Н.Энхтуяа
7	Жамбалжамц овогтой Ойджаргал-а ТУЗ-ийн дарга-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2022.10.13	Н.Энхтүвшин
9	Шинэ үүсгэн байгуулагчид гишүүн тоо нийт 4 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2023.03.03	Б.Батзориг
8		2022.10.13	Б.Батзориг
9	Шинэчилсэн дүрэм бүртгэв.	2023.03.03	Б.Батзориг





6.5 ТОЛГОЙ КОМПАНИЙН ДҮРЭМ

2023 оны 02 сарын 17-ны өдрийн МХХХ Хувьцаа эзэмшигчийн тоот тогтоолоор батлаа

"М-СИ-ЭС ХОЛДИНГ" ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ



Нэг. Нийтлэг үндэслэл


- 1.1 Хуулийн этгээдийн тухай
 - 1.1.1 Компанийн оноосон нэр:
 - А. Монголоор: М-Си-Эс Холдинг ХХК
 - Б. Англиар: MCS Holding LLC
 - 1.1.2 Регистрийн дугаар: 2628236
- 1.2 Компанийн оршин байгаа газар:
 - Улсын нэр: Монгол Улс
 - Аймаг, нийслэлийн нэр: Улаанбаатар хот
 - Сум, дүүргийн нэр: Сүхбаатар дүүрэг
 - Баг, хороо, хорооллын нэр: 1-р хороо
 - Гудамж, талбайн нэр: Олимпын гудамж 19А, Шангри-Ла оффис, 24 давхар
 - Харилцах утасны дугаар: 77778833
- 1.3 Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн нэр:
 - Хуулийн этгээдийн нэр, хэлбэр: М-Си-Эс Монголиа ХХК
 - Регистрийн дугаар: 6210619
 - Улсын бүртгэлийн дугаар: 9011691002
 - Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж 19А, Шангри-Ла оффис 24 давхар 77778833
 - Харилцах утасны дугаар: 77778833
- 1.4 Компани нь бие даасан тайлан тэмцэлтэй, харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг, хариуцлага хүлээх, нэг хувьцаа эзэмшигчтэй, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр ажиллана.
- 1.5 Компани нь үйл ажиллагаагаа дараах чиглэлээр явуулна.
 - 1.5.1 Аж ахуй нэгжийн удирдах дээд байгууллагын толгой компанийн үйл ажиллагаа,
 - 1.5.2 Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа,
 - 1.5.3 Менежментийн зөвлөгөө өгөх үйлчилгээ.
- 1.6 Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг хуульд заасны дагуу холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрлийг бичгээр авч, энэхүү дүрэмдээ өөрчлөлт оруулан бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.
- 1.7 Компанийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа: Хугацаагүй
- 1.8 Компани нь Монгол Улсад болон гадаад улсад өөрийн салбар, төлөөлөгчийн газартай байж болно. Компанийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу салбар, төлөөлөгчийн газраа байгуулан, бүртгэх байгууллагад бүртгүүлж, үйл ажиллагаагаа явуулна.
- 1.9 Компани нь үүсгэн байгуулах баримт бичигт болон улсын бүртгэлийн жагсаалтад агуулагдаж байгаа бусад мэдээлэлд оруулсан өөрчлөлтүүдээ хуульд заасан хугацаанд бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

Хоёр. Компанийн эрх

- 2.1 Компанийн иргэний эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ
- 2.2 Компани нь өөрийн бэлэгдэл (эмблем), албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг хэрэглэнэ.
- 2.3 Компани нь Компанийн тухай хуулийн 6.1-6.8 дахь хэсэгт заасны дагуу хараат болон охин компани байгуулж болох бөгөөд үүнийгээ бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.



2023.08.18



- 2.4. Компани нь өөрийн үйл ажиллагаагаа бие даасан байдлаар, эсхүл бусад хуулийн этгээдтэй хамтран Монгол Улсын хуулийн хүрээнд эрхлэн явуулна.
- 2.5. Компани нь үндсэн ба туслах үйл ажиллагаагаа хэвийн явуулах зорилгоор мэргэжил, үр чадвар, дадлага туршлагатай хүмүүсийг хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулах, тэдгээрийн ажиллах нөхцөл, цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтооно.

Гурав. Компанийн үүрэг

- 3.1. Компани нь энэхүү дүрмийн 1.5, 1.6-д заасан үйл ажиллагааг Монгол Улсын хуульд заасны дагуу эрхлэнэ.
- 3.2. Компани нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль болон Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргана.
- 3.3. Компани нь Монгол Улсын албан татварын хуулийн дагуу орлого, татвараа өөрөө тодорхойлж, албан татвараа сайн дураар төлнө.
- 3.4. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай мэдээ, мэдээллийг тухай бүр эрх бүхий байгууллагуудад гаргаж өгнө.
- 3.5. Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсадын өмнө хуулиар өгөгдсөн үүргүүдийг биелүүлнэ.
- 3.6. Компани нь Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан баримт бичгийг хадгалах, байнга хадгалах, хувьцаа эзэмшигчийн шаардлагаар танилцуулах, тэдгээрийг архивт шилжүүлнэ.

Дөрөв. Компанийн хариуцлага

- 4.1. Компани нь Компанийн тухай хуулийн 9.1 дэх хэсэгт заасан хариуцлага хүлээнэ.
- 4.2. Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсадын эрхийг зөрчсөн тохиолдолд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээнэ.
- 4.3. Компани нь улсын бүртгэлд бүртгүүлэхээсээ өмнө иргэний эрх зүйн харилцаанд бие даан оролцохыг хориглоно. Энэхүү заалтыг зөрчсөний улмаас бусдад гэм хор учруулсан бол буруутай этгээд гэм хорыг арилгана.
- 4.4. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд, Гүйцэтгэх захирал болон Санхүү эрхэлсэн удирдах ажилтан нар нь эрх бүхий албан тушаалтан байх бөгөөд Компанийн тухай хуулийн 64, 85 дугаар зүйлд заасан хариуцлагыг хүлээнэ.
- 4.5. Компани нь Монгол Улсын хуульд заасан бусад хариуцлагыг хүлээнэ.

Тав. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон өөрийн хөрөнгө

- 5.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хуулийн 30.1 дэх хэсэгт зааснаар тодорхойлно. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 2,238,035,000 (Хоёр тэрбум хоёр зуун гучин найман сая гучин таван мянга) төгрөг байна.
- 5.2. Компанийн зарласан болон гаргасан хувьцаа нь нэг бүр нь 1000 (Нэг мянга) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 2,238,035 (Хоёр сая хоёр зуун гучин найман мянга гучин тав) ширхэг энгийн хувьцаа байна.
- 5.3. Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хуулийн 30.2 дахь хэсэгт зааснаар тодорхойлно.
- 5.4. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөхдөө Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасныг баримтланэ.



Зургаа. Компанийн удирдлага

- 6.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрхийг компанийн цорын ганц хувьцаа эзэмшигч болох М-Си-Эс Монголиа ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл эдэлнэ.
- 6.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрхийг эдлэх М-Си-Эс Монголиа ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:
- 6.2.1 Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн найруулгыг батлах;
- 6.2.2 Компанийг нэгдэх, нийлэх, тусгаарлах, хуваах болон бусад хэлбэрээр өөрчлөн байгуулах;
- 6.2.3 Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
- 6.2.4 Энгийн болон давуу эрхийн хувьцаа, тэдгээрт хөөрөх үнэт цаас гаргах;
- 6.2.5 Компанийн өрийг хувьцаагаар солих;
- 6.2.6 Компанийн ногдол ашгийн хэмжээ болон түүнийг төлөх журмыг тодорхойлох;
- 6.2.7 ТУЗ-ийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгаар болгох;
- 6.2.8 Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- 6.2.9 Хувьцааг хуваах буюу нэгтгэх;
- 6.2.10 Компани гаргасан хувьцаагаа эргүүлэн худалдан авах, халаасны хувьцааг дахин худалдах замаар эргэлтэнд оруулах, хүчингүй болгох замаар эргэлтээс гаргах;
- 6.2.11 Компанийн тухай хуульд заасны дагуу их хэмжээний хэлцэл батлах;
- 6.2.12 Компанийн тухай хуулийн 12-р бүлэгт заасан сонирхолын зөрчилтэй хэлцэл батлах;
- 6.2.13 ТУЗ-ийн шийдвэрээр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлэхээр оруулсан бусад асуудлууд;
- 6.2.14 Хууль тогтоомж болон энэхүү дүрэмд заасан хувьцаа эзэмшигчдийн шийдвэрлэх бусад асуудал.
- 6.3 Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрхийг эдлэх М-Си-Эс Монголиа ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас шийдвэрлэсэн бүх асуудлаар тогтоол гаргана. Тогтоолд М-Си-Эс Монголиа ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга гарын үсэг зурна. Хурлын явц хэлэлцсэн асуудлын талаар дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлнө. Хэлэлцсэн асуудал, тэмдэглэл, тогтоолуудыг Компани бүртгэж хадгална.
- 6.4 М-Си-Эс Монголиа ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөр хэлэлцэхээр товлосгүй асуудлыг хуралд оролцож буй Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар хэлэлцэж болно.
- 6.5 Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийн эрх барих дээд байгууллага нь Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид "ТУЗ" гэх) байна.
- 6.6 Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрхийг эдлэх М-Си-Эс Монголиа ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТУЗ-ийг 7 хүртэл гишүүнтэйгээр томилно.
- 6.7 ТУЗ нь Компанийн тухай хуульд заасан төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг эдэлж үүрэг хүлээхээс гадна дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 6.7.1 Компанийн болон охин компаниудын (цаашид нийтэд нь "Компаниуд" гэх) үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох;
- 6.7.2 Компаниудын маркетингийн нэгдсэн төлөвлөгөө, төсвийг ханган батлах, тэдгээрийн гүйцэтгэлийн талаар дүгнэлт гаргах;
- 6.7.3 Компаниудын урт болон богино хугацааны санхүүгийн болон хөрөнгө оруулалтын нэгдсэн төлөвлөгөөг батлах, тэдгээрийн гүйцэтгэлийн талаар дүгнэлт гаргах;
- 6.7.4 Компаниудын зохион байгуулалтын бүтэц, орон тоо болон цалингийн сангийн хэмжээг тогтоох;
- 6.7.5 Охин компаниудын Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх удирдлагыг томилох, өөрчлөх, бүрэн эрхийг тогтоох, тэдгээртэй байгуулах гэрээний нөхцөл, тэдгээрт олгох шагнал урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;
- 6.7.6 Охин компаниудын Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам болон компаниудад нийтээр мөрдөгдөх дүрэм, журмыг батлах;
- 6.7.7 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
- 6.7.8 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, хурлыг хуралдуулахтай холбогдолтой асуудлыг шийдвэрлэх;



2023.08.18

- 6.7.9 Компаниудын эд хөрөнгөөс хувь хүн, хуулийн этгээдэд хандивлах, бэлэглэх, барьцаалах, хөрөнгийн баталгаа гаргах, зээл олгох;
 - 6.7.10 Сонирхолын зөрчил бүхий этгээдтэй хэлцэл хийх зөвшөөрлийг олгох;
 - 6.7.11 Охин компани болон компанийн салбар, төлөөлөгчийн газрыг байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааг зогсоох, татан буулгах;
 - 6.7.12 Компанийн болон охин компаниудын Гүйцэтгэх удирдлага болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрийг шаардлагатай тохиолдолд өөрчлөх;
 - 6.7.13 Охин компанийн ногдол ашгийн хэмжээ болон түүнийг төлөх журмыг тогтоох;
 - 6.7.14 Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрлийг олгох;
 - 6.7.15 Компанийн санхүүгийн тайлан тэнцэлд хөндлөнгийн хяналт хийх аудитын байгууллагыг сонгож гэрээ байгуулах, хяналт хийлгэх, тайланг хэлэлцэж дүгнэлт гаргах;
 - 6.7.16 Ердийн бизнесийн үйл ажиллагаанаас гадуур компанийн эд хөрөнгийг худалдах, барьцаалах болон бусад хэлбэрээр захиран зарцуулах;
 - 6.7.17 Компанийн болон охин компаниудын Гүйцэтгэх удирдлага болон Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс шийдвэрлүүлэхээр оруулсан асуудлыг хэлэлцэх.
- 6.8 ТУЗ-ийн шийдвэр хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхийн саналгаар хүчин төгөлдөр болох бөгөөд тогтоол хэлбэрээр гаргана. Тогтоолд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга гарын үсэг зурна. Хурлын явц, хэлэлцсэн асуудлын талаар далгэрэнгүй протокол хөтөлнө. Халалцсан асуудал, протокол, тогтоолуудыг компани бүртгэж хадгална.

Долоо. Гүйцэтгэх удирдлага

- 7.1. Компанийн гүйцэтгэх удирдлагыг компанийн Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.
- 7.2. Гүйцэтгэх захирлыг ТУЗ-өөс томилно. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 7.3. ТУЗ нь Гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулан захирлын эрх, үүрэг, хариуцлагын хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэргийг тогтоож өгнө.
- 7.4. Компанийн Гүйцэтгэх захирал нь дор дурдсан үүрэг хүлээж эрх эдэлнэ.
 - 7.4.1 Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, хувицаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, тухайн жилийн бизнес төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;
 - 7.4.2 Компанийн нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг явуулах;
 - 7.4.3 ТУЗ-ийн хурлаас баталсан зардлын хэмжээнд багтаан компанийн ажилтнуудын орон тоо, үндсэн болон нэмэгдэл цалин, тэтгэмж, хөнгөлөлт, урамшууллын хэмжээг тогтоох;
 - 7.4.4 Ажилтнуудын ажил үүргийн хуваарийг тогтоох, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх;
 - 7.4.5 ТУЗ-тэй байгуулсан гэрээгээр олгогдсон эрх хэмжээний хүрээнд компанийн нэрийн өмнөөс баталгаа гаргах, гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурах;
 - 7.4.6 Компанийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар өөрийн эрх хэмжээний дотор дүрэм, журам, заавар батлах, тушаал гаргаж, биелэлтийг хангуулах;
 - 7.4.7 Энэхүү дүрэмд болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан үүргээ биеллэн гүйцэтгэх;
 - 7.4.8 Компанид учруулсан хохирлыг төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах, компанид холбогдох эрүү, иргэн, захиргааны хэрэг маргааны асуудлаар шүүх, цагдаа бусад хуулийн байгууллагад нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилон оролцуулах;
 - 7.4.9 Компанийн эд хөрөнгийг захиран зарцуулах төлбөрийн баримтад гарын үсэг зурах, арилжааны банкинд харилцах данс нээх, хаах, дансаар гадаад болон дотоод бэлэн болон бэлэн бус гүйлгээ хийх, интернет банк ашиглах, банкинд гаргаж өгсөн өөрийн гарын үсгийн баталгааг сольж өөрчлөх, хоёрдугаар гарын үсэг зурах эрх бүхий этгээдийг томилох, чөлөөлөх, Компанийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотойгоор банкны бусад үйлчилгээг авах;
 - 7.4.10 Гэрээнд заасан бусад эрх, үүрэг.
- 7.5. Компанийн гүйцэтгэх захирал нь компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна.



- 7.6. Гүйцэтгэх захирал ээлжийн амралт эдлэх, гадаад дотоодод албан томилолтоор ажиллах, удаан хугацаагаар өвчлөх тохиогдолд өөрийн эрх, үүргийг өөрийн томилсон этгээдэд шилжүүлнэ. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Найм. Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих хяналт

- 8.1. Компанийн санхүүгийн жил нь жил бүрийн 1-р сарын 1-ний өдрөөс эхэлж, тухайн жилийн 12-р сарын 31-ний өдөр дуусна.
- 8.2. Компанийн санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу жил бүр гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан хэвлүүлнэ.
- 8.3. Санхүүгийн тайланд Компанийн тухай хуулийн 96.1 дэх хэсэгт заасанчлан санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулга бүрэлдэхүүнтэй байна.
- 8.4. Санхүүгийн тайлангуудын үнэн зөвийг Гүйцэтгэх захирал, Санхүү эрхэлсэн удирдах ажилтан хариуцна.
- 8.5. Компанийн өдөр тутмын нягтлан бодох бүртгэл, санхүү бизнесийн үйл ажиллагаа холбогдох заавар журмын дагуу явагдаж буй эсэхэд дотоод аудитын нэгж нь хөндлөнгийн хяналт шалгалт хийж, ажлаа Компанийн Гүйцэтгэх удирдлагад тайлагнах үүрэг хүлээнэ.
- 8.6. Компанийн санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулж, санхүү эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудиторыг сонгон ажиллуулж болно.
- 8.7. Аудитын байгууллагын шалгалтын хөлсийг Компанийн тухай хуулийн 94.8 дахь хэсэгт заасны дагуу компани хариуцан төлнө.
- 8.8. Аудитор нь хувьцаа эзэмшигчдийн хуралд зөвхөн тайлбар өгөх үүрэгтэй оролцож болно.
- 8.9. Компани нь Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан баримт бичгийг хадгалах, байнга хадгалах, эрх бүхий этгээдийн шаардлагаар танилцуулах, хуульд заасан хугацаа дууссаны дараа архивт шилжүүлнэ.

Ес. Ногдол ашиг хуваарилах, компанийн өмчийг шилжүүлэх


- 9.1. Компанийн ногдол ашиг хуваарилах шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хурал гаргана.
- 9.2. Ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байна.
- 9.3. Ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно.
- 9.4. Компани эргүүлж авсан өөрийн хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй.

Арав. Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах

- 10.1. Компанийн хувьцаа эзэмшигч нь компанийг өөрчлөн байгуулахдаа Компанийн тухай хуулийн 18-23 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.
- 10.2. Компанийг Компанийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан үндэслэлээр татан буулгана.
- 10.3. Компанийг татан буулгах шийдвэр гаргасан эрх бүхий этгээд татан буулгах комиссыг томилно.
- 10.4. Компанийг татан буулгах шийдвэр гаргасан эрх бүхий этгээд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулинд заасан хугацаанд бүртгэх байгууллагад бичгээр мэдэгдэж, холбогдох баримт бичгийг хавсаргасан байна.
- 10.5. Татан буулгах комисс Иргэний хуулийн 32.2-32.10 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 26, 27, 28 дугаар зүйлд заасны дагуу компанийг татан буулгах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.
- 10.6. Компани татан буугдсаныг улсын бүртгэлд бүртгүүлэхдээ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулинд заасан баримт бичгийг бүрдүүлж бүртгэх байгууллагад ирүүлнэ.



2023.08.18



VI. ХАВЦРАЛТ

Арван нэг. Бусад зүйл

- 11.1. Энэхүү дүрмийг монгол хэлээр тус бүр 2 хуви үйлдэж, нэг хувийг хуулийн этгээдийн бүртгэх байгууллагад, нэг хувийг Компани хадгална.
- 11.2. Компанийн дүрмийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болсонд тооцогдоно.




-000-



2023.08.18

6.6 СИМПЛ АССЕТ ТЭК ХХК-ИЙН ГЭРЧИЛГЭЭ



МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
000252707

2022.04.13 <small>/ Бүртгэсэн өч сар, өдөр /</small>	9011838466 <small>/ Хувийн хэргийн дугаар /</small>	
	6852688 <small>/ Регистрийн дугаар /</small>	
Симпл ассет	Хязгаарлагдмал хармуцлагатай компани <small>/ Хуулийн этгээдийн нэр, хармуцлагын хэлбэр /</small>	
Дүрэм <small>/ Үүсгэн байгуулах баримт бичиг /</small>		
Шийдвэр <small>/ Шийдвэрийн нэр /</small>	01 <small>/ Дугаар /</small>	2022.04.06 <small>/ Он, сар, өдөр /</small>
82990 <small>/ Код /</small>	Бизнесийн зөвлөх үйлчилгээ <small>/ Үйл ажиллагааны чиглэл /</small>	
Хугацаагүй <small>/ Хугацаа /</small>	1 <small>/ Хувийн тоо /</small>	1,000.00 <small>/ Хөөнгөийн хэмжээ, мянган төгрөгөөр /</small>
<small>Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, Сантрал гауэр, 15 дөвхөр. Утас1: 77112828, Утас2: Факс: <small>/ Хуулийн этгээдийн албан ёсны хаяг /</small></small>		
	ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР <small>/ Бүртгэсэн байгууллагын нэр /</small>	
	УЛСЫН БҮРТГЭГЧ <small>(Гэгээт)</small>	Э.МӨНХЗАГА <small>(Тарын үсэг)</small>

УЛААНБААТАР ХОТ
АШНД КАПИТАЛ
ББСХ ХХК
ATAA987 4 61055
90220105

МАНДАЛ КАПИТАЛ
МАРКЕТС УЦК ХХК
MANDAL CAPITAL
MARKETS SC
LLC
УТ 00082 21070414 5013407

2023.08.18



Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Наранчулуун овогтой Эрдэнэхүүн Гүлжээтэй захирал -р сонгогсон(тэмдэглэсэн)-ыг бүртгэв. Давшадорж овогтой Баярсайхана Туяагийн дараа-р сонгогсон(тэмдэглэсэн)-ыг бүртгэв.	2022.04.13 2022.04.13	Э Мөнхзаяа Э Мөнхзаяа



Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.


000252787





6.7 СИМПЛ АССЕТ ТЭК ХХК-ИЙН ДҮРЭМ

Үүсгэн байгуулагчийн 2022 оны 04 сарын 03 өдрийн ~~13~~ албан тоотын хавсралт



"СИМПЛ АССЕТ"
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ
КОМПАНИЙН ДҮРЭМ





Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Сигл Ассет ХХК /цаашид "Компани" гэх/ нь Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулах хязгаарлагдмал хариуцлагатай компани байна.
- 1.2. Компанийн оноосон нэр:
 - а) Бүтэн нэр: "Сигл Ассет" ХХК /цаашид энэ дүрэмд "Компани" гэх/;
 - б) Товчилсон нэр: "Сигл Ассет" ХХК;
 - в) Англи нэр: Simple Asset
- 1.3. Компанийн оршин байгаа газар:

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар Дүүрэг, 8-р хороо, Сэнтрал тауэр 15 давхар
Харилцах утасны дугаар: 77112828
- 1.4. Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн мэдээлэл:

Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл	Регистрийн дугаар	Хаяг	Утас
"Ашид Капитал ББСБ" ХХК	6105572	СБД, 8-р хороо, Сэнтрал тауэр 15 давхар	77112828

- 1.5. Компани нь өөрийн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байна.
- 1.6. Компани нь өөрийн ажил болон бизнесийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэхтэй холбоотой бүхий л үйлчилгээг гуравдагч этгээдтэй гэрээ байгуулж гүйцэтгүүлнэ.
- 1.7. Компанийн одоогийн болон ирээдүйн өр төлбөр нь (татварыг оролцуулан) тоогоор илэрхийлэгдэх ба түүний боломжит эх үүсвэрээр хангагдахуйц боломжтой байна.

Хоёр. Компанийн үйл ажиллагаа

- 2.1. Компани нь бизнесийн зөвлөх үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулна.

Гурав. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө
- 3.1. Компани нь 1 ширхэгийн 1,000,000.00 (нэг сая) төгрөгийн үнэ бүхий хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна.

Дөрөв. Компанийн удирдлага

- 4.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал
 - 4.1.1. Компанийн эрх барих дээд байгууллага болох хувьцаа эзэмшигчдийн хурал (цаашид "ХЭХ" гэх)-ын бүрэн эрхийг энэ дүрмийн 1.4-т заасан ганц хувьцаа эзэмшигч болох "Ашид Капитал ББСБ" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл



2023.08.18

(цаашид "АШИД-ТУЗ" гэх) компанийн ХЭХ хуралдуулах тухай Компанийн тухай хуульд заасан журмын дагуу дараах байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд:

- 4.1.1.1. АШИД-ТУЗ нь ХЭ-ын ээлжит хурлын бүрэн эрхийг Компанийн ТУЗ-өөс Компанийн тухай хуульд заасан хугацаа, журмын дагуу гаргасан шийдвэрийг үндэслэн хэрэгжүүлнэ. Компанийн ТУЗ энэхүү шийдвэрийг зохих хугацаанд нь гаргаагүй бол ХЭХ-ын бүрэн эрхийг хэрэгжүүлэх тухай шийдвэр гаргахас бусад эрх нь дуусгавар болно.
- 4.1.1.2. Энэхүү дүрмийн 4.1.1.1-д зааснаас өөр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх асуудал үүссэн тохиолдолд Компанийн ТУЗ эсхүл АШИД-ТУЗ-ийн хурал хуралдуулах тухай гаргасан шийдвэрийг үндэслэн АШИД-ТУЗ хуралдаж холбогдох шийдвэрийг гаргана.
- 4.1.1.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэх тухай Компанийн ТУЗ болон АШИД-ТУЗ шийдвэр гаргахдаа Компанийн тухай хуулийн 60.2-т заасныг удирдлага болгоно.
- 4.1.1.4. АШИД-ТУЗ Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэх хурлыг өөрийн хурал хуралдуулж шийдвэр гаргах журмын дагуу хэрэгжүүлнэ. АШИД-ТУЗ-ийн энэхүү хурлын шийдвэр нь Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын хуулийн хүчин төгөлдөр шийдвэр болно.

4.2. Төлөөлөн удирдах зөвлөл

- 4.2.1. Компани нь ТУЗ-тэй байх бөгөөд ТУЗ нь Компанийн тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээний асуудлаас гадна энэ дүрмийн 4.2.6-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
- 4.2.2. Компанийн ТУЗ нь 3 (гурван) хүртэлх гишүүнтэй байх ба ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Тэдгээрийг компанийн ХЭХ-ын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч энэ дүрмийн 4.1-т заасан этгээд томилно.
- 4.2.3. Хараат бус гишүүн нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 4.2.3.1. АШИД-ТУЗ-ийн гишүүн эсхүл гишүүний төрөл садан бус байх;
 - 4.2.3.2. Ашид Капитал ББСБ ХХК-ийн ажилтан эсхүл ажилтны төрөл садан бус байх;
 - 4.2.3.3. Сүүлийн 2 жилийн хугацаанд Ашид Капитал ББСБ ХХК-ийн ажилтан, эсхүл АШИД-ТУЗ-ийн гишүүнээр ажиллаагүй байх;
 - 4.2.3.4. Өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран Компанийн энгийн хувьцааны 5 хувиас дээш хувийг эзэмшдэггүй байх;
 - 4.2.3.5. Өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь Компанийн болон Компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчдод эрх бүхий албан тушаал эрхэлдэггүй байх;



2023.08.18

- 4.2.3.6. Компанийн эрх ашигт бүрэн нийцүүлэн ажиллах чадвар, бие даан шийдвэр гаргахад нөлөөлөх боломжтой аливаа ажил хэргийн эсхүл Ашид Капитал ББСБ ХХК-тай холбоотой бусад харилцаа холбооноос ангид байх.
- 4.2.4. ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүдийн дотроос тэдгээрийн олонхын саналаар сонгоно. ТУЗ-ийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байна.
- 4.2.5. ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлсөн, эсхүл аливаа шалтгаанаар гишүүний эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд түүнийг ХЭХ-ын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нөхөн сонгоно.
- 4.2.6. ТУЗ нь Компанийн тухай хуульд заасан бүрэн эрхээс гадна дор дурдсан үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 4.2.6.1. Компанийн дүрмийн хэрэгжилтийг хангуулах;
- 4.2.6.2. Компанийн хөрөнгийг хадгалж хамгаалах ажиллагааг хэрэгжүүлэх;
- 4.2.6.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан эрх үүргийн дагуу хяналт тавих;
- 4.2.6.4. энэхүү Дүрэмд заасан Компанийн зөвшөөрөгдсөн ажил хэрэг болон үйл ажиллагаатай холбоотой гэрээ болон бусад баримт бичиг байгуулах;
- 4.2.6.5. Компанийн нэр дээр банкны данс нээлгэх;
- 4.2.6.6. Компанийн худалдан авсан зээлийн хөрөнгөд үйлчилгээ үзүүлж буй этгээдийн гүйцэтгэлийг хянах, шаардлагатай бол тэдгээрийг солих санал гаргах;
- 4.2.6.7. Компани нь өөрийн байгуулсан гэрээ болон бусад баримт бичгүүдээр хүлээсэн үүргээ чанд мөрдөж, гүйцэтгэж байгаад хяналт тавьж, хангуулах;
- 4.2.6.8. Компанийн байгуулсан гэрээ болон бусад баримт бичгүүдээр Компанид олгогдсон бүх эрх болон эрх хамгаалах хэрэгслийг хэрэгжүүлэх;
- 4.2.6.9. Хууль, СЗХ-ны журам болон Компанийн дүрэмд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх.
- 4.2.7. ТУЗ-ийн хурал гурван сард нэгээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн даргын санаачилгаар эсхүл ТУЗ-ийн гишүүдийн олонхын саналаар ээлжит бус хурлыг хуралдуулж болно.



- 4.2.8. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх нь оролцсоноор хурлын ирцийг бүрдүүлэх ба ТУЗ-ийн шийдвэр нь хуралд оролцсон гишүүдийн санал нэгтэй шийдвэрээр батлагдана.
- 4.2.9. ТУЗ-ийн гишүүн нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасны дагуу эрх бүхий албан тушаалтанд тооцогдох бөгөөд тус хуулийн 85 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ.
- 4.3. Гүйцэтгэх удирдлага:
- 4.3.1. Компани нь Гүйцэтгэх захиралтай байна.
- 4.3.2. Гүйцэтгэх захирал нь Компаний тухай хуульд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.
- 4.3.3. Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

Тав. Аудит ба хяналтын тогтолцоо

- 5.1. Компанийн ТУЗ нь ХЭХ-ын эрхийг хэрэгжүүлэгчийн шийдвэрийг үндэслэн СЗХ-оос зөвшөөрөл авсан аудиторыг томилж гэрээ байгуулна. Ээлжит аудитыг Компанийн санхүүгийн жилийн тайланг хянуулах, баталгаажуулах үүднээс хийлгэнэ. ХЭХ-ын эрхийг хэрэгжүүлэгчийн шийдвэрийн дагуу тусгай (ээлжит бус) аудитын шалгалтыг хийж болно.
- 5.2. Аудитор нь Компанийн дүрмийн нөхцөлийг дагаж мөрдөж байгаа эсэх болон шийдвэрүүдийн хэрэгжилтэд шалгалт хийх, Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг хянаж тайлан гаргах, СЗХ-ны шаардлагаар Компанийн эдийн засгийн болон санхүүгийн үйл ажиллагааг шалгах, мөн Компанийн тухай хууль болон энэхүү Дүрэмд заасан бусад ажил болон чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 5.3. Аудитор нь ХЭХ-ын хурлын эрхийг хэрэгжүүлэгчид хийсэн аудитын тайлангийн үр дүнг танилцуулж зохих шийдвэр гаргуулах эрхтэй.

Зургаа. Санхүүгийн үйл ажиллагаа

- 6.1. Компанийн санхүүгийн жил тухайн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дараа жилийн 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл байна.
- 6.2. Компани нь нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг болон бүртгэлийг хадгалж, хувьцаа эзэмшигч болон хуулиар шаардсан эрх бүхий бусад этгээдэд танилцуулахаар санхүүгийн тайланг бэлтгэнэ.
- 6.3. Компани санхүүгийн тайлангаа бүртгэх, хөтлөх, тайлагнахдаа Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартыг баримтална.
- 6.4. Компанийн бэлтгэсэн нягтлан бодох бүртгэл хөтлөлт болон санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хөрөнгө итгэмжлэн удирдагч хариуцна.



2023.08.18

Долоо. Дүрэм хүчин төгөлдөр болох ба татан буугдах ажиллагаа

7.1. Энэхүү дүрэм нь Компанийг улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.



—ooOoo—

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ:
АШИД КАПИТАЛ ББСБ ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ,
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ


Б.ТЭМҮҮЛЭН







MCS ХОЛДИНГ ХХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 он 08 сар 14 өдөр

Дугаар 940

Улаанбаатар хот

Өрийн бичиг гаргахыг
охин компанид зөвшөөрөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт болон 62.1.16 дахь заалт, Ашид Капитал ББСБ ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч М-Си-Эс Холдинг ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 05 сарын 12-ны өдрийн 03 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. М-Си-Эс Холдинг ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 05 сарын 12-ны өдрийн тогтоолоор олгогдсон 55,000,000,000 /Тавин таван тэрбум/ төгрөг хүртэлх дүнгээр үнэт цаас гаргах ерөнхий зөвшөөрлийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авсан байгууллагаар санхүүгийн чадавхын зэрэглэл тогтоолгосны дагуу 15,000,000,000 /Арван таван тэрбум/ төгрөгийн үнийн дүнтэй өрийн бичгийг дараах нөхцөлөөр нийтэд санал болгон гаргахыг зөвшөөрсүгэй:
 - 1.1. Өрийн бичгийн арилжаа: Нийтэд нээлттэй санал болгон арилжих
 - 1.2. Үнэт цаасны төрөл: Нээлттэй өрийн бичиг
 - 1.3. Өрийн бичгийн тоо, ширхэг: 150,000 /нэг зуун тавин мянга/ ширхэг
 - 1.4. Нэгжийн нэрлэсэн үнэ: 100,000 /нэг зуун мянга/ төгрөг
 - 1.5. Өрийн бичгийн хугацаа: 12 сар
 - 1.6. Өрийн бичгийн хүү: жилийн 17.5 хувь
 - 1.7. Хүүгийн төлөлт: Сар тутамд
 - 1.8. Үндсэн төлбөр: Хугацааны эцэст
 - 1.9. Үндсэн төлбөр төлөлт: Хугацааны эцэст
 - 1.10. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зориулалт: Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт
 - 1.11. Арилжаалах зах зээл: Монголын Хөрөнгийн бирж ХК
2. Өрийн бичгийг нийтэд санал болгож хөрөнгө татан төвлөрүүлэхтэй холбоотойгоор шаардагдах ажлыг зохион байгуулах, Бондын гэрээ болон шаардлагатай гэрээ, хэлцэл байгуулах болон холбогдох бусад бичиг баримтад Ашид Капитал ББСБ ХХК-ийг төлөөлж гарын үсэг зурах, холбогдох этгээдэд итгэмжлэл олгох болон шаардлагатай арга хэмжээг авч ажиллах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал П. Батжаргалд олгосугай.
3. Өрийн бичиг гаргах зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржээс авах, холбогдох хүсэлт гаргах, хүлээн авах, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэх эрхийг Ашид Капитал ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирал П. Батжаргалд олгосугай.




Handwritten signature



2023.08.18



simple



4. Энэхүү тогтоолтой холбогдуулан Ашид Капитал ББСБ ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолд М-Си-Эс Холдинг ХХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал Л. Гантөмөрт олгосугай.
5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ашид Капитал ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ж. ОДЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТ
АШИД КАПИТАЛ
ЕВЭС ХХК
АТЭСНЭЗ-4 61002
ШТК0162 9021070414 5213487

Handwritten signature

МАНДАЛ КАПИТАЛ
МАРКЕТС ҮЦК ХХК
MANDAL CAPITAL
MARKETS SC
LLC
127
ШТК0162 9021070414 5213487

ГЭМЭГ
2023.08.18



3. Энэхүү шийдвэртэй холбогдуулан өрийн бичиг гаргах зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржээс авах, холбогдох хүсэлт гаргах, хүлээн авах, шаардлагатай арга хэмжээг тухай бүри авч хэрэгжүүлж ажиллах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал П.Батжаргалд олгосугай.
4. Шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ашид Капитал ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

М-СИ-ЭС ХОЛДИНГ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



П. ГАНТӨМӨР




128



2023.08.18

6.9 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУЗ ТОМИЛСОН ШИЙДВЭР



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 08 сарын 08 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Охин компанийн дүрмийн шинэчлсэн найруулга болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай


Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, М-Си-Эс Холдинг ХХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.7.5 дахь заалт болон Ашид Капитал ББСБ ХХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх заалтыг тус тус үндэслэн Ашид Капитал ББСБ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч М-Си-Эс Холдинг ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ НЬ:

1. М-Си-Эс Холдинг ХХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттай охин компани Ашид Капитал ББСБ ХХК-ийн дүрмд бичигдсэн "Захирлуудын зөвлөл" гэх нэршлийг "Төлөөлөн Удирдах Зөвлөл" болгон өөрчилсүгэй.
2. Дээрх заалттай холбогдуулан Ашид Капитал ББСБ ХХК-ийн холбогдох бусад баримт бичигт бичигдсэн "Захирлуудын зөвлөл" гэх нэршлийг "Төлөөлөн Удирдах Зөвлөл" болгон өөрчилсүгэй.
3. Ашид Капитал ББСБ ХХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.9 дэх заалтыг дараах байдлаар өөрчилсүгэй:
7.3.9 Компанийн дотоод журалд заасан эрх хэмжээний хүрээнд Компанийн эд хөрөнгийг захиран зарцуулах төлбөрийн баримтад гарын үсэг зурах, арилжааны банкинд харилцах данс нээх, хаах, дансаар гадаад болон дотоод бэлэн болон бэлэн бус гүйлгээ хийх, интернет банк ашиглах, банкинд гаргаж өгсөн өөрийн гарын үсгийн баталгааг сольж өөрчлөх, нэг болон хоёрдугаар гарын үсэг зурах эрх бүхий этгээдийг томилох, чөлөөлөх, Компанийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотойгоор банкны бусад үйлчилгээг авах;
4. Тогтоолын 1 болон 3-т заасан өөрчлөлтийг тусгасан Ашид Капитал ББСБ ХХК-ийн дүрмийн шинэчлсэн найруулгыг хавсралт босоор баталсугай.
5. Ашид Капитал ББСБ ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

ДАРГА
ГИШҮҮД

ХАРААТ БУС ГИШҮҮН

Батболд овогтой Билигүүн /РД: Ц376060216/
Ганбямба овогтой Мянмаржав /РД: БЭ84091173/
Лингов овогтой Гангөмөр /РД: УН170042214/
Батмөнх овогтой Тэмүүлэн /РД: ЦБ86022313/
Даваадорж овогтой Баярсайхан /РД: ЧН82091915/



Handwritten signature



129



2023.08.18



simple




- 6. Ашид Капитал ББСБ ХХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулга болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх, түүнтэй холбогдуулан улсын бүртгэлийн байгууллага, албан гушаалтантай Ашид Капитал ББСБ ХХК-ийг бүрэн эрхтэйгээр төлөөлөн харилцах, шаардлагатай бүх баримт бичгийг хүлээлгэн өгөх, хүлээн авах бүрэн эрхийг Ашид Капитал ББСБ ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга Батбаатар овогтой Энхмандах-д олгосугай.
- 7. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ашид Капитал ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захиралд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ж. ОДЖАРГАЛ



Handwritten signature



2023.08.18



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ШИЙДВЭР

2023 3 9

01

Компанийн дүрмийн шинэчлсэн найруулга болон
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Ашид
Капитал ББСБ ХХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх заалтыг тус тус үндэслэн
ШИЙДВЭРЛЭХ НЬ:

1. Ашид Капитал ББСБ ХХК-ийн дүрэмд бичигдсэн “Захирлуудын зөвлөл” гэх нэршлийг
“Төлөөлөн Удирдах Зөвлөл” болгон өөрчилсүгэй.
2. Дээрх заалттай холбогдуулан Ашид Капитал ББСБ ХХК-ийн холбогдох бусад баримт
бичигт бичигдсэн “Захирлуудын зөвлөл” гэх нэршлийг “Төлөөлөн Удирдах Зөвлөл” болгон
өөрчилсүгэй.
3. Ашид Капитал ББСБ ХХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.9 дэх заалтыг дараах
байдлаар өөрчилсүгэй:

*7.3.9 Компанийн дотоод журалд заасан эрх хэмжээний хүрээнд Компанийн эд хөрөнгийг
захирын зарцуулах төлбөрийн баримтад гарын үсэг зурах, арилжааны банкинд харилцах
данс нээх, хаах, дансаар гадгаад болон дотоод бэлэн болон бэлэн бус гүйлгээ хийх, интернет
банк ашиглах, банкинд гаргаж өгсөн өөрийн гарын үсгийн баталгааг сольж өөрчлөх,
хоёрдугаар гарын үсэг зурах эрх бүхий этгээдийг томилж, чөлөөлөх, Компанийн өдөр
тутмын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотойгоор банкны бусад үйлчилгээг авах:*



4. Шийдвэрийн 1 болон 3-т заасан өөрчлөлтийг тусгасан Ашид Капитал ББСБ ХХК-ийн
дүрмийн шинэчилсэн найруулгыг хавсралт ёсоор баталсугай.
5. Ашид Капитал ББСБ ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр
баталсугай.

ДАРГА
ГИШҮҮД

ХАРААТ БУС ГИШҮҮН

Батболд овогтой Билигүүн /РД: Ц376060216/
Ганбямба овогтой Мягмаржав /РД: ЕЭ84091173/
Лингов овогтой Гантөмөр /РД: УШ70042214/
Батмөнх овогтой Тэмүүлэн /РД: ЦБ86022313/
Даваадорж овогтой Баярсайхан /РД: ЧЙ182091915/





VI. ХАВСРАЛТ

6. Ашид Капитал ББСБ ХХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулга болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх, түүнтэй холбогдуулан улсын бүртгэлийн байгууллага, албан тушаалтантай Ашид Капитал ББСБ ХХК-ийг бүрэн эрхтэйгээр төлөөлөн харилцах, шаардлагатай бүх баримт бичгийг хүлээлгэн өгөх, хүлээн авах бүрэн эрхийг Ашид Капитал ББСБ ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичиг Батбаатар овогтой Энхмандах-д олгосугай.
7. Шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ашид Капитал ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

М-СИ-ЭС ХОЛДИНГ ХХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ж. ОДЖАРГАЛ



2023.08.18

6.10 КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН АНКЕТ



Д.Баярсайхан
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Боловсрол

- Токиогийн их сургууль-Эдийн засгийн магистр
- Хитофибаши их сургууль - Эдийн засгийн бакалавр
- МУИС-Эдийн засгийн сургууль - Олон улсын худалдааны бакалавр

Туршлага

- Ашид Капитал ББСБ ХХК- ТУЗ-ийн хараат бус гишүүн
- Лонг терм партнерс ХХК- Гүйцэтгэх захирал
- Дэлхийн Банк/Санхүүгийн олон улсын корпораци - Хөрөнгө оруулалтын мэргэжилтэн
- Deutsche Securities- Хувьцааны дилер

Гарын үсэг:  /Д.Баярсайхан/



Б.Тэмүүлэн
ТУЗ-ийн гишүүн

Боловсрол


- Күйн Мэригийн их сургууль: Банк, санхүү - Магистр
- Швед Улсын Ионшопин олон улсын бизнесийн дээд сургууль: Бизнесийн удирдлага - Бакалавр

Туршлага

- Ашид Капитал ББСБ ХХК: Гүйцэтгэх захирал
- М ХХК: Судалгаа хөгжүүлэлт, бизнес хөгжлийн албаны дарга
- М-Си-Эс Холдинг ХХК: Хөрөнгө оруулалтын ахлах менежер
- М-Си-Эс Металс ХХК: Бизнес хөгжлийн менежер
- Энержи Ресурс ХХК: Санхүүгийн шинжээч

Гарын үсэг:  /Б.Тэмүүлэн/





ТУЗ-ийн гишүүн:
Г.Мягмаржав

Эрхлэж буй албан тушаал:
М-Си-Эс Инвестмент ХХК-ийн Гүйцэтгэх захирал

Боловсрол:
2010-2012 онд - АНУ-ын "Диврай" Их сургууль
2002-2006 онд - ШУТИС-ийн Компьютерийн техник,
менежментийн сургууль

Санхүүгийн удирдлага мэргэжилтэй, Магистр

Ажилын туршлага:
2020 оноос - М-Си-Эс Инвестмент ХХК; М-Си-Эс Венчерс ХХК-ийн Гүйцэтгэх захирал
2013-2020 онд - Юнител Группийн Дэд Ерөнхийлөгч, Санхүү эрхэлсэн захирал
2012-2013 онд - Гоёо ХХК-ийн Дэд захирал
2009-2010 онд - Монголиан Майнинг Корпорацийн Санхүүгийн менежер
2007-2009 онд - М-Си-Эс Холдинг ХХК-д Санхүүгийн Менежер
2005-2007 онд - Интерпресс ХХК, Анун ХХК-д Санхүүгийн шинжээч

Гарын үсэг:  /Г.Мягмаржав/



Ж.Од
М-Си-Эс Холдинг ХХК-ийн
Ерөнхийлөгч

Боловсрол

- Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Оксфордын их сургууль: Олон улсын харилцаа - Магистр
- ЗХУ-ын Москва хотын Олон улсын харилцааны их Сургууль: Олон улсын харилцаа - Бакалавр

Туршлага


- М-Си-Эс Холдинг ХХК: Ерөнхийлөгч
- Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх
- АНУ дахь Монгол Улсын Элчин сайдын яам: Нэгдүгээр нарийн бичгийн дарга
- Гадаад харилцааны яамны Америк, Европын газар: Мэргэжилтэн
- Гадаад харилцааны яамны Гэрээ эрхийн хэлтэс: Мэргэжилтэн
- Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Нью-Йорк дахь байнгын төлөөлөгчийн газар: Атташе
- Гадаад харилцааны яамны Гэрээ эрхийн хэлтэс: Мэргэжилтэн



Гарын үсэг:  /Ж. Од/



2023.08.18



Брокер буй албан тушаал
М-Си-Эс Холдинг ХХК-ийн Гүйцэтгэх захирал

Боловсрол

- 1997-1998 онд - Нидерландын Ванг Улсын Маастрихтийн менежментийн сургууль
- 1993-1995 онд - ШУТИС-ийн Компьютерийн техник, менежментийн сургууль
- 1988-1993 онд - ОХУ-ын Москва хотын Удирдлагын академи


Инженер-эдийн засагч мэргэжилтэй, Бизнесийн удирдлагын магистр




ТУЗ-ийн гишүүн:
Л.Гантөмөр

Ажлын туршлага

- 2015 оноос - М-Си-Эс Холдинг ХХК-ийн Гүйцэтгэх захирал
- 2014-2015 онд - М-Си-Эс Кока-Кола ХХК-ийн Гүйцэтгэх захирал
- 2006-2014 онд - М-Си-Эс Группийн Дэд ерөнхийлөгч
- 2004-2005 онд - Проктер энд Гэмбл Казахстан компанид Дистрибьюторын үйл ажиллагаа хариуцсан менежер
- 2001-2004 онд - Проктер энд Гэмбл Истерн Европ Инк компанид Улс хариуцсан менежер
- 1999-2000 онд - Проктер энд Гэмбл Истерн Европ Инк компанид Борлуулалтын менежер
- 1999 онд - Проктер энд Гэмбл Казахстан компанид Борлуулалтын менежер
- 1997 онд - ЗГХЭГ-ын "Төвлөрлийг сааруулах, нутгийн захиргааг бэхжүүлэх" төслийн удирдлагын нэгжид Төслийн үндэсний зохицуулагч
- 1993-1997 онд - ШУТИС-ийн Компьютерийн техник, менежментийн сургуульд Багш

Гарын үсэг:  /Л.Гантөмөр/





ТУЗ-ийн дарга:
Б.Билигун

Эрхэлж буй албан тушаал:
М-Си-Эс Инвестмент ХХК-ийн Гүйцэтгэх дэд ерөнхийлөгч

Боловсрол:
1998-2000 онд - АНУ-ын Техасын их сургууль
1993-1997 онд - МУИС-ийн Физик, электроникийн сургууль
Электроникийн инженер мэргэжилтэй, Бизнесийн удирдлагын магистр

Ажлын туршлага:
2022 оноос - М-Си-Эс Инвестмент ХХК-ийн Гүйцэтгэх дэд ерөнхийлөгч
2016-2022 - М-Си-Эс Группийн Дэд ерөнхийлөгч
2014-2016 онд - Анунгоо ХХК-ийн Гүйцэтгэх захирал
2012-2014 онд - М-Си-Эс Группийн Дэд ерөнхийлөгч
2008-2012 онд - Юнител ХХК-ийн Гүйцэтгэх захирал
2006-2007 онд - Юнител ХХК-ийн Дэд захирал
1997-2003 онд - М-Си-Эс Электроникс ХХК-д Бизнес менежер
1997 онд - М-Си-Эс Интернэйшнл ХХК-д Инженер

Гарын үсэг: /Б.Билигун/



Ж.Оджаргал
М-Си-Эс Холдинг ХХК-ийн
ТУЗ-ийн дарга

Боловсрол

- Нидерландын Вант Улсын Маастрихтийн менежментийн сургууль: Бизнесийн удирдлага - Магистр
- Монгол Улсын удирдлагын хөгжлийн институт: Бизнесийн удирдлагын арга зүйч - Бакалавр
- ЗХУ-ын Киев хотын Политехникийн дээд сургууль: Цахилгааны инженер - Бакалавр

Туршлага

- М-Си-Эс Холдинг ХХК: Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга
- М-Си-Эс Холдинг ХХК: Захирлуудын зөвлөлийн дарга
- Монголиан Майнинг Корпораци: Захирлуудын зөвлөлийн дарга
- М-Си-Эс Интернэйшнл ХХК: Ерөнхий захирал
- Эрчим хүчний удирдах газар: Автоматикийн инженер


Гарын үсэг: /Ж. Оджаргал/



2023.08.18

6.11 КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН ЗАСАГЛАЛЫН
СУРГАЛТАД ХАМРАГДСАНЫГ НОТЛОХ ГЭРЧИЛГЭЭ

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ


СЕРТИФИКАТ
ГЭРЧИЛГЭЭ

№ 0430928

Батмөнх Тэмүүлэн

Компанийн тухай хуулийн 75.8 дахь заалтын үндэслэн
"Компанийн төлөөлөн зурдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга" нэрт зориулсан
Компанийн засаглалын 36 цэврийн туралтанд халгарагдсан тул эерчилгээ олгог.

Д.ГАНБАЯР
Компанийн засаглалын
Үндэсний зөвлөлийн дарга

Ц.ХУЯГ
Монголын үнэт цаасны
архижаа эрхлэгчдийн холбоо
Гүйцэтгэх захирал


2022 оны 07-р сарын 07 өдөр

УЛААНБААТАР ХЧТ
АШИД КАПИТАЛ
ББС ХХК


Handwritten signature

МАНДАЛ КАПИТАЛ
МАРКЕТС ҮЦК ХХК
MANDAL CAPITAL
MARKETS SC
LLC
137
ШТК0162 9021070414 521344

Голлоомын Засаг Засаг
2023.08.18



simple



CORPORATE
GOVERNANCE
DEVELOPMENT
CENTRE



International
Finance Corporation
World Bank Group



In recognition of the contribution and participation of

Gantumur L.

in the IFC Corporate Directors Workshop

Ulaanbaatar, Mongolia

May 6-7, June 29 -30, 2010

Unenbat Jigjid
Director
Corporate Governance
Development Center

Sergii Tryputen
Project Manager
Mongolia CG Project
IFC



2023.08.18



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ



САНХҮҮГИЙН
 ЗОХИЦУУЛАХ ХОРОО
 ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ



ЦЕХЭТЛЭГЭВ
 ГЭРЭЦЛЭГЭВ



Эмгэг 0130761

..... оговтой нь

Компанийн шухай хуулийн 75.8 дахь заалтыг үндэслэн

“Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга” нарт зориулсан

Компанийн засаглалын 36 цагийн сурвалжанд хамрагдсан тул гэрчилгээ олгог.

Д.ГАНБАЯР
 Компанийн засаглалын үж 30413
 Үндэсний зөвлөлийн үж 1116 224847



Т.ЦЭНД-АЮУШ
 Компанийн Засаглалын Хөгжлийн
 Төвийн Гүйцэтгэх Захирал

2017. оны 1. сарын 1. өдөр

УЛААНБААТАР ХОТ
 МАНДА КАПИТАЛ
 ББСБ ХАК
 АТ 4696141165572
 902114567

МАНДАЛ КАПИТАЛ
 MARKETS SC
 LLC 139
 ШТК0162 9021070414 5213487

2023.08.18



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ХӨГЖЛИЙН ТӨВ

ГЭРЧИЛГЭЭ



Дугаар 0131654

..... *Дангуйба* овогтой *Молормаг* нь

Компанийн тухай хуулийн 75.8 дахь заалтыг үндэслэн

"Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга" нарт зориулсан

Компанийн засаглалын богино хугацаат сургалтанд хамрагдсан тул гэрчилгээ олгов.

[Signature]
Т.ЦЭНД-АЮУШ
Компанийн Засгийн Хөгжлийн
Төвийн Гүйцэтгэх Зөвлөл

2023. 1 сарын 08 -р сарын 14 өдөр



[Signature]

[Signature]

2023.08.18

2023-08-18
simple

CSX
2023-08-02 өдөр
VI. ХАВСРАЛТ
№ 31

КОМПАНИЙН ЗАСАГЛААЛЫН ХӨГЖЛИЙН ТӨВ

ГЭРЧИЛГЭЭ



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО
/MANGAL BAYALGЕХТЭМЖИЙН
УИ ВУУДАЛ

Дугаар 0131652

Тамбаг овогтой *Т.Цэнцэ* нь

Компанийн тухай хуулийн 75.8 дахь заалтыг үндэслэн
"Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга" нарт зориулсан
Компанийн засаглалын бодлого хугацаат сургалтанд хамрагдсан тул гэрчилгээ олгов.

(Signature)
Т.ЦЭНЦЭОЮШ
Компанийн Засаглалын Хөгжлийн
Төвийн Гүйцэтгэх Зөхирөл

2023.08.08-р сарын 14 өдөр

УЛААНБААТАР ХСТ
АНДИ КАПИТАЛ
БЭСӨС ХХК
(Signature)

МАНДАЛ КАПИТАЛ
МАРКЕТС ҮЦК ХХК
MANDAL CAPITAL
MARKETS SC
LLC 141
(Signature)
ШТК0162 9021070414 5213487

(Signature)

2023.08.18



6.12 КОМПАНИЙН ҮНДСЭН АНДЕРРАЙТЕРТАЙ ХИЙСЭН ГЭРЭЭ

АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

2023 оны 5-р сарын 19-ний одор

Дугаар: 25/44

Улаанбаатар хот

Энэхүү Андеррайтерийн үйлчилгээний гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г Монгол Улсын Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Биржээс гаргасан журам, заавар болон бусад энэ төрлийн харилцааг зохицуулсан холбогдох эрх зүйн актуудыг үндэслэн,

Нэг талаас "АШИД КАПИТАЛ ББСБ" ХХК (цаашид "Компани" гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал П.БАТЖАРГАЛ,

БОЛОН

Нөгөө талаас "ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК" ХХК (цаашид "Андеррайтер" гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал С.ГАН-ЭРДЭНЭ (цаашид гэрээ байгуулагч талуудыг хамтад нь "Талууд", тусад нь "Тал" гэх) нар нь дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Гэрээний зорилго нь Андеррайтер нь Компанид хөрөнгийн зах зээлд нээлттэй хүрээнд 55,000,000,000 /тавин таван тэрбум/ төгрөг хүртэлх үнийн дүн бүхий өрийн хэрэгслийг Хавсралт №4 дахь хуваарийн дагуу хэд хэдэн удаа хэсэгчлэн бүртгүүлэх хөтөлбөрийг СЗХ, МХБ-ээс зөвшөөрөл авч, олон нийтэд нээлттэй санал болгон хөрөнгө татахад Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх, шаардагдах тооцоолол, судалгаа, бэлтгэл ажлуудыг гүйцэтгэх, зөвлөгөө өгөх, хөрөнгө оруулагч нарт Компанийг танилцуулах, санал болгох, санхүүжилт татаж өгөх; Компани нь Андеррайтерийг Гэрээгээр хүлээсэн ажлаа гүйцэтгэхэд нь дэмжин ажиллаж шаардлагатай мэдээлэл, материалыг гарган өгч гэрээний чөлөөт байдлын зарчимд үндэслэн хамтран ажиллахаар харилцан тохиролцсонтой холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Талууд Гэрээний зорилгоо хэрэгжүүлэх явцад бие биенийхээ хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх, хамгаалах болон шударга байх зарчмыг баримтлан ажиллана.
- 1.3. Талуудын мэдээлэл:

Компани: "АШИД КАПИТАЛ ББСБ" ХХК

Регистрийн дугаар: 6105572

Хаяг: Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, Сентрал тауэр 15 давхарт

Утас/Факс: 1800 2828

Андеррайтер: "ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК" ХХК


Регистрийн дугаар: 5481589

Хаяг: Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 24, Парк плейс оффис, 403 тоот;

Утас/Факс: 7012-1530



2023.08.18




Хоёр. Нэр томъёоны тайлбар

- 2.1 Гэрээнд дараах нэр томъёог дөр дүрдсэн утгаар ойлгоно. Үүнд:
- 2.1.1. “**Үнэт цаас**” гэж Монгол улсын хуулийн дагуу байгуулагдсан аж ахуй нэгж байгууллага болон бусад эрх бүхий этгээдээс гаргасан өрийн бичиг (бонд), компанийн бүх төрлийн хувьцаа, компанийн гаргасан эсхүл гаргахаар санал болгож буй хувьцааг худалдах, худалдан авах, эрхийн опцион, хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, түүнчлэн Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нийцүүлэн үнэт цаас гэж тодорхойлсон бичиг баримтыг;
 - 2.1.2. “**Хөрөнгө оруулагч**” гэж үнэт цаас худалдан авагч иргэн, хуулийн этгээд буюу Компанийн үнэт цаасыг худалдан авснаар дагалдах мөнгөн урсгал болон бусад эрхийг хүлээн авах эрх бүхий этгээдийг;
 - 2.1.3. “**Анхдагч зах зээлийн арилжааг амжилттай хэрэгжүүлэх**” гэж үнэт цаас гаргагч анхдагч зах зээл дээрээс татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн хөрөнгийг амжилттай бүрдүүлэх;
 - 2.1.4. “**СЗХ**” гэж Санхүүгийн Зохицуулах Хороог;
 - 2.1.5. “**МХБ**” гэж Монголын Хөрөнгийн Биржийг;
 - 2.1.6. “**ҮЦГХТ**” гэж Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвийг;
 - 2.1.7. “**Эрх бүхий этгээд**” гэж СЗХ, МХБ, ҮЦГХТ зэрэг нээлттэй өрийн хэрэгсэл гарган арилжаалахтай холбоотой үйл ажиллагаанд зохицуулагчийн үүрэгтэй оролцож байгаа болон бусад төрийн эрх бүхий байгууллагуудыг тус тус ойлгоно.
 - 2.1.8. “**Үнэт цаасны танилцуулга (Проспектус)**” гэж үнэт цаасны захиалга авах, худалдах зорилгоор үнэт цаас гаргагч болон Андеррайтерийн зүгээс холбогдох хууль, тогтоомжид заасан журмын дагуу СЗХ, МХБ-д үнэт цаасыг бүртгүүлэх зорилгоор бэлтгэсэн танилцуулга, баримт бичгийн бүрдлийг.

Гурав. Андеррайтерийн үйлчилгээний цар хүрээ

- 3.1. Андеррайтерийн зүгээс үзүүлэх үйлчилгээнүүд нь гэрээний хүчинтэй хугацаанд дараах зөвлөмж, үйлчилгээгээр тодорхойлогдоно. Үүнд:
- 3.1.1. Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны чадавх дээр магадлан шинжилгээ (due diligence) хийх;
 - 3.1.2. Үнэт цаасыг олон нийтэд санал болгох үйлчилгээг үзүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг бэлтгэн, тухайн хамтарсан төлөвлөгөөний дагуу оролцогч талуудын үйл ажиллагаанд хяналт тавих;
 - 3.1.3. Үнэт цаасны танилцуулга материалыг (Проспектус) боловсруулах, эрх бүхий байгууллагуудаас зөвшөөрөл авахад хүчин чармайлт гарган ажиллах, компанийн өрийн хэрэгслийг худалдан авах боломжит хөрөнгө оруулагчдыг тодорхойлж үнэт цаас худалдан авах захиалга авах, холбогдох хууль журамд заасан андеррайтерийн цогц үйлчилгээг үзүүлэх;
 - 3.1.4. Гадаад, дотоодын боломжит хөрөнгө оруулагчдыг тодорхойлох, тэдгээрээс хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэх, Компанийг төлөөлөн танилцуулга хийх, санал тавих, уулзалт зохион байгуулах, зуучлах, хөрөнгө оруулагчидтай хэлцэл хийхэд болон гэрээ байгуулахад зуучлах, хамтран ажиллах;





- 3.1.5. Компаниас хөрөнгийн зах зээлд нээлттэй хүрээнд гаргах бондыг танилцуулах, сурталчлах, хөрөнгө оруулагчдад борлуулах;
- 3.2. Компани нь энэ Гэрээний дагуу дээр дурдсан үйлчилгээний хүрээнд дараах нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн болно. Үүнд:
- 3.2.1. Гэрээний хүчинтэй хугацаанд Компани нь Андеррайтерт Компанийг төлөөлөн энэхүү Гэрээний зорилгын дагуу хөрөнгө оруулагчид болон холбогдох зохицуулалтын байгууллагуудтай уулзалт, танилцуулга хийх эрхийг олгов. ;
- 3.3. Талууд энэхүү Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ур чадвартай төслийн багийн гишүүдийг томилж энэхүү гэрээний Хавсралт №2-оор батлан хамтран ажиллана. Гэрээний явцад төслийн багийн гишүүдэд өөрчлөлт орсон тухай бүр багийн ахлагчид харилцан баталгаат и-мэйлээр мэдэгдэж төслийн багт өөрчлөлтийг оруулж ажиллана. Хэрвээ Талуудын томилсон төслийн багийн гишүүд үүрэгт ажлаа зохион байгуулахад мэргэжлийн ур чадвар дутагдсан нь баримтаар нотлогдсон тохиолдолд, нөгөө Талын саналаар тухайн Тал нь өөрийн багт өөрчлөлт оруулах үүрэгтэй.

Дөрөв. Гэрээний хугацаа

- 4.1 Гэрээнд талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 4.2 Гэрээг аль нэг талын санаачилгаар цуцалсан эсхүл талууд харилцан тохиролцож дуусгавар болгосноос бусад тохиолдолд талуудын гэрээний дагуу хүлээсэн үүрэг, хамтын ажиллагааны зорилго бүрэн биелснээр Гэрээ дуусгавар болно.
- 4.3 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээний хугацааг дахин сунгах боломжтой.

Тав. Үйлчилгээний төлбөр

- 5.1 Компаниас Андеррайтерт төлөх нийт үйлчилгээний төлбөр нь гэрээний хавсралт 3-д заасан үйлчилгээний тогтмол болон хувьсах төлбөрөөс бүрдэнэ.
- 5.2 Гэрээний хавсралт 3-д заасан үйлчилгээний тогтмол төлбөрийн урьдчилгаа 50 хувь болох / төгрөгийг гэрээ байгуулагдсанаас хойш ажлын 5 хоногийн дотор, үлдэх 50 хувь болох / төгрөгийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэх материалыг эрх бүхий байгууллагад хүргүүлснээс хойш ажлын 5 хоногийн дотор Андеррайтерийн нэхэмжлэхийг үндэслэн доорх дансанд төлнө.

Банкны нэр:	Голомт банк
Дансны дугаар:	2005002269 /MNT/
Данс эзэмшигч:	Голомт Капитал ҮЦК

- 5.3 Компани анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явж татан төвлөрүүлэх хөрөнгө Компанийн дансанд бүрэн орж, гэрээт ажлыг дүгнэх акт үйлдэж, Талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш ажлын 5 /тав/ өдрийн дотор Гэрээний хавсралт 3-д заасан үйлчилгээний хувьсах төлбөрийг 5.2-т заасан дансанд төлнө.



- 5.4 Компани нь Энэхүү гэрээний зорилтот үр дүнг бий болгохтой холбоотой дараах төлбөр, зардлуудыг бүрэн хариуцна.
- 5.4.1 Компани нь үнэт цаасыг нийгэд гаргах үйл ажиллагаатай холбогдуулан СЗХ, МХБ, ҮЦТХТ зэрэг эрх бүхий байгууллагуудын шимтгэл, татвар, хураамжийг холбогдох хууль, журамд заасны дагуу тухай бүр бүрэн хариуцан төлнө.
- 5.4.2 Компани нь Гэрээний зорилтод үр дүнг бий болгохтой холбоотой Маркетинг, PR-ийн сурталчилгаа явуулах, үйл ажиллагаа зохион байгуулах, Үнэт цаас танилцуулах аян зохион байгуулах зэрэгтэй холбоотой зардлыг бүрэн хариуцна. Үүнд, Андеррайтерийн Маркетинг, PR-тай холбоотой Үнэт цаас гаргагчид өгсөн санал, зөвлөмж, өөрийн боломжит олон нийтийн сувгуудаар танилцуулах, боломжит хөрөнгө оруулагчтай Компанийг төлөөлөн холбогдох зэрэг үйл ажиллагаа хамраахгүй болно.
- 5.5 Андеррайтер нь гэрээт ажлын зарим хэсгийг Компанийн зөвшөөрлөөр туслан гүйцэтгэгч буюу хамтрагч андеррайтераар гүйцэтгүүлэх тохиолдолд Компани нэмэлт төлбөр төлөхгүй.

Зургаа. Компанийн эрх, үүрэг

- 6.1 Компани нь дараах үүрэгтэй байна. Үүнд:
- 6.1.1 Андеррайтерт Гэрээнд заасан үйлчилгээг үзүүлэхэд нь шаардлагатай үнэн зөв, бодит мэдээлэл, бичиг баримт болон материалуудын эх хувь болон баталгаажсан хуулбарыг цаг тухайд нь бүрэн гаргаж өгөх;
- 6.1.2 Компанийн хөрөнгө оруулагчдад үйл ажиллагааны талаар үнэн зөв, бодит мэдээллээр ханган ажиллах;
- 6.1.3 Гэрээний 4 болон 5 дугаар зүйлд тусгагдсан Компанийн хариуцах бүхий л үүргээ биелүүлэх;
- 6.1.4 Компани талаас шаардлагатай тохиолдолд стратегийн хөрөнгө оруулагчийг Андеррайтерт холбож өгөх бөгөөд Андеррайтер нь тухай бүр Компанийн өрийн хэрэгслийн танилцуулга хийх;
- 6.1.5 СЗХ, МХБ болон бусад эрх бүхий байгууллагаас гаргасан холбогдох дүрэм, журмын дагуу хүлээх бусад үүрэг;
- 6.2 Компани нь дараах эрхтэй байна. Үүнд:
- 6.2.1 Андеррайтерийн буруутай үйл ажиллагааны улмаас Компанид учирсан бодит хохирлыг Андеррайтераас нэхэмжлэн төлүүлэх замаар барагдуулах;
- 6.2.2 Андеррайтерийн буруутай үйл ажиллагаа, зөвлөгөөний улмаас Компанид учирсан бодит хохирлыг Андеррайтераас нэхэмжлэн төлүүлэх замаар барагдуулах;
- 6.2.3 Туслах андеррайтер санал болгох;
- 6.2.4 СЗХ, МХБ болон бусад эрх бүхий байгууллагаас гаргасан холбогдох дүрэм, журмын дагуу хүлээх бусад эрх.

Долоо. Андеррайтерийн эрх үүрэг






- 7.1 Андеррайтер нь дараах үүрэгтэй байна. Үүнд:
- 7.1.1 Андеррайтераас үл хамаарах шалтгаанаар Андеррайтерийн үйлчилгээний чанар, үр дүнд муугаар нөлөөлөх ямар нэг нөхцөл байдал бий болсон тохиолдолд Компанид нэн даруй мэдэгдэх;
 - 7.1.2 Гэрээний дагуу Компаниас ирүүлсэн бичиг баримт, материалын бүрэн бүтэн байдлыг хангах талаар өөрөөс шалтгаалах бүхий л арга хэмжээг авах;
 - 7.1.3 Эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авахад хүчин чармайлт гарган ажиллах;
 - 7.1.4 Компанийн бизнесийн нууцад хамаарах мэдээ, мэдээлэл, нийтэд тарваалдаагүй байгаа мэдээллийн нууцыг чанд хадгалах;
 - 7.1.5 Гэрээт ажлыг хийж гүйцэтгэх, хөрөнгө оруулагчидтай уулзалт, танилцуулга хийх, санал тавих бүрд Компанид урьдчилан мэдэгдэж, компанийн эрх, ашиг сонирхлын эсрэг үйлдэл хийхгүй байх;
 - 7.1.6 Энэхүү гэрээт ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл эрхийн гэрчилгээтэй байх бөгөөд тэдгээр нь гэрээний хугацаанд хүчин төгөлдөр байх;
 - 7.1.7 Компанийн өрийн хэрэгслийг амжилттай арилжаалахад холбогдох бүхий л ажилд хүчин чармайлт гарган ажиллаж, тухай бүр ажлын тайланг нарийвчилсан төлөвлөгөөний дагуу Компанид хүргүүлэх;
 - 7.1.8 Хууль тогтоомж, дүрэм, журам зөрчсөнөөс үүдэн гарах хариуцлагыг бүрэн хүлээх, Компанийг үүнээс ангид байлгах;
 - 7.1.9 Андеррайтерийн үйлчилгээг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гэрээнд заасан хугацаанд мэргэжлийн өндөр түвшинд үр дүнтэй арга зүйг ашиглан хийж гүйцэтгэх;
 - 7.1.10 Андеррайтер нь Компанийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавих ба өөр төсөл, арга хэмжээ, өөрийн байгууллагын болон Хамтрагч андеррайтерийн эрх ашигтай сонирхлын зөрчилд орохоос зайлсхийх;
 - 7.1.11 Андеррайтерийн үйлчилгээг аливаа байдлаар доголдолтой гүйцэтгэсэн тохиолдолд доголдлыг өөрийн зардлаар арилгах;
 - 7.1.12 СЗХ, МХБ болон бусад эрх бүхий байгууллагаас гаргасан холбогдох дүрэм, журмын дагуу хүлээх бусад үүрэг;
- 7.2 Андеррайтер нь дараах эрхтэй байна. Үүнд:
- 7.2.1 Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай бүхий л мэдээ мэдээлэл, тоо баримт, санхүүгийн тайлангууд болон бусад холбогдох бичиг баримтуудыг Компаниас гаргуулан авах;
 - 7.2.2 Туслах андеррайтер сонгох, түүнтэй гэрээ байгуулан хамтран ажиллах;
 - 7.2.3 Компанид хөрөнгө босгох зорилгоор боломжит хөрөнгө оруулагч нарт Компанийг танилцуулах;
 - 7.2.4 Компанийг Гэрээнд заасан бүхий л үүргээ биелүүлэхийг шаардах;
 - 7.2.5 Андеррайтерийн үйлчилгээний хүрээнд Компанийн ажлын байр болон гэрээний үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор холбогдох газарт саадгүй нэвтрэх хүсэлт гаргах;
 - 7.2.6 Компанийн буруутай үйл ажиллагааны улмаас Андеррайтерт учирсан хохирлыг Компаниас нэхэмжлэн төлүүлэх замаар барагдуулах;
 - 7.2.7 СЗХ, МХБ болон бусад эрх бүхий байгууллагаас гаргасан холбогдох дүрэм, журмын дагуу хүлээх бусад эрх.



2023.08.18



Найм. Нууц хадгалах

- 8.1 Талууд эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд байгууллагын нууцад хамаарах мэдээллийг энэхүү Гэрээний бус зорилгоор шууд болон шууд бус замаар ашиглахгүй, задруулахгүй эсхүл гуравдагч этгээд болон олон нийтэд мэдээлэхгүй байх үүргийг Гэрээний хугацаанд хүлээнэ.
- 8.2 Гэрээний дор хүлээж буй Андеррайтерийн нууц хадгалах үүрэгт дараах нөхцөл байдал хамаарахгүй буюу Андеррайтер хариуцлага хүлээхгүй болно. Үүнд:
 - 8.2.1 Андеррайтерт мэдээлэл өгөх үед болон дараа нь тухайн мэдээлэл Андеррайтераас хамааралгүйгээр олон нийтэд зарлагдсан;
 - 8.2.2 Компанийн бусад эх үүсвэрээр дамжин нууцын бус зэрэглэлтэй материал Андеррайтерт хүрсэн;
 - 8.2.3 Гэрээгээр хүлээсэн ямар нэгэн үүргээ зөрчилгүйгээр Андеррайтер нь өөрөө тухайн мэдээллийг олж авсан эсхүл боловсруулсан;
 - 8.2.4 Хуулийн дагуу эрх бүхий байгууллагын шийдвэрээр тухайн нууцлалын зэрэглэлийн мэдээлэл олон нийтэд ил болсон.
- 8.3 Андеррайтерийн үйлчилгээний хүрээнд хийгдэх танилцуулга материал болон бусад нийтэд нээлттэй болох шаардлагатай мэдээллүүдийг нийтэд танилцуулснаар энэхүү Гэрээнд заасан нууц мэдээллийг задруулсан гэж үзэхгүй.
- 8.4 Нууцад тооцогдох мэдээллийг эрх бүхий байгууллагаас шаардсан тохиолдолд, талууд энэ талаар урьдчилж харилцан бие биедээ мэдэгдэнэ.

Ес. Хариуцлага



- 9.1 Монгол улсын Иргэний хуульд заасан гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас аль нэг тал Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон бол хариуцлагаас чөлөөлөгдөнө. Энэ тохиолдолд тэрхүү нөхцөл байдлаа нэн даруй нөгөө талдаа мэдэгдэж, нотлох үүрэгтэй. Нотолж чадаагүй тохиолдолд Гэрээгээр хүлээсэн үүргээсээ чөлөөлөгдөхгүй.
- 9.2 Компанийн буруутай, хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн гарсан аливаа хохирол, өр төлбөрийг Андеррайтер хариуцахгүй болно.
- 9.3 Компанийн ирүүлсэн бөгөөд мэргэжлийн байгууллага (хуульч, санхүүгийн шинжээч, үнэлгээний байгууллага, эсхүл аудитын дүгнэлт гэх мэт)-аас баталгаажсан мэдээлэл нь худал буюу бодит байдалд нийцээгүй, төөрөгдүүлсэн байсны улмаас ирээдүйд учрах хохирлыг Андеррайтер хариуцахгүй болно. Хөндлөнгийн магадлан шинжилгээ хийх байгууллагуудын гаргасан дүгнэлтээс үүдэн СЗХ, МХБ зэрэг эрх бүхий этгээдүүдийн бүртгэлийн шаардлагыг хангаагүйгээс үүдэн гарах хариуцлагыг буруутай тал хариуцна. Хугацаа хойшлох тухай бүр төлөвлөгөөт ажлын хугацааг хамтран сунгаж ажиллана.
- 9.4 Андеррайтер болон түүний туслах андеррайтер нь дотоод мэдээлэл эзэмшигч бөгөөд энэхүү гэрээ байгуулагдсантай холбогдуулан олж мэдсэн Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан дотоод мэдээллийг ашиглах аливаа үйлдэл, эс үйлдэхгүй гаргахгүй байх үүрэгтэй.



Handwritten signature

Handwritten signature

2023.08.18



9.5 Хэрэв Андеррайтер нь гэрээний 9.4-д заасан үүргээ зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээх ба Компанид учирсан хохирлыг бүрэн төлж барагдуулна.

Арав. Гэрээ дуусгавар болох

- 10.1 Гэрээ нь дор дурдсан үндэслэлээр дуусгавар болно. Үүнд:
 - 10.1.1 Талууд Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлснээр;
 - 10.1.2 Талууд харилцан тохиролцсоноор Гэрээг дуусгавар болсон өдрөөр;
 - 10.1.3 Аль нэг тал Гэрээний үүргээ зөрчсөн бөгөөд тухайн зөрчлийг арилгах тухай нөгөө талдаа албан ёсоор мэдэгдсэн тохиолдолд тус зөрчлийг боломжит хугацаанд арилгаагүй, арилгах боломжгүй бол нэг талын санаачилгаар Гэрээг цуцалснаар;
 - 10.1.4 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шинээр Андеррайтерийн үйлчилгээний гэрээ байгуулснаар;
 - 10.1.5 Хуульд заасан бусад үндэслэлээр.
- 10.2 Гэрээний үүргээ зөрчсөний улмаас гэрээ цуцалснаас үүсэх үр дагаврыг тухайн буруутай тал бүрэн хариуцна.
- 10.3 Дараах үндэслэлээр Компани гэрээг цуцлах шаардлага гаргах эрхтэй. Үүнд:
 - 10.3.1 Андеррайтер нь гэрээт ажлыг дутуу эсхүл доголдолтой ажил гүйцэтгэсэн эсхүл харилцан тохирсон нэмэлт хугацаанд ажлын гүйцэтгэлийн доголдлыг арилгаагүй;
 - 10.3.2 Компани өрийн хэрэгслийг арилжаалахтай холбоотой шийдвэрийг хүчингүй болгох тухай шийдвэр гаргасан.
 - 10.3.3 Андеррайтер нь Компанийн буюу үнэт цаас гаргагчийн Дотоод мэдээлэл болон Нууц мэдээллийг түүний зөвшөөрөлгүйгээр задруулсан, ашигласан нь үндэслэл бүхий баримтаар тогтоогдсон.
- 10.4 Талуудын гэрээт ажил зорилгот үр дүнд хүрээгүй, Гэрээнд заасан хугацаанаас өмнө Андеррайтерийн буруутай үйлдлээс шалтгаалан Компанийн санаачилгаар гэрээ цуцлагдсан тохиолдолд Компани нь гэрээний хугацаанд учирсан бодит хохирлыг Андеррайтераас шаардах эрхтэй.
- 10.5 Дараах үндэслэлээр Андеррайтер гэрээг цуцлах шаардлага гаргах эрхтэй. Үүнд:
 - 10.5.1 Компани энэ Гэрээний 6 дугаар зүйлийн 6.1.1-т заасан баримт бичгүүдийг 30 хоногийн дотор эсхүл Андеррайтерийн заасан хугацаанд хүргүүлээгүй, тус баримт бичгүүдийг хуурамчаар бүрдүүлсэн эсхүл нуун дарагдуулсан нь илэрсэн;
 - 10.5.2 Хөндлөнгийн дүгнэлт гаргах байгууллагын гаргасан дүгнэлт нь эрх бүхий байгууллагын шаардлагыг хангаагүйгээс үүдэн үнэт цаас гаргах үйл ажиллагаа амжилтгүй болох нөхцөл үүссэн;
 - 10.5.3 Эрх бүхий байгууллагын зүгээс үнэт цаас гаргах үйл ажиллагааг түдгэлзүүлсэн.

Арван нэг. Давагдашгүй хүчин зүйл

11.1 Талуудын аль нэг нь гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ. Андеррайтер нь дээрх нөхцөл





Handwritten signature



148



2023.08.18



байдал болон түүний үр дагавар арилмагц гүйцэтгээгүй үүргээ нэн даруй бодитойгоор биелүүлнэ. Үүнтэй холбоотойгоор гэрээний хугацаанд өөрчлөлт орхоор бол хоёр тал харилцан тохиролцоно.

- 11.2 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэдэгт дараах нөхцөл байдлыг хамруулж ойлгоно. Үүнд: газар хөдлөлт, үерийн аюул, дайн байлдаан, байгалийн гамшиг, үймээн самуун, эрх бүхий байгууллагаас гаргасан хорио, цээр зэрэг болно.
- 11.3 Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас энэхүү гэрээ саатсан буюу хэрэгжээгүй тохиолдолд гэрээний аль нэг тал нөгөө талаасаа алданги, торгууль зэрэг аливаа хохирлыг нөхөн төлөхийг шаардахгүй болно.

Арван хоёр. Бусад зүйл


- 12.1 Энэхүү Гэрээний Хавсралт №1, 2, 3 нь Гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд хамтдаа нэг баримт бичиг байна.
- 12.2 Энэхүү Гэрээ нь сайн дурын үндсэн дээр, талуудын эрх, ашиг сонирхлын төлөө байгуулагдсан бөгөөд талуудын хувьд зайлшгүй дагаж мөрдөх баримт бичиг мөн.
- 12.3 Талууд Гэрээтэй холбоотойгоор үүссэн санал зөрөлдөөн, үл ойлголцол, маргааныг харилцан тохиролцож, эв зүйгээр шийдвэрлэх ба тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд маргааныг Монгол улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 12.4 Гэрээнд тусгагдаагүй бусад асуудлыг дээр дурдсан холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.
- 12.5 Гэрээг Монгол хэл дээр, ижил хүчинтэй 2 хувь үйлдэх ба Компанид 1 хувь, Андеррайтерт 1 хувь хадгалагдана.
- 12.6 Гагцхүү бичгээр үйлдэн талууд гарын үсэг зурж баталгаажуулсан тохиолдолд Гэрээний нөхцөл, болзол болон үйлчилгээний цар хүрээг засварлах, өөрчлөх болон үүнтэй холбоотойгоор гэрээнд өөрчлөлт оруулж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:


КОМПАНИЙГ ТӨЛӨӨЛЖ:
"АШИД КАПИТАЛ ББСБ"
ХХК-ИЙН



АНДЕРРАЙТЕРИЙГ ТӨЛӨӨЛЖ:
"ГОЛОМТ КАПИТАЛ УЦК"
ХХК-ИЙН




2023.08.18




2023 оны 5 сарын 19-ны өдрийн 21 тоот
Андеррайтерийн үйлчилгээний
сүрээний Хавсралт №1

НЭЭЛТТЭЙ ӨРИЙН ХЭРЭГСЛИЙГ ГАРГАХТАЙ ХОЛБООТОЙ ХИЙГДЭХ АЖЛУУД

№	Гүйцэтгэх ажил	Хугацаа
1	Бэлтгэх үе шат	
1.1	Андеррайтерийн үйлчилгээний гэрээг байгуулах	5/10/2023
1.2	Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогчидтой хийсэн гэрээний хувийг компаниас гаргуулах	5/10/2023
1.3	Зээлжих зэрэглэлийн үнэлгээг эхлүүлэх	5/10/2023
1.4	Хуулийн дүгнэлт гаргах үйл ажиллагааг эхлүүлэх	5/10/2023
1.5	Хуулийн дүгнэлтийг хүлээн авах	5/31/2023
1.6	Зээлжих зэрэглэлийн үнэлгээний тайланг хүлээн авах	6/9/2023
2	Үнэт цаасны танилцуулга боловсруулах	
2.1	Үнэт цаасны танилцуулгад тусгах шаардлагатай мэдээллийг компаниас гаргуулах, хавсаргах	5/12/2023
2.2	Аудитын дүгнэлтийг хавсаргах	5/10/2023
2.3	Үнэт цаас гаргах тухай ТУЗ-ийн шийдвэрийг гаргуулах	5/10/2023
2.4	Үнэт цаасны проспектус, эхний танилцуулгыг боловсруулах <ul style="list-style-type: none">• Үнэт цаас гаргагчийн мэдээллийг бэлтгэх• Зах зээлийн судалгааг гүйцэтгэх• Санхүү болон мөнгөн урсгалын шинжилгээг гүйцэтгэх• Бондын нөхцөлийг тодорхойлох• Эрсдэл, эрсдэлийн удирдлага• Оролцогч байгууллагуудын тухай мэдээлэл	6/5/2023
2.5	Үнэт цаасны эхний танилцуулгыг хянах	6/8/2023
2.6	Үнэт цаасны проспектус бэлэн болох	6/9/2023
2.7	Андеррайтерийн дүгнэлтийг боловсруулах	6/9/2023
3	Зохихуулах байгууллагуудаас холбогдох зөвшөөрөл авах	
3.1	Өрийн хэрэгслийг СЗХ болон МХБ-д бүртгүүлэх өргөдөл гаргах, хураамж төлөх, үнэт цаасны танилцуулга, бусад материалуудыг хүргүүлэх	6/10/2023
3.2	СЗХ болон МХБ-с үнэт цаасыг бүртгэх зөвшөөрөл авах	7/7/2023
4	Арилжааны үе шат (Эхний транчийн тухайд)	
4.1	Хөрөнгө оруулагчдад зориулсан үнэт цаасны хураангуй танилцуулга брошур бэлтгэж хэвлэх	3 хоног
4.2	Хөрөнгө оруулагчдад зориулсан PPT бэлдэх	1 хоног
4.3	Мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санал болгох уулзалт зохион байгуулах	5 хоног
4.4	МХБ-ын гадна сурталчилгаа байршуулах	5 хоног
4.5	Хөрөнгө оруулагчдад үнэт цаасыг борлуулах	5 хоног
4.6	Анхдагч зах зээлийн арилжааг хийж гүйцэтгэх	5 хоног
4.7	Анхдагч зах зээлийн арилжааны хуваарилалтыг хийж гүйцэтгэх	2 хоног
4.8	Анхдагч зах зээлийн арилжааны тайланг СЗХ-нд хүргүүлэх	1 хоног
4.9	СЗХ болон МХБ-с үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрөл гаргуулах	3 хоног



2023.08.18



2023 оны 5 сарын 19-ны өдрийн 24-тоот
Андеррайтерийн үйлчилгээний
гэрээний Хавсралт №2

НЭЭЛТТЭЙ ЗАХ ЗЭЭЛД ӨРИЙН ХЭРЭГСЛИЙГ ГАРГАХ ТӨСЛИЙН БАГ

№	Овог / Нэр	Албан тушаал	Утас	И-мэйл
Компани				
1	П.Батжаргал	Гүйцэтгэх захирал	88886719	Batjargal.p@simple.mn
2	Г.Мөнхбаясгалан	Санхүүгийн удирдлагын албаны дарга	99055619	Munkhbayasealan.g@simple.mn
3	Н.Эрдэнэтунгалаг	Санхүүгийн бүртгэлийн албаны дарга	88020292	Erdenetungalag.n@simple.mn
4				
Андеррайтер				
1	С.Ган-Эрдэнэ	Гүйцэтгэх захирал	99101055	ganerdene@golomtcapital.com
2	Н.Нарангэрэл	Хөрөнгө оруулалтын газрын захирал	89043735	narangerel@golomtcapital.com
3	Б.Нямдулам	Хөрөнгө оруулалтын шинжээч	99223375	nyamdulam@golomtcapital.com
4	С.Дашням	Хөрөнгө оруулалтын шинжээч	90229295	dashnyam@golomtcapital.com

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

КОМПАНИЙГ ТӨЛӨӨЛЖ:
"АШИД КАПИТАЛ ББСБ"
ХХК-ийн





АНДЕРРАЙТЕРИЙГ ТӨЛӨӨЛЖ:
"ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК"
ХХК-ийн

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:



2023.08.18




2023 оны 5 сарын 19-ны өдрийн 23/44 тоот
Андеррайтерийн үйлчилгээний
гэрээний Хавсралт №4

АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУВААРЬ

1. Андеррайтер нь Компанид хөрөнгийн зах зээлд нээлттэй хүрээнд нийт 55,000,000,000 /тавин таван тэрбум/ төгрөг хүртэлх үнийн дүн бүхий өрийн хэрэгслийг хэд хэдэн удаа хэсэгчлэн хэрэгжүүлэх үйлчилгээ үзүүлнэ.
2. СЭХ-ны "ББСБ-ын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ын өрийн хэрэгслийн харьцааг хангахтай холбоотойгоор өрийн бичгийг хэсэгчлэн гаргах, арилжаалах хуваарь:
 1. Симпли бонд 1: 2023 оны 7 сард 20 тэрбум төгрөг
 2. Симпли бонд 2: 2023 оны 9 сард 13 тэрбум төгрөг
 3. Симпли бонд 3: 2023 оны 11 сард 22 тэрбум төгрөг





6.13 ҮНДСЭН БОЛОН ТУСЛАХ АНДЕРРАЙТЕРИЙН ХАМТАРСАН ГЭРЭЭ

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2023 оны 5 дугаар сарын 24-ний өдөр

№ *ХА-23/02*

Улаанбаатар хот

Энэхүү Хамтран ажиллах гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г Монгол Улсын Иргэний хуулийн 476-480 дугаар зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.5 дахь хэсгийг тус тус үндэслэн,

Нэг талаас Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан 5481589 тоот регистрийн дугаартай Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, 24, Парк Плэйс оффисын барилга, 4 дүгээр давхар, 403, 404 тоот хаягт орших “Голомт Капитал ҮЦК” ХХК (цаашид “Үндсэн андеррайтер” гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал С.Ган-эрдэнэ болон

Нөгөө талаас Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан 5213487 тоот регистрийн дугаартай, Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, Жамьян гүний гудамж, Мэру тауер барилга, 602 тоот хаягт орших “Мандал капитал маркетс ҮЦК” ХХК (цаашид “Туслах андеррайтер” гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхтуяа (цаашид Үндсэн болон Туслах андеррайтерыг хамтад нь “Талууд” гэх) нар нь дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү Гэрээгээр Үндсэн андеррайтер нь “АШИД КАПИТАЛ ББСБ” ХХК (цаашид “Компани” эсхүл “Үнэт цаас гаргагч” гэх)-ийн нийт 55.0 (тавны таван) тэрбум хүртэл төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл (цаашид “Үнэт цаас” эсвэл “Бонд” гэх)-ийг хэд хэдэн удаа хэсэгчлэн буюу транчаар гаргах хөтөлбөрийг СЗХ, МХБ-ээс зөвшөөрөл авч, олон нийтэд нээлттэй санал болгон хөрөнгө татахад Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх, шаардагдах тооцоолол, судалгаа, бэлтгэл ажлуудыг гүйцэтгэх, зөвлөгөө өгөх, хөрөнгө оруулагч нарт Компанийг танилцуулах, санал болгох, санхүүжилт татаж өгөх ажил (цаашид “Андеррайтерийн үйлчилгээ” гэх)-ыг Туслах андеррайтертай хамтран зохион байгуулахтай холбогдуулан Талуудын эрх, үүрэг, хариуцлага, төлбөрийн нөхцөлийг тодорхойлохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Үнэт цаас гаргагч нь Үндсэн андеррайтераар нар 2023 оны 5 дугаар сарын 19-ний өдөр 23/24 дугаартай “Андеррайтерын үйлчилгээний гэрээ” байгуулагдсан болно.

1.3. Үндсэн андеррайтер Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд болох “Мандал Капитал Маркетс ҮЦК” ХХК-ийг туслах андеррайтераар сонгосон бөгөөд Үнэт цаас гаргагч нь үүнийг хүлээн зөвшөөрсөн болно.

ХОЁР. ТУСЛАХ АНДЕРРАЙТЕРЫН ҮЙЛЧИЛГЭЭ

2.1. Туслах Андеррайтер нь Үнэт цаас гаргагчид шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүжилтийн 14 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхэд шаардлагатай бүхий л хүчин чармайлтыг гарган ажиллана.


2.2. Талууд Үнэт цаас гаргагчид Үйлчилгээг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4.3 дахь заалтын дагуу хөрөнгө оруулагчид тухайн Үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүхий л хүчин чармайлтыг гаргана.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

3.1. Гэрээ нь Талуудын бүрэн эрхт төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдэг даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд талуудын гэрээний дагуу хүлээсэн үүрэг, хамтын ажиллагааны зорилго бүрэн биелснээр Гэрээ дуусгавар болно.



2023.08.18



3.2. Үнэт цаас гаргагчийн гаргасан бондын үндсэн болон хүүгийн төлбөр бүрэн төлөгдөж дуусах хугацаа нь талуудын хооронд байгуулагдах Бондын хөтөлбөрийн гэрээгээр зохицуулагдана.

3.3. Зах зээлийн ноцол байдлаас шалтгаалан Андеррайтерын үйлчилгээг Талууд Гэрээний хугацаанд гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд Үнэт цаас гаргагч болон Үндсэн андеррайтерын хооронд байгуулсан гэрээ сунгах нөхцөлөөр Талууд Гэрээг сунган ажиллана.

3.4. Гэрээг аль нэг талын санаачилгаар цуцалсан эсхүл Талууд харилцан тохиролцож дуусгавар болгосноос бусад тохиолдолд Гэрээний 3.1 дэх хэсэгт тодорхойлсон хугацаанд дуусгавар болно.

ДӨРӨВ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР

4.1. Туслах андеррайтерын үйлчилгээний төлбөр нь Үнэт цаас гаргагчид амжилттай татан төвлөрүүлж өгсөн хөрөнгийн нийт үнийн дүнгийн тэнцүү байна.

4.2. Үндсэн андеррайтер нь Андеррайтерын үйлчилгээний төлбөрийг Үнэт цаас гаргагчаас хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор Гэрээний 4.1-т заасан төлбөрийн хувь хэмжээг үндэслэн Туслах андеррайтерийн нэхэмжлэхийг дагуу түүнд төлнө.

4.3. Үндсэн андеррайтер нь андеррайтерын үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд Туслах андеррайтерт бүрэн төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд Туслах андеррайтерт гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс хоног тутамд хувийн алданги төлнө.

ТАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Үндсэн андеррайтер нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

5.1.1. Гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан олж авсан Үнэт цаас гаргагчийн аливаа мэдээллийн нууцлалыг хадгалах, энэхүү үүргээ зөрчсөнөөс Үнэт цаас гаргагч болон аливаа гуравдагч этгээдэд учирсан бодит хохирлыг бүрэн хариуцах;

5.1.2. Үнэт цаас гаргагчаас бичгээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд Үнэт цаас гаргагчийн нууц мэдээллийг аливаа гуравдагч этгээдэд ямар нэгэн хэлбэрээр задруулахгүй байх;

5.1.3. Гэрээнд заасан үйлчилгээг бүрэн үзүүлж дууссаны дараа үйлчилгээтэй холбогдох тайлан, баримт бичгийг Үнэт цаас гаргагчид хургүүлэх;

5.1.4. Талуудын харилцан тохиролцсон ажил гүйцэтгэх төлөвлөгөөнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлэх болон төлөвлөгөөнд заасан ажлыг төлөвлөгөөнд заасан хугацаанд гүйцэтгэх;

5.1.5. Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ аль нэг талынхаа албан ёсны зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд хэсэгчилсэн буюу бүрэн хэмжээгээр шилжүүлэхгүй байх;

5.1.6. Андеррайтерын үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд бүрэн төлөх;

5.1.7. Хууль болон Гэрээгээр хүлээсэн бусад үүрэг.

5.2. Үндсэн андеррайтер нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

5.2.1. Үнэт цаас гаргах үндсэн үйл ажиллагааг бүхэлд нь удирдан явуулах;

5.2.2. Туслах андеррайтер нь Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс Үнэт цаас гаргагч, Үндсэн андеррайтер болон аливаа гуравдагч этгээдэд хохирол учруулсан тохиолдолд тухайн хохирлыг барагдуулахыг Туслах андеррайтераас шаардах;



5.2.3. Туслах андеррайтер нь Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд Үндсэн андеррайтер нь бие даан гэрээг цуцалж болно.

5.2.4. Туслах андеррайтераас хууль болон Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэхийг шаардах.

5.3. Туслах андеррайтер нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

5.3.1. Үндсэн андеррайтераас ирүүлсэн ажил гүйцэтгэх ерөнхий төлөвлөгөө болон төслийн ерөнхий зохион байгуулалтын хүрээнд төслийн ажлыг хэрэгжүүлэх;





5.3.2. Үнэт цаас гаргах үндсэн үйл ажиллагааг бүхэлд нь Үндсэн андеррайтер удирдан явуулах бөгөөд Туслах андеррайтер нь Үндсэн андеррайтераас бичгээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотой аливаа ач холбогдол бүхий шийдвэрийг бие даан гаргахгүй байх;

5.3.3. Хууль болон Гэрээгээр хүлээсэн бусад үүрэг.

5.4. Туслах андеррайтер нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

5.4.1. Үйлчилгээний хөлсийг Гэрээнд заасны дагуу төлөхийг Үндсэн андеррайтераас шаардах;

5.4.2. Үндсэн андеррайтер нь Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс Үнэт цаас гаргагч, Туслах андеррайтер болон аливаа гуравдагч этгээдэд хохирол учруулсан тохиолдолд тухайн хохирлыг барагдуулахыг Үндсэн андеррайтераас шаардах;

5.4.3. Үндсэн андеррайтераас хууль болон Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэхийг шаардах.

ЗУРГАА. ТАЛУУДЫН БАТАЛГАА

6.1. Талууд нь Үйлчилгээ үзүүлэх хууль эрх зүйн болон хүний нөөц, техникийн чадамжтай болохыг үүгээр баталж байна.

6.2. Гэрээг байгуулснаар Талуудын бусад үйл ажиллагаатай харшлахгүй болохыг Талууд харилцан хүлээн зөвшөөрч байна.

ДОЛОО. НУУЦЛАЛ

7.1. Нууцад хамаарах мэдээлэл

7.1.1. Гэрээний хэрэгжилттэй холбоотой Үнэт цаас гаргагчийн хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл, төлөвлөгөө, төслийн аливаа баримт бичиг, мэдээлэл, мэдэгдэл, бизнесийн, үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөө, Үнэт цаас гаргагчийн харилцагчид, хөрөнгө оруулагч, хувь эзэмшлийн тухай мэдээлэл, Үнэт цаас гаргагчийн санхүүгийн нөхцөл байдлын тухай аливаа мэдээлэл, санхүүгийн тайлан, зах зээлийн судалгаа, хуулийн этгээдийн бүртгэл болон үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг, дүрэм журам, заавар, бодлого, гэрээ хэлцэл эдгээрт заасан нөхцөл, мэдээлэл, тоон үзүүлэлт, зураг, график нь нууцлалд хамаарагдана.

7.1.2. Гэрээний хэрэгжилттэй холбоотой Зөвлөхүүдийн Үнэт цаас гаргагчид зориулан бэлтгэсэн аливаа загвар, модел, тайлан, бусад оролцогч талуудтай байгуулсан, байгуулах гэрээ, үйлчилгээний ноу хау, үнэт цаасыг зуучлан борлуулсан хөрөнгө оруулагчдын мэдээлэл нь нууцлалд хамаарна.

7.1.3. Талуудын Гэрээний 7.1.1, 7.1.2-т хамаарах мэдээллийг прокурор болон шүүхийн байгууллагын шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд дамжуулахыг харилцан хориглоно.

7.1.4. Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах, дуусгавар болгох тохиолдолд нууц мэдээллийг хүлээлгэн өгөх, устгах журмыг Талууд харилцан тохиролцоно.

7.2. Нууц хадгалах хугацаа

7.2.1. Энэхүү Гэрээ цуцлагдсан, дуусгавар болсноос хойш Талууд нөгөө талынхаа болон Үнэт цаас гаргагчийн Гэрээний 7.1.1, 7.1.2-т хамаарах мэдээллийг 3 жилийн хадгалах үүрэг хүлээнэ.


НАЙМ. ХАРИУЦЛАГА

8.1. Талуудын аль нэг нь Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйн улмаас нөгөө тал, Үнэт цаас гаргагч болон гуравдагч этгээдэд учирсан хохирлыг гэм буруутай тал нь бүрэн хүлээж, үүнээс үүдэн гарсан аливаа хохирлыг төлж барагдуулна.

8.2. Талууд Гэрээний 7 дугаар зүйлд заасан үүргээ зөрчсөн бол үүнээс учирсан шууд ба шууд бус хохирол, зардлыг гэм буруутай тал нь бүрэн хариуцна.



2023.08.18



8.3. Талуудын хооронд байгуулагдсан Гэрээ цуцлагдсан буюу дуусгавар болсон нь цуцлагдахаас өмнө бий болсон үүргийн харилцаанд хамаарахгүй буюу тэдгээр үүргийг биелүүлэхээс татгалзах үндэслэл болохгүй бөгөөд уг харилцааны үндэстэнд бий болсон хөрөнгө оруулалттай холбоотой бусад харилцаа хэвээр үргэлжилнэ.

ЕС. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

9.1. Талууд Гэрээний дагуу үйл ажиллагаа явуулахдаа Талуудын эрхийг хүндэтгэн, шударга байдлаар хандах ба Гэрээний зорилгын хэрэгжилтийг хангахын тулд бүхий л зохистой арга хэмжээг авна.

9.2. Гэрээний хэрэгжилтийн явцад үүсэж болох бүх харилцааг Гэрээнд урьдчилан зохицуулах нь бодит байдалд нийцэхгүй гэдгийг Талууд хүлээн зөвшөөрч, энэ Гэрээ хэн хэнийх нь эрх ашигт харилцахгүйгээр шударгаар хэрэгжих ёстойг харилцан ойлголцон, аль нэг тал нь Гэрээний үйл ажиллагаа шударгаар хэрэгжихгүй байна гэж үзвэл энэ байдалд нөлөөлж байгаа шалтгааныг арилгах талаар Талууд сайтар чармайлт гаргахаа үүгээр хүлээн зөвшөөрч байна.

9.3. Гэрээтэй холбогдон үүссэн аливаа санал зөрөлдөөн, маргааныг Талууд харилцан зөвшилцөх аргаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

9.4. Талууд Гэрээний 9.3-т заасан аргаар маргаан, зөрөлдөөнийг шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Монгол Улсын шүүхээр Монгол Улсын хуулийн дагуу шийдвэрлүүлнэ.

АРАВ. БУСАД

10.1. Гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тэмдэг даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

10.2. Гэрээг 2 (хоёр) хувь үйлдэж Тал тус бүр нэгийг хадгалсан нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

10.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр Гэрээний нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэх бөгөөд энэхүү Гэрээний салшгүй хэсэг байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ТУСЛАХ АНДЕРРАЙТЕРИЙГ ТӨЛӨӨЛЖ:
“МАНДАЛ КАПИТАЛ МАРКЕТС ҮЦК” ХХК



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
М. МӨНХТУЯА

ҮНДСЭН АНДЕРРАЙТЕРИЙГ ТӨЛӨӨЛЖ:
“ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК” ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
С. ГАН-ЭРДЭНЭ



2023.08.18



6.14 КОМПАНИЙН АУДИТЫН КОМПАНИТАЙ ХИЙСЭН ГЭРЭЭ

Батлав:
"Мэжик Консалтинг Аудит" ХХК-ийн

Гүйцэтгэх захирал  С.Мөнхбаяр

Батлав:
"М Си Эс Холдинг" ХХК-ийн

Гүйцэтгэх захирал  Д.Гантөмөр

АУДИТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

2022 оны 11 дүгээр сарын 16 Дугаар: 22-118/08/34/МССН-22,235 Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий үндэслэл

Энэхүү гэрээг нэг талаас "Мэжик Консалтинг Аудит" ХХК /цаашид гүйцэтгэгч гэх/-ийг толоолж Гүйцэтгэх захирал С.Мөнхбаяр, нөгөө талаас "М-Си-Эс Холдинг" ХХК /цаашид үйлчлүүлэгч гэх/-ийг төлөөлж Санхүү эрхэлсэн дэд ерөнхийлөгч Г. Энхтүвшин нар харилцан тохиролцож, дараах зүйлүүдэд дурдсан нөхцлийг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр байгуулав.

- 1.1. Энэхүү гэрээний зорилго нь "М-Си-Эс Монголиа" ХХК болон түүний охин компаниуд /хамтад нь "Групп" гэх/-ын 2022 оны 12 дугаар сарын 31, болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн байдлын тайланд аудит хийх, түүнтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. 2022 оны 01 дүгээр сарын 01 өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2023 оны 01 дүгээр сарын 01 өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон хугацааны санхүүгийн үйл ажиллагаанд хамаарах бөгөөд тухайн жилийн санхүүгийн тайланд аудитын ажлыг гүйцэтгэж, зохих дүгнэлт, зөвлөмжийг танилцуулснаар дуусгавар болно.
- 1.3. Энэхүү гэрээний дагуу хийгдэх Аудитын ажлын хүрээнд Гүйцэтгэгч нь Үйлчлүүлэгчийн аливаа баримт бичиг, мэдээлэл, нотлох баримт нь гэрээний дагуу хийж гүйцэтгэх аудитын ажилтай зайлшгүй холбоотой, хууль, журам болоод стандартын дагуу зайлшгүй мэдэх шаардлагатай байх тохиолдолд гэрээ болон хуульд заасны дагуу Үйлчлүүлэгчийн зөвшөөрлийн дагуу, өгсөн хэлбэрээр танилцах боломжтой байна.
- 1.4. "М-Си-Эс Монголиа" ХХК-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд орох болон охин компаниудын тусдаа санхүүгийн тайланд дүгнэлт гаргах үйлчлүүлэгчийн жагсаалтыг Хавсралт 2-т харуулна. Хавсралт 2-т заасан жагсаалтаас бусад байгууллагад дүгнэлт гаргах, нэгтгэлд оруулах тохиолдолд хавсралт 1-т заасан аудиторын цагийн үнэлгээг баримтлан гүйцэтгэгчээс ирүүлсэн цагийн тайланд үндэслэн үйлчлүүлэгч нь нэмэлт төлбөрийг төлнө.

Хоёр. Стандарт

Гүйцэтгэгч нь аудитын ажлыг хийж, гүйцэтгэхдээ дараах стандартууд, хууль журмыг мөрдлөг болгож ажиллана: Үүнд:





- 2.1. Нягтлан Бодогчдын Олон Улсын Холбооны (НБОУХ) Аудит ба Баталгаажуулалтын Олон Улсын Стандартын Зөвлөл (АБОУСЗ)-өөс батлан гаргасан Аудитын Олон Улсын Стандарт (АОУС);
- 2.2. Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс баглан гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ууд;
- 2.3. Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс батлан гаргасан Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС)-ууд;
- 2.4. Монгол Улсын Их Хурлаас баталсан Аудитын тухай хууль, Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжууд, Аудит, Нягтлан бодох бүртгэлийн талаарх Сангийн сайдын тушаалаар батлагдсан, бусад заавар журам, аргачлалууд;

Гурав. Аудиторын хараат бус байдал

- 3.1. Гүйцэтгэгч нь үйлчлүүлэгч байгууллага болон үйлчлүүлэгчээс ажил төрөл, хувийн харилцаа холбооны хувьд, мөн аудитын үйлчилгээ үзүүлж байгаатай холбогдсон нөхцөл байдлын хувьд хараат бус байна.
- 3.2. Гүйцэтгэгч нь аливаа нэг талыг барьсан үзэл бодол болон сонирхлын зөрчилд автаагүй, бусдын нөлөөгүйгээр дүгнэлтээ гаргасан, эсвэл дүгнэлтээ гаргахын тулд оюун санаа болон бодит хандлагын хувьд хараат бус байна.
- 3.3. Гүйцэтгэгч нь хараат бус байх, хараат бус байдлыг алдагдуулахад нөлөөлж болох гуравдагч талын шахалт, эрхшээлд орох аливаа нөхцөл байдлаас зайлсхийж ажиллана.

Дөрөв. Нууцлал

- 4.1. Аудитын явцад Гүйцэтгэгчийн Үйлчлүүлэгчээс авсан болон оороо цуглуулсан, бэлтгэсэн бүхий л мэдээллийн нууцыг Үйлчлүүлэгчтэй байгуулсан "Нууцын гэрээ"-ний дагуу чандлан хадгалах нь АОУС-ын нэг үндсэн зарчим юм. Аудитор нь энэхүү гэрээний хугацаанд мөн түүнийг дуусгавар болсноос хойших хугацаанд, аудитын үйлчилгээ үзүүлэх явцад Үйлчлүүлэгчээс хүлээн авсан, өөрөө цуглуулсан, өөрөө бэлтгэсэн Үйлчлүүлэгчийн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой оюуны өмчлөлийн болон бусад үйлчлүүлэгчийн нууцлал бүхий бүх мэдээлэл, материалыг Үйлчлүүлэгч талаас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр аливаа гуравдагч талд задруулахыг хориглоно.
- 4.2. Үйлчлүүлэгчээс ирүүлсэн мэдээллийн нууцлалыг хангахын тулд Гүйцэтгэгч нь гэрээг ажилд оролцож буй бүх аудитын мэргэжилтнүүдээс энэ талаар батламж авна.

Тав. Аудиторын эрх, үүрэг

- 5.1. Гүйцэтгэгч нь дараах эрхтэй.
 - 5.1.1 Үйлчлүүлэгч байгууллага, түүний гүйцэтгэх удирдлага, нягтлан бодох бүртгэлийн удирдах ажилтан, аудитын хорооны дарга, дотоод аудитын нэгжийн ажилтан, санхүү, бүртгэлийн болон бусад ажилтнаас гэрээнд заасан аудитын ажил үүргийг гүйцэтгэхтэй холбогдсон баримт, мэдээллийг гаргуулж авах, ажиглалт, асуулга, ярилцлага, тулган баталгаажуулалт хийх;



2023.08.18

- 5.1.2 Үйлчлүүлэгч байгууллагад өмнө нь хийсэн аудитын ажлын баримт, мэдээлэлтэй танилцах;
- 5.1.3 Аудитын үйл ажиллагааг гүйцэтгэхтэй холбоотой баримт, мэдээллийг харилцагч банк, санхүүгийн байгууллага болон бусад холбогдох аж ахуйн нэгж, байгууллагаас шаардан авч танилцах;
- 5.1.4 Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний 1.2-т заасан санхүүгийн тайлант хугацаанд хамаарах санхүүгийн тайланд аудит хийх бөгөөд тус хугацаанаас өмнөх онд хамаарах санхүүгийн тайланд аудит, нягтлах ажил эсвэл ямар нэгэн баталгаажуулах горим хэрэгжүүлэхгүй байж болно.
- 5.1.5 Аудит хийх явцад санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд үнэн зөв, бодитой байгаа нөхцөлд эерэг, зөрчилтэй байгаа нөхцөлд өөрчлөгдсөн дүгнэлт (Хязгаарлалттай, Сөрөг, Татгалзан) гаргана. Үйлчлүүлэгч нь тайланд байгаа зөрчил, алдаатай зүйлүүдийг засварласны дараа гүйцэтгэгч өмнөх дүгнэлтийг эерэг байдлаар өөрчилж болно.
- 5.1.6 Хэрэв Аудитын зөрчилтэй дүгнэлт гарах тохиолдолд тухайн Аудитын дүгнэлтийг эцсийн байдлаар гаргахаас өмнө зөрчлийн шалтгааны талаар Үйлчлүүлэгчтэй хэлэлцэнэ.
- 5.1.7 Үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн хотлолт, санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Монгол улсын хууль тогтоомжийн шаардлага хангаагүй болон захиалагч нь нотлох баримт бичиг, тайлбарыг гаргаж өгөөгүй буюу алдаа залруулах тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд гүйцэтгэгч, үйлчлүүлэгчийн санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргахаас татгалзах эрхтэй.
- 5.1.8 Үйлчлүүлэгч "Аудит хийхэд шаардагдах мэдээллийн дэлгэрэнгүй жагсаалт"-ын дагуу баримт, материалыг гаргаж өгснөөр аудитын ажил эхлэх ба гаргаж өгөөгүйн улмаас үүсэх хариуцлагыг гүйцэтгэгч хүлээхгүй.
- 5.2. **Гүйцэтгэгч нь дараах үүрэгтэй.**
- 5.2.1 Аудитын үйл ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд, хууль тогтоомж, холбогдох стандартын дагуу явуулах;
- 5.2.2 Аудит хийж болохооргүй нөхцөл байдал бий болсон тохиолдолд аудит хийхээс татгалзах, эсхүл бусад мэргэжилтнийг татан оролцуулах, шаардлага гарвал энэ тухай өөрийн болон үйлчлүүлэгч байгууллагад мэдэгдэх;
- 5.2.3 Үйлчлүүлэгч хүсвэл дүгнэлтийнхээ үндэслэлийг бичгээр болон амаар тайлбарлах;
- 5.2.4 Гэрээний хугацаанд тайлант хугацааны явцад нягтлан бодох бүртгэл хөтлөх үйл ажиллагааны болон дотоод хяналтын системд байгаа сул доголдолтой зүйсийн талаар зөвлөмж өгнө.
- 5.2.5 Гүйцэтгэгч нь гаргасан дүгнэлтийн үнэн зөвийн талаар хууль, тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.
- 5.2.6 Гүйцэтгэгч түүний ажилтан Үйлчлүүлэгч байгууллагын мэдээллийг задлах, ашигласан тохиолдолд Үйлчлүүлэгч байгууллагад учирсан бүхий л хохирлыг Үйлчлүүлэгчтэй байгуулсан "Нууцын гэрээ"-ний дагуу хариуцан барагдуулна.
- 5.2.7 Гүйцэтгэгч нь аудитын үйл ажиллагаанд туслан гүйцэтгэгч оролцуулахгүй.
- 5.2.8 Хэрэв туслан гүйцэтгэгч ажиллуулах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд Үйлчлүүлэгчид мэдэгдэж зөвшөөрөл авч ажиллуулах бөгөөд Гүйцэтгэгч нь туслан гүйцэтгэгчийн аливаа бүх үйлдэлд бүрэн хариуцлага хүлээнэ.
- 5.2.9 Аудитын тайланг Үйлчлүүлэгчийн шаардлагын дагуу Монгол хэл болон Англи хэл дээр гарган өгнө.



[Handwritten signature]



2023.08.18

**Зургаа. Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг**

- 6.1 Үйлчлүүлэгчийн эрх**
- 6.1.1 Үйлчлүүлэгч нь аудитын дүгнэлтийн талаар тайлбар авах;
- 6.1.2 Аудитын дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй бол холбогдох байгууллагад гомдол гаргах;
- 6.1.3 Гүйцэтгэгчид аудиторыг солих хүсэлт гаргах;
- 6.1.4 Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг нэхэмжлэх.
- 6.2 Үйлчлүүлэгчийн үүрэг**
- 6.2.1 Байгууллагын аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэл, тайланд стандартын дагуу зөв тусгасан тухай, мөн элгээртэй холбогдох баримт, материал, тайлбарыг бүрэн танилцуулсан, энэ талаар үүсч болох хариуцлагыг хүлээх тухайгаа нотолсон тодорхойлолтыг аудиторт гаргаж өгөх;
- 6.2.2 Үйлчлүүлэгч нь СТОУС, Монгол улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтөлж санхүүгийн тайланг гаргасан байна.
- 6.2.3 СТОУС, Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцүүлэн гаргасан санхүүгийн тайланг аудиторт шалгуулахаар хүлээлгэн өгөх;
- 6.2.4 Аудитын үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоогоор хангах;
- 6.2.5 Гүйцэтгэгчийн шаардсан баримт, мэдээллийг хугацаанд нь гаргаж өгөх;
- 6.2.6 Аудит хийх явцад илэрсэн бүртгэл хөтлөлт болон санхүүгийн тайлантай холбоотой хүлээн зөвшөөрсөн алдаа, зөрчлийг шуурхай залруулах;
- 6.2.7 Байгууллагын удирдлагын зүгээс аудитын үйл ажиллагаанд саад учруулахгүй, хөндлөнгөөс оролцохгүй, ямар нэг хэлбэрээр дарамт шахалт үзүүлэхгүй байх;
- 6.2.8 Гүйцэтгэгчийн аудитын ажлын хүрээний дагуу хүссэн шаардлагатай нотлох баримтыг гуравдагч этгээдээс гаргуулж өгөх;
- 6.2.9 Гүйцэтгэгчид гаргаж танилцуулсан санхүүгийн тайланг СТОУС болон эрх бүхий байгууллагаас тогтоосон дүрэм журамд нийцүүлэн гаргасан эсэхийг болон бусад баримт, мэдээллийн үнэн зөв, бодитой байх хариуцлагыг үйлчлүүлэгч байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч (нягтлан бодогч) нар хүлээнэ.
- 6.2.10 Дотоод хяналтын системийг зөв зохистой хэрэгжүүлэх, түүний байнгын ажиллагааг хангах замаар алдаа, зальт ажиллагааг илрүүлэх болон түүнээс урьдчилан сэргийлэх үүрэг нь компанийн удирдлагын үүрэг хариуцлагад хамаарна.
- 6.2.11 Гэрээний 7.2-д заасан аудитын үйлчилгээний хөлсийг дүгнэлтийн төрөл (сэрэг, сөрөг, хязгаарлалттай болон татгалзсан)-өөс үл хамааран гүйцэтгэгчид төлнө.

Долоо. Ажлын хугацаа, үйлчилгээний үнэ

- 7.1. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний 1.1-д заасан тайлант хугацааны санхүүгийн тайланг баталгаажуулах аудитын үйлчилгээг жил бүр Хавсралт 2-т заасан хугацаанд багтаан гүйцэтгэнэ. Хавсралт 2-т заасан хугацаа өөрчлөгдөх бол аудитын талбарын ажил эхлэхээс өмнө урьдчилан мэдэгдэнэ.
- 7.2. Санхүүгийн тайлангийн аудитын хөлс төгрөг байна. Аудитын хөлс нь НӨАТ-гүй дүн болно. Аудитын үйлчилгээний төлбөрийг талбарын ажил эхлэх үед 50%-ийг, Санхүүгийн тайланг баталгаажуулж, дүгнэлт өгсний дараа 50%-ийг компани бүрээр тус тус нэхэмжилнэ.
- 7.3. Компани бүр төлбөрийг гүйцэтгэгчийн илгээсэн нэхэмжлэхэд үндэслэн төлнө.



2023.08.18

- 7.4. Төлбөр хүлээн авах данс: “Мэжик Консалтинг Аудит” ХХК-ийн Голомт банкны 3155116868 тоот төгрөгийн данс.
- 7.5. Хэрэв аудитын тайлан гарсан өдрөөс хойш үйлчлүүлэгч санхүүгийн тайланд өөрчлөлт оруулсан тохиолдолд гүйцэтгэгчид өөрчлөлт оруулсан талаарх мэдээллийг албан бичгээр зохистой нотлох баримтын хамт хүргүүлж аудитын тайланд өөрчлөлт оруулж болно. Энэ тохиолдолд дахин гаргасан Аудитын тайлангийн үнэ нь Хавсралт 2-т заасан компани бүрийн үнийн дүнгийн 10% байна.
- 7.6. Аудитын ажлыг 7.1-д заасан хугацаанд багтаан гүйцэтгэж дуусаагүй нөхцөлд гэрээний талууд энэ талаар хэлэлцэж дараах байдлаар шийдвэрлэнэ. Үүнд:
- Гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас шалтгаалсан бол энэхүү гэрээт ажлыг дуусгах хүртэл ажлыг нэмэлт төлбөргүйгээр гүйцэтгэж дуусгана.
 - Үйлчлүүлэгчийн үйл ажиллагаанаас шалтгаалсан бол гэрээт ажлыг дуусгахад цаашид шаардлагатай хугацааг тухайн компанийн хувьд харилцан тохиролцон нэмэлт гэрээ байгуулна. Нэмэлт гэрээний 1 цагийн хөлсийг Хавсралт-1-д заасан аудиторын үнэлгээнд үндэслэн тооцох бөгөөд энэ дүн нь Хавсралт 2-т заасан тухайн компанийн гэрээний үнийн дүнгийн 15 хувиас хэтрэхгүй байна. Нэмэлт гэрээний төлбөрийн цагийн тооцооллыг “тооцоо нийлсэн акт”-д үндэслэн хийнэ.
 - 7.7. Хавсралт 2-т заасан аудитын ажлын хамрах хүрээ өөрчлөгдсөн тохиолдолд анхны үнийн саналын үнэлгээг баримталж харилцан тохиролцоно.

Найм. Гэрээний хариуцлага

- 8.1. Энэхүү гэрээт ажлын хэрэгжилт, үр дүнг гүйцэтгэгч талыг төлөөлж “Мэжик Консалтинг Аудит” ХХК-ийн Аудитын менежер Н.Мөнхзаяа, үйлчлүүлэгч талыг төлөөлж “М-Си-Эс Холдинг” ХХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн контроллер Т. Цэнгэлжаргал нар хяналт тавьж ажиллана.
- 8.2. Үйл ажиллагааныхаа орлого зардал, санхүүгийн үр дүн болон санхүүгийн байдлыг бүртгэл, тайландаа буруу эсвэл дугуу тусгаснаас үүсэх материаллаг хохирлыг үйлчлүүлэгч бүрэн хариуцна. Ажил гүйцэтгэгч энэ талаар үйлчлүүлэгчийн өмнөөс материалын хариуцлага хүлээхгүй.
- 8.3. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувиар тооцож хугацаа хэтрүүлсэн хоног тутамд алданги төлнө.

Ес. Гэрээг цуцлах

- 9.1. Үйлчлүүлэгч компанийн зүгээс гэрээг цуцлах болсон тохиолдолд аудиторын гүйцэтгэсэн ажилд хамаарах төлбөрийг компани буцаан нэхэмжлэх эрхгүй.
- 9.2. Гүйцэтгэгчийн буруугаас гэрээг цуцлах болсон тохиолдолд үйлчлүүлэгч компаниас хүлээн авсан төлбөрийг буцааж бүрэн төлнө.
- 9.3. Аль нэг Тал нь Гэрээний үүрэг ноцтой зөрчсөний улмаас нөгөө талдаа шууд хохирол учруулсан тохиолдолд Гэрээний үүрэг зөрчөөгүй Тал нь тус зөрчлийн талаар мэдэгдэл хүргүүлсэнээс хойш зөрчлийг тогтоосон хугацаанд арилгаагүй эсвэл арилгахаас татгалзсан тохиолдолд Гэрээний үүрэг зөрчөөгүй Тал нь Гэрээ цуцлах мэдэгдэл өгч, түүнээс хойш арав (10) хоногийн дотор Гэрээг цуцлах эрхтэй байна.



Handwritten signature



2023.08.18



- 9.4. Хэрэв 9.1-9.3-д дурдсан үйл явдал тохиолдвол Гүйцэтгэгч нь аудитын дүгнэлт гаргах үүрэг хүлээхгүй.

Арав. Гэрээний бусад заалт

- 10.1. Аудитын үйл ажиллагааны явцад Гүйцэтгэгчийн Үйлчлүүлэгчээс хүлээн авснаас бусад өөрөө цуглуулсан болон өөрөө бэлтгэсэн цахим баримт бичиг, файлыг оролцуулан аудит хийх хугацааны бүх ажлын баримтууд болон файлууд нь Гүйцэтгэгчийн өмч байна.
- 10.2. Гэрээ байгуулах бүрэн эрхтэй этгээдүүдэд өөрийн бүрэн эрхээ нотолсон бөгөөд хожим энэ талаар маргаан гаргах эрхгүй.
- 10.3. Талууд харилцан тохиролцсоноор энэхүү Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд тэрхүү нэмэлт, өөрчлөлт нь энэ Гэрээний салшгүй хэсэг байна.
- 10.4. Аудиторын тайланг Монгол, Англи хэлээр гаргасан үед тайлан болон зөвлөмжид утгын зөрүү гарвал Монгол хэл дээрх хувилбарыг үндэслэл болгоно.
- 10.5. Гэрээг Монгол хэлээр хууль, эрх зүйн хувьд адил хүчин төгөлдөр 2 /хоёр/ хувь үйлдсэн бөгөөд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 10.6. Энэхүү гэрээ нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, дүрэм журмын хүрээнд хийгдэж байгаа бөгөөд гэрээнд оролцогч талууд гэрээний хүрээнд үүсэх аливаа маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Байгууллагын нэр:
“Мэжик Консалтинг Аудит”
ХХК

Албан тушаал: Аудитын менежер
Овог нэр: Н.Мөнхзаяа

Гарын үсэг:

Хаяг:
Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 25-р
хороо, Манлай баатар
Дамдинсүрэнгийн гудамж, UB
Tower 15 давхар, 1502 тоот

Утас: 70131044, 88112064
2022 оны 11 дүгээр сарын __

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Байгууллагын нэр:
“М-Си-Эс Холдинг” ХХК

Албан тушаал: Санхүү эрхэлсэн дэд
ерөнхийлөгч
Овог нэр: Г. Энхтүвшин



Гарын үсэг:

Хаяг:
Монгол-Улс, Улаанбаатар 14241,
Сүхбаатар дүүрэг 1, Олимпын гудамж 19,
Шангри-Ла оффис, 24 давхар

Утас: 77778833
2022 оны 11 дүгээр сарын 16



2023.08.18



2023-08-18
ТООТ Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээний
Хавсралт I

“Мэжик Консалтинг Аудит” ХХК-ийн Гүйцэтгэх
Захирлын 2016 оны 06 дугаар сарын 15-ний
өдрийн 6 дугаар тушаалаар батлав.

1. Аудитын үйлчилгээний үнэ тогтоох

- 1.1. Санхүүгийн тайлангийн хараат бус аудитын ажлыг гүйцэтгэх аудиторын нэг цагийн үнэлгээг аудиторын ур чадвар, мэргэшилд үндэслэн тогтооно. Тухайн харилцагчийн санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэхэд зарцуулагдах хугацааг уламжлалт болон хяналтын эрсдэлд үндэслэн тодорхойлох бөгөөд аудиторуудын гүйцэтгэх үнэлгээгээр үржүүлэн аудитын үйлчилгээний үнийг тооцно.
- 1.2. Аудиторын нэг цагийн үнэлгээг дараах байдлаар тогтооно:

Ангилал	Нэг цагийн үнэлгээ (төгрөг)
Чанарын хяналтын аудитор	
Гүйцэтгэх захирал	
Аудит менежер	
Татварын мэргэшсэн зөвлөх	
IT инженер	
Аудит ахлах	
Туслах	




Handwritten signature



Handwritten signature

2023.08.18



KPMG Audit LLC
#602, Blue Sky Tower
Peace Avenue 17,
1st khoroo, Sukhbaatar district,
Ulaanbaatar 14240, Mongolia

Telephone +976 7011 8101
Fax +976 /011 8102
Internet www.kpmg.com/mn

MCSH-22-257

Mr. Ariunbayar.B,
Managing Director,
MCS Mongolia LLC
24F, Shangri-La office,
19A Olympic street, SBD-1,
Ulaanbaatar 14241, Mongolia

Ms. Enkhtuvshin.G,
Vice President for Finance,
MCS Holding LLC
24F, Shangri-La office,
19A Olympic street, SBD-1,
Ulaanbaatar 14241, Mongolia

Mr. Purevsuren.Ya,
Vice President,
MCS Properties Holding LLC
16F, Central Tower,
Chinggis square-2, SBD-8,
Ulaanbaatar 14200, Mongolia

6 December 2022

Dear Mr. Ariunbayar.B, Ms. Enkhtuvshin.G and Mr. Purevsuren.Ya

Addendum to the Engagement letter dated 13 December 2021


This addendum (the "Addendum") made on 6 December 2022 forms an addendum to the auditing service engagement letter dated 13 December 2021 by and between MCS Mongolia LLC, MCS Holding LLC and MCS Properties Holding LLC (the "Client" or "Clients") and KPMG Audit LLC (the "Engagement letter").

This addendum forms a variation to the Engagement Letter dated 13 December 2021 and except as expressly provided herein all the terms of that engagement letter shall continue to apply.



I. Amend section 1.1 as follows:

1.1 The directors are responsible for the maintenance of the Clients' accounting records and the preparation of financial statements which give a true and fair view in accordance with International Financial Reporting Standards ("IFRS"). The financial statements for the purpose of this contract comprise the consolidated financial statements of MCS Mongolia LLC, MCS Holding LLC, and MCS Properties Holding LLC, consolidated financial statements of Ashid Capital NBFI LLC, and stand-alone financial statements of MBank Closed JSC and financial statements of International Medical Center LLC. These various financial statements consist of:

- 1) *MCS Mongolia LLC*: the consolidated statement of financial position as at 31 December 2022, consolidated statements of comprehensive income, changes in equity and cash flows for the year then ended and notes to the financial statements;
- 2) *MCS Holding LLC*: the consolidated statement of financial position as at 31 December 2022, consolidated statements of comprehensive income, changes in equity and cash flows for the year then ended and notes to the financial statements;
- 3) *MCS Properties Holding LLC*: the consolidated statement of financial position as at 31 December 2022, consolidated statements of comprehensive income, changes in equity and cash flows for the year then ended and notes to the financial statements;
- 4) *MBank Closed JSC*: the stand-alone statement of financial position as at 31 December 2022, stand-alone statements of comprehensive income, changes in equity and cash flows for the year then ended and notes to the financial statements;
- 5) *International Medical Center LLC*: the statement of financial position as at 31 December 2022, statements of comprehensive income, changes in equity and cash flows



2023.08.18



*MCS Mongolia LLC, MCS Holding LLC, MCS Properties Holding LLC,
 MBank Closed JSC, International Medical Center LLC and Ashid Capital NBF LLC
 Addendum to the Engagement letter dated 13 December 2021*

- for the year then ended and notes to the financial statements (investment in associate at equity method); and
- 6) *Ashid Capital NBF LLC*: the consolidated statement of financial position as at 31 December 2022, consolidated statements of comprehensive income, changes in equity and cash flows for the year then ended and notes to the financial statements of Ashid Capital NBF LLC and its subsidiary.


II. Amend section 8.1 as follows:

The proposed fees for the audits of the financial statements are as follows:


Non-statutory audit of the consolidated financial statements of MCS Mongolia LLC for the year ended 31 December 2022, prepared in accordance with IFRS	
Non-statutory audit of the consolidated financial statements of MCS Holding LLC for the year ended 31 December 2022, prepared in accordance with IFRS	
Non-statutory audit of the consolidated financial statements of MCS Properties Holding LLC for the year ended 31 December 2022, prepared in accordance with IFRS	
Statutory audit of the stand-alone financial statements of MBank Closed JSC for the year ended 31 December 2022, prepared in accordance with IFRS	
Non-statutory audit of the financial statements of International Medical Center LLC for the year ended 31 December 2022, prepared in accordance with IFRS (investment in associate at equity method)	
Statutory audit of the consolidated financial statements of Ashid Capital NBF LLC for the year ended 31 December 2022, prepared in accordance with IFRS	



2023.08.18



simple



MCS Mongolia LLC, MCS Holding LLC, MCS Properties Holding LLC, MBank Closed JSC, International Medical Center LLC and Ashid Capital NBF LLC Addendum to the Engagement letter dated 13 December 2021

Except as set forth in this Addendum, the auditing service engagement letter dated 13 December 2021 and related terms and conditions are unaffected and shall continue in full force and effect.

Best regards,

Handwritten signature of Sang Yong Cho
Sang Yong Cho,
Partner, Head of Audit
KPMG Audit LLC

We hereby agree to the terms and conditions as set out above (signed and stamped):

Stamp: МОНГОЛЫН ХАНАГААТ АЖ АХУЙН ХӨДӨӨ АЖ АХАЙН ХӨДӨӨ
Mr. Ariunbayar.B,
Managing Director
MCS Mongolia LLC

Handwritten signature of Enkhtuvshin.G
Enkhtuvshin.G
Vice President for finance
MCS Holding LLC



Handwritten signature of Purevsuren.Ya
Purevsuren.Ya
Vice President
MCS Properties Holding LLC

Stamp: УЛААНБААТАР ХОТ
АШИД КАПИТАЛ
ББС ХХК
Handwritten signature

Stamp: МАНДАЛ КАПИТАЛ
МАРКЕТС ТҮХ ХХК
MANDAL CAPITAL
MARKETS SC
LLC
166
Handwritten signature
9021070414 5213487

Stamp with handwritten signature

2023.08.18



6.15 КОМПАНИЙН ХУУЛИЙН КОМПАНИТАЙ ХИЙСЭН ГЭРЭЭ

АШИД КАПИТАЛ ББСБ ХХК

БОЛОН



ӨМГӨӨЛЛИЙН БАТБАЯР ЭНД ПАРТНЭРС ХХН-ИЙН

**ХООРОНД БАЙГУУЛСАН
ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ**

Огноо: 2023/05/19
Дугаар: 23/06
ТЛ-31-01-23-720

УЛААНБААТАР ХОТ





Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ

2023 оны 5 дугаар
сарын 19-ний өдөр

№ 23/06

Улаанбаатар хот

Энэхүү Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г Монгол Улсын Иргэний хуулийн 343-356 дугаар зүйлүүд болон холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн,

Нэг талаас Монгол Улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сентрал Тауэр, 15 давхар хаягт орших АШИД КАПИТАЛ ББСБ ХХК (цаашид "А тал" гэх),

Нөгөө талаас Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Монгол ТВ цамхаг, 10 давхар албан ёсны хаягт байрлах Өмгөөллийн Батбаяр энд Партнерс ХХН (цаашид "Б тал", хамтад нь "Талууд" гэх), нар

дараах нөхцөлүүдийн талаар харилцан тохиролцож байгуулав. Үүнд:

1. Гэрээний дагуу Б тал нь А талын нийтэд санал болгон гаргаж буй өрийн бичгийг үнэт цаасны бүртгэлд болон хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгүүлэхэд шаардагдах хөндлөнгийн дүн шинжилгээг А талаас гаргаж өгсөн баримт материал, шийдвэрт үндэслэн шалгаж Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн №225 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн №226 тоот тогтоолоор батлагдсан "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам", Монголын Хөрөнгийн бирж ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн №2018/01 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэгт заасан асуудлыг хамруулсан хуулийн дүгнэлт бэлтгэх ажил (цаашид "Ажил" гэх)-ыг энэхүү Гэрээнд заасан үнэ, хугацаа, нөхцөлөөр хийж гүйцэтгэх ба А тал нь тохирсон ажлын хөлсийг тогтоосон хугацаанд төлнө.

2. Гэрээ, бичиг баримтын албан ёсны орчуулга хийх, А талыг шүүх, арбитр, цагдаа, шийдвэр гүйцэтгэх байгууллагад төлөөлөх, нотариатын үйлчилгээ, улсын тэмдэгтийн хураамжийн зардал, бүртгэлийн байгууллагын хураамж, шийтгэл, бүх төрлийн лавлагаа, тодорхойлолтын хураамж, төлөөлөх үйлчилгээ, Улаанбаатар хотоос өөр газар хийх уулзалтад оролцох, татвар, санхүү, техникийн холбогдолтой болон даатгалын асуудал, байгууллагын бизнесийн үйл ажиллагаа (Гэрээний Хавсралт №1-т зааснаас бусад)-ны талаар зөвлөх, Монгол Улсаас бусад улсын хууль тогтоомжийн асуудлаар зөвлөгөө өгөх зэрэг Гэрээний Хавсралт №1-т заасан үйлчилгээтэй холбоотой үүсэж болох бусад харилцаа нь Гэрээний дагуу гүйцэтгэх үйлчилгээнд хамаарахгүй, нэмэлт ажил гэж үзнэ.

3. Дараах Гэрээний хавсралтууд нь Гэрээний салшгүй хэсэгт тооцогдоно.

3.1. Хавсралт №1: Ажлын хамрах хүрээ, төлөөлөгөө;

3.2. Хавсралт №2: А талаас гаргаж өгөх материал, лавлагаа, тодорхойлолт.

4. Энэхүү Гэрээний дагуу Б талаас үзүүлэх үйлчилгээ нь А талаас гаргаж өгсөн мэдээлэл, баримт материал, шийдвэрт үндэслэх бөгөөд А тал нь Гэрээний дагуу гүйцэтгэх ажил, үйлчилгээтэй холбоотой бүхий л мэдээлэл, баримт материал, шийдвэрийг үнэн зөв, бүрэн гүйцэт, шаардлагатай цаг хугацаанд нь гаргаж өгөх үүрэг хүлээнэ. Ийнхүү гаргаж өгөөгүй, алдаатай, буруу эсвэл дутуу мэдээлэл, баримт өгсний улмаас үүсэх аливаа хууль зүйн болон санхүүгийн үр дагаврыг Б тал хариуцахгүй.

5. А тал нь Б талыг Компанийн байранд нэвтрэх, уулзалт хийхэд шаардлагатай холбогдох мэдээллийг авах, шалгах ажлыг гүйцэтгэх орчноор хангах, тухайн мэдээлэл, баримтыг хариуцсан ажилтнуудыг томилж ажиллуулах, мэдээ, материал, түүний агуулгыг тодорхойлоход туслах, зэрэг Ажлыг үнэн зөв, цаг хугацаанд нь гүйцэтгэхэд шаардлагатай бусад ажлыг зохион байгуулах, эрх бүхий байгууллагаас лавлагаа, тодорхойлолт, тодруулга авч өгөх үүрэгтэй.

6. Гэрээний хугацаа нь Гэрээ хүчин төгөлдөр болж, Б талаас гаргаж өгсөн баримт материалын жагсаалтын дагуу А талаас бүрэн гаргаж өгсөн өдрөөс эхлэн 1 (нэг) сар байна. Гэрээний хугацааг талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр хугацаанаас нь дуусгавар болгож, эсвэл хугацааны эцэст сунгаж болно.

7. А тал нь Гэрээний Хавсралт №2-т заасан мэдээлэл, материалыг Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш ажлын 5 (таван) өдрийн дотор бэлтгэж, Б талд албан ёсны и-мэйл хаяг, бусад платформууд болон биет байдлаар хүлээлгэн өгнө. Б талаас үл хамаарах шалтгаанаар (тухайлбал А тал тохиролцсон хугацаандаа материал гаргаж өгөхгүй байх г.м) ажил гүйцэтгэх

А тал

2

Б тал



2023.08.18

Нууц

Эх хувь

хугацаа хойшлогдсон бол Б тал нь А талд ажлыг гүйцэтгэх хугацаанд өөрчлөлт оруулах санал гаргаж болно. Ажлын төлөвлөгөөг энэхүү Гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш талууд харилцан тохиролцож, баталгаажуулна. Урьдчилан гаргаж өгсөн баримтууд дээр үндэслэн дараагийн шаардлагатай дүн шинжилгээ хийж, эрх бүхий байгууллагаас шаардсан нөхцөлийг тодруулахад ач холбогдолтой баримтуудыг Хуулийн фирмээс тодорхойлох бөгөөд А тал нь тухай бүр шуурхай гаргаж өгч ажиллана.

8. Гэрээгээр тохиролцсон Ажлын хөлс ӨАТ
ороогүй):

8.1. А тал нь Б талаас ирүүлсэн төг лын
хөлсийг дараах нөхцөлөөр 3 (гурав) хувааж те

8.1.1. иван
эрээ байгуулагдсан өдрөөс

8.1.2. иван
мянган) төгрөгийг Хуулийн өдөрт багтаан төлнө;

8.1.3. Ажлын хөлсний үлдэгдэл 1 иван
гурван зуун мянган) төгрөг
гарсан өдрөөс хойш ажлын 3 (тав) өдөрт багтаан төлнө.

8.2. Хэрэв Гэрээний 8.1.2-т заасан нөхцөлд Б талаас үл хамаарах шалтгаанаар саатсан, хойшилсон бол А тал нь Гэрээний 8.1.2-8.1.3-т заасан төлбөр Гэрээний 6-т заасан хугацааны эцэст нэгтгэн төлнө.

8.3. Нэмэлт ажил: Хэрэв Б талаас үл хамаарах шалтгаанаар Ажил Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш 1 (нэг) сараас дээш хугацаагаар үргэлжилсэн эсхүл өрийн бичгийг нэмэлт транч гаргах нөхцөлд нэмэгдэл ажил гэж тооцно. Нэмэлт ажил болон нэмэгдэл ажлын хөлсийг Талууд харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд нэмэлт транч 8 сар, 10 сард гаргах тохиолдолд тухай бүрд 2 сая төгрөг (НӨАТ ороогүй) байхаар, хугацааны хувьд өөрчлөгдөх тохиолдолд ажлын цар хүрээгээс хамаарч тухай бүр харилцан тохиролцож шийдвэрлэхээр тохиролцов.

8.4. А тал нь Гэрээний 8.1-8.3-т заасан Ажлын хөлснөөс ямар нэгэн татвар болон шимтгэл суутгахгүй болно. Гэрээний төлбөрийг Б талаас ирсэн нэхэмжлэхийн дагуу доорх дансанд төлнө. Үүнд:

Худалдаа, хөгжлийн банк: 470006252
Төлбөр хүлээн авагч: Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН

9. Б тал нь энэхүү Гэрээний дагуу зөвлөх үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой олж авсан А талын нууц гэж тодорхойлсон мэдээллийн нууцлалыг чанд хадгалах үүргийг хугацаагүйгээр хүлээнэ.

10. Б талын энэхүү Гэрээний дагуу хүлээх аливаа хариуцлага нь Гэрээний дагуу А талаас бодитоор төлсөн төлбөрийн 50 (тавь) хувиас хэтрэхгүй бөгөөд аль ч тохиолдолд олох байсан ашиг, шууд бус хохирол, зардал, алдагдал, А талын гурвадагч этгээдийн өмнө хүлээх үүрэг, хариуцлагыг хариуцахгүй.

11. Б талын хариуцлага нь гэрээний Хавсралт №2-т заасан мэдээлэлд үндэслэж, Үнэт цаасны бүртгэлийн журам болон Өрийн хэрэгслийн бүртгэлийн журамд заасан асуудлаар үнэн зөв дүгнэлт гаргах үүргээр хязгаарлагдана.

12. Талуудын хан аль нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй хугацаа хожимдуулсан тохиолдолд хожимдсон хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,1%-ийн алдангийг нөгөө талдаа төлнө.



13. Талуудыг төлөөлж Гэрээний дагуу мэдээлэл солилцох ажилтан:

13.1. А талыг төлөөлж:

Нэр: Г.Мөнхбаясгалан
Албан тушаал: Санхүүгийн удирдлагын албаны дарга
Утас: 99055619
Гар утас: 99055619
Цахим шуудан: munkhbayasgaln.g@simple.mn



2023.08.18



Нууц

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сентрал Тауэр, 15 давхар.

13.2. Б талыг төлөөлж:

Нэр: Д.Хулан
Албан тушаал: Гүйцэтгэх захирал
Утас: 77119008
Гар утас: 88681505
Цахим шуудан: khulan.d@bnp.mn
Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Монгол ТВ цамхаг, 10 давхар

14. Талуудаас Гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ашиглагдсан мэдээлэл, баримт материалууд нь тухайн талын эзэмшил, өмчлөлд хэвээр үлдэнэ. Талуудын Гэрээний хүрээнд солилцсон бүх мэдээлэл нь нууц баримтад тооцогдох бөгөөд дүн шинжилгээ хийж, хуулийн дүгнэлт гаргахаас бусад зорилгоор ашиглахгүй. Талууд гэрээт ажлын явцад шууд болон шууд бусаар олж мэдсэн байгууллага, хувь хүний нууцад хамаарах аливаа мэдээ, мэдээллийг бусдад бичгээр, амаар болон бусад хэлбэрээр задруулахгүй байх, уг мэдээллийг өгсөн байгууллагынхтай нь ижил төвшинд нууцалж хамгаалах үүргийг хугацаагүй хүлээнэ.

15. Талууд харилцан тохиролцож бичгээр гэрээ байгуулах хэлбэрээр Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

16. Энэхүү Гэрээ нь Монгол Улсын хуулиар зохицуулагдах бөгөөд маргаантай асуудлыг эв зүйгээр зохицуулах боломжгүй нөхцөлд Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

17. Энэхүү Гэрээ нь Талууд гарын үсэг зурж, тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж, Гэрээний нөхцөл бүрэн биелэгдсэн эсвэл Гэрээ хугацаанаасаа өмнө цуцлагдсанаар дуусгавар болно.

18. Талуудын төлөөлөгчид энэхүү гэрээг байгуулах эрхтэй гэдгээ харилцан баталгаажуулсан болно.

19. Гэрээгээр тохиролцсон ажил гүйцэтгэх өрөнхий хугацаа дуусахад Гэрээний зорилго бүрэн биелээгүй байх нөхцөлд хоёр тал харилцан тохиролцож, гэрээний хугацааг сунгаж болно.

ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ БАЙГУУЛСАН:

А тал:

Ашид Капитал ББСБ ХХК

түүнийг төлөөлж
Гүйцэтгэх захирал
П.Батжаргал



Б тал:


Өмгөөллийн Батбаяр энд Партнерс ХХН

түүнийг төлөөлж
Гүйцэтгэх захирал
Д.Хулан



Checked by
Legal Department
Date: 2023.05.28

Signature: [Signature]



Б тал



2023.08.18

Хавсралт №1

Ажлын хамрах хүрээ, төлөвлөгөө

Энэхүү Гэрээ байгуулагдаж, А талаас гаргаж өгсөн мэдээлэл, баримт материалыг бүрэн хүлээн авсан өдрөөс хойш 1 (нэг) сарын хугацаанд ажлыг хийж гүйцэтгэх бөгөөд ажлын дэлгэрэнгүй хуваарийг А талын ажлын явцад нийцүүлж Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 5 (таван) өдөрт баггаан нарийвчлан тохиролцоно. Нарийвчлан тохиролцсон ажил, үүргийн хуваарь нь Гэрээний салшгүй хэсэгт тооцогдоно

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн №225 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.4 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн №226 тоот тогтоолоор батлагдсан "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам", Монголын Хөрөнгийн бирж ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн №2018/01 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэгт заасан асуудлыг хамруулсан хуулийн дүгнэлт гаргана. Хуулийн дүгнэлт нь дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:

Санхүүгийн зохицуулах хороо Үнэт цаасны бүртгэлийн журамд тусгагдсан асуудал	Монголын Хөрөнгийн бирж ТӨХК Үнэт цаасны бүртгэлийн журамд тусгагдсан асуудал
(i) Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх, үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх;	(i) Үнэт цаас гаргагч компанийн улсын бүртгэл, татавар төлөгчийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх;
(ii) Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж болон Хорооноос баталсан "Монголын Компанийн Засаглалын кодекс"-т заасан шаардлага хангасан болон гэмт хэрэгт холбогдож байсан эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын байдал;	(ii) Компанийн дүрэм, үнэт цаасаа анх удаа нийтэд санал болгон гаргаж байгаа компанийн хувьд хувьцаат компанийн дүрмийн төсөл, бусад дотоод журмууд нь хууль тогтоомж, Хорооноос баталсан "Монголын компанийн засаглалын кодекс"-т нийцсэн эсэх;
(iii) Үнэт цаас гаргагчийн дүрэм, дотоод журмууд нь холбогдох хууль тогтоомж, Хорооноос баталсан "Монголын компанийн засаглал кодекс"-т нийцсэн эсэх;	(iii) Бусадтай байгуулсан худалдах, худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бусад гэрээ хэлцэл нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх;
(iv) Бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бусад гэрээ, хэлцэл нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх;	(iv) Сүүлийн 1 жилийн дотор хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг хуульд заасан журмын дагуу байгуулсан эсэх;
(v) Сүүлийн 3 жилийн дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх;	(v) Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг, газар эзэмших эрх нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх;
(vi) Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг, газар эзэмших эрх нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх;	(vi) Үнэт цаас, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх;
(vii) Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа	




2023.08.18



simple

Нууц



VI. ХАВСРАЛТ

БҮРТГЭЭ-02

Эх хувь

<p>үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх;</p> <p>(viii) Үнэт цаасыг бүртгүүлэх танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх;</p> <p>(ix) Үнэт цаас гаргагчийн толгой, охин, хараат, зэрэгцээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн үнэт цаас гаргагчийн хяналтыг хэрэгжүүлэгч, эцсийн өмчлөгч этгээдийг тодорхойлох;</p> <p>(x) Үнэт цаас гаргагч нь аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэг, иргэн захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байсан эсэх;</p> <p>(xi) Татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх.</p>	<p>(vii) Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хуулийн 6.13-т заасан хуулийн этгээдийн нэгдэлд хамаарч байгаа бол толгой, охин, хараат, зэргэлдээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн үнэт цаас гаргагч компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээд нь хэн болохыг тодорхойлох.</p>
-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

—ooOoo—




Handwritten signature



Handwritten signature

2023.08.18



Хавсралт №2

А талаас гаргаж өгөх материал, мэдээллийн жагсаалт

(Урьдчилсан байдлаар)

1. Төрийн эрх бүхий байгууллагаас лавлагаа авах:
(Лавлагаа авах байгууллагын жагсаалт, лавлагаа авах төслийг Хуулийн фирмээс гаргаж өгнө);
2. Тохиролцсон хугацаанд бусадтай бичгээр байгуулсан бүх гэрээ хэлцлийн жагсаалт, мэдээлэл, тэдгээрийн хуулбар Үүнд: (Хугацаа дуусаагүй хүчин төгөлдөр байгаа гэрээ, хэлцлийг ойлгож мэдээллээ өгнө үү);

Дараах баримт материалуудын хуулбарыг бэлтгэж өгнө үү. Үүнд:



3. Үнэт цаас гаргагчийн дүрэм;
4. Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээ;
5. Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл;
6. Өрийн бичиг гаргахтай холбоотой шийдвэр, тогтоолын хуулбар;
7. Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан;
8. Үнэт цаас гаргагчийн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалт;
9. Үнэт цаас гаргагчийн дотоод зохион байгуулалтын бүтцийн схем, түүнийг баталсан тогтоол, шийдвэрийн хуулбар;
10. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, Гүйцэтгэх захирал, Менежментийн баг, эрх бүхий албан тушаалтны мэдээлэл, анкет, тэдгээрийг баталсан, томилсон холбогдох тогтоол, Компанийн засаглалын сургалтад хамрагдсан гэрчилгээ;
11. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод, гишүүдийг томилсон тогтоол, шийдвэрийн хуулбар;
2.	3.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Хангасан	Заасан мэдээллийг тухай бүр нийтэд ил год тайлагнаж, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг тогтмол өөрийн цахим хуудсанд байршуулдаг.
3.	Санхүүгийн болон санхүүгийн бус тайланг ил тоо танилцуулж, хөндлөнгүй тодорхой бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болохгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтуудад хүсн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	Хангасан	Банк бус санхүүгийн байгууллагын тухай хууль, Компанийн тухай хууль болон зохицуулагч байгууллагаас батлан гаргасан холбогдох дүрэм журамд заасан мэдээллийг тухай бүр нийтэд ил тоо тайлагнаж, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг тогтмол өөрийн цахим хуудсанд байршуулдаг.
1.	4.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, журмын хэрэгжилтэд хяналт тавина.	Хангасан	Компанийн тухай хууль болон Аудитын тухай хууль, Компанийн дүрэмд тус тус заасны дагуу хөндлөнгийн аудитын байгууллага, аудитортой харилцахдаа дээрх хуулийг удирдлага болгож, хараат бус байдал алвилаа нөлөө үзүүлэхгүй, ажил үүргээ гүйцэтгэхэд нь саад учруулахгүй байх нөхцөлийг биелүүлж ажилладаг.
2.	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчийн эзэжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Хангасан	Компанийн тухай хууль болон компанийн тухай хуульд заасны дагуу жилийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитын байгууллагаар багалаажуулж, төвлөлийн үр дүнг ТУЗ-ийн дүгнэлтийг үндэслэн Хувьцаа эзэмшигчийн хуралд танилцуулж, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгөх боломжийг бүрдүүлж ажилладаг.
3.	4.3. Дотоод аудитын тогтолцоо түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар	Хангасан /бүрэн бус/	Дотоод аудитын нэгжийн бүтэц зохион байгуулалтыг гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар зохион байгуулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн удирдлага дор үйл ажиллагаагаа тайлагнаж ажиллаж байна.

	дамжуулан олон нийтэд мэдээлж, тэдгээрт орсон өөрчлөлийг тухай бүр мэдэгдэнэ.		
1.	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.	Хангасан	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 3 сарын 20-ны өдрийн бодлогын баримт бичиг батлах 02 дугаар тогтоолоор Эрсдэлийн удирдлагын бодлогыг баталсан ба эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгож, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдлыг тодорхойлж, тэдгээрт ТУЗ-аас хяналт тавих зохицуулалтыг тусгасан. Уг журмын хэрэгжилтэд ТУЗ хяналт тавьж ажилладаг.
2.	5.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ эрсдэлийн удирдлага харуулсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гуравас доошгүй гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.	Шийдвэрлэх шатандаа	Компанийн тухай хуульд заасны Төлөөлөн удирдах зөвлөл нь швардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно. Компани нь 2023 оны 5 сарын 12-ны өдөр итгэцлийн үйл ажиллагааны зөвшөөрлийг авч, улсын бүртгэлд 5 сарын 21-ний өдөр бүртгүүлсэн ба үүнтэй холбоотойгоор Компанийн засаглалын кодекст заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодыг бий болгох эсэх асуудлыг Эрх мэдэл хуваарилалтын журамд заасны дагуу дэд удирдагуудад шийдвэрлүүлэхээр бэлдэж байна.
3.	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгэмийн харууллага, эрүүд мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлсэн нийтэд мэдээлж, тэдгээрийн эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	Хангасан	Толгой компаниас Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн бодлогыг баталсан ба группын охин компаниуд өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан байгаль орчин, нийгэм, засаглалын бодлогыг мөрдлөг болгон ажиллаж байна.
4.	5.4. Компани нь комплаенсийн хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.	Хангасан	Бизнесийн үйл ажиллагаанд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам болон дотоод хяналтын хөтөлбөрийг хэрэгжүүлж ажилладаг. Комплаенсийн ажилтан нь Гүйцэтгэх захирлын шууд удирдлага дор ажиллаж байгаа ба өөрийн үйл ажиллагааны тайланг Гүйцэтгэх удирдлага болон Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж ажиллаж байна.



1	6.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	Хангасан	Хувьцаа эзэмшигчийн хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин хөлс, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг нээлттэй хэлэлцэж тухай бүр баталдаг.
2	6.2. Компанийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримт бичигт тусгана.	Хангасан	Толгой компаниас баталсан Цалин хөдсний журмыг охин компаниуд өөрийн үйл ажиллагаандаа мөрддөг болгон ажилладаг ба уг журамд цалин хөлс, урамшуулал олгох хэмжээг тогтоох үндэслэл, ажил үүргийн бүрдэл хэсэг, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг тусгасан.
3	6.3. Компанийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын шилин, шагнал, бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	Хангасан	Компанийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ тусгагддаг ба түүний цалин хөлс, шагнал болон бусад урамшуулал нь хүний хувийн нууцал хамарах тул жилийн үйл ажиллагааны тайланд тусгайлан тусгагддаггүй.
1.	7.1. Компани нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүднэ.	Хангасан	Толгой компаниас баталсан Худалдан авалт, Тендер шалгаруулалтын журам, Ашиг сонирхлын зөрчлийг мэдүүлэх журмыг охин компаниуд үйл ажиллагаандаа мөрддөг болгон ажилладаг. Эдгээр журмуудад харилцагч, бэлтгэн нийлүүлэгч болон охин компани болон ажилтнуудын хооронд үүсч болзошгүй ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бизнесийн харилцаанд талуудын эрх ашгийг хүндэтгэн, бизнесийн нэр хүн, алдар хүндийг хамгаалж, харилцан ашигтай хамтран ажиллах талаар зохицуулсан байна.
2.	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	Хангасан	Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг www.supplier.mcs.mn цахим хуудсанд байршуулж, нээлттэй зарладаг.
3.	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	Хангасан	Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.
4.	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Хангасан	Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх хүрээнд Гүйцэтгэх захирлын 2020 оны 055/А/20, 013/А/20 дугаар тушаалаар батлагдсан Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх журам болон Гомдол, талархлыг хүлээн авах, шийдвэрлэх журамд тус тус завсны дагуу уг санал, хүсэлт, гомдлыг түргэн

УЛААНБААТАР ХОТ
АШИГД КАПИТАЛ
БВЭС ХХК

МАНДАЛ КАПИТАЛ
MARKETS SC
LLC 215
УТМН 162 9021070414 5213487

2023.08.18



			шуурхай шийдвэрлэж ажилладаг. Ажилны нийгмийн асуудал болон мэргэжил дээшлүүлэхтэй холбоотой харилцааг Хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулж байна.
1	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг өнөөцтэй готорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөл нь ёс зүйн дүрмийг батлан нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Хангасан	Толгой компаниас баталсан Ёс зүйн дүрмийг охин компаниуд нь үйл ажиллагаандаа мөрддөг болгон ажилладаг ба ёс зүйн дүрмийг үндсэн болон гэрээт ажилтнууд, бэлтгэн нийлүүлэгчдийн харилцаанд дагаж мөрддөг. Гүйцэтгэх удирдлагын дэргэд Ёс зүйн хороо ажилладаг.
2	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх шүтэл үлээгчийн тогтолцоотой байна.	Хангасан	Аливаа хууль ёс үйлдэл болон ёс зүйн зөрчлийг толгой компаниас баталсан Ёс зүйн дүрэм болон Гүйцэтгэх захирлын 2020 оны 055/А/22 дугаар тушаалаар батлагдсан Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх журамд заасны дагуу Гүйцэтгэх удирдлагын дэргэдэх ёс зүйн хороонд шүтэл үлээх сувгаар дамжуулан, харавт бусаар шийдвэрлүүлэх тогтолцоог нэвтрүүлэн ажилладаг.
3	8.3. Ёс зүйн дүрмээр авилга албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих /дэмжихгүй байх/ хандив өргөх/өргөхгүй байх/ талаар зохицуулна.	Хангасан	Толгой компаниас баталсан Ёс зүйн дүрмийн 7, 8 дугаар зүйлд Авилга, хээл хахуулиас ангид байж, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх, Компанийн хувьд улс төрийн аливаа үйл ажиллагаанаас ангид байж, Монгол Улсын хууль тогтоомжоос гадуур аль нэг улс төрч, улс төрийн хүчинд хандив өргөхийг тус тус хориглосон.
1.	9.1. Компани хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр хүргэнэ.	Хангасан	Компанийн тухай хууль, Банк бус санхүүгийн байгууллагын тухай хууль болон Компанийн дүрэмд зааснаар хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад үйл ажиллагааны болон санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалтын талаарх мэдээллийг тухай бүр цахим хуудсаараа дамжуулан мэдээлдэг.



2.	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	Хангасан	Толгой компаниас баталсан Эрх мэдэл хуваарилалтын журам болон Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журамд заасны дагуу хөрөнгө оруулагчдад өөрийн цахим хуудсаар дамжуулан мэдээлэл солилцдог.
3.	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо ноцгойгоо бүрдүүлнэ.	Хангасан	Толгой компаниас баталсан Эрх мэдэл хуваарилалтын журам, Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журам, Компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд тус тус заасны дагуу хувьцаа эзэмшигчийн хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэн ажилладаг.
4.	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарах	Хангасан	Компани нь ганц хувьцаа эзэмшигчтэй бөгөөд толгой компаниас баталсан Эрх мэдэл хуваарилалтын журам, Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журам болон Компанийн дүрэмд уг асуудлыг нарийвчлан тусгасан.
5.	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зорчигдохөөс сэргийлэх зорилгоор сонирхлыг зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба түүнийг хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Хангасан	Компани нь сонирхлын зөрчилтэй хэлцлийг Компанийн тухай хуульд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцж шийдвэрлэх журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг.

ТАЙЛАН БАТАЛГААЖУУСАН:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ






Т.БАТЖАРГАЛ

Ашиг Капитал ББСБ ХХК-ийн Компанийн засаглалын үйл ажиллагааны тайвныгын Ашигласан ББСБ ХХК

1. Ашиг Капитал ББСБ ХХК-ийн толгой компани нь дор дурдсан журам, бодлогын баримт бичгүүдийг баталж, мөрдүүлэх замаар нийт групп компанийн хэмжээнд зохицтой засаглалыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

№	Бодлогын баримт бичиг /Бодлого, журам/	Тайлбар	Баталсан огноо, дугаар	Хэрэгжилтэй төмөр хяналт (тайлбар)	Компанийн үйл ажиллагаанд төмөр хяналтын төлөвлөгөө		
					Бүтэц	Хэрэгжилтэд хяналт төмөр лтгээнийг гомчилсон эрх бүхий этгээл	Ажил үүрэг
1	Эрх мэдэл хуваарилалтын журам	Уг журам нь шийдвэр хөрөнгө оруулагчид үйл ажиллагааны шаардлыг гомчилсон болон тооцоглохгүй зарцуулалт, санхүүгийн үр ашгаар бүхий гэрээ хэлцэл, ашиг гүйцэтгэх хариуцагчтай удирдлага, үр ашгатай шийдвэрээр хангаж чиглээсн группийн толгой болон охин компаниудад мэдээлэх балимг бичиг юм.	2013.06.21, №036	М-Сн-Эс Холдинг ХХК болон компанийн Гүйцэтгэх захирлууд хэрэгжилтэй хяналт тавина.	I Хувьцаа эзэмшигчдийн хурал II Захируулын товчоон III М-Сн-Эс Холдинг ХХК-ийн гүйцэтгэх захирал IV Охин компанийн Захируулын товчоол V Охин компанийн гүйцэтгэх захирал	М-Сн-Эс Холдинг ХХК-ийн Товчоолон удирдах зөвлөл	Стратегийн шийдвэр гаргах Хөрөнгө оруулалтын зардал зарцуулах Үйл ажиллагааны зардал зарцуулах Хуудсанд авалт хийж бусад үйл ажиллагаа
2	Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журам	Уг журам нь М-Сн-Эс Группийн харил компанийн хууль эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэр гаргах, ХХК-ийн зар мэдээллийн хууль эзэмшигчдэд хургал, хурал хуралдуулах, шийдвэрийг баталгаажуулахтай холбоотой харилцааг зохицуулна.	2022.12.02, №013	М-Сн-Эс Холдинг ХХК-ийн Хууль, нийтийн шийдвэр болон охин компаниудын Гүйцэтгэх удирдлуудын журмын хэрэгжилтэй хяналт тавина.	М-Сн-Эс Группийн харил компаниудын хууль эзэмшигчдийн хуралд зардал зарцуулах эрх бүхий этгээл нь Компанийн тухай хууль болон эрхлүү журамд заасны зотор хууль эзэмшигчдийн хуралд зардал зарцуулах.	М-Сн-Эс Мөнгөлөг ХХК-ийн Товчоолон удирдах зөвлөл	Компанийн тухай хууль, компанийн дүрэм болон Эрх мэдэл хуваарилалтын журам, хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхлээг хангаж асуудлыг хэлэлцж шийдвэрийг.
3	Захируулын товчоол (Төлөөлөн удирдах зөвлөл) ийн үйл ажиллагааны журам	Уг журам нь Төлөөлөн удирдах зөвлөлийн үндсэн чиг үүрэг, бүрэн эрх, гишүүдийн чиг үүрэг, хурлын зар мургал, хуралд оролцох, гишүүдийг мэдээлэх хяналт, зурвалз шийдвэр гаргах, үйл ажиллагааны журмын хэрэгжилтэй бусад харилцааг зохицуулна.	2021.01.01, №02	М-Сн-Эс Холдинг ХХК-ийн Гүйцэтгэх захирал журмын хэрэгжилтэд хяналт тавина.	Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн охин болон харилт компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Охин компаниудын Гүйцэтгэх захирлууд оюрсдын Төлөөлөн удирдах зөвлөлөөр журмын	М-Сн-Эс Холдинг ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл	Компанийн тухай хуульд заасны болон Компанийн дүрмээр тогтоосон бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.





4	Дотоод аудитын бодлого	Энэхүү бодлогын баримт бичгийн зорилго нь М-Си-Эс Группийн зор дурдсан нэгж, ажлагуудыг илгэсэн бодлого, арга зүй, гарын авлагад хангахад оршино. Үүнд: 1. Дотоод аудитын алба 2. Дотоод аудитор 3. Компанийн удирдлага	2018.06.05, №09	М-Си-Эс Холдинн ХХК-ийн Төлөөлөн удирдах ажлынхон дэргэдэх Аудит ба эрсдэлийн удирдлын хороо журмын хэрэгжилтэд хяналт тавина.	Дотоод аудитын алба, Дотоод аудитор, Компанийн удирдлага хяналтыг хэрэгжүүлнэ.	М-Си-Эс Холдинн ХХК-ийн Төлөөлөн удирдах мөхөөл	Аудитын хороо нь санхүүгийн тайлбар, дотоод хяналтын тусламж, аудитын үйл ажиллагаа болон компанийн үйл ажиллагаа нь хууль, дүрэм, журмын бичиг баримт бичиг, эрсдэл зөвлөхөөр хяналт, эс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавина. Дотоод Төлөөлөн удирдах мөхөөл эрсдэлийн үүрэг үүрэгтэй.
5	Компани гоорондын шинг сонирхлын зорилгыг тогтоогуулах журам	М-Си-Эс Группийн харьяа компаниудын бизнесийн үйл ажиллагаатай холбоотойгоор тэдгээрийн хооронд шинг сонирхлын зорилгыг үзсэн төлөвлөгөөнд агуулах, шуударга, тэнцвэртэй, хяналт буцаар шийдвэрлэх эс зүйн хэм хэмжээг тус тусын хөшүүгчдэд мэдэгдэх журмын зорилго оршино.	2017.12.29, №А/21	М-Си-Эс Холдинн ХХК-ийн Захираа хүний нөөцийн газар болон М-Си-Эс Холдинн ХХК-ийн Эс зүйн хороо журмын хэрэгжилтэд хяналт тавина.	М-Си-Эс Холдинн ХХК-ийн Эс зүйн хороо журмын хэрэгжилтэд хяналт тавина. М-Си-Эс Холдинн ХХК-ийн Төлөөлөн удирдах мөхөөл тавина.	М-Си-Эс Холдинн ХХК-ийн Гүйцэтгэх захирал	М-Си-Эс Группийн компаниуд нь бизнесийн зорилго хэрэгжүүлэх журмын талаар шинг сонирхлын зорилго агуулах, шуударга оролдлын дүрмийг агуулах.
6	Нийцлийн багц журам	Энэхүү багц журмын зорилго нь М-Си-Эс Группийн үйл ажиллагаатай холбоотойгоор хэрэгжилтэд хяналт тавина. Энэхүү хэмжээнд нийцлийн удирдлын тусламж болон нийцлийн хяналт, соёлыг бүрдүүлэх, төлөвшүүлэх, амтга, мөнгө угаах эрсдэлийг урьдчилан сэргийлэх, М-Си-Эс Группийн компаниудын удирдлага болон шийт ажлагуудын эн талаарх мэдээг мэдээллийн дүрмийг хариуцаагч нэмэгдүүлэх, улс төрийн хандан өгөх харилцааг хуульд хяналт тавина. Дотоод хяналт тавина. Хяналт тавина. Хяналт тавина.	2021.12.08, №011	М-Си-Эс Холдинн ХХК-ийн Хууль, нийцлийн алба болон М-Си-Эс Группийн компаниудын Гүйцэтгэх удирдлагууд журмын хэрэгжилтэд хяналт тавина.	М-Си-Эс Группийн компаниуд нь Нийцлийн багц журмын хэрэгжүүлэх төлөвлөгөөнд нийцүүлэн хариуцаагч зөвлөхөөр журмын багц мэдээлэл, нийцлийн чиг үүргийг хариуцаагч эсгэж, амтгагч төлөөлөн ажиллуулна. Нийцлийн чиг үүргийг хариуцаагч эсгэж, амтгагч нь компанийн үйл ажиллагаанд нийцлийн багцтай хяналтын тавина.	М-Си-Эс Монголиа ХХК-ийн Гүйцэтгэх удирдах мөхөөл	М-Си-Эс Группийн компаниуд нь Гүйцэтгэх удирдлын багц журмын зорилго хэрэгжүүлэх, нийцлийн чиг үүргийг хариуцаагч эсгэж, амтгагч нь компанийн үйл ажиллагаанд нийцлийн багцтай хяналтын тавина.




2. Ашиг Капитал ББСБ ХХК-ийн толгой компани нь дор дурдсан журам, боллогын баримт бичгүүдийг батгалж, мөрдүүлэх замвор нийт групп компанийн хэмжээнд хоорондын гэрээ гүйцэтгэл харанг бус байдалаар хийгдэх нөхцөлийг хангадаг.

№	Боловсон баримт бичиг /Бошгоо, журам/	Тайлбар	Батлагын огноо, дугаар	Хэрэглэгд тавих амнагт
1	Эрх зүйн баримт бичгийн журам	Энэхүү журмын зорилго нь "М-Си-Эс Холдинг" ХХК болон түүний охин компани эрх зүйн баримт бичгийн тогтол боловсруулахад баримтлах нилсэн стандартыг бий болгох, хянах, батлах, хэрэгжүүлэхэд оршино.	2015.06.24, №090	М-Си-Эс Холдинг ХХК болон түүний охин компанийн Гүйцэтгэх захирлууд
2	Гэрээний журам (шингичлсэн)	Энэхүү журмын зорилго нь М-Си-Эс Группийн харьяа компанийн иргэн, хуулийн этгээд, торийн байгууллаагай байгуулах гэрээний хэмжигэр хийх, төслийг боловсруулах, хянах, гэрээг байгуулах, бүртгэх, чадалгах, гэрээний хэрэгжилтийг хянах дүнхэл болон хэлбэлгээг бусад хариуцааг зохицуулахад оршино.	2023.01.23, № А/03	М-Си-Эс Холдинг ХХК-ийн Хууль, нийцлийн алба болон М-Си-Эс Группийн компанийн Гүйцэтгэх удирдагчууд
3	Худалдан авалтын журам (шингичлсэн)	Энэхүү журамд М-Си-Эс Группийн харьяа компанийн бараа, ашиг, үйлчилгээг худалдан авах үйл ажиллагаанд баримтлах гол зарчмуудыг зингээсөн ба нийлүүлэгч болон компанийн ажиглагч нь ашиг сонирхлын зорчлоос өнхд байх, компанийн ажиглагч нийлүүлэгчтэй аливаа төрлийн үнэ бүхий зүйл, шинэ харамж авсан, шаварсан бол харуулаша хэрэгжээгээр авсан. Мөн түүнчлэн, энхүү журмаар худалдан авалтын үйл ажиллагаанд хэрэгжээгээр шууд худалдан авалт, харуулагч, тендер шинэ оруулагч, тусгай нөхцөл гэсэн 4 аргыг тодорхойлсон ба тус бүрээр нь тайлбарлаж, хэрэглэх үндэслэлийг тодорхойлсон. Эгээр аргыг шингичлэн нийлүүлэгчийг сонгох шааргуулсны дараа гэрээ байгуулахаар зохицуулаш.	2022.03.15, № А/07	М-Си-Эс Холдинг ХХК-ийн Худалдан авалтын нэгж
4	Тендер шааруулалтын журам (шингичлсэн)	Энхүү журмаар худалдан авалтын нэг арга болох тендер шааруулалтын үйл ажиллагаанд харьяагийн зохицуулаш. Тендер шааргуулаш үйл ажиллагаа түйэтгэх захирлаас томилогч тендерийн хороо хэрэгжүүлэх ба тус хороо нь тендер шааруулалттай холбогдох, мэдээ, мэдээлэл, баримт бичгийн нууцлалыг хянаж, ашиг сонирхлын зорчлод болон ажил хэм хатуулаш өнхд байх, харанг бусад ажиглах үүрэг хүтээсэн. Харьяагийн нэгдсэн үнэгжээгээр хамгийн өндөр өнх авсан оролцогчийг шааргуулаж гэрээ байгуулахаар тус журамд авсан болно.	2022.03.15, № А/07	М-Си-Эс Холдинг ХХК-ийн Худалдан авалтын нэгж
5	Ашиг сонирхлын зорчлоог мэдүүлэх журам (шингичлсэн)	Энхүү журам нь М-Си-Эс Группийн бизнесийн үйл ажиллагаанд сөөргөөр нөлөөлж болзошгүй компани болон ажигчтын хооронд үүсч болох аливаа ашиг сонирхлын зорчлоог урьдчилэн сэргийлэх, хянах зохистой шийдвэрлэх зорилготой. Эсэхүү журмаар компанийн эрх бүхий албаг тушаалагч, ажиглагч нь болзошгүй ашиг сонирхлын зорчлоог гөлөөр компанид мэдүүлэх, компаниг шааруулаш гавьсны дгуу тухайн зорчлоог өрхлөх үүрэг хүтээсэн.	2021.03.05, № А/04	М-Си-Эс Группийн харьяа компанийн Гүйцэтгэх захирал болон хуульч нөгөөний нөгж



2023.08.18



6.31 АУДИТЫН КОМПАНИЙН СЭХ-НД ГАРГАСАН ТОДОРХОЙЛОХ ЗАХИДАЛ



ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК-Д

МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК
Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
25-р хороо, Манлай Бөхтөр Дамдинсүрэнгийн
гудамж, UB tower, 15 давхар, 1502 тоот.
Утас: 7013-1044 И-мэйл: info@magicgroup.mn
Вэб хуудас: www.magicgroup.mn
2023.08.16 дугаар 43-04/06/29
Танай _____-ны дугаар _____-т

Тодорхойлох захидал

Бид "Ашид Капитал ББСБ" ХХК-ийн 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болсон санхүүгийн тайланд аудит хийсэн бөгөөд тус компанийн зүгээс нээлттэй бонд-ll гаргахтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороо (СЭХ)-нд бүртгүүлэхээр хүргүүлж буй үнэт цаасны танилцуулга, уг танилцуулгад багтсан нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн мэдээлэл нь аудитлагдсан санхүүгийн тайлангийн мэдээлэлтэй тохирч байгаа эсэхийг Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 06 дугаар сарын 11-ний 225 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын дагуу хяналт хийлээ.

Бидний гүйцэтгэсэн аудитлагдсан санхүүгийн тайлан нь СЭХ-нд хүргүүлэх материалд багтсан ба Үнэт цаасны танилцуулгад багтсан дараах санхүүгийн болон нягтлан бодох бүртгэлийн мэдээллийг бид хянасан. Үүнд:

- A. Үнэт цаасны танилцуулгын 1.3.1 болон 1.3.2 Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлантай холбоотой мэдээллүүд ба иж бүрэн аудитлагдсан санхүүгийн тайлангаас бэлтгэгдсэн Хураангуй санхүүгийн тайлан, шинжилгээ
B. Үнэт цаасны танилцуулгын 1.3.3 Үнэт цаас гаргагчийн санхүүгийн мэдээлэл дээр үндэслэн тооцсон харьцааны шинжилгээнүүд болон зохистой харьцааны үзүүлэлтүүд
B. Үнэт цаасны танилцуулгын 1.4.2 Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар мэдээлэл


Энэхүү захидалтай холбогдуулж дараах зүйлсийг мэдэгдэж байна. Үүнд:

- 1. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын Аудитын тухай хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагуудын дагуу тус компаниас хараат бус, ашиг сонирхлын зөрчилгүй бөгөөд хууль болон холбогдох ёс зүйн шаардлагуудын дагуу үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн.
2. Бид үнэт цаас гаргагч "Ашид Капитал ББСБ" ХХК-тай аливаа сонирхлын зөрчилгүй бөгөөд үүсэж болзошгүй сонирхлын зөрчлөөс сэргийлэх арга хэмжээг тухай бүрд нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу авч хэрэгжүүлнэ.
3. "Мэжик консалтинг Аудит" ХХК нь тус компанийн 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөрх санхүүгийн тайланд аудитыг хийж гүйцэтгэсэн ба Үнэт цаасны танилцуулгын хавсралтад харуулсан аудитлагдсан санхүүгийн тайлан нь материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д нийцсэн гэж дүгнэсэн.
4. Үнэт цаасны танилцуулгын 1.3.1 болон 1.3.2-т Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагааны талаар дурдсан санхүүгийн тайлантай холбоотой түүхэн мэдээллүүд болон Хураангуй санхүүгийн тайлан нь аудитлагдсан санхүүгийн тайлангийн дүнтэй тохирч байна. Бид эдгээр мэдээллүүдийг шалгахад дараах горимуудыг гүйцэтгэсэн. Үүнд:
- Үнэт цаасны танилцуулгад дурдсан үйл ажиллагаатай холбоотой түүхэн мэдээллүүдийг аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын хүрээнд цуглуулсан нотлох баримтуудтай тулган шалгасан.
- Уг түүхэн мэдээллийг боловсруулсан дата мэдээллийг нягталсан.



2023.08.18

2023-08-18



5. Үнэт цаасны танилцуулгын 1.3.3-т Үнэт цаас гаргагчийн санхүүгийн мэдээлэл дээр үндэслэн тооцсон харьцааны шинжилгээнүүд болон зохистой харьцааны үзүүлэлтийг харуулсан. Харьцааны болон санхүүгийн зохистой харьцааны үзүүлэлтүүдийг үнэн зөв тооцсон байна. Бид дараах горимуудыг гүйцэтгэсэн. Үүнд:
 - Аудитлагдсан санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд дээр үндэслэн тооцоолсон харьцааны шинжилгээ, үнэт цаас гаргагчийн санхүүгийн тогтвортой байдал, санхүүгийн зохистой харьцааны үзүүлэлтүүдийг давтан тооцоолсон.
6. Үнэт цаасны танилцуулгын 1.4.2-т Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар дурдсан ба 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл байгуулсан хэлцлүүдийг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд шалгаж, Компанийн тухай хуульд заасан шаардлагуудтай нийцсэн гэж дүгнэсэн.
7. Үнэт цаасны бүртгэлийн журмаар шаардсан бусад асуудал Бид 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болсон санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналтын тогтолцоо нь СТОУС-д нийцэж буй эсэх талаар тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим сорил гүйцэтгэсэн. Дотоод хяналтыг шалгах аудитын горимын үр дүнд компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналтын тогтолцоо нь СТОУС-д нийцсэн, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, түүний үр ашигтай байдлыг хангаж байна гэж дүгнэсэн. Үүнтэй холбоотой дараах горимуудыг гүйцэтгэсэн. Үүнд:
 - Компанийн санхүүгийн тайлангийн дотоод хяналт, үүнд хяналтын орчин, эрсдэлийн үнэлгээ, хяналтын үйл ажиллагаа, мэдээлэл болон харилцаа, мониторинг зэргийн талаар ойлголт олж авсан ба эдгээр хяналтуудын талаар даган мөшгөх сорил гүйцэтгэсэн.
8. Гүйцэтгэсэн аудитын горимуудтай холбоотой хязгаарлалтууд
 - Үнэт цаасны танилцуулгыг хянаж, аудитын горимууд нь зөвхөн санхүүгийн түүхэн мэдээллийг хамарсан ба дунд хугацааны бодлого, стратеги төлөвлөгөө болон санхүүгийн хэтийн төсөөллийг хамраагүй болно.
 - Бид 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс хойших дараа үеийн санхүүгийн тайланд аудит хийгээгүй учир уг өдрөөс хойш энэхүү захидал гарах хүртэлх завсар үеийн санхүүгийн мэдээллийг аудитлаагүй болно.
 - Дээр дурдсан горимууд нь хууль тогтоомж болон СЗХ-ны дүрэм журмын шаардлагын хүрээнд хийгдсэн ба эдгээр горимуудаар бид үнэт цаасны танилцуулгатай холбоотой бүх асуудлуудыг илрүүлэх шаардлагагүй бөгөөд танилцуулгад орсон бүх мэдээллүүд нь үнэн зөв эсэхэд ямар нэг баталгаа өгөхгүй.
 - Эдгээр горимын үр дүнд бидний анхааралд өртсөн зөрүүтэй илэрхийлэл илрээгүй боловч үнэт цаасны танилцуулгад дурдсан хяналт хийгдээгүй, бусад мэдээллүүд нь бидний хяналт хийсэн санхүүгийн мэдээлэл болон холбогдох дүрэм, журамд нийцэж байгаа гэдэгт итгэж байна.
 - Энэхүү тайланг зөвхөн үнэт цаас гаргахтай холбоотой андеррайтерийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх зорилгоор бэлтгэсэн бөгөөд өөр бусад зорилгоор бэлтгээгүй болно.



С.МӨНХБАЯР
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, ПАРТНЕР,



2023.08.18

6.32 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН 2020 ОНЫ АУДИТЫН ТАЙЛАН

Ашид Капитал ББСБ ХХК


АШИД КАПИТАЛ ББСБ ХХК
Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын
дагуу бэлтгэгдсэн Санхүүгийн Тайлан болон
Хараат бус Аудиторын Тайлан
2020 оны 12 дугаар сарын 31



Handwritten signature



2023.08.18



Ашид Капитал ББСБ ХХК

АГУУЛГА

Хараат бус Аудиторын Тайлан

Санхүүгийн Тайлан

2020 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн

Санхүүгийн Байдлын Тайлан.....	1
Орлого Үр Дүн болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан.....	2
Өмчийн Өөрчлөлтийн Тайлан.....	3
Мөнгөн Гүйлгээний Тайлан.....	4

1. Компанийн танилцуулга.....	6
2. Компанийн үйл ажиллагааны орчин.....	6
3. Тайлан бэлтгэх үндэслэл.....	7
4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого.....	7
5. Нягтлан бодох бүртгэлийн тооцоолууд болон Хэмжилтийн суурь.....	27
6. Шинэ болон өөрчлөгдсөн стандарт болон тайлбаруудын хэрэгжилт.....	28
7. Нягтлан бодох бүртгэлийн шинэ мэдэгдлүүд.....	29
8. Үндсэн хөрөнгө.....	33
9. Биет бус хөрөнгө.....	34
10. Түрээс.....	35
11. Харилцагчид олгосон зээл ба урьдчилгаа.....	36
12. Худалдааны болон бусад авлага.....	37
13. Урьдчилж төлсөн төлбөр ба урьдчилгаа.....	38
14. Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө.....	39
15. Худалдааны ба бусад өглөг.....	39
16. Хувь нийлүүлсэн хөрөнгө.....	40
17. Хүү ба түүнтэй адилтгах орлого.....	40
18. Зардал, төрлөөр.....	41
19. Үйл ажиллагааны бусад орлого (зардал).....	41
20. Орлогын албан татвар.....	42
21. Санхүүгийн хэрэглүүр – Санхүүгийн эрсдэлийн удирдлага.....	43
22. Санхүүгийн хэрэглүүр – Бодит үнэ цэнэ.....	49
23. Хөрөнгийн удирдлага.....	50
24. Болзошгүй өр төлбөр ба үүрэг хариуцлага.....	50
25. Хамаатай талуудын ажил гүйлгээ.....	52
26. Тайлант хугацааны дараах үйл явдлууд.....	53
27. Орчуулга.....	53



2023.08.18



“АШИД КАПИТАЛ ББСБ” ХХК-ийн
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

“ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ” ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
6 дугаар хороо, Метро бизнес оффис,
6 дугаар давхар 603 тоот

Утас: 70150001, 80110088

Цахим шуудан: www.shonkhor.mn

И-мэйл: shonkhor.mn@gmail.com

2023.08.02 № 21/37
төний _____ ны № _____ -т

АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

“Ашид капитал ББСБ” ХХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон бусад тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр “Ашид капитал ББСБ” ХХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид СТОУС гэх)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид АОУС гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү дүгнэлтийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид МНБЕЗ-н дүрэм гэх)-ийн дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байж ёс зүйн үүрэг хариуцлагаа биелүүлж ажилласан.

Аудитаар санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, тэдгээрийн нэмэлт тодруулгыг нотлох аудитын нотолгоог түүвэр шалгалтын арга ашиглан магадлав.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай, зохистой үндэслэл болж чадсан гэдэгт бид итгэлтэй байна.



Handwritten signature

Handwritten signature

2023.08.18

Хараат бус аудитын дүгнэлтийн үргэлжлэл

Удирдлага ба Засаглах удирдлагын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа, санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулахын тулд дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд Удирдлага компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг баримтлан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг, хариуцлага

Бидний зорилго нь санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв бөгөөд шударгаар толилуулагдсан эсэх талаар боломжит үндэслэлтэй баталгааг олж авах, түүнчлэн аудиторын дүгнэлтэнд тусгах явдал юм.

Бидний олж авсан үндэслэлтэй нотолгоо нь энэхүү гаргасан дүгнэлтэд өндөр баталгаатай үндэслэл болж чадна гэдэгт итгэлтэй байгаа ч, АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байж болзошгүй бүхий залилан ба алдааг бүрэн илэрхийлдэг гэсэн баталгаа биш юм.

Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг. АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажигладаг.

Бусад

Энэхүү дүгнэлтийг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан бэлтгэсэн ба дүгнэлтийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

(Энэхүү дүгнэлт нь Хавсралтын хамт хүчин төгөлдөр болно.)

ЗАХИРАЛ


Д.ШИЙРЭВ



"АШИД КАПИТАЛ БЭСБ" ХХК

2020 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ АУДИТЛАГДСАН САМХУУГИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	2019-12-31	2020-12-31
<i>/төгрөгөөр/</i>		
А. Үлдэгдлийн тэнцэл		
Мөнгө түүнтэй амтгах хөрөнгө	50,000.0	31,095,263,173.1
Эзэл /Цэвэрээр/	-	6,393,364,243.8
Бусад авлага	-	142,795,085.2
Бусад хөрөнгө	-	246,409,861.9
Эргэлтийн хөрөнгийн дүн	50,000.0	37,877,832,364.1
Үндсэн хөрөнгө /цэвэр/	-	119,819,766.8
Биег бус хөрөнгө /цэвэр/	-	618,720,629.1
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	738,540,395.9
Нийт хөрөнгийн дүн	50,000.0	38,616,372,760.0
Цалингийн өглөг	-	83,015,260.0
ЭМД, НДШ-ийн өглөг	-	1,073,808.5
ХХОАТ-ын өглөг	-	966,311.6
ОАТ-ын өглөг	-	7,844,467.8
Бусад	-	406,167,530.3
Богино зугаават ор төлбөрийн дүн	-	499,067,378.1
Нийт ор төлбөрийн дүн	-	499,067,378.1
Энгийн хувьцаа	50,000.0	40,000,000,000.0
Хувьцаат капиталын дүн	50,000.0	40,000,000,000.0
Хуримтлагдсан ашиг /алдагдал	0.0	(1,882,694,618.1)
Тайлант үеийн ашиг/алдагдал	-	(1,882,694,618.1)
Өмнөх үеийн ашиг/алдагдал	-	-
Эзэмшигчийн өмчийн дүн	50,000.0	38,117,305,381.9
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	50,000.0	38,616,372,760.0
Б. Орлогын тайлан		
Хүүгийн орлого	-	482,829,843.0
Хүүгийн зардал	-	-
Цэвэр хүүгийн орлого	-	482,829,843.0
Хүүгийн бус орлого	-	309,998,249.9
Хүүгийн бус зардал	-	2,703,582,050.3
Болзоогүй эрсдэлийн сан байгуулахаас өмнөх үйл ажиллагааны ашиг/алдагдал	0.0	(1,910,753,937.4)
Болзоогүй эрсдэлийн сан	-	105,785,250.8
Нийт ашиг алдагдал	0.0	(2,016,539,208.2)
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	-	1,482,291.2
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	-	58,234,567.6
Ердийн үйл ажиллагааны ашиг/алдагдал	0.0	(2,073,291,484.6)
Орлогын татварын зардал	-	190,596,866.5
Цэвэр ашиг/алдагдал	0.0	(1,882,694,618.1)
В. Өмчийн өөрчлөлтийн тайлан		
Өмч	50,000.0	40,000,000,000.0
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	0.0	(1,882,694,618.1)
Эцсийн үлдэгдэл	50,000.0	38,117,305,381.9
Г. Мөнгөн гүйлгээний тайлан		
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.0	(8,916,092,696.9)
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	0.0	4,505,460,192.0
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зардал	0.0	13,421,552,888.9
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого	0.0	40,011,305,870.0
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зардал	0.0	0.0
Бүт цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	31,095,213,173.1
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	50,000.0
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	50,000.0	31,095,263,173.1

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН

"ШОНХОР ҮНЭЛГЭЭ АШИД ХХК-НИЙ
ЗАХИРАЛ *[Signature]*

Д. ШИЙРЭВ



Ашид Капитал ББСБ ХХК

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ


“Ашид Капитал ББСБ” ХХК /цаашид “Компани” гэх/-ийн Гүйцэтгэх захирал Б.Тэмүүлэн, НББ-ийн менежер Н.Эрдэнэтунгалаг нар өөрсдийн үнэлэлт, дүгнэлтээр 1-53 дугаар хуудсанд буй санхүүгийн тайлан нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх компанийн санхүүгийн байдал, мөн тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын /СТОУС/ дагуу бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн болохыг үүгээр мэдэгдэж байна.



Н.ЭРДЭНЭТУНГАЛАГ
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН
МЕНЕЖЕР



2023.08.18



Ашид Капитал ББСБ ХХК
2020 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Санхүүгийн Байдлын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ХӨРӨНГӨ			
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ			
Үндсэн хөрөнгө	8	7,613	-
Биет бус хөрөнгө	9	618,721	-
Ашиглах эрхтэй хөрөнгө	10	112,206	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	20	205,091	-
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН		943,631	-
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ			
Бараа материал		3,832	-
Харилцагчид олгосон зээл ба урьдчилгаа	11	6,393,364	-
Худалдааны болон бусад авлага	12	142,795	-
Урьдчилж төлсөн төлбөр ба урьдчилгаа	13	37,487	-
Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө	14	31,095,263	50
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН		37,672,741	50
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		38,616,372	50
ЭЗДИЙН ӨМЧ			
Хувь нийлүүлсэн хөрөнгө	16	40,000,000	50
Хуримтлагдсан алдагдал		(1,882,695)	-
ЭЗДИЙН ӨМЧ		38,117,305	50
ӨР ТӨЛБӨР			
Санхүүгийн түрээсийн өглөг	10	48,254	-
Урт хугацаат өр төлбөрийн нийт дүн		48,254	-
Худалдааны болон бусад өглөг	15	377,422	-
Санхүүгийн түрээсийн өглөг	10	65,547	-
Орлогын татварын өглөг		7,844	-
Богино хугацаат өр төлбөрийн нийт дүн		450,813	-
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН		499,067	-
ЭЗДИЙН ӨМЧ, ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		38,616,372	50

2021 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хэвлэн, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нэрийн өмнөөс гарын үсэг зурахыг зөвшөөрөв.



Н.Эрдэнэтунгалаг

Нягтлан бодох бүртгэлийн менежер

Хуудас 6-53 хийгдсэн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.



Ашид Капитал ББСБ ХХК
2020 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Орлого Үр Дүн болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан


Мянган төгрөгөөр	Тодруулга	2020 он	2019 он
Хүү болон түүнтэй адилтгах орлого	17	483,170	-
Хүүгийн зардал		(6,419)	-
Цэвэр хүү болон түүнтэй адилтгах орлого		476,751	-
Зээлийн болзошгүй эрсдэлийн нөөцийн зардал	11	(105,785)	-
Үйл ажиллагааны цэвэр орлого		370,966	-
Удирдлага, захиргааны зардал	18	(2,705,919)	-
Үйл ажиллагааны бусад орлого (зардал)	19	261,662	-
Татварын өмнөх алдагдал		2,073,291	-
Орлогын албан татварын зардал	20	190,596	-
Тайлант хугацааны цэвэр алдагдал		(1,882,695)	-
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-
Орлого, үр дүн рүү ангилагдсан эсвэл ангилагдах боломжтой зүйлс:		-	-
Орлого, үр дүн рүү ангилагдахгүй зүйлс:		-	-
Холбогдох татвар		-	-
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-
Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй алдагдал		(1,882,695)	-

2

Хуудас 6-53 хийгдсэн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.



2023.08.18



Ашигт Капитал ББСБ ХХК
Өмчийн Өөрчлөлтийн Тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант хугацаа


<i>Мянган төгрөгөөр</i>	Хувьцаат капитал- Энгийн хувьцаа	Хуримтлагдсан ашиг/(алдагдал)	Нийт эздийн өмч
2020 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	50	-	50
Хувьцаа гаргасан	39,999,950		39,999,950
Нийт дэлгэрэнгүй орлого:			
Тайлант хугацааны алдагдал	-	(1,882,695)	(1,882,695)
Нийт дэлгэрэнгүй алдагдал	-	(1,882,695)	(1,882,695)
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	40,000,000	(1,882,695)	38,117,305



2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант хугацаа

<i>Мянган төгрөгөөр</i>	Хувьцаат капитал- Энгийн хувьцаа	Хуримтлагдсан ашиг/(алдагдал)	Нийт эздийн өмч
2019 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	50	-	50
Нийт дэлгэрэнгүй орлого:			
Тайлант хугацааны алдагдал	-	-	-
Нийт дэлгэрэнгүй алдагдал	-	-	-
2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	50	-	50

Хуудас 6-53 хийгдсэн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

3





Ашид Капитал ББСБ ХХК
Мөнгөн Гүйлгээний Тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант хугацаа

Мянган төгрөгөөр	Тодруулга	2020 он	2019 он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Татварын өмнөх алдагдал		(2,073,291)	-
Тохируулгууд :			
Үндсэн хөрөнгийн элэгдэл	8	462	-
Биет бус хөрөнгийн хорогдуулга	9	5,124	-
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл, хорогдуулга	10	16,794	-
Худалдааны болон бусад авлагын үнэ цэнийн бууралтын гарз/(олзны буцаалт)	11, 12	105,785	-
Санхүүгийн орлого (цэвэр дүнгээр)	17	(138,520)	-
Валютын ханшийн цэвэр гарз/(олз)	19	(265,848)	-
Актлагдсан бараа материал	18	18,091	-
Ажлын капиталын өөрчлөлтөөс өмнөх үйл ажиллагааны ашиг		(2,331,403)	-
Ажлын капиталын өөрчлөлт:			
Худалдааны болон бусад авлагын (өсөлт)/бууралт		(94,848)	-
Бараа материалын (өсөлт)/бууралт		(21,923)	-
Худалдааны болон бусад өглөгийн өсөлт/(бууралт)		377,422	-
Үйл ажиллагаанаас олсон мөнгө		(2,070,752)	-
Орлогын албан татвар		(6,649)	-
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(2,077,401)	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	8	(8,414)	-
Биет бус хөрөнгийн худалдан авалт	9	(623,845)	-
Хүлээн авсан хүү	17	59,843	-
Санхүүгийн авлагын өсөлт/бууралт	11	(11,216,82)	-
Санхүүгийн авлагаас эргэн төлөгдсөн	11	4,717,679	-
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ		(7,071,566)	-

4

Хуудас 6-53 хийгдсэн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.





Ашид Капитал ББСБ ХХК

Мөнгөн гүйлгээний тайлан (үргэлжлэл)

Манган төгрөгөөр


Тодруулга 2020 он 2019 он

**САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
МӨНГӨН ГҮЙЛГЭЭ**

Шинээр гаргасан хувьцаа	16	39,999,950	-
Санхүүгийн түрээсийн өглөгийн өсөлт	10	(15,200)	-
Төлсөн хүү	10	(6,419)	-
Санхүүжилтийн цэвэр мөнгөн гүйлгээ		39,978,331	-
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт (бууралт)		30,829,364	-
1-р сарын 1-рх мөнгө болон мөнгөтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл		50	-
Ханшийн өөрчлөлтийн нөлөө		265,848	50
12 -р сарын 31-рх мөнгө болон мөнгөтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл		31,095,263	50



Хуудас 6-53 хийгдсэн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.



2023.08.18

Ашид Капитал ББСБ ХХК

1. Компанийн танилцуулга

“Ашид Капитал ББСБ” ХХК нь (цаашид “Компани” гэх) Монгол Улсын компанийн тухай хуулийн дагуу хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр үүсгэн байгуулагдсан Монгол Улсын хуулийн этгээд юм. Компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2020 оны 2-р сарын 12-ны өдөр олгосон зээл, факторинг, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах 101/63 тоот тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Компани нь 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр Улсын Бүртгэлийн Газарт бүртгэгдсэн 6105572 тоот бүртгэлийн дугаар бүхий 9015005118 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй болно.

Компанийн үндсэн үйл ажиллагаа нь гар утасны Simple аппликэйшнээр дамжуулан харилцагчийн зээлийн эрхийг зайнаас үнэлж, зээл олгодог дижитал технологид суурилсан банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа байна. Simple гэдэг нь компанийн дотоодоо хөгжүүлсэн финтек шийдэл бүхий санхүүгийн үйлчилгээ үзүүлэх технологи юм.

Компани нь 2020 оны жилийн эцсийн байдлаар 1 харилцагчийн төв, 5054 харилцагч, 96 ажилтантайгаар үйл ажиллагаа явууллаа.

Компанийн бүртгэгдсэн албан ёсны хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, 8-р хороо, Их эзэн Чингис хааны талбай, Сентрал Тауэр, 15-р давхар.

2. Компанийн үйл ажиллагааны орчин

2017-2019 оны хооронд дунджаар 6 гаруй хувиар өсөж байсан эдийн засаг 2020 онд Ковид-19 цар тахлын нөлөө болон суурь макро эдийн засгийн сул байдлаас хамаарч огцом уналтад орлоо. Үндэсний Статистикийн Газар Монгол Улсын Эдийн Засаг 2020 онд 5.3%-р агшсан гэж тооцсон байна. Хэцүү жил өнгөрч байгаа боловч 2021 оноос эдийн засаг буцан сэргэж 5% өсөх төлөвтэй байна. (Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банк)



Сангийн Яамнаас ДНБ-ийн 7.2 хувьтай тэнцэх эдийн засгийг дэмжих хөтөлбөр 2020 оны хагасаас хэрэгжүүлж эхэлсэн. УИХ баталсан төсвийн алдагдал 2020 онд ДНБ-ийн -12.5, 2021 онд -5.1 байна.

Ковид-19 үед хэрэгжүүлэх хууль, хөтөлбөрийн хүрээнд Монгол Банк (МБ) бодлогын хүүг 500 суурь нэгжээр бууруулж 6 хувь болгосон, заавал байлгах албан нөөцийг 4.5 хувиар бууруулсан, хэрэглээний болон ипотекийн зээлийн төлөлтийг хойшлуулсан, бизнесийн зээлийн бүтцэд өөрчлөлт оруулж мөн банкнуудад урт хугацааны санхүүжилт олгосон.

2020 онд инфляци суларч, зорилтот түвшингөөс бага байсан ба 2021 онд тогтворжиж 6 хувьтай байх төлөвтэй байна. Эдийн засгийн сэргэлт нь БНХАУ-ын нэмэгдэж буй нүүрс болон зэсийн эрэлт, зөөлөн мөнгөний бодлого болон төсвийн бодлого мөн уул уурхайн салбарын өсөлт тээвэрлэлт болон худалдааны салбарт нөлөөлж буйтай холбоотой байна.

Монгол улс амжилттайгаар урт хугацаанд үргэлжилж байсан эрсдэлийг шийдэж чадсан билээ – засгийн газрын төлөлт ойртож байсан зээлүүдийн дахин санхүүжүүлж сунгасан мөн Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага (Financial Action Task Force буюу ФАТФ) -ийн саарал жагсаалтаас гарсан болно. Гэсэн хэдий ч дараах эрсдэлүүд эдийн засагт байсаар байна:





Ашид Капитал ББСБ ХХК

Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

- ДНБ-ийн 70 хувьтай тэнцэх их хэмжээний засгийн газрын өр – үүний 90 хувь нь гадаад валютын зээл
- Эдийн засаг нийтдээ их өртэй (ДНБ-ийн 220 хувь), байнгын урсгал дансны алдагдал (ДНБ-ийн 15 хувь) мөн хязгаарлагдмал валютын нөөцтэй (нийт 8 сарын импорттой дүйцэх) байгаа нь гадаад орчинд болж буй нөлөөнд илүү их мэдрэг байлгаж байна
- Үргэлжилж буй зээлийн тасалдал болон их хэмжээний чанаргүй зээл санхүүгийн зуучлагч болон банкны секторт муугаар нөлөөлөхөөр байна.

2020 он хүнд хэцүү жил байсан ч байгалийн баялгийн нөөц, өсөж буй нүүрс болон зэсийн үнэ болон БНХАУ-ын нэмэгдэж буй эрэлтээс улбаатайгаар Монгол улсын дунд хугацааны эдийн засгийн төлөв өөдрөг байна.

3. Тайлан бэлтгэх үндэслэл

а) Санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/-ын дагуу бэлтгэгдсэн талаарх мэдэгдэл

Компанийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлан нь СТОУС-ын дагуу бэлтгэгдсэн болно. Компаний Төлөөлөн Удирдах Зөвлөл 2021 оны 3 дугаар сарын 23-ны өдөр санхүүгийн тайланг хэвлэн гаргахыг зөвшөөрч батлав.

б) Бүртгэлийн болон тайлагналын мөнгөн тэмдэгт

Санхүүгийн тайланг өөрөөр заагаагүй бол Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох Монгол Төгрөгөөр илэрхийлсэн болно. Компанийн бүртгэлийн валют нь Монгол Төгрөг юм.

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого

А. Санхүүгийн хэрэглүүр

а) Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн ангилал болон хэмжилт

Компани нь санхүүгийн хэрэглүүрийн гэрээний нэг тал болсон үед санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Хорогдуулсан өртөг эсвэл бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөхдөө хөрөнгө, өр төлбөрийн дүн дээр түүнтэй шууд хамааралтай ажил гүйлгээний өртгийг нэмж бүртгэнэ. Харин бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг анх хэмжиж бүртгэхдээ зөвхөн хөрөнгө, өр төлбөрийн үнээр бүртгэх ба түүнтэй шууд хамааралтай ажил гүйлгээний өртгийг тайлант үед ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгө

Санхүүгийн хөрөнгийн дараа үеийн ангилал, хэмжилтийг хийхдээ дараах хоёр нөхцөлд үндэслэнэ.

1. Байгууллагын бизнесийн загварын зорилго: Гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах зорилгоор эзэмшиж байгаа эсэхээс хамаарна. Бизнесийн загвар өөрчлөгдсөн тохиолдолд дахин ангилал хийнэ.



2023.08.18

Ашид Капитал ББСБ ХХК

Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

2. Санхүүгийн хөрөнгийн гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанар: Гэрээний мөнгөн гүйлгээ нь үндсэн төлбөр, хүүгийн төлбөр болон бусад төлбөрөөс бүрдэж буй эсэх.

Ангвалал	Бүрэлдэхүүн болон Хэмжилт
Хорогдуулсан өртөг	Дараах хоёр шалгуурыг аль алийг нь хангаж байвал: (а) Бизнес загварын зорилго: Гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө (б) Гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанар: Зөвхөн үндсэн төлбөрийн төлөлт ба үлдэгдэл төлбөрийн дүнд тооцогдох хүүгийн төлөлт байх
Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдсэн	Дараах хоёр шалгуурыг аль алийг нь хангаж байвал: (а) Бизнес загварын зорилго: Гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах болон борлуулах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө (б) Гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанар: Зөвхөн үндсэн төлбөрийн төлөлт ба үлдэгдэл төлбөрийн дүнд тооцогдох хүүгийн төлөлт байх
Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдсэн	Санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр нь эсвэл бодит үнэ цэнийг бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэж хэмжихээс бусад тохиолдолд бодит үнэ цэнийг ашиг, алдагдлаар хэмжинэ. Бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэсэн санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлт эсвэл дахин ангилал хийх үед гарсан бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.
Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдсэн өмчийн хөрөнгө оруулалтууд	Эдгээр хөрөнгүүдийн дараа үеийн хэмжилт нь бодит үнэ цэнээр хэмжигддэг. Ногдол ашгийг хөрөнгө оруулалтын зардлын зарим хэсгийг нөхөхийг тодорхой заагаагүй бол ногдол ашгийг ашиг, алдагдлын хэсэгт орлого гэж хүлээн зөвшөөрнө. Бусад цэвэр ашиг, алдагдлыг бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт хүлээн зөвшөөрдөг ба ашиг, алдагдалд дахин ангилахгүй.

Санхүүгийн өр төлбөр

Санхүүгийн өр төлбөрийн хэмжилтийг дараах 2 төрлөөр ангилна. Үүнд:

- Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөрүүд:
 - Арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн өр төлбөр;
 - Дериватив буюу үүсмэл санхүүгийн өр төлбөр;
 - Агуулагдсан дериватив;
 - Болзошгүй өр төлбөр; болон

8



2023.08.18



Ашид Капитал ББСБ ХХК

Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

- Анх ашиг, алдагдлаар хэмжигдсэн санхүүгийн өр төлбөр.
- 2. Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн өр төлбөрүүд:
 - Худалдааны болон бусад өр төлбөр
 - Банкны зээл
 - Бусад зээл ба өглөг
 - Холбоотой талууд болон удирдлагад өгөх өр төлбөр
 - Дээрхээс бусад

Санхүүгийн өр төлбөрийн хэмжилтэд дахин ангилал хийхгүй.

Компани санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд данснаас хасна: санхүүгийн хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах гэрээний эрх дууссан үед; санхүүгийн хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрхээ шилжүүлсэн ажил гүйлгээний үр дүнд санхүүгийн хөрөнгийг эзэмшихтэй холбоотой эрсдэл болон өгөөж үндсэндээ шилжсэн үед; эсвэл санхүүгийн хөрөнгө, түүнийг эзэмшихтэй холбоотой үндсэн эрсдэл болон өгөөжийг шилжүүлээгүй боловч хөрөнгийн хяналтын эрхийг алдсан үед. Хөрөнгийг данснаас хасахад үүссэн эсвэл үлдсэн хэсгийг тусдаа, шинэ санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөр гэж үзэн, бүртгэлд тусгана.

Компани санхүүгийн өр төлбөрийг тухайн өр төлбөртэй холбоотой гэрээний үүрэг хариуцлагаа бүрэн төлж барагдуулсан, цуцалсан эсвэл үүрэг хариуцлагын хугацаа дууссан үед данснаас хасна.

Компани санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг тухайн хөрөнгө болон өр төлбөрийг цэвэр дүнгээр тайлагнах хуулиар олгогдсон эрхтэй бөгөөд тэдгээрийг цэвэр дүнгээр нь төлөх эсвэл санхүүгийн хөрөнгийг хэрэгжүүлэхдээ санхүүгийн өр төлбөрийг зэрэг төлж барагдуулах төлөвлөгөөтэй байгаа тохиолдолд л хооронд нь хааж, санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр толилуулж болно.

Худалдааны болон бусад авлагыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгөнд касс дахь бэлэн мөнгө, банкны харилцах дансны үлдэгдэл болон гурван сар буюу бага хугацаатайгаар банканд байршуулсан хадгаламж зэргийг оруулна. Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийг үр ашигт хүүгийн аргын ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

Гэрээний нөгөө тал гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэсэн даруйд худалдааны болон бусад өглөгийг хүлээн зөвшөөрч бүртгэх ба үр ашигт хүүгийн аргын ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

б) Дериватив санхүүгийн хэрэглүүр

Агуулагдсан деривативийг үндсэн гэрээнээс салгахгүй. Харин үндсэн гэрээ нь санхүүгийн хөрөнгө биш ба тодорхой шалгуурыг хангасан нөхцөлд агуулагдсан деривативыг үндсэн гэрээнээс нь салгаж, тусад нь бүртгэдэг.

Шалгуур: агуулагдсан үүсмэл хэрэглүүрийг салгах

1. Агуулагдсан дериватив болон үндсэн гэрээний эдийн засгийн шинж чанар нь нягт уялдаатай биш;
2. Ижил нөхцөл бүхий төстэй хэрэглүүр нь деривативын тодорхойлолтыг хангасан, ба



Ашигт Капитал ББСБ ХХК

Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

3. (Холимог) гэрээг бүхэлд нь бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжсэн.

Деривативыг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр нь хэмжинэ. Ажил гүйлгээтэй шууд хамааралтай гарсан зардлыг тухай бүрд нь ашиг, алдагдлаар бүртгэнэ. Анх хүлээн зөвшөөрч бүртгэсний дараа деривативыг мөн бодит үнэ цэнээр хэмжиж бүртгэх ба бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ихэвчлэн ашиг, алдагдлаар бүртгэдэг.

в) Нийлмэл санхүүгийн хэрэглүүр

Компанийн гаргасан нийлмэл санхүүгийн хэрэглүүрт эзэмшигч буюу нөгөө талын сонголтоор хувьцаанд хөрвөх боломжтой (хөрвүүлэх хувьцааны тоо ширхэг нь тодорхой бөгөөд бодит үнэ цэнийн өөрчлөлтийг дагаж өөрчлөгддөггүй) хөрвөх өрийн бичиг орно.

Нийлмэл санхүүгийн хэрэглүүрийн хувьцаанд хөрвөх сонголтгүй өр төлбөрийн хэсгийг ижил төрлийн өр төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжиж бүртгэнэ. Нийлмэл санхүүгийн хэрэглүүрийн өмчийн хэсгийг анх хүлээн зөвшөөрөхдөө нийлмэл санхүүгийн хэрэглүүрийн нийт бодит үнэ цэнээс өр төлбөрийн хэсгийн бодит үнэ цэнийг хасч тооцно. Ажил гүйлгээтэй шууд хамааралтай зардлыг өр төлбөр болон өмчийн хэсгийн анхны дансны дүнг харгалзан хуваарилна.

Анх хүлээн зөвшөөрч бүртгэсний дараа нийлмэл санхүүгийн хэрэглүүрийн өр төлбөрийн хэсгийг үр ашигт хүүгээр хорогдуулсан өртгөөр хэмжинэ. Харин нийлмэл санхүүгийн хэрэглүүрийн өмчийн хэсгийг дахин хэмжихгүй.

Өр төлбөрийн хэсгийн хүүгийн зардлыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Хөрвүүлэх үед өр төлбөрийг өмчид ангилан бүртгэх ба энэ үед ямар ч олз, гарз хүлээн зөвшөөрч бүртгэхгүй.

Б. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн анхдагч хүлээн зөвшөөрөлтийн өртөг дараах зүйлсээс бүрдэнэ:

- Худалдан авсан үнэ, импортын татвар болон буцаан олгогдохгүй худалдан авалтын татварын нийлбэрээс худалдааны хөнгөлөлт, урамшууллыг хассан дүн;
- Хөрөнгийг удирдлагаас тогтоосон зориулалтын дагуу ашиглахад бэлэн болгож, зохих байршил болон нөхцөлд хүргэхтэй шууд холбоотой гарсан зардлууд. Жишээ нь, хүргэлт болон тээвэрлэлтийн зардал, талбарыг бэлтгэх зардал, суурилуулалт болон угсралтын зардал, мэргэжлийн үйлчилгээ болон хуульчийн зардал гэх мэт; болон
- Хөрөнгийг олж эзэмших үед эсвэл түүнийг тодорхой хугацааны туршид бараа материал үйлдвэрлэхээс бусад зорилгоор ашигласны улмаас үүссэн, хөрөнгийг задлах, буулгах, холдуулах болон хөрөнгийн байрлаж байсан ажлын талбарыг сэргээх гэх зэрэгтэй холбоотой үүрэг хариуцлагын анхдагч тооцооллын дүн.

Өөрөө барьж байгуулсан хөрөнгийн өртөгт хөрөнгийг барьж байгуулахтай холбогдон гарсан шууд материал, шууд хөдөлмөр, хөрөнгийг задлах, буулгах, холдуулах болон хөрөнгийн байрлаж байсан ажлын талбарыг сэргээх гэх зэрэгтэй холбоотой үүрэг хариуцлагын анхдагч тооцооллын дүн, үйлдвэрлэлийн бусад нэмэгдэл зардал, зээлийн хүүгийн зардлыг үндэслэлтэйгээр хуваарилсан дүнг тус тус оруулна.

Анх хүлээн зөвшөөрч бүртгэсний дараа компани өөрийн хэрэгцээнд ашигладаг барилга байгууламжийг дахин үнэлсэн дүнгээр буюу дахин үнэлгээ хийгдсэн өдрөөрх бодит үнэ цэнээс


10



Handwritten signature



2023.08.18



Ашид Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

аливаа хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн бусад ангиллуудын хувьд өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр бүртгэнэ.

Тайлант үеийн эцэс дэх барилга байгууламжийн дансны дүн болон бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү гаргахгүй байх үүднээс, барилга байгууламжийн дахин үнэлгээг тогтмол хийдэг.

Хэрэв барилга байгууламжийн дансны дүн нь дахин үнэлгээний үр дүнд өссөн бол, дансны дүнгийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт хүлээн зөвшөөрч, өмчийн хэсэгт дахин үнэлгээний нөөцөөр хуримтлуулан бүртгэнэ. Хэрэв тухайн барилга байгууламжийн дансны дүн нь дахин үнэлгээний үр дүнд буурсан бол дахин үнэлгээний бууралтыг зардлаар бүртгэнэ. Ингэхдээ:

- Дахин үнэлгээний нөлөөгөөр дансны үнэ буурсан боловч өмнө нь тухайн хөрөнгөтэй холбоотой дахин үнэлгээний нөөц дансанд үлдэгдэл байсан бол зөвхөн уг үлдэгдлээс давсан дүнг орлого, үр дүнгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.
- Дахин үнэлгээний нөлөөгөөр дансны үнэ өссөн боловч өмнө нь тухайн хөрөнгөтэй холбоотой дахин үнэлгээний бууралт орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн байсан бол өмнө нь хүлээн зөвшөөрөгдсөн зардлыг буцаах хүртэл дүнгээр орлого, үр дүнгийн тайланд орлого хүлээн зөвшөөрөх ба түүнээс давсан дүнг бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт хүлээн зөвшөөрч, өмчийн хэсэгт дахин үнэлгээний нөөцөөр хуримтлуулан бүртгэнэ.

Үндсэн хөрөнгийн дахин үнэлэгдсэн дүн эсвэл өртгөөс үлдэх өртгийг (хэрэв байгаа бол) хассан дүнг системтэйгээр хуваарилах зорилгоор, хөрөнгийн тооцоолсон ашиглалтын хугацаанд шулуун шугамын аргыг ашиглан элэгдлийг тооцоолно.

Компанийн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа нь энэ тайлант үе болон зэрэгцүүлэн толилуулагдсан тайлант үед дараах байдлаар тооцоологдсон:

Үндсэн хөрөнгө	Ашиглалтын хугацаа (жилээр)
Барилга байгууламж, бусад барилга	10-50
Машин техник, тоног төхөөрөмж	3-20
Конторын тоног төхөөрөмж, тавилга эд хогшил	3-15
Тээврийн хэрэгсэл	3-15
Бусад үндсэн хөрөнгө	3-15

Үндсэн хөрөнгийн томоохон бүрэлдэхүүн хэсгийн ашиглалтын хугацаа нь хөрөнгийн бусад бүрэлдэхүүнтэй харьцуулахад өөр байвал, уг хэсгийг тусад нь элэгдүүлнэ. Дуусаагүй барилгад элэгдэл байгуулахгүй.

Хөрөнгийн үлдэх өртөг гэдэг нь тухайн хөрөнгийн ашиглалтын хугацаа дууссан, хуучирсан гэж үзвэл компани одоо худалдаж болох үнээс худалдан борлуулахтай холбогдон гарах зардлыг хассан дүнг хэлнэ. Компани үндсэн хөрөнгийн үлдэх өртөг болон ашиглалтын хугацааг тайлант жил бүрийн эцэст эргэн хянаж, шаардлагатай тохиолдолд өөрчилнө.



Ашигт Капитал ББСБ ХХК

Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

Үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгэсний дараа нэмж гарсан зардлыг, зөвхөн уг зардалтай холбогдох ирээдүйн эдийн засгийн үр өгөөж компанид орж ирэх магадлалтай үед л үндсэн хөрөнгийн өртөгт капиталжуулна.

Үндсэн хөрөнгийг данснаас хасахад үүсэх олз, гарзыг холбогдох цэвэр орлогын дүн болон дансны дүнгийн зөрүүгээр тооцох ба данснаас хассаны олз, гарзыг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Данснаас хасагдсан үндсэн хөрөнгөтэй холбогдох дахин үнэлгээний нөөцийн үлдэгдэл (хэрэв байгаа бол) орлогын тайланд тусгагдахгүйгээр хуримтлагдсан ашигт хаагдана.

Үндсэн хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болзошгүйг илтгэх шинж тэмдэг байгаа эсэхийг удирдлага тайлант үе бүрийн эцэст хянаж үздэг. Үнэ цэнэ буурсан гэдгийг илтгэх шинж тэмдэг байвал, үндсэн хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ болон бодит үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүн хоёрын аль ихээр нь хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцоолно. Үндсэн хөрөнгийн дансны дүнг нөхөгдөх дүн хүртэл бууруулж, үнэ цэнийн бууралтыг тухайн тайлант хугацааны ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Өмнөх тайлант хугацаануудад үндсэн хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ болон бодит үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүнг хэмжихэд ашигласан тооцооллууд нь өөрчлөгдсөн бол, өмнө нь хүлээн зөвшөөрөгдсөн үнэ цэнийн бууралтыг зохих хэмжээгээр нь буцаана.

В. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг /ХОЗҮХХ/ анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь хэмжинэ. Анх хүлээн зөвшөөрч бүртгэсний дараа тайлант жилийн эцэст баригдаж дуусаагүй болон уг хөрөнгийн бодит үнэ цэнэ нь найдвартай хэмжигдэх боломжгүйгээс бусад бүх тохиолдолд ХОЗҮХХ-г бодит үнэ цэнээр хэмжиж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

ХОЗҮХХ-н өртөгт худалдан авалтын үнэ болон олж эзэмшихтэй шууд холбоотой зардлууд орно. Компанийн өөрөө барьж байгуулсан ХОЗҮХХ-н өртөгт шууд материалын зардал, шууд хөдөлмөрийн зардал болон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглахад бэлэн болгохтой шууд холбогдох бусад зардлууд, мөн капиталжуулсан зээлийн зардлууд тус тус орно.

ХОЗҮХХ-н бодит үнэ цэнийг тайлант жил бүрийн эцэст бие даасан хараат бус үнэлгээчнээр дараах зарчмын дагуу тодорхойлуулж үнэлгээний тайлангаар баталгаажуулдаг.


Бодит үнэ цэнийн хамгийн сайн үндэслэл нь ижил байршил, нөхцөл байдалд байгаа адил төстэй хөрөнгийн идэвхтэй зах зээл дээрх өнөөгийн үнэ юм.

Харин идэвхтэй зах зээлийн өнөөгийн үнэ байхгүй тохиолдолд, компани ХОЗҮХХ-н бодит үнэ цэнийг хэмжихийн тулд олон төрлийн эх үүсвэрээс мэдээллийг цуглуулан авч үздэг. Үүнд:

- Шинж чанар, нөхцөл байдал, байршил ялгаатай хөрөнгийн идэвхтэй зах зээл дэх өнөөгийн үнэнд дээрх ялгаануудыг тусгаж, тохируулсан дүн;
- Ажил гүйлгээ багатай зах зээл дээр ижил төстэй хөрөнгийн ойрын хугацаанд арилжаалагдсан үнэнд ажил гүйлгээ гарсан өдрөөс хойших эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлтийг тусгаж, тохируулсан дүн; болон
- Ирээдүйн мөнгөн гүйлгээний найдвартай тооцоолол дээр үндэслэсэн дискаунтчилагдсан мөнгөн урсгалын төсөвлөсөн дүн, энэхүү төсөв нь хүчин төгөлдөр хэрэглэгдэж байгаа

12





Ашид Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

түрээс, өөр бусад гэрээний заалт, нөхцөл болон боломжтой бол ижил байршил, нөхцөлд байгаа адил төстэй хөрөнгийн түрээсийн өнөөгийн үнийн зах зээлийн мэдээлэл дээр тулгуурласан бөгөөд өнөөгийн зах зээлийн үнэлэмжээр мөнгөн гүйлгээний цаг хугацааны болон үнийн дүнгийн тодорхой бус байдлыг тусгасан дискаунтын хувийг ашигласан байна.

ХОЗҮҮХ-н бодит үнэ цэнийн өөрчлөлт болон данснаас хасахтай холбоотой үүсэх олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгөөс ХОЗҮҮХ-нд ангилагдсан хөрөнгийг данснаас хасах үед, уг хөрөнгөтэй холбоотой дахин үнэлгээний нөөцийг (хэрэв байгаа бол) хуримтлагдсан ашигт хаана.

Г. Биет бус хөрөнгө

Тусад нь худалдаж авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь хэмжинэ. Анх хүлээн зөвшөөрч бүртгэсний дараа тэдгээрийг өртгөөс хуримтлагдсан хорогдол (ашиглалтын хугацаа нь тодорхой хөрөнгийн хувьд) болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр хэмжинэ.

Хөгжүүлэлтийн үе шатны зардлыг зөвхөн түүнийг найдвартай хэмжих боломжтой бөгөөд уг ажлын үр дүнд тооцоологдсон бүтээгдэхүүн, процесс нь техник, эдийн засгийн үндэслэлтэй, ирээдүйн эдийн засгийн үр өгөөжтэй, компани хөгжүүлэлтийг гүйцээж, цаашид ашиглах хангалттай нөөцтэй ба төлөвлөгөөтэй байгаа эсвэл худалдан борлуулах боломжтой нөхцөлд л капиталжуулан бүртгэнэ. Дээрх нөхцлүүд биелэгдээгүй тохиолдолд хөгжүүлэлтийн зардлыг тухай бүрд нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Хүлээн зөвшөөрч бүртгэсний дараагаас хөгжүүлэлтийн зардлыг өртгөөс хуримтлагдсан хорогдол болон үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр хэмжинэ.

Судалгааны үе шатны зардлыг тухай бүрд нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Биет бус хөрөнгийг шулуун шугамын аргаар хорогдуулах боловч тухайн хөрөнгийн хүлээгдэж буй хэрэглээ, холбогдох ирээдүйн эдийн засгийн өгөөжтэй илүү уялдсан хорогдуулгын өөр бусад аргыг хэрэглэж болно.

Тодорхой ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулах арга болон ашиглалтын хугацааг дор хаяж тайлант жил бүрийн эцэст дахин хянаж, шаардлагатай бол өөрчлөх бөгөөд эдгээр өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзэн бүртгэлд тусгана. Биет бус хөрөнгийн хорогдуулгын зардлыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Ашиглалтын хугацаа нь тодорхой дараах биет бус хөрөнгүүдийг ашиглахад бэлэн болсон өдрөөс эхлэн доорх тооцоолсон ашиглалтын хугацаагаар хорогдуулна.

Биет бус хөрөнгө	Ашиглалтын хугацаа (жилээр)
Лиценз	5-20
Програм хангамж	3-10
Худалдааны тэмдэг	10
Бусад	10



**Ашид Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31**

Ашиглалтын хугацаа нь тодорхойгүй гэж дүгнэгдсэн биет бус хөрөнгийг хорогдуулахгүй. Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа нь тодорхойгүй гэсэн дүгнэлтийг тайлант жил бүр дахин хянаж, үйл явдал ба нөхцөл байдал ашиглалтын хугацаа тодорхойгүй болохыг үргэлжлүүлэн нотолж байгаа эсэхийг шалгана. Хэрэв үгүй бол, уг биет бус хөрөнгийг тодорхой ашиглалтын хугацаатай болсон гэж үзэн, холбогдох өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзэн бүртгэлд тусгана.

Биет бус хөрөнгийн ангилал дотор тусгагдсан хайгуул ба үнэлгээний хөрөнгийн өртөгт хайгуул ба үнэлгээтэй шууд холбоотой зардлууд орно. Үүнд бэлэн байгаа хайгуулын мэдээнд анализ хийх, геологийн судалгаа хийх, хайгуулын өрөмдлөг болон дээж авах, олборлолт болон баяжуулалтын аргуудыг судлах ба турших, урьдчилсан болон батлагдсан техник эдийн засгийн үндэслэл, мэдээнд судалгаа, дүн шинжилгээ хийх болон үйл ажиллагааны бусад цалин хөлс, хоол, түлш, түрээс зэрэг хайгуулын талбайд явуулж буй үйл явцтай шууд холбогдох зардлуудыг багтаана. Хайгуул ба үнэлгээний хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралт байгаа эсэхийг жил бүр хянана.

Д. Охин болон хараат компани/хамтарсан компани дахь хөрөнгө оруулалт

Энэхүү тусдаа санхүүгийн тайланд охин болон хараат/хамтарсан компанид оруулсан хөрөнгө оруулалтыг өртгийн аргаар бүртгэдэг бөгөөд өртгөөс нь үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр толилуулсан болно. Хөрөнгө оруулалтыг данснаас хасахтай холбоотой цэвэр орлогын дүнгээс дансны дүнг хассан зөрүүг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Е. Урьдчилж төлсөн төлбөр

Урьдчилж төлсөн төлбөрийг өртгөөс үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр хэмжинэ. Төлөгдсөн урьдчилгаатай холбоотой бараа, үйлчилгээг нэг жилийн дараа хүлээн авахаар хүлээгдэж байгаа эсвэл урьдчилгаа нь төлөгдсөн хөрөнгө нь ирээдүйд хүлээн зөвшөөрч бүртгэгдэхэд эргэлтийн бус хөрөнгөөр ангилагдах бол тухайн урьдчилж төлсөн төлбөрийг эргэлтийн бус гэж ангилна.

Компани хөрөнгийн хяналтын эрхийг олж эзэмшин, хөрөнгийн эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг нь хүртэх магадлалтай болсон үед уг хөрөнгөтэй холбоотой урьдчилж төлсөн төлбөрийг хөрөнгийн өртөгт шилжүүлэн бүртгэнэ. Бусад урьдчилж төлсөн төлбөрийг холбогдох бараа, үйлчилгээг хүлээн авсан тайлант хугацаанд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Хэрэв урьдчилгаа нь төлөгдсөн бараа, үйлчилгээг хүлээн авахгүй байх магадлал бий болсон үед, урьдчилж төлсөн төлбөрийн дансны дүнг бууруулан, холбогдох үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.


Ё. Бараа материал

а) Үйлдвэрлэл

Бараа материал нь өртөг болон цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь хэмжигдэнэ.

Бараа материалын өртгийг жинлэсэн дундаж өртгийн аргыг ашиглан тооцоолох ба өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон бараа материалыг одоогийн байршил ба нөхцөлд авчрахтай холбогдож гарсан бүх зардал орно.





simple



Ашигт Капитал ББСБ ХХК

Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

Бараа материалын цэвэр боломжит үнэ цэнэ гэдэг нь бизнесийн хэвийн үйл ажиллагааны хүрээнд борлуулахаар тооцоолсон үнээс тооцоолсон иж бүрдэл болгох зардал болон борлуулалтын зардлыг хассан дүн юм.

Борлуулсан бараа материалын дансны дүнг холбогдох борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрсөн тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрнө. Бараа материалыг цэвэр боломжит үнэ цэнэ хүртэл буулган хэмжээнтэй холбоотой болон өөр бусад гарзыг тухайн тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрнө. Харин бараа материалын цэвэр боломжит үнэ цэнэ өссөнөөс үүссэн гарзын буцаалтыг тухайн тайлант үед бүртгэгдсэн бараа материалтай холбоотой зардлыг бууруулан бүртгэлд тусгана.

б) Үл хөдлөх хөрөнгийн бүтээн байгуулалт

Үл хөдлөх хөрөнгийн бүтээн байгуулалтын үр дүнд үүсэх бараа материалыг өртөг болон цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар хэмжинэ. Өртөг болон цэвэр боломжит үнэ цэнийг дараах байдлаар тооцоолно:

- Худалдах зорилгоор барьж буй үл хөдлөх хөрөнгө

Худалдах зорилгоор барьж буй үл хөдлөх хөрөнгийн өртөгт газар олж эзэмших зардал, бүтээн байгуулалтын нийт өртөг, түүхий эд, туслах материалын зардал, цалин болон бусад шууд зардал зэрэг тусгайлан тодорхойлогдохуйц зардлууд болон үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлын хуваарилалт болон капиталжуулсан эзэлийн өртөг зэрэг хөрөнгийг одоогийн байршил ба нөхцөлд авчрахтай холбогдох бүх зардал орно. Цэвэр боломжит үнэ цэнийг борлуулахаар тооцоолсон үнээс тооцоолсон бүтээн байгуулалтыг гүйцээх болон борлуулалтын зардлыг хасч тооцоолно.

- Барьж дууссан, худалдахаар эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгө

Компанийн барьж дууссан боловч зарагдаагүй байгаа үл хөдлөх хөрөнгийн өртгийг бүтээн байгуулалтын нийт өртгийн дүнд хувь тэнцүүлэн тооцно. Цэвэр боломжит үнэ цэнийг борлуулахаар тооцоолсон үнээс тооцоолсон борлуулалтын зардлыг хасч тооцно.

Барьж дууссан, худалдахаар эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгийн өртөгт худалдан авалтын нийт өртөг, бүтээн байгуулалтын нийт өртөг болон хөрөнгийг одоогийн байршил ба нөхцөлд авчрахтай холбогдсон бүх зардал орно.

Ж. Харилцагчтай байгуулсан гэрээний орлого

Компани харилцагчид үйлчилгээ үзүүлэх, бараа борлуулахаар амласан гэрээний орлогоос тодорхойлогдсон ажил гүйлгээний дүнгээр борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрнө. Харилцагчтай байгуулсан гэрээний орлогыг дараах 5 алхмын дагуу хүлээн зөвшөөрөх юм. Үүнд:

1. Харилцагчтай байгуулсан гэрээг (гэрээнүүдийг) тодорхойлох: Гэрээ нь “хоёр ба түүнээс дээш талуудын хоорондох албан ёсны эрх, үүргийг бий болгодог хэлэлцээр” юм. Гэрээ нь амаар, бичгээр болон компанийн тогтсон жишиг буюу уламжлалт үйл ажиллагаагаар илэрхийлэгдсэн байж болно. Харилцагч гэдэг нь “Компанийн энгийн үйл ажиллагааны үр дүн болох бараа үйлчилгээг олж авахын тулд Компанитай гэрээ байгуулсан тал” юм. Тухайн харилцагчтай нэг



Ашигт Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

өдөр эсвэл ойролцоо хугацаанд байгуулсан гэрээнүүдийг дараах шалгууруудаас нэг ба түүнээс дээш нь хангагдаж байвал нэгтгэн нэг гэрээ гэж үзэн бүртгэнэ. Үүнд:

- (i) Гэрээнүүдийг ажил гүйлгээний нэг зорилго бүхий багц гэж тодорхойлсон;
 - (ii) Нэг гэрээний төлбөрийн дүн нь бусад гэрээний биелэлт эсвэл үнээс хамаарч байвал, эсвэл
 - (iii) Гэрээгээр амласан бүтээгдэхүүн, үйлчилгээ нь нэг гүйцэтгэлийн үүргийг илтгэж байвал зэрэг юм.
2. Гэрээнд тусгагдсан бие даасан гүйцэтгэлийн үүргүүдийг тодорхойлох: Гэрээг тодорхойлсны дараа тухайн гэрээний гүйцэтгэлийн үүргийг тодорхойлно. Үндсэн гэрээнд агуулагдаж буй бүтээгдэхүүн үйлчилгээг хуваарилна.
 3. Хэлцлийн үнийг тодорхойлох: Хэлцлийн үнэ гэдэг нь бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авагчид үзүүлсний хариуд хүлээн авахаар хүлээгдэж буй дүн юм. Энэ дүнг тодорхойлохын тулд Компани нь хувьсах зардал, бэлэн мөнгөөрх бус төлбөр тооцоо, харилцагчид төлөх хувьсах төлбөр, санхүүжилтийн томоохон бүрэлдэхүүн хэсгүүдийг багтаасан зэрэг хүчин зүйлүүдийг харгалзан үзнэ.
 4. Хэлцлийн үнийг гүйцэтгэлийн үүрэг тус бүрд хуваарлах: Компани нь гэрээгээр амласан ялгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээ бүрийн тус тусын тогтоосон борлуулалтын үнэд үндэслэн гүйцэтгэх үүрэг бүрд хэлцлийн үнийг хуваарилна.
 5. Орлого хүлээн зөвшөөрөх: Компани харилцагчид үзүүлэхээр тохиролцсон үйлчилгээгээ нийлүүлснээр гүйцэтгэх үүргээ биелүүлсэн гэж үзэн орлогоо тодорхой хугацааны туршид хүлээн зөвшөөрнө. Дараах шалгуурын аль нэгийг хангасан бол аж ахуйн нэгж бүтээгдэхүүн үйлчилгээний хяналтыг тодорхой хугацааны турш биелүүлж, орлогыг тодорхой хугацааны турш хүлээн зөвшөөрнө.

- ✓ Аж ахуйн нэгж үүргээ гүйцэтгэж байх үед түүний өгөөжийг харилцагч зэрэг хүлээн авч хэрэглэдэг.
- ✓ Аж ахуйн нэгж хөрөнгө шинээр бий болгох эсвэл сайжруулах ажил хийж байх явцад түүний хяналтыг харилцагч эзэмшиж байх хөрөнгийг аж ахуйн нэгжийн гүйцэтгэл шинээр бий болгох эсвэл сайжруулдаг. (жишээ нь: дуусаагүй үйлдвэрлэл); эсвэл
- ✓ Аж ахуйн нэгжийн гүйцэтгэл нь аж ахуйн нэгж өөрөө өөр хэлбэрийн ашиглах боломжтой хөрөнгийг бий болгодоггүй ба аж ахуйн нэгж тухайн өдөр хүртэл гүйцэтгэсэн ажилдаа төлбөр хүлээж авах хууль зүйн эрхтэй.

Гэрээний орлогод гэрээгээр тохирсон эхний үнэ болон гэрээнд оруулсан өөрчлөлт, нэхэмжлэл, урамшууллын төлбөр багтана. Гүйцэтгэлийн хэмжээг орцын эсвэл гарцын арга дээр үндэслэн гаргана.


3. Хөрөнгийн үнэ цэнийн бууралт

а) Дериватив бус санхүүгийн хөрөнгө

Дериватив бус санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болзошгүйг илтгэх шинж тэмдэг байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцэст тогтооно. Хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болзошгүйг илтгэх шинж тэмдгүүд:

- Зээлдэгчийн санхүүгийн хүндрэл;





Ашид Капитал ББСБ ХХК

Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

- Зээлдэгч гэрээний үүргээ зөрчих, тухайлбал зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй, эсвэл төлбөрийн чадваргүй болох;
- Зээлдэгч дампуурал зарлах эсвэл санхүүжилтийн бусад бүтцийн өөрчлөлтөд орох нь тодорхой болох;
- Технологи, эдийн засаг, болон хууль эрх зүйн орчинд зээлдэгчид сөргөөр нөлөөлөхүйц томоохон өөрчлөлтүүд гарсан; болон
- Гэрээний хугацаанд өөрчлөлт оруулах;

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг хөрөнгийн төрлөөс хамааран дараах хоёр аргаар тооцно.

1. Ерөнхий арга:

- Компани хоорондын хугацаатай ба хугацаагүй зээл
- Гаргасан санхүүгийн баталгаа ба зээлийн амлалт
- Засгийн газрын болон компанийн бонд дахь хөрөнгө оруулалт
- Холбоотой талуудад олгосон хугацаатай ба хугацаагүй зээл
- Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт

2. Хялбаршуулсан арга: (томоохон санхүүжилтийн бүрэлдэхүүн хэсэг байгаа эсэхээс үл хамаарна)

- Худалдааны авлага
- Түрээсийн авлага
- Гэрээний хөрөнгө

Ерөнхий арга

Санхүүгийн хөрөнгийг 3 түвшинд ангилах ба тухайн түвшин тус бүрээс хамаарч үнэ цэнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрнө.

Түвшин	1	2	3
	Зээлийн эрсдэл их хэмжээгээр өсөөгүй	Зээлийн эрсдэл их хэмжээгээр өссөн	Зээлийн үнэ цэнийн бууралт үүссэн
Үнэ цэнийн бууралт	12 сарын хүлээгдэж буй зээлийн алдагдал	Нийт ашиглалтын хугацааны хүлээгдэж буй зээлийн алдагдал	
Хүү	Нийт дансны үнийг үр ашигт хүүгээр		Цэвэр дансны үнийг үр ашигт хүүгээр

Үнэ цэнийн бууралтыг заавал тодорхойлох ба тодорхойлсноо санхүүгийн тайландад тодруулна.

Хялбаршуулсан арга

Ашиглалтын нийт хугацааны таамагласан зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх ба дараах таван алхамаар тооцооллыг хийнэ. Үүнд:

1. Авлагын бүлгийг тодорхойлон ангилах: Газар зүйн бүс нутаг, бүтээгдэхүүний төрөл, харилцагчийн зэрэглэл, барьцаа эсвэл худалдааны зээлийн даатгал, харилцагчийн төрөл гэх мэт;
2. Түүхэн алдагдал тохиолдож байсан хугацааг тодорхойлох: Ангиан бүлэглэсний дараа ангилал бүрийн хувьд түүхэн алдагдлын мэдээллийг цуглуулна.

17



2023.08.18

Ашид Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

3. Түүхэн алдагдлын хувь хэмжээг тодорхойлох: Компани нь цуглуулсан мэдээллээ ашиглан ангилал бүрийн хувьд түүхэн алдагдлын хувь хэмжээг тодорхойлно.
4. Макро эдийн засгийн одоогийн хүчин зүйлсийг тооцоолж зохих алдагдлын түвшинг тодорхойлох: Тухайн байгууллагын одоогийн нөхцөл байдал болон ирээдүйн хүлээлтэнд нөлөөлж болохуйц макро эдийн засгийн хүчин зүйлсийг тодорхойлж таамаглал боловсруулах;
5. Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолох.

Хорогдуулсан өртгөөр бүртгэгддэг санхүүгийн бүлэг хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг үнэлэхдээ эргэн төлөгдөлт болон хүлээн зөвшөөрсөн гарз хохирлын талаарх түүхэн мэдээллийг харгалзан үзэхээс гадна цаашдын эдийн засаг, зээлжилтийн нөхцөл байдал, түүнээс үүсэх бодит гарз хохирол ямар байх зэрэг хүлээгдэж буй зээлийн алдагдалд үндэслэн зохих тохируулгыг хийнэ.

Хөрөнгийн дансны дүн болон тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалыг анхдагч үр ашигт хүүгийн түвшингээр дискаунтчилан гаргасан өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр үнэ цэнийн бууралтын гарзыг тооцно. Уг гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч, хорогдуулгын дансанд бүртгэнэ. Компани хөрөнгө эргэн нөхөгдөх бодит боломж байхгүй гэж дүгнэсэн үед холбогдох дүнг данснаас хасна. Харин үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгасны дараа болсон үйл явдлын нөлөөгөөр үнэ цэнийн бууралтын гарз буурах нь тодорхой болсон тохиолдолд өмнө нь хүлээн зөвшөөрсөн гарзыг ашиг, алдагдлаар дамжуулан буцаан бүртгэнэ. Үнэ цэнийн бууралтын буцаалтын нөлөөгөөр хөрөнгийн дансны үнэ өмнөх жилүүдэд тооцогдсон үнэ цэнийн бууралт огт тооцоологдоогүй байх дүнгээс хэтрэх ёсгүй. Үнэ цэнийн бууралтыг заавал тодорхойлох ба тодорхойлсоноо санхүүгийн тайландаа тодруулна.

Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн нөөцөд хуримтлагдсан гарзыг тайлант хугацааны ашиг, алдагдлаар шилжүүлэн бүртгэнэ. Ашиг, алдагдлаар бүртгэгдэх хуримтлагдсан дүн нь анхны өртгөөс эргэн төлөлт болон хорогдуулгыг хассан дүн болон өнөөгийн бодит үнэ цэнийн зөрүүгээс өмнө нь ашиг, алдагдлаар бүртгэгдсэн үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр тооцогдоно. Өмчийн хөрөнгө оруулалтын ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдсөн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаахдаа ашиг, алдагдлаар дамжуулахгүй. Үнэ цэнийн бууралтын дараа үеийн өсөлтийг бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрнө.

II. Ажиллагсдын олговор

а) Ажиллагсдын богино хугацаат олговор

Цалин хөлс, түүнтэй адилтгах олговрыг ажиллагсдын ажил үүргээ гүйцэтгэсэн тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрнө. Ээлжийн амралтын олговор зэрэг богино хугацаанд хуримтлуулан нөхөн олгоддог цалинтай чөлөөний зардлыг уг олговрыг авах эрх нь үүсэх хүртэл ажиллагсдыг үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Харин өвчний чөлөө зэрэг хуримтлуулан нөхөн олгоддоггүй богино хугацааны цалинтай чөлөөг ажиллагсад уг шалтгаанаар чөлөө авсан тухай бүрд зардлаар хүлээн зөвшөөрнө.

б) Тогтмол шийтгэлтэй хотөлбөр





**Ашигт Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31**

Хуулийн дагуу Монгол улсын компаниуд Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын сан буюу үндэсний тэтгэвэр, тэтгэмжийн схемд шимтгэл төлдөг. Уг шимтгэлийг тухай бүрд нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

в) Тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр

Тогтоосон тэтгэмжийн үүргийн цэвэр өр төлбөрийг хөтөлбөр бүрээр тусад нь тооцох ба ажиллагсдын тайлант болон өнгөрсөн хугацаанд үзүүлсэн үйлчилгээний төлөө ирээдүйд төлөх тэтгэмжийн тооцоолсон дүнг дискаунтчилсан өнөөгийн үнэ цэнээс хөтөлбөртэй холбоотой хөрөнгийн бодит үнэ цэнийг хассан дүнгээр хэмжигдэнэ. Ингэхдээ төсөвлөсөн нэгжийн кредит аргыг ашиглана. Тооцооллын үр дүн компанид өгөөжтэй гарсан тохиолдолд хүлээн зөвшөөрөгдөх хөрөнгийн дүн нь хөтөлбөрөөс ирээдүйд буцаан авах эсвэл ирээдүйд төлөх шимтгэлийн дүнг бууруулах зэрэг эдийн засгийн өгөөжийн өнөөгийн үнэ цэнээс хэтрэх ёсгүй.

Үйлчилгээний зардал болон тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр(хөрөнгө)-н хүүгийн цэвэр зардал/(орлого)-г ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч холбогдох функцүүдэд буюу “борлуулалтын өртөг”, “борлуулалт, түгээлтийн зардал” эсвэл “удирдлага, захиргааны зардал”-д хуваарилан бүртгэнэ. Тайлант үеийн үйлчилгээний зардал нь ажиллагсдын тайлант үед үзүүлсэн үйлчилгээтэй холбоотойгоор тогтоосон тэтгэмжийн өр төлбөрийн өсөлтийн өнөөгийн үнэ цэнээр хэмжигдэнэ.

Тэтгэмжийн хөтөлбөрт өөрчлөлт орсон эсвэл томоохон хэмжээний цомхотгол хийгдсэн тохиолдолд ажиллагсдын өмнөх үеүдийн үйлчилгээтэй холбогдох тэтгэмжийн өөрчлөлт болон цомхотголтой холбоотой олз, гарзыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөхдөө хөтөлбөр өөрчлөгдсөн, цомхотгол хийгдсэн эсвэл холбогдох дахин зохион байгуулалтын өртөг, хөдөлмөр эрхлэлт дуусгавар болох үеийн олговрыг хүлээн зөвшөөрсөн хугацааны аль эхний огноогоор бүртгэлд тусгана.


Тухайн тайлант хугацааны хүүгийн цэвэр зардал/(орлого)-г тодорхойлохдоо тайлант хугацааны эхэнд тогтоосон тэтгэмжийн үүргийн өр төлбөрийг хэмжихэд хэрэглэгдсэн дискаунтын хүүгийн түвшинг ашиглан тооцно. Уг хүү нь ойролцоо дуусах хугацаатай, зээлжих зэрэглэл өндөртэй корпорацийн бондын тайлант үеийн эцэс дэх өгөөжийн хувь байна.

Тогтоосон тэтгэвэр тэтгэмжийн хөтөлбөрийн дахин хэмжилтийн үр дүнг бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх ба шууд хуримтлагдсан ашигт хааж бүртгэнэ. Дахин хэмжилтийн үр дүнд актуар олз ба гарз, төлөвлөгөөт хөрөнгөөс үүдэлтэй орлого болон тогтоосон тэтгэмжийн хөрөнгийн хүлээн зөвшөөрөгдөх дээд хязгаарын өөрчлөлттэй холбоотой өөрчлөлт (тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-н хүүгийн цэвэр зардал (орлого)-г хассанаар) зэргээс бүрдэнэ.

г) Бусад урт хугацаат олговор

Ажиллагсдын тайлант болон өмнөх үеүдэд үзүүлсэн үйлчилгээний төлөө ирээдүйд олгох дүнгийн өнөөгийн үнэ цэнээр компанийн ажиллагсдын урт хугацаат олговрын өр төлбөрийн цэвэр дүн хэмжигдэнэ.

д) Хөдөлмөр эрхлэлт дуусгавар болох үеийн олговор



Ашид Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

Компани хөдөлмөр эрхлэлт дуусгавар болох үеийн олговрыг олгох саналаа буцаан татах боломжгүй болсон эсвэл дахин зохион байгуулалттай холбогдох зардлыг хүлээн зөвшөөрөх үе хоёрын аль түрүүнд тохиолдсон өдрөөр зардлаар хүлээн зөвшөөрнө. Хэрэв олговор нь тайлангийн өдрөөс хойш 12 сарын дотор бүхэлдээ төлөгдөхөөргүй бол олговрын дүнг дискаунтчилан бүртгэлд тусгана.

Й. Сан

Дараах нөхцөлүүдийг зэрэг хангасан тохиолдолд санг хүлээн зөвшөөрнө:

- Өнгөрсөн үйл явдлын үр дүнд одоогийн (хуулиар хүлээсэн эсвэл гэрээний бус) үүрэгтэй байх;
- Үүргийг барагдуулахад шаардлагатай эдийн засгийн үр өгөөж бүхий нөөцийг зарцуулах магадлалтай байх (магадлал >50%);
- Үүргийн дүнгийн талаар найдвартай тооцоолол хийж чадахаар байх;

Хүлээгдэж буй мөнгөн урсгалыг мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн зах зээлийн өнөөгийн үнэлгээ болон тухайн өр төлбөрийн эрсдэлийг тусгасан татварын өмнөх хүүгийн түвшингээр дискаунтчилсан дүнгээр сангийн дүнг хэмждэг. Тайлант хугацаа бүрийн эцэст санг дахин хянаж тооцоолдог. Санг нэмэгдүүлсэн, бууруулсан дискаунтчилсан дүнгээр санхүүгийн зардал хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

К. Түрээс

а) Түрээсийг тодорхойлох

Гэрээ эсвэл гэрээний нэг хэсэг нь төлбөрийн хариуд хөрөнгийг ашиглах эрхийг тодорхой хугацааны турш олгодог бол түүнийг Компани түрээс гэж үздэг. Түрээс гэдэг нь дараах шалгууруудыг хангасан гэрээ юм:


- Тодорхойлсон хөрөнгөтэй;
- Хөрөнгийн ашиглалтаас үүсэх эдийн засгийн бараг бүх үр өгөөжийг Компани хүртдэг; ба
- Компани хөрөнгийг ашиглалтыг удирдан чиглүүлэх эрхтэй.

Бэлтгэн нийлүүлэгч тухайн түрээсийн хөрөнгийг солих, орлуулах эрхтэй эсэхийг Компани харгалзан үзэх ба хэрэв тийм бол тухайн гэрээг түрээсийн гэрээ гэж үзэхгүй.

Хөрөнгийн ашиглалтаас үүсэх эдийн засгийн бараг бүх үр өгөөжийг Компани хүртэх эрхтэй эсэхийг тодорхойлохдоо Компани нь хууль ёсны эзэмшил эсвэл бусад боломжит үр өгөөжтэй хамааралтай бус харин зөвхөн хөрөнгийн ашиглалтаас үүсэх эдийн засгийн үр өгөөжийг л авч үзнэ.

Компани нь хөрөнгийн ашиглалтыг удирдан чиглүүлэх эрхтэй эсэхийг тодорхойлохдоо ашиглалтын хугацааны туршид хөрөнгийг хэрхэн, ямар зорилгоор ашиглахаа удирдан чиглүүлэх эрхтэй эсэхийг харгалзан үзнэ. Хөрөнгийн шинж чанарын улмаас шийдвэр нь урьдчилан тодорхойлогдсон тул тухайн хөрөнгийг хэрхэн, ямар зорилгоор ашиглахтай холбоотой хамгийн их хамааралтай шийдвэр гаргахгүй байх үед Компани нь хөрөнгийн загварыг гаргах үед ашиглалтын хугацааны турш хөрөнгийг хэрхэн, ямар зорилгоор ашиглахыг урьдчилан тодорхойлох байдлаар оролцсон эсэхийг харгалзан үзнэ. Хэрэв гэрээ эсвэл гэрээний нэг хэсэг нь эдгээр шалгуурыг хангахгүй бол Компани СТОУС 16-гаас бусад холбогдох СТОУС-ын мөрдөнө.

20



2023.08.18

Ашид Капитал ББСБ ХХК

Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

б) Түрээсийн ангилал

Дараах түрээсийг үйл ажиллагааны түрээсээр бүртгэх бөгөөд бусад бүх түрээсийг ашиглах эрхтэй хөрөнгө ба түрээсийн өр төлбөр хүлээн зөвшөөрөх замаар бүртгэнэ:

- Бага үнэ цэнэтэй хөрөнгийн түрээс; ба
- 12 сар эсвэл түүнээс бага хугацаатай түрээс.

Түрээслүүлэгчид төлөх гэрээний төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр түрээсийн өр төлбөрийг хэмжинэ. Түрээсийн нуугдмал хүүгийн түвшнийг шууд тодорхойлох боломжит бол уг түвшнийг ашигласнаар түрээсийн төлбөрийг дискаунтчилна. Хэрэв тэрхүү түвшнийг шууд тодорхойлох боломжгүй бол Компани эзэлийн өсөн нэмэгдэх хүүгийн түвшнийг ашиглана.

Зөвхөн индекс эсвэл хувь хэмжээнээс хамааралтай л бол түрээсийн хувьсах төлбөрийг түрээсийн өр төлбөрийн хэмжилтэд оруулна. Ийм үед түрээсийн өр төлбөрийг анх хэмжихдээ хувьсах элементүүд нь түрээсийн хугацаанд өөрчлөгдөхгүй гэж төсөөлдөг. Түрээсийн бусад хувьсах төлбөрүүдийг гарсан үед нь зардлаар хүлээн зөвшөөрнө.

Анхны хүлээн зөвшөөрөлтийн үед түрээсийн өр төлбөрийн дансны үнэд дараах зүйлс багтана:

- үлдэх өртгийн баталгааны дагуу төлөхөөр хүлээгдэж буй дүн;
- худалдан авах сонголтоо Компани хэрэгжүүлэх нь ул үндэслэлтэйгээр тодорхой бол тэрхүү сонголтыг хэрэгжүүлэх үнэ;
- түрээсийг цуцлах сонголтоо хэрэгжүүлэх талаар тухайн түрээсийн нөхцөлд тусгадаг бол түрээсийг цуцалсны улмаас төлөх торгуулийн дүн.

Ашиглах эрхтэй хөрөнгийг анх хэмжихдээ түрээсийн өр төлбөрийн дүнгээс аливаа түрээсийн урамшууллыг хасаж, дараах зүйлсийг нэмж тооцно:

- түрээсийн эхлэл өдөр эсвэл түүнээс өмнө төлсөн түрээсийн төлбөрүүд;
- компани гаргасан анхны шууд зардал; ба
- түрээсийн хөрөнгийг буулгаж нураах, холдуулж зайлуулах эсвэл нөхөн сэргээхийг гэрээгээр шаардсан бол түүнтэй холбоотой компани хүлээн зөвшөөрөх нөөцийн дүн.

Анхны хэмжилтийн дараа түрээсийн өр төлбөрийн дүн нь үлдэгдэл төлбөрийн дүнд тооцсон хүүгийн зардлын улмаас өсөж, төлсөн түрээсийн төлбөрийн дүнгээр буурна. Ашиглах эрхтэй хөрөнгийг түрээсийн үлдсэн хугацааны турш эсвэл хөрөнгийн ашиглалтын хугацаа нь түрээсийн хугацаанаас богино байх ховор тохиолдолд хөрөнгийн эдийн засгийн ашиглалтын үлдсэн хугацааны турш шулуун шугамын аргаар хорогдуулна.

Компани аливаа түрээсийн хугацааны тооцоололд өөрчлөлт оруулсан бол (жишээ нь, сунгах эсвэл цуцлах сонголтыг түрээслэгч хэрэгжүүлэх магадлалыг дахин үнэлсэн гэх мэт шалтгаанаар) шинэчлэгдсэн хугацааны турш хийх төлбөрийг илтгэхийн тулд түрээсийн өр төлбөрийн дансны үнэд тохируулга хийх бөгөөд үүнийг түрээсийн эхлэлд мөрдөж байсантай ижил дискаунтын хувь ашиглан дискаунтчилна. Хувь хэмжээ эсвэл индексээс хамааралтай ирээдүйн түрээсийн төлбөрийн хувьсах элементүүдийг шинэчилсэн бол түрээсийн өр төлбөрийн дансны үнийг ч мөн шинэчилнэ. Аль ч тохиолдолд ашиглах эрхтэй хөрөнгийн дансны үнэд зохих тохируулгыг хийх бөгөөд шинэчилсэн дансны үнийг түрээсийн үлдсэн (шинэчилсэн) хугацааны турш хорогдуулна.

21



2023.08.18

Ашид Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

Компани нь түрээслүүлэгчтэй түрээсийн гэрээний нөхцөлийг дахин хэлэлцэж байх үед гэрээнд орох өөрчлөлтийн шинж чанараас хамаарч нягтлан бодох бүртгэл нь ялгаатай байна:

- хэрэв дахин хэлцлийн үр дүнд нэмэлт хөрөнгө ашиглах эрхийн бие даасан үнэтэй дүйцэх нэг эсвэл түүнээс олон нэмэлт хөрөнгийг түрээслэхэд хүргэж байвал дээрх бодлогын дагуу уг өөрчлөлтийг тусдаа түрээс гэж бүртгэнэ;
- дахин хэлцэл нь түрээсийн хамрах хүрээг өсгөж буй бусад бүх тохиолдолд (түрээсийн хугацааг сунгасан, эсвэл нэг эсвэл түүнээс олон нэмэлт хөрөнгийг түрээслэх болсон эсэхээс үл хамааран) өөрчлөлтийн өдрөөр хамаарах дискаунтын хувийг ашиглан түрээсийн өр төлбөрийг дахин хэмжих бөгөөд ашиглах эрхтэй хөрөнгийг ижил дүнгээр залруулна;

хэрэв дахин хэлцлийн үр дүнд түрээсийн хамрах хүрээ буурахад хүрсэн тохиолдолд түрээсийн бүрэн эсвэл зарим хэсгийг цуцалсан хэмжээг илтгэхийн тулд түрээсийн өр төлбөр болон ашиглах эрхтэй хөрөнгийн аль алины дансны үнийг ижил хэмжээгээр бууруулж, аливаа үүссэн зөрүүг ашиг, алдагдалд тусгана. Үүний дараа дансны үнэ нь дахин хэлэлцсэн хугацааны турш дахин хэлэлцсэн төлбөрийн дүнг илтгэж байгаа гэдгийг бататгахын тулд түрээсийн өр төлбөрт нэмж тохируулга/залруулга хийх бөгөөд үүний тулд өөрчлөгдсөн түрээсийн төлбөрийг өөрчлөлтийн өдрөөр хамаарах хувь хэмжээг ашиглан дискаунтлана. Ашиглах эрхтэй хөрөнгийг ижил дүнгээр тохируулна.

Л. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээ

Тайлант хугацаанд гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээ хийгдсэн өдрийн Монгол Банкнаас зарласан албан ханшаар хөрвүүлэн бүртгэнэ.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйл болох хөрөнгө болон өр төлбөрийг тайлангийн өдрийн Монгол Банкнаас зарласан албан ханшийг ашиглан бүртгэлийн валютад хөрвүүлнэ. Түүхэн өртөг нь гадаад валютаар тооцогдсон мөнгөн бус зүйлсийг хаалтын ханшаар хөрвүүлэхгүй.


Бодит үнэ цэнээр хэмжигддэг мөнгөн бус зүйлс болох хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнэ гадаад валютаар тооцогдсон бол уг тооцоолол хийгдсэн өдрийн албан ханшийг ашиглан бүртгэлийн валютад хөрвүүлнэ. Гадаад валютын ханшийн зөрүү ихэвчлэн ашиг, алдагдлаар бүртгэгддэг.

Гэхдээ дараах зүйлсийг бүртгэлийн валютад хөрвүүлэхэд үүсэх ханшийн зөрүүг бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрнө:

- Борлуулахад бэлэн байгаа өмчийн хөрөнгө оруулалт (гэхдээ хөрөнгийн үнэ цэнэ нь буурснаас бусад үед, учир нь үнэ цэнийн бууралтын үед өмнө нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдсөн ханшийн зөрүүг тайлант үеийн ашиг, алдагдалд хаадаг);
- Гадаад үйл ажиллагаан дахь цэвэр хөрөнгө оруулалтын хэйджээр тодорхойлогдсон санхүүгийн өр төлбөр (гэхдээ хэйдж нь үр дүнтэй байгаа хүртэлх хэмжээгээр);

2020 оны 12 дугаар сарын 31-ний гадаад валютаар илэрхийлэгдсэн үлдэгдлийг хөрвүүлэхэд ашигласан үндсэн ханш 1 ам.доллар=2,849.51 төгрөг (2019: 1 ам.доллар=2,733.52 төгрөг) байсан.





*Ашид Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31*

М. Санхүүгийн орлого болон санхүүгийн зардал

Санхүүгийн орлого нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх хүүгийн орлогоос бүрдэнэ. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан тооцож, аккрузал сууриар бүртгэнэ.

Санхүүгийн зардалд зээлийн хүүгийн зардал болон санг буцаах дискаунтчиллын дүн тус тус орно. Гадаад валютаар илэрхийлэгдсэн зээлийн өр төлбөрийн ханшийн зөрүүг гадаад валютын ханшийн цэвэр өсөлт, бууралтаас шалтгаалан, цэвэр дүнгээр нь санхүүгийн орлого эсвэл санхүүгийн зардлаар хүлээн зөвшөөрнө.

Н. Зээлийн өртөг

Зориулалтын дагуу ашиглаж эхлэхэд тодорхой хугацаа, бэлтгэл ажиллагаа шаардагдах хөрөнгийн худалдан авалт, бүтээн байгуулалт эсвэл үйлдвэрлэлд шууд хамаарах зээлийн өртгийг тухайн хөрөнгийн өртөгт капиталжуулна. Бусад зээлийн өртгийг гарсан тайлант хугацааны ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Зээлийн хүүгийн зардал гарсан, бэлтгэл ажиллагаа шаардагдах хөрөнгөтэй холбоотой зарцуулалт хийгдэж эхэлсэн, болон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, худалдахад бэлэн болгохтой холбоотой үйл ажиллагаа явагдаж эхэлсэн өдрөөс эхлэн зээлийн зардлыг хөрөнгийн өртөгт капиталжуулж эхэлнэ. Хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, худалдахад бэлэн болгохтой холбоотой үйл ажиллагаа түр саатах эсвэл бүрмөсөн дуусахад зээлийн зардлыг хөрөнгийн өртөгт капиталжуулахыг мөн адил түр эсвэл бүр зогсооно.

О. Орлогын албан татвар

Тайлант хугацааны орлогын албан татварын зардал нь тухайн тайлант хугацааны татвар болон хойшлогдсон татварын хөрөнгө болон өр төлбөрийн өөрчлөлтөөс бүрддэг. Тайлант хугацааны орлогын албан татварыг үндсэнд нь тайлант хугацааны ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг боловч бусад дэлгэрэнгүй орлогоор эсвэл шууд өмчийн хэсэгт хүлээн зөвшөөрөгдөх ажил гүйлгээтэй холбогдох татварыг харгалзан бусад дэлгэрэнгүй орлогоор эсвэл шууд өмчийн хэсэгт тус тус хүлээн зөвшөөрнө.

а) Тайлант хугацааны татвар

Тайлант жилийн татвар ногдох орлого нь тайлант хугацааны эцсээр хэрэглэж байгаа эсвэл хэрэглэх нь тодорхой болсон татварын хувийг ашиглан тооцсон татвар болон өмнөх тайлант жилүүдийн татварын ногдуулалтанд хийсэн тохируулгыг оруулан төлөхөөр хүлээгдэж буй нийт дүнгээс бүрдэнэ.

Тайлант хугацааны татварын хөрөнгө болон өр төлбөрийг зөвхөн тодорхой шаардлагуудыг хангасан нөхцөлд хооронд нь хааж, цэвэр дүнгээр толилуулдаг.

б) Хойшлогдсон татвар

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр нь санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгө эсвэл өр төлбөрийн дансны дүн болон тэдгээрийн татварын суурийн зөрүүтэй холбоотой ирээдүйд татвар ногдох орлогоос хасагдах болон татвар ногдох түр зөрүүнээс бий болдог. Мөн түүнчлэн татварын тайлангаар



**Ашигт Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31**

гарсан алдагдал болон ашиглагдаагүй татварын хөнгөлөлттэй холбоотой хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрдөг.

Цөөн тооны тодорхой заалтаас бусад тохиолдолд, ирээдүйд татвар ногдох эсвэл татвар ногдох орлогоос хасагдах магадлалтай бүх зөрүүгийн хувьд хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Хасагдах түр зөрүүтэй холбоотой хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрөх үндэслэл болох ирээдүйн татвар ногдох орлогод одоо байгаа татвар ногдох түр зөрүүгийн буцаалтыг оруулан тооцдог ба эдгээр татвар ногдох түр зөрүүнүүд нь нэг татварын байгууллага, нэг аж ахуйн нэгжид хамааралтай байх ёстой. Татварын тайлангаар гарсан алдагдал болон ашиглагдаагүй татварын хөнгөлөлт нь нэг татварын байгууллага, нэг аж ахуйн нэгжид хамаарах ба эдгээрийг ашиглах боломжтой тайлант үе, үеүдэд хангалттай хэмжээний татвар ногдох орлого (одоо байгаа татвар ногдох түр зөрүүг оруулан тооцсоноор)-той ажиллахаар хүлээгдэж байгаа нөхцөлд холбогдох хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн болон татварын тайлагналын аль алинд хүлээн зөвшөөрч бүртгэгддэггүй хоролго болон өр төлбөр (бизнесийн нэгдлийн нэг хэсэг биш), татварын зорилгоор хасагдахгүй гүүдвил, охин компанид оруулсан хөрөнгө оруулалттай холбоотой үүссэн түр зөрүү болон Компани татварын түр зөрүүг буцаах цаг хугацааг хянах боломжтой боловч түр зөрүү нь ойрын ирээдүйд буцаагдахааргүй, эсвэл ирээдүйд татвар ногдох орлогоос хасагдах магадлалтайгаас бусад татвар ногдох орлогоос хасагдах зөрүүтэй холбоотой хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр хүлээн зөвшөөрөхөд тавигддаг тодорхой хязгаарлалт, заалтууд байдаг.

Бүртгэлийн бодлогын дагуу ХОЗҮХХ-ийг бодит үнэ цэнээр хэмжсэнтэй холбоотой үүссэн түр зөрүү нь элэгдлээр дамжин татварын зорилгоор хасагдах тул холбогдох хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг уг хөрөнгийн хүлээгдэж буй хэрэглээ, төлөгдөх хэлбэрээс үл хамааран хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгана. Харин бусад бүх тохиолдлуудад, хойшлогдсон татварын хөрөнгийг хөрөнгө, өр төлбөрийн дансны дүнгийн хэрэгжих, төлж барагдуулахаар хүлээгдэж буй хэлбэр дээр үндэслэн тайлант хугацааны эцсээр хэрэглэж байгаа эсвэл хэрэглэх нь тодорхой болсон татварын хувийг ашиглан тооцоолно. Хойшлогдсон татварын хөрөнгө болон өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр хэмжихгүй.

Тайлант жил бүрийн эцэст хойшлогдсон татварын хөрөнгийг эргэн хянах ба уг хөрөнгийн өгөөжийг хүртэх боломжийг олгохуйц хэмжээний татвар ногдох орлого олох магадлалгүй болсон тохиолдолд холбогдох дансны дүнг бууруулан бүртгэнэ. Харин хангалттай хэмжээний татвар ногдох орлого олох магадлалтай болсон нөхцөлд өмнө бууруулсан дүнг буцаан дансны дүнг өсгөж бүртгэнэ.


Ногдол ашиг хуваарилсантай холбогдох орлогын албан татварыг ногдол ашгийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөн үед хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын хөрөнгө болон өр төлбөрийг зөвхөн тодорхой шаардлагуудыг хангасан тохиолдол л хооронд нь хааж, цэвэр дүнгээр толилуулдаг.

в) Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)

Борлуулалтад ногдуулсан НӨАТ-ын өглөг нь (а) харилцагчид НӨАТ-н падаан бичиж өгсөн, (б) харилцагчаас авлагаа цуглуулан авсан, эсвэл (в) харилцагчид бараа, үйлчилгээг хүргэн өгсөн өдрүүдийн аль түрүүлж тохиосон өдрөөр татварын байгууллагад төлөхөөр хүлээн зөвшөөрсөн өглөг юм. Худалдан





Ашид Капитал ББСБ ХХК

Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

авалтад төлсөн НӨАТ-ыг мөнгөөр төлсөн үед НӨАТ-ын баримтанд үндэслэн борлуулалтын НӨАТ-аас хасч тооцох боломжтой. Татварын байгууллагууд НӨАТ-ыг цэвэр дүнгээр төлж барагдуулахыг зөвшөөрдөг. Борлуулалт, худалдан авалтын НӨАТ-ыг хооронд нь хааж, санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр тодлуулдаг.

г) Татварын тодорхой бус байр суурь

Удирдлага компанийн хувьд татварын тодорхой бус байр суурийг тайлант хугацааны эцэс бүрд дахин хянаж үздэг. Удирдлагын зүгээс татварын байгууллага нь компанийн орлогын татварын байр суурийг хүлээн зөвшөөрөхгүйн улмаас нэмэлт татвар ногдуулах магадлал нь ногдуулахгүй байх магадлалаас өндөр гэж үзсэн тохиолдолд өр төлбөр хүлээн зөвшөөрнө.

Уг үнэлгээг тайлант хугацааны эцсээрх бүхэлдээ буюу үндсэндээ хэрэгжиж буй хууль тогтоомжийн тайлбар, мөн шүүх байгууллагын ижил төстэй маргааныг шийдвэрлэсэн байдал зэрэг дээр үндэслэдэг. Торгууль, алданги болон орлогын бус татвартай холбоотой өглөгийн хувьд, удирдлага тайлант хугацааны эцэс дэх өр төлбөрийг барагдуулахад шаардагдах зардлыг хамгийн найдвартайгаар хэмжин, санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрдөг.

Монгол улсын татвар, мөнгөн тэмдэгт болон гаалийн тухай хууль тогтоомжууд нь өөр хоорондоо зөрүүтэйгээр тайлбарлагдах хандлагатай байдаг. Тодруулга 20-ийг харна уу.

Ө. Хувь нийлүүлсэн хөрөнгө

а) Энгийн хувьцаа

Энгийн хувьцаа гаргахтай холбоотой гарсан шууд зардлыг татварын нөлөөг хассан дүнгээр өмчийн хэсэгт хасах дүнгээр тусгана.


б) Давуу эрхтэй хувьцаа

Компани давуу эрхтэй хувьцаанд ногдол ашиг заавал төлөх, мөн эзэмшигч буюу нөгөө талын хүсэлтээр мөнгөөр эргүүлэн худалдан авах үүрэгтэй бол уг давуу эрхтэй хувьцааг санхүүгийн өр төлбөрөөр ангилна. Заавал төлөгдөх ногдол ашгийг аккруэлдсэн тухай бүрд санхүүгийн зардалд ангилан ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Давуу эрхтэй хувьцаанд ногдол ашиг зарлах үгүйг компани дангаараа шийддэг, мөнгө болон санхүүгийн бусад хөрөнгийг шилжүүлэх эсвэл хувьсах тоо ширхэг бүхий компанийн өмчийн хэрэглүүрээр төлж барагдуулж буцаан худалдан авах үүрэг хүлээгээгүй давуу эрхтэй хувьцааг өмчөөр ангилж бүртгэнэ. Хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрснөөр ногдол ашгийг зарлаж, хүлээн зөвшөөрнө.

в) Халаасны хувьцаа

Хүлээн зөвшөөрч өмчөөр бүртгэгдсэн өөрийн хувьцаанаас эргүүлэн худалдан авсан бол татварын нөлөөллийг тооцож хасан, шууд холбогдох зардлуудыг оруулан нийт төлсөн дүнгээр өмчийг бууруулан бүртгэнэ. Эргүүлэн худалдан авсан хувьцааг халаасны хувьцаа гэж ангилах ба өмчийн нөөц



Ашид Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

хэсэгт толилуулна. Халаасны хувьцааг эргүүлэн худалдах эсвэл буцаан эргэлтэнд оруулах үед хүлээн авсан дүнгээр өмчийг өсгөх ба холбогдох зөрүүг хувьцааны урамшуулалд хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

д) Ногдол ашиг

Ногдол ашгийг зарлаж, батлагдсан тайлант хугацаанд нь өр төлбөрөөр хүлээн зөвшөөрч, өмчийг бууруулан бүртгэнэ. Тайлант хугацаа дуусгавар болсны дараа, санхүүгийн тайланг хэвлэн нийтлэхийг зөвшөөрөхөөс өмнө зарлагдсан ногдол ашгийг тайлагналын өдрийн дараах үйл явдлаар тодруулна.

П. Хамаатай талууд

а) Хувь хүн эсвэл түүний ойр дотны гэр бүлийн гишүүнийг дараах тохиолдлуудад компанийн хувьд хамаатай тал гэж үзнэ. Хувь хүн нь:

- (i) компанийг хянадаг эсвэл хамтын хяналттай бол;
- (ii) компанид мэдэгдэхүйц нөлөөтэй бол; эсвэл
- (iii) компани эсвэл түүний толгой компанийн гол албан тушаалтны нэг бол.

Компанитай хийх хэлцэлд өөрөө болон уг хувь хүнээр дамжуулан нөлөө үзүүлэх магадлалтай гэр бүлийн гишүүдийг ойр дотны гэр бүлийн гишүүнд тооцно.

б) Компанийг дараах тохиолдлуудад нөгөө компанийн хамаатай тал гэж үзнэ:

- (i) Нэг групп компанийн гишүүд хоорондоо хамаатай талууд байна;
- (ii) Компани нь нөгөө компанийнхаа хараат компани эсвэл хамтарсан хөрөнгө оруулалттай компани бол (эсвэл компани нь нөгөө компанийн харьяалагддаг группийн өөр нэг гишүүн компанийн хараат компани эсвэл хамтарсан хөрөнгө оруулалттай компани бол);
- (iii) Хоёр компани хоёулаа нэг ижил гуравдагч талын хамтарсан хөрөнгө оруулалттай компаниуд бол;
- (iv) Компани нь гуравдагч талын хамтарсан хөрөнгө оруулалттай компани ба нөгөө компани нь уг гуравдагч талын хараат компани бол;
- (v) Компани нь нөгөө компанийн эсвэл түүнтэй хамаатай компанийн ажиллагсдын ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хөтөлбөрийн үйл ажиллагааг эрхэлдэг бол;
- (vi) (а)-д тодорхойлогдсон хувь хүн нөгөө компанид хяналт эсвэл хамтын хяналттай бол; эсвэл
- (vii) (а)(i)-д тодорхойлогдсон хувь хүн нөгөө компанид мэдэгдэхүйц нөлөөтэй, эсвэл нөгөө компани эсвэл түүний толгой компанийн гол албан тушаалтны нэг бол.

Р. Санхүүгийн тайланг хэвлэн нийтэлсний дараа өөрчлөлт оруулах тухай

Компанийн Захирлуудын Зөвлөл санхүүгийн тайланг хэвлэн нийтэлсний дараа өөрчлөлт оруулах бүрэн эрхтэй болно.





[Handwritten signature]

[Handwritten signature]



2023.08.18



**Ашид Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31**

С. Толилуулгын өөрчлөлтүүд

Шаардлагатай тохиолдлуудад, өмнөх тайлант хугацааны зэрэгцүүлэгдэх мэдээллийг энэ тайлант хугацааны толилуулгатай нийцүүлэн өөрчилсөн. Одоогоор толилуулгын өөрчлөлт байхгүй болно.

5. Нягтлан бодох бүртгэлийн тооцооллууд болон Хэмжилтийн суурь

а) Нягтлан бодох бүртгэлийн үндсэн үнэлэмж, тооцоолол болон таамаглал

СТОУС-д нийцсэн санхүүгийн тайлан бэлтгэхтэй холбоотойгоор нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэх явцад санхүүгийн тайланд толилуулагдсан хөрөнгө, өр төлбөр, орлого болон зардлын дүнд нөлөөлөхүйц үнэлэмж, тооцоолол, болон таамаглалыг удирдлагын зүгээс хийх шаардлагатай байдаг. Бодит үр дүн нь эдгээр тооцоолоос ялгаатай байж болно.

Тооцоолол болон үндсэн таамаглалуудыг тасралтгүй эргэн харж, хянана. Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтийг ирээдүйд мөрдөх горимыг баримтлан бүртгэлд тусгана.

i. Үнэлэмж

Компанийн санхүүгийн тайланд толилуулагдсан зүйлсийн дүнгүүдэд хамгийн их нөлөө үзүүлэх, нягтлан бодох бүртгэлийн бодлогын хүрээнд хийгдсэн үнэлэмжийн талаарх мэдээллийг дараах тодруулгуудаас харна уу:

- Тодруулга 9 – Биет бус хөрөнгө
- Тодруулга 11 – Харилцагчид олгосон зээл ба урьдчилгаа
- Тодруулга 21 – Санхүүгийн хэрэглүүр – Санхүүгийн эрсдэлийн удирдлага

ii. Таамаглал ба тооцоолол

2020 оны 12 дугаар сарын 31-р дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн хувьд материаллаг хэмжээний залруулга хийгдэх шаардлагыг бий болгох эрсдэл бүхий таамаглал болон тооцооллын талаарх мэдээллийг дараах тодруулгуудаас харна уу.

- Тодруулга 24 – Сан болон болзошгүй өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт: эдийн засгийн өгөөж бүхий нөөцийн гадагшлах урсгалын магадлал болон дүнг тооцоолоход ашигласан үндсэн таамаглалууд.

б) Хэмжилтийн суурь

Компани санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ доор дурдсанаас бусад зүйлсийн хувьд түүхэн өртгөөр бүртгэх зарчмыг баримталсан:

- Анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр бүртгэгддэг санхүүгийн хэрэглүүрүүд;
- Дахин үнэлэгдсэн дүнгээр хэмжигддэг өөрийн хэрэгцээнд ашигладаг барилга байгууламж; болон
- Бодит үнэ цэнээр хэмжигддэг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө.
- Дискаунтчилсан өнөөгийн үнэ цэнээс бодит үнэ цэнийг хассан тэтгэмжийн нөөц



Ашигт Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

6. Шинэ болон өөрчлөгдсөн стандарт болон тайлбаруудын хэрэгжилт

Компани нь 2020 оны 01 сарын 01-ний өдрөөс эхэлсэн тайлант хугацаанд доорх шинэ стандарт болон өөрчлөлтүүдийг анх удаа мөрдөж эхэлсэн:

Шинэ болон өөрчлөгдсөн стандартууд	Дараах өдрөөс хойших санхүүгийн жилээс хучин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ
Нэмэлт өөрчлөлт, СТОУС 3 Бизнесийн Нэгдэл: Бизнесийн тодорхойлолт	2020 оны 1-р сарын 1
Нэмэлт өөрчлөлт, НББОУС 1 Санхүүгийн Тайлангийн Толилуулга ба НББОУС 8 Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа: Материаллаг байдлын тодорхойлолт	2020 оны 1-р сарын 1
Нэмэлт өөрчлөлт, СТОУС 9 Санхүүгийн Хэрэглүүр, НББОУС 39 Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба Хэмжилт, СТОУС 7 Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга: Жишиг хүүний түвшиний шинэчлэл—1-р үе шат	2020 оны 1-р сарын 1
Нэмэлт өөрчлөлт, СТОУС 16 Түрээс: Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлт	2020 оны 6-р сарын 1

Компани нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг анх мөрдөж эхлэх үеийн нөлөөлөл, нөлөөллийн үнэлгээг хийсэн ба мэдэгдэхүйц нөлөөллийн дэлгэрэнгүйг доор тодруулав.

Нэмэлт өөрчлөлт, СТОУС 3 Бизнесийн Нэгдэл: Бизнесийн тодорхойлолт

"Бизнесийн тодорхойлолт" (2018 оны 10 дугаар сард батлагдсан ба 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших тайлант хугацаанд мөрдөгдөж эхэлсэн).

Уг нэмэлт өөрчлөлт нь санхүүгийн тайланд нөлөөлөөгүй.

Нэмэлт өөрчлөлт, НББОУС 1 Санхүүгийн Тайлангийн Толилуулга ба НББОУС 8 Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа: Материаллаг байдлын тодорхойлолт

"Материаллаг байдлын тодорхойлолт" (2018 оны 10 дугаар сард батлагдсан ба 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших тайлант хугацаанд мөрдөгдөж эхэлсэн).

Компанийн санхүүгийн тайлангийн гол хэрэглэгчдийн тус тайлан дахь мэдээллийг ашиглан гаргадаг аливаа шийдвэрт нөлөөлөх материаллаг байдлыг НББОУС 1 болон НББОУС 8-д шинээр тодорхойлсны дагуу буюу аливаа мэдээллийг

- Орхигдуулсан

Ашид Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

- Буруу илэрхийлсэн
- Тодорхойгүй болгосон ажил гүйлгээ, үйл явдал үүссэн эсэхийг үнэлэн тодорхойлж материаллаг буруу илэрхийлэлгүйгээр санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэсэн болно.

Нэмэлт өөрчлөлт, СТОУС 9 Санхүүгийн Хэрэглүүр, НББОУС 39 Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба Хэмжилт, СТОУС 7 Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга: Жишиг хүүний түвшний шинэчлэл—1-р үе шат

"Жишиг хүүний түвшний шинэчлэл—1-р үе шат" (2019 оны 09 дүгээр сард батлагдсан ба 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш түр хугацаагаар мөрдөгдөж эхэлсэн).

Уг нэмэлт өөрчлөлт нь санхүүгийн тайланд нөлөөлөөгүй.

Нэмэлт өөрчлөлт, СТОУС 16 Түрээс: Ковид-19-тэй холбоотой түрээсийн хонгололт

"Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлт" (2020 оны 05 дугаар сард батлагдсан ба 2020 оны 06 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш түр хугацаагаар мөрдөгдөж эхэлсэн).

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор цөөнгүй түрээслүүлэгчид түрээсийн хөнгөлөлт үзүүлж эхэлсэн. Эдгээр түрээсийн хөнгөлөлтүүдийг СТОУС 16-ын дагуу бүртгэх нь нарийн төвөгтэй байсан учир 2020 оны 5-р сард Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл СТОУС 16-ын нэмэлт өөрчлөлт болох "Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлт"-ийг баталж гаргасан. Уг нэмэлт өөрчлөлт нь Ковид-19 цар тахлын шууд нөлөөгөөр эдэлж буй түрээсийн хөнгөлөлтийг түрээсийн өөрчлөлтөөр бүртгэхгүй байх сонголт бүхий практик чөлөөлөлтийг түрээслэгчдэд олгосон. Компанид уг өөрчлөлтөд хамрагдсан ажил гүйлгээ байгаагүй.

7. Нягтлан бодох бүртгэлийн шинэ мэдэгдлүүд

2020 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жилийн тусдаа санхүүгийн тайланд авч хэрэглэгдээгүй боловч цаашид Компанийн тусдаа санхүүгийн тайланд нөлөө үзүүлж болзошгүй шинэ стандарт, өөрчлөлтүүдийг жагсаавал дараах байдалтай байна.

Шинэ болон өөрчлөгдсөн стандартууд	Дараах өдрөөс хойших санхүүгийн жилээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ
Нэмэлт өөрчлөлт, СТОУС 9 Санхүүгийн Хэрэглүүр, НББОУС 39 Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба Хэмжилт, СТОУС 7 Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга, СТОУС 4 Даатгалын Гэрээ, СТОУС 16 Түрээс: Жишиг хүүний түвшний шинэчлэл—2-р үе шат	2021 оны 1-р сарын 1
Нэмэлт өөрчлөлт, СТОУС 9, Санхүүгийн Хэрэглүүр: Санхүүгийн өр талбөрийн үл хүлээн зөвшөөрөлтийн '10 хувийн' төстийн тооцоололд оруулах хураамж	2022 оны 1-р сарын 1



Ашид Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

Нэмэлт өөрчлөлт, НББОУС 37, Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Хөрөнгө: Алдагдалтай гэрээ—гэрээг биелүүлэх зардал	2022 оны 1-р сарын 1
Нэмэлт өөрчлөлт, НББОУС 16, Өмч, Барилга, Тоног Төхөөрөмж: Зориулалтын дагуу хэрэглэхээс өмнө олсон орлого	2022 оны 1-р сарын 1
Нэмэлт өөрчлөлт, СТОУС 1, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартыг Анх Удаа Хэрэгжүүлэх нь: Стандартыг анх удаа хэрэгжүүлж буй охин компани	2022 оны 1-р сарын 1
Нэмэлт өөрчлөлт, НББОУС 41, Хөдөө Аж Ахуй: Бодит үнэ цэнийн хэмжилтэн дэх татвар	2022 оны 1-р сарын 1
Нэмэлт өөрчлөлт, СТОУС 3, Бизнесийн Нэгдэл: Онолын үзэл баримтлал руу холбосон холбоосын шинэчлэл	2022 оны 1-р сарын 1

Компани нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг анх мөрдөж эхлэх үеийн нөлөөллийн үнэлгээ хийж шатандаа явж байна. Одоогийн байдлаар Компани нь тусдаа санхүүгийн тайланд мэдэгдэхүйц нөлөө үзүүлж болох нэмэлт өөрчлөлтүүдийн зарим асуудлыг тодорхойлсон. Хүлээгдэж буй нөлөөллийн дэлгэрэнгүйг доор тодруулав.

Нэмэлт өөрчлөлт, СТОУС 9 Санхүүгийн Хэрэглүүр, НББОУС 39 Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба Хэмжилт, СТОУС 7 Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга, СТОУС 4 Даатгалын Гэрээ, СТОУС 16 Түрээс: Жишиг хүүний түвшний шинэчлэл—2-р үе шат


"Жишиг хүүний түвшний шинэчлэл—2-р үе шат" (2020 оны 08 дугаар сард батлагдсан ба 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш түр хугацаагаар мөрдөгдөж эхэлсэн).

Жишиг хүүний түвшний шинэчлэлээс үүдэлтэй тодорхойгүй байдал шийдэгдэх хүртэл хейджийн нягтлан бодох бүртгэлийн тодорхой шаардлагуудаас түр хугацаагаар чөлөөлөх зорилгоор хоёр үе шаттайгаар стандартуудад өөрчлөлт оруулсан. 2020 оны 8-р сард Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл "Жишиг Хүүний Түвшний Шинэчлэл—2-р үе шат"-ыг баталж гаргасан бөгөөд үр дүнд нь СТОУС 9, НББОУС 39, СТОУС 7, СТОУС 4 болон СТОУС 16-д нэмэлт өөрчлөлт орсон.

Нэмэлт өөрчлөлтөөр хейджийн нягтлан бодох бүртгэлд дараах өөрчлөлтүүд орно:

- Үр ашигт хүүг өөрчлөх замаар шинэчлэлийн үр дүнд гэрээний мөнгөн гүйлгээнд орсон өөрчлөлтийг бүртгэх;
- Шинэчлэлээс үүдэн хейджийн зүйл болон хейджийн хэрэглүүрт өөрчлөлт орох тохиолдолд хейджийн нягтлан бодох бүртгэлээ үргэлжлүүлэх;
- Шинэчлэлийн үзүүлсэн үр нөлөөг хөрөнгө оруулагчдад илүү ойлгомжтой болгохын тулд санхүүгийн тайландаа нэмэлт тодруулга хийх.

Уг нэмэлт өөрчлөлт нь санхүүгийн тайланд нөлөөлөхгүй.



Ашигт Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

Нэмэлт өөрчлөлт, СТОУС 9, Санхүүгийн Хэрэглүүр: Санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлтийн '10 хувийн' тестийн тооцоололд оруулах хураамж

"Санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлтийн '10 хувийн' тестийн тооцоололд оруулах хураамж" (2020 оны 05 дугаар сард батлагдсан ба 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших тайлант хугацаанд мөрдөгдөнө).

Шинэ эсвэл өөрчлөгдсөн санхүүгийн өр төлбөрийн нөхцөл нь анхны санхүүгийн өр төлбөрийн нөхцөлөөс эрс ялгаатай эсэхийг үнэлэх үнэлгээнд ямар хураамжийг оруулан тооцохыг тодорхой болгосон.

Нэмэлт өөрчлөлт, НББОУС 37, Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Хөрөнгө: Алдагдалтай гэрээ—гэрээг биелүүлэх зардал

"Алдагдалтай гэрээ—гэрээг биелүүлэх зардал" (2020 оны 05 дугаар сард батлагдсан ба 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших тайлант хугацаанд мөрдөгдөнө).

Гэрээ алдагдалтай эсэхийг үнэлэхийн тулд гэрээг биелүүлэх (гүйцэтгэх) зардалд ямар зардлыг оруулан тооцохыг тодорхойлсон.

Нэмэлт өөрчлөлт, НББОУС 16, Өмч, Барилга, Тоног Төхөөрөмж: Зориулалтын дагуу ашиглахаас өмнө олсон орлого

"Зориулалтын дагуу ашиглахаас өмнө олсон орлого" (2020 оны 05 дугаар сард батлагдсан ба 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших тайлант хугацаанд мөрдөгдөнө).

Хөрөнгөө бүрэн ашиглалтад оруулахаас өмнө тухайн хөрөнгийг ашиглан үйлдвэрлэсэн зүйлсийг борлуулснаар олсон орлогыг үндсэн хөрөнгийн өртгөөс суутган тооцохыг хориглосон бөгөөд ийм төрлийн орлого болон холбогдох зардлыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөхөөр заасан.

Нэмэлт өөрчлөлт, СТОУС 1, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартыг Анх Удаа Хэрэгжүүлэх нь: Стандартыг анх удаа хэрэгжүүлж буй охин компани

"Стандартыг анх удаа хэрэгжүүлж буй охин компани" (2020 оны 05 дугаар сард батлагдсан ба 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших тайлант хугацаанд мөрдөгдөнө).

Хөрвүүлэлтийн хуримтлагдсан зөрүүгийн хэмжилтэй холбоотойгоор охин компаниудад СТОУС 1-г анх удаа хэрэгжүүлэхэд нь хялбар болгож өгсөн.

Уг нэмэлт өөрчлөлт нь санхүүгийн тайланд нөлөөлөхгүй.

Нэмэлт өөрчлөлт, НББОУС 41, Хөдөө Аж Ахуй: Бодит үнэ цэнийн хэмжилтэн дэх татвар

"Бодит үнэ цэнийн хэмжилтэн дэх татвар" (2020 оны 05 дугаар сард батлагдсан ба 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших тайлант хугацаанд мөрдөгдөнө).



**Ашиг Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31**

Бодит үнэ цэнийг хэмжихдээ татварт төлсөн аливаа мөнгөн дүнг хасах шаардлагыг хүчингүй болгож бусад СТОУС-уудтай уялдуулсан.

Нэмэлт өөрчлөлт, СТОУС 3, Бизнесийн Нэгдэл: Онолын үзэл баримтлал руу холбосон холбоосын шинэчлэл

"Онолын үзэл баримтлал руу холбосон холбоосын шинэчлэл" (2020 оны 05 дугаар сард батлагдсан ба 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших тайлант хугацаанд мөрдөгдөнө).

СТОУС 3 доторх Санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлал (Conceptual Framework for Financial Reporting)-н хуучин хувилбар луу холбосон холбоосуудыг 2018 оны 3-р сард гаргасан сүүлийн хувилбар луу холбож өөрчилсөн.

Уг нэмэлт өөрчлөлт нь санхүүгийн тайланд нөлөөлөхгүй.



2023.08.18

Ашид Капитал ББСБ ХХК

8. Үндсэн хөрөнгө

а) Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн

Мянган төгрөгөөр	Тоног төхөөрөмж ба машин	Оффисын тавилга	Оффисын тоног төхөөрөмж	Нийт
Өртөг эсвэл үнэлгээ:				
2019 оны 12 дугаар сарын 31-ээрх дүн	-	-	-	-
2020 оны 1 дүгээр сарын 1-ээрх дүн	-	-	-	-
Гуравдагч компаниас худалдан авсан	-	-	8,075	8,075
Бараа материалын данснаас шилжүүлж авсан	-	-	-	-
Хамаатай талаас шилжүүлэн авсан	-	-	-	-
Өртгийн залруулга хийгдсэн	-	-	-	-
2020 оны 12 дугаар сарын 31-ээрх дүн	-	-	8,075	8,075

Мянган төгрөгөөр	Тоног төхөөрөмж ба машин	Оффисын тавилга	Оффисын тоног төхөөрөмж	Нийт
Элэгдэл болон үнэ цэнийн бууралт:				
2019 оны 12 дугаар сарын 31-ээрх дүн	-	-	-	-
2020 оны 1 дүгээр сарын 1-ээрх дүн	-	-	-	-
Тайлант хугацаанд байгуулсан элэгдэл	-	-	(462)	(462)
Өртгийн залруулга хийгдсэн	-	-	-	-
2020 оны 12 дугаар сарын 31-ээрх дүн	-	-	(462)	(462)
Дансны үнэ				
2019 оны 12 дугаар сарын 31-ээрх дүн	-	-	-	-
2020 оны 12 дугаар сарын 31-ээрх дүн	-	-	7,613	7,613

б) Үндсэн хөрөнгийн бэлтгэл ажиллагаа

Тайлант хугацааны эцэст үндсэн хөрөнгийн бэлтгэл ажиллагааны зардлын үлдэгдэлгүй болно.

в) Үнэ цэнийн бууралт

Компанийн үндсэн хөрөнгө дансанд бүртгэлтэй хөрөнгүүд нь 2020 оны эцсээр шинээр олж эзэмшсэн хөрөнгүүд бөгөөд үнэ цэнийн бууралт байхгүй болно.

г) Санхүүгийн түрээсээр түрээслүүлж буй үндсэн хөрөнгө

Тайлант хугацааны эцэст аливаа үйл санхүүгийн түрээсээр түрээслүүлж буй үндсэн хөрөнгө байхгүй болно.



Handwritten signature



Ашид Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

д) Үйл ажиллагааны түрээсээр түрээслүүлж буй үндсэн хөрөнгө

Тайлант хугацааны эцэст аливаа үйл ажиллагааны түрээсээр түрээслүүлж буй үндсэн хөрөнгө байхгүй болно.

е) Өр төлбөрийн барьцаанд байгаа үндсэн хөрөнгө

Тайлант хугацаанд аливаа өр төлбөрийн хугацаанд байгаа хөрөнгө байхгүй болно.

9. Биет бус хөрөнгө

а) Биет бус хөрөнгийн хөдөлгөөн

Мянган төгрөгөөр	Программ хангамж	Нийт
2019 оны 1 дүгээр сарын 1-ээрх дүн	-	-
Гуравдагч компаниас худалдан авсан	-	-
Худалдсан	-	-
2019 оны 12 дугаар сарын 31-ээрх дүн	-	-
Тайлант хугацааны хорогдуулга	-	-
2019 оны 12 дугаар сарын 31-ээрх дүн	-	-
2020 оны 1 дүгээр сарын 1-ээрх дүн	-	-
Гуравдагч компаниас худалдан авсан*	623,845	623,845
Худалдсан	-	-
2020 оны 12 дугаар сарын 31-ээрх дүн	623,845	623,845
Тайлант хугацааны хорогдуулга	(5,124)	(5,124)
2020 оны 12 дугаар сарын 31-ээрх дүн	618,721	618,721

*Компани тайлант хугацааны туршид Simple аппликэйшнийг хөгжүүлэхтэй холбогдон гарсан 623,845 мянган төгрөгийн хөгжүүлэлтийн зардлыг капиталжуулж, биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

Тайлант хугацааны хорогдуулгын зардал нь орлого, үр дүн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлангийн “удирдлага, захиргааны зардал”-д толилуулагдсан.



Ашигт Капитал ББСБ ХХК

10. Түрээс

а) Ашиглах эрхтэй хөрөнгө

Мянган төгрөгөөр	Барилга байгууламж ба талбай	Нийт
2020 оны 01 сарын 01	-	-
Нэмэгдсэн	129,001	129,001
Хорогдуулга	(16,794)	(16,794)
2020 оны 12 сарын 31	112,206	112,206

б) Түрээсийн өр толбор

Мянган төгрөгөөр	Барилга байгууламж ба талбай	Нийт
2020 оны 01 сарын 01	-	-
Нэмэгдсэн	129,001	129,001
Хүүгийн зардал	3,719	3,719
Түрээсийн төлбөр	(15,200)	(15,200)
2020 оны 12 сарын 31	117,520	117,520

Түрээсийн өр төлбөрийг төлөгдөх хугацаагаар доорх хүснэгтээр тодруулав.

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31		
	1 жил хүртэлх	1-5 жилийн дотор	5 жилээс дээш
Түрээсийн өр төлбөр	65,547	48,254	-

в) Ашиг алдагдалд хүлээн зөвшөөрсөн дүн

Мянган төгрөгөөр	2020	2019
Санхүүгийн түрээсийн өглөгийн хүүгийн зардал	3,719	-
Ашиглах эрхтэй хөрөнгийн давхар түрээсээс хүлээн зөвшөөрсөн бусад орлого	-	-
Богино хугацаат түрээсийн зардал	362,200	-
Бага дүнтэй түрээсийн зардал	-	-
Ашиглах эрхтэй хөрөнгийн хорогдуулга	16,794	-
Ковид-19-тэй холбоотой түрээсийн чөлөөлөлтөөр бүртгэсэн дүн	-	-



[Handwritten signatures]



Ашид Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

11. Харилцагчид олгосон зээл ба урьдчилгаа

Мянган төгрөгөөр	Нийт
2020 оны 01 сарын 01	
Зээлийн авлага	6,499,149
Зээлийн эрсдэлийн сан (тодруулга 21)	(105,785)
2020 оны 12 сарын 31	6,393,364

Компанийн нийт зээлийн багцын 99% нь Simple апплекэйшнээр олгосон дижитал зээл ба үлдэх хэсгийг жижиг, дунд бизнес эрхлэгч иргэдэд зориулсан зээлийн багц эзэлж байна.



Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын сан

Компани нь зээлийн үнэ цэнийн бууралтыг СТОУС 9-ийн дагуу үнэлэн бүртгэсэн. Ерөнхий аргачлалын дагуу компани зээлийн багцыг доор дурьдсан 1, 2 болон 3 гэсэн шатлалаар ангилж, төлбөр төлөгдөхгүй байх магадлал /PD/, алдагдал үүсэх магадлал /LGD/-ыг үе шат бүрт тооцдог.

2020 онд дэлхий нийтийг хамарсан цар тахлын хямрал манай улсад эрчимтэй үргэлжилж, улс орон даяар тайлангийн ихэнх хугацаанд хөл хорионд байсантай холбоотой Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 854 дүгээр “Банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоодод авах арга хэмжээний тухай” тогтоол гаргасан. Уг тогтоолоор активыг ангилах хугацааг уртасгах, төлбөрийн чадвар буурсан иргэдийн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосон. Хэдий хугацаа хэтрэлтийн хоногийг өөрчилсөн ч компани нь СТОУС 9-ийн дагуу зээлийн багцын үнэ цэнийн бууралтыг хэмждэг. Тооцоолол бодлогын дэлгэрэнгүйг Тодруулга 21-т тусгасан болно.

2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны хүлээгдэж буй үнэ цэнийн бууралт дараах байдалтай байна.

Мянган төгрөгөөр	Зээлийн авлага	Зээлийн хүүгийн авлага	Зээлийн багцын хүлээгдэж буй алдагдал
2020 оны 12 сарын 31			
Шатлал 1	6,252,505	74,443	55,649
Шатлал 2	226,288	10,094	33,520
Шатлал 3	20,356	559	16,615
	6,499,149	85,095	105,785



Ашид Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх зээлийн үлдэгдлийн чанар

мянган төгрөгөөр	2020 он			Нийт
	Шатлал 1	Шатлал 2	Шатлал 3	
Хэвийн зээл	6,252,505	-	-	6,252,505
Чанаргүй зээл	-	226,288	20,356	246,644
Нийт	6,252,505	226,288	20,356	6,499,149

12. Худалдааны болон бусад авлага

а) Худалдааны болон бусад авлага

Мянган төгрөгөөр	2020	2019
Эргэлтийн:		
Гуравдагч талуудаас авах худалдааны авлага	84,323	-
Гуравдагч талуудаас авах бусад авлага	36,473	-
Бусад хамаатай талуудаас авах бусад авлага	21,226	-
Эргэлтийн худалдааны болон бусад авлага доторх санхүүгийн хөрөнгө	142,022	-
Ажиллагсадаас авах авлага	773	-
Эргэлтийн худалдааны болон бусад авлага	142,795	-
Эргэлтийн бус:		
Бусад хамаатай талуудаас авах худалдааны авлага	-	-
Гуравдагч талуудаас авах бусад авлага	-	-
Хасах нь: Найдваргүй авлагын хасагдуулга	-	-
Эргэлтийн бус худалдааны болон бусад авлага доторх санхүүгийн хөрөнгө	-	-
Эргэлтийн бус худалдааны болон бусад авлага	-	-
Нийт	142,795	-

б) Найдваргүй авлагын хасагдуулга

Тусгайлан болон ерөнхийд нь байгуулсан найдваргүй авлагын хасагдуулга байхгүй.



Handwritten signature.



Ашид Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

в) Худалдааны болон бусад авлагын зээлжих чанарын шинжилгээ

<i>Мянган төгрөгөөр</i>	2020	2019
Төлөгдөх хугацаа нь хэтрээгүй бөгөөд үнэ цэнэ нь буураагүй авлагын дүн:		
Гуравдагч талуудаас авах худалдааны болон бусад авлага	121,569	-
Бусад хамаатай талуудаас авах авлага	21,226	-
Нийт	142,795	-
Төлөгдөх хугацаа нь хэтэрсэн боловч үнэ цэнэ нь буураагүй авлагын дүн:		
Төлөгдөх хугацаа нь 1 жилээс бага хугацаанд хэтэрсэн	-	-
Төлөгдөх хугацаа нь 1 жил ба түүнээс дээш хугацаанд хэтэрсэн	-	-
Нийт	-	-
Үнэ цэнэ нь буурсан авлага (нийт дүнгээр):	-	-
Нийт	-	-
Хасах нь: Найдваргүй авлагын хасагдуулга	-	-
Нийт	-	-

13. Урьдчилж төлсөн төлбөр ба урьдчилгаа

<i>Мянган төгрөгөөр</i>	2020	2019
Эргэлтийн:		
Ажиллагсад өгсөн урьдчилгаа	-	-
Урьдчилж төлсөн төлбөр	37,238	-
Бусад урьдчилгаа	249	-
Нийт	37,487	-
Эргэлтийн бус:	-	-
Нийт	37,487	-

Богино хугацаат худалдааны урьдчилж төлсөн төлбөр болон урьдчилгааны нийт дүн буюу 37,487 мянган төгрөг нь 12 сарын дотор хэрэгжихээр хүлээгдэж байгаа болно.

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар худалдааны болон бусад авлагын ангилалд толилуулагдсан баталгаат хугацааны авлагын дүн байхгүй.

Ашид Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

14. Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө

Мянган төгрөгөөр	2020	2019
Касс дахь бэлэн мөнгө	-	50
Харилцах данс	3,057,327	-
Мөнгөтэй адилтгах хөрөнгө	28,037,936	-
Санхүүгийн байдлын тайлан дахь мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө	31,095,263	50
Хасах: 3 сараас дээш хугацаанд байршуулсан мөнгөтэй адилтгах хөрөнгө	-	-
Мөнгөн гүйлгээний тайлан дахь мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө	31,095,263	50

Тайлант жилийн эцсээр компанийн банкин дахь харилцах болон хадгаламжийн дансны хүү нь жилийн 0%-иас 12.6%-ийн хооронд байна.

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар өр төлбөрийн барьцаанд байгаа мөнгө болон мөнгөтэй адилтгах хөрөнгийн дансны дүн байхгүй.

Мөнгө болон мөнгөтэй адилтгах хөрөнгийн зээлжих чанарыг Стандарт ба Пүүрсийн зэрэглэлээр нэгтгэн тодруулбал дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	2020	2019
Хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ буураагүй:		
- В зэрэгжилттэй	29,782,447	-
- Зэрэгжилтгүй	1,312,816	-
Нийт	31,095,263	-

15. Худалдааны ба бусад өглөг

Мянган төгрөгөөр	2020	2019
Эргэлтийн:		
Гуравдагч талуудад өгөх бусад өглөг	121,746	-
Бусад хамаатай талуудад өгөх бусад өглөг	172,661	-
Эргэлтийн худалдааны болон бусад өглөг доторх санхүүгийн өр төлбөр	294,407	-
Ажиллагсад өгөх өглөг	83,015	-
НӨАТ, бусад татварын өглөг	-	-
Эргэлтийн худалдааны болон бусад өглөг	377,422	-
Эргэлтийн бус:		
Гуравдагч талуудад өгөх бусад өглөг	-	-
Эргэлтийн бус худалдааны болон бусад өглөг доторх санхүүгийн өр төлбөр	-	-
Эргэлтийн бус худалдааны болон бусад өглөг	-	-
Нийт	377,422	-



Ашид Капитал ББСБ ХХК
 Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

16. Хувь нийлүүлсэн хөрөнгө

а) Хувь нийлүүлсэн хөрөнгө болон хувьцааны урамшуулал

Мянган төгрөгөөр	2020	2019
12 дугаар сарын 31-рх зөвшөөрөгдсөн нийт хувьцааны тоо ширхэг	40,000,000	50
12 дугаар сарын 31-рх нэгж хувьцааны нэрлэсэн үнэ	1	1
Гаргасан нийт хувьцааны тоо ширхэг:		
Тайлант хугацааны эхэнд	50	-
Тайлант хугацаанд нэмж гаргасан хувьцаа	39,999,950	-
Тайлант хугацааны эцэст	40,000,000	-
Бүрэн төлөгдсөн:	40,000,000	-
Бүрэн төлөгдөөгүй:	-	-
Эргэлтэнд байгаа нийт хувьцааны тоо ширхэг	40,000,000	50

б) Энгийн хувьцаа

Компанийн нийт эргэлтэнд гаргасан хувьцааг Монгол улсад бүртгэлтэй М-Си-Эс Холдинг ХХК 100 хувь эзэмшдэг.

М-Си-Эс Холдинг ХХК-ийн Захирлуудын Зөвлөлийн тогтоолоор Компани нэг бүр нь 1,000 төгрөгийн үнэтэй 39,999,950 ширхэг хувьцааг нэмж гаргасан. Гаргасан бүх энгийн хувьцаа бүрэн төлөгдсөн.

17. Хүү ба түүнтэй адилтгах орлого

Мянган төгрөгөөр	2020	2019
Хүү болон түүнтэй адилтгах орлого		
Банк, санхүүгийн байгуулагад байршуулсан харилцах, хадгаламж	144,939	-
Харилцагчид олгосон зээл ба урьдчилгаа	337,891	-
Зээл судалсны шимтгэл	340	-
Нийт хүү ба түүнтэй адилтгах орлого	483,170	-

Ашид Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

18. Зардал, төрлөөр

2020 он Мянган төгрөгөөр	Маркетингийн үйл ажиллагааны зардал	Борлуулалт, түгээлтийн үйл ажиллагааны зардал	Удирдлага, захиргааны зардал	Нийт зардал (төрлөөр)
Бараа материалын бусад зардал	-	14,462	3,628	18,090
Элэгдэл, хорогдол	-	220	5,365	5,585
Элэгдэл, хорогдол-Ашиглах эрхтэй хөрөнгө	-	-	16,794	16,794
Ажиллагсдын олговор	90,089	229,661	1,516,745	1,836,495
Түрээсийн зардал	-	4,173	358,027	362,200
PR	188,274	-	-	188,274
Харилцаа холбооны зардал	469	15,092	70,041	85,602
Баяр ёслол	-	-	39,764	39,764
Харуул хамгаалалт	-	-	26,759	26,759
Хөдөлмөр хамгаалалт	1,436	5,759	14,006	21,201
Оффис, байрны үйлчилгээ, ариутгал цэвэрлэгээ	-	1,688	19,487	21,175
Хүний нөөцийн үйл ажиллагаа	-	-	13,977	13,977
Бизнес уулзалт	-	-	12,803	12,803
Гэрээт ажил	-	5,450	6,197	11,647
Бусад	2,145	8,188	35,220	45,553
Нийт	282,413	284,693	2,138,813	2,705,919

Ажиллагсдын олговор

Мянган төгрөгөөр	2020	2019
Цалин	1,488,198	-
Шагнал урамшуулал	269,849	-
Нэмэгдэл, хөнгөлөлтүүд	191	-
Байгууллагаас төлж байгаа НДШ	78,257	-
Нийт	1,836,495	-

19. Үйл ажиллагааны бусад орлого (зардал)

Мянган төгрөгөөр	2020	2019
Гадаад валютын ханшийн зөрүүний цэвэр ашиг (алдагдал)	265,848	-
Үйл ажиллагааны бусад орлого	1,482	-
Үйл ажиллагааны бусад зардал	(5,668)	-
Нийт	261,662	-

Ашид Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

20. Орлогын албан татвар

а) Ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдсөн орлогын албан татвар

Мянган төгрөгөөр	2020	2019
Тайлант хугацааны татварын зардал	14,495	
Хойшлогдсон татварын зардал	(205,091)	
Тайлант хугацааны орлогын албан татварын зардал	(190,596)	-

б) Бодит болон хүлээгдэж буй татварын зардлын зөрүүгийн тохируулга


Компани санхүүгийн тайланд тусгагдсан орлогод үндэслэн тооцсон татварын зардлыг татварын зорилгоор татвар ногдохгүй орлого, хасагдахгүй зардлын зүйлсээр тохируулсан дүнгийн хамт тодруулдаг. Монгол Улсын татварын хуулийн дагуу тайлант жилийн татвар ногдох орлогын 6 тэрбум (2019: 3 тэрбум) төгрөг хүртэлх дүнд 10 хувиар, 6 тэрбум (2019: 3 тэрбум) төгрөгөөс давсан хэсэгт 25 хувиар (2019: 25%) орлогын албан татвар ногдуулан төлөх үүрэгтэй.

Мянган төгрөгөөр	2020	2019
Татварын өмнөх ашиг	(2,050,907)	-
Тайлант хугацааны татварын зардал (2020: 10%; 2019: 10%)	(221,823)	-
Тусгай хувь хэмжээгээр ногдуулсан татварын зардал	14,494	-
Албан татвар ногдох орлогоос хасагдахгүй эсвэл орлогод тооцогдохгүй зүйлсийн нөлөө:		
- Албан татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал	16,732	-
- Хүлээн зөвшөөрсөн түр зөрүүний өөрчлөлт	205,091	-
- Тайлант хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй татварын алдагдал	(205,091)	-
Тайлант үеийн орлогын албан татварын зардал	(190,596)	-

в) Хойшлогдсон татварын хөдөлгөөн

СТОУС болон Монгол улсад үйлчилж буй татварын хуулийн ялгаатай холбоотойгоор хөрөнгө болон өр төлбөрийн санхүүгийн тайлан дахь дансны дүн болон татварын суурь хоёрын хооронд түр зөрүү үүсдэг. Эдгээр түр зөрүүгийн хөдөлгөөнд гарсан татварын нөлөөг доорх хүснэгтэд дэлгэрэнгүй тодруулсан бөгөөд татварыг 10 хувиар тооцоолсон болно.





Ашигт Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

Мянган төгрөгөөр	Ашиг/ алдагдал тооцсон	2020 оны 12 дугаар сарын 31
Татвар ногдох орлогоос хасагдах / (албан татвар ногдуулах) түр зөрүүний нөлөө:		
Дараа жилүүдэд шилжүүлэх алдагдал	205,091	205,091
Бусад	-	-
Хойшлогдсон татварын хөрөнгө (өр төлбөр)	205,091	205,091

Компани 2021 онд ашигтай ажиллана гэсэн хүлээлттэй байгаа тул 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант хугацааны алдагдлыг дараа жилүүдэд шилжүүлэн тооцохоор хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн.

21. Санхүүгийн хэрэглүүр – Санхүүгийн эрсдэлийн удирдлага

Эрсдэлийн удирдлагыг компанийн санхүү, үйл ажиллагаа, хуультай холбогдох бүх эрсдэлийн хүрээг хамааруулан хэрэгжүүлдэг. Санхүүгийн эрсдэлд зах зээлийн эрсдэл (үүнд валют, хүүний түвшин болон бусад үнийн эрсдэл орно), кредит эрсдэл болон төлбөрийн хөрвөх чадварын эрсдэлийг хамруулан авч үздэг. Санхүүгийн эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь хүлээж болох эрсдэлийн хязгаарыг тогтоож, улмаар бодит эрсдэлийг тухайн тогтоосон хязгаарт барих явдал юм. Үйл ажиллагааны болон эрх зүйн эрсдэлийн удирдлагын гол үүрэг нь дотоод бодлого, журмын зөв зохистой ажиллагааг хангах замаар үйл ажиллагааны болон хууль эрх зүйн эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгахад чиглэгддэг.


а) Кредит эрсдэл

Компанид учирч болзошгүй кредит эрсдэлийн хамгийн өндөр дүн нь санхүүгийн байдлын тайланд тусгагдсан санхүүгийн хөрөнгүүдийн дансны дүн байх ба тэдгээрийг ангилал бүрээр доорх хүснэгтэд тодруулав:

Мянган төгрөгөөр	2020	2019
Богино хугацаат зээлийн авлага	6,393,364	-
Худалдааны болон бусад авлага	142,022	-
Мөнгө болон мөнгөтэй адилтгах хөрөнгө	31,095,263	50
Кредит эрсдэлд өртөх магадлалтай нийт дүн	37,630,649	50

Зээлийн үнэ цэнийн бууралтын үнэлгээ

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 39-ийн дагуу үүссэн алдагдал дээр үндэслэн үнэ цэнэ буурсан зээлүүд дээр эрсдэлийн санг тооцоолдог байсан бол СТОУС 9-ийн хувьд хүлээгдэж буй алдагдалд үндэслэн эрсдэлийн санг тооцдог. СТОУС 9-ийн дагуу байгуулах эрсдэлийн сан нь зах зээлийн нөхцөл байдалтай уялдан хурдтай хариу үйлдэл үзүүлж, цаг алдалгүйгээр ирээдүйд бий болох алдагдлыг нөхөхүйд байх бөгөөд ирээдүйн эдийн засгийн төлөв байдлын өөрчлөлтийг оруулан тооцсон байх шаардлагатай.



Ашигт Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

Санхүүгийн байдлын тайланд бүртгэгдсэн санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнийг идэвхтэй зах зээлээс олж мэдэх боломжгүй үед математик, статистикийн төрөл бүрийн техникүүдийг ашиглан тодорхойлдог. СТОУС 9-д зээлийн үнэ цэнийн бууралтын ирээдүйд хүлээгдэж буй алдагдлыг тооцох ерөнхий зарчмыг тусгаж өгсөн бөгөөд тусгайлсан, тодорхой загварчлалыг тайлбарладаггүй. Иймд санхүүгийн байгууллага нь түүхэн хугацааны өгөгдлийг ашиглан математик, статистик загвараар дотооддоо хүлээгдэж буй алдагдлыг тооцох аргачлалыг боловсруулах шаардлагатай.

Компани нь 2020 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс иргэдэд чиглэсэн хэрэглээний зээлийн үйл ажиллагаагаа идэвхжүүлж эхэлсэн бөгөөд зээлийн насжилт бага, төлбөр хэтэрсэн зээлийн тоо цөөн, өгөгдлийн хүрэлцээ муу учир зах зээлийн жишгийн дагуу үнэ цэнийн бууралтын хүлээгдэж буй алдагдлыг тооцоолсон.

Тодорхойлолт

Эрсдэлд өртөх дүн (EAD) гэдэг нь дансны үнэ дээр хуримтлагдсан хүүг нэмж, тайлант хугацааны үндсэн болон хүүгийн төлбөрийг хасч бүртгэснийг;

Төлбөр хэтрэлт гэж зээлдэгч Компанитай байгуулсан гэрээнийхээ дагуу зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг 90-ээс дээш хоног хугацаа хэтрүүлсэн тохиолдлыг;

Төлбөр төлбөгдөхгүй байх магадлал (PD) нь зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцох зээлийн эрсдэлийн параметр бөгөөд төлбөр хэтрэлт бий болох магадлалыг;

Зээлийн алдагдал үүсэх магадлал (LGD) нь зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцох параметр бөгөөд зээлдэгч төлбөр хэтэрснээс хойш үүсэх бодит алдагдлыг илэрхийлэх магадлалыг хэлнэ.

Зээлийн үнэ цэнийн бууралтын хүлээгдэж буй алдагдал тооцох ерөнхий загвар

Зээлийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрснөөс хойш зээлийн эрсдэлийн түвшний өөрчлөлттэй холбоотойгоор зээлийг үндсэн 3 шатлалд ангилна. Энэхүү 3 шатлал бүрт хүлээгдэж буй алдагдлаар хүлээн зөвшөөрөх үнэ цэнийн бууралтын дүнг тодорхойлно. Компани нь Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 12 дугаар сарын 23-ны 1020 тогтоолд заасны дагуу Активыг ангилах, эрсдэлийн сан байгуулах, байгуулах зарцуулах журмын хугацааны үзүүлэлтээр ангилсан.

Үзүүлэлтүүд	Шатлал 1	Шатлал 2	Шатлал 3
Зээлийн эрсдэлийн түвшин	Зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өсөөгүй	Зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн	Зээлийн эрсдэлд өртсөн буюу үнэ цэнэ буурсан
Тодорхойлолт	30 хүртэлх хоног хугацаа хэтэрсэн зээл	30-90 хүртэлх хоног хугацаа хэтэрсэн зээл	90-ээс дээш хоног хугацаа хэтэрсэн зээл
Хүлээгдэж буй алдагдал	12 сарын хүлээгдэж буй алдагдал	Нийт хугацаанд хүлээгдэж буй алдагдал	Нийт хугацаанд хүлээгдэж буй алдагдал



Handwritten signature



Ашид Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

Томьёолол	$PD_{12M} * EAD_{12M} * LGD_{12M}$	$PD_{LT} * EAD_{LT} * LGD_{LT}$	$EAD_{LT} * LGD_{LT}$
Хүүгийн орлого	Дансны нийт дүн	Дансны нийт дүн	Дансны цэвэр дүн

Зах зээлийн жишиг хүүний түүврийн хэмжээ

СТОУС 9 нь 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн бөгөөд санхүүгийн байгууллагууд 2018 оны эцсээр хөндлөнгийн аудитын тайлангаа СТОУС 9-ийн дагуу олон нийтэд тайлагнаж эхэлсэн.

2019 оны эцсээр банк, санхүүгийн салбарын системийн нөлөө бүхий 6 банк, дижитал зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг 1 ББСБ ХК-ийн хөндлөнгийн аудитын тайланг авч үзэхэд дараах байдалтай байна.

Тайлагнасан байдал	Санхүүгийн байгууллагын тоо
1. СТОУС 9-ийн дагуу бэлдээгүй	1 банк
2. СТОУС 9-ийн дагуу дэлгэрэнгүй тайлангаа нийтлээгүй	1 банк
3. СТОУС 9-ийн дагуу дэлгэрэнгүй тайлагнасан	4 банк, 1 ББСБ

СТОУС 9-ийн дагуу дэлгэрэнгүй тайлагнасан дээрх банк, санхүүгийн байгууллагуудаас иргэдэд олгосон хэрэглээний зээлийн үнэ цэнийн бууралтын хүлээгдэж буй алдагдлаа тодруулсан 3 банк, 1 ББСБ байна. Эдгээр байгууллагуудын эдийн засгийн өнөөгийн байдал болон ирээдүйн төлвөө харгалзан тооцсон төлбөр төлөгдөхгүй магадлал (PD), зээлийн алдагдал үүсэх магадлал (LGD)-ын үржвэрээр зээлийн алдагдлын хувийг тодорхойлж, хоргодуулсан өртгөөр жигнэхэд дараах байдалтай байна.

Шатлалууд	Томьёолол	Зээлийн алдагдлын хувь
- Шатлал 1	$PD_{12M} * LGD_{12M}$	0.9%
- Шатлал 2	$PD_{LT} * LGD_{LT}$	14.2%
- Шатлал 3	LGD_{LT}	65.3%

Компани нь дээрх зээлийн алдагдлын хувийг (PD*LGD) зээлийн үнэ цэнийн бууралтын хүлээгдэж буй алдагдлыг тооцохдоо ашигласан болно.



Ашигт Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

Худалдааны авлагын хувьд уг эрсдэлийг зохицуулахдаа, харилцагч бүрийн үүргээ биелүүлэхгүй байх эрсдэлийг нь нухацтай үнэлж, дүгнэдэг. Ингэхдээ тухайн харилцагчийн төлбөр төлөлтийн өмнөх үеийн мэдээлэл, санхүүгийн байдал болон бусад үзүүлэлтүүдийг авч үздэг. Худалдааны авлага нь нэхэмжлэлийн өдрөөс хойш 30-90 хоногийн дотор төлөгдөх ёстой байдаг ба компани харилцагчдаасаа барьцаа ихэнхдээ авдаггүй. Тайлант хугацааны эцсийн байдлаар худалдааны авлагын хувьд компанид төвлөрсөн, том хэмжээний кредит эрсдэл байхгүй болно.

Зээлийн авлага болон бусад авлагын хувьд компани зээл олгохоосоо өмнө зээлдэгчийн санхүүгийн чадамжийг судалж, үнэлгээ хийдэг. Компани зээлийн авлагын эргэн төлөлтийг тогтмол хянадаг.

б) Төлбөрийн хөрвөх чадварын эрсдэл

Төлбөрийн хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь компани мөнгө эсвэл өөр бусад санхүүгийн хөрөнгөөр барагдуулах санхүүгийн өр төлбөртэй холбоотой үүргээ биелүүлэхэд үүсч болзошгүй хүндрэлтэй холбоотой эрсдэлийг хэлнэ. Компани энэхүү эрсдэлийн удирдлагын хүрээнд санхүүгийн хэвийн болон хүндрэлтэй аль ч нөхцөлд шаардлагагүй гарз хүлээж, компанийн нэр хүндийг сэвтээхгүйн тулд санхүүгийн өр төлбөрийн төлөгдөх хугацаанд хангалттай хэмжээний нөөцтэй байхыг зорилго болгож ажилладаг.


Компани мөнгөний хэрэгцээ шаардлагыг мөнгөн орлоготой тогтмол уялдуулан хянадаг ба мөнгөн гүйлгээний төсвийг тогтмол бэлдэж, үндсэн үйл ажиллагаа, санхүүжилт, мөн капитал зарцуулалтын хэрэгцээнд шаардлагатай мөнгө болон мөнгөтэй адилтгах хөрөнгийг хангалттай түвшинд байлгадаг. Удирдлага төлбөрийн хөрвөх чадварын эрсдэлийг маш бага байгаа гэж үзэж байна.

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн өр төлбөрийг гэрээний үлдсэн хугацаагаар нь доорх хүснэгтэд тодруулж байна. Энэхүү хүснэгтэд толилуулагдсан дүн нь өр төлбөрийн гэрээний нэрлэсэн мөнгөн гүйлгээний дүн бөгөөд үүнд санхүүгийн түрээсийн нийт төлбөр (ирээдүйн санхүүгийн зардлыг хасахаас өмнөх) орно. Хэрэв өр төлбөрийн дүн тогтмол биш тохиолдолд доор толилуулагдах дүнг тайлант хугацааны эцсээрх нөхцөл байдлыг харгалзан үзэж, тооцоолон гаргасан болно. Гадаад валютаар илэрхийлэгдсэн төлбөрийн дүнг тайлант хугацааны эцсээрх спот ханшаар хөрвүүлсэн.





simple



Ашид Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

Мянган төгрөгөөр	Дансны дүн	Гэрээгээр хүлээсэн үүргийн дүн (дискаунтчилагдаагүй)		
		Нийт дүн	1 жилийн дотор	1-2 жилийн дотор
Урт хугацаат санхүүгийн түрээсийн өр төлбөр	48,254	50,450	-	50,450
Богино хугацаат санхүүгийн түрээсийн өр төлбөр	65,547	75,676	75,676	-
Худалдааны болон бусад өглөг	294,407	294,407	294,407	-
Нийт	408,208	420,533	370,083	50,450

в) Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл гэдэг нь зах зээлийн үнийн өөрчлөлтөөс үүсэх эрсдэлийг хэлнэ. Үүнд гадаад валютын ханшийн өөрчлөлт болон хүүгийн түвшний өөрчлөлт зэрэг компанийн орлого болон санхүүгийн хэрэглүүрүүдийн үнэ цэнэд нөлөөлөхүйц өөрчлөлтүүд орно. Компани зах зээлийн эрсдэлийн удирдлагаар хүлээн зөвшөөрч болохуйц хэмжээнд эрсдэлийг барихын зэрэгцээ өгөөжийг оновчтой түвшинд байлгахыг зорилго болгон ажилладаг.

г) Гадаад валютын эрсдэл

Гадаад валютын эрсдэл гэдэг нь гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс болж санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн урсгал нь хэлбэлзэх эрсдэл юм. Компанийн бүртгэлийн валют нь Монгол Төгрөг. Гадаад валютын эрсдэлийг шууд өсгөх нөлөөтэй валют нь Америк Доллар болно.



Ашигт Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

д) Гадаад валютын ханшийн эрсдэл

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх компанийн гадаад валютын ханшийн эрсдэлийг доорх хүснэгтээр нэгтгэн тодруулав:

Мянган төгрөгөөр	Нийт	Төгрөг	Ам.доллар	Юань
Санхүүгийн хөрөнгө:				
Богино хугацаат зээлийн авлага	6,393,364	6,393,364	-	-
Худалдааны болон бусад авлага	142,022	142,022	-	-
Мөнгө болон мөнгөтэй адилтгах хөрөнгө	31,095,263	31,027,216	67,990	57
Нийт	37,630,649	37,562,602	67,990	57
Санхүүгийн өр төлбөр:				
Урт хугацаат санхүүгийн түрээсийн өр төлбөр	(48,254)	(48,254)	-	-
Богино хугацаат санхүүгийн түрээсийн өр төлбөр	(65,547)	(65,547)	-	-
Худалдааны болон бусад өглөг	(294,407)	(294,407)	-	-
Нийт	(408,208)	(408,208)	-	-
Цэвэр дүн	37,222,441	37,154,394	67,990	57


Гадаад валютын ханш



Тайлант хугацаанд хэрэглэгдсэн голлох гадаад валютын ханш:

Гадаад валютын ханш	Дундаж ханш		12 сарын 31-рх хаалтын ханш	
	2020	2019	2020	2019
Ам.Доллар	2,813.29	2,663.54	2,849.51	2,733.52
Евро	3,212.67	2,982.51	3,495.78	3,061.00
Канад доллар	2,099.97	2,007.83	2,227.40	2,090.97
Юань	407.98	385.70	436.13	391.12
Хонг Конг доллар	-	-	367.56	351.07

Гадаад валютын ханшийн боломжит өөрчлөлтийн нөлөөлөл

Тайлант хугацааны эцэс дэх гадаад валютын ханшийн боломжит өөрчлөлтийн компанийн ашиг, алдагдалд үзүүлэх нөлөөллийг доорх хүснэгтээр тодруулав. Ингэхдээ зөвхөн валютын ханш хувьсах, бусад бүх хүчин зүйлс тогтмол байх үеийн нөлөөллийг тооцсон болно. Гэхдээ бодит байдал дээр энэ нь бараг боломжгүй нөхцөл байдал бөгөөд зарим хүчин зүйлсийн өөрчлөлт хоорондоо харилцан хамааралтай байх нь бий. Тухайлбал: хүүгийн түвшин болон гадаад валютын ханшийн өөрчлөлтүүд.





Ашигт Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

	2020		2019	
	Гадаад валютын ханшийн өсөлт (бууралт)	Ашиг/алдагдалд нөлөөлөх нь: (мянган төгрөгөөр)	Гадаад валютын ханшийн өсөлт (бууралт)	Ашиг/алдагдалд нөлөөлөх нь: (мянган төгрөгөөр)
Ам. Доллар	10%	6,799	10%	-
	-10%	(6,799)	-10%	-
Юань	10%	6	10%	-
	-10%	(6)	-10%	-

Нөлөөллийг компанийн бүртгэлийн валютаас бусад гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийн хувьд тооцоолон хэмжсэн. Тайлант хугацааны эцсээрх гадаад валютын эрсдэл нь тухайн тайлант хугацааны дундуурх ердийн эрсдэлийг харуулдаг.

е) Хүүгийн түвшний эрсдэл

Компанийн санхүүгийн байдал болон мөнгөн урсгалд зах зээлийн голлох хүүгийн түвшний өөрчлөлттэй холбоотой үүсэх эрсдэл юм.

Хүүгийн түвшин

Компани санхүүгийн хэрэглүүрүүдийнхээ хүүгийн түвшинг тогтмол хянадаг бөгөөд тайлант хугацааны эцэст компанийн санхүүгийн хэрэглүүрүүдэд хүүгийн түвшинтэй холбогдох хүүгийн түвшиний эрсдэл байхгүй болно.


22. Санхүүгийн хэрэглүүр – Бодит үнэ цэнэ

Бодит үнэ цэнийн үнэлгээний түвшинг дараах байдлаар шатлан тодорхойлдог: (i) Түвшин 1, ижил төстэй хөрөнгө, өр төлбөрийн идэвхтэй зах зээл дээр тогтоогдсон үнэ цэнэ (залруулж, тохируулахгүй); (ii) Түвшин 2, хөрөнгө, өр төлбөртэй холбоотой харгалзан үзвэл зохих мэдээ, мэдээллийг шууд (үнэ) болон шууд бус (үнээс тооцож гаргасан) хэлбэрээр цуглуулан, үнэлгээний арга аргачлалыг ашиглан тооцсон үнэ цэнэ; (iii) Түвшин 3, зах зээлийн мэдээлэлд тулгуурлаагүй (зах зээл дээр бэлэн байдаггүй мэдээлэл) үнэ цэнийг тус тус хэлнэ. Удирдлага бодит үнэ цэнийн шатлалыг ашиглан санхүүгийн хэрэглүүрүүдийг ангилан үздэг. Зах зээлийн мэдээллийг нилээд өөрчилж тохируулан гаргасан үнэ цэнийг Түвшин 3-т хамааруулна. Үнэлгээнд ашиглагдаж буй өгөгдлийн ач холбогдлыг бодит үнэ цэнийн хэмжилттэй бүхэлд нь харьцуулан авч үздэг.

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн дансны дүн болон бодит үнэ цэнийг, шатлалын хамт доорх хүснэгтэд тодруулав. Бодит үнэ цэнээр хэмжигддэггүй боловч, дансны дүн нь бодит үнэ цэнэтэй нь ойролцоо санхүүгийн хэрэглүүрийг доорх хүснэгтэд тодруулаагүй болно.



Handwritten signature



Ашид Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

Мянган төгрөгөөр	2020 оны 12 дугаар сарын 31-ний дансны дүн	2020 оны 12 дугаар сарын 31-ний бодит үнэ цэнэ			
		Нийт	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3
Урт болон богино хугацаат зээлийн авлага	6,393,364	6,393,364	-	6,393,364	-
Санхүүгийн түрээсийн өглөг	(113,801)	(113,801)	-	(113,801)	-

23. Хөрөнгийн удирдлага

Компанийн хөрөнгийн удирдлагын үндсэн зорилго нь хувьцаа эзэмшигчдийн өгөөж, бусад ашиг сонирхлын бүлгүүдийн үр ашгийг өсгөх боломжийг олгодог компанийн үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх баталгааг хангахад чиглэгддэг. Компани капитал хувьцаа эзэмшигчдийн өгөөжийг өндөр байлгахын зэрэгцээ хөрөнгийн бүрэн бүтэн байдлаар дамжуулан давуу тал, аюулгүй байдлыг баталгаажуулсан түвшинд хөрөнгийн бүтцийг байлгахыг зорьж ажилладаг. 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар компанийн удирдаж буй хөрөнгийн хэмжээ 38,616,372 (2019: 50 мянган төгрөг) мянган төгрөг байсан.

24. Болзошгүй өр төлбөр ба үүрэг хариуцлага

а) Үйл ажиллагааны түрээсийн ирээдүйн үүрэг хариуцлага

Үйл ажиллагааны түрээсийн гэрээний дагуу тайлант хугацааны ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдсөн дүн:

Мянган төгрөгөөр	2020	2019
Түрээсийн зардал	(362,201)	-

б) Татварын хууль, зохицуулалт

Монгол улсын татвар, валют болон гаалийн зохицуулалттай холбоотой хууль тогтоомжууд нь өөр хоорондоо зөрүүтэйгээр тайлбарлагдах, мөн үе үе өөрчлөгдөж болзошгүй байдаг. Удирдлагын үнэлэмж, тайлбараар хууль журмыг ажил гүйлгээ, үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн байдлыг холбогдох төрийн албаны зүгээс хүлээн зөвшөөрөгдөхгүй байх тохиолдол гардаг.

Монгол Улсын татварын алба хууль тогтоомжийг тайлбарлан үнэлэхдээ илүү хатуу байр суурь баримтлах талтай байдаг ба өмнө нь санал зөрөлдөж байгаагүй үйл ажиллагаа, ажил гүйлгээг татварын алба хожим нь үгүйсгэх боломжтой. Үүнээс үүдэж томоохон хэмжээний нэмэлт татвар, торгууль болон алдангийг ногдуулах магадлалтай байдаг. Татварын хяналт шалгалт орох үед өмнөх







**Ашид Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31**

таван жилийн татварыг шалгадаг тул эдгээр татварын жилүүд хяналт шалгалтанд нээлттэй хэвээр үлддэг. Зарим тохиолдолд татварын хяналт шалгалтанд илүү урт хугацааг хамруулах явдал байдаг.

Монгол Улсын татварын хууль журам, зохицуулалтаар нэмэгдсэн өртгийн албан татвар, суутган татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, үнэ шилжүүлэлт болон бусад зүйлстэй холбоотой зарим зүйл, заалт, асуудлаар тодорхой зааварчилгаа байдаггүй. Зарим нэг тохиолдолд удирдлага хуулийн энэхүү тодорхой бус зүйлсийн тухайд компанийн татварын ерөнхий хувийг бууруулах чиглэлд тайлбарлан хэрэглэдэг. Сүүлийн үед явагдсан захиргааны болон шүүхийн практик шинэчлэлийн үр дүнд дээрх тодорхой бус байдлын талаарх байр суурь илүү их хатуу хяналт шалгалтанд өртөх талтай болсон. Хэдийгээр татварын албанаас тавигдах шаардлага компанийн санхүүгийн байдал болон нийт үйл ажиллагаанд материаллаг нөлөө үзүүлэх боломжтой боловч, холбогдох нөлөөллийг найдвартай хэмжих боломжгүй юм.

Компанийн удирдлага холбогдох хууль тогтоомжийг зохистойгоор тайлбарлан хэрэглэсэн гэж үзэж байгаа бөгөөд компани татвар болон бусад хууль тогтоомжийн талаарх компанийн байр сууриа тогтвортой хадгалах болно. Удирдлага татварын эрсдэлийг тогтмол эргэн харж үнэлдэг бөгөөд одоогоор татвар болон бусад хууль тогтоомжоос үүсэх эрсдэлийг бага гэж үнэлж байгаа.

Компанийн удирдлага 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар татварын тодорхой бус байдалтай холбоотой сан хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэж үзэж байна.

д) Зээлийн гэрээнд тусгасан санхүүгийн болон санхүүгийн бус үзүүлэлтүүдийн нийцэл

Компани зарим зээлийн гэрээгээр тусгайлан заасан санхүүгийн болон санхүүгийн бус үзүүлэлтүүдийг хангаж ажиллах үүрэг хүлээсэн байдаг. Эдгээрийн үл нийцэлтэй холбоотойгоор компанийн зээлийн зардал нэмэгдэх, үүргээ биелүүлээгүй тухай мэдэгдэл хийх зэрэг сөрөг үр дагавар бий болно.

е) Батлан даалт


Батлан даалт гэдэг нь нөгөө тал үүргээ биелүүлж чадахгүй болсон тохиолдолд компани түүний өмнөөс төлж барагдуулах үүрэг хүлээсэн, буцаагдахгүй баталгаа юм. Компанид ямар нэгэн гэрээгээр хүлээсэн батлан даалтын үүрэг байхгүй байна.

ё) Барьцаанд байгаа, хязгаарлалттай хөрөнгө

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр өр төлбөрийн барьцаанд байгаа хөрөнгүүд байхгүй.

ж) Байгаль орчны асуудал

Монгол улсад байгаль орчны хууль тогтоомжийг дагаж мөрдөх үйл явц улам хөгжиж, улмаар хууль сахиулах төрийн байгууллагууд хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн байр суурийг баттай баримталж ажиллаж байна. Компани нь байгаль орчны хууль тогтоомжийн хүрээн дэхь үүрэг хариуцлага байгаа эсэхийг тогтмол шалгаж, хэрэв байгаа тохиолдолд, нэн даруу санхүүгийн тайландаа тусгадаг.



Ашид Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

Одоогийн мөрдөгдөж буй хууль тогтоомжинд өөрчлөлт гарах, мөн иргэний болон эрх зүйн маргааны шийдвэрт өөрчлөлт гарах зэргээс үүдэн бий болох, болзошгүй өр төлбөрийн дүнг найдвартай хэмжих боломжгүй байдаг; гэхдээ дүн нь материаллаг байхыг үгүйсгэхгүй. Удирдлага одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд, байгаль орчныг бохирдуулсантай холбоотой их хэмжээний үүрэг хариуцлага компанид байхгүй гэж үзэж байна.

з) Зарга, маргаан

Компани бизнесийн хэвийн үйл ажиллагааныхаа хүрээнд өөрийн эсрэг нэхэмжлэл хүлээн авах магадлал бий. Удирдлага өөрсдийн үнэлэмж, тооцоо, компанийн мэргэжилтнүүдийн зөвлөмжид үндэслэн нээлттэй байгаа зарга, нэхэмжлэлтэй холбоотой материаллаг хохирол хүлээхгүй гэж үзэж байгаа тул санхүүгийн тайланд үүнтэй холбогдуулж аливаа сан хүлээн зовшоороогүй болно.

25. Хамаатай талуудын ажил гүйлгээ

а) Шууд болон эцсийн толгой компани

2019 он болон 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар компанийн шууд болон эцсийн толгой компани нь М Си Эс Холдинг ХХК ба М Си Эс Монголиа ХХК юм. Компанийн эцсийн шатны хяналтыг хэрэгжүүлэгч тал нь Жамбалжамц овогтой Оджаргал болон Жамбалжамц овогтой Од нар болно.

б) Хамаатай талуудтай хийх тооцооны үлдэгдэл

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх хамаатай талуудтай хийх тооцооны үлдэгдлийг дараах хүснэгтэд тодруулав:

Мянган төгрөгөөр	Толгой компани	Удирдах албан тушаалтан	Бусад хамаатай талууд	Нийт
Худалдааны болон бусад авлага	-	-	21,226	21,226
Худалдааны ба бусад өглөг	-	-	(172,661)	(172,661)
Санхүүгийн түрээсийн өр төлбөр	-	-	(113,801)	(113,801)

Хамаатай талуудаас авах худалдааны болон бусад авлага дээр найдваргүй авлагын хасагдуулга байхгүй.



simple



Ашид Капитал ББСБ ХХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд- 2020 оны 12 дугаар сарын 31

в) Хамаатай талуудтай хийсэн ажил гүйлгээ

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант хугацааны орлого, зардлуудаас хамаатай талуудтай холбогдох дүнгүүдийг доорх хүснэгтэд тодруулав:

Мянган төгрөгөөр	Толгой компани	Удирдах албан тушаалтан	Бусад хамаатай талууд	Нийт
Үйлчилгээний орлого	-	-	354	354
Үйл ажиллагааны зардал	-	-	(445,544)	(445,544)

г) Гол удирдах ажилтнуудын нийт олговор

Мянган төгрөгөөр	2020	2019
Цалин	117,625	-
Шагнал урамшуулал	44,655	-
Байгууллагаас төлж байгаа НДШ	4,262	-
Нийт	166,542	-

26. Тайлант хугацааны дараах үйл явдлууд

Тайлагналын эцсийн өдөр болон санхүүгийн тайлант хэвлэн нийтлэх зөвшөөрөл олгогдсон өдрийн хооронд үүссэн аливаа залруулагдах үйл явдлууд байхгүй болно.

27. Орчуулга

Энэхүү санхүүгийн тайлант Монгол хэл болон Англи хэл дээр бэлтгэсэн болно. Тайлангууд Монгол хэл дээр бэлтгэгдэн орчуулагдаж байгаа тул Монгол, Англи хувилбаруудын хооронд ялгаа, зөрчилдөх зүйл гарвал Англи хувийг мөрдөнө.



[Handwritten signature]

[Handwritten signature]




2023.08.18

**“Ashid Capital NBFI” LLC
Separate Financial Statements and
Independent Auditor’s Report
31 December 2021**


УЛААНБААТАР ХОТ
АШИД КАПИТАЛ
БЭЭС ХХХ



МАНДАЛ КАПИТАЛ
МАРКЕТС ҮЦХ ХХХ
MANDAL CAPITAL
MARKETS SC
LLC
28
ШТХ0162 9021070414 5213487



2023.08.18



Ashid Capital NBFI LLC

CONTENTS

Independent Auditor's Report

Separate Financial Statements

Statement of Financial Position	1
Statement of Comprehensive Income	2
Statement of Changes in Equity	3
Statement of Cash Flows	4

Notes to the Separate Financial Statements

1. Reporting entity	6
2. Operating environment of the Company	6
3. Basis of accounting	7
4. Significant accounting policies	7
5. Accounting estimates and Basis of measurement	26
6. Adoption of new or revised standards and interpretations	27
7. New accounting pronouncements	28
8. Property, plant and equipment	31
9. Intangible assets	32
10. Lease	33
11. Loans and advances to customers	34
12. Trade and other receivables	35
13. Prepayments and advances	36
14. Cash and cash equivalents	37
15. Trade and other payables	37
16. Loans and borrowings	38
17. Share capital and reserves	39
18. Interest and similar income	39
19. Expenses by nature	40
20. Other net income (expenses)	41
21. Income tax	41
22. Financial instruments - Financial risk management	42
23. Financial instruments – Fair value measurement	48
24. Capital management	49
25. Contingencies and Commitments	49
26. Related party transactions	50
27. Events after the reporting period	52
28. Translation	52




2023.08.18

Ashid Capital NBF LLC

STATEMENT BY DIRECTOR AND EXECUTIVES

We, B. Temuulen, being an Executive director and G. Munkhbayasgalan being an Senior accounting specialist of Ashid Capital NBF LLC (the "Company"), do hereby state that, in our opinion, the accompanying separate financial statements set out on pages 1 and 52 give a true and fair view of the financial position of the Company as at 31 December 2021 and of their financial performance and their cash flows for the year then ended, in accordance with International Financial Reporting Standards.


B.TEMUULEN
EXECUTIVE DIRECTOR


G.MUNKHBAYASGALAN
SENIOR ACCOUNTING SPECIALIST

УЛААН БУТАГ КӨТ
АШИД КАПИТАЛ
ББС ХХК
2023.08.02



МАНДАЛ КАПИТАЛ
МАРКЕТС ҮЦК ХХК
MANDAL CAPITAL
MARKETS SC
LLC
283
ШТК0162 9021070414 623340



2023.08.18



“ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ” ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
6 дугаар хороо, Метро бизнес оффис,
6 дугаар давхар 603 тоот

Утас: 70150001, 80110088

Цахим шуудан: www.shonkhor.mn

И-мэйл: shonkhor.mn@gmail.com

2022.03.30 № 22/38
талай _____ -ыг № _____ -т

**“To the Shareholders of
Ashid capital” LLC**

INDEPENDENT AUDITORS'S REPORT

Opinion


We have audited the financial statements of “Ashid capital” LLC (“Company”), which comprise:

- the statement of financial position as at December 31, 2021;
- the statement of comprehensive income, statement of changes in equity, and statement of cash flows for the year then ended; and
- notes to the financial statements, including a summary of significant accounting policies.

In our opinion the accompanying financial statements present fairly, in all material respects, the financial position of the Company as at December 31, 2021 and its financial performance and its cash flows for the year then ended in accordance with International Financial Reporting Standards (IFRSs).

Basis for Opinion

We conducted our audit in accordance with International Standards on Auditing (ISAs). Our responsibilities under those standards are further described in the Auditor’s Responsibilities for the Audit of the Financial Statements section of our report. We are independent of the Company in accordance with the International Ethics Standards Board for Accountants’ Code of Ethics for Professional Accountants (IESBA Code) together with the ethical requirements that are relevant to our audit of the financial statements in Mongolia, and we have fulfilled our other ethical responsibilities in accordance with these requirements and the IESBA Code. We believe that the audit evidence we have obtained is sufficient and appropriate to provide a basis for our opinion.



web:www.shonkhor.mn



[Signature]

[Signature]

[Signature]

2023.08.18

Other information

Management is responsible for the other information. The other information comprises the information included in the annual report, but does not include the financial statements and our auditor's report thereon.

Our opinion on the financial statements does not cover the other information and we do not express any form of assurance conclusion thereon.

Компанийн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа нь энэ тайлант үе болон зэрэгцүүлэн тоилуулагдсан тайлант үед дараах байдлаар тооцоологдсон:

Үндсэн хөрөнгө	Ашиглалтын хугацаа (жилээр)
Барилга байгууламж, бусад барилга	10-50
Машин техник, тоног төхөөрөмж	3-20
Конторын тоног төхөөрөмж, тавилга эд хогшил	2-15
Тээврийн хэрэгсэл	3-15
Бусад үндсэн хөрөнгө	3-15

Үндсэн хөрөнгийн томоохон бүрэлдэхүүн хэсгийн ашиглалтын хугацаа нь хөрөнгийн бусад бүрэлдэхүүнтэй харьцуулахад өөр байвал, уг хэсгийг тусад нь элэгдүүлнэ. Дуусаагүй барилгад элэгдэл байгуулахгүй.

Хөрөнгийн үлдэх өртөг гэдэг нь тухайн хөрөнгийн ашиглалтын хугацаа дууссан, хуучирсан гэж үзвэл компани одоо худалдаж болох үнээс худалдан борлуулахтай холбогдон гарах зардлыг хассан дүнг хэлнэ. Компани үндсэн хөрөнгийн үлдэх өртөг болон ашиглалтын хугацааг тайлант жил бүрийн эцэст эргэн хянаж, шаардлагатай тохиолдолд оөрчилнө.



Ашид Капитал ББСБ ХХК
 2022 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон эсгийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга



4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн боллого (үргэлжлэл)

Б. Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)

Үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгэсний дараа нэмж гарсан зардлыг, зөвхөн уг зардалтай холбогдох ирээдүйн эдийн засгийн үр өгөөж компанид орж ирэх магадлалтай үед л үндсэн хөрөнгийн өртөгт капиталжуулна.

Үндсэн хөрөнгийг данснаас хасахад үүсэх олз, гарзыг холбогдох цэвэр орлогын дүн болон дансны дүнгийн зөрүүгээр тооцох ба данснаас хассаны олз, гарзыг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Данснаас хасагдсан үндсэн хөрөнгөтэй холбогдох дахин үнэлээний нөөцийн үлдэгдэл (хэрэв байгаа бол) орлогын тайланд тусгагдахгүйгээр хуримтлагдсан ашигт хаагдана.

Үндсэн хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болзошгүйг илтгэх шинж тэмдэг байгаа эсхийг удирдлага тайлант үе бүрийн эцэст хянаж үздэг. Үнэ цэнэ буурсан гэдгийг илтгэх шинж тэмдэг байвал, үндсэн хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ болон бодиг үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүн хоёрын аль ихээр нь хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцоолно. Үндсэн хөрөнгийн дансны дүнг нөхөгдөх дүн хүртэл бууруулж, үнэ цэнийн бууралтыг тухайн тайлант хугацааны ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Өмнөх тайлант хугацаануудад үндсэн хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ болон бодиг үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүнг хэмжихэд ашигласан тооцоолууд нь өөрчлөгдсөн бол, өмнө нь хүлээн зөвшөөрөгдсөн үнэ цэнийн бууралтыг зохих хэмжээгээр нь буцаана.

В. Биет бус хөрөнгө

Тусад нь худалдаж явсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь хэмжинэ. Анх хүлээн зөвшөөрч бүртгэсний дараа тэдгээрийг өртгөөс хуримтлагдсан хорогдол (ашиглалтын хугацаа нь тодорхой хөрөнгийн хувьд) болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гэрээг хассан дүнгээр хэмжинэ.

Хөгжүүлэлтийн үе шатны зардлыг зөвхөн түүнийг найдвартай хэмжих боломжтой бөгөөд уг ажлын үр дүнд тооцоологдсон бүтээгдэхүүн, процесс нь техник, эдийн засгийн үндэслэлтэй, ирээдүйн эдийн засгийн үр өгөөжтэй, компани хөгжүүлэлтийг гүйцэтгэж, шинэ ашиглах хангалттай нөөцтэй ба төлөвлөгөөтэй бийгаа эсвэл худалдан борлуулах боломжтой нөхцөлд л капиталжуулан бүртгэнэ. Дээрх нөхцлүүд биелэгдээгүй тохиолдолд хөгжүүлэлтийн зардлыг тухай бүрд нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Хүлээн зөвшөөрч бүртгэсний дараагаас хөгжүүлэлтийн зардлыг өртгөөс хуримтлагдсан хорогдол болон үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр хэмжинэ.



Судалгааны үе шатны зардлыг тухай бүрд нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Биет бус хөрөнгийг шулуун шугамын аргаар хорогдуулах боловч тухайн хөрөнгийн хүлээгдэж буй хэрэглээ, холбогдох ирээдүйн эдийн засгийн өгөөжтэй илүү уялдсан хорогдуулгын өөр бусад аргыг хэрэглэж болно.

Тодорхой ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулах арга болон ашиглалтын хугацааг дор хаяж тайлант жил бүрийн эцэст дахин хянаж, шаардлагатай бол өөрчлөх бөгөөд эдгээр өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзэн бүртгэлд тусгана. Биет бус хөрөнгийн хорогдуулгын зардлыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Ашиглалтын хугацаа нь тодорхой дараах биет бус хөрөнгүүдийг ашиглахад бэлэн болсон өдрөөс эхлэн доорх тооцоолсон ашиглалтын хугацаагаар хорогдуулна.

Биет бус хөрөнгө	Ашиглалтын хугацаа (жилээр)
Лиценз	5-20
Програм хангамж	3-10
Худалдааны тэмдэг	10
Бусад	10





Ашид Капитал ББСБ ХХК
2022 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд

MAGIC
CONSULTING AUDIT

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн боллого (үргэлжлэл)

В. Биет бус хөрөнгө (үргэлжлэл)

Ашиглалтын хугацаа нь тодорхойгүй гэж дүгнэгдсэн биет бус хөрөнгийг хорогдуулахгүй. Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа нь тодорхойгүй гэсэн дүгнэлтийг тайлант жил бүр дахин хянаж, үйл явдал ба нөхцөл байдал ашиглалтын хугацаа тодорхойгүй болохыг үргэлжлүүлэн нотолж байгаа эсэхийг шалгана. Хэрэв үгүй бол, уг биет бус хөрөнгийг тодорхой ашиглалтын хугацаатай болсон гэж үзэн, холбогдох өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзэн бүртгээд тусгана.

Биет бус хөрөнгийн ангилал дотор туслагдсан хайгуул ба үнэлгээний хөрөнгийн өртөгт хайгуул ба үнэлгээтэй шууд холбоотой зардлууд орно. Үүнд бэлэн байгаа хайгуулын мэдээнд анализ хийх, геологийн судалгаа хийх, хайгуулын өрөмдлөг болон дээж авах, олборлолт болон баяжуулалтын аргуудыг судлах ба туршиж, урьдчилсан болон батлагдсан техник эдийн засгийн үндэслэл, мэдээнд судалгаа, дүн шинжилгээ хийх болон үйл ажиллагааны бусад цалин хөлс, хоол, түлш, түрээс зэрэг хайгуулын талбайд явуулж буй үйл ажилтай шууд холбогдох зардлуудыг багтаана. Хайгуул ба үнэлгээний хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралт байгаа эсэхийг жил бүр хянана.

Г. Охин болон хараат компани/хамтарсан компани дахь хөрөнгө оруулалт

Энэхүү тусдаа санхүүгийн тайланд охин болон хараат/хамтарсан компанид оруулсан хөрөнгө оруулалтыг өртгийн аргаар бүртгэдэг бөгөөд өртгөөс нь үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр толилуулсан болно. Хөрөнгө оруулалтыг данснаас хасахтай холбоотой цэвэр орлогын дүнгээс дансны дүнг хассан зөрүүг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Д. Урьдчилж төлсөн төлбөр

Урьдчилж төлсөн төлбөрийг өртгөөс үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр хэмжинэ. Төлөгдсөн урьдчилгаатай холбоотой бараа, үйлчилгээг нэг жилийн дараа хүлээн анахаар хүлээгдэж байгаа эсвэл урьдчилгаа нь төлөгдсөн хөрөнгө нь ирээдүйд хүлээн зөвшөөрч бүртгэгдэхэд эргэлтийн бус хөрөнгөөр ангилагдах бол тухайн урьдчилж төлсөн төлбөрийг эргэлтийн бус гэж ангилна.

Компани хөрөнгийн хяналтын эрхийг олж эзэмшин, хөрөнгийн эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг нь хүртэх магадлалтай болсон үед уг хөрөнгөтэй холбоотой урьдчилж төлсөн төлбөрийг хөрөнгийн өртөгт шилжүүлэн бүртгэнэ. Бусад урьдчилж төлсөн төлбөрийг холбогдох бараа, үйлчилгээг хүлээн авсан тайлант хугацаанд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Хэрэв урьдчилгаа нь төлөгдсөн бараа, үйлчилгээг хүлээн авахгүй байх магадлал бий болсон үед, урьдчилж төлсөн төлбөрийн дансны дүнг бууруулан, холбогдох үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.



Ашигт Капитал ББСБ ХХК
2022 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

MAGIC
CONSULTING AUDIT

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого (үргэлжлэл)

Е. Бараа материал

а) Үйлдвэрлэл

Бараа материал нь өртөг болон цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь хэмжигдэнэ.

Бараа материалын өртгийг жинлэсэн дундаж өртгийн аргыг ашиглан тооцоолох ба өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон бараа материалыг одоогийн байршил ба нөхцөлд авчрахтай холбогдож гарсан бүх зардал орно.

Бараа материалын цэвэр боломжит үнэ цэнэ гэдэг нь бизнесийн хэвийн үйл ажиллагааны хүрээнд борлуулахаар тооцоолсон үнээс тооцоолсон иж бүрдэл болгох зардал болон борлуулалтын зардлыг хассан дүн юм.

Борлуулсан бараа материалын дансны дүнг холбогдох борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрсөн тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрнө. Бараа материалыг цэвэр боломжит үнэ цэнэ хүртэл буулган хэмжээнтэй холбоотой болон өөр бусад гарзыг тухайн тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрнө. Харин бараа материалын цэвэр боломжит үнэ цэнэ өссөнөөс үүссэн гарзын буцаалтыг тухайн тайлант үед бүртгэгдсэн бараа материалтай холбоотой зардлыг бууруулан бүртгэлд тусгана.

б) Үл хөдлөх хөрөнгийн бүтээн байгуулалт

Үл хөдлөх хөрөнгийн бүтээн байгуулалтын үр дүнд үүсэх бараа материалыг өртөг болон цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар хэмжинэ. Өртөг болон цэвэр боломжит үнэ цэнийг дараах байдлаар тооцоолно:


- Худалдах зорилгоор барьж буй үл хөдлөх хөрөнгө

Худалдах зорилгоор барьж буй үл хөдлөх хөрөнгийн өртөгт газар олж эзэмших зардал, бүтээн байгуулалтын нийт өртөг, түүхий эд, туслах материалын зардал, цалин болон бусад шууд зардал зэрэг тусгайлан тодорхойлогдохуйц зардлууд болон үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлын хуваарилалт болон капиталжуулсан зээлийн өртөг зэрэг хөрөнгийг одоогийн байршил ба нөхцөлд авчрахтай холбогдох бүх зардал орно. Цэвэр боломжит үнэ цэнийг борлуулахаар тооцоолсон үнээс тооцоолсон бүтээн байгуулалтыг гүйцээх болон борлуулалтын зардлыг хасч тооцоолно.

- Барьж дууссан, худалдахаар эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгө

Компанийн барьж дууссан боловч зарагдаагүй байгаа үл хөдлөх хөрөнгийн өртгийг бүтээн байгуулалтын нийт өртгийн дүнд хувь тэнцүүлэн тооцно. Цэвэр боломжит үнэ цэнийг борлуулахаар тооцоолсон үнээс тооцоолсон борлуулалтын зардлыг хасч тооцно.

Барьж дууссан, худалдахаар эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгийн өртөгт худалдан авалтын нийт өртөг, бүтээн байгуулалтын нийт өртөг болон хөрөнгийг одоогийн байршил ба нөхцөлд авчрахтай холбогдсон бүх зардал орно.



simple



Ашид Капитал ББСБ ХХК
2022 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд



4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого (үргэлжлэл)

Б. Харилцагчтай байгуулсан гэрээний орлого

Компани харилцагчид үйлчилгээ үзүүлэх, бараа борлуулахаар амласан гэрээний орлогоос тодорхойлогдсон ажил гүйлгээний дүнгээр борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрнө. Харилцагчтай байгуулсан гэрээний орлогыг дараах 5 алхмын дагуу хүлээн зөвшөөрөх юм. Үүнд:

1. Харилцагчтай байгуулсан гэрээг (гэрээнүүдийг) тодорхойлох: Гэрээ нь "хоёр ба түүнээс дээш талуудын хоорондох албан ёсны эрх, үүргийг бий болгодог хэлэлцээр" юм. Гэрээ нь амаар, бичгээр болон компанийн тогтсон жишиг буюу уламжлалт үйл ажиллагааны үр дүн болох бараа үйлчилгээг олж авахын тулд Компанитай гэрээ байгуулсан тал" юм. Тухайн харилцагчтай нэг өдөр эсвэл ойролцоо хугацаанд байгуулсан гэрээнүүдийг дараах шалгууруудаас нэг ба түүнээс дээш нь хангагдаж байвал нэгтгэн нэг гэрээ гэж үзэн бүртгэнэ. Үүнд:
 - (i) Гэрээнүүдийг ажил гүйлгээний нэг зорилго бүхий багц гэж тодорхойлсон;
 - (ii) Нэг гэрээний төлбөрийн дүн нь бусад гэрээний биелэлт эсвэл үнээс хамаарч байвал, эсвэл
 - (iii) Гэрээгээр амласан бүтээгдэхүүн, үйлчилгээ нь нэг гүйцэтгэлийн үүргийг илтгэж байвал зэрэг юм.
2. Гэрээнд тусгагдсан бие даасан гүйцэтгэлийн үүргүүдийг тодорхойлох: Гэрээг тодорхойлсны дараа тухайн гэрээний гүйцэтгэлийн үүргийг тодорхойлно. Үндсэн гэрээнд агуулагдаж буй бүтээгдэхүүн үйлчилгээг хуваарилна.
3. Хэлшлийн үнийг тодорхойлох: Хэлшлийн үнэ гэдэг нь бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авагчид үзүүлсний хариуд хүлээн авахаар хүлээгдэж буй дүн юм. Энэ дүнг тодорхойлохын тулд Компани нь хувьсах зардал, бэлэн мөнгөөрх бус төлбөр тооцоо, харилцагчид толох хувьсах төлбөр, санхүүжилтийн томоохон бүрэлдэхүүн хэсгүүдийг багтаасан зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзнэ.
4. Хэлшлийн үнийг гүйцэтгэлийн үүрэг тус бүрд хуваарилах: Компани нь гэрээгээр амласан илгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээ бүрийн тус тусын тогтоосон борлуулалтын үнэд үндэслэн гүйцэтгэх үүрэг бүрд хэлшлийн үнийг хуваарилна.
5. Орлого хүлээн зөвшөөрөх: Компани харилцагчид үзүүлэхээр тохиролцсон үйлчилгээгээ нийлүүлснээр гүйцэтгэх үүргээ биелүүлсэн гэж үзэн орлогоо тодорхой хугацааны туршид хүлээн зөвшөөрнө. Дараах шалгуурын аль нэгийг хангасан бол аж ахуйн нэгж бүтээгдэхүүн үйлчилгээний хяналтыг тодорхой хугацааны турш биелүүлж, орлогыг тодорхой хугацааны турш хүлээн зөвшөөрнө.
 - ✓ Аж ахуйн нэгж үүргээ гүйцэтгэж байх үед түүний өгөөжийг харилцагч зэрэг хүлээн авч хэрэглэдэг.
 - ✓ Аж ахуйн нэгж хөрөнгө шинээр бий болгох эсвэл сайжруулах ажил хийж байх явцад түүний хяналтыг харилцагч эзэмшиж байх хөрөнгийг аж ахуйн нэгжийн гүйцэтгэл шинээр бий болгох эсвэл сайжруулдаг. (жишээ нь: дуусаагүй үйлдвэрлэл); эсвэл
 - ✓ Аж ахуйн нэгжийн гүйцэтгэл нь аж ахуйн нэгж өөрөө өөр хэлбэрийн ашиглах боломжтой хөрөнгийг бий болгодоггүй ба аж ахуйн нэгж тухайн өдөр хүртэл гүйцэтгэсэн ажилдаа төлбөр хүлээж авах хууль зүйн эрхтэй.

Гэрээний орлогод гэрээгээр тохирсон эхний үнэ болон гэрээнд оруулсан өөрчлөлт, нэхэмжлэл, урамшууллын төлбөр багтана. Гүйцэтгэлийн хэмжээг орцын эсвэл гарцын арга дээр үндэслэн гаргана.



2023.08.18

Ашид Капитал ББСБ ХХК
2022 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд

MAGIC
CONSULTING AUDIT

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого (үргэлжлэл)

Ж. Хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Дериватив бус санхүүгийн хөрөнгө

Дериватив бус санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болзошгүйг илтгэх шинж тэмдэг байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцэст тогтооно. Хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болзошгүйг илтгэх шинж тэмдгүүд:

- Зээлдэгчийн санхүүгийн хүндрэл;
- Зээлдэгч гэрээний үүргээ зөрчих, тухайлбал зээлийн үндсэн болон хүүгийг төлбөрийг хугацаанд нь төлөөгүй, эсвэл төлбөрийн чадваргүй болох;
- Зээлдэгч дампуурал зарлах эсвэл санхүүжилтийн бусад бүтцийн өөрчлөлтөд орох нь тодорхой болох;
- Технологи, эдийн засаг, болон хууль эрх зүйн орчинд зээлдэгчид сөргөөр нөлөөлөхүйц томоохон өөрчлөлтүүд гарсан; болон
- Гэрээний хугацаанд өөрчлөлт оруулах;

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг хөрөнгийн төрлөөс хамааран дараах хоёр аргаар тооцно.

1. Ерөнхий арга:

- Компани хоорондын хугацаатай ба хугацаагүй зээл
- Гаргасан санхүүгийн баталгаа ба зээлийн амлалт
- Засгийн газрын болон компанийн бонд дахь хөрөнгө оруулалт
- Холбоотой талуудад олгосон хугацаатай ба хугацаагүй зээл
- Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт

2. Хялбаршуулсан арга: (томоохон санхүүжилтийн бүрэлдэхүүн хэсэг байгаа эсэхээс үл хамаарна)

- Худалдааны авлага
- Түрээсийн авлага
- Гэрээний хөрөнгө

Ерөнхий арга

Санхүүгийн хөрөнгийг 3 түвшинд ангилах ба тухайн түвшин тус бүрээс хамаарч үнэ цэнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрнө.

Түвшин	1	2	3
	Зээлийн эрсдэл их хэмжээгээр өсөөгүй	Зээлийн эрсдэл их хэмжээгээр өссөн	Зээлийн үнэ цэнийн бууралт үүссэн
Үнэ цэнийн бууралт	12 сарын хүлээгдэж буй зээлийн алдагдал	Нийт ашиглалтын хугацааны хүлээгдэж буй зээлийн алдагдал	
Хүү	Нийт дансны үнийг үр ашигт хүүгээр		Цэвэр дансны үнийг үр ашигт хүүгээр

Үнэ цэнийн бууралтыг заавал тодорхойлох ба тодорхойлсноо санхүүгийн тайландаа тодруулна.



simple

VI. ХАВСРАЛТ

БҮРТГЭЭ-02

Ашид Капитал ББСБ ХХК
2022 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд



4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого (үргэлжлэл)

Ж. Хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

Хялбаршуулсан арга

Ашиглалтын нийт хугацааны таамагласан зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх ба дараах таван алхмаар тооцооллыг хийнэ. Үүнд:

1. Авлагын бүлгийг тодорхойлон ангилах: Газар зүйн бүс нутаг, бүтээгдэхүүний төрөл, харилцагчийн зэрэглэл, барьцаа эсвэл худалдааны зээлийн даатгал, харилцагчийн төрөл гэх мэт;
2. Түүхэн алдагдал тохиолдож байсан хугацааг тодорхойлох: Ангилан бүлэглэсний дараа ангилал бүрийн хувьд түүхэн алдагдлын мэдээллийг цуглуулна.
3. Түүхэн алдагдлын хувь хэмжээг тодорхойлох: Компани нь цуглуулсан мэдээллээ ашиглан ангилал бүрийн хувьд түүхэн алдагдлын хувь хэмжээг тодорхойлно.
4. Макро эдийн засгийн одоогийн хүчин зүйлсийг тооцоолж зохих алдагдлын түвшнийг тодорхойлох: Тухайн байгууллагын одоогийн нөхцөл байдал болон ирээдүйн хүлээлтэд нөлөөлж болохуйц макро эдийн засгийн хүчин зүйлсийг тодорхойлж таамаглал боловсруулах;
5. Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолох.

Хорогдуулсан өртгөөр бүртгэгддэг санхүүгийн бүлэг хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг үнэлэхдээ эргэн төлөгдөлт болон хүлээн зөвшөөрсөн гарз хохирлын талаарх түүхэн мэдээллийг харгалзан үзэхээс гадна цаашдын эдийн засаг, зээлжилтийн нөхцөл байдал, түүнээс үүсэх бодит гарз хохирол ямар байх зэрэг хүлээгдэж буй зээлийн алдагдалд үндэслэн зохих тохируулгыг хийнэ.

Хөрөнгийн дансны дүн болон тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалыг анхдагч үр ашигт хүүгийн түвшнээр дискаунтчилян гаргасан өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр үнэ цэнийн бууралтын гарзыг тооцно. Уг гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч, хорогдуулгын дансанд бүртгэнэ. Компани хөрөнгө эргэн нөхөгдөх бодит боломж байхгүй гэж дүгнэсэн үед холбогдох дүнг данснаас хасна. Харин үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгасны дараа болсон үйл явдлын нөлөөгөөр үнэ цэнийн бууралтын гарз буурах нь тодорхой болсон тохиолдолд өмнө нь хүлээн зөвшөөрсөн гарзыг ашиг, алдагдлаар дамжуулан буцаан бүртгэнэ. Үнэ цэнийн бууралтын буцаалтын нөлөөгөөр хөрөнгийн дансны үнэ өмнөх жилүүдэд тооцогдсон үнэ цэнийн бууралт огт тооцоологдоогүй байх дүнгээс хэтрэх ёсгүй. Үнэ цэнийн бууралтыг заавал тодорхойлох ба тодорхойлсноо санхүүгийн тайландаа тодруулна.

Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн нөөцөд хуримтлагдсан гарзыг тайланг хугацааны ашиг, алдагдлаар шинжүүлэн бүртгэнэ. Ашиг, алдагдлаар бүртгэгдэх хуримтлагдсан дүн нь анхны өртгөөс эргэн төлөлт болон хорогдуулгыг хассан дүн болон өнөөгийн бодит үнэ цэнийн зөрүүгээс өмнө нь ашиг, алдагдлаар бүртгэгдсэн үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр тооцогдоно. Өмчийн хөрөнгө оруулалтын ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдсөн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаахлаа ашиг, алдагдлаар дамжуулахгүй. Үнэ цэнийн бууралтын дараа үеийн өсөлтийг бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрнө.



Ашигт Капитал ББСБ ХХК
2022 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого (үргэлжлэл)

3. Ажиллагсдын олговор

а) Ажиллагсдын богино хугацаат олговор

Цалин хэлс, түүнтэй адилтгах олговрыг ажиллагсдын ажил үүргээ гүйцэтгэсэн тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрнө. Ээлжийн амралтын олговор зэрэг богино хугацаанд хуримтлуулан нөхөн олгогддог цалинтай чөлөөний зардлыг уг олговрыг авах эрх нь үүсэх хүртэл ажиллагсдыг үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Харин өвчний чөлөө зэрэг хуримтлуулан нөхөн олгогддоггүй богино хугацааны цалинтай чөлөөг ажиллагсад уг шалтгаанаар чөлөө авсан тухай бүрд зардлаар хүлээн зөвшөөрнө.

б) Тогтмол шимтгэлтэй хөтөлбөр

Хуулийн дагуу Монгол улсын компаниуд Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын сан буюу үндэсний тэтгэвэр, тэтгэмжийн схемд шимтгэл төлдөг. Уг шимтгэлийг тухай бүрд нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

в) Тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр


Тогтоосон тэтгэмжийн үүргийн цэвэр өр төлбөрийг хөтөлбөр бүрээр тусад нь тооцох ба ажиллагсдын тайлант болон өнгөрсөн хугацаанд үзүүлсэн үйлчилгээний төлөө ирээдүйд төлөх тэтгэмжийн тооцоолсон дүнг дискаунтчилсан өнөөгийн үнэ цэнээс хөтөлбөртэй холбоотой хөрөнгийн бодит үнэ цэнийг хассан дүнгээр хэмжигдэнэ. Ингэхдээ төсөлсөн нэгжийн кредит аргыг ашиглана. Тооцооллын үр дүнд компанид өгөөжтэй гарсан тохиолдолд хүлээн зөвшөөрөгдөх хөрөнгийн дүнд нь хөтөлбөрөөс ирээдүйд буцаан авах эсвэл ирээдүйд төлөх шимтгэлийн дүнг бууруулах зэрэг эдийн засгийн өгөөжийн өнөөгийн үнэ цэнээс хэтрэх ёсгүй.

Үйлчилгээний зардал болон тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр/(хөрөнгө)-н хүүгийн цэвэр зардал/(орлого)-г ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч холбогдох функцүүдэд буюу "борлуулалтын өртөг", "борлуулалт, түгээлтийн зардал" эсвэл "удирлалга, тэжиргааны зардал"-д хуваарилан бүртгэнэ. Тайлант үеийн үйлчилгээний зардал нь ажиллагсдын тайлант үед үзүүлсэн үйлчилгээтэй холбоотойгоор тогтоосон тэтгэмжийн өр төлбөрийн өсөлтийн өнөөгийн үнэ цэнээр хэмжигдэнэ.

Тэтгэмжийн хөтөлбөрт өөрчлөлт орсон эсвэл томоохон хэмжээний цомхотгол хийгдсэн тохиолдолд ажиллагсдын өмнөх үеүдийн үйлчилгээтэй холбогдох тэтгэмжийн өөрчлөлт болон цомхотголтой холбоотой олз, гарзыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөхдөө хөтөлбөр өөрчлөгдсөн, цомхотгол хийгдсэн эсвэл холбогдох дахин зохион байгуулалтын өртөг, хөдөлмөр эрхлэлт дуусгавар болох үеийн олговрыг хүлээн зөвшөөрсөн хугацааны аль эхний огноогоор бүртгэлд тусгана.

Тухайн тайлант хугацааны хүүгийн цэвэр зардал/(орлого)-г тодорхойлохдоо тайлант хугацааны эхэнд тогтоосон тэтгэмжийн үүргийн өр төлбөрийг хэмжихэд хэрэглэгдсэн дискаунтын хүүгийн түвшнийг ашиглан тооцно. Уг хүү нь ойролцоо дуусах хугацаатай, эзэлж хэрэглэл өндөртэй корпорацийн бондын тайлант үеийн эцэс дэх өгөөжийн хувь байна.

Тогтоосон тэтгэвэр тэтгэмжийн хөтөлбөрийн дахин хэмжилтийн үр дүнд бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх ба шууд хуримтлагдсан ашигт хааж бүртгэнэ. Дахин хэмжилтийн үр дүнд актуар олз ба гарз, төлөвлөгөөт хөрөнгөөс үүдэлтэй орлого болон тогтоосон тэтгэмжийн хөрөнгийн хүлээн зөвшөөрөгдөх дээд хязгаарын өөрчлөлттэй холбоотой өөрчлөлт (тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-н хүүгийн цэвэр зардал (орлого)-г хассанаар) зэргээс бүрдэнэ.



simple

Ашид Капитал ББСБ ХХК
2022 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд



4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого (үргэлжлэл)

3. Ажиллагсдын олговор (үргэлжлэл)

г) Бусад урт хугацаат олговор

Ажиллагсдын тайлант болон өмнөх үеүүдэд үзүүлсэн үйлчилгээний төлөө ирээдүйд олгох дүнгийн өнөөгийн үнэ цэнээр компанийн ажиллагсдын урт хугацаат олговрын өр төлбөрийн цэвэр дүн хэмжигдэнэ.

д) Хөдөлмөр эрхлэлт дуусгавар болох үеийн олговор

Компани хөдөлмөр эрхлэлт дуусгавар болох үеийн олговрыг олгох сандалаа буцаан татах боломжгүй болсон эсвэл дахин зохион байгуулалттай холбогдох зардлыг хүлээн зөвшөөрөх үе хоёрын аль түүнүд тохнолдсон өдрөөр зардлаар хүлээн зөвшөөрнө. Хэрэв олговор нь тайлангийн өдрөөс хойш 12 сарын дотор бүхэлдээ төлөгдөхөөргүй бол олговрын дүнг дискаунтчилан бүртгэлд тусгана.

И. Сан

Дараах нөхцөлүүдийг зэрэг хангасан тохиолдолд санг хүлээн зөвшөөрнө:

- Өнгөрсөн үйл явдлын үр дүнд одоогийн (хуулиар хүлээсэн эсвэл гэрээний бус) үүрэгтэй байх;
- Үүргийг барагдуулахад шаардлагатай эдийн засгийн үр өгөөж бүхий нөөцийг зарцуулах магадлалтай байх (магдалал >50%);
- Үүргийн дүнгийн талаар найдвартай тооцоолол хийж чадахаар байх;

Хүлээгдэж буй мөнгөн урсгалыг мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн зах зээлийн өнөөгийн үнэлгээ болон тухайн өр төлбөрийн эрхдэлийг тусгасан татварын өмнөх хүүгийн түвшнээр дискаунтчилсан дүнгээр сангийн дүнг хэмждэг. Тайлант хугацаа бүрийн эцэст санг дахин хянаж тооцоолдог. Санг нэмэгдүүлсэн, бууруулсан дискаунтчилсан дүнгээр санхүүгийн зардал хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Й. Түрээс

а) Түрээсийг тодорхойлох

Гэрээ эсвэл гэрээний нэг хэсэг нь төлбөрийн хариуд хөрөнгийг ашиглах эрхийг тодорхой хугацааны турш олгодог бол түүнийг Компани түрээс гэж үздэг. Түрээс гэдэг нь дараах шалгууруудыг хангасан гэрээ юм:

- Тодорхойлсон хөрөнгөтэй;
- Хөрөнгийн ашиглалтаас үүсэх эдийн засгийн бараг бүх үр өгөөжийг Компани хүртдэг; ба
- Компани хөрөнгийн ашиглалтыг удирдан чиглүүлэх эрхтэй.

Бэлтгэн нийлүүлэгч тухайн түрээсийн хөрөнгийг солих, орлуулах эрхтэй эсэхийг Компани харгалзан үзэх ба хэрэв тийм бол тухайн гэрээг түрээсийн гэрээ гэж үзэхгүй.

Хөрөнгийн ашиглалтаас үүсэх эдийн засгийн бараг бүх үр өгөөжийг Компани хүртэх эрхтэй эсэхийг тодорхойлохдоо Компани нь хууль ёсны эзэмшил эсвэл бусад боломжит үр өгөөжтэй хамааралтай бус харин зөвхөн хөрөнгийн ашиглалтаас үүсэх эдийн засгийн үр өгөөжийг л авч үзнэ.



Ашид Капитал ББСБ ХХК
2022 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд

MAGIC
CONSULTING AUDIT

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого (үргэлжлэл)

Й. Түрээс (үргэлжлэл)

Компани нь хөрөнгийн ашиглалтыг удирдан чиглүүлэх эрхтэй эсэхийг тодорхойлохдоо ашиглалтын хугацааны туршид хөрөнгийг хэрхэн, ямар зорилгоор ашиглахаа удирдан чиглүүлэх эрхтэй эсэхийг харгалзан үзнэ. Хөрөнгийн шинж чанарын улмаас шийдвэр нь урьдчилан тодорхойлогдсон тул тухайн хөрөнгийг хэрхэн, ямар зорилгоор ашиглахтай холбоотой хамгийн их хамааралтай шийдвэр гаргахгүй байх үед Компани нь хөрөнгийн загварыг гаргах үед ашиглалтын хугацааны турш хөрөнгийг хэрхэн, ямар зорилгоор ашиглахыг урьдчилан тодорхойлох байдлаар оролцсон эсэхийг харгалзан үзнэ. Хэрэв гэрээ эсвэл гэрээний нэг хэсэг нь эдгээр шалгуурыг хангахгүй бол Компани СТОУС 16-гаас бусад холбогдох СТОУС-ын мөрдөнө.

б) Түрээсийн ангилал

Дараах түрээсийг үйл ажиллагааны түрээсээр бүртгэх бөгөөд бусад бүх түрээсийг ашиглах эрхтэй хөрөнгө ба түрээсийн өр толбөр хүлээн зөвшөөрөх замаар бүртгэнэ:

- Бага үнэ цэнэтэй хөрөнгийн түрээс; ба
- 12 сар эсвэл түүнээс бага хугацаатай түрээс.

Түрээслүүлэгчид төлөх гэрээний төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр түрээсийн өр төлбөрийг хэмжинэ. Түрээсийн нуугдмал хүүгийн түвшнийг шууд тодорхойлох боломжтой бол уг түвшнийг ашигласнаар түрээсийн төлбөрийг дискаунтилна. Хэрэв тэрхүү түвшнийг шууд тодорхойлох боломжгүй бол Компани зээлийн өсөн нэмэгдэх хүүгийн түвшнийг ашиглана.

Зөвхөн индекс эсвэл хувь хэмжээнээс хамааралтай л бол түрээсийн хувьсах төлбөрийг түрээсийн өр төлбөрийн хэмжилтэд оруулна. Ийм үед түрээсийн өр төлбөрийг анх хэмжихдээ хувьсах элементүүд нь түрээсийн хугацаанд өөрчлөгдөхгүй гэж төсөөлдөг. Түрээсийн бусад хувьсах төлбөрүүдийг гарсан үед нь зардлаар хүлээн зөвшөөрнө.

Анхны хүлээн зөвшөөрөлтийн үед түрээсийн өр төлбөрийн дансны үнэд дараах зүйлс багтана:

- үлдэх өртгийн баталгааны дагуу төлөхөөр хүлээгдэж буй дүн;
- худалдан авах сонголтоо Компани хэрэгжүүлэх нь ул үндэслэлтэйгээр тодорхой бол тэрхүү сонголтыг хэрэгжүүлэх үнэ;
- түрээсийг цуцлах сонголтоо хэрэгжүүлэх талаар тухайн түрээсийн нөхцөлд тусгадаг бол түрээсийг цуцалсны улмаас төлөх торгуулийн дүн.

Ашиглах эрхтэй хөрөнгийг анх хэмжихдээ түрээсийн өр төлбөрийн дүнгээс аливаа түрээсийн урамшууллыг хасаж, дараах зүйлсийг нэмж тооцно:

- түрээсийн эхлэл өдөр эсвэл түүнээс өмнө төлсөн түрээсийн төлбөрүүд;
- компани гаргасан анхны шууд зардал; ба
- түрээсийн хөрөнгийг буулгаж нураах, холдуулж зайлуулах эсвэл нөхөн сэргээхийг гэрээгээр шаардсан бол түүнтэй холбоотой компани хүлээн зөвшөөрөх нөөцийн дүн.

Анхны хэмжилтийн дараа түрээсийн өр төлбөрийн дүн нь үлдэгдэл төлбөрийн дүнд тооцсон хүүгийн зардлыг улмаас өсөж, төлсөн түрээсийн төлбөрийн дүнгээр буурна. Ашиглах эрхтэй хөрөнгийг түрээсийн үлдсэн хугацааны турш эсвэл хөрөнгийн ашиглалтын хугацаа нь түрээсийн хугацаанаас богино байх ховор тохиолдолд хөрөнгийн эдийн засгийн ашиглалтын үлдсэн хугацааны турш шулуун шугамын аргаар хорогдуулна.





Ашид Капитал ББСБ ХХК
2022 оны 12 сарын 31-ний өдрөөр тусалбир болсон жилийн
Санхүүгийн Тийлэнгийн Тодруулгууд



4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого (үргэлжлэл)

Й. Түрээс (үргэлжлэл)

Компани аливаа түрээсийн хугацааны тооцоололд өөрчлөлт оруулсан бол (жишээ нь, сунгах эсвэл цуцлах сонголтыг түрээслэгч хэрэгжүүлэх магадлалыг дахин үнэлсэн гэх мэт шалтгаанаар) шинэчлэгдсэн хугацааны турш хийх төлбөрийг илтгэхийн тулд түрээсийн өр төлбөрийн дансны үндэд тохируулга хийх бөгөөд үүнийг түрээсийн эхлэлд мөрдөж байсантай ижил дискаунтын хувь ашиглан дискаунтчилна. Хувь хэмжээ эсвэл индексээс хамааралтай ирээдүйн түрээсийн төлбөрийн хувьсах элементүүдийг шинэчилсэн бол түрээсийн өр төлбөрийн дансны үнийг ч мөн шинэчилнэ. Аль ч тохиолдолд ашиглах эрхтэй хөрөнгийн дансны үндэд зохих тохируулгыг хийх бөгөөд шинэчилсэн дансны үнийг түрээсийн үлдсэн (шинэчилсэн) хугацааны турш хорогдуулна.

Компани нь түрээслүүлэгчтэй түрээсийн гэрээний ноцлолыг дахин хэлэлцэж байх үед гэрээнд орох өөрчлөлтийн шинж чанараас хамаарч нягтлан бодох бүртгэл нь алгаатай байна:

- хэрэв дахин хэлцлийн үр дүнд нэмэлт хөрөнгө ашиглах эрхийн бие даасан үнэтэй дүйцэх нэг эсвэл түүнээс олон нэмэлт хөрөнгийг түрээслэхэд хүргэж байвал дээрх бодлогын дагуу уг өөрчлөлтийг тусдаа түрээс гэж бүртгэнэ;
- дахин хэлцэл нь түрээсийн хамрах хүрээг өсгөж буй бусад бүх тохиолдолд (түрээсийн хугацааг сунгасан, эсвэл нэг эсвэл түүнээс олон нэмэлт хөрөнгийг түрээслэх болсон эсэхээс үл хамааран) өөрчлөлтийн өдрөөр хамаарах дискаунтын хувийг ашиглан түрээсийн өр төлбөрийг дахин хэмжих бөгөөд ашиглах эрхтэй хөрөнгийг ижил дүнгээр залруулна;

Хэрэв дахин хэлцлийн үр дүнд түрээсийн хамрах хүрээ буурихад хүрсэн тохиолдолд түрээсийн бүрэн эсвэл зарим хэсгийг цуцалсан хэмжээг илтгэхийн тулд түрээсийн өр төлбөр болон ашиглах эрхтэй хөрөнгийн аль алины дансны үнийг ижил хэмжээгээр бууруулж, аливаа үүссэн зөрүүг ашиг, алдагдалд тусгана. Үүний дараа дансны үнэ нь дахин хэлэлцсэн хугацааны турш дахин хэлэлцсэн төлбөрийн дүнг илтгэж байгаа гэдгийг бататгахын тулд түрээсийн өр төлбөрт нэмж тохируулга/залруулга хийх бөгөөд үүний тулд өөрчлөгдсөн түрээсийн төлбөрийг өөрчлөлтийн өдрөөр хамаарах хувь хэмжээг ашиглан дискаунтлана. Ашиглах эрхтэй хөрөнгийг ижил дүнгээр тохируулна.

К. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээ

Тайлант хугацаанд гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээ хийгдсэн өдрийн Монгол Банкаас зарласан албан ханшаар хөрвүүлэн бүртгэнэ.

Гадаад валютээр илэрхийлэгдсэн мөнгөн зүйл болох хөрөнгө болон өр төлбөрийг тайлангийн өдрийн Монгол Банкаас зарласан албан ханшийг ашиглан бүртгэлийн валютад хөрвүүлнэ. Түүхэн өртөг нь гадаад валютаар тооцогдсон мөнгөн бус зүйлсийг хаалтын ханшаар хөрвүүлэхгүй.

Бодит үнэ цэнээр хэмжигддэг мөнгөн бус зүйлс болох хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнэ гадаад валютаар тооцогдсон бол уг тооцоолол хийгдсэн өдрийн албан ханшийг ашиглан бүртгэлийн валютад хөрвүүлнэ. Гадаад валютын ханшийн зөрүү ихэвчлэн ашиг, алдагдлаар бүртгэгддэг.




Handwritten signature



2023-09-19

БҮРТ simple



Ашид Капитал ББСБ ХХК
2022 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд

MAGIC
CONSULTING AUDIT

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого (үргэлжлэл)

К. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээ (үргэлжлэл)

Гэхдээ дараах зүйлсийг бүртгэлийн валютад хөрвүүлэхэд үүсэх ханшийн зөрүүг бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрнө:

- Борлуулахад бэлэн байгаа өмчийн хөрөнгө оруулалт (гэхдээ хөрөнгийн үнэ цэнэ нь буурснаас бусад үед, учир нь үнэ цэнийн бууралтын үед өмнө нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдсөн ханшийн зөрүүг тайлант үеийн ашиг, алдагдалд хаадаг);
- Гадаад үйл ажиллагаан дахь цэвэр хөрөнгө оруулалтын хэйджээр тодорхойлогдсон санхүүгийн өр төлбөр (гэхдээ хэйдж нь үр дүнтэй байгаа хүртэлх хэмжээгээр);

2022 оны 12 дугаар сарын 31-ний гадаад валютаар илэрхийлэгдсэн үлдэгдлийг хөрвүүлэхэд ашигласан ханш 1 ам.доллар=3444.60 төгрөг (2021: 1 ам.доллар=2848.80 төгрөг) байсан.

Л. Хүүгийн орлого, зардал

Санхүүгийн орлого нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх хүүгийн орлогоос бүрдэнэ. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан тооцож, аккруал сууриар бүртгэнэ.

Санхүүгийн зардал зээлийн хүүгийн зардал болон санг буцаах дискаунтчиллын дүн тус тус орно. Гадаад валютаар илэрхийлэгдсэн зээлийн өр төлбөрийн ханшийн зөрүүг гадаад валютын ханшийн цэвэр өсөлт, бууралтаас шалтгаалан цэвэр дүнгээр нь санхүүгийн орлого эсвэл санхүүгийн зардалар хүлээн зөвшөөрнө.

М. Зээлийн өртөг

Зориулалтын дагуу ашиглаж эхлэхэд тодорхой хугацаа, бэлтгэл ажиллагаа шаардагдах хөрөнгийн худалдан авалт, бүтээн байгуулалт эсвэл үйлдвэрлэлд шууд хамаарах зээлийн өртгийг тухайн хөрөнгийн өртөгт капиталжуулна. Бусад зээлийн өртгийг гарсан тайлант хугацааны ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Зээлийн хүүгийн зардал гарсан, бэлтгэл ажиллагаа шаардагдах хөрөнгөтэй холбоотой зарцуулалт хийгдэж эхэлсэн, болон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, худалдахад бэлэн болгохтой холбоотой үйл ажиллагаа явагдаж эхэлсэн өдрөөс эхлэн зээлийн зарлыг хөрөнгийн өртөгт капиталжуулж эхэлнэ. Хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, худалдахад бэлэн болгохтой холбоотой үйл ажиллагаа түр сагтах эсвэл бүрмөсөн дуусахад зээлийн зарлыг хөрөнгийн өртөгт капиталжуулахыг мөн адил түр эсвэл бүр зогсооно.

Н. Орлогын албан татвар

Тайлант хугацааны орлогын албан татварын зардал нь тухайн тайлант хугацааны татвар болон хойшлогдсон татварын хөрөнгө болон өр төлбөрийн өөрчлөлтөөс бүрддэг. Тайлант хугацааны орлогын албан татварыг үндсэнд нь тайлант хугацааны ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх боловч бусад дэлгэрэнгүй орлогоор эсвэл шууд өмчийн хэсэгт хүлээн зөвшөөрөгдөх ажил гүйлгээтэй холбогдох татварыг харгалзан бусад дэлгэрэнгүй орлогоор эсвэл шууд өмчийн хэсэгт тус тус хүлээн зөвшөөрнө.



а) Тайлант хугацааны татвар

Тайлант жилийн татвар ногдох орлого нь тайлант хугацааны эцсээр хэрэглэж байгаа эсвэл хэрэглэх нь тодорхой болсон татварын хувийг ашиглан тооцсон татвар болон өмнөх тайлант жилүүдийн татварын ногдуулалтад хийсэн тохируулгыг оруулан төлөхөөр хүлээгдэж буй нийт дүнгээс бүрдэнэ.

Тайлант хугацааны татварын хөрөнгө болон өр төлбөрийг зөвхөн тодорхой шаардлагуудыг хангасан нөхцөлд хооронд нь хааж, цэвэр дүнгээр толилуулдаг.

24





Ашид Капитал ББСБ ХХК
 2022 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд



4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого (үргэлжлэл)

Н. Орлогын албан татвар (үргэлжлэл)

б) Хойшлогдсон татвар

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр нь санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгө эсвэл өр төлбөрийн дансны дүн болон тэдгээрийн татварын суурийн зөрүүтэй холбоотой ирээдүйд татвар ногдох орлогоос хасагдах болон татвар ногдох түр зөрүүнээс бий болдог. Мөн түүнчлэн татварын тайлангаар гарсан алдагдал болон ашиглагдаагүй татварын хөнгөлөлттэй холбоотой хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрдөг.

Цөөн тооны тодорхой заалтаас бусад тохиолдолд, ирээдүйд татвар ногдох эсвэл татвар ногдоо орлогоос хасагдах магадлалтай бүх зөрүүгийн хувьд хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Хасагдах түр зөрүүтэй холбоотой хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрөх үндэслэл болох ирээдүйн татвар ногдох орлогод одоо байгаа татвар ногдох түр зөрүүгийн буцаалтыг оруулан тооцдог ба эдгээр татвар ногдох түр зөрүүнүүд нь нэг татварын байгууллага, нэг аж ахуйн нэгжид хамааралтай байх ёстой. Татварын тайлангаар гарсан алдагдал болон ашиглагдаагүй татварын хөнгөлөлт нь нэг татварын байгууллага, нэг аж ахуйн нэгжид хамаарах ба эдгээрийг ашиглах боломжтой тайлант үе, үеүдэд хангалттай хэмжээний татвар ногдох орлого (одоо байгаа татвар ногдох түр зөрүүг оруулан тооцсоноор)-той ажиллахаар хүлээгдэж байгаа нөхцөлд холбогдох хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн болон татварын тайлагналын аль алинд хүлээн зөвшөөрч бүртгэгддэггүй хөрөнгө болон өр төлбөр (бизнесийн нэгдлийн нэг хэсэг биш), татварын зорилгоор хасагдахгүй гүүдчил, охин компанид оруулсан хөрөнгө оруулалттай холбоотой үүссэн түр зөрүү болон Компани татварын түр зөрүүг буцаах цаг хугацааг хянах боломжтой боловч түр зөрүү нь ойрын ирээдүйд буцаагдахыггүй, эсвэл ирээдүйд татвар ногдох орлогоос хасагдах магадлалтайгаас бусад татвар ногдох орлогоос хасагдах зөрүүтэй холбоотой хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр хүлээн зөвшөөрөхөд тавигддаг тодорхой хязгаарлалт, заалтууд байдаг.

Бүртгэлийн бодлогын дагуу ХОЗҮХХ-ийг бодит үнэ цэнээр хэмжсэнтэй холбоотой үүссэн түр зөрүү нь элэгдлээр дамжин татварын зорилгоор хасагдах тул холбогдох хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг уг хөрөнгийн хүлээгдэж буй хэрэглээ, төлөгдох хэлбэрээс үл хамааран хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгана. Харин бусад бүх тохиолдлуудад, хойшлогдсон татварын хөрөнгийг хөрөнгө, өр төлбөрийн дансны дүнгийн хэрэгжих, төлж барагдуулахаар хүлээгдэж буй хэлбэр дээр үндэслэн тайлант хугацааны эцсээр хэрэглэж байгаа эсвэл хэрэглэх нь тодорхой болсон татварын хувийг ашиглан тооцоолно. Хойшлогдсон татварын хөрөнгө болон өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр хэмжихгүй.

Тайлант жил бүрийн эцэст хойшлогдсон татварын хөрөнгийг эргэн хянах ба уг хөрөнгийн өгөөжийг хүртэх боломжийг олгохуйц хэмжээний татвар ногдох орлого олох магадлал үй болсон тохиолдолд холбогдох дансны дүнг бууруулан бүртгэнэ. Харин хангалттай хэмжээний татвар ногдох орлого олох магадлалтай болсон нөхцөлд өмнө бууруулсан дүнг буцаан дансны дүнг өсгөж бүртгэнэ.

Ногдол ашиг хуваарилсантай холбогдох орлогын албан татварыг ногдол ашгийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрхөн үед хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын хөрөнгө болон өр төлбөрийг зөвхөн тодорхой шаардлагуудыг хангасан тохиолдол л хооронд нь хааж, цэвэр дүнгээр толилуулдаг.



2023-09-19

simple

СЭХ

VI. ХАВСРАЛТ
БҮРТГЭЭ
№ 01

Ашигт Капитал ББСБ ХХК
2022 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд

MAGIC
CONSULTING AUDIT

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого (үргэлжлэл)

Н. Орлогын албан татвар (үргэлжлэл)

в) Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)

Борлуулалтад ногдуулсан НӨАТ-ын өглөг нь (а) харилцагчид НӨАТ-н падаан бичиж өгсөн, (б) харилцагчаас авлагаа цуглуулан авсан, эсвэл (в) харилцагчид бараа, үйлчилгээг хүргэн өгсөн өдрүүдийн аль түрүүлж тохиосон өдрөөр татварын байгууллагад төлөхөөр хүлээн зөвшөөрсөн өглөг юм. Худалдан авалтад төлсөн НӨАТ-ыг мөнгөөр төлсөн үед НӨАТ-ын баримтад үндэслэн борлуулалтын НӨАТ-аас хасч тооцох боломжтой. Татварын байгууллагууд НӨАТ-ыг цэвэр дүнгээр төлж барагдуулахыг зөвшөөрдөг. Борлуулалт, худалдан авалтын НӨАТ-ыг хооронд нь хааж, санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр толилуулдаг.

г) Татварын тодорхой бус байр суурь

Удирдлага компанийн хувьд татварын тодорхой бус байр суурийг тайлант хугацааны эцэс бүрд дахин хянаж үздэг. Удирдлагын зүгээс татварын байгууллага нь компанийн орлогын татварын байр суурийг хүлээн зөвшөөрөхгүйн улмаас нэмэлт татвар ногдуулах магадлал нь ногдуулахгүй байх магадлалаас өндөр гэж үзсэн тохиолдолд өр төлбөр хүлээн зөвшөөрнө.

Уг үнэлгээг тайлант хугацааны эцэсээрх бүхэлдээ буюу үндсэндээ хэрэгжиж буй хууль тогтоомжийн тайлбар, мөн шүүх байгууллагын ижил төстэй маргааныг шийдвэрлэсэн байдал зэрэг дээр үндэслэдэг. Торгууль, алданги болон орлогын бус татвартай холбоотой өглөгийн хувьд, удирдлага тайлант хугацааны эцэс дэх өр төлбөрийг баригдуулахад шаардагдах зардлыг хамгийн найдвартайгаар хэмжин, санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрдөг.

Монгол улсын татвар, мөнхөн тэмдэгт болон гаалийн тухай хууль тогтоомжууд нь өөр хоорондоо зөрүүтэйгээр тайлбарлагдах хандлагатай байдаг. Тодруулга 27-г харна уу.

О. Хувь нийлүүлсэн хөрөнгө

а) Энгийн хувьцаа

Энгийн хувьцаа гаргахтай холбоотой гарсан шууд зардлыг татварын нөлөөг хассан дүнгээр өмчийн хэсэгт хасах дүнгээр тусгана.

б) Давуу эрхтэй хувьцаа

Компани давуу эрхтэй хувьцаанд ногдол ашиг заавал төлөх, мөн эзэмшигч буюу нөгөө талын хүсэлтээр мөнгөөр эргүүлэн худалдан авах үүрэгтэй бол уг давуу эрхтэй хувьцааг санхүүгийн өр төлбөрөөр ангилна. Заавал төлөгдөх ногдол ашгийг аккрузлэдсэн тухай бүрд санхүүгийн зардалд ангилан ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Давуу эрхтэй хувьцаанд ногдол ашиг зарлах үгүйг компани дангаараа шийддэг, мөнгө болон санхүүгийн бусад хөрөнгийг шилжүүлэх эсвэл хувьсах тоо ширхэг бүхий компанийн өмчийн хэрэглүүрээр төлж барагдуулж бунаан худалдан авах үүрэг хүлээгээгүй давуу эрхтэй хувьцааг өмчөөр ангилж бүртгэнэ. Хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрснөөр ногдол ашгийг зарлаж, хүлээн зөвшөөрнө.

26

АШИГТ КАПИТАЛ
ББСБ ХХК

ATA668206109872
9021054

МАНДАЛ КАПИТАЛ
МАРКЕТС УЦК ХХК
MANDAL CAPITAL
MARKETS SC
LLC

367

ШТКУ162 9021070474 521944*

2023.08.18



Ашигт Капитал ББСБ ХХК
2022 оны 12 сарын 31-ний өдөрөөр тасалбар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд



4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого (үргэлжлэл)

О. Хувь нийлүүлсэн хөрөнгө (үргэлжлэл)

в) Халаасны хувьцаа

Хүлээн зөвшөөрч өмчөөр бүртгэгдсэн өөрийн хувьцаанаас эргүүлэн худалдан авсан бол татварын нөлөөллийг тооцож хасан, шууд холбогдох зардлуудыг оруулан нийт төлсөн дүнгээр өмчийг бууруулан бүртгэнэ. Эргүүлэн худалдан авсан хувьцааг халаасны хувьцаа гэж ангилах ба өмчийн нөөц хэсэгт толилуулна. Халаасны хувьцааг эргүүлэн худалдах эсвэл буцаан эргэлтэд оруулах үед хүлээн авсан дүнгээр өмчийг өсгөх ба холбогдох зөрүүг хувьцааны урамшуулалд хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

д) Ногдол ашиг

Ногдол ашгийг зарлаж, батлагдсан тайлант хугацаанд нь ор төлбөрөөр хүлээн зөвшөөрч, өмчийг бууруулан бүртгэнэ. Тайлант хугацаа дуусгавар болсны дараа, санхүүгийн тайланг хэвлэн нийтлэхийг зөвшөөрөхөөс өмнө зарлагдсан ногдол ашгийг тайлагналын өдрийн дараах үйл явдлаар тодруулна.

Ө. Холбоотой талууд

а) Хувь хүн эсвэл түүний ойр дотны гэр бүлийн гишүүнийг дараах тохиолдлуудад компанийн хувьд холбоотой тал гэж үзнэ. Хувь хүн нь:

- (i) компанийг хянадаг эсвэл хамтын хяналттай бол;
- (ii) компанид мэдэгдэхүйц нөлөөтэй бол; эсвэл
- (iii) компани эсвэл түүний толгой компанийн гол албан тушаалтны нэг бол.

Компанитай хийх хэлцэлд өөрөө болон уг хувь хүнээр дамжуулан нөлөө үзүүлэх магадлалтай гэр бүлийн гишүүдийг ойр дотны гэр бүлийн гишүүнд тооцно.

б) Компанийг дараах тохиолдлуудад нөгөө компанийн холбоотой тал гэж үзнэ:

- (i) Нэг групп компанийн гишүүд хоорондоо холбоотой талууд байна;
- (ii) Компани нь нөгөө компанийнхаа хараат компани эсвэл хамтарсан хоронгө оруулалттай компани бол (эсвэл компани нь нөгөө компанийн харьяалагддаг группийн өөр нэг гишүүн компанийн хараат компани эсвэл хамтарсан хөрөнгө оруулалттай компани бол);
- (iii) Хоёр компани хоёулаа нэг ижил гуравдагч талын хамтарсан хөрөнгө оруулалттай компаниуд бол;
- (iv) Компани нь гуравдагч талын хамтарсан хөрөнгө оруулалттай компани ба нөгөө компани нь уг гуравдагч талын хараат компани бол;
- (v) Компани нь нөгөө компанийн эсвэл түүнтэй холбоотой компанийн ажиллагсдын ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хөтөлбөрийн үйл ажиллагааг эрхэлдэг бол;
- (vi) (а)-д тодорхойлогдсон хувь хүн нөгөө компанид хяналт эсвэл хамтын хяналттай бол; эсвэл
- (vii) (а)(i)-д тодорхойлогдсон хувь хүн нөгөө компанид мэдэгдэхүйц нөлөөтэй, эсвэл нөгөө компани эсвэл түүний толгой компанийн гол албан тушаалтны нэг бол.



2023-09-19

simple

VI. ХАВСРАЛТ

БҮРТГЭВ
№ 01

Ашид Капитал ББСБ ХХК
2022 оны 12 сарын 31-ний өөрөөр тасалбар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд

MAGIC
CONSULTING AUDIT

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого (үргэлжлэл)

П. Санхүүгийн тайланг хэвлэн нийтэлсний дараа өөрчлөлт оруулах тухай

Компанийн Захирлуудын Зөвлөл санхүүгийн тайланг хэвлэн нийтэлсний дараа өөрчлөлт оруулах бүрэн эрхтэй болно.

Р. Толилуулгын өөрчлөлтүүд

Шаардлагатай тохиолдлуудад, өмнөх тайлант хугацааны зэрэгцүүлэгдэх мэдээллийг энэ тайлант хугацааны толилуулгатай нийцүүлэн өөрчилсөн. Одоогоор толилуулгын өөрчлөлт байхгүй болно.

5. Нягтлан бодох бүртгэлийн тооцооллууд болон хэмжилтийн суурь

а) Нягтлан бодох бүртгэлийн үндсэн үнэлэмж, тооцоолол болон таамаглал

СТОУС-д нийцсэн санхүүгийн тайлан бэлтгэхтэй холбоотойгоор нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэх явцад санхүүгийн тайланд толилуулагдсан хөрөнгө, өр төлбөр, орлого болон зардлын дүнд нөлөөлөхүйц үнэлэмж, тооцоолол, болон таамаглалыг удирдлагын зүгээс хийх шаардлагатай байдаг. Бодит үр дүн нь эдгээр тооцооллоос ялгаатай байж болно.

Тооцоолол болон үндсэн таамаглалуудыг тасралтгүй эргэн харж, хянана. Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтийг ирээдүйд мөрдөх горимыг баримтлан бүртгэлд тусгана.

Үнэлэмж

Компанийн санхүүгийн тайланд толилуулагдсан зүйлсийн дүнгүүдэд хамгийн их нөлөө үзүүлэх, нягтлан бодох бүртгэлийн бодлогын хүрээнд хийгдсэн үнэлэмжийн талаарх мэдээллийг дараах тодруулгуудаас харна уу:

- Тодруулга 11 – Харилцагчид олгосон зээл ба урьдчилгаа
- Тодруулга 17 – Зээлийн өр төлбөр
- Тодруулга 24 – Санхүүгийн хэрэглүүр - Санхүүгийн эрсдэлийн удирдлага

б) Хэмжилтийн суурь


Компани санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ доор дурдсанаас бусад зүйлсийн хувьд түүхэн өртгөөр бүртгэх зарчмыг баримталсан:

- Анх хүлээн зөвшөөрөхөө бодит үнэ цэнээр бүртгэгддэг санхүүгийн хэрэглүүрүүд;
- Дахин үнэлэгдсэн дүнгээр хэмжигддэг өөрийн хэрэгцээнд ашигладаг барилга байгууламж; болон
- Бодит үнэ цэнээр хэмжигддэг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө.
- Дискаунтчилсан өнөөгийн үнэ цэнээс бодит үнэ цэнийг хассан тэтгэмжийн нөөц

28



2023.08.18



Ашид Капитал ББСБ ХХК
2022 оны 12 сарын 31-ний өдрөөр насалбар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд



6. Шинэ болон өөрчлөгдсөн стандарт болон тайлбаруудын хэрэгжилт

Компани нь 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхэлсэн тайлант хугацаанд доорх нэмэлт өөрчлөлтүүдийг анх удаа мөрдөж эхэлсэн:

Шинэ болон өөрчлөгдсөн стандартууд	Дараах өдрөөс хойших санхүүгийн жилээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ
Нэмэлт өөрчлөлт, СТОУС 9, Санхүүгийн Хэрэглүүр: Санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлтийн '10 хувийн' тестийн тооцоололд оруулах хураамж	2022 оны 1-р сарын 1
Нэмэлт өөрчлөлт, НББОУС 37, Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Хөрөнгө: Алдагдалтай гэрээ—гэрээг биелүүлэх зардал	2022 оны 1-р сарын 1
Нэмэлт өөрчлөлт, НББОУС 16, Өмч, Барилга, Тоног Төхөөрөмж: Зориулалтын дагуу хэрэглэхээс өмнө олсон орлого	2022 оны 1-р сарын 1
Нэмэлт өөрчлөлт, СТОУС 1, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартыг Анх Удаа Хэрэгжүүлэх нь: Стандартыг анх удаа хэрэгжүүлэх буй охин компани	2022 оны 1-р сарын 1
Нэмэлт өөрчлөлт, НББОУС 41, Хөдөө Аж Ахуй: Бодит үнэ цэнийн хэмжилтэн дэх татвар	2022 оны 1-р сарын 1

Компани нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг анх мөрдөж эхлэх үеийн нөлөөлөл, нөлөөллийн үнэлгээг хийсэн ба мэдэгдэхүйц нөлөөллийн дэлгэрэнгүйг доор тодруулав.

Нэмэлт өөрчлөлт, СТОУС 9, Санхүүгийн Хэрэглүүр: Санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлтийн '10 хувийн' тестийн тооцоололд оруулах хураамж

"Санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлтийн '10 хувийн' тестийн тооцоололд оруулах хураамж" (2020 оны 05 дугаар сард батлагдсан ба 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших тайлант хугацаанд мөрдөгдөж эхэлсэн).

Шинэ эсвэл өөрчлөгдсөн санхүүгийн өр төлбөрийн нөхцөл нь анхны санхүүгийн өр төлбөрийн нөхцөлөөс эрс ялгаатай эсэхийг үнэлэх үнэлгээнд ямар хураамжийг оруулан тооцохыг тодорхой болгосон.

Нэмэлт өөрчлөлт, НББОУС 37, Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Хөрөнгө: Алдагдалтай гэрээ—гэрээг биелүүлэх зардал

"Алдагдалтай гэрээ—гэрээг биелүүлэх зардал" (2020 оны 05 дугаар сард батлагдсан ба 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших тайлант хугацаанд мөрдөгдөж эхэлсэн).

Гэрээ алдагдалтай эсэхийг үнэлэхийн тулд гэрээг биелүүлэх (гүйцэтгэх) зардалд ямар зардлыг оруулан тооцохыг тодорхойлсон.



Handwritten signature



Handwritten signature

2023-08

simple

БҮРТГЭГ-02

VI. ХАВСРАЛТ

№ 01

Ашид Капитал ББСБ ХХК
2022 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд

MAGIC
CONSULTING & AUDIT

6. Шинэ болон өөрчлөгдсөн стандарт болон тайлбаруудын хэрэгжилт (үргэлжлэл)

Нэмэлт өөрчлөлт, НББОУС 16, Өмч, Барилга, Тоног Төхөөрөмж: Зориулалтын дагуу ашиглахаас өмнө олсон орлого

"Зориулалтын дагуу ашиглахаас өмнө олсон орлого" (2020 оны 05 дугаар сард батлагдсан ба 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших тайлант хугацаанд мөрдөгдөж эхэлсэн).

Хөрөнгөө бүрэн ашиглагдах оруулахаас өмнө тухайн хөрөнгийг ашиглан үйлдвэрлэсэн зүйлсийг борлуулснаар олсон орлогыг үндсэн хөрөнгийн өртгөөс суутган тооцохыг хориглосон бөгөөд ийм төрлийн орлого болон холбогдох зардыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөхөөр заасан.

Нэмэлт өөрчлөлт, СТОУС 1, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартыг Анх Удаа Хэрэгжүүлэх нь: Стандартыг анх удаа хэрэгжүүлж буй охин компани

"Стандартыг анх удаа хэрэгжүүлж буй охин компани" (2020 оны 05 дугаар сард батлагдсан ба 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших тайлант хугацаанд мөрдөгдөж эхэлсэн).

Хөрвүүлэлтийн хуримтлагдсан зөрүүгийн хэмжилтэй холбоотойгоор охин компаниудад СТОУС 1-г анх удаа хэрэгжүүлэхэд нь хялбар болгож өгсөн.

Уг нэмэлт өөрчлөлт нь санхүүгийн тайланд нөлөөлөхгүй.

Нэмэлт өөрчлөлт, НББОУС 41, Хөдөө Аж Ахуй: Бодит үнэ цэнийн хэмжилтэн дэх татвар

"Бодит үнэ цэнийн хэмжилтэн дэх татвар" (2020 оны 05 дугаар сард батлагдсан ба 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших тайлант хугацаанд мөрдөгдөж эхэлсэн).

Бодит үнэ цэнийг хэмжихдээ татварт төлсөн аливаа мөнгөн дүнг хасах шаардлагыг хүчингүй болгож бусад СТОУС-уудтай уялдуулсан.

Компанид уг өөрчлөлтөд хямрагдсан ажлыг гүйцгээ байгаагүй.

Нягтлан бодох бүртгэлийн шинэ мэдэгдлүүд

2022 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жилийн тусдаа санхүүгийн тайланд авч хэрэглэгдээгүй боловч цаашид Компанийн тусдаа санхүүгийн тайланд нөлөө үзүүлж болзошгүй шинэ стандарт, өөрчлөлтүүдийг жагсаавал дараах байдалтай байна.

<i>Шинэ болон өөрчлөгдсөн стандартууд</i>	<i>Дараах өдрөөс хойших санхүүгийн жилээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ</i>
Шинэ стандарт, СТОУС 17 Даатгалын Гэрээ болон СТОУС 17 Даатгалын Гэрээ-ний нэмэлт өөрчлөлтүүд	2023 оны 1-р сарын 1
Нэмэлт өөрчлөлт, НББОУС 1, Санхүүгийн Тайлангийн Тодруулга: Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Тодруулга	2023 оны 1-р сарын 1
Нэмэлт өөрчлөлт, НББОУС 8, Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа: Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Тодорхойлолт	2023 оны 1-р сарын 1
Нэмэлт өөрчлөлт, НББОУС 12, Орлогын Албан Татвар: Нэг Ажил Гүйцгээгээс Үүссэн Хөрөнгө, Өр төлбөртэй Холбоотой Хойшилогдсон Татвар	2023 оны 1-р сарын 1

30

АШИД КАПИТАЛ
ББСБ ХХК


АТАГАЛЫН ХУДИСТ
МОНГОЛ

МАНДАЛ КАПИТАЛ
МАРКЕТС УЦК ХХК

MANDAL CAPITAL
MARKETS SC
LLC

ШТК0162 900100000001487

2023.08.18



Ашид Капитал ББСБ ХХК
2022 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд



6. Шинэ болон өөрчлөгдсөн стандарт болон тайлбаруудын хэрэгжилт (үргэлжлэл)

Компани нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг анх мөрдөж эхлэх үеийн нөлөөллийн үнэлгээ хийх шатандаа явж байна. Одоогийн байдлаар Компани нь туслаа санхүүгийн тайланд мэдэгдэхүйц нөлөө үзүүж болох нэмэлт өөрчлөлтүүдийн зарим асуудлыг тодорхойлсон. Хүлээгдэж буй нөлөөллийн дэлгэрэнгүйг доор тодруулав.

Шинэ стандарт, СТОУС 17 Даатгалын Гэрээ болон СТОУС 17 Даатгалын Гэрээ-ний нэмэлт өөрчлөлтүүд

"СТОУС 17 Даатгалын Гэрээ" (2017 оны 05 дугаар сард батлагдаж 2020 оны 06 дугаар сар болон 2021 оны 12 дугаар сард тус тус өөрчлөгдсөн ба 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших тайлант хугацаанд мөрдөгдөнө).

Шинэ стандартаар даатгалын гэрээг хэмжих нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн нэг загвар бий болсон. 2020 оны 06 дугаар сард оруулсан өөрчлөлт мөрдөхөд туслах зорилготой бол 2021 оны 12 дугаар сард оруулсан өөрчлөлт нь санхүүгийн хөрөнгө болон даатгалын гэрээний өр төлбөрийн хооронд нягтлан бодох бүртгэлийн түр зуурын уялдаагүй байдал үүсэхээс зайлсхийх, улмаар санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд зэрэгцүүлэгдэх мэдээллийн ашиг тусыг сайжруулахад аж ахуйн нэгжүүдэд туслах зорилготой юм.

Уг нэмэлт өөрчлөлт нь санхүүгийн тайланд нөлөөлөхгүй.

Нэмэлт өөрчлөлт, НББОУС 1, Санхүүгийн Тайлангийн Төмилүүлга: Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Тодруулга

1. Тайлант хугацааны орлогын албан татвар

Тайлант жилийн болон өмнөх хугацааны албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг татварын байгууллагаас буцаан авахаар хүлээж байгаа эсвэл татварын байгууллагад төлөх дүнгээр хэмжинэ. Энэ дүнг тооцоолоход хэрэглэсэн татварын хувь хэмжээ, татварын хуулиуд нь санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан болно.

Эдгээр зүйлд холбоотой тайлант жилийн орлогын албан татварыг орлого үр дүнгийн тайланд биш шууд өөрийн хөрөнгөд хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татвар ногдох дүн ба тэдгээрийн санхүүгийн тайлан дээрх бүртгэлийн хооронд гарах түр зөрүүнд "Балансын арга"-ыг ашиглан хойшлогдсон албан татварыг хүлээн зөвшөөрнө.

2. Хойшлогдсон татвар

Хойшлогдсон албан татварын өр төлбөрийг дор дурдсанаас бусад бүх түр зөрүүнд хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Хойшлогдсон албан татварын өр төлбөр нь гүүдвилийг анх хүлээн зөвшөөрөх үед эсвэл бизнесийн нэгдлийн бус хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээнээс үүссэн, уг гүйлгээ нь НББ-ийн ашиг (алдагдал), татвар ногдох ашиг (алдагдал) - ийн аль алинд нөлөө үзүүлэхгүй байгаа үед,
- Түр зөрүү нь охин болон холбоотой компаниудад оруулсан хөрөнгө оруулалт ба хамтарсан компани дахь ашиг сонирхол зэрэгтэй холбоотойгоор үүссэн, түр зөрүүг хэзээ арилгахыг толгой компани, хөрөнгө оруулагч эсвэл хамтрагч тал хянаж байгаа, түр зөрүү нь ойрын хугацаанд арилахгүй байх магадлалтай байгаа үед,

Дор дурдсанаас бусад тохиолдолд хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгийг татвар ногдох орлогоос хасагдах бүх түр зөрүүнүүд, ирээдүйд шилжүүлэн тооцох, ашиглаагүй татварын бүх хөнгөлөлт ба алдагдлуудад (эдгээр түр зөрүү, хөнгөлөлт, алдагдлуудыг хасаж болох татвар ногдох орлогын ирээдүйд орж ирэх нь тодорхой болсон үед) хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Татвар ногдох орлогоос хасагдах түр зөрүүтэй холбоотой хойшлогдсон албан татварын хөрөнгө нь бизнесийн нэгдлийн бус хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг анх хүлээн зөвшөөрөх үед үүссэн ба гүйлгээ гарах үед, НББ-ийн болоод татварын ашиг (алдагдал) - ийн аль алинд нөлөө үзүүлэхгүй байгаа үед;
- Татвар ногдох орлогоос хасагдах түр зөрүү нь охин болон холбоотой компаниудад оруулсан хөрөнгө оруулалт ба хамтарсан компани дахь ашиг сонирхолтой холбоотойгоор үүссэн бол хойшлогдсон албан татварын хөрөнгийг, түр зөрүү нь ойрын хугацаанд арилах магадлалтай, түр зөрүүг хасаж болох татвар ногдох орлого орж ирэх нь тодорхой болсон үед зөвхөн хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын хөрөнгийн бүртгэлийн дүнг тайлант хугацаа бүрийн эцэст хянаж үзэх ба хойшлогдсон татварын хөрөнгийг хэсэгчлэн эсвэл бүхлээр нь нөхөн олж авахад хүрэлцэхүйц хэмжээний татвар ногдох орлого цаашид орж ирэх нь тодорхойгүй болсон үед харгалзах хэмжээгээр хөрөнгийн дүнг бууруулна.

Хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант хугацаа бүрийн эцэст дахин үнэлж үзэх ба хойшлогдсон татварын хөрөнгийг нөхөн олж авахад хүрэлцэхүйц хэмжээний татвар ногдох орлого цаашид орж ирэх нь тодорхой болсон үед харгалзах хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн тайлант хугацааны эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээнүүд дээр үндэслэн хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах тайлант хугацаанд хэрэглэгдэхээр хүлээгдэж буй татварын хэмжээгээр хойшлогдсон татварыг тооцно.



АШИД КАПИТАЛ БВСБ ХХК



2023 оны 6 дугаар сарын 30-ны өдөрөөр тасалбар болсон хаягс жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

3. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Й. Татвар (үргэлжлэл)

2. Хойшлогдсон татвар (үргэлжлэл)

Хэрэв өнөөгийн татварын хөрөнгийг татварын өр төлбөрт суутгуулах хууль ёсны эрхтэй бөгөөд хойшлогдсон татварууд нь нэг татвар төлөгч аж ахуйн нэгж ба нэг татварын байгууллагатай холбоотой байгаа бол хойшлогдсон албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлж болно. Татварын байгууллагаас авах эсвэл татварын байгууллагад өгөх өглөгийн цэвэр дүнг санхүүгийн байдлын тайланд авлага эсвэл өглөгийн нэг хэсэг болгон толилуулна.

К. Зээлийн эрсдэлийн удирдлага

Компанийн харилцагчид зээлийн нөхцөлөөр худалдан авалт хийгээд түүнийгээ төлж чадахгүй болсноор Компанид санхүүгийн хохирол учрах зээлийн эрсдэлийг үүсгэдэг. Санхүүгийн хөрөнгийн дансны үнэ нь аливаа хасагдуулгыг хассан цэвэр дүнгээр илэрхийлэгдсэн ба зээлийн эрсдэлийн дээд хэмжээ нь санхүүгийн тайлан дахь санхүүгийн хөрөнгө бүрийн дансны үнээр хязгаарлагддаг.

2023 оны 6-р сарын 30-ны байдлаарх компанийн зээлийн эрсдэлд хамгийн ихээр өртөж болох дүнгүүдийг хөрөнгийн ангиллаар доор харуулав:

	2023 оны 06-р сарын 30 мян.төг	2022 оны 12-р сарын 31 мян.төг
Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө	13,716,800	28,531,631
Зээл /Цэврээр/	131,130,388	137,694,383
Бусад авлага	3,252,526	1,891,799
	148,099,714	168,117,813

Л. Гадаад валютын ажил гүйлгээ

Гадаад валютын эрсдэл гэдэг нь гадаад валютын ханшийн өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнэ хэлбэлзэх эрсдэл юм. Компанийн гадаад валютын ажил гүйлгээ нь ихэнхдээ америк доллароор хийгддэг. Дараах хүснэгтэд америк долларын сүүлийн 3 жилийн ханшийн өөрчлөлтийг харууллаа.

Үзүүлэлт	Хаалтын ханш	Өсөлт, бууралт	Өсөлт бууралтын хувь
2021.12.31	2,848.80	-0.71	-0.02%
2022.12.31	3,444.60	595.80	21.00%
2023.06.30	3,432.51	-12.09	-0.35%


М. Төлбөрийн чадварын эрсдэл

Төлбөрийн чадварын эрсдэл нь аливаа аж ахуйн нэгж нь санхүүгийн өр төлбөрийг барагдуулах үүргээ биелүүлэхэд хүндрэл үүсэх эрсдэлийг илэрхийлдэг. Энэ нь компани санхүүгийн өр төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулахад хүндрэлтэй тулгарах эрсдэл юм.

Компанийн бодлого нь өр төлбөр төлөх хугацаа болоход хангалттай бэлэн мөнгөтэй байх явдал юм. Энэ зорилгод хүрэхийн тулд Компани нь хүлээгдэж буй шаардлагыг биелүүлэхийн тулд тогтмол бэлэн мөнгөний үлдэгдэлтэй байх явдал юм.

Компани нь өөрийн бэлэн мөнгөний эх үүсвэрээс өдөр тутмын хэрэгцээг хангаж байна. Төлбөрийн чадварын эрсдэлийг Компанийн удирдлага зохицуулдаг бөгөөд удирдлага нь компанийн мөнгөн урсгалын сар бүрийн төсвийг хянадаг.





АШИД КАПИТАЛ ББСБ ХХК



2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болсон хагас жилийн
 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

3. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

М. Төлбөрийн чадварын эрсдэл (үргэлжлэл)

Компани нь төлбөрийн чадварыг удирдахын тулд сар бүр мөнгөн урсгалын тайлан бэлдэж зайлшгүй төлөгдөх төлбөр болон нэмэлт шаардлагатай мөнгөн урсгалын бэлэн байдлыг тооцоолдог. Мөн ирээдүйн учирч болох мөнгөн урсгалын тасалдлыг илрүүлж, төлөвлөж ажилладаг. Төлбөрийн чадварын эрсдэл нь Компанийн мөнгөн урсгалыг удирдах чадвараас үүсдэг. Компани тухайн жилийн төсвийг мөнгөн урсгалын хэрэгцээ шаардлагыг үнэлсний үндсэн дээр бэлтгэдэг.

Компанийн өр төлбөрийг насжилтаар нь харуулбал:

	1 жил хүртэл	(мянган төгрөг) 1 жилээс дээш
2023-06-30-ны байдлаар		
Богино хугацаат өр төлбөр	24,980,137	-
Бусад эх үүсвэр	6,030,300	-
Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	1,030,207	-
Бусад өглөг	6,088,160	-
Хоёрдогч өглөг		50,000,000
	38,128,804	50,000,000

Н. Тасралтгүй байх зарчим

Санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ компани нь тасралтгүй байх чадвартай эсэхийг удирдлагууд дүгнэж тогтооно. Санхүүгийн тайланг тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэх эсэхийг тогтоохдоо, одоогийн болон ойрын ирээдүйн, боломжит бүх мэдээллийг харгалзан үзнэ. Тодруулбал: Удирдлага нь одоогийн болон тухайн тайлант үеийн эцсээс хойших хамгийн багадаа 12 сарын хугацаан дахь ирээдүйн ашиг орлоготой байдал, өр төлбөрийн эргэн төлөлтийн хуваарь болон дахин санхүүжилтийн боломжит эх үүсвэр зэргийг тооцож үзнэ.

Хэрэв компанийн удирдлага нь тайлант үеийн дараа компанийг татан буулгахаар эсвэл худалдаа, арилжааг нь зогсоохоор төлөвлөж байгаа, эсвэл ийнхүү татан буулгах, зогсоохоос өөр сонголт байхгүй гэж дүгнэсэн тохиолдолд, санхүүгийн тайланг тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэхгүй.

4. Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

	2023 оны 06-р сарын 30 мян.төг	2022 оны 12-р сарын 31 мян.төг
Касс дахь мөнгө	-	-
Банкин дахь харилцах данс	4,146,915	12,117,496
Банкин дахь хадгаламжийн данс	9,569,885	16,414,135
	13,716,800	28,531,631

2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөрх мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдлийг үндсэн валютаар илэрхийлбэл:

Валют	2023 оны 06-р сарын 30 мян.төг	2022 оны 12-р сарын 31 мян.төг
Монгол төгрөг	4,948,734	28,518,862
Америк доллар	8,767,981	12,674
Юань	85	95
	13,716,800	28,531,631



АШИД КАПИТАЛ ББСБ ХХК



2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болсон хагас жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

5. Богино хугацаат хөрөнгө оруулалт

	2023 оны 06-р сарын 30 мян.төг	2022 оны 12-р сарын 31 мян.төг
Богино хугацаат хөрөнгө оруулалт	5,000,000	3,000,000
	5,000,000	3,000,000

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 456 тоот тогтоолоор олгосон "Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх" тусгай зөвшөөрлийн хүрээнд 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 5,000,000 (2022: 3,000,000) мянган төгрөгийн богино хугацаат хөрөнгө оруулалт хийсэн.

6. Зээл (цэврээр)

	2023 оны 06-р сарын 30 мян.төг	2022 оны 12-р сарын 31 мян.төг
Хэвийн	120,740,782	127,267,528
Хугацаа хэтэрсэн	5,730,298	5,046,594
Хэвийн бус	3,162,757	3,229,523
Эргэлзээтэй	5,150,520	6,420,898
Муу	7,672,470	3,267,429
Зээлийн эрсдэлийн сан	(11,326,439)	(7,537,588)
	131,130,388	137,694,383

Компанийн нийт зээлийн багцын 65% (2022: 75%) нь Simple аппликэйшнээр олгосон дижитал зээл ба үлдэх хэсгийг жижиг, дунд бизнес эрхлэгч иргэдэд зориулсан болон репо арилжааны зээлийн багц эзэлж байна.


7. Бусад авлага

	2023 оны 06-р сарын 30 мян.төг	2022 оны 12-р сарын 31 мян.төг
Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага	1,894,045	1,774,221
Хуримтлуулж тооцсон үнэт цаасны хүүгийн авлага	284,219	88,233
Бусад	1,074,262	29,345
	3,252,526	1,891,799

8. Бусад хөрөнгө

	2023 оны 06-р сарын 30 мян.төг	2022 оны 12-р сарын 31 мян.төг
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	834,063	277,193
Материал, үнэ бүхий зүйлс	10,124	14,459
Бусад	2,239	1,002
	846,426	292,654





АШИД КАПИТАЛ ББСБ ХХК



2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болсон хагас жилийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

9. Үндсэн хөрөнгө

	2023 оны 06-р сарын 30 мян.төг	2022 оны 12-р сарын 31 мян.төг
Тавилга эд хогшил	354,209	62,641
Хуримтлагдсан элэгдэл. ТЭХ	(13,027)	(3,558)
Техник хэрэгсэл	373,768	83,800
Хуримтлагдсан элэгдэл (техник хэрэгсэл)	(79,839)	(28,272)
	635,111	114,611

10. Түрээс

а) Ашиглах эрхтэй хөрөнгө

	Барилга байгууламж мян.төг
2021 оны 12 дугаар сарын 31	334,483
Нэмэгдсэн	295,674
Хорогдуулга	(630,157)
2022 оны 12 дугаар сарын 31	-
Нэмэгдсэн	1,303,417
Хорогдуулга	(610,551)
2023 оны 6 дугаар сарын 30	692,866

б) Түрээсийн өр төлбөр

	Барилга байгууламж мян.төг
2021 оны 12 дугаар сарын 31	343,928
Нэмэгдсэн	272,609
Хүүгийн зардал	23,065
Түрээсийн төлбөр	(639,602)
2022 оны 12 дугаар сарын 31	-
Нэмэгдсэн	1,303,417
Хүүгийн зардал	58,446
Түрээсийн төлбөр	(659,208)
2023 оны 6 дугаар сарын 30	702,655

Компани нь Шангри-Ла-Улаанбаатар ХХК-ийн барилга Сэнтрал Тауэр-ийн 5 болон 15 давхарт оффисын барилга түрээсэлдэг.

11. Биет бус хөрөнгө

	2023 оны 06-р сарын 30 мян.төг	2022 оны 12-р сарын 31 мян.төг
Программ хангамж	766,131	766,131
Хуримтлагдсан хорогдол (Программ хангамж)	(170,086)	(130,298)
Барааны тэмдэг	12,000	12,000
Хуримтлагдсан хорогдол (Барааны тэмдэг)	(992)	(398)
	607,053	647,435



АШИД КАПИТАЛ ББСБ ХХК



2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болсон хагас жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

12. Өр төлбөр

Богино хугацаат

	2023 оны 06-р сарын 30 мян.төг	2022 оны 12-р сарын 31 мян.төг
Өрийн бичгээрх өглөг *	24,980,137	49,939,562
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	6,030,300	-
Хуримтлуулж тооцсон бусад хүүгийн өглөг	1,030,207	1,014,356
Цалингийн өглөг	10,074	82,101
ЭМД,НДШ-ийн өглөг	-	1,995
ХАОАТ-ын өглөг	30	52
Орлогын албан татварын өглөг	231,540	352,719
Санхүүгийн түрээсийн өглөг	702,655	-
Бусад	5,143,861	8,971,910
	38,128,804	60,362,694

- Компани нь 2021 оны 04-р сарын 23-нд толгой компани болох М-Си-Эс Холдинг ХХК-аас жилийн 13%-ийн хүүтэй, 15,000,000 мянган төгрөгийн 2023 оны 04-р сарын 23-нд төлөгдөх нөхцөлтэй өрийн бичгийг гаргасан ба уг өрийн бичгийг төлж барагдуулсан байна.

2021 оны 12 сарын 23-нд гаргасан нэгжийн 100,000 төгрөгийн үнэтэй, 7,5%-13% хүүтэй 100,000 ширхэг хаалттай бондыг төлж барагдуулсан.

Мөн Компани нь 2022 оны 02-р сарын 08-наас 2022 оны 04-р сарын 05-ны өдрийн хооронд нэгжийн 100,000 төгрөгийн үнэтэй, 13 хувийн хүүтэй, 250,000 ширхэг хаалттай бондуудыг гаргасан байна. Эргэн төлөгдөх хугацаа нь 2023 оны 08-р сарын 09-нөөс 2023 оны 10-р сарын 05-ны хооронд байна.

Урт хугацаат

	2023 оны 06-р сарын 30 мян.төг	2022 оны 12-р сарын 31 мян.төг
Хоёрдогч өглөг	50,000,000	50,000,000
	50,000,000	50,000,000

Компани нь толгой компани болох М-Си-Эс Холдинг ХХК-аас 2021 оны 6-р сарын 02-нд 20,000,000 мянган төгрөг, 2021 оны 09-р сарын 17-нд 30,000,000 мянган төгрөг, нийт 50,000,000 мянган төгрөгийн хоёрдогч өглөгийг жилийн 13%-ийн хүүтэй 5 жилийн хугацаатай авсан.

13. Хувьцаат капитал

	2023 оны 06-р сарын 30 мян.төг	2022 оны 12-р сарын 31 мян.төг
Энгийн хувьцаа	55,000,000	55,000,000
	55,000,000	55,000,000

Компанийн хувьцаат капитал 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нэг бүр нь 1 мянган төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 55,000,000 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байсан.





АШИД КАПИТАЛ ББСБ ХХК



2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болсон хагас жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

14. Хуримтлагдсан ашиг

	2023 оны 06-р сарын 30 мян.төг	2022 оны 12-р сарын 31 мян.төг
Тайлант үеийн ашиг	5,942,547	8,468,665
Өмнөх үеийн ашиг (алдагдал)	6,809,819	(1,658,847)
	12,752,366	6,809,819

15. Хүү ба түүнтэй адилтгах орлого

	2023 оны 06-р сарын 30 мян.төг	2022 оны 12-р сарын 31 мян.төг
Зээлийн хүүгийн орлого	17,229,900	32,087,081
Үнэт цаасны хүүгийн орлого	648,589	88,233
Харилцах, хадгаламжийн хүүгийн орлого	1,631,595	969,145
	19,510,083	33,144,460

16. Хүү ба түүнтэй адилтгах зардал

	2023 оны 06-р сарын 30 мян.төг	2022 оны 12-р сарын 31 мян.төг
Банкны байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал	-	(3,744)
Өрийн бичгийн хүүгийн зардал	(6,309,639)	(12,448,066)
	(6,309,639)	(12,451,811)

17. Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого

	2023 оны 06-р сарын 30 мян.төг	2022 оны 12-р сарын 31 мян.төг
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	1,141,431	1,376,762
	1,141,431	1,376,762

18. Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого (зардал)

	2023 оны 06-р сарын 30 мян.төг	2022 оны 12-р сарын 31 мян.төг
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	3,428	10,573
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал	(119,791)	(9)
	(116,363)	10,564



АШИД КАПИТАЛ ББСБ ХХК



2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болсон хагас жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

19. Боловсон хүчинтэй холбоотой зардал

	2023 оны 06-р сарын 30 мян.төг	2022 оны 12-р сарын 31 мян.төг
Ажилтнуудын цалин	(1,308,786)	(2,448,245)
Халамж, тэтгэмж	(3,966)	(4,655)
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал	(162,773)	(309,200)
Албан томилолт	(11,763)	(12,614)
Сургалтын зардал	(9,200)	(47,808)
Бусад зардал	(62,960)	(30,637)
	(1,559,448)	(2,853,157)

20. Ерөнхий ба удирдлагын зардал

	2023 оны 06-р сарын 30 мян.төг	2022 оны 12-р сарын 31 мян.төг
Авлагыг барагдуулахтай холбогдон гарсан зардал	(101,406)	-
Аудитын төлбөр, мэргэжлийн үйлчилгээ	(19,292)	(152,613)
Даатгал	(93)	(1,540)
Түрээс	(120,706)	(186,334)
Ашиглалтын зардал /цахилгаан, уур ус, дулаан/	(17,858)	(26,099)
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	(711,969)	(714,909)
Харуул, хамгаалалтын зардал	(26,490)	(52,280)
Харилцаа холбоо, интернэт	(166,793)	(269,035)
Шатахуун болон тээврийн зардал	(6,094)	(8,993)
Сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ	(5,639)	(31,048)
Зохицуулалтын хураамжийн зардал	(18,564)	(10,281)
Хөдөлмөр хамгаалал, галын аюулаас хамгаалах	(50)	(31,973)
Автоматжуулалттай холбоотой урсгал зардал	(484,102)	(1,177,458)
Зар сурталчилгаа, маркетингийн судалгаа	(188,611)	(487,627)
Бичиг хэргийн зардал	(29,689)	(81,463)
Ариун цэврийн зардал	(15,942)	(83,062)
Харилцагчдын сургалт судалгааны зардал	-	(39)
Бусад зардал	(292,717)	(355,369)
	(2,206,016)	(3,670,125)

21. Зээлийн үнэ цэнийн (зардал), буцаалт

	2023 оны 06-р сарын 30 мян.төг	2022 оны 12-р сарын 31 мян.төг
Эрсдэлийн сангийн зардал-Зээл	(3,788,851)	(6,111,106)
	(3,788,851)	(6,111,106)

22. Орлогын татварын зардал

	2023 оны 06-р сарын 30 мян.төг	2022 оны 12-р сарын 31 мян.төг
Тайлант хугацааны татварын зардал	(550,600)	(708,229)
Хойшлогдсон татварын зардал	(123,357)	(165,123)
	(673,957)	(873,352)





АШИД КАПИТАЛ ББС ХХК



2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болсон хагас жилийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

23. Холбоотой талуудын тодруулга

Холбоотой талуудыг тодорхойлох

Компанийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаатай холбоотой хяналт хэрэгжүүлдэг талууд болон түүнтэй шууд хамааралтай талуудыг холбоотой тал гэж үзэх бөгөөд холбоотой талууд нь хувь хүмүүс, аж ахуйн нэгж байгууллагууд байж болно.

Холбоотой талуудыг тодорхойлохдоо компаниас гаргаж өгсөн болон нийтэд ил тод байгаа мэдээлэлд суурилсан учраас тодруулагдаагүй бусад холбоотой талууд, ажил гүйлгээ байж болзошгүй.

Компанийн холбоотой талууд болон тэдгээрийн харилцан хамаарлыг харуулбал:

Холбоотой талууд	Харилцан хамаарал	Гол ажил гүйлгээний төрөл
М-Си-Эс Холдинг ХХК	Толгой компани	Хоорондын тооцоо
Симпл Ассет ХХК	Охин компани	Хоорондын тооцоо
Анунгоо ХХК	Бусад холбоотой тал	Хоорондын тооцоо
Баяка Трейд ХХК	Бусад холбоотой тал	Хоорондын тооцоо
Вэлл Бий ХХК	Бусад холбоотой тал	Хоорондын тооцоо
Маркет Гейт ХХК	Бусад холбоотой тал	Хоорондын тооцоо
М Армор ХХК	Бусад холбоотой тал	Хоорондын тооцоо
М-Си-Эс Кока Кола ХХК	Бусад холбоотой тал	Хоорондын тооцоо
М банк хаалттай ХК	Бусад холбоотой тал	Хоорондын тооцоо
Пик Пак ХХК	Бусад холбоотой тал	Хоорондын тооцоо
Юнител ХХК	Бусад холбоотой тал	Хоорондын тооцоо
Юнивишн ХХК	Бусад холбоотой тал	Хоорондын тооцоо
Юни Сервис Солюшн ХХК	Бусад холбоотой тал	Хоорондын тооцоо
Топ моторс ХХК	Бусад холбоотой тал	Хоорондын тооцоо
Тэнгэрлэг Эх Орон ХХК	Бусад холбоотой тал	Хоорондын тооцоо

Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний тооцооны үлдэгдэл

2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаарх холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний тооцооны үлдэгдлийн мэдээллийг доор харууллаа.

Холбоотой талаас авгах авлага	2023 оны 06-р сарын 30 мян.төг	2022 оны 12-р сарын 31 мян.төг
Тэнгэрлэг Эх Орон ХХК	27,500	-
Юнивишн ХХК	265	265
Шангри-Ла Улаанбаатар ХХК	318,920	19,011
М банк хаалттай ХК	17,199	7,277
Бусад	4,461	50,301
	368,345	76,854



2023.08.18

АШИД КАПИТАЛ ББСБ ХХК



2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болсон хагас жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

23. Холбоотой талуудын тодруулга (үргэлжлэл)

	2023 оны 06-р сарын 30 мян.төг	2022 оны 12-р сарын 31 мян.төг
Холбоотой талд өгөх өглөг		
М-Си-Эс Холдинг ХХК	50,000,000	65,000,000
М-Си-Эс Проперти ХХК	24,980,137	34,947,931
Симпл Ассет ХХК	4,730,533	8,521,547
Анунгоо ХХК	116	-
М банк хаалттай ХК	-	7,277
Шангри-Ла Улаанбаатар ХХК	702,655	-
Юнивишн ХХК	-	12,448
Вэлл Бий ХХК	1,304	288
Пик Пак ХХК	-	1,932
	80,414,745	108,491,423

24. Хүлээж болзошгүй үүрэг хариуцлага

Татвар, Нийгмийн даатгалын хууль, зохицуулалт

Монгол улсын татвар, Нийгмийн даатгал, бусад хууль тогтоомжууд нь өөр хоорондоо зөрүүтэйгээр тайлбарлагдах тохиолдол байдаг. Мөн түүнчлэн төрийн байгууллагууд хууль тогтоомжийг тайлбарлан үнэлэхдээ хатуу байр суурь баримталдаг ба өмнө нь маргалдаж байгаагүй үйл ажиллагаа, ажил гүйлгээг үгүйсгэх боломжтой. Үүний үр дүнд, мэдэгдэхүйц хэмжээний нэмэлт татвар, торгууль болон алдангийг ногдуулах магадлалтай байдаг. Хэдийгээр Компанийн удирдлага бусдын өмнө хүлээсэн болзошгүй үүрэг хариуцлага болон алдагдал учрах үйл явдал тохиолдоогүй гэж үзэж болох боловч төрийн байгууллагуудын байр суурийг урьдчилан таамаглах боломжгүй юм.

Шүүхийн нэхэмжлэл

2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Ашид Капитал ББСБ ХХК-ийн эсрэг гаргасан ямар нэг томоохон зарга маргаан, шийдвэрлэгдээгүй нэхэмжлэл байгаагүй. Өөрөөр хэлбэл, байгууллагын ирээдүйн тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадварт эргэлзээ төрүүлэхүйц болзошгүй өр төлбөрийн эрсдэл байхгүй байна.





simple


МОНГОЛЫН ХӨРӨНГЭЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

VI. ХАВСРАЛТ

БҮРТГЭСЭН

ҮНДЭСНИЙ АУДИТЫН КОМПАНИ

Since 2007



МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 25-р хороо, UB Tower, 15-р давхар, 1502 тоот

Утас: 7013-1044

Цахим хуудас: www.magicgroup.mn

Э-шуудан: audit@magicgroup.mn



2023.08.18

6.37 АНДЕРРАЙТЕРИЙН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ТУХАЙ МЭДЭГДЭЛ

Golomt Capital
Delivering diversity

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Чингисийн өргөн чөлөө 24, Парк Плэйс
оффисын барилга, 4 давхар, 403 тоот,
Утас: 7012-1530, 7012-1529
И-мэйл: info@golomtcapital.com,
Вэбсайт: www.golomtcapital.com

САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО
БОЛОН МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН БИРЖИД

№ _____
2023.08.18 -ны № 23/386 Т

*Нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг
сонирхлын талаар мэдэгдэл гаргах тухай*

“Голомт Капитал ҮЦК” ХХК нь “Ашид Капитал ББСБ” ХХК-ийн гаргахаар төлөвлөж буй нээлттэй өрийн хэрэгслийг олон нийтэд танилцуулах, санал болгох төсөлд андеррайтерын үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Манай компани уг үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч бусад талуудтай холбогдох хууль, журам болон талуудын хооронд байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд хамтран ажиллаж буй бөгөөд доор дурдсан этгээдүүдтэй уг үнэт цаасыг гаргахаас бусад аливаа асуудлаар нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхолгүй болохоо үүгээр баталгаажуулан мэдэгдэж байна.

1. Үнэт цаас гаргагч “Ашид Капитал ББСБ” ХХК
2. Хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч “Өмгөөллийн Батбаяр энд Партнерс” ХХН
3. Санхүүжих чадварын зэрэглэлийн үнэлгээний компани “Монголын Хөрөнгө Оруулалтын Зэрэглэлийн Эжинс” ХХК
4. Аудитын компани “Мэжик Консалтинг Аудит” ХХК
5. Хөрөнгийн үнэлгээний компани “Эм Би Ви Си” ХХК

Баталгаажуулсан,
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ





С. ГАН-ЭРДЭНЭ

000956



2023.08.18



6.38 ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХ КОМПАНИЙН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ТУХАЙ МЭДЭГДЭЛ

Mongolian Investment Rating Agency

☎ +976 9903-0338
✉ info@mira.mn
🌐 http://www.mira.mn
📍 #605, Max Tower, 4 khoroo,
Juuichin street Chingeltei District,
Ulaanbaatar, 15170 Mongolia

Монголын хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси ХХК

2023 оны 08 дугаар сарын 17-ны өдөр

No.: 29/2023

"ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ С. ГАН-ЭРДЭНЭ ТАНАА

Баталгаажуулах захидал хүргүүлэх тухай

Тус компани нь "Ашид Капитал ББСБ" ХХК-ийн гаргахаар төлөвлөж буй нээлттэй өрийн хэрэгсэлд зээлжих зэрэглэл тогтоон ажиллаж байна.

Манай байгууллага уг үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч бусад талуудтай холбогдох хууль, журам болон талуудын хооронд байгуулсан гэрээ, хэлцлийн хүрээнд хамтран ажиллаж буй бөгөөд доор дурдсан этгээдүүдтэй уг үнэт цаас гаргахаас бусад аливаа асуудлаар нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхолгүй болохоо үүгээр баталгаажуулж байна.

1. Үнэт цаас гаргагч "Ашид Капитал ББСБ" ХХК
2. Үндсэн андеррайтер "Голомт Капитал ҮЦК" ХХК
3. Туслах андеррайтер "Мандал Капитал Маркетс ҮЦК" ХХК
4. Хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч "Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс" ХХН
5. Аудитын компани "Мэжик Консалтинг Аудит" ХХК
6. Хөрөнгийн үнэлгээний компани "Эм Би Ви Ся" ХХК

Хүндэтгэсэн,



Цэдэвсүрэнгийн Мөнхбаяр
Гүйцэтгэх захирал


The MIRA is the first credit rating agency in Mongolia



474



2023.08.18



6.39 ХУУЛИЙН КОМПАНИЙН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ТУХАЙ МЭДЭГДЭЛ



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО
БОЛОН МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
БИРЖ ТАНАА

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, ИЭСЭ, СТЭБААТАР ДҮҮРЭГ, 1-Р ХОРОО, ЧИНГЭСНИЙ ӨРГӨН ЧӨЛӨӨ-18, МОНГОЛ ТӨ ЦАХИГАТ, 10-Р ДАВХАР, 1001-1003, УТАС/ФАКС: (976) 7711-8008, ЦАХИМ ШУУДАН: CONTACT@BNP.MN, ЦАХИМ ХАЯГ: WWW.BNP.MN

2023.08.17 № 45/23
танай _____-ны/ний № _____-т

Нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхлын талаар мэдэгдэл гаргах

Өмгөөллийн "Батбаяр энд Партнэрс" ХХН ("Хуулийн фирм") нь "Ашид Капитал ББСБ" ХХК-ийн гаргахаар төлөвлөж буй нээлттэй өрийн хэрэгслийг олон нийтэд танилцуулах, санал болгох төсөлд хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Хуулийн фирм нь уг үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч бусад талуудтай холбогдох хууль, журам болон талуудын хооронд байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд хамтран ажиллаж буй бөгөөд доор дурдсан этгээдүүдтэй уг үнэт цаасыг гаргахаас бусад аливаа асуудлаар нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхолгүй болохоо үүгээр баталгаажуулан мэдэгдэж байна.

1. Үнэт цаас гаргагч "Ашид Капитал ББСБ" ХХК
2. Үндсэн андеррайтер "Голомт Капитал ҮЦК" ХХК
3. Туслах андеррайтер "Мандал Капитал Маркетс ҮЦК" ХХК
4. Санхүүжих чадварын зэрэглэлийн үнэлгээний компани "Монголын Хөрөнгө Оруулалтын Зэрэглэлийн Эжинси" ХХК
5. Аудитын компани "Мэжик Консалтинг Аудит" ХХК
6. Хөрөнгийн үнэлгээний компани "Эм Би Ви Си" ХХК

ХҮНДЭТГЭСЭН,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Д.ХУЛАН



2023.08.18



6.40 АНДЕРРАЙТЕРИЙН ДҮГНЭЛТ, ТОДОРХОЙЛОХ ЗАХИДАЛ



Golomt Capital
Delivering diversity

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Чингисийн өргөн чөлөө 24, Парк Плейс
оффисын барилга, 4 давхар, 403 тоот,
Утас: 7012-1530, 7012-1529
И-мэйл: info@golomtcapital.com,
Вэбсайт: www.golomtcapital.com

САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО
БОЛОН МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН БИРЖИД

№
2023.08.18 -ны № 23/387 т

Андеррайтерийн тодорхойлох захидал

"Голомт Капитал ҮЦК" ХХК нь (Цаашид "Андеррайтер" гэх) Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2015 оны 03 сарын 23-ны өдрийн 156 дугаартай шийдвэрийн дагуу олгосон "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх" тусгай зөвшөөрлийн хүрээнд Үнэт цаас гаргагчтай 2023 оны 5 сарын 19-ний өдрийн 23/44 тоот "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ" (Цаашид "Гэрээ" гэх) байгуулж, Ашид Капитал ББСБ ХХК-ийн (цаашид "Үнэт цаас гаргагч" гэх) 55,000,000,000 (тавин таван тэрбум) төгрөгийн дүнтэй нээлттэй өрийн хэрэгслийг хэсэгчлэн Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй арилжаалах хүрээнд хоёр дугаар ээлжид 15,000,000,000 (Арван таван тэрбум) төгрөгтэй тэнцэх нээлттэй өрийн хэрэгслийг гарган арилжаалах үйл ажиллагаанд Андеррайтераар оролцож байна. Андеррайтерийн үйл ажиллагааны хүрээнд "Мандал Капитал ҮЦК" ХХК-тай 2023 оны 5 сарын 24 өдөр ХА-23/02 тоот хамтран ажиллах гэрээ байгуулсан.

Үнэт цаасыг олон нийтэд санал болгох үйл ажиллагаа нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хорооны (СЗХ) 2021 оны 06 сарын 11-ний өдрийн 226 дугаар тоот тогтоолоор батлагдсан "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам", Монголын Хөрөнгийн Биржийн (МХБ) 2018 оны 1 сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", болон бусад холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэж байна.

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг МХБ-ийн 2018 оны 10-р сарын 25-ны өдрийн 15 тоот тогтоолоор батлагдан журмын дагуу үнэт цаас гаргагчийн тогтоосон тодорхой үнэ (өгөөж)-ээр санал болгох ба захиалга 100 хувь биелсэн тохиолдолд анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсанд тооцож, анхдагч зах зээлийн арилжааг хаана.

Нээлттэй өрийн хэрэгслийг олон нийтэд санал болгон хөрөнгө оруулалт татах бэлтгэл ажлын хүрээнд Андеррайтер нь Үнэт цаасны танилцуулгыг боловсруулан, дараах мэргэжлийн дүгнэлтийг танилцуулж байна. Үүнд:

1. Үнэт цаасны гаргагчийн бизнес, үйл ажиллагаа
2. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн төлөв байдал

000993



2023.08.18

3. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал
4. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт
5. Хөрөнгө оруулалтын эрсдэл, өгөөж
6. Эргэн төлөлтийн баталгаа
7. Ерөнхий дүгнэлт

НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕС, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үнэт цаас гаргагчийн нэг бүрийн 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт гаргасан 55,000,000 ширхэг хувьцааг буюу 100 хувийн хувь эзэмшлийг М-Си-Эс-Холдинг ХХК (РД: 2628236) эзэмшиж байна.

Үнэт цаас гаргагч "Ашид Капитал ББСБ" ХХК нь 2016 онд М Си Эс Холдинг ХХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттайгаар үүсгэн байгуулагдсан ба 2020 оны 2-р сарын 12-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон №ТЗ 101\663 тоот гэрчилгээ бүхий тусгай зөвшөөрлийн дагуу банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг эрхлэн явуулдаг.

Ашид капитал ББСБ ХХК нь дижитал зээлийн үйл ажиллагаа буюу Simple аппликэйшнээр дамжуулан хэрэглэгчдэд зээлийн үйл ажиллагааг түргэн шуурхай хүргэж байна. Үнэт цаас гаргагч нь дараах тусгай зөвшөөрлүүдийг эзэмшиж байна:

- Зээл
- Факторинг
- Төлбөр тооцооны хэрэгсэл
- Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх
- Итгэлцэл

ХОЁР. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ


2022 он гарснаар Монгол Улсын эдийн засгийн гол түнш орон болох БНХАУ-д Тэг-Ковидын бодлогыг хэрэгжүүлж эхэлснээр том хот, мужуудад хөл хорио тогтоосон нь үйлдвэрлэл, худалдааны эргэлтийг бууруулах хөшүүрэг болсон. Энэ нь уул уурхайн экспортоос ихээхэн хамааралтай манай улсын өсөлтийг бууруулах үйл явдал болов. Түүнчлэн 2022 оны 2-р сард гарсан ОХУ-Украины дайны асуудлаар нийлүүлэлтийн тасалдал үүсэж, инфляцын түвшин нэмэгдэж, эдийн засгийн өсөлт удааширсан. Үүнтэй холбоотойгоор 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Монгол Банкнаас бодлогын хүүг 13 хувь болгож шинэчилсэн ба 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдөр бодлогын хүүг 13 хувьд хэвээр хадгалах шийдвэр гарсан.

2022 онд инфляцын түвшин өсөж, улмаар Монгол Улсын инфляцын түвшин дунджаар 14.6 хувь, Улаанбаатар хотын инфляцын түвшин дунджаар 15.2 хувьд хүрсэн бол өнөөгийн байдлаар инфляц Улаанбаатарт 10.9 хувь, Улс даяар 11.3 хувь болж буурсан. Монгол Банк нь 2023 онд мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлж, инфляцын түвшнийг 6 хувийн зорилтод түвшинд тогтвортой барих бодлого хэрэгжүүлэх үүднээс Монгол Банкнаас мөнгөний хатуу бодлогыг үргэлжлүүлэн барих хандлагатай байх нь хөрөнгө оруулагчдын тогтмол хүүтэй санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах эрэлтийг өсгөж байна.

Монгол Банк, ОУВС, АХБ-ны шинжээчдийн тайланд инфляцын түвшинг 2023 онд дунджаар 10 хувь, 2024 онд дунджаар 8 хувьд хүрнэ гэж таамаглаж байгаа нь богино



2023.08.18



хугацаанд инфляцын түвшин буурах магадлалтайг харуулж байна. Харин Дэлхийн банк, ОУВС, АХБ-ны шинжээчид Монгол Улсын эдийн засгийг 2023 онд дунджаар 5 хувь, 2024 онд 6 хувиар өснө хэмээн таамаглаж байна.

Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ), СЗХ, Монголын Банкны Холбооноос гаргасан тооцооллын дагуу 2022 оны жилийн эцсийн санхүүгийн салбар бүрийн нийт хөрөнгийн хэмжээг авч үзвэл нийт санхүүгийн зах зээлийн хөрөнгийн хэмжээ ойролцоогоор 57 их наяд төгрөгт хүрсэн. Үүнээс банкны салбарын хөрөнгө 46 их наяд төгрөг буюу 80.6 хувийг, хөрөнгийн зах зээл 6.9 их наяд төгрөг буюу 12.1 хувийг, ББСБ салбар 3.5 их наяд төгрөг буюу нийт зах зээлийн 6.1 хувийг, даатгалын салбар 474.9 тэрбум төгрөг буюу 0.8 хувийг, үлдсэн 187.5 тэрбум төгрөг буюу 0.3 хувийг хадгаламж зээлийн хоршооны салбар бүрдүүлсэн. ББСБ-ын салбар нь 2015 оноос эхлэн хурдацтай өсөж байгаа бөгөөд 2015-2022 онуудад Монгол Улсын эдийн засгийн жигнэсэн нийлмэл өсөлт дунджаар 12.7 хувь байсан бол ББСБ салбарынх дунджаар 31.9 хувь байж бодит эдийн засгаас өндөр өсөлт үзүүлсэн байна.

ГУРАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН БАЙДАЛ


Үнэт цаас гаргагч нь 2023 оны 06-р сарын 30-ний өдрөөр тасалбар болсон санхүүгийн тайландаа "Мэжик консалтинг аудит" ХХК-аар хөндлөнгийн аудит хийлгэсэн бөгөөд 2023 оны 7-р сарын тайланг журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороонд тайлагнан ажиллаж байна.

Нийт хөрөнгө: Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө 2022 оны байдлаар 172.2 тэрбум төгрөг байсан ба 2023 оны 2-р улирлын байдлаар 2020 оны дүнгээс 4.0 дахин өсөж 155.9 тэрбум төгрөгт хүрчээ



Цэвэр зээл: Харин 2023 оны 2-р улирлын байдлаар үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн 84 хувь буюу 131.1 тэрбум төгрөг нь цэвэр зээлийн багц байна. 2022 оны жилийн эцэст нийт зээлийн багцын 87.6 хувь нь хэвийн ангилалтай зээл байсан бол 2023 оны 2-р улирлын дүнгээр 84.7 хувь нь хэвийн ангилалтай, 11.2 хувь нь чанаргүй ангилалтай зээл байна.

Хүүгийн бус орлого, зардал: Үнэт цаас гаргагчийн аудитын тайланд зээл судалсны шимтгэл, банк санхүүгийн байгууллагаас олсон хүүгийн орлогыг хүү, түүнтэй адилтгах орлого гэж ангилсан ба хүүгийн бус орлогод валютын олз зэрэг бусад орлогыг тусгажээ. Харин хүүгийн бус зардалд ерөнхий үйл ажиллагааны зардлыг хамруулах ба зардлын дийлэнх хэсгийг цалингийн зардал, элэгдэл, хорогдол болон харилцаа холбооны зардлууд бүрдүүлсэн байна.

Цэвэр ашиг: Үнэт цаас гаргагч нь 2020 онд алдагдалтай ажилласан бол 2021 оноос үндсэн үйл ажиллагаа тэлж ашигтай ажиллаж эхэлсэн ба 2022 оны тайлангаар 8.5 тэрбум төгрөгийн цэвэр ашиг, 2023 оны 2-р улирлын байдлаар 5.9 тэрбум төгрөгийн цэвэр ашиг тус тус бүртгэжээ. Үйл ажиллагаа 2022 оноос хойш тогтворжиж ашиг ажиллагааны харьцаанууд тогтвортой болсон байна.




2023.08.18



Үнэт цаас гаргагч нь СЭХ-оос тогтоосон ББСБ-ын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг амжилттай биелүүлэн ажиллаж байна. Харин итгэлчлийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл 2023 оны 5-р сарын 22-нд авсан ба 2023 оны 2-р улирлын байдлаар нийт 6 тэрбум төгрөгийн итгэлцэл татан төвлөрүүлээд байна.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас: Үнэт цаас гаргагч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор "Симпл ассет ТЗК" ХХК-г 2022 оны 4-р сарын 22-ны өдөр үүсгэн байгуулж улсын бүртгэлд бүртгүүлсэн. Түүнчлэн 50.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий, жилийн 15% хүүтэй, 18 сарын хугацаатай Симпл ассет





ХБУЦ-ийг 2022 оны 6-р сарын 16-нд Монголын хөрөнгийн биржид бүртгүүлж арилжсан байна.

ХБУЦ-д нийт 10,236 эзэлдэгчийн 50.0 тэрбум төгрөгийн үлдэгдэл бүхий эзэлийн багцыг тусгаарлан багцалсан ба хөрөнгө итгэмжлэн удирдагчаар Юнайтэд эйр финанс ХХК ажиллаж байна. Уг ХБУЦ-ийн үндсэн төлбөрийн 50% буюу 25 тэрбум төгрөг нь 2023 оны 6-р сард төлөгдсөн ба үлдэгдэл 50% буюу 25 тэрбум төгрөгийг 2023 оны 12-р сард эргэн төлөгдөх хуваарьтай байна.

Өрийн бичиг: Үнэт цаас гаргагч нь 2022 онд биржийн бус зах зээл дээр Өлзий энд Ко Капитал ҮЦК-аар дамжуулан нийт 35.0 тэрбум төгрөгийн бонд гаргасан ба тус бондын 18 тэрбум төгрөг нь эргэн төлөгдөж, үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар тус бондын үлдэгдэл 17 тэрбум төгрөг байна.

	Дүн	Хугацаа	Гаргасан огноо	Дуусгавар болох	Хүү
1	9.0 тэрбум төгрөг	18 сар	2022.04	2023.10	13%
2	8.0 тэрбум төгрөг	18 сар	2022.02	2023.09	13%
3	8.0 тэрбум төгрөг	18 сар	2022.02	Төлөгдсөн	13%
4	10.0 тэрбум төгрөг	18 сар	2021.12	Төлөгдсөн	13%

2023 оны 7 дугаар сард Simple нээлттэй бонд буюу нийт 55 тэрбум төгрөгийн өрийн хэрэгслийн хөтөлбөрийн эхний ээлж болох 20 тэрбум төгрөгийн нээлттэй бондыг амжилттай борлуулсан. Тус бондын эргэн төлөх хуваарь нь:

	Дүн	Хугацаа	Гаргасан огноо	Дуусгавар болох	Хүү
1	20.0 тэрбум төгрөг	12 сар	2023.07	2024.07	18%

2023 оны аудитын тайлан гарснаас хойш өрийн бичгийн дүнд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- 2023.07 сард 20.0 тэрбум төгрөгийн нээлттэй бонд МХБ дээр гаргасан;
- 2023.08.08-нд Симпл хаалттай бондын 8.0 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдсэн

Тодруулга:
2022 оны жилийн эцэс болон 2023 оны 1-р улирлын байдлаар өрийн бичгийн зохистой харьцаа нь тус тус 44.7% болон 21.2% байна. Өрийн бичигтэй холбоотой дээрх өөрчлөлтүүд хийгдсэний дараа тус харьцаа 31.4% болох бөгөөд Симпл II бондыг татан төвлөрүүлэх үед 44.2% болж тус харьцааны зохистой үзүүлэлт хангагдах юм.

Хоёрдогч өглөг: Үнэт цаас гаргагч нь 2021 онд толгой компани болох М-Си-Эс Холдинг ХХК-аас нийт 50.0 тэрбум төгрөгийн хоёрдогч өглөгийг жилийн 13 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай авсан. Хоёрдогч өглөг нь нийт өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор гэрээнд заасан хугацаа дууссаны эцэст хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг үндэслэн хувьцаанд хөрвүүлэх нөхцөлтэй, гуравдагч этгээдээс авсан мөнгөн хөрөнгийг ойлгох ба хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө гэж тооцдог. М-Си-Эс Холдинг ХХК-аас авсан хоёрдогч өглөг нь 2027



2023.08.18

оноос эхлэн хувьцаанд хөрвөж, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болох хуваарьтай байна.

ДӨРӨВ. ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Үнэт цаас гаргагч нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 150,000 ширхэг өрийн хэрэгслийг нээлттэй хүрээнд олон нийтэд санал болгон арилжаалах ба татан төвлөрүүлэх хөрөнгийг эргэлтийн хөрөнгийн санхүүжилт буюу зээлийн багцыг нэмэгдүүлэхэд зарцуулна.

ТАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨГӨӨЖ, ЭРСДЭЛ

Үнэт цаас гаргагч нь бондын хүүгийн түвшнийг тодорхойлохдоо Монгол Банкнаас зарласан бодлогын хүү, зах зээл дэх ижил төстэй өрийн хэрэгслийн хүүгийн түвшин, үнэт цаас гаргагчийн санал болгож буй үнэт цаасны эрсдэлийн хүчин зүйл зэрэгт үндэслэж тооцсон.

2023 оны 8 дугаар сарын байдлаар Монголбанкнаас зарласан бодлогын хүү 13 хувь, инфляцын түвшин улсын хэмжээнд 9.2 хувь байна. Харин 2023 оны 8 дугаар сарын байдлаар системийн топ-5 банкны 12 сарын хугацаатай төгрөгийн хадгаламжийн дундаж хүү 12.2 хувь буюу хадгаламжийн бодит өгөөж 3.0 хувь байна. Үнэт цаас гаргагчийн санал болгож буй бондын бодит өгөөж 8.3 хувь, системийн Топ-5 банкны хадгаламжийн хүүгээс 1.43 дахин өндөр байна.

Үнэт цаас гаргагч нь өөрийн бизнес, үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл болон эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоог бий болгон ажиллаж байна. Үнэт цаас гаргагчийн хувьд учирч болзошгүй эрсдэлүүдийг дараах байдалтай байна:


- Зээлийн эрсдэл
- Зах зээлийн эрсдэл
- Хүүгийн эрсдэл
- Өөрийн хөрөнгийн хүрэлцээний эрсдэл
- Хөрвөх чадварын эрсдэл
- Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл
- Хянан нийцүүлэлтийн эрсдэл

Үнэт цаас гаргагч нь эдгээр эрсдэлийг удирдах, хяналт тавихын тулд хамгаалалтын гурван бүсийн зарчмыг мөрдлөг болгон ашигладаг бөгөөд тус зарчмын дагуу алба, нэгжүүдийн эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргүүдийг тодорхойлсон байна. Хамгаалалтын гурван бүсийг дараах байдлаар тодорхойлсон байна:

- Хамгаалалтын нэгдүгээр бүс: Бизнесийн нэгжүүд нь үйл ажиллагааны бодлого журмуудыг хэрэгжүүлэх, эрсдэлийг үнэлэх, тайлагнах, бууруулж ажиллах чиг үүргүүдийг хүлээнэ.
- Хамгаалалтын хоёрдугаар бүс: Эрсдэлийн удирдлагын нэгж нь эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоог тодорхойлох, болзошгүй эрсдэл түүний хүлээн зөвшөөрөгдөх хэмжээг тогтоож, хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллана.



2023.08.18



VI. ХАВСРАЛТ

➤ Хамгаалалтын гуравдугаар бүс: Дотоод хяналтын нэгж нь нэг болон хосрдугаар бүсийн эрсдэлийн удирдлагын үр дүнд хараат бус дүгнэлт өгөх, ТУЗ-д тайлагнах чиг үүргүүдийг хүлээнэ.

Мөн Үнэт цаас гаргагч нь байгууллагын эрсдэл даах чадварыг үнэлэх, болзошгүй хохирлыг тодорхойлж, хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулахын тулд стресс тест хийж гүйцэтгэдэг.

Хөрөнгө Оруулалтын Зэрэглэлийн Эжинси ХХК нь 2023 оны 7 дугаар сард татан төвлөрүүлсэн Симпл I бонд болон байгууллагын зээлжих зэрэглэлийг 2023 оны 6 сарын 6-ны Зэрэглэлийн хорооны шийдвэрээр BBB+ гэж тодорхойлсон байна. Харин 2023 оны 8 сарын 11-ний өдрийн Зэрэглэлийн хорооны хурлаар байгууллагын болон Симпл I бондын зэрэглэлийг дахин хянаж үзээд зэрэглэл болон төлөвийг хэвээр үлдээсэн бөгөөд нэмэлтээр гаргахаар төлөвлөж буй 20 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий Симпл II бондын зэрэглэлийг мөн адил BBB+ гэж тодорхойлсон байна.

ЗУРГАА. ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТ

Үнэт цаас гаргагч нь олон нийтэд санал болгохоор төлөвлөж буй өрийн хэрэгслийг эргэн төлөлтийг харилцагчдад олгосон зээлийн багцаас бий болох хүүгийн орлого, үндсэн төлбөрийн эргэн төлөлтөөр санхүүжүүлнэ.

ДОЛОО. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Андеррайтер нь судалгаа шинжилгээ болон бусад хөндлөнгийн байгууллагуудын дүгнэлт, тайланд үндэслэн Үнэт цаас гаргагчийн гаргаж буй өрийн хэрэгсэл нь МХБ-ээр нээлттэй арилжаалагдах шалгуурыг хангасан бөгөөд олон нийтэд санал болгох боломжтой гэж үзлээ.


Энэхүү дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн төлөвлөгөө тайланд үндэслэн хийгдсэн ба төсөөлөл, таамаглал болон биелэлтийн баталгаа болохгүй. Иймд хөрөнгө оруулагчдыг компанийн үйл ажиллагаа, үнэт цаасны танилцуулга, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар судалсны үндсэн дээр шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

Баталгаажуулсан:

Овог, нэр: САНХҮҮЯГ ОВОГТОЙ ГАН-ЭРДЭНЭ

Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:



2023.08.18

Mongolian Investment Rating Agency

+976 9903-0338
info@mira.mn
http://www.mira.mn
#605, Max Tower, 4 khoroo,
Juilchin street Chingeltei District,
Ulaanbaatar, 15170 Mongolia

Монголын хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси ХХК
2023 оны 08 дугаар сарын 15-ны өдөр
No.: 27/2023

"АШИД КАПИТАЛ ББСБ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ П. БАТЖАРГАЛ ТАНАА

Зээлжих зэрэглэл тогтоосон тухай

Тус компанийн Зэрэглэлийн хороо 2023.08.11-ний өдөр хуралдаж, "Ашид Капитал ББСБ" ХХК-ийн 2023 оны хагас жилийн гүйцэтгэлийг хянаж, өмнө тогтоосон байгууллагын болон үнэт цаасны зээлжих зэрэглэлийг хэвээр үлдээх, шинээр гаргаж байгаа үнэт цаасны зээлжих зэрэглэлийг дараах байдлаар тогтоосныг үүгээр мэдэгдэж байна:

Үнэт цаасны нэр:	Симпл II бонд
Үнэт цаасны зэрэглэл:	BBB+
Төлөв:	Хувьсах (Evolving)
Хүчинтэй хугацаа:	Бондын хугацаа дуустал

Зээлжих зэрэглэлийн үнэлгээний тайланг хавсралтаар хүргүүлж буйг хүлээн авч, нийтэд мэдээлэх зөвшөөрөл өгөхийг хүсье.

Хавсралт 8 хуудастай.

Хувийг: Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газарт.

Хүндэтгэсэн,


Цэдэвсүрэйгийн Мөнхбаяр
Гүйцэтгэх захирал

The MIRA is the first credit rating agency in Mongolia

УЛААНБААТАР ХӨТ
АШИД КАПИТАЛ
ББСБ ХХК
АТГАЖИЛГА
2023.08.18

МАНДАЛ КАПИТАЛ
МАРКЕТС ҮЦК ХХК
483
MANDAL CAPITAL
MARKETS SC
LLC
ШТК0162 9021070414 5713427

Монголын Хөрөнгө
Бүрттэйв
Golomt Capital
Dedication and diversity
2023.08.18



Credit Rating Report

Investment
Rating Agency

Зээлжих Зэрэглэлийн Үнэлгээний Тайлан
"Ашид Капитал ББСБ" ХХК

МИРА компанийн Зэрэглэлийн Хорооны 2023.08.11-ний өдрийн хуралдаанаас "Ашид Капитал" ББСБ" ХХК-ийн байгууллагын болон Симпл 1 бонд-ын зэрэглэлийг "BBB+/Хувьсах" хэвээр үлдээж, шинээр гаргаж буй Симпл 2 бондын үнэлгээг "BBB+/Хувьсах" гэж тогтоов.

Энэхүү холбоос дээр дарж зэрэглэл тогтоосон үндэслэлтэй танилцах боломжтой.

Зэрэглэлийн төрөл	Үнэт цаасны төрөл	Үнэт цаасны нэр	Үнэт цаасны дүн	Зэрэглэлийн ҮА	Хүчинтэй огноо	Зэрэглэл & Төлөв байдал
Байгууллагын зэрэглэл	n/a	n/a	n/a	Хянасан ¹	6/6/2024	BBB+ Хувьсах
Үнэт цаасны зэрэглэл ²	Энгийн бонд	Симпл бонд 1	20.0 тэрбум төгрөг	Хянасан	Бондын хугацаа дуустал	BBB+ Хувьсах
Үнэт цаасны зэрэглэл	Энгийн бонд	Симпл бонд 2	15.0 тэрбум төгрөг	Тогтоосон	Бондын хугацаа дуустал	BBB+ Хувьсах

Компанийн тухай

"Ашид Капитал ББСБ" ХХК (РД: 6105572, Хаяг: Монгол Улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Централ Тауэр 5 давхар, цаашид "Үнэт цаас гаргагч" гэх) нь 2016 онд үүсгэн байгуулагдаж, 2020 оноос үйл ажиллагаа явуулж байна. Тус банк бус санхүүгийн байгууллага нь Simple нэрээр буюу дижитал зээлийн платформоор дотоодын зах зээлд танигдсан, цаашид тэргүүлэх дижитал зээлийн платформ болох алсын хараатай үйл ажиллагаа явуулж байна.

Компанийн гол зорилго нь сүүлийн үеийн технологи, зээлийн эрсдэлийн үнэлгээний ухаалаг систем (credit scoring systems)-ийг ашиглан санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хэрэглэгчдэд өөрсдийн санхүүгийн чадавхид тохирсон зээлийн үйлчилгээг авах боломжийг олгох явдал юм.

Зэрэглэлийн ерөнхий мэдээлэл

Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагаагаа өргөжүүлэх, бондын дахин санхүүжилтийг хийх зорилгоор 50 тэрбум бондыг үе шаттайгаар гаргаж байна. Симпл 1 бондыг 2023 оны 7 дугаар сард 20 тэрбум төгрөгийн дүнтэй гаргасан бол Симпл 2 бондыг 15 тэрбум

¹ Ашид Капитал ББСБ ХХК болон Симпл 1 бондод тус тус хяналтын үйл ажиллагаа явуулахад 2023 оны хэвсгэжлийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, тус байгууллагаас хүргүүлсэн тайлбаруудад үндэслэсэн болно.

² Бондын зэрэглэл нь бонд гаргаж буй байгууллагын зэрэглэлээс ялгавтай байж болно. Бондын зэрэглэл нь тухайн бонд гаргаж буй байгууллагын өр талберийн дараалал, санал болгож буй бондын нөхцөлөөс хамваран тогтоогдох бөгөөд зэрэглэлийн ялгавтай байдал нь зах зээлийн эрсдэлээс хамвардаггүй.



2023.08.18

MIRA Зээлжих зэрэглэлийн үнэлгээ

төгрөгийн дүнтэйгээр энэ улиралд гаргахаар төлөөлж байна. Компани нь үлдсэн 15 тэрбум төгрөгийн бондыг энэ ондоо багтаан гаргана гэсэн хүлээлттэй байна.

Үнэт цаас гаргагчийн зээлийн багцын чанар 2022 оны эцсээс муудсан хэдий ч энэ нь МИРА-н өмнөх тооцоолол, хүлээлттэй нийцтэй байсны зэрэгцээ хөрвөх чадварын үзүүлэлт, ашигт ажиллагаа сайжирсан, өөрийн хөрөнгө хүрэлцээтэй байгаа нь зээлжих зэрэглэлийн үнэлгээг хэвээр хадгалахад голлон нөлөөлөв.

Хөрвөх чадвар

Үнэт цаас гаргагчийн хөрвөх чадварын үзүүлэлт 2023 оны эхний хагас жилийн байдлаар сайжирлаа. Тус байгууллага нь 2023 оны 5 дугаар сард 25 тэрбум төгрөгийн өрийн бичгийг эргэн төлсөн, 6 дугаар сард ТЗК-ийн эхний эргэн төлөлт болох 25 тэрбум төгрөгийн эргэн төлөлтийг хийсэнтэй холбоотойгоор нийт байгууллагын өрийн хэмжээ буурсан нь голчлон нөлөөлсөн байна.

Харьцаа үзүүлэлтүүд	2021	2022	2023. II	Өөрчлөлт
Ажлын капитал / Нийт хөрөнгө	98.0%	52.0%	65.9%	▲
Ажлын капитал / Нийт өр төлбөр	166.5%	73.1%	106.5%	▲
Богоно хугацаат өр төлбөр / Нийт хөрөнгө	1.1%	47.7%	33.4%	▲
Урт хугацаат өр төлбөр / Нийт хөрөнгө	57.8%	23.4%	28.5%	▼
(Өр төлбөр - мөнгөн хөрөнгө) / Нийт хөрөнгө	11.1%	16.7%	12.5%	▲

Ашигт ажиллагаа

Симпл-н 2023 оны хагас жилийн байдлаар ашигт ажиллагааны үзүүлэлтүүд³ сайжирсан үзүүлэлттэй байна. Үндсэн шалтгаан нь тус тайлант хугацаанд зээлийн хүүгийн орлого нэмэгдсэн нь голчлон нөлөөлсөн.

Үзүүлэлтүүд	2021	2022	2023. II	Өөрчлөлт
Цэвэр ашиг / Нийт хөрөнгө	0.2%	3.9%	5.7%	▲
Цэвэр ашиг / Эздийн өмч	0.4%	13.6%	15.1%	▲

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ



Симпл-н 2023 оны хагас жилийн байдлаарх өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа үзүүлэлтүүд сайжирсан үзүүлэлттэй байна. Үндсэн шалтгаан нь тус байгууллагын 2023 оны хагас жилийн тайлант хугацааны ашиг 5.9 тэрбум байсан нь өөрийн хөрөнгийн харьцаа үзүүлэлтүүд сайжрах үндсэн нөлөө үзүүлэв.

Харьцаа үзүүлэлтүүд ³	2021	2022	2023. II	Өөрчлөлт
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө / Эрсдэлээс жигнэсэн нийт актив (10%-с доошгүй)	44.4%	40.6%	43.0%	▲
Өөрийн хөрөнгө / Эрсдэлээр жигнэсэн нийт актив (20%-с доошгүй)	86.0%	73.3%	74.8%	▲
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө / Нийт актив (10%-с доошгүй)	41.1%	35.9%	43.5%	▲

³ Ашигт ажиллагааны үзүүлэлтийг тооцохдоо цэвэр ашигт 2022Q3-2023Q2 хурталх 4 улирлыг нэгтгэн тооцсон болно.



2023.08.18



MIRA

Зээлжих зэрэглэлийн үнэлгээ

Активын чанар

Зээлийн багц 2023 оны хагас жилд өмнөх оноос 13.9%-иар буурч, 160'662 сая төгрөгт хүрсэн байна. Түүнчлэн чанаргүй зээл нь 11.6%, чанаргүй зээл эздийн өмчид эзлэх хувь 27.9%-тай байгаа нь өмнөх оны үзүүлэлтүүдтэй харьцуулахад зээлийн үзүүлэлтүүд муудсан үзүүлэлттэй байна.

2023 оны хагас жилийн байдлаар Симпл-н нийт олгогдсон зээлийн 65.5% нь цахимаар олгогдсон бол үлдсэн 34.5% нь уламжлалт байдлаар олгогдсон зээл байна. Нийт чанаргүй зээлийн 91.9% нь дижиталаар олгогдсон зээлүүд тул цаашид кредит скоринг моделийг сайжруулах нь компанийн дунд болон урт хугацааны зээлийн эрсдэлийг удирдахад нэн чухал үүрэгтэй байна.

Үзүүлэлтүүд	2021	2022	2023.И	Өөрчлөлт
Зээлийн багцын дүн (сая төг)	116'089	186'604	160'662	▼
Чанаргүй зээлийн %	1.8%	7.5%	11.6%	▼
Чанаргүй зээл / Эздийн өмч	4.0%	22.7%	27.9%	▼

Зээлжих зэрэглэлд цаашид нөлөөлж болзошгүй хүчин зүйлс

Зэрэг нөлөөлж болзошгүй хүчин зүйлс:

- Активын чанарыг муутгахгүйгээр бизнесийн өсөлтийг дэмжих
- Үйл ажиллагааг тогтвортой явуулах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох
- Зээлдэгчдийн скоринг моделийг үргэлжлүүлэн сайжруулах
- Хангалттай хөрвөх чадвар, санхүүгийн хөрөнгийн нөөцийг бүрдүүлэх

Сэргөөр нөлөөлж болзошгүй хүчин зүйлс:

- Бизнесийг өргөжүүлэх хүлээлтэд хүрэхгүй байх
- Санхүүжилтийн сорилттой тулгарч хөрвөх чадвар буурах
- Хөрөнгө багассанаар эрсдэлээс хамгаалах нөөц хөрөнгө буурах
- Хөрөнгө өр төлбөрийн харьцаа 3х хэтрэх
- Чанаргүй зээл өсөх

Шинжээчид:

М. Энхчимэг
enkhchimeg@mira.mn

Г. Бүтэнбаяр
butenbayar@mira.mn

Гүйцэтгэх захирал:

Ц. Мөнхбаяр
munkhbayar@mira.mn

Холбогдох мэдээлэл:

И-Мейл: info@mira.mn,
Цахим хуудас: www.mira.mn,

Утас: +976 7774-7700

Үнэлгээний мэдээлэл:

www.mira.mn



2023.08.18

Хавсралт 1

Зээлжих зэрэглэлийн шатлал

Үнэлгээ	Зэрэглэл	Тайлбар
AAA		Хамгийн бага эрсдэлтэй, хөрөнгө оруулалтын зэрэглэл
AA+		
AA		Маш бага эрсдэлтэй, хөрөнгө оруулалтын зэрэглэл
AA-		
A+	Хөрөнгө оруулалтын	
A		Эрсдэл багатай, хөрөнгө оруулалтын дундаас дээш зэрэглэл
A-		
BBB+		
BBB		Дунд зэргийн эрсдэлтэй, хөрөнгө оруулалтын дундаж зэрэглэл
BBB-		
BB		
BB+		Ихээхэн эрсдэлтэй, спекулятив шинжтэй
BB-		
B+		
B		Өндөр эрсдэлтэй, спекулятив
B-		
CCC+	Спекулятив	
CCC		Маш өндөр эрсдэлтэй, спекулятив
CCC-		
CC+		
CC		Үндсэн төлбөр болон хүүгийн нөхөн төлбөрийг барагдуулах магадлал багатай эсвэл барагдуулах магадлал маш бага байна.
CC-		
C+		
C		Үндсэн болон хүүгийн төлбөрийг төлөх магадлал бага.
C-		
D	Дефолт	


*Тэмдэглэл: MIRA нь AA-аас C хүртэлх ерөнхий үнэлгээний ангилал бүрт зэрэг, тогтвортой, хувьсах, сөрөг хэтийн төлөв хавсаргана. Зэрэг төлөв нь тухайн шатлалын дээд ангилал; тогтвортой төлөв нь дунд ангилалд; хувьсах төлөв нь дундаас доош ангилалд; сөрөг төлөв нь доод ангилалд багтана.

'AAA' шатлалаас 'BBB' хүртэл хөрөнгө оруулалтын зэрэглэл, 'BB' шатлалаас 'D' хүртэл спекулятив буюу хөрөнгө оруулалтын бус гэж үздэг. "Хөрөнгө оруулалтын зэрэглэл" нь зээлийн эрсдэл дунд юм уу бага байгааг илэрхийлдэг бол "хөрөнгө оруулалтын бус зэрэглэл" нь зээлийн эрсдэл өндөр байгааг эсвэл дампуурах магадлал аль хэдийн үүссэн гэдгийг илэрхийлдэг.

Хөрөнгө оруулалтын зэрэглэл нь хөрөнгө оруулалтын зорилгоор үнэт цаас болон бусад ерийн хэрэгсэл худалдан авах талаар ямар нэгэн санал зөвлөмж болохгүй.



2023.08.18



Зээлжих зэрэглэлийн төлөв

MIRA компанид зээлжих зэрэглэл тогтооходоо 1 жилийн хугацаанд тухайн тогтоосон зээлжих зэрэглэл нь аль шатлал руу өөрчлөгдөх боломжтойг илэрхийлсэн дараах 4 төлөвийг (эерэг, тогтвортой, сөрөг болон хувьсах) үнэлдэг.

Төлөв	Төлөвийн тэмдэгт
Эерэг	+
Сөрөг	-
Хувьсах	●
Тогтвортой	■



2023.08.18

MIRA

Зэрлжих зэрэглэлийн үнэлгээ

Хавсралт 2

(мянган төг)


Тайлан тэнцэлийн үзүүлэлтүүд	2021	2022	2023. II
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ			
Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө	11,932,957	29,017,398	15,757,371
Богино хугацаат хөрөнгө оруулалт	95,155	3,088,233	5,284,219
Зээлийн авлага	114,662,025	180,421,001	149,732,510
Зээлийн хүү болон бусад авлага	1,338,563	320,999	3,283,366
Урьдчилж төлсөн төлбөр ба урьдчилгаа	599,934		
Барав материал	27,507		
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН	128,656,141	212,847,631	174,057,467
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН	1,098,767	762,045	1,242,164
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	129,754,908	213,609,676	175,299,631
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	1,449,228	101,850,515	58,525,555
Зээлийн өр төлбөр	74,964,527	50,000,000	50,000,000
Санхүүгийн түрээсийн өглөг			
Урт хугацаат өр төлбөрийн нийт дүн	74,964,527	50,000,000	50,000,000
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	76,413,755	151,850,515	108,525,555
ЭЗДИЙН ӨМЧ			
Хувь нийлүүлсэн хөрөнгө	55,000,000	55,000,000	55,000,000
Хуримтлагдсан ашиг	(1,658,847)	6,759,161	11,774,075
ЭЗДИЙН ӨМЧ	53,341,153	61,759,161	66,774,075
ЭЗДИЙН ӨМЧ, ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	129,754,908	213,609,676	175,299,631

Орлогын тайлангийн үзүүлэлтүүд	2021	2022	2023. II
Хүү болон түүнтэй адилтгах орлого	12,927,051	39,152,441	24,105,769
Хүүгийн зардал	(3,614,116)	(16,620,472)	(10,173,514)
Цэвэр хүү болон түүнтэй адилтгах орлого	9,312,935	22,531,969	13,932,255
Зээлийн болзошгүй эрсдэлийн нөөцийн зардал	(1,370,563)	(7,038,459)	(4,589,833)
Үйл ажиллагааны цэвэр орлого	7,942,372	15,493,510	9,342,421
Удирдлага, захиргааны зардал	(7,564,685)	(6,775,261)	(3,453,815)
Үйл ажиллагааны бусад орлого (зардал)	(17,336)	652,513	(132,501)
Татварын өмнөх алдагдал	360,351	9,370,762	5,756,105
Орлогын албан татварын зардал	(136,503)	(952,754)	(741,281)
Тайлант хугацааны цэвэр алдагдал	223,848	8,418,008	5,014,824

Харьцаа үзүүлэлтүүд	2021	2022	2023. II	Өөрчлөлт
Цэвэр ашиг / Нийт хөрөнгө	0.2%	3.9%	5.7%	▲
Цэвэр ашиг / Эздийн өмч	0.4%	13.6%	15.1%	▲
Ажлын капитал / Нийт хөрөнгө	98.0%	52.0%	65.9%	▲
Ажлын капитал / Нийт өр төлбөр	166.5%	73.1%	106.5%	▲
Богино хугацаат өр төлбөр / Нийт хөрөнгө	1.1%	47.7%	33.4%	▲
Урт хугацаат өр төлбөр / Нийт хөрөнгө	57.8%	23.4%	28.5%	▼
(Өр төлбөр - мөнгөн хөрөнгө) / Нийт хөрөнгө	11.1%	16.7%	12.5%	▲
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө / Эрсдэлээс жигнэсэн нийт актив (10%-с доошгүй)	44.4%	40.6%	43.0%	▲
Өөрийн хөрөнгө / Эрсдэлээр жигнэсэн нийт актив (20%-с доошгүй)	86.0%	73.3%	74.8%	▲
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө / Нийт актив (10%-с доошгүй)	41.1%	35.9%	43.5%	▲
Зээлийн багцын дүн (сая төг)	116,089	186,604	160,662	▼
Чанаргүй зээлийн %	1.8%	7.5%	11.6%	▼
Чанаргүй зээл / Эздийн өмч	4.0%	22.7%	27.9%	▼



2023.08.18



VI. ХАВСРАЛТ

MIRA

Зээлжих зэрэглэлийн үнэлгээ

Санамж

МИРА-гийн зэрэглэлийн үнэлгээ холбогдох эх сурвалжаас цуглуулсан мэдээлэлд үндэслэсэн бөгөөд санаатайгаар ямар нэгэн мэдээллийг орхигдуулаагүй болно. Бид цуглуулсан мэдээллийн үнэн зөв байдалд хариуцлага хүлээхгүй бөгөөд тооцоолол, ирээдүйн төсөөллийн биелэлтэд баталгаа өгөөгүй болно.

Зэрэглэлийн үнэлгээ нь хөрөнгө оруулагч нарын хөрөнгө оруулалтын шинжилгээг орлохгүй бөгөөд аливаа эрсдэл үүссэн нөхцөлд манай байгууллага үүрэг хүлээхгүй болно.

Мөн МИРА-гийн тогтоосон аливаа зэрэглэлд төрийн эрх бүхий байгууллага үүрэг хүлээхгүй болно.

Зэрэглэлийн тэмдэглэгээ болон түүний тайлбар нь байгууллагын цахим хуудсанд нээлттэй байна. Мөн МИРА-гийн тогтоосон зэрэглэл, зэрэглэл тогтооход ашигласан аргачлал, ёс зүйн кодикс, ашиг сонирхлын зөрчил, мэдээллийн нууцлал болон холбогдох бусад журам болон мэдээллийг цахим хуудсаас авах боломжтой.

Доорх линкээр орж нэмэлт анхааруулга, тодруулгатай танилцана уу.

<http://www.mira.mn/disclaimer>



2023.08.18

Тайлан бэлтгэсэн:

Гүйцэтгэх захирал:



(Ц.Мөнхбаяр)

Шинжээч:

(М.Энхчимэг)

Шинжээч:

(Г.Бүтэнбаяр)

Зэрэглэлийн хорооны шийдвэр: BBB+ хувьсах

Шийдвэр гаргасан огноо: 8/11/2023



2023.08.18



6.42 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ТУХАЙ МЭДЭГДЭЛ



Ашид
Капитал
ББСБ

2023/08/17

Дугаар 01/3573

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БОЛОН МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ-д

Нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхлын талаар мэдэгдэл гаргах тухай.

“Ашид Капитал ББСБ” ХХК нь нээлттэй өрийн хэрэгслийг олон нийтэд санал болгохоор ажиллаж байгаа бөгөөд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Ингэхдээ оролцогч бусад талуудтай холбогдох хууль, журам болон талуудын хооронд байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд хамтран ажиллаж буй бөгөөд доор дурдсан этгээдүүдтэй уг үнэт цаасыг гаргахаас бусад аливаа асуудлаар нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхолгүй болохоо үүгээр баталгаажуулан мэдэгдэж байна.

1. Үндсэн андеррайтер “Голомт Капитал ҮЦК” ХХК
2. Туслах андеррайтер “Мандал Капитал Маркетс ҮЦК” ХХК
3. Хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч “Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс” ХХН
4. Санхүүжих чадварын зэрэглэлийн үнэлгээний компани “Монголын Хөрөнгө Оруулалтын Зэрэглэлийн Эжинси” ХХК
5. Аудитын компани “Мэжик Консалтинг Аудит” ХХК
6. Хөрөнгийн үнэлгээний компани “Эм Би Ви Си” ХХК

Баталгаажуулсан,
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



П.БАТЖАРГАЛ

“АШИД КАПИТАЛ ББСБ” ХХК

- ☎ Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сантрал тауэр, 15 давхар.
- ☎ 7711 2828
- ✉ info@simple.mn
- 🌐 www.simple.mn



2023.08.18

6.43 ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ КОМПАНИЙН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ТУХАЙ МЭДЭГДЭЛ



"ЭМ БИ ВИ СИ" ХХК
Хөрөнгө болон бизнесийн үнэлгээ
УБ хот, СБД, 1-р хороо,
Бягд Тавуур, 9 дунгар, 908 тоот
Утас: +976-89008922
Email: mbvcapital@gmail.com
2023.08.17 № 250817/001

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО
БОЛОН МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
БИРЖ-Д

Нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг
сонирхлын талаар мэдэгдэл гаргах
тухай,


"Ашид Капитал ББСБ" ХХК нь нээлттэй өрийн хэрэгслийг олон нийтэд санал болгохоор ажиллаж байгаа бөгөөд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Ингэхдээ оролцогч бусад талуудтай холбогдох хууль, журам болон талуудын хооронд байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд хамтран ажиллаж буй бөгөөд уг үнэт цаасыг гаргахаас бусад аливаа асуудлаар нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхолгүй болохоо үүгээр баталгаажуулан мэдэгдэж байна.

Баталгаажуулсан,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Д.МӨНХБАТ



2023.08.18



БОНДЫН ГЭРЭЭ

2023 оны 8 дугаар сарын 16-ны өдөр Дугаар № АС-51-01-23-980 Улаанбаатар хот

Энэхүү Бондын гэрээ (цаашид "Гэрээ" гэх -г Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай Монгол Улсын хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн,

нэг талаас Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, 24, Парк Плэйс оффисын барилга, 4 давхар, 404 тоот хаягт байрлах Голомт Капитал ҮЦК ХХК, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал С.Ган-Эрдэнэ (цаашид "Андеррайтер гэх) болон

нөгөө талаас Монгол Улс, Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, Сентрал тауэр, 5 давхар хаягт байрлах Ашид Капитал ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирал П. Батжаргал нар нь (цаашид "Бонд гаргагч" гэх) энэхүү Гэрээг дор дурдсан нөхцөлөөр байгуулав.

1. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

- 1.1 Энэхүү Гэрээгээр Бонд гаргагчаас өрийн хэрэгсэл (цаашид "Бонд" гэх)-ийг Өрийн бичиг (цаашид "Бонд" гэх) гаргахтай холбогдуулан бондын нөхцөл, төлбөрийг тооцоолох аргачлал, худалдан авах нөхцөл, Бонд гаргагч хөрөнгө оруулагчдын өмнө үүргээ гүйцэтгэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад энэхүү Гэрээний зорилго оршино.
- 1.2 Энэхүү Гэрээг талууд бичгээр байгуулж, гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр хэрэгжинэ.

2. БОНДЫН НӨХЦӨЛ

2.1. Бонд гаргагч нь дараах нөхцөлөөр Бонд гарган нийтэд санал болгоно.

2.1.1	Үнэт цаасны төрөл	Нээлттэй өрийн хэрэгсэл (энгийн хүүтэй бонд)
2.1.2	Бондын арилжаа	Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй хүрээнд
2.1.3	Бондын тоо ширхэг	150,000 (нэг зуун тавин мянга) ширхэг
2.1.4	Бондын нэрлэсэн үнэ, (ширхэг)	100,000 (нэг зуун мянга) төгрөг
2.1.5	Бондын хөтөлбөрийн нийт дүн	15,000,000,000 (арван таван тэрбум) төгрөг
2.1.6	Бондын хугацаа	12 сар
2.1.7	Бондын хүү	17.5 хувь, жилийн
2.1.8	Хүүгийн төлөлт	Сар тутам
2.1.9	Үндсэн төлбөр төлөлт	Хугацааны эцэст




2023.08.18

2023-08-18

simple

БҮРГЭЭР



- 2.1.10 **Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулах зориулалт** Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт, зээлийн багцыг нэмэгдүүлэх
- 2.1.11 **Үнэт цаасны хүүгийн орлогын татвар** 5.0 хувь
- 2.1.12 **Бондын эргэн төлөлт** Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны эргэн төлөлтийг харилцагчдад олгосон зээлийн багцаас бий болох хүүгийн орлого, үндсэн төлбөрийн эргэн төлөлтөөр санхүүжүүлнэ.
- 2.1.13 **Үнэт цаас гаргагчийн зээлжих зэрэглэлийн үнэлгээ** Зээлжих Зээлжих зэрэглэлийн эжинси: Хөрөнгө Оруулалтын Зэрэглэлийн Эжинси ХХК Үнэлгээ: BBB+
- 2.1.14 **Хүүгийн төлбөр тооцох аргачлал** Бондын хүүг хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс эхлэн жилийн хүүг 365 хоногоор тооцно. Хэрэв хүү төлөх өдөр амралтын өдөр таарвал дараагийн ажлын өдөр төлөх ба энэ тохиолдолд амралтын өдрүүдэд хүүг нэмж тооцохгүй.
- 2.1.15 **Нийтэд санал болгох хугацаа** 2023 оны 9 сар
- 2.2. Бонд нь Хугацаанаас өмнө эргүүлэн дуудах болон хөрвөх нөхцөлгүй байна.

3. БОНДЫН ЗАХИАЛГА

- 3.1. Талууд нь Санхүүгийн Зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 226 тоот тогтоолоор батлагдсан Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журмын харгалзан анхдагч зах зээлийн үйл ажиллагааг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан зохион байгуулна.
- 3.2. Анхдагч зах зээлийн арилжаа хаагдахад Бонд нь худалдан авсан хөрөнгө оруулагчийн нэр дээр бүртгэгдэнэ.

4. ТӨЛБӨРИЙН ТАСАЛДАЛ, ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ТООЦОХ НӨХЦӨЛ

- 4.1. Бонд гаргагч нь Бондын хүү болон үндсэн төлбөрийг Үнэт цаасны танилцуулга болон бусад баримт бичигт заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүй нөхцөл үүсэх тохиолдолд төлбөрийн тасалдал болсонд тооцно.
- 4.2. Төлбөрийн чадваргүй болох нөхцөлийг хуульд зааснаар тодорхойлно.
- 4.3. Бонд гаргагч төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан дарааллыг харгалзах бөгөөд ямар ч тохиолдолд Бондын хүү болон үндсэн төлбөрийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахаас өмнө тэргүүн ээлжид барагдуулна.

5. БОНДЫГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ

- 5.1. Бонд гаргагч нь Бондыг хугацааны эцэст эргүүлэн худалдан авах буюу үндсэн төлбөрийг төлнө.
- 5.2. Бонд гаргагч нь Бондыг хугацаанаас өмнө эргүүлэн худалдан авах үүрэггүй.





6. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 6.1. Бонд гаргагчийн эрх, үүрэг
- 6.1.1. Андеррайтер, бонд эзэмшигчээс хууль тогтоомж болон энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах;
- 6.1.2. Андеррайтераас гаргасан нарийвчилсан шинжилгээ, судалгаа, хийсэн үнэлгээ, дүгнэлтэд үндэслэн нийтэд санал болгох бондын үнэ, хүүгийн түвшнийг тогтоох;
- 6.1.3. Үнэт цаасны тусгагдсан хугацаанд хүүгийн төлбөрийг болон хугацааны эцэст үндсэн төлбөрийг төлөх, энэхүү үүргээ биелүүлэхэд шаардлагатай бүхний л арга, хэмжээг авч ажиллах, андеррайтерийн өгсөн зөвлөмжид үндэслэн санхүүгийн чадавхыг сайжруулахтай холбоотой шаардлагатай арга хэмжээ авч ажиллах;
- 6.1.4. Татан төвлөрүүлсэн хөрөнгийг үнэт цаасны танилцуулгад тусгагдсаны дагуу үр ашигтай захиран зарцуулах;
- 6.1.5. Бонд гаргагчийн үйл ажиллагаа, санхүү болон бусад бодит байдлын талаарх мэдээллийг үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэд, тодорхой байх зарчмаар буюу хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад хангалттай байдлаар мэдээлэх;
- 6.1.6. Андеррайтер шаардсаны дагуу бонд гаргалттай холбоотой мэдээллийг гаргаж өгөх;
- 6.1.7. Хууль, тогтоомжид болон энэхүү гэрээнд заасан мэдээллийг цахим шуудан, эсхүл олон нийтийн хэрэгслээр дамжуулан, хугацаанд нь бонд эзэмшигчид мэдээлэх;
- 6.1.8. Холбогдох хууль тогтоомж болон энэхүү Гэрээнд заасны дагуу мэдээллийн ил тод байдлыг тогтмол хангах, Бонд эзэмшигчийн өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллах;
- 6.1.9. Бондын нөхцөл, холбогдох баримт бичигт өөрчлөлт орсон, бондын үнэ ханшид нөлөөлж болохуйц аливаа үйл явдал бий болсон тохиолдолд нэн даруй Андеррайтер, олон нийт, Хороор, арилжаа эрхлэх байгууллагад мэдэгдэж, холбогдох арга хэмжээг авах;
- 6.1.10. Бондыг бүртгүүлэхтэйгээр холбоотойгоор СЗХ-нд хүргүүлсэн баримт бичиг, түүнд хавсаргасан баримт бичгийг бондын хугацаа дуусах, үндсэн болон хүүгийн төлбөрийг бүрэн төлж дуусах хүртэлх хугацаанд компанийн байранд, цаашид хуульд заасан хугацаанд хадгалах;
- 6.1.11. Хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас бонд эзэмшигчид учруулсан хохирлыг төлж барагдуулах;
- 6.1.12. Хууль тогтоомжид заасны дагуу үнэт цаас гаргагчид хориглосон үйл ажиллагаа хэрэгжүүлэхгүй байх;
- 6.1.13. Хууль тогтоомжид заасан бусад.
- 6.2. Андеррайтерийн эрх, үүрэг
- 6.2.1. Хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргахад шаардлагатай Бонд гаргагчийн талаарх хуулиар хориглосноос бусад бүхий л мэдээллийг бонд гаргагчаас гаргуулах авах;
- 6.2.2. Бондын танилцуулгыг бэлтгэх анхдагч зах зээлийн захиалгыг авах, хуваарилах, худалдан авах, байршуулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
- 6.2.3. Хувь хүний болон байгууллагын нууцтай холбоотой мэдээ, мэдээлэл, баримт бичгийг гуравдагч этгээдэд задруулахгүй байх;
- 6.2.4. Бонд гаргагчийн бондын хүүгийн болон үндсэн төлбөрийн эргэн төлөлтөд хяналт тавих;
- 6.2.5. Хөрөнгө оруулагчийн эрх, үүргийг зохих ёсоор хоёрдмол утгагүй танилцуулах;
- 6.2.6. Бонд гаргагч төлбөрийн чадваргүй болж хүүгийн болон үндсэн төлбөрөө төлөөгүй бол үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар шүүхэд нэхэмжлэх гаргах;
- 6.2.7. Хууль тогтоомжид заасан бусад;
- 6.3. Бонд эзэмшигч буюу хөрөнгө оруулагчийн эрх үүрэг
- 6.3.1. Бонд эзэмшигч, түүний хамтран эзэмшигч нь компанийн санхүүгийн тайлан, үнэт цаасны танилцуулгыг хөрөнгө оруулалтын зорилгоор судлан үзэж, бүрэн танилцсаны үндсэн дээр бонд худалдан авч, хөрөнгө оруулалт хийх шийдвэрийг бие даан гаргах;
- 6.3.2. Бондыг бирж дээрээс чөлөөтэй худалдан авах, хоёрдогч зах зээл дээр худалдах;



2023.08.18

- 6.3.3. Санхүүгийн Зохицуулах Хорооны Үнэт цаасны мэдээллийн ил тод байдлын журамд заасны дагуу Бонд гаргагчийн мэдээллийг авах, бондын хоёрдогч зах зээлийн үнний мэдээлэлтэй танилцах;
- 6.3.4. Бондын үнэ болон түүнийг худалдан авахтай холбоотой шимтгэл, хураамжийн үүргийг гүйцэтгэснээр Үнэт цаасыг эзэмшлээ шилжүүлэхийг Бонд гаргагчаас шаардах;
- 6.3.5. Хугацааны эцэст бондыг нэрлэсэн үнээр худалдах, худалдан авах, хуримтлагдсан хүүг төлөхийг Бонд гаргагчаас шаардах эрхтэй ба хэрэв Бонд гаргагч нь энэ үүргээ биелүүлэхгүй бол гэрээнд заасны дагуу үүргийн гүйцэтгэл хангуулахыг шаардах;
- 6.3.6. Бонд гаргагч төлбөрийн чадваргүй болсон буюу үүргийн гүйцэтгэлийг хангах эд хөрөнгийн хэмжээ багассан, эсхүл эд хөрөнгөгүй болсон бол Бонд эзэмшигч нь тогтоосон хугацаанаас өмнө үүргээ нэн даруй гүйцэтгэхийг түүнээс шаардах;
- 6.3.7. Бонд эзэмшигч, түүний хамтран эзэмшигчийн бондын төлбөрт төлсөн мөнгөн хөрөнгө нь түүний хууль ёсны үйл ажиллагаанаас олсон орлого бөгөөд "Мөнгө угаах, терроризмтай тэмцэх тухай хууль"-ийн дагуу холбогдох шалгуурыг хангасан, эрх зүйн аливаа доголдолгүй, маргаангүй мөнгөн хөрөнгө болохыг бүрэн баталж, эрсдэл болон өгөөжийг бүрэн тооцоолж хөрөнгө оруулалтын шийдвэрийг бие даан гаргасан талаар баталгаа гаргаж Андеррайтераас гаргасан анхан шатны маягтыг үнэн зөв мэдээлэх болон түүнд орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэх;
- 6.3.8. Мөнгөн хөрөнгөө урьдчилан байршуулах нөхцөлөөр өөрийн захиалсан бондын төлбөрийг төлөх, тийнхүү төлөөгүй бол захиалсан бондыг Андеррайтер худалдах эрхтэйг хүлээн зөвшөөрөх;
- 6.3.9. Монгол Улсын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу бондын хүүгийн орлогоос татвар төлөх;
- 6.3.10. Хууль тогтоомжид заасан бусад
- 6.4. Энэхүү Гэрээгээр тохиролцоноос бусдаар Бонд гаргагчид тусгайлан хориглох буюу заавал хэрэгжүүлэх тусгай нөхцөл тогтоогүй болно.

7. Бусад зүйл

- 7.1. Гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгч нар гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
- 7.2. Талууд харилцан тохиролцсоноор Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 7.3. Гэрээний заалтын аль нэг зүйл хүчингүй болсон нь энэхүү гэрээ бүхэлдээ хүчин төгөлдөр бус болох үндэслэл болохгүй.
- 7.4. Энэхүү гэрээг Монгол хэлээр 2 хувь үйлдсэн бөгөөд тал тус бүр нэг хувийг хадгална.
- 7.5. Талуудын хооронд үүссэн аливаа маргааныг Монгол Улсын хуулийн дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Андеррайтер
ГОЛОМТ КАПИТАЛ УЦК ХХК
С.Ган-Эрдэнэ
Гүйцэтгэх захирал

Бонд гаргагч
АШИД КАПИТАЛ ББСБ
АШИД КАПИТАЛ
ББСБ ХХК
Т.Багсаргал
Гүйцэтгэх захирал

Checked by
Legal Department
Date:
Signature:


Checked by
Legal Department
Date: 2023.08.16
Signature: Д.Амгалан

УЛААНБААТАР ХОТ
АШИД КАПИТАЛ
ББСБ ХХК
АТАА 1119300111 1119300111 1119300111


МАНДАЛ КАПИТАЛ
MARKETS УЦК ХХК
MANDAL CAPITAL
MARKETS SC
LLC 497
111930162 9021070414 5213447

ГОЛОМТ КАПИТАЛ УЦК ХХК
Golomt Capital
1119300111 1119300111 1119300111

2023.08.18



6.45 ХУУЛИЙН ДҮГНЭЛТИЙН ТАЙЛАН



Нүүц баримт
Эх хувь



**ӨМГӨӨЛЛИЙН
БАТБАЯР ЭНД
ПАРТНЭРС ХХН**

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн эргэн чөлөө - 15, Монгол ТВ цаннаг, 10-р давхар, 1001-1003 тоот, Утас/Факс: (+976) 7711 9008, Цахил шуудан: contact@bnp.mn, Веб: www.bnp.mn

**АШИД КАПИТАЛ ББСБ ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
П.БАТЖАРГАЛ
ТАНАА**

Огноо: 2023.08.21
Дугаар: BNP-46/23
Утга: Хуулийн дүгнэлт



**Ашид
Капитал
ББСБ**

**АШИД КАПИТАЛ ББСБ ХХК-ИЙН
НИЙТЭД САНАЛ БОЛГОН ГАРГАЖ БҮЙ ӨРИЙН БИЧГИЙГ
НИЙТЭД САНАЛ БОЛГОХЫГ ЗӨВШӨӨРСӨН ҮНЭТ ЦААСНЫ
БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН БЭЛТГЭСЭН
ХУУЛИЙН ДҮГНЭЛТ**

Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН (цаашид “Хуулийн фирм” гэх) нь танай компанитай 2023 оны 05 сарын 19-ний өдөр байгуулсан №23/06 тоот Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээний дагуу Ашид капитал ББСБ ХХК (цаашид “Ашид капитал ББСБ ХХК”, “Үнэт цаас гаргагч” эсхүл “ББСБ” гэх)-ийн нийтэд санал болгон гаргаж буй өрийн бичиг (цаашид “Өрийн бичиг” эсхүл “Бонд” гэх)-ийг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд болон хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгүүлэхэд шаардагдах хөндлөнгийн дүн шинжилгээг хийж гүйцэтгэх, улмаар хуулийн дүгнэлт гаргах ажлыг хийхээр тохиролцсон. Тус ажилтай холбогдуулан Хуулийн фирмийн зүгээс Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Үнэт цаасны бүртгэлийн журам, Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам болон Монголын Хөрөнгийн бирж ХК (цаашид “Монголын Хөрөнгийн бирж” гэх)-аас баталсан Үнэт цаасны бүртгэлийн журамд заасан асуудлын хүрээнд Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн үйл ажиллагаанд хөндлөнгийн дүн шинжилгээ хийж, хуулийн дүгнэлт (цаашид “Хуулийн дүгнэлт” гэх)-ийг бэлтгэж үүгээр хүргүүлж байна. Хүлээн авна уу.

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Ашид капитал ББСБ ХХК, түүний эрх бүхий албан тушаалтан болон төрийн эрх бүхий гуравдагч этгээдээс бусад этгээдийн хувьд нүүц материалд тооцогдоно. Зөвшөөрөл аваагүй этгээд болон бусад эрх олгогдсон этгээд аливаа хэлбэрээр энэхүү нүүц материалд агуулагдсан мэдээ, мэдээллийг хэсэгчлэн болон бүтнээр нь бусдад дамжуулсан, цааш түгээсэн, түгээх нөхцөл боломжийг бүрдүүлсэн, хуулбарласан, задруулсан бол үүссэн үр дагаврыг бүрэн хариуцахыг анхаарна уу.

Тус Хуулийн фирм нь энэхүү Ашид капитал ББСБ ХХК-ийн нийтэд санал болгон гаргах өрийн бичгийг үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх үйл ажиллагаанд оролцож байгаа андеррайтер Голомт Капитал ҮЦК ХХК, туслах андеррайтер Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК, санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох байгууллага Монголын хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси ХХК болон Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан,



2023.08.18

Монголын Хөрөнгийн бирж ХК-ийн 2023 оны 08 сарын 18 өдөр /2023 оны 08 сарын 18 өдөр/ үйл ажиллагаанд оролцож байгаа андеррайтер Голомт Капитал ҮЦК ХХК, туслах андеррайтер Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК, санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох байгууллага Монголын хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси ХХК болон Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан, нүүц баримт /Printed copy/

Нүүц баримт
Эх хувь


холбоотой этгээдүүдтэй аливаа байдлаар харилцан хамааралгүй бөгөөд ашиг сонирхлын хувьд холбоогүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

Хуулийн дүгнэлт гаргах үндэслэл, ажлын даалгавар

Ашид капитал ББСБ ХХК-ийн нийтэд санал болгон анх удаа гаргаж буй өрийн бичгийг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд болон хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгүүлэх гэж байгаатай холбогдуулан Хуулийн фирм нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт "Үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг ... хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр, ... тус тус хянуулж, дүгнэлт гаргуулна", 10.7 дахь хэсэгт "... хууль зүйн дүгнэлт нь тухайн үнэт цаасны танилцуулгын салшгүй хэсэг байна" болон Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны №225 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.14 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны №226 тоот тогтоолоор батлагдсан "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам", Монголын Хөрөнгийн биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны №2018/01 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн дараах асуудлуудыг Үнэт цаас гаргагч үйл ажиллагаандаа мөрдөж, хангаж буй эсэхэд хөндлөнгийн дүн шинжилгээ хийж, Хуулийн дүгнэлт гаргаж өгөхөөр тохиролцсон. Үүнд:

- (i) Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх болон үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх;
- (ii) Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекст заасан шаардлага хангаж байгаа эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын байдал болон эрх бүхий албан тушаалтан нь тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлага хангаж байгаа эсэх;
- (iii) Үнэт цаас гаргагчийн дүрэм, бусад дотоод дүрэм, журмууд нь холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекст нийцсэн эсэх;
- (iv) Бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх, ББСБ-ын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх;
- (v) Сүүлийн 3 (гурван) жилийн дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх;
- (vi) Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой, сөргөөр нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх;
- (vii) Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх;
- (viii) Үнэт цаасыг бүртгүүлэх танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх;
- (ix) Үнэт цаас гаргагчийн толгой, охин, хараат, зэрэгцээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн Үнэт цаас гаргагчийн хяналтыг хэрэгжүүлэгч, эцсийн өмчлөгч этгээдийг тодорхойлох;
- (x) Үнэт цаас гаргагч нь аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байсан эсэх;
- (xi) Үнэт цаас гаргагч татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх.





VI. ХАВСРАЛТ

Нууц баримт
Эх хувь

Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээгээр хүлээсэн Ажлын даалгаварт багтсанаас бусад асуудлаар Хуулийн фирм хууль зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлээгүй болно.

Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргаж байгаа өрийн бичгийн тухай

Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрхийг хэрэгжүүлэгч М-Си-Эс Холдинг ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 05 сарын 12-ны өдрийн №024 тоот Үнэт цаас гаргах ерөнхий зөвшөөрлийг охин компанид олгох тухай тогтоолоор Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авсан байгууллагаар санхүүгийн чадавхын зэрэглэл тогтоолгож, 2023 онд нийт 55,000,000,000 (тавин таван тэрбум) төгрөг хүртэлх дүнгээр үнэт цаас гаргах ерөнхий зөвшөөрлийг Ашид капитал ББСБ ХХК-д олгож, тус тогтоолтой холбогдуулан Ашид капитал ББСБ ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолд хувьцаа эзэмшигч М-Си-Эс Холдинг ХХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал Л.Гантөмөрт олгож шийдвэрлэсэн байна. Улмаар Ашид капитал ББСБ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 05 сарын 12-ны өдрийн №03 тоот Үнэт цаас гаргах ерөнхий зөвшөөрлийг охин компанид олгох тухай шийдвэрээр Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авсан байгууллагаар санхүүгийн чадавхын зэрэглэл тогтоолгож, 2023 онд нийт 55,000,000,000 (тавин таван тэрбум) төгрөг хүртэлх дүнгээр үнэт цаас гаргах ерөнхий зөвшөөрлийг Ашид капитал ББСБ ХХК-д олгож шийдвэрлэсэн байна.

Тус тогтоол, шийдвэртэй холбогдуулан Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 05 сарын 12-ны өдрийн №04 тоот Өрийн бичиг гаргах тухай шийдвэрээр нэг бүр нь 100,000 (нэг зуун мянган) төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 200,00 (хоёр зуун мянган) ширхэг нийт 20,000,000,000 (хорин тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий, 12 (арван хоёр) сарын хугацаатай, жилийн 18 (арван найман) хувийн хүүтэй, улирал тутамд хүү төлөгдөх давтамжтай өрийн бичиг гарган Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн. Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 06 сарын 23-ны өдрийн Ашид капитал ББСБ ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй өрийн хэрэгслийг бүртгэх тухай №212 тоот тогтоолын дагуу Ашид капитал ББСБ ХХК-ийн нийтэд санал болгон гаргах 12 (арван хоёр) сарын хугацаатай, жилийн 18 (арван найман) хувийн хүүтэй, нэг бүр нь 100,000 (нэг зуун мянган) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 200,000 (хоёр зуун мянган) ширхэг өрийн хэрэгслийг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг зөвшөөрсөн. Монголын Хөрөнгийн биржийн 2023 оны 06 сарын 29-ний өдөр Анхдагч зах зээлийн арилжааны тухай №01/510 тоот албан бичгээс үзвэл Ашид капитал ББСБ ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй 12 (арван хоёр) сарын хугацаатай, жилийн 18 (арван найман) хувийн хүүтэй, нэг бүр нь 100,000 (нэг зуун мянган) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 200,000 (хоёр зуун мянган) ширхэг өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2023 оны 06 сарын 29-ний өдөр хүлээн авч, амжилттай зохион байгуулсан дүгнэлтийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн байна. Улмаар Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 07 сарын 03-ны өдрийн №1/2802 тоот албан бичгээр нийтэд санал болгохыг зөвшөөрсөн өрийн хэрэгслийн хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг олгосон байгааг дурдаж байна.


Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрхийг хэрэгжүүлэгч М-Си-Эс Холдинг ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 08 сарын 14-ний өдрийн №040 тоот Өрийн бичиг гаргахыг охин компанид зөвшөөрөх тухай тогтоолоор нэг бүр нь 100,000 (нэг зуун мянган) төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 150,000 (нэг зуун тавин мянган) ширхэг нийт 15,000,000,000 (арван таван тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий, 12 (арван хоёр) сарын хугацаатай, жилийн 17.5 (арван долоо аравны таван) хувийн хүүтэй, сар тутамд хүү төлөгдөх давтамжтай өрийн бичиг гарган Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд санал болгон нээлттэй арилжих, хөрөнгө татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн байна. Түүнчлэн Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 08 сарын 14-ний өдрийн №05 тоот Өрийн бичиг гаргах тухай шийдвэрээр нэг бүр нь 100,000 (нэг зуун мянган) төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 150,000 (нэг зуун тавин мянган) ширхэг нийт 15,000,000,000 (арван таван тэрбум) төгрөгийн үнийн




3



2023.08.18



Нүүц баримт
Эх хувь



дүн бүхий, 12 (арван хоёр) сарын хугацаатай, жилийн 17.5 (арван долоо аравны таван) хувийн хүүтэй, сар тутамд хүү төлөгдөх давтамжтай өрийн бичиг гарган Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд санал болгон нээлттэй арилжих, хөрөнгө татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журамд нийцүүлэн өрийн бичиг гаргагч нь дотоодын эсхүл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаар санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгосон бол үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгож эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийг барьцаалахгүй байж болохоор зохицуулсан бөгөөд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржээс тогтоосон шалгуурыг хангасан компани нийтэд санал болгон өрийн бичиг гаргаж болох хуулийн зохицуулалттай байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.22 дахь заалтад "нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэл" гэж энэ хуульд заасан журмын дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлийг хэлнэ" гэж заасан байх бөгөөд мөн зүйлийн 4.1.21 дэх заалтад "нийтэд санал болгох" гэж Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон журмын дагуу үнэт цаасаа 50 (тавь)-аас дээш тооны этгээдэд санал болгон худалдахаар мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдэгдэхийг хэлнэ гэж заасан байна. Эдгээр хуулийн зохицуулалтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржээс нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг зөвшөөрсөн тохиолдолд Ашид капитал ББСБ ХХК өрийн бичгийг нийтэд чөлөөтэй арилжих, арилжихыг санал болгох эрхтэй гэж Хуулийн фирмээс үзсэн болно.

Товчилсон үгсийн товьёг

Хуулийн дүгнэлт гаргахад ашигласан товчилсон үгсийг дараах утгаар ойлгож хэрэглэнэ үү.

Үүнд:

Үгсийн дарааллаар:

ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
КЗК	Компанийн засаглалын кодекс
МУИС	Монгол Улсын Их Сүргүүл
СЭХ	Санхүүгийн зохицуулах хороо
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХН	Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл
ШУТИС	Шинжлэх Ухаан, Технологийн Их Сүргүүл

Дүн шинжилгээ хийсэн арга, аргачлал

Энэхүү дүн шинжилгээг хийж гүйцэтгэхдээ Үнэт цаас гаргагчтай Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээгээр тохиролцсон асуудлын хүрээнд Үнэт цаас гаргагчийн гаргаж өгсөн баримт материалд үндэслэх зарчмыг баримталсан болно.

Дүн шинжилгээг хийхдээ хараат бус байх зарчмыг баримталсан бөгөөд Хуулийн дүгнэлт гаргахад ашиглах эх сурвалжийг сонгохдоо хөндлөнгийн гуравдагч этгээдээс олгосон/тодорхойлсон лавлагаа, тодорхойлолт, баримт бичиг болон гуравдагч этгээдтэй байгуулсан, солилцсон зэргээр Үнэт цаас гаргагчаас хараат бусаар баталгаажсан үйл баримтад үндэслэгдсэн байхыг удирдлага болгож ажилласан.

Хууль тогтоомжоор тодорхойлсон төрийн эрх бүхий байгууллагын бүрэн эрхэд хамаарах асуудлаар болон гадаад улсын хуулийг хэрэглэх асуудлаар Хуулийн фирм дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргаагүй бөгөөд холбогдох лавлагаа, тодорхойлолтыг гаргуулан авч дүн шинжилгээндээ ашигласан болохыг тусгайлан анхаарч Хуулийн дүгнэлтэд дурдагдаагүй асуудлаар Үнэт цаас



2023.08.18



Нууц баримт
Эх хувь



гаргагчаас, лавлагаа тодруулга бүхий албан бичигт дурдагдсан асуудлаар тухайн шатны төрийн эрх бүхий байгууллагаас тодруулж лавлана уу.

Хууль тогтоомжид тусгагдсан хэм хэмжээ, заалт, нөхцөл, журмыг тодорхойлж ойлгохдоо хууль зүйн ач холбогдол бүхий үг, үгс, үтгийг Улсын Дээд шүүхийн гаргасан албан ёсны тайлбар, түүнд тодорхойлсон утгын дагуу, хэрэв тухайн нөхцөлд хэрэглэх албан ёсны тайлбар, практик байхгүй нөхцөлд хууль зүйн шинжлэх ухаанд түгээмэл тогтсон утга агуулгыг ашигласан бөгөөд ердийн хэрэглээний оноосон нэрийг тухайн үгийн хэлзүйн шүүд утга агуулгаар ойлгон, ашиглаж тайлбарласан.

Үнэт цаас гаргагчийн шилжүүлэн өгсөн цаасан болон электрон хэлбэртэй баримт бичигт агуулагдаж байгаа эх болон хуулбар баримт материал, тэдгээрт агуулагдаж байгаа мэдээлэл, хөндлөнгийн эрх бүхий байгууллагын гаргаж өгсөн лавлагаа, тодорхойлолт, баримт бичиг, түүнд агуулагдсан мэдээ, мэдээлэл, баримт, үйл баримтыг үнэн, зөв, хууль ёсны, хүчин төгөлдөр гэж үзэж ашигласан.

Хөндлөнгийн эрх бүхий байгууллагуудаас гаргуулан авсан лавлагаа, тодорхойлолт нь үнэн зөв бөгөөд дурдагдсан үйл баримт нь Хуулийн дүгнэлт гаргах өдрийг хүртэл хугацаанд хэвээр хадгалагдаж байгаа гэж үзсэн.

Хуулийн фирм нь төрийн эрх бүхий байгууллагаас гаргаж өгсөн лавлагаа, тодорхойлолтод тусгагдсан оноосон нэр томъёонууд харилцан адилгүй тусгагдсан байсныг нэг ижил формат, стандартад оруулж илэрхийлсэн болно.

Хуулийн дүгнэлтэд дурдсан хуулийн этгээдүүдийн оноосон нэрийг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн оноосон нэрээр, төрийн эрх бүхий байгууллагуудын нэрийг тухайн лавлагаа, тодорхойлолт, албан бичигт ашиглагдсан оноосон нэрээр ашиглаж хэрэглэсэн болно.

Энэхүү Хуулийн дүгнэлтийг Монгол Улсын хууль тогтоомж, хэм хэмжээний актаар тогтоосон нөхцөл, журмын хүрээнд бэлтгэсэн.

Хуулийн фирмийн мэдэгдэл

Хуулийн фирм нь дүн шинжилгээг Үнэт цаас гаргагчийн хүлээлгэн өгсөн баримт бичиг, материал, тэдгээрт агуулагдсан баримтат мэдээллийн хүрээнд хийж гүйцэтгэсэн бөгөөд Үнэт цаас гаргагчаас үнэн зөв, бүрэн мэдээлэл өгсөн, холбогдох шилжүүлж өгсөн баримт бичгүүд нь үнэн зөв, хүчин төгөлдөр, жинхэнэ эх эсхүл жинхэнэ эхээс хуулбарлагдсан гэж үзэж, ашигласан болно.

Энэхүү Хуулийн дүгнэлт нь хөндлөнгийн дүн шинжилгээ хийсэн баримт бичиг бөгөөд Үнэт цаас гаргагч, түүнээс хүлээн авсан бусад этгээдийн хувьд заавал дагаж мөрдөх, мөрдөхийг шаардах эрх, үүрэг, хариуцлага үүсгэхгүй, хууль зүйн туслалцаа, зөвлөгөө үзүүлсэнд тооцогдохгүй.



Хуулийн фирм нь Гэрээгээр хүлээсэн ажлын даалгаварт тусгагдсанаас бусдаар Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд тусгайлан дүн шинжилгээ хийгээгүй болохыг анхаарна уу.

Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Өрийн хэрэгслийн бүртгэлийн журамд нийцүүлэн Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан эрх бүхий байгууллагаар санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгож, үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгож эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийг барьцаалахгүйгээр өрийн бичиг гаргаж байгаа гэж ойлгож энэхүү Хуулийн дүгнэлтийг бэлтгэсэн болно.

Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргасан өмнөх өрийн бичигтэй холбогдуулан хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээ хийж гаргасан Хуулийн дүгнэлтээ үргэлжлүүлэн энэхүү Хуулийн дүгнэлтийг бэлтгэсэн бөгөөд Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан гэрээ, хэлцлийн хувьд 2020 оны 08 сарын 01-ний өдрөөс эхлэн 2023 оны 08 сарын 01-ний өдрийн хооронд Ашид капитал ББСБ ХХК-ийн бусадтай бичгээр байгуулсан нийт гэрээ,



2023.08.18



Нүүц баримт
Эх хувь

хэлцлийг гаргуулан авч хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэрээ, хэлцлийг сонгон авч дүн шинжилгээ хийсэн болохыг дурдаж байна.

Хуулийн дүгнэлтийг зөвхөн энд дурдагдсан зорилгоор хийж гүйцэтгэсэн бөгөөд Үнэт цаас гаргагч нь өөр бусад зорилгоор ашиглах, хэсэгчлэн болон бүхлээр нь нийтэд дэлгэх, түгээх, хуулбарлах, хадгалах болон Хуулийн фирмийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөлт оруулахыг хориглоно.

Хуулийн дүгнэлтэд ашигласан баримт бичиг, тэдгээрт агуулагдсан мэдээлэлд Хуулийн дүгнэлт гаргасан өдрөөс хойш аливаа өөрчлөлт орсон бол Хуулийн фирм хариуцлага хүлээхгүй.

Хуулийн фирм нь илэрхий үг үсэг, утга найруулгын зөрүүнээс бусдаар Үнэт цаас гаргагчийн шилжүүлж өгсөн баримт бичгийн материалд агуулагдаж байгаа дараах асуудлыг үнэн зөв гэж үзэж дүгнэлт гаргасан болно. Үүнд:

- Баримт бичигт агуулагдсан хүсэл зориг, гол санаа, дурдсан/дурдагдсан асуудал нь үндэслэлтэй, үнэн зөв, хууль ёсны дагуу илэрхийлэгдсэн, хүчин төгөлдөр;
- Баримт бичгүүд нь цаг хугацаандаа үйлдэгдсэн, үнэн, зөв, бүрэн, гарын үсэг зурсан этгээд нь хуулийн дагуу албан ёсоор төлөвлөх эрхтэй;
- Хуулийн дүгнэлт гаргах иш үндэслэл болсон баримт материалд дурдагдсан нөхцөл байдал нь Хуулийн дүгнэлт гаргаснаас хойш эсхүл тухайн баримт бичгийг үйлдсэн огноо, хугацаанаас хойш өөрчлөгдөөгүй бөгөөд аливаа байдлаар талуудын эрх ашигт сөргөөр нөлөөлөх үйл явдал үүсээгүй;
- Аливаа дарагдсан тэмдэг (тамга) нь үнэн, зөв, жинхэнэ, эрх бүхий ашиглах эрхтэй этгээдийн зөвшөөрлөөр дарагдсан.

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Ашид капитал ББСБ ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй өрийн бичигт гаргасан аливаа төрлийн амлалт, баталгаанд тооцогдохгүй болохыг анхаарна үү.

Үнэт цаас гаргагчийн бичгээр тавьсан хүсэлтийг үндэслэн Хуулийн фирм нь шаардлагатай гэж үзвэл Хуулийн дүгнэлтийн талаар гүравдагч этгээдэд нэмэлт тайлбар, тодруулга өгөх боломжтой болохыг дурдаж байна. Хуулийн фирмийн зүгээс өгөх нэмэлт тайлбар, тодруулга нь Үнэт цаас гаргагчийн зүгээс гаргасан ажлын даалгаварт тусгаснаас бусад асуудлаар нэмэлт дүн шинжилгээ хийх, тайлбар өгөх үүрэг үүсгэхгүй болно.

Хуулийн фирм нь дүн шинжилгээ хийхэд ашиглагдсан лавлагаа, тодорхойлолт, Үнэт цаас гаргагчийн гаргаж өгсөн аливаа баримт, материалд дурдагдсан үйл баримт, нөхцөл байдал Хуулийн фирмд мэдэгдэлгүйгээр өөрчлөгдсөн аливаа асуудлаар хариуцлага хүлээхгүй.

Энэхүү Хуулийн дүгнэлтийг Монгол Улсын хууль тогтоомж, хэм хэмжээний актаар тогтоосон нөхцөл, журмын хүрээнд бэлтгэсэн бөгөөд гадаад улсын хууль тогтоомж, хэм хэмжээг тайлбарлах, хэрэглэх, ашиглахтай холбоотой асуудал багтаагүй болохыг илэрхийлж байна.

Хууль тогтоомж, хэм хэмжээний акт

Хуулийн дүн шинжилгээг хийж гүйцэтгэхдээ энэхүү Хуулийн дүгнэлтийг бэлтгэж өгөх өдрийн байдлаар Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж, тэдгээрийг дагалдаж батлагдсан холбогдох хэм хэмжээний актуудыг үндэслэл болгон бэлтгэсэн.


Дүн шинжилгээ, дүгнэлт

Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн эрх зүйн байдал, хувьцаа эзэмшигч, хувь нийлүүлсэн хөрөнгийн талээр тодруулж авч үзлээ.

Ашид капитал ББСБ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04 сарын 13-ны өдрийн №02 тоот шийдвэрээр Ашид капитал ББСБ ХХК-ийн одоогийн хүчин төгөлдөр хэрэгжиж буй дүрмийг



2023.08.18



VI. ХАВСРАЛТ
БҮРТГЭВ-02

баталсан бөгөөд хуулийн этгээдийн улсын бүртгэлд 2023 оны 05 сарын 21-ний өдөр бүртгэгдсэн байна.

Ашид капитал ББСБ ХХК-ийн дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.4 дэх хэсэгт "Компани нь бие даасан тайлан тэнцэлтэй, харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг, хариуцлага хүлээх, нэг хувьцаа эзэмшигчтэй, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр¹ ажиллана" гэж банк бус санхүүгийн байгууллага өөрийн эрх зүйн байдлыг тодорхойлсон байна.

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч, хувь нийлүүлсэн хөрөнгийн хувьд Үнэт цаас гаргагчийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт "Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хуулийн 30.1 дэх хэсэгт зааснаар тодорхойлно. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 55,000,000,000 (тавин таван тэрбум) төгрөг байна", 5.2 дахь хэсэгт "Компанийн зарласан болон гаргасан хувьцаа нь нэг бүр нь 1,000 (нэг мянган) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 55,000,000 (тавин таван сая) ширхэг энгийн хувьцаа байна", 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэгт "Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь М-Си-Эс Холдинг ХХК байна" гэж тусгасан байна.

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчийн хувьд Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт "Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрхийг компанийн хувьцаа эзэмшигч болох М-Си-Эс Холдинг ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл эдэлнэ" гэж тусгасан байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн 2023 оны 08 сарын 14-ний өдрийн №23280002003935 тоот Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаанаас үзвэл Ашид капитал ББСБ ХХК нь нэг бүр нь 1,000 (нэг мянган) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 55,000,000 (тавин таван сая) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх нийт 55,000,000,000 (тавин таван тэрбум) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй бөгөөд 1 (нэг) хувьцаа эзэмшигчтэй, хязгаарлагдмал хариуцлагатай компани болохыг тодорхойлсон байна.

Хуулийн фирм нь энэхүү Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Ашид капитал ББСБ ХХК-ийн хүчин төгөлдөр хэрэгжиж буй дүрэм болон хөндлөнгийн гуравдагч этгээдээс олгосон лавлагаа, тодорхойлолтод үндэслэн Үнэт цаас гаргагчаас гаргаж өгсөн баримт материал, тэдгээрт агуулагдсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж энэхүү Хуулийн дүгнэлтийг бэлтгэж дараах байдлаар дүгнэлээ.

Нэг. Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх болон үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх асуудлын хувьд авч үзвэл:

Банк бус санхүүгийн үйл ажиллагааг зохицуулж буй хуулийн зохицуулалтын дагуу банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг Компанийн тухай хуульд заасны дагуу үүсгэн байгуулж, хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлснээр хуулийн этгээдийн иргэний эрх зүйн

Компанийн тухай хууль (2011).

3 дугаар зүйл Компани, түүний хэлбэр

3.1 Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээдийг компани гэнэ.

3.2 Хувьцаа нь тухайн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох бөгөөд харин компанийн эд хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй.

3.3 Хувьцаа эзэмшигчийн эрхийг энэ хууль болон компанийн дүрмээр тогтох бөгөөд хувьцаа эзэмшигч нь ногдол ашиг авах, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хэлэлцэж байгаа асуудлаар санал өгөх, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртээ зэрэг үндсэн эрх эдэлнэ.

3.4 Компани нь хязгаарлагдмал хариуцлагатай болон хувьцаат компани гэсэн хэлбэртэй байна.

3.5 Хязгаарлагдмал хариуцлагатай компани гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, түүнийг захиран зарцуулах эрх нь хууль болон компанийн дүрмээр хязгаарлагддаг компанийг хэлнэ.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль (2002).

5 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг үүсгэн байгуулах

5.1 Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг Компанийн тухай хуульд заасны дагуу үүсгэн байгуулна.



2023.08.18

Нүүц баримт
Эх хувь

чадвар үүсэх² бөгөөд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль¹ болон Зөвшөөрлийн тухай хуульд⁵ заасан журмын дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авснаар банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн зохицуулалттай.


Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн зохицуулалтын дагуу компанийн хэлбэрээр үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд нь улсын бүртгэлийн байгууллагад мэдээллээ бүртгүүлэх бөгөөд хуулийн этгээд бүхэн хувийн хэрэгтэй байхаар зохицуулсан². Тус зохицуулалтыг үндэслэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан дахь Ашид капитал ББСБ ХХК-ийн хувийн хэргийн хуулбар лавлагаа болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаанд үндэслэн дүн шинжилгээ хийлээ.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн лавлагаа болон Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн 2023 оны 08 сарын 14-ний өдрийн №23280002003935 тоот Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаанаас үзвэл Үнэт цаас гаргагч нь үүсгэн байгуулагчийн 2016 оны 09 сарын 06-ны өдрийн №001 шийдвэрээр Хорайзон Капитал оноосон нэртэй, хязгаарлагдмал хариуцлагатай

² Иргэний хууль (2002).
¹ 26 дугаар зүйл. Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар
² 26.1 Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсч, хуульд заасан журмын дагуу татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дүүсгавар болно.
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хууль (2018).
³ 3 дугаар зүйл Хуулийн үйлчлэх хүрээ
⁴ 3.1 Хуулийн этгээдийн төрөл, хэлбэрээс үл хамааран иргэний эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсэж, хуульд заасан журмын дагуу татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дүүсгавар болохтой холбогдон үүсэх харилцааг энэ хуулиар зохицуулна.
⁵ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль (2002).
⁶ 6 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх
^{6.1} Банк бус санхүүгийн үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон зөвшөөрлийн дагуу Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээд эрхэлж болно.
⁷ Зөвшөөрлийн тухай хууль (2022).
⁸ 8.1 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийн жагсаалт
⁹ 2 Банк, банкинаас бусад санхүүгийн үйлчилгээний чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:
¹⁰ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль (2018).
⁴ дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт
^{4.1} Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:
^{4.1.1} "хуулийн этгээдийн хувийн хэрэг" гэж улсын бүртгэлийн мэдээллийн санд цаасан болон цахим хэлбэрээр байгаа, энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан мэдээллийн бүрдлийг;
^{4.1.2} "хуулийн этгээдийн мэдээлэл" гэж хуулийн этгээдийн хувийн хэрэгт агуулагдаж байгаа энэ хуулийн 10.1-д заасан болон бусад мэдээллийг;
¹⁰ дугаар зүйл. Хуулийн этгээдийн хувийн хэргийн агуулга
^{10.1} Хуулийн этгээдийн хувийн хэрэг дараах мэдээллийг агуулна:
^{10.1.1} хуулийн этгээдийн нэр, регистрийн болон хувийн хэргийн дугаар;
^{10.1.2} хуулийн этгээдийн төрөл, хэлбэр, үйл ажиллагааны чиглэл;
^{10.1.3} хуулийн этгээдийн ерөнхий захиргаа оршин байгаа газрын албан ёсны хаяг, хэрэв байгын ажиллагаатай ерөнхий захиргаа байхгүй бол тухайн хуулийн этгээдийг итгэмжлэгчгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн оршин байгаа газрын хаяг;
^{10.1.4} хуулийн этгээдийг шинээр байгуулах, эсхүл өөрчлөн байгуулах, татан буулгах тухай;
^{10.1.5} үүсгэн байгуулагчийн талаарх мэдээлэл;
^{10.1.6} үүсгэн байгуулах баримт бичиг;
^{10.1.7} өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдах болон үйл ажиллагаа нь зогссон хуулийн этгээд тус бүрийн эрх залгамжлалын талаар;
^{10.1.8} хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн тухай мэдээлэл, түүнийг бүртгэсэн он, сар, өдөр;
^{10.1.9} компанийн хувьд үүсгэн байгуулах баримт бичигт заасан хувь шийтүүлсэн хөрөнгийн хэмжээ,
^{10.1.10} хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний үнэмлэхийн хуулбар, гадаадын иргэн бол паспортын хуулбар;
^{10.1.11} хуулийн этгээд нь салбар, төлөөлөгчийн газартай бол түүний оршин байгаа газрын албан ёсны хаяг, эрх бүхий этгээдийн иргэний үнэмлэхийн хуулбар;
^{10.1.12} хуулийн этгээдийн эрх барих этгээдийн гишүүдийг сонгосон, өөрчилсөн тухай үүсгэн байгуулагчийн шийдвэр, хурлын тэмдэглэл;
^{10.1.13} төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр хуулийн этгээдийн улсын бүртгэлд хориг тавьсан, цуцалсан тухай баримт бичиг, хяналтын улсын байцаагчийн дүгнэлт, шийтгэлийн хуудас;
^{10.1.14} хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон түүний хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн талаарх мэдээлэл.



2023.08.18



VI. ХАВСРАЛТ
БҮРТГЭВ-02

Нууц баримт
Эх хувь

компани хэлбэрээр, 1 (нэг) үүсгэн байгуулагчтайгаар үүсгэн байгуулагдаж, хуулийн этгээдийн улсын бүртгэлд 2016 оны 09 сарын 09-ний өдөр бүртгэгдсэн байна.

Улмаар Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн 2016 оны 09 сарын 27-ны өдрийн шийдвэрээр Хорайзон Капитал оноосон нэрийг Ашид капитал болгон өөрчилж шийдвэрлэсэн бөгөөд тус оноосон нэрийн өөрчлөлт нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд 2016 оны 09 сарын 30-ны өдөр бүртгэгдсэн байна.

Хувьцаа эзэмшигчийн 2020 оны 01 сарын 08-ны өдрийн №20/01 тоот шийдвэрээр Ашид капитал ХХК-ийн нийт зарласан болон гаргасан хувьцааны 100 (нэг зуун) хувийг М-Си-Эс Холдинг ХХК-д Хувьцаа худалдах, худалдах авах гэрээний дагуу шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна. М-Си-Эс Холдинг ХХК-ийн Захирлуудын зөвлөлийн 2020 оны 01 сарын 08-ны өдрийн №01 тоот тогтоолоор Ашид капитал ХХК-ийн нийт зарласан болон гаргасан хувьцааны 100 (нэг зуун) хувийг Хувьцаа худалдах, худалдах авах гэрээний дагуу нэрлэсэн үнээр худалдаж авахыг М-Си-Эс Холдинг ХХК-д зөвшөөрч шийдвэрлэсэн байна. Ингэснээр хувьцаа эзэмшигч М-Си-Эс Холдинг ХХК-ийн хувьд 2020 оны 01 сарын 10-ны өдөр Ашид капитал ХХК-ийн хувьцаа эзэмшигчээр улсын бүртгэлд бүртгүүлсэн байгааг лавлагаанд тусгасан байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон Зөвшөөрлийн тухай хуульд Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авснаар банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхээр заасны дагуу Ашид капитал ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын эрхийг хэрэгжүүлэгч М-Си-Эс Холдинг ХХК-ийн Захирлуудын зөвлөлийн 2020 оны 01 сарын 29-ний өдрийн №03 тоот тогтоолоор банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхээр шийдвэрлэсэн.

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 02 сарын 12-ны өдрийн №68 тоот тогтоолоор Ашид капитал ХХК-д банк бус санхүүгийн зээл, факторингийн үйлчилгээ, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, 2022 оны 09 сарын 21-ний өдрийн №456 тоот тогтоолоор богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх болон 2023 оны 05 сарын 12-ны өдрийн №155 тоот тогтоолоор итгэлцлийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг тус тус олгосон байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 08 сарын 16-ны өдрийн №9/3212 тоот Хариу хүргүүлэх тухай албан бичгээс үзвэл Ашид капитал ББСБ ХХК-д Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны №68 тоот тогтоолоор банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бөгөөд 2023 оны 07 сарын 31-ний өдрийн байдлаар 1 хувьцаа эзэмшигч (М Си Эс Холдинг ХХК)-тэй, 55,000,000,000 (тавин таван тэрбум) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, банк бус санхүүгийн зээл, факторинг, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэйгөөр Санхүүгийн зохицуулах хорооны хяналт, зохицуулалтад үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тус Ашид капитал ББСБ ХХК-д холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн, захиргааны хариуцлага хүлээлгэсэн талаарх мэдээлэл Санхүүгийн зохицуулах хорооны мэдээллийн санд бүртгэгдээгүй, сар, улирал бүхийн тайлан, мэдээг хугацаанд нь бүрэн ирүүлж, Ашид капитал ББСБ ХХК-ийн хангаж ажиллавал зохих зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажиллаж байгаа болохыг тодорхойлсон байна. Мөн Ашид капитал ББСБ ХХК нь Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний агуулгыг тогтмол ирүүлдэг бөгөөд 2023 оны хагас жилийн байдлаар эрсдэлээр "бага" буюу 2.84 гэж үнэлэгдсэн болохыг тодорхойлсон байна.

Иймд дурдсан хуулийн зохицуулалт, баримт материалын хүрээнд Хуулийн фирм нь Ашид капитал ББСБ ХХК-ийг хуульд тогтоомжид нийцүүлэн үүсгэн байгуулж, хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн бөгөөд хуулиар зөвшөөрөл олгох бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан эрх бүхий этгээд Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр банк бус санхүүгийн үйл ажиллагааг эрхэлж байна гэж Хуулийн фирмээс дүгнэлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 12 сарын 27-ны өдрийн №441 тоот Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, үе шаттай нэмэгдүүлэх



2023.08.18

Нүүц баримт
Эх хувь

хуваарийг шинэчлэн батлах тухай тогтоолоор Ашид капитал ББСБ ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг банк бус санхүүгийн гадаад валютын үйл ажиллагааг дагнан эрхлэхээс бусад банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг Улаанбаатар хотод 2,500,000,000 (хоёр тэрбум таван зуун сая төгрөг)-өөр тогтоосон бөгөөд 2023 оны 02 сарын 10-ны өдрөөс эхлэн Улаанбаатар хотод 2,500,000,000 (хоёр тэрбум таван зуун) төгрөгөөр нэмэгдүүлж 5,000,000,000 (таван тэрбум) байхаар тогтоож шийдвэрлэсэн.

Хувьцаа эзэмшигч М-Си-Эс Холдинг ХХК-ийн зүгээс Ашид капитал ББСБ ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийг тухай бүр нэмэгдүүлж ажилласан байх бөгөөд энэхүү Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар 55,000,000,000 (тавин таван тэрбум) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байх тул дээр дурдсан журмын зохицуулалтыг шаардлагыг хангаж байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Ашид капитал ББСБ ХХК-ийн дүрмээс үзвэл нэг бүр нь 1,000 (нэг мянган) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 55,000,000 (тавин таван сая) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх нийт 55,000,000,000 (тавин таван тэрбум) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй бөгөөд Ашид капитал ББСБ ХХК-ийн гаргасан хувьцааны 100 (нэг зуун) хувийг М-Си-Эс Холдинг ХХК эзэмшиж байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн 2023 оны 08 сарын 14-ны өдрийн №23280002003935 тоот Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаанаас үзвэл Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ нь нэг бүр нь 1,000 (нэг мянган) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 55,000,000 (тавин таван сая) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх нийт 55,000,000,000 (тавин таван тэрбум) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй бөгөөд дараах 1 (нэг) хувьцаа эзэмшигчийн эзэмшилд байна. Үүнд:

Хүснэгт №01. Ашид капитал ББСБ ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн бүтэц.

№	Хувьцаа эзэмшигч	Нэгж хувьцааны үнэ (төгрөгөөр)	Хувьцааны тоо (ширхэгээр)	Нийт дүн (төгрөгөөр)	Хувь хэмжээ
1.	М-Си-Эс Холдинг ХХК	1,000	55,000,000	55,000,000,000	100.00%
	НИЙТ	1,000	55,000,000	55,000,000,000	100.00%

Ашид капитал ББСБ ХХК-ийн оршин байгаа газрын хувьд Компанийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт⁷ заасны дагуу түүний ерөнхий захиргаа байршиж байгаа газраар тодорхойлогдох бөгөөд ББСБ-ын хаягийн өөрчлөлтийг бүртгэх байгууллагад бүртгүүлэх хуулийн зохицуулалттай. Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн одоогийн оршин байгаа газар буюу үйл ажиллагаа эрхлэн явуулах албан ёсны хаягийн хувьд Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сентрал Тауэр, 15 давхар хаягаар хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн байна.

Үнэт цаас гаргагчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд буюу Гүйцэтгэх захирлаар Монгол Улсын иргэн П.Батжаргал улсын бүртгэлд бүртгэлтэй байна. Ашид капитал ББСБ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 09 сарын 19-ний өдрийн №04 тоот шийдвэрээр П.Батжаргалыг ББСБ-ын Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдсон бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 09 сарын 27-ны өдрийн №ЦМ-7/142 тоот албан бичгээр Гүйцэтгэх захирал П.Батжаргалыг эрх бүхий албан тушаалтнаар бүртгэсэн тухай мэдэгдэж, тус мэдэгдлийн дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэлд 2022 оны 10 сарын 11-ний өдөр бүртгэгдсэн байна.

Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК нь холбогдох хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж, хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн бөгөөд хувь

⁷ Компанийн тухай хууль (2011).


10 Дугаар зүйл Компанийн оноосон нэр, оршин байгаа газар

10.4 Компанийн оршин байгаа газар, шуудангийн хаягийг түүний ерөнхий захиргаа байршин байгаа газраар тодорхойлно.

10.5 Компанийн хаягийн өөрчлөлтийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.



2023.08.18



Нүүц баримт
Эх хувь

нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон шалгуурыг хангаж байна гэж дүгнэлээ.

Үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх асуудлын тухайд авч үзвэл:

Үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх асуудлын хувьд Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрхийг хэрэгжүүлэгч М-Си-Эс Холдинг ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 05 сарын 12-ны өдрийн №024 тоот Үнэт цаас гаргах ерөнхий зөвшөөрлийг охин компанид олгох тухай тогтоолоор Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авсан байгууллагаар санхүүгийн чадавхын зэрэглэл тогтоолгож, 2023 онд нийт 55,000,000,000 (тавин таван тэрбум) төгрөг хүртэлх дүнгээр үнэт цаас гаргах ерөнхий зөвшөөрлийг Ашид капитал ББСБ ХХК-д олгож, тус тогтоолтой холбогдуулан Ашид капитал ББСБ ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолд хувьцаа эзэмшигч М-Си-Эс Холдинг ХХК-ийг төлөөлж гарын үсэг зурх эрхийг Гүйцэтгэх захирал Л.Гантөмөрт олгож шийдвэрлэсэн байна. Улмаар Ашид капитал ББСБ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 05 сарын 12-ны өдрийн №03 тоот Үнэт цаас гаргах ерөнхий зөвшөөрлийг охин компанид олгох тухай шийдвэрээр Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авсан байгууллагаар санхүүгийн чадавхын зэрэглэл тогтоолгож, 2023 онд нийт 55,000,000,000 (тавин таван тэрбум) төгрөг хүртэлх дүнгээр үнэт цаас гаргах ерөнхий зөвшөөрлийг Ашид капитал ББСБ ХХК-д олгож шийдвэрлэсэн байна.

Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрхийг хэрэгжүүлэгч М-Си-Эс Холдинг ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 05 сарын 12-ны өдрийн №024 тогтоолын үндэслэлийг дүгнэж үзвэл Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалтад "төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал", Ашид капитал ББСБ ХХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт "Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрхийг компанийн хувьцаа эзэмшигч болох М-Си-Эс Холдинг ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл эдэлнэ" гэж заасныг тус тус үндэслэн Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрхийг хэрэгжүүлэгч М-Си-Эс Холдинг ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс шийдвэрлэсэн байх тул үнэт цаас гаргах шийдвэр нь Компанийн тухай хуульд нийцсэн байна гэж үзлээ.

Дээрх тогтоол, шийдвэртэй холбогдуулан Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 05 сарын 12-ны өдрийн №04 тоот Өрийн бичиг гаргах тухай шийдвэрээр нэг бүр нь 100,000 (нэг зуун мянган) төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 200,00 (хоёр зуун мянган) ширхэг нийт 20,000,000,000 (хорин тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий, 12 (арван хоёр) сарын хугацаатай, жилийн 18 (арван найман) хувийн хүүтэй, улирал тутамд хүү төлөгдөх давтамжтай өрийн бичиг гарган Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд санал болгосон болохыг дурдаж байна.

Улмаар дээр дурдсан тогтоол, шийдвэртэй холбогдуулан Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрхийг хэрэгжүүлэгч М-Си-Эс Холдинг ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 08 сарын 14-ний өдрийн №040 тоот Өрийн бичиг гаргахыг охин компанид зөвшөөрөх тухай тогтоолоор нэг бүр нь 100,000 (нэг зуун мянган) төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 150,000 (нэг зуун тавин мянган) ширхэг нийт 15,000,000,000 (арван таван тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий, 12 (арван хоёр) сарын хугацаатай, жилийн 17.5 (арван долоо арван таван) хувийн хүүтэй, сар тутамд хүү төлөгдөх давтамжтай өрийн бичиг гарган Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд санал болгон нээлттэй арилжих, хөрөнгө татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн байна. Түүнчлэн Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 08 сарын 14-ний өдрийн №05 тоот Өрийн бичиг гаргах тухай шийдвэрээр нэг бүр нь 100,000 (нэг зуун мянган) төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 150,000 (нэг зуун тавин мянган) ширхэг нийт 15,000,000,000 (арван таван тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий, 12 (арван хоёр) сарын хугацаатай, жилийн 17.5 (арван долоо арван таван) хувийн хүүтэй, сар тутамд



Нүүц баримт
Эх хувь

хүү төлөгдөх давтамжтай өрийн бичиг гарган Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд санал болгон нээлттэй арилжих, хөрөнгө татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Компанийн тухай хуулийн зохицуулалтын дагуу² компани өөрийн хөрөнгийн хэмжээгээр барьцаалан тодорхой хугацааны дараа тогтоосон хүү төлж, эргүүлэн худалдаж авах нөхцөлтэйгөөр өрийн бичиг гаргаж болохоор зохицуулсан байдаг бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны №226 тоот тогтоолоор батлагдсан Өрийн хэрэгслийн бүртгэлийн журмаар³ Үнэт цаас гаргагч нь дотоодын эсхүл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаар санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгосон бол үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгож эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийг барьцаалахгүй байж болохоор нарийвчлан зохицуулсан. Түүнчлэн Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар¹⁰ Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржээс тогтоосон шалгуурыг хангасан компани нийтэд санал болгон өрийн хэрэгсэл гаргаж болохыг зөвшөөрч зохицуулсан байна.

Иймд Үнэт цаас гаргагч нь хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журамд нийцүүлэн дотоодын эсхүл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаар санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгосон бол үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгож эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийг барьцаалахгүйгээр өрийн бичиг гаргах боломжтой бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлсэн нөхцөлд үнэт цаасны анхдагч зах зээл дээр олон нийтэд нээлттэй санал болгож хөрөнгө татан төвлөрүүлэх боломжтой байна.

Компанийн тухай хуулийн холбогдох зохицуулалтын дагуу компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, компанийн дүрэмд заасан бусад төрлийн үнэт цаас болон өрийн бичиг гаргах тухай шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл гаргах¹¹

² Компанийн тухай хууль (2011).

41 дүгээр зүйл. Компанийн өрийн бичиг

41.1 Компани өөрийн хөрөнгийн хэмжээгээр барьцаалан тодорхой хугацааны дараа тогтоосон хүү төлж, эргүүлэн худалдаж авах нөхцөлтэйгөөр өрийн бичиг гаргаж болно.

41.2 Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 41.1-д заасны дагуу өрийн бичиг гаргах шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ гаргана.

41.3 Энэ хуулийн 41.2-т заасан шийдвэрт өрийн бичгийн хэмжээ, төрөл, хугацаа, гаргасан үнэ, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, эргүүлэн худалдаж авах үнэ, бусад мэдээллийг заана.

41.4 Компани нь нэг удаа бүрэн төлөгдөх, эсхүл хэсэгчлэн төлөгдөх өрийн бичиг гаргаж болно.

41.5 Компанийн өрийн бичиг нь өөр компаниас тусгайлан гаргасан баталгаатай байж болно.

41.6 Өрийн бичиг гаргах шийдвэрт заасан бол компани гаргасан өрийн бичгээ төлөгдөх хугацаанаас нь өмнө эргүүлэн худалдаж авч болно.

41.7 Энэ хуулийн 41.6-д заасны дагуу өрийн бичгийг эргүүлэн худалдаж авах шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ гаргана.

³ Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам. СЗХ (2021).

Хöөр Нийтэд санал болгон бонд гаргагчид тавигдах шаардлага

2.8 Бонд гаргагч нь дотоодын эсхүл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаар санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгосон бол үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгож эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийг барьцаалахгүй байж болно.

¹⁰ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль (2013).

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1 Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.9 "өрийн хэрэгсэл" гэж үнэт цаас гаргагчаас тогтоосон хугацаа дуусмагц үндсэн төлбөр болон хүүг мөнгөн хэлбэрээр, эсхүл тодорхой эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр тухайн үнэт цаасыг эзэмшигчид эргүүлэн төлөх үүргийг гэрчилсэн болон түүнтэй адилтгах бусад үнэт цаасыг;

15 дугаар зүйл. Компанийн өрийн хэрэгсэл

15.1 Санхүүгийн зохицуулах хороо болон хөрөнгийн биржээс тогтоосон шалгуурыг хангасан компани нийтэд санал болгон өрийн хэрэгсэл гаргаж болно.

15.2 Компанийн нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийг бүртгэх журмыг Хороо тогтооно.

15.3 Компанийн нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгсэл нь үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаатай байж болно.

15.4 Компанийн нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийн үнийн дүн нь тухайн компанийн өөрийн хөрөнгийн хэмжээнээс илүүгүй байх ба гуравдагч этгээдийн баталгаатай гаргаж байгаа нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийн үнийн дүн нь тухайн компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ болон гуравдагч этгээдийн гаргасан баталгааны нийлбэр дүнгээс илүүгүй байна.

¹¹ Компанийн тухай хууль (2011).

42 дугаар зүйл. Үнэт цаас гаргах тухай шийдвэр

42.1 Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, компанийн дүрэмд заасан бусад төрлийн үнэт цаас болон өрийн бичиг гаргах тухай шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ гаргах бөгөөд уг шийдвэрт үнэт цаасны төрөл, төс, гаргах хугацаа, нөхцөлийг заана.



2023.08.18



Нүүд баримт
Эх хувь

зохицуулалттай байна. Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн дүрмийн холбогдох зохицуулалтаас үзвэл үнэт цаас гаргах эрх Төлөөлөн удирдах зөвлөлд олгогдоогүй байна. Иймд хуулийн зохицуулалтын дагуу үнэт цаас гаргах шийдвэр нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарахаар зохицуулсан байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 05 сарын 12-ны өдрийн №04 тоот Өрийн бичиг гаргах тухай шийдвэрийн үндэслэлийг дүгнэж үзвэл Компанийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт “Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 41.1-д заасны дагуу өрийн бичиг гаргах шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал) гаргана”, 41.3 дахь хэсэгт “энэ хуулийн 41.2-т заасан шийдвэрт өрийн бичгийн хэмжээ, төрөл, хугацаа, гаргасан үнэ, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, эргүүлэн худалдаж авах үнэ, бусад мэдээллийг заана”, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт “Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, компанийн дүрэмд заасан бусад төрлийн үнэт цаас болон өрийн бичиг гаргах тухай шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал) гаргах бөгөөд уг шийдвэрт үнэт цаасны төрөл, тоо, гаргах хугацаа, нөхцөлийг заана”, 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт “төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал”, 62.1.16 дахь заалт “энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудал”, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт “Энэ хуулийн зохицуулалтад хамрагдах үнэт цаасанд дараах санхүүгийн хэрэгсэл хамаарна: компанийн өрийн хэрэгсэл”, 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт “Үнэт цаасыг нийтэд санал болгон, эсхүл нийтэд санал болгохгүйгээр хаалттай хүрээнд худалдахаар гаргаж болно”, 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалт “Санхүүгийн зохицуулах хороо болон хөрөнгийн биржээс тогтоосон шалгуурыг хангасан компани нийтэд санал болгон өрийн хэрэгсэл гаргаж болно”, Ашид капитал ББСБ ХХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг “Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрхийг компанийн хувьцаа эзэмшигч болох М-Си-Эс Холдинг ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл эдэлнэ”, Компанийн хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч М-Си-Эс Холдинг ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 05 сарын 12-ны өдрийн №024 тоот тогтоол болон Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 05 сарын 12-ны өдрийн №03 тоот Үнэт цаас гаргах ерөнхий зөвшөөрлийг охин компанид олгох тухай тогтоолыг тус тус тусгасан нь өрийн бичиг гаргах эрх нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах тул Ашид капитал ББСБ ХХК-ийг өрийн бичиг гарган биржээр дамжуулан нийтэд санал болгох шийдвэрийг холбогдох хуулийн дагуу гарсан байна гэж дүгнэлээ.

Мөн тус шийдвэрээр өрийн бичиг гаргах нөхцөлийг баталсан бөгөөд тус нөхцөлд үнэт цаасны төрөл, өрийн бичгийн тоо, ширхэг, нэрлэсэн үнэ, хугацаа, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, давтамж, татан төвлөрүүлэх хөрөнгийн зориулалт зэргийг тусгасан нь Компанийн тухай хуульд заасан өрийн бичиг гаргах шийдвэрт тусгавал зохих зүйлийг тусгасан, Компанийн эрх барих дээд байгууллага бүрэн эрхийн хүрээнд гаргасан шийдвэр байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны №226 тоот тогтоолоор батлагдсан Өрийн хэрэгслийн бүртгэлийн журмын 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтад¹² Үнэт цаас гаргагч нь

42.2 Компани зарласан энгийн хувьцааг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг нь гаргах үүрэгтэй.
42.3 Компани давуу эрхийн хувьцааг зарласан хэмжээгээр нь, эсхүл зарим хэсгийг нь гаргаж болохоос гадна тодорхой хугацаанд гаргахгүй байж болно.
42.4 Компани нийтэд худалдахаар гаргаж байгаа үнэт цаас болон хувьцаат компанийн нэмж гарган байгаа хувьцааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлнэ.
¹² Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам. СЗХ (2021).
Хоёр.Нийтэд санал болгон бонд гаргагчид тавигдах шаардлага
2.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга бонд гаргахад Өрийн үндэслэлийн тухай хуульд заасан шаардлагыг бусад бонд гаргагч нь дараах шалгуур үндэслэлийг тус тус бүрэн хангасан байна
/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 68 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/
1 1.1 Хаялттай хувьцаат компани, эсхүл хязгаарлагдмал хариуцагатай компани хэлбэртэй бол гурваас доошгүй жилийн өмнө үүсгэн байгуулагдсан, Хороонд хүсэлт гаргахаас өмнө сүүлийн гурван жилд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх.
2 1.2 Санхүүгийн зохицуулах хороонд хүсэлт гаргах үед эзэл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа итгэрсэн болон шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өө төлбөргүй байх.



Нууц баримт
Эх хувь

хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэртэй бол гурваас доошгүй жилийн өмнө үүсгэн байгуулагдсан, Санхүүгийн зохицуулах хороонд хүсэлт гаргахаас өмнөх сүүлийн гурван жилд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх бөгөөд хүсэлт гаргах үед зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн болон шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй байх, хөрөнгө оруулагчдын өмнө хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлдэг байх шаардлагыг хангасан байхыг журамласан. Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 08 сарын 15-ны өдрийн №01/3403 тоот Батламж хүргүүлэх тухай албан бичиг болон төрийн эрх бүхий байгууллагын лавлагаанд үндэслэн Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК нь Өрийн хэрэгслийн бүртгэлийн журамд тусгасан нийтэд санал болгон өрийн бичиг гаргагчид тавигдсан шаардлагыг хангаж байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Нэгтгэн дүгнэж үзвэл Ашид капитал ББСБ ХХК-ийн нээлттэй өрийн бичиг гаргах шийдвэр нь Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Өрийн хэрэгслийн бүртгэлийн журмын дагуу гарсан бөгөөд Үнэт цаас гаргагч нь Санхүүгийн зохицуулах хорооноос нийтэд санал болгон өрийн бичиг гаргагчид тавьсан шалгуур, шаардлагыг хангаж байна гэж дүгнэлээ.

Хоёр. Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекст заасан шаардлага хангаж байгаа эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын байдал болон эрх бүхий албан тушаалтан нь тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлага хангаж байгаа эсэх асуудлын хувьд үзвэл:

Хуулийн фирм нь тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекст заасан шаардлага хангасан эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлага болон тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлага хангаж буй эсэхэд Компаниас ирүүлсэн баримт материал болон Санхүүгийн зохицуулах хорооны лавлагаанд үндэслэн дүн шинжилгээ хийлээ.

Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн хувьцаа эзэмшигч М-Си-Эс Холдинг ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2023 оны 03 сарын 09-ний өдрийн №03 тоот тушаалаар Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Б.Билигүүн, Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Г.Мягмаржав, Л.Гантөмөр, Б.Тэмүүлэн, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бүс гишүүнээр Д.Баярсайхан нарыг тус тус сонгож шийдвэрлэсэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөл

Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн зохицуулалтын хүрээнд үзвэл хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл¹³ байх бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог компанийн дүрмээр тогтооно¹⁴, компанийн дүрэмд заасан бол хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төлөөлөн удирдах зөвлөл хараат бүс гишүүнтэй байж болно¹⁵, компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн

2.1.3.хөрөнгө оруулагчдын өмнө хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлдэг байх.

¹³ Компанийн тухай хууль (2011).

75 дугаар зүйл Төлөөлөн удирдах зөвлөл

75.1.Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байна.

¹⁴ Компанийн тухай хууль (2011).

75 дугаар зүйл Төлөөлөн удирдах зөвлөл

75.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог компанийн дүрмээр тогтооно.

¹⁵ Компанийн тухай хууль (2011).

75 дугаар зүйл Төлөөлөн удирдах зөвлөл


75.5.Компанийн дүрэмд заасан бол хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төлөөлөн удирдах зөвлөл хараат бүс гишүүнтэй байж болно.



Handwritten signature



2023.08.18



Нүүц Баримт
Эх хувь

хугацаа дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хүрал хүралдах өдрөөр дуусгавар болох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг улируулан сонгож болно¹⁵, компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос нийт гишүүний олонхын саналаар сонгоно¹⁷, нэг буюу түүнээс дээш хараат бус, нийт 5 (тав)-аас доошгүй гишүүн бүхий төлөөлөн удирдах зөвлөлтэй байна¹⁸ гэж нарийвчлан зохицуулсан.

Хуулийн зохицуулалтын дагуу авч үзвэл Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт "Хувьцаа эзэмшигчдийн хүрлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага нь Ашид капитал ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл байна. Хувьцаа эзэмшигчдийн хүрлын эрхийг эдлэх "М-Си-Эс Холдинг ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Төлөөлөн удирдах зөвлөлийг 5 (тав) хүртэл гишүүнтэйгээр томилно" гэж заасан бөгөөд ББСБ-ын Дүрмийн зохицуулалт нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна гэж үзэх үндэслэлтэй байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний хувьд авч үзвэл энэхүү Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Ашид капитал ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

Хүснэгт №02. Ашид капитал ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн.

№	Овог, нэр	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн төлөв	СЗХ-ны зөвшөөрлийн огноо, дугаар	Томилсон тогтоолын дугаар
1.	Б.Билигүүн	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга	2022.03.18 №7/1039	№03
2.	Г.Мягмаржав	Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн	2022.03.18 №7/1039	№03
3.	Л.Гантөмөр	Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн	2022.03.18 №7/1039	№03
4.	Б.Тэмүүлэн	Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн	2023.03.27 №ЦМ-7/053	№03
5.	Д.Баярсайхан	Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн	2023.03.27 №ЦМ-7/053	№03

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга


Б.Билигүүн нь М-Си-Эс Инвестмент ХХК-ийн Гүйцэтгэх дэд ерөнхийлөгч бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хүрлын 2023 оны 03 сарын 09-ний өдрийн №03 тоот тогтоолоор Ашид капитал ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар томилогдсон. Тэрээр МУИС-ийн Физик, электроникийн сургуулийг Электроникийн инженер мэргэжлээр бакалавр, Америкийн Нэгдсэн Улсын Техасын их сургуулийг Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй тус тус төгссөн. Б.Билигүүн нь М-Си-Эс Интернэйшнл ХХК-д Инженер, М-Си-Эс Электроникс ХХК-д Бизнес менежер, Юнител ХХК-д Дэд захирал, Анунгоо ХХК-д Гүйцэтгэх захирал, М-Си-Эс Групп ХХК-д Дэд ерөнхийлөгчөөр тус тус ажиллаж байсан. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Билигүүн нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын

¹⁵ Компанийн тухай хууль (2011).
¹⁷ 77 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох
¹⁸ 77.2.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хүрал хүралдах өдрөөр дуусгавар болох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг улируулан сонгож болно.
¹⁷ Компанийн тухай хууль (2011).
¹⁸ 78 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга
¹⁹ 78.1.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос нийт гишүүний олонхын саналаар сонгоно.
²⁰ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулах журам (2016).
Хөр.Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага
2.14.1 нэг буюу түүнээс дээш тэмдэг хараат бус, нийт 5-аас доошгүй гишүүн бүхий төлөөлөн удирдах зөвлөлтэй байх.





simple



Нүүц баримт
Эх хувь

сургалтад 2021 оны 08 сард хамрагдаж №0131666 дугаартай гэрчилгээ авсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 сарын 18-ны өдрийн №7/1039 тоот тушаалаар Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн эрх бүхий албан тушаалтнаар бүртгэгдсэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүд

Г.Мягмаржав нь М-Си-Эс Инвестмент ХХК-ийн Гүйцэтгэх захирал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 03 сарын 09-ний өдрийн №03 тоот тогтоолоор Ашид капитал ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон. Тэрээр ШУТИС, Компьютерын техник, менежментийн сургуулийг Санхүүгийн удирдлагын бакалавр, Америкийн Нэгдсэн Улсын Диврай их сургуулийг Санхүүгийн удирдлагын магистр зэрэгтэй тус тус төгссөн. Г.Мягмаржав нь Анун ХХК-д Санхүүгийн шинжээч, М-Си-Эс Холдинг ХХК-д Санхүүгийн менежер, Монголиан Майнинг Корпораци ХХК-д Санхүүгийн менежер, Гоёо ХХК-д Дэд захирал, Юнител ХХК-д Дэд ерөнхийлөгч, Санхүү эрхэлсэн захирал, М-Си-Эс Венчерс ХХК-д Гүйцэтгэх захирлаар тус тус ажиллаж байсан. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Г.Мягмаржав нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад 2021 оны 08 сард хамрагдаж №0131654 дугаартай гэрчилгээ авсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2022 оны 03 сарын 18-ны өдрийн №7/1039 тоот тушаалаар Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн эрх бүхий албан тушаалтнаар бүртгэгдсэн байна.

Л.Гантөмөр нь М-Си-Эс Холдинг ХХК-ийн Гүйцэтгэх захирал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 03 сарын 09-ний өдрийн №03 тоот тогтоолоор Ашид капитал ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон. Тэрээр Оросын Холбооны Улсын Москва хотын удирдлагын академийг Инженер-Эдийн засагч мэргэжлээр бакалавр, ШУТИС-ийн Компьютерын техник, менежментийн сургуулийг Бизнесийн удирдлага мэргэжлээр бакалавр, Нидерландын Вант Улсын Маастрихтийн менежментийн сургуулийг Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэйгээр тус тус төгссөн. Л.Гантөмөр нь Проктер энд Гэмбл Истерн Европ Инк компанид Улс хариуцсан мэргэжилтэн, Проктер энд Гэмбл Казакстан компанид Дистрибьюторын үйл ажиллагаа хариуцсан менежер, М-Си-Эс Кока-Кола ХХК-д Гүйцэтгэх захирал, М-Си-Эс Групп ХХК-д Дэд ерөнхийлөгчөөр тус тус ажиллаж байсан. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Л.Гантөмөр нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад 2010 оны 06 сард хамрагдаж гэрчилгээ авсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2022 оны 03 сарын 18-ны өдрийн №7/1039 тоот тушаалаар Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн эрх бүхий албан тушаалтнаар бүртгэгдсэн байна.

Б.Тэмүүлэн нь М Банкны Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 03 сарын 09-ний өдрийн №03 тоот тогтоолоор Ашид капитал ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон. Тэрээр Швед Улсын Ионшопин олон улсын бизнесийн дээд сургуулийг Бизнесийн удирдлагын бакалавр, Күйн Мэригийн их сургуулийг Банк, санхүүгийн магистр зэрэгтэй тус тус төгссөн. Б.Тэмүүлэн нь Энержи Ресурс ХХК-д Санхүүгийн шинжээч, М-Си-Эс Металс ХХК-д Бизнес хөгжлийн менежер, М-Си-Эс Холдинг ХХК-д Хөрөнгө оруулалтын ахлах менежер, М ХХК-д Судалгаа хөгжүүлэлт, бизнес хөгжлийн албаны дарга, Ашид капитал ББСБ ХХК-д Гүйцэтгэх захирлаар тус тус ажиллаж байсан. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Б.Тэмүүлэн нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад 2022 оны 04 сард хамрагдаж №0430928 дугаартай гэрчилгээ авсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны 03 сарын 27-ны өдрийн №ЦМ-7/053 тоот тушаалаар Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн эрх бүхий албан тушаалтнаар бүртгэгдсэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн


Д.Баярсайхан нь Лонг Терм Партнерс оф Монголиа ХХК-ийн Гүйцэтгэх захирал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 03 сарын 09-ний өдрийн №03 тоот тогтоолоор Ашид



Handwritten signature



2023.08.18



Нууц баримт
Эх хувь

капитал ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгогдсон байна. Тэрээр МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг Олон улсын худалдааны бакалавр, Хитофцбаши их сургуулийг эдийн засгийн бакалавр, Токиогийн их сургуулийг эдийн засгийн магистр зэрэгтэйгээр тус тус төгссөн. Д.Баярсайхан нь Доёчэ Секюритис компанид Хувьцааны дилер, Дэлхийн банк, санхүүгийн олон улсын корпорацад Хөрөнгө оруулалтын мэргэжилтнээр тус тус ажиллаж байсан. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Д.Баярсайхан нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад 2017 оны 04 сард хамрагдаж №0130761 дугаартай гэрчилгээ авсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны 03 сарын 27-ны өдрийн №ЦМ-7/053 тоот тушаалаар Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн эрх бүхий албан тушаалтнаар бүртгэгдсэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1 дэх хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно" гэж хуульчилсан хэдий ч Санхүүгийн зохицуулах хорооны Компанийн засаглалын кодекст банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ эрхэлдэг компани тус Компанийн засаглалын кодексийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөхийг үүрэг болгож зохицуулсан. Компанийн засаглалын кодексийн Засаглалын зарчмын 2 дугаар зэрчимд "Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагаагаа тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг өөрөө хүлээнэ" гэж заасан.

Ашид капитал ББСБ ХХК-ийн Хуулийн фирмд ирүүлсэн баримт, материалаас авч үзвэл Төлөөлөн удирдах зөвлөл нь тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодгүй байна. Иймд Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 05 сарын 12-ны өдрийн №155 тоот тогтоолоор итгэлцлийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авсан тул Компанийн засаглалын кодекст заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодыг байгуулж, төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаагаа хороодоор дамжуулан хэрэгжүүлж ажиллахыг Хуулийн фирмийн зүгээс зөвлөж байна.

Эрх бүхий албан тушаалтан

Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1 дэх хэсэгт "Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шүүд болон шүүд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно" гэж хуульчилсан байдаг бөгөөд хуулийн этгээд өөрийн үүсгэн байгуулах баримт бичиг буюу дүрмээрээ илүү нарийвчлан тодорхойлох эсхүл албан тушаалаар нэр заан тодорхойлох боломжийг олгосон байдаг.

Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн дүрмээс үзвэл эрх бүхий албан тушаалтны талаар тодорхойлж тусгаагүй байна. Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн Хуулийн фирмд ирүүлсэн баримт материал, эрх бүхий албан тушаалтны мэдээлэлд үндэслэн дараах эрх бүхий албан тушаал буюу ажлын байр, орон тоо Ашид капитал ББСБ ХХК-ийн бүтцэд байна гэж үзлээ. Үүнд:

Хүснэгт №03. Эрх бүхий албан тушаалын ажлын байрны мэдээлэл.

№	Овог, нэр	Албан тушаал	Орон тоо
1.	П.Батжаргал	Гүйцэтгэх захирал	1
2.	Н.Эрдэнатунгалаг	Санхүү бүртгэлийн албаны дарга	1
3.	Г.Мөнхбаярсгалан	Санхүүгийн удирдлагын албаны дарга	1
4.	Б.Энхмэндэх	Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга	1



Нууц баримт
Эх хувь

Гүйцэтгэх удирдлага

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.3 дахь хэсэгт "Хувь хүн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлж байгаа тохиолдолд уг этгээд нь гүйцэтгэх захирал байна", Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэгт¹⁹ Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал дараах (i) зээлийн гэрээ буюу баталгаагаар хүлээсэн, хугацаа хэтэрсэн аливаа өргүй; (ii) ял шийтгэлгүй; (iii) ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь банк бус санхүүгийн байгууллагыг удирдахад харшлахгүй байх; болон (iv) банк, санхүүгийн мэргэжилтэй, тухайн салбарт ажилласан туршлагатай байх, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журмын 2 дугаар зүйлийн 2.11²⁰ дэх хэсэгт (v) Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооноос зохион байгуулсан сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх шалгуурыг тус тус хангахаар хуульчилсан.

Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт "Компанийн гүйцэтгэх удирдлагыг компанийн Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ", 7.2 дахь хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь Гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулан захирлын эрх, үүрэг, хариуцлагын хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэргийг тогтоож өгнө" гэж тусгасан байна.

Ашид капитал ББСБ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 09 сарын 19-ний өдрийн №04 тоот шийдвэрээр П.Батжаргалыг ББСБ-ын Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилсон байна. Улмаар Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 09 сарын 27-ны өдрийн №ЦМ-7/142 тоот албан бичгээр Гүйцэтгэх захирал П.Батжаргалыг эрх бүхий албан тушаалтнаар бүртгэсэн тухай мэдэгдэж, тус мэдэгдлийн дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэлд 2022 оны 10 сарын 11-ний өдөр бүртгэгдсэн байна.

Иймд Компанийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Ашид капитал ББСБ ХХК-ийн Дүрэм, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаа болон тэдгээрт холбогдох баримт материалд үндэслэн Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал П.Батжаргал хэрэгжүүлж байна гэж үзэх үндэслэлтэй байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журмын 2 дугаар зүйлийн 2.11 дэх хэсэгт "Тусгай зөвшөөрөл авснаас хойш 6 сарын хугацаанд банк бус санхүүгийн байгууллагын удирдлага нь Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооноос зохион байгуулсан сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна" гэж заасан. Ашид капитал ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирал П.Батжаргал нь 2022 оны 10 сард Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журамд заасан сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх тул тус журмын хэрэгжилтийг хангаж байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Бусад эрх бүхий албан тушаалтан

Ашид капитал ББСБ ХХК-ийн гаргаж өгсөн мэдээлэлд үндэслэж үзвэл эрх албан тушаал буюу ажлын байранд дараах элбан тушаалтнууд томилогдон ажиллаж байна. Үүнд:

§ Н.Эрдэнэтүнгалаг Ашид капитал ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 11 сарын 14-ний өдрийн №256/Б/22 тоот тушаалаар Ашид капитал ББСБ ХХК-ийн

¹⁹ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай (2002).
13 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлага
13.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал дараах шалгуурыг хангасан байна:
13.5.1 зээлийн гэрээ буюу баталгаагаар хүлээсэн, хугацаа хэтэрсэн аливаа өргүй;
13.5.2 ял шийтгэлгүй;
13.5.3 ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь банк бус санхүүгийн байгууллагыг удирдахад харшлахгүй байх.
13.6 Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн гүйцэтгэх удирдлага нь банк, санхүүгийн мэргэжилтэй, тухайн салбарт ажилласан туршлагатай байна.
²⁰ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулах журам (2016).
Хоёр Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага
2.11.Тусгай зөвшөөрөл авснаас хойш 6 сарын хугацаанд ББСБ-ын удирдлага нь Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооноос зохион байгуулсан сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна



2023.08.18



Нүүц баримт
Эх хувь

Санхүү бүртгэлийн албаны дарга албан тушаалд томилогдон ажиллаж байна.

§ Г.Мөнхбаясгалан

Ашид капитал ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 11 сарын 14-ний өдрийн №257/Б/22 тоот тушаалаар Ашид капитал ББСБ ХХК-ийн албан тушаалд томилогдон ажиллаж байна.

§ Б.Энхмандах

Ашид капитал ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 06 сарын 28-ны өдрийн №10 тоот тушаалаар Ашид капитал ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдон ажиллаж байна.

Хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хууль тогтоомжийн зохицуулалт болон Компанийн засаглалын кодексийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтанд тавигддаг шаардлагын хүрээнд Хуулийн фирм нь Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл, анкет, тэдгээрийн мэдлэг чадварыг тодорхойлох баримт материалыг гаргаж өгөхийг хүссэн. Хуулийн фирм нь Ашид капитал ББСБ ХХК-ийн ирүүлсэн баримт материалд үндэслэн Үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг дараах хүснэгтээр дэлгэрүүлэн авч үзлээ.

Хүснэгт №04. Ашид капитал ББСБ ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекст тавигдсан шаардлагыг хангасан эсэх мэдээлэл.

№	Эрх бүхий албан тушаал	Эрх бүхий албан тушаалтны нэрс	Компанийн тухай хууль				Компанийн засаглалын кодекс ТУЗ-ийн гишүүд нь КЗК 1.2-ийн Тэйлбар 1 хэсэгт заасан мэдээллийг шалгасан эсэх Тийм/Үгүй/ N/A*
			Компанийн засаглалын чиглэлээр сурталтад хамрагдан, гэрчилгээ авсан эсэх Тийм/Үгүй/ N/A*	Төрийн болон нутгийн захиргааны байгууллагад удирдах албан тушаал хашдаг эсэх Тийм/Үгүй	Ял шийтгэл эдэлж байгаа болон эдэлж байсан эсэх Тийм/Үгүй	ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх удирдлагыг хувь хүн хэрэгжүүлдэг эсэх Тийм/Үгүй/ N/A*	
Нэг. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд							
1.	ТУЗ-ийн дарга	Б.Билигүүн	Тийм	Үгүй	Үгүй	Тийм	Тийм
2.	ТУЗ-ийн гишүүн	Г.Мягмаржав	Тийм	Үгүй	Үгүй	Тийм	Тийм
3.	ТУЗ-ийн гишүүн	Л.Гантөмөр	Тийм	Үгүй	Үгүй	Тийм	Тийм
4.	ТУЗ-ийн гишүүн	Б.Тэмүүлэн	Тийм	Үгүй	Үгүй	Тийм	Тийм
5.	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Д.Баярсайхан	Тийм	Үгүй	Үгүй	Тийм	Тийм
Хоёр. Бусад эрх бүхий албан тушаалтан							
6.	Гүйцэтгэх захирал	П.Батжаргал	Тийм	Үгүй	Үгүй	N/A	N/A
7.	Санхүү бүртгэлийн албаны дарга	Н.Эрдэнэтүнгэлэг	N/A	Үгүй	Үгүй	N/A	N/A
8.	Санхүүгийн удирдлагын	Г.Мөнхбаясгалан	N/A	Үгүй	Үгүй	N/A	N/A



2023.08.18

Нүүц баримт
Эх хувь

9.	албаны дарга Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга	Б Энхмандах	Тийм	Үгүй	Үгүй	N/A	N/A
----	-----------------------------------------------------------------	-------------	------	------	------	-----	-----

*N/A Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодексийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэгч удирдлага болон эрх бүхий албан тушаалтанд тусгайлан тавигдсан шаардлагад үндэслэн шалгах шаардлагагүй гэж үзсэн этгээдийн харгалзах нүдэнд тус тэмдэглэгээг оруулсан болно. Хуулийн фирм.

Хүснэгт №05. Ашид капитал ББСБ ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу тавигдах шаардлага, Тохиромжтой этгээдийг тодорхойлох журмын шалгуурыг хангасан эсэх мэдээлэл.

№	Эрх бүхий албан тушаал	Эрх бүхий албан тушаалтны нэрс	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль		
			Зээлийн гэрээ бусуу баталгаагаар хүлээсэн, хугацаа хэтэрсэн аливаа өртэй эсэх Тийм/Үгүй/NA*	Ял шийтгэлтэй эсэх Тийм/Үгүй/NA*	Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь банк бус санхүүгийн байгууллыг удирдахад хариулах эсэх Тийм/Үгүй/NA*
Нэр: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд					
1.	ТУЗ-ийн дарга	Б.Билигүүн	Үгүй	Үгүй	Үгүй
2.	ТУЗ-ийн гишүүн	Г.Мягмаржав	Үгүй	Үгүй	Үгүй
3.	ТУЗ-ийн гишүүн	Л.Гантөмөр	Үгүй	Үгүй	Үгүй
4.	ТУЗ-ийн гишүүн	Б.Тэмүүлэн	Үгүй	Үгүй	Үгүй
5.	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Д.Баярсайхан	Үгүй	Үгүй	Үгүй
6.	Гүйцэтгэх захирал	П.Батжаргал	Үгүй	Үгүй	Үгүй
Хоёр. Бусад эрх бүхий албан тушаалтан					
7.	Санхүү бүртгэлийн албаны дарга	Н.Эрдэнэтүнгэлэг	Үгүй	Үгүй	Үгүй
8.	Санхүүгийн удирдлагын албаны дарга	Г.Мөнхбаясгалан	Үгүй	Үгүй	Үгүй
9.	Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга	Б.Энхмандах	Үгүй	Үгүй	Үгүй

Дээр дурдсан хүснэгт дэх мэдээлэл болон Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн баримт материалд үндэслэн Үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал болон эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж, журам болон Компанийн засаглалын кодекс, тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шалгуурыг хангасан эсэх асуудлыг дэлгэрүүлэн авч үзлээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх шаардлагыг Компанийн тухай хуулийн 75.8 дахь хэсэг²¹ заасан бөгөөд Ашид капитал ББСБ ХХК-аас Хуулийн фирмд ирүүлсэн компанийн засаглалын сургалтад хамрагдсан гэрчилгээнд үндэслэн Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд болон Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан бөгөөд холбогдох хууль, журмын шаардлагыг хангаж байна гэж үзлээ. Компанийн засаглалын кодексийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсгийн Тайлбар №1 дэх хэсэгт Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх этгээдийг сонгохдоо тэдгээрийн ёс зүй, зан суртахуун, ажлын


²¹ Компанийн тухай хууль (2011).

75 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөл

75.8. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.




2023.08.18



simple

Нүүц баримт
Эх хувь



туршлага, мэргэжлийн ур чадвар, боловсрол, гэмт хэрэг үйлдэж байсан эсэх, шүүхээр тогтоосон хугацаа хэтэрсэн зээлтэй эсэх талаарх мэдээллийг нэг бүрчлэн шалгасны үндсэн дээр томилно²² гэж заасан. Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээлэл болон Баталгаанд үндэслэн Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь Компанийн засаглалын кодекст заасан шалгуурыг хангаж байна гэж үзлээ.

Эрх бүхий албан тушаалтны хувьд Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.3 дахь хэсэгт²³ (i) хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаг; болон (ii) ял шийтгэл эдэлж байгаа этгээдийг Компанийн эрх бүхий албан тушаалд ажиллахыг хориглохоор хуульчилсан; Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэгт Банк бус санхүүгийн байгууллагын Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал нь (i) зээлийн гэрээ буюу баталгаагаар хүлээсэн, хугацаа хэтэрсэн аливаа өргүй; (ii) ял шийтгэлгүй болон; (iii) ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь банк бус санхүүгийн байгууллагыг удирдахад харшлахгүй байх шаардлагыг хангаж байх бөгөөд Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн эрх бүхий албан тушаалтны эрхэлж байгаа ажил, албан тушаал, анкет, баримт бичигт тусгагдсан мэдээлэл, эрх бүхий албан тушаалтнуудын гаргаж өгсөн дээрх хуулийн шаардлагыг хангаж байгаа тухай Баталгаанд үндэслэн Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, Гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнууд нь хуульд заасан шаардлагыг хангаж байна гэж үзлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 04 сарын 08-ны өдрийн №179 тоот тогтоолоор батлагдсан Тохиромжтой этгээдийг тодорхойлох журмын дагуу банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан²⁴, тохиромжтой этгээдийн шалгуурыг²⁵ хангасан нотлох баримтыг бүрдүүлж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж

²² Компанийн засаглалын кодекс. СЗХ (2022).

1.2. Тайлбар 1.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх этгээдийг сонгохдоо тэдгээрийн ёс зүй, зан суртахуун, ажлын туршлага, мэргэжлийн ур чадвар, боловсрол, гэмт хэрэг үйлдэж байсан эсэх, шүүхээр тогтоосон хугацаа хэтэрсэн зээлтэй эсэх талаарх мэдээллийг нэг бүрчлэн шалгана.

²³ Компанийн тухай хууль (2011).

84 дүгээр зүйл Компанийн эрх бүхий албан тушаалтан

84.3 Дараах этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалд ажиллахыг хориглоно:

84.3.1.хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаг;

84.3.2.ял шийтгэл эдэлж байгаа.

²⁴ Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам. СЗХ (2020).

Нэг.Нийтлэг үндэслэл

1.2. Санхүүгийн зохицуулах хороо дор дурдсан хувь хүн, хуулийн этгээдэд энэхүү журмын дагуу тохиромжтой этгээдийн шалгуурыг хангаж байгаа эсэхэд хяналт тавина. Үүнд:

1.2.1. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч, бүртгүүлээгээр хураалт гаргагч болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, бүртгэлтэй этгээд, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан, комплайнсын амилтан.

Дөрөв.Тохиромжтой этгээдийн шалгуур хангасан эсэхийг тодорхойлох баримт бичгийг бүрдүүлэх

4.1.Энэхүү журмын 1.2-т заасан этгээд өөрийн тохиромжтой этгээд болсноо нотлох баримтыг бүрдүүлнэ, Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэх үүрэгтэй.

²⁵ Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам. СЗХ (2020).

Хоёр.Тохиромжтой этгээдийн шалгуур

2.1. Санхүүгийн зохицуулах хороо дараах шалгууруудыг хангасан этгээдийг тохиромжтой этгээд гэж үзнэ. Үүнд:

2.1.2 Хувь хүнд дараах шалгуур тавигдана. Үүнд:

2.1.2.1 мэдлэг боловсрол, ажлын туршлагатай байх;
2.1.2.2 гэмт хэрэгт холбогдож байгаагүй байх;
2.1.2.3 ёс зүйн нэр хүндтэй байх;
2.1.2.4 ашиг сонирхлыг зөрчлөөс ангид байх;
2.1.2.5 хуульд заасан бусад.

Гурав.Тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан эсэхийг тодорхойлох

3.2.Энэхүү журмын 2.1.2-т заасан хувь хүнд тавигдах тавигдах шалгуурууд нь дараах байдалтай байна.


3.2.1.энэхүү журмын 2.1.2.1-д заасан "Мэдлэг боловсрол, ажлын туршлагатай байх" шалгуурыг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлно. түүнд: Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын хувьд:

3.2.1.1. төлөөлөн удирдах зөвлөл гүйцэтгэх удирдлага, салбарын удирдлага, эрх бүхий албан тушаалтан, комплайнсын амилтан зэрэг эрх бүхий албан тушаалд томилогдох этгээдүүд нь:

(Энэ заалтд Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 307 дугаар тогтоолоор нэмэлт өрүүлсэн.)

а) Банк, санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засаг, хууль, эрх зүйн болон Хорооноос хүлээн зөвшөөрөгдсөн бусад мэргэжлийн чиглэлээр их, дээд сургууль төгссөн байх;





Нууц баримт
Эх хувь

ажиллах үүрэгтэй. Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан Санхүү бүртгэлийн албаны дарга Н.Эрдэнэтунгалаг, Санхүүгийн удирдлагын албаны дарга Г.Мөнхбаясгалан, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Энхмэндах нар нь тохиромжтой этгээдийг тодорхойлж журамд заасан нотлох баримтаа 2023 оны 08 сарын 17-ны өдрийн №01/3514 тоот албан бичгээр Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн байна. Иймд Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-аас ирүүлсэн баримт материалд үндэслэн дүрдсэн эрх бүхий албан тушаалтныг тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг Хуулийн фирмээс тодорхойлох боломжгүй байгааг дурдаж байна. Үнэт цаас гаргагчийн энд тухайлан дүрдсанаас бусад эрх бүхий албан тушаалтнууд нь Санхүүгийн зохицуулах хорооноос бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр эрх бүхий албан тушаалтнаар томилогдсон байх тул тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан гэж үзэх үндэслэлтэй байна. Харин Санхүүгийн зохицуулах хорооноос бичгээр зөвшөөрөл аваагүй эрх бүхий албан тушаалтны хувьд тус журамд нарийвчлан тусгасан шалгуурыг хангаж байгаа талаарх нотлох баримтыг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж, бүртгүүлж, бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр Компанийн эрх бүхий албан тушаалтнаар томилж ажиллахыг Хуулийн фирмээс зөвлөж байна.

Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-аас Хуулийн фирмд ирүүлсэн баримт материал болон тохиромжтой этгээдийг тодорхойлох журмын дагуу тохиромжтой этгээд нь мэдлэг, боловсрол, ажлын туршлагатай байх шаардлагын дагуу Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл, анкет, баталгаанд үндэслэн Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтан нь санхүү, эдийн засаг, хууль эрх зүйн чиглэлээр мэргэшсэн бөгөөд эдгээр албан тушаалтан нь эрх бүхий албан тушаалтанд шаардагдах мэргэжлийн бсловсрол, хөдөлмөр эрхлэлтийн түүхтэй байна гэж Хуулийн фирмээс үзсэн болохыг дурдаж байна.


Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан нь тухайлан дүрдсанаас бусдаар холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекс болон Тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлагыг хангаж байна гэж үзлээ.

Цаашид Үнэт цаас гаргагчийг Санхүүгийн зохицуулах хорооноос бичгээр өгсөн зөвшөөрөлд үндэслэн эрх бүхий албан тушаалтныг томилох, томилсон эрх бүхий албан

- б) Тухайн албан тушаалд дүйцэхүйц албан тушаалд 1-ээс доошгүй жил ажилласан туршлагатай байх;
 - в) Санхүүгийн салбарт 2-аас доошгүй жил ажилласан байх.
- 3.2.2 Энэхүү журмын 2.1.2.2-т заасан "гэмт хэрэгт холбогдож байгаагүй байх" шалгуурыг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлно. Үүнд:
- 3.2.2.1. Эрүүгийн хуульд заасан болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига, хээл хахууль, эдийн засгийн гэмт хэрэг, зөрчилтэй холбоотойгоор Эрүүгийн хариуцлага, шийтгэл хүлээгээгүй байх;
 - 3.2.2.2. Эрүүгийн хуульд заасан болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига, хээл хахууль, эдийн засгийн гэмт хэрэг, зөрчилтэй холбогдон шалгагдах болон шүүх хуралд шүүгдэгчээр, хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын шатанд сэжиглэгдэж байгаа эсэх.
- 3.2.3 Энэхүү журмын 2.1.2.3-т заасан "эс зүйн нэр хүндтэй байх" шалгуурыг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлно. Үүнд:
- 3.2.3.1 сүүлийн 1 жилийн хугацаанд өөрийн буруутай үйлдлээс, салбарын эс зүйн хэм хэмжээг зөрчсөнөөс үүдэн ажлаас халагдах арга хэмжээ авч үзүүлээгүй байх;
 - 3.2.3.2 санхүүгийн болон санхүүгийн бүс үйлчилгээ, үйл ажиллагаатай холбоотой үүссэн гомдлын гол буруутан байсан эсэх;
 - 3.2.3.3 сүүлийн 1 жилийн хугацаанд салбарын эс зүйн хэм хэмжээг зөрчөөгүй байх;
 - 3.2.3.4. Монгол Улс болон гадаад улсын нутаг дэвсгэрт хууль, журам, бизнесийн эс зүй, дүрмийг зөрчсөн эсэх бусдад энэхүү үйлдлийг хийхэд тусалсан хэрэгт холбогдоогүй байх;
 - 3.2.3.5. Монгол Улсын болон гадаад улсын нутаг дэвсгэрт зохицуулалтын аллага шаардлагыг хангаж, эсхүл мэргэжлийн болон эс зүйн аливаа стандартыг дагаж мөрдөхөд бэлэн байх.
- 3.2.4 Энэхүү журмын 2.1.2.4-д заасан "Ашиг сонирхлыг зөрчлөөс ангид байх" шалгуурыг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлно. Үүнд:
- 3.2.4.1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.21.22 дугаар зүйлд харшлаггүй байх;
 - 3.2.4.2. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1-д заасан санхүүгийн үйлчилгээнд хамаарах үйл ажиллагааг зохицуулсан тусгайлан хууль, журамд харшлаггүй байх.
- (Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 307 дугаар тогтоолсоор өөрчлөлт оруулсан.)



2023.08.18



Нууц баримт
Эх хувь

тушаалтныг Санхүүгийн зохицуулах хороонд тухай бүр бүртгүүлэх, тохиромжтой этгээд болохыг нотлох баримтыг тухай бүр бүрдүүлж Санхүүгийн зохицуулах хороонд хурдүүлж холбогдох журамд заасан шаардлагыг хангаж ажиллахыг Хуулийн фирмээс зөвлөж байна.

Гурав. Үнэт цаас гаргагчийн дүрэм, бусад дотоод дүрэм, журмууд нь холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекст нийцсэн эсэх асуудлын хувьд үзвэл:

Хуулийн фирм нь энэхүү асуудлын хүрээнд Ашид капитал ББСБ ХХК-ийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа дүрэм, журамд дүн шинжилгээ хийлээ. Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-аас Хуулийн фирмд ирүүлсэн баримт материалаас үзвэл нийт 63 (жаран гурван) дүрэм, журам хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Ашид капитал ББСБ ХХК-ийн дүрэм, журмын жагсаалтыг Хавсралт №01. "Ашид капитал ББСБ ХХК-ийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журмын жагсаалт" хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Хүснэгт №06. Ашид капитал ББСБ ХХК-ийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журмын жагсаалтын тоон үзүүлэлт.

№	Дүрэм, журмын нэр, төрөл	Нийт
1	Компанийн засаглалд хамаарах дүрэм, журам	11
2	Хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцөд хамаарах дүрэм, журам	4
3	Тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журам	16
4	Санхүү, нягтлан бодох бүртгэлд хамаарах дүрэм, журам	8
5	Мэдээллийн аюулгүй байдалд хамаарах дүрэм, журам	11
6	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журам	2
7	Бусад дүрэм, журам	11
	НИЙТ	63

Хуулийн фирм нь Ашид капитал ББСБ ХХК-аас тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэж ирүүлсэн нийт дүрэм, журмын хүчин төгөлдөр байдал буюу хуульд заасан шаардлага хангасан эсэхэд дүгнэлт өгөхдөө дүрэм, журмаар зохицуулж байгаа харилцаанд үндэслэн хамааруулан дараах шалгуурыг удирдлага болголоо. Үүнд:

- (i) Компанийн засаглалд хамаарах дүрэм, журам нь Компанийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон Компанийн засаглалын кодекст харшилсан эсэх, эрх бүхий этгээд баталж, мөрдүүлсэн эсэх;
- (ii) Хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцөд хамаарах дүрэм, журам нь Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Байгууллагын нүүцэн тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Компанийн хөдөлмөрийн дотоод журам, ББСБ-ын хүний нөөцийн талаар баримтлах бодлогод тус тус нийцсэн эсэх, агуулга нь хууль, журамд харшилсан эсэх, эрх бүхий этгээд баталж, мөрдүүлсэн эсэх;
- (iii) Банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагаа буюу Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан зээл, факторингийн үйлчилгээ, төлбөрийн баталгаа гаргах, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, гадаад валют арилжаа, итгэлцлийн үйлчилгээ, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, үл хөдлөх хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зүүлчлэлийн үйлчилгээний журам нь Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд тус тус нийцсэн эсэх, агуулга нь хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм, журамд харшилсан эсэх, эрх бүхий этгээд баталж, мөрдүүлсэн эсэх;
- (iv) Санхүү нягтлан бодох бүртгэлд хамаарах дүрэм, журам нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Намэгдсэн ертгийн албан татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад тус тус нийцсэн эсэх, агуулга нь хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм, журамд харшилсан эсэх, эрх бүхий этгээд баталж, мөрдүүлсэн эсэх;



Нүүц баримт
Эх хувь

- (v) Эрсдэлийн удирдлага болон мэдээллийн аюулгүй байдалд хамаарах дүрэм, журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн засаглалын кодекст тус тус нийцсэн эсэх, агуулга нь хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм, журамд харшилсан эсэх, эрх бүхий этгээд баталж, мөрдүүлсэн эсэх;
- (vi) Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журам нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нийцсэн эсэх, агуулга нь хууль болоод Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журамд харшилсан эсэх, эрх бүхий этгээд баталж, мөрдүүлсэн эсэх;
- (vii) Бусад ангилалд хамаарах дүрэм, журам нь холбогдох хууль, тогтоомжид нийцсэн эсэх, агуулга нь хууль, журамд харшилсан эсэх, эрх бүхий этгээд баталж, мөрдүүлсэн эсэх.

Ашид капитал ББСБ ХХК-ийн үйл ажиллагаанд мөрдөж буй 59 (тавин есөн) дүрэм, журмаас үзвэл 7 (долоон) дүрэм, журам нь Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор баталсан, 52 (тавин хоёр) журмыг Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан байна.

(i) Компанийн засаглалд хамаарах дүрэм, журам

Үнэт цаас гаргагчийн дүрэм, бусад дотоод дүрэм, журмууд нь холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекст нийцсэн эсэх асуудлын хувьд үзвэл:

Ашид капитал ББСБ ХХК-ийн дүрэм


Ашид капитал ББСБ ХХК-ийг 2016 оны 09 сарын 09-ний өдөр үүсгэн байгуулсан бөгөөд Үүсгэн байгуулагчийн №01 шийдвэрээр анхны дүрмийг баталсан байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 07 сарын 05-ны өдрийн №017 тоот тогтоолоор ББСБ-ын дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд үүнээс хойш ББСБ-ын дүрэмд нийт 5 (таван) удаа нэмэлт, өөрчлөлт оруулсныг тухай бүр хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.

Одоогийн хүчин төгөлдөр хэрэгжиж буй дүрмийн хувьд Ашид капитал ББСБ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04 сарын 13-ны өдрийн хурлын №010 тоот тогтоолоор баталсан байна. Хуулийн фирмээс Ашид капитал ББСБ ХХК-ийн дүрэм нь Компанийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны №145 тоот тогтоолоор шинэчлэн баталсан Компанийн засаглалын кодекст тус тус нийцэж байгаа эсэхэд дараах байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт "Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрхийг компанийн хувьцаа эзэмшигч болох "М-Си-Эс Холдинг" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл эдэлнэ", 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт "Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрхийг эдлэх М-Си-Эс Холдинг ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас шийдвэрлэсэн бүх асуудлаар тогтоол гаргана. Тогтоолд М-Си-Эс Холдинг ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга гарын үсэг зурна. Хурлын явц, хэлэлцсэн асуудлын талаар дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлнө. Хэлэлцсэн асуудал, тэмдэглэл, тогтоолуудыг М-Си-Эс Холдинг ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга бүртгэж хадгална" гэж заасан нь тогтоол хүчин төгөлдөр болох, хурлын тэмдэглэлийг хөтлөх зэрэг асуудлуудыг шийдвэрлэхээр тусгасан байна. Бусад эрх, үүргийг нарийвчлан тусгаагүй хэдий ч Компанийн тухай хуулийг мөрдлөг болгохоор байна. Иймд дүрэмд заасан хувьцаа эзэмшигчдийн эрх, шийдвэр гаргах ажиллагаа зэрэг нь Компанийн тухай хуулийг зөрчөөгүй байна гэж үзэх үндэслэлтэй байна. Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт "М-Си-Эс Холдинг ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцэхээр товлөөгүй асуудлыг хуралд оролцож буй Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар хэлэлцэж болно" гэж заасан нь Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.11 дэх хэсэгт заасантай нийцэж байна.

Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, 6.5 дахь хэсэгт Төлөөлөн удирдах зөвлөлийн талаарх зохицуулалт орсон бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрхийг эдлэх М-Си-Эс Холдинг ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Ашид капитал ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг 5





Нүүц баримт
Эх хувь

(тав) хүртэл гишүүнтэйгээр томилохоор заасан байна. Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.2 дэхь хэсэгт²⁵ зааснаар хязгаарлагдмал хариуцлагатай компани нь дүрэмдээ тусгаснаар Төлөөлөн удирдах зөвлөлтэй байж болохоор байна. Мөн тус хуулийн 75 дугаар зүйлийн 75.3 дэхь хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог компанийн дүрмээр тогтооно", 75 дугаар зүйлийн 75.5 дэхь хэсэгт "компанийн дүрэмд заасан бол хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төлөөлөн удирдах зөвлөл хараат бус гишүүнтэй байж болно", Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулах журмын 2.14 дүгээр зүйлийн 2.14.1 дэх заалтад "нэг буюу түүнээс дээш гооны хараат бус, нийт 5-аас доошгүй гишүүн бүхий төлөөлөн удирдах зөвлөлтэй байх", Компанийн засаглалын кодекст заасан үндсэн зарчмын нэг болох компани Төлөөлөн удирдах зөвлөлтэй байх шаардлагыг тус тус хангаж байна.

Дүрэмд Гүйцэтгэх захирлыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох эрхтэй бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь Гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулан захирлын эрх, үүрэг, хариуцлагын талаар үүрэг, хариуцлагын хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хэлс, урамшуулал зэргийг тогтоож өгнө" гэж заасан нь Компанийн тухай хуульд нийцэж байна.

Ашид капитал ББСБ ХХК-ийн дүрэм нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг болон Банк бус санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан дүрэмд тусгавал зохих зүйлийг тусгасан, агуулгын хувьд Компанийн тухай хуульд нийцсэн байна гэж үзлээ.

Компанийн засаглалд хамаарах дүрэм, журам

Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй компанийн засаглалын дараах 10 (арван) дүрэм, журмыг Хуулийн фирмд ирүүлсэн. Үүнд:

- (i) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны №ТУ3-01 тоот тогтоолоор баталсан Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам;
- (ii) Гүйцэтгэх захирлын 2023 оны №061/А/23 тоот тушаалаар баталсан Удирдлагын хорооны үйл ажиллагааны журам;
- (iii) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны №11 тоот тогтоолоор баталсан Эрх мэдэл хуваарилах журам;
- (iv) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны №ТУ3-02 тоот тогтоолоор баталсан Дотоод аудитын үйл ажиллагааны журам;
- (v) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны №15 тоот тогтоолоор баталсан Эрсдэлийн удирдлагын бодлого;
- (vi) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны №ТУ3-04 тоот тогтоолоор баталсан Эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журам;
- (vii) Гүйцэтгэх захирлын 2023 оны №112/А/23 тоот тушаалаар баталсан Бизнесийн тасралтгүй байдлын төлөвлөгөө;
- (viii) Гүйцэтгэх захирлын 2023 оны №113/А/23 тоот тушаалаар баталсан Бизнесийн тасралтгүй байдлын журам;
- (ix) Гүйцэтгэх захирлын 2020 оны №054/А/20 тоот тушаалаар баталсан Хянан нийцүүлэлтийн үйл ажиллагааны журам;
- (x) Гүйцэтгэх захирлын 2020 оны №055/А/20 тоот тушаалаар баталсан Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх журам.

Ашид капитал ББСБ ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 05 сарын 12-ны өдрийн №155 тоот тогтоолоор итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байна. Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны №145 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан Компанийн засаглалын кодексийн үйлчлэх хүрээнд итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч нь уг кодексийг дагаж

²⁵ Компанийн тухай хууль [2011].

75 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөл

75.2 Хувьцаат компани нь төлөөлөн удирдах зөвлөлтэй байх бөгөөд хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлгүй байж болно



Нууц баримт
Эх хувь

мөрдөхөөр заасан байх тул кодекст заасан дүрэм, журмыг батлан үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Хуулийн фирмийн зүгээс зөвлөж байна.

Ашид капитал ББСБ ХХК-ийн засаглалд хамаарах дүрэм, журмаас онцгойлон дурдвал Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03 сарын 19-ний өдрийн №01 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг баталсан байна. Уг журмаар төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх, бүрэлдэхүүн, эрх, чиг үүрэг, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад тавигдах шаардлага, эрх, чиг үүргийг зохицуулсан байна. Журмын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг батлагдсан жилийн ажлын төлөвлөгөөний дагуу жилд 4-өөс доошгүй удаа хуралдуулна" гэж заасан. Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1 дэх хэсэгт "Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг сард нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл нэмэлт хурал хийж болно" гэж хуульчилсан. Ашид капитал ББСБ ХХК нь дүрэмдээ Төлөөлөн удирдах зөвлөл хэдэн удаа хуралдах талаар нарийвчлан зааж өгөөгүй байх тул журмын энэхүү заалтыг дүрэмдээ тусгах эсхүл хуулийн заалтыг баримтлах шаардлагатай байна гэж үзлээ.

Ашид капитал ББСБ ХХК нь Гүйцэтгэх захирлын 2020 оны 06 сарын 22-ны өдрийн №055/А/20 тоот тушаалаар Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх журмыг батлан үйл ажиллагаандаа мөрдөж байна. Энэхүү журмаар банк бус санхүүгийн байгууллагын ажилтан, эрх бүхий албан тушаалтан, хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн зэрэг бүхий л албан тушаалтанд аливаа ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх, хянах, гарсан зөрчлийг шийдвэрлэхээр заасан байх бөгөөд Компанийн засаглалын кодекст заасан шүгэл үлээх тогтолцоог тусгасан байна.

Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК нь Дотоод аудит, Эрсдэлийн удирдлагын хороо, Удирдлагын хороотой бөгөөд эдгээрээр дамжуулан өдөр тутмын үйл ажиллагааг хянаж, дүрэм журмын нийцлийг хангадаг байна. Дотоод аудит нь Дотоод аудитын үйл ажиллагааны журмын дагуу ББСБ-ын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх арга хэлбэрийг тодорхойлж, дотоод аудитын үйл ажиллагааг зохион байгуулан, үнэлэлт, дүгнэлт өгч ажиллахаар заасан байна. Эрсдэлийн удирдлагын хороо нь Эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд банк бус санхүүгийн байгууллагад учирч болзошгүй эрсдэлийн төрлүүдийг тодорхойлох, тэдгээрийг удирдан гүйцэтгэх захирал болон Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан зохистой засаглал, тогтолцоог бий болгоход чиглэн ажиллахаар заасан байна. Мөн уг бодлоготой холбогдуулан Эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журмыг баримтлан ажилладаг бөгөөд энэхүү журмаар эрсдэлийн удирдлагын бодлогын хэрэгжилт, эрсдэл бий болоход нөлөөлж буй хүчин зүйлстэй холбоотой шийдвэрийг гаргаж ажиллахаар заасан байна. Удирдлагын хороо нь Удирдлагын хорооны ажиллах журмын хүрээнд ББСБ-ын бизнес стратеги төлөвлөгөө, өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой асуудлууд, үйл ажиллагаанд дагаж мөрдөх шаардлагатай дүрэм, журам, заавар, мэдээллийн аюулгүй байдлын талаар хуралдан шийдвэр гаргаж, шийдвэрийг тухайн асуудал эрхэлсэн захирал болон нэгжийн удирдах ажилтанд хүргүүлэн, шийдвэрийн дагуу авагдсан ажлуудын үр дүнгийн талаар эргэн хорооны хуралд тайлагнахаар журамласан байна.


Иймд Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн дүрэм болон засаглалын үйл ажиллагааны дүрэм, журам нь Компанийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн засаглалын кодекст нийцсэн байна гэж үзлээ. Цаашид Компанийн засаглалын кодекст заасан дүрэм, журмыг боловсруулан баталж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Хуулийн фирмийн зүгээс зөвлөж байна.

(ii) Хөдөлмөрийн харилцаа хүний нөөцөд хамаарах журам

Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн хүчин төгөлдөр мөрдөгдөж хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцөд хамаарах дараах 4 (дөрвөн) дүрэм, журмыг Хуулийн фирмд ирүүлсэн. Үүнд:

- (i) М-Си-Эс Холдинг ХХК-аас 2015 онд баталсан Хөдөлмөрийн дотоод журам:





Нүүц баримт
Эх хувь

- (ii) Гүйцэтгэх захирлын 2022 оны №008/А/22 тоот тушаалаар баталсан Борлуулалтын мэргэжилтний ажлын гүйцэтгэл үнэлэх, урамшуулал тооцох журам;
- (iii) Гүйцэтгэх захирлын 2023 оны №111/А/23 тоот тушаалаар баталсан Хүний нөөцийн журам;
- (iv) Гүйцэтгэх захирлын 2023 оны №203/А/23 тоот тушаалаар баталсан Мерчант хариуцсан борлуулалтын ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх, урамшуулал тооцож олгох журам.

Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 03 сарын 02-ны өдрийн №004/А/20 тоот тушаалаар М-Си-Эс Холдинг ХХК-ийн охин компаниудад хамаарал бүхий дүрэм, журам, заавар, бодлогыг ББСБ-д мөрдөн ажиллахыг үүрэг болгосон бөгөөд уг тушаалын дагуу М-Си-Эс Групп ХХК-ийн 2015 оны 10 сарын 19-ний өдрийн Хөдөлмөрийн дотоод журмыг дагаж мөрддөг байна. Энэхүү журмаар ажилтны болон ажил олгогчийн эрх үүрэг, ажилтныг сонгон шалгаруулах, ажлын цаг, ээлжийн амралт, ажилтанд олгох цалин хөлс, хөнгөлөлт, хангамж, сургалт, хөгжил, эрүүл мэндийн үзлэг, ажилтанд тосцох хариуцлага, эд хөрөнгийн хариуцлага, хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дүүсгавар болгох, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдал зэрэг асуудлыг тус тус тодорхойлон тусгасан байна. Мөн дээрх асуудал тус бүр дээр баталсан холбогдох журмыг мөрдөн ажиллахаар журамласан байна. Ашид капитал ББСБ ХХК нь Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэг²⁷ заасан ажил олгогч нь хууль тогтоомжид нийцүүлэн хөдөлмөрийн дотоод журам баталж мөрдүүлнэ гэж заасны дагуу Гүйцэтгэх захирлын 2023 оны 04 сарын 12-ны өдрийн №111/А/23 тоот тушаалаар Хүний нөөцийн журмыг баталсан байна. Уг журмаар ажилтныг сонгон шалгаруулах, хөдөлмөрийн гэрээ байгуулах талаар тусгасан байна.

Иймд Ашид капитал ББСБ ХХК-аас ирүүлсэн хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцөд хамаарах дүрэм, журмууд нь Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомжид нийцсэн байна гэж үзлээ.

(iii) Тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журам

Үнэт цаас гаргагч нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй, тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагаанд хамаарах нийт 16 (арван зургаан) дүрэм, журмыг Хуулийн фирмд ирүүлсэн байна. Эдгээр дүрэм, журмаас онцгойлон дурдвал Ашид капитал ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны №126/А/23 тоот тушаалаар Итгэлцлийн үйлчилгээний журмыг баталсан байна. Тус журмаар ББСБ нь иргэн болон хуулийн этгээдийн активыг үнэгүйдлээс хамгаалж, ашиг олж өгөх зорилгоор тэдгээртэй харилцан тохиролцсон гэрээний үндсэн дээр итгэл хүлээгчээс нэр бүхий активыг түр хугацаанд хянах, ашиглах, захиран зарцуулахтай холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулдаг байна. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалтад²⁸ банк бус санхүүгийн үйл ажиллагаанд итгэлцлийн үйлчилгээ орохоор хуульчилсан. Тус журамд итгэлцлийн үйлчилгээ 6 сараас 24 сарын хугацаатай байх ба валютын төрлийг тохиролцож болохоор тусгаж зохицуулсан байна. Мөн итгэлцлийн үр шимийг тодорхой давтамжтай өгөх, хөрөнгө итгэмжлүүлсэн этгээдийн хүсэлтээр гүравдагч этгээдэд өгөх зэрэг зохицуулалтыг тусгасан байна. Итгэлцлийн үйлчилгээний журмын 5 дугаар зүйлд зааснаар ББСБ итгэлцлийн хүрээнд хүлээн авсан хөрөнгийг итгэл хүлээлгэгчтэй байгуулсан гэрээний дагуу зохицуулагч байгууллагын тавьсан шаардлагад нийцүүлэн, зөвшөөрсөн хэлбэрээр зохистой үр ашигтай зарцуулах үүрэг хүлээсэн байх ба талуудын хооронд зааснаас өөр байдлаар зарцуулахыг хориглосон байна. Мөн итгэмжлэгчийг татах зорилгоор олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан сурталчилгаа явуулах, үр шимийн талаар олон нийтэд урьдчилан амлах зэргийг хориглосон байна. Энэ нь Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 03 сарын 11-ний

²⁷ Хөдөлмөрийн тухай хууль (2021).

122 дугаар зүйл Хөдөлмөрийн дотоод журам

122.1 Ажил олгогч ажилтны төлөөлөгчийн саналыг харгалзан хууль тогтоомжид нийцүүлэн тухайн ажлын нэгж байгууллагын хэмжээнд үйлчлэх хөдөлмөрийн дотоод журмыг баталж мөрдүүлнэ.

²⁸ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль (2002).

7 дугаар зүйл Банк бус санхүүгийн үйл ажиллагаа

7.1 Банк бус санхүүгийн үйл ажиллагаа гэгч дараахь үйл ажиллагааг ойлгоно:
7.1.8 итгэлцлийн үйлчилгээ;



Handwritten signature



Нүүц баримт
Эх хувь

өдрийн №71 тоот тогтоолоор баталсан Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журмын 2 дугаар зүйлийн 2.15 дахь хэсгийг хангасан байна.

Ашид капитал ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 04 сарын 27-ны өдрийн №11/21 тоот тушаалаар Зээлийн бодлогыг шинэчлэн баталсан байна. Уг Зээлийн бодлогоор ББСБ нь өөрийн зорилтот зах зээлийг иргэдэд зориулсан хэрэглээний зээл, бичил болон жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч иргэн хуулийн этгээд байна гэж тодорхойлсон байна. Үүнээс гадна тусгайлан бизнес эрхлэгч эмэгтэйчүүдээс гадна байгаль орчинд ээлтэй, экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжихээр заажээ. Зээлийн үйл ажиллагаанд харилцагчийн нууцыг чандлан хадгалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарчмыг баримтлахаар заасан байна. Шашны байгууллага, ашгийн төлөө бус хуулийн этгээд, улс төрийн намд зээл олгохгүй байхаар зааснаас гадна байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй бизнес, галт зэвсгийн худалдаа, цэрэг дайны зориулалттай тоног төхөөрөмжтэй холбоотой үйл ажиллагаанд зориулж зээл олгохгүй гэдгээ уг бодлогод тодорхой тусгасан байна. Мөн бодлогод зээлийн судалгаа, барьцаа хөрөнгөд тавигдах шаардлага, түүнийг хэрхэн үнэлэх, зээл олгох шийдвэр гаргалт, харилцагчийн эрх ашгийг хамгаалах тухай, зээлийг эргэн төлүүлэх, төлөлт хийх дараалал, зээлтэй холбоотой дүн шинжилгээ, мэдээллийн нүүцлэл зэрэг зохицуулалтыг нарийвчлан тусгасан байна.

Ашид капитал ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 04 сарын 26-ны өдрийн №129/А/23 тоот тушаалаар Зээлийн хорооны ажиллах журмыг шинэчлэн баталсан байна. Уг журмаар ББСБ нь зээлийн хороотой байх ба хорооны даргыг оролцуулан 5 (тав)-аас доошгүй гишүүнтэй байхаар заасан байна. Хорооны дэргэ нь Гүйцэтгэх захирал байх ба хорооны гишүүдийг Гүйцэтгэх захирлын тушаалаар томилж, чөлөөлж байхаар журамд заасан байна. Мөн хороодын ажиллах зарчим, хурлын ирц, шийдвэр хүчин төгөлдөр болох, эрх үүрэг зэргийг журамд нарийвчлан тусгасан байна.

Зээлийн бодлого, зээлийн хороодын ажиллах журамд нийцүүлэн Ашид капитал ББСБ ХХК-аас санал болгож буй зээлийн бүтээгдэхүүн тус бүр дээр зээлийн журмуудыг боловсруулан Гүйцэтгэх захирлаар тус тус батлуулсан байна. Эдгээр зээлийн журмууд нь тухайн зээлийн бүтээгдэхүүний онцлог, зээлийн судалгаа, зээлийн хүгцаа, зээлийн хэмжээ, барьцааны шаардлага мөн холбогдох зээлийн гэрээ зэргийг агуулсан байна. Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн дээр дүрдсэн зээлийн үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журмууд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны тогтоолоор баталсан Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журамд нийцсэн байна.

Иймд Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагаа буюу итгэлцлийн үйлчилгээ, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, гадаад валютын арилжаа, зээл болон санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах харилцааг зохицуулсан журмууд нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Банк бус санхүүгийн байгууллагын хэмжээнд дагаж мөрдвөл зохих дүрэм, журамд нийцсэн байна гэж үзлээ.

(iv) Санхүү, нягтлан бодох бүртгэлд хамаарах дүрэм, журам

Үнэт цаас гаргагч нь тасалбар болгосон өдрийн байдлаар ББСБ-ын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд хамаарах дараах 8 (найман) журмыг Хуулийн фирмд ирүүлсэн байна. Үүнд:



- (i) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны №02 тоот тогтоолоор батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар;



[Handwritten signature]



2023.08.18



Нууц баримт
Эх хувь

- (ii) Гүйцэтгэх захирлын 2020 оны №043/A/20 тоот тушаалаар батлагдсан Төлбөр тооцооны үйл ажиллагааны журам;
- (iii) Гүйцэтгэх захирлын 2020 оны №148/A/20 тоот тушаалаар батлагдсан Активыг ангилах, эрсдэлийн сан байгуулж зарцуулах журам;
- (iv) Гүйцэтгэх захирлын 2021 оны №172/A/21 тоот тушаалаар батлагдсан Чанаргүй актив барагддуулах журам;
- (v) Гүйцэтгэх захирлын 2023 оны №038/A/23 тоот тушаалаар батлагдсан Зээлийн багцын үнэ цэнийн бууралтыг тооцох, хүлээгдэж буй алдагдлын сан байгуулах, тайлагнах журам;
- (vi) Гүйцэтгэх захирлын 2020 оны №059/A/20 тоот тушаалаар батлагдсан Залруулгын гүйлгээний журам;
- (vii) Гүйцэтгэх захирлын 2023 оны №122/A/23 тоот тушаалаар батлагдсан Хөрөнгийн удирдлагын журам;
- (viii) Гүйцэтгэх захирлын 2020 оны №013/A/20 тоот тушаалаар батлагдсан Маргаантай, луйврын шинжтэй гүйлгээг илрүүлэх, шалган шийдвэрлэх журам.

Ашид капитал ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 03 сарын 20-ны өдрийн №02 тоот тогтоолоор ББСБ-ын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, зааврыг баталсан байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, зааврын 1 дүгээр зүйлийн 1.8.4 дэх заалтад “ББСБ нь СТОУС дээр суурилан Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Сэнгийн яамнаас батлан гаргасан бүртгэлийн бодлого, зарчмыг түүштэй мөрдөнө” гэж заасан ба нягтлан бодох бүртгэлийн зарчим болгож тусгажээ. Мөн тус журмын 2 дугаар зүйлийн 2.1.20 дахь заалтад “СТОУС гэж Нягтлан бодох бүртгэлийн болон СТОУС-ыг ойлгоно” хэмээн тодорхойлсон ба 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүрэг, хариуцлагыг ББСБ-ын удирдлага хүлээнэ” гэж тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг болон 18.2 дахь хэсэг²⁹ заасантай нийцсэн байна. Мөн Нягтлан бодох бүртгэлийн бодлого, зааврын 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт “ББСБ-ын удирдлага санхүүгийн тайлангаа үнэн зөв гаргасан гэдгээ албан ёсоор нотолсон баримт бичиг үйлдэн он, сар, өдрийг тэмдэглэж, ББСБ-ын төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх удирдлага, холбогдох бусад эрх бүхий албан тушаалтан гарын үсгээ зурж, тамга, тэмдгээр баталгаажсан байна” гэж заасан нь Компанийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.4 дэх хэсэг³⁰ заасантай нийцсэн байна.

Үнэт цаас гаргагчийн Нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар нь Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын зөвлөлөөс гаргасан СТОУС (2021) болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад тус тус нийцсэн байна гэж үзлээ.

Санхүү, нягтлан бодох бүртгэлд хамаарах бусад дүрэм, журмуудын хувьд хөрөнгийн удирдлага, худалдан авалт, төлбөр тооцоо, активтай холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан байх ба холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг дагаж мөрдөх, удирдлага болгож ажиллах талаар тусгасан байх ба хууль тогтоомжид нийцсэн байна.

Иймд Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлд хамаарах дүрэм, журам нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн байна гэж үзлээ.

²⁹ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль (2015).

³⁰ 15 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн удирдлага, зохион байгуулалт

18.1 Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.

18.2 Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.



³¹ Компанийн тухай хууль (2011).

95 дугаар зүйл. Компанийн нягтлан бодох бүртгэл, тайлан

95.4 Компанийн гүйцэтгэх удирдлага тухайн компанийн нягтлан бодох бүртгэл санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна



2023.08.18



Нүүц баримт
Эх хувь

(ix) Мэдээллийн аюулгүй байдалд хамаарах дүрэм, журам

Үнэт цаас гаргагч нь тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа мэдээллийн аюулгүй байдалд хамаарах дараах 11 (арван нэгэн) дүрэм, журмыг хуулийн фирмд ирүүлсэн. Үүнд:

- (i) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны №18 тоот тогтоолоор батлагдсан Мэдээллийн аюулгүй байдлын бодлого;
- (ii) Гүйцэтгэх захирлын 2023 оны №090/A/23 тоот тушаалаар батлагдсан Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны дотоод аудитын журам;
- (iii) Гүйцэтгэх захирлын 2023 оны №115/A/23 тоот тушаалаар батлагдсан Хандах эрхийн зохицуулалтын журам;
- (iv) Гүйцэтгэх захирлын 2023 оны №118/A/23 тоот тушаалаар батлагдсан Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний журам;
- (v) Гүйцэтгэх захирлын 2023 оны №119/A/23 тоот тушаалаар батлагдсан Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хамрах хүрээний бодлого;
- (vi) Гүйцэтгэх захирлын 2023 оны №120/A/23 тоот тушаалаар батлагдсан Нийлүүлэгчийн харилцаанд мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам;
- (vii) Гүйцэтгэх захирлын 2023 оны №132/A/23 тоот тушаалаар батлагдсан Мэдээллийн аюулгүй байдлын цогц журам;
- (viii) Гүйцэтгэх захирлын 2023 оны №171/A/23 тоот тушаалаар батлагдсан Криптограф ба түлхүүрийн удирдлагын журам;
- (ix) Гүйцэтгэх захирлын 2020 оны №013/A/20 тоот тушаалаар батлагдсан Зээлийн мэдээллийн сангаас мэдээлэл авах, нийлүүлэх, ашиглах үйл ажиллагааны журам;
- (x) Гүйцэтгэх захирлын 2023 оны №114/A/23 тоот тушаалаар батлагдсан Программ хангамж хөгжүүлэх журам;
- (xi) Гүйцэтгэх захирлын 2020 оны №046/A/20 тоот тушаалаар батлагдсан Үндсэн болон нөөц дата төвд ажиллах журам.

ББСБ-ын Гүйцэтгэх захирлын 2020 оны 06 сарын 04-ний өдрийн 046/A/20 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар Мэдээллийн аюулгүй байдлын цогц журмыг батлан мөрдүүлсэн байна. Тус журмаар ББСБ-д ашиглаж байгаа программ, систем, төхөөрөмжийн нэвтрэх нэр, нүүц үг, нэвтрэлт, эрхийн зохицуулалт, интернэт үйлчилгээ, төвлөрсөн удирдлагатай холбогдох зэрэг ББСБ-ын мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулсан байна.

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээллийн аюулгүй байдалд хамаарах бусад дүрэм, журмаас онцгойлон дүрдвэл ББСБ-ын Гүйцэтгэх захирлын 2020 оны 03 сарын 20-ны өдрийн №013/A/20 тоот тушаалын долоодугаар хавсралтаар Зээлийн мэдээллийн сангаас мэдээлэл авах, нийлүүлэх, ашиглах үйл ажиллагааны журмыг баталсан. Энэхүү журмын 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт “Зээлийн мэдээллийн сангаас мэдээлэл авах, ашиглах, нийлүүлэх үйл ажиллагаанд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай, Зээлийн мэдээллийн тухай, Хувь хүний нүүцэн тухай, Байгууллагын нүүцэн тухай хуулиуд болон бусад холбогдох хууль тогтоомж, түүнчлэн Ашид капитал ББСБ ХХК-ийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй журам, заавар, тушаалыг удирдлага болгон ажиллана” гэж заасан байна. Хувь хүний нүүцэн тухай хууль нь 2022 оны 05 сарын 01-ний өдөр Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээр хүчингүй болсон тул журмын зохицуулалтыг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нийцүүлэн өөрчлөхийг Хуулийн фирмээс зөвлөж байна.

(xii) Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журам

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд Ашид капитал ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 05 сарын 04-ний өдрийн №08 тоот тогтоолоор Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналтын хөтөлбөрийг тус тус баталсан байна.



2023.08.18



Нүүц баримт
Эх хувь

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтад³¹ зааснаар банк бус санхүүгийн байгууллага нь 20,000,000 (хорин сая) төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг мэдээлэх үүрэгтэй байдаг. Энэ үүргээ хэрэгжүүлэн уг журамд ББСБ нь 20,000,000 (хорин сая) төгрөгтэй тэнцэх болон түүнээс дээш үнийн дүн бүхий гүйлгээг мэдээлэх ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулахаар заасан байна. Мөн тус журамд ББСБ нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт³² зааснаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг эрсдэлд суурилсан хэлбэрээр хэрэгжүүлж, өөрт учирч болох эрсдэлийг харилцагчийн эрсдэл, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний эрсдэл, болон түүнийг хүргэх хэлбэр, газар зүйн байршлаас хамаарсан эрсдэл гэж ангилжээ.

Мөн тус журмаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд эрсдэлийг хянах, харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй гүйлгээг мэдээлэх, үг мэдээллийг хадгалах, тайлагнах болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ББСБ-ын ажилчдад жил бүр сургалт зохион байгуулах талаар тусгасан нь Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нийцсэн байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналтын хөтөлбөрийн тухайд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт³³ заасан шаардлагыг хангасан гэж үзэхээр байна.

Үнэт цаас гаргагчаас Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам болон дотоод хяналтын хөтөлбөрийг үйл ажиллагаандаа батлан хэрэгжүүлсэн нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 01 сарын 21-ний өдрийн №А-26 тоот тушаалаар батлагдсан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журамтай тус тус нийцсэн байна гэж Хуулийн фирмийн зүгээс үзлээ.

(xiii) Бусад дүрэм, журам

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн бусад дүрэм, журмаас харилцагчийн үйлчилгээнд хамаарах дүрэм, журмыг авч үзвэл Ашид капитал ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 04 сарын 27-ны өдрийн №135/А/23 тоот тушаалаар Харилцагч бүртгэх журмыг батлан мөрдүүлсэн байна. Тус журмаар ББСБ-ын бүтээгдэхүүн, үйлчилгээг авахаар хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийг харилцагчаар бүртгэх, тэдгээрийн хувийн хэргийг бүрдүүлэн хадгалах, харилцагчийн мэдээллийг шинэчлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан бөгөөд ББСБ нь харилцагчийг шинээр бүртгэхдээ бусдын баримт бичгийг ашиглах болон хуурамчаар баримт бичиг бүрдүүлэх зэрэг сэжиг бүхий оролдлогыг харилцагчаар бүртгэхээс татгалзаж, Комплайнсын нэгжид мэдэгдэхээр заасан нь ББСБ-ын дотооддоо мөрдөж буй Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан

³¹ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (2013).

4 дүгээр зүйл. Мэдээлэх үүрэгтэй этгээд

4.1. Дараах этгээд энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан гүйлгээний талаар энэ хуулийн 16.1-д заасан Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй:

4.1.2. Банк бус санхүүгийн байгууллага.

³² Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (2013).

4 дүгээр зүйл. Мэдээлэх үүрэгтэй этгээд

4.3. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг эрсдэлд суурилсан хэлбэрээр хэрэгжүүлэх бөгөөд ийнхүү хэрэгжүүлэхдээ дараах эрсдэлийг харгалзан өөрийн аж ахуйн үйл ажиллагааны онцлог, хамрах хүргэлд нийцүүлэн бодитойгоор үнэлнэ:

4.3.1. харилцагчаас хамаарч үүсэх эрсдэл;

4.3.2. бүтээгдэхүүн, үйлчилгээгээс хамаарч үүсэх эрсдэл;

4.3.3. бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчид хүргэх арга, хэлбэрээс хамаарч үүсэх эрсдэл;

4.3.4. газар зүйн байршлаас хамаарч үүсэх эрсдэл.

³³ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (2013).

14 дүгээр зүйл. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн дотоод хяналт

14.2. Дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр нь энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн бизнесийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, бүтэц, зохион байгуулалтад нийцсэн байх ба мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор үс дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломжийг хангасан байна.



Handwritten signature



2023.08.18

Нууц баримт
Эх үүсвэр

сэргийлэх үйл ажиллагааны журамтай²² уялджээ. Үнэт цаас гаргагч нь ийнхүү харилцагчийг шинээр бүртгэхдээ шаардлагатай тохиолдолд таньж мэдэх ажиллагаа хийсний үндсэн дээр бүртгэн, улмаар харилцагчийн мэдээллийг ББСБ-ын нүүцэн зэрэглэлтэйгээр харилцагчийн хувийн хэрэгт хадгалж, аливаа байдлаар хууль бусаар ашиглахыг хориглосон нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг²³ болон Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нийцсэн байна.

Мөн Үнэт цаас гаргагч нь бүтээгдэхүүн үйлчилгээгээ харилцагчид хүргэх, харилцагчийн үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэхээр Гүйцэтгэх захирлын 2022 оны 08 сарын 30-ны өдрийн №222/А/22 тоот тушаалаар Харилцагчийн үйлчилгээний журмыг баталсан бөгөөд харилцагчийн мэдээллийн төвийн зохион байгуулалт, эжилтнуудын чиг үүрэг, үйлчилгээний стандарт, гомдол, талархлыг хүлээн авах, шийдвэрлэхтэй холбогдсон харилцаагч нарийвчлан зохицуулахаар Гүйцэтгэх захирлын 2020 оны 03 сарын 20-ний өдрийн №013/А/20 тоот тушаалаар Харилцагчийн мэдээллийн төвийн үйл ажиллагааны журам болон Гомдол, талархлыг хүлээн авах, шийдвэрлэх журмыг тус тус баталсан нь Ашид капитал ББСБ ХХК-ийн дүрэмд нийцсэн байна.

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн ББСБ-ийн дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөх бусад дүрэм, журам нь Иргэний хууль, Компанийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн байна.

Нэгтгэн дүгнэвэл Ашид капитал ББСБ ХХК-ийн дотоод үйл ажиллагаандаа мөрдөж байгаа 63 (жаран гурван) дүрэм, журам нь Иргэний хууль, Компанийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох хуульд нийцсэн бөгөөд эрх бүхий этгээдээс баталж мөрдүүлсэн байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Дөрөв. Бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх, компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх асуудлын хувьд үзвэл:

Хуулийн фирм нь энэхүү асуудлын хүрээнд сүүлийн 3 (гурван) жилийн хугацаанд буюу 2020 оны 08 сарын 01-ний өдрөөс 2023 оны 08 сарын 01-ний өдөр (цаашид “Гэрээг тасалбар болгосон өдөр” гэх)-өөр тасалбар болгон Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн бусадтай бичгээр байгуулсан гэрээний жагсаалтыг гаргуулан авч гэрээний жагсаалтаас өөрсдийн тогтоосон загварчлалын дагуу санамсаргүй түүврийн аргаар сонгон авч дүн шинжилгээ хийлээ.

Ашид капитал ББСБ ХХК-аас ирүүлсэн баримт материалаас үзвэл Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар нийт 153,905 (нэг зуун тавин гурван мянга есөн зуун таван) гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Үүнд:

Хүснэгт №07. Сүүлийн 3 (гурван) жилийн дотор бусадтай бичгээр байгуулсан нийт хүчин төгөлдөр гэрээний тоон үзүүлэлт.

№	Гэрээний нэр, төрөл	2020.08.01 – 2021.07.31	2021.08.01 – 2022.07.31	2022.08.01 – 2023.08.01	НИЙТ
1.	Хөрөнгө итгэмжлэх буюу итгэлцлийн гэрээ болон Өрийн хэрэгсэл худалдах, худалдан авах гэрээ	-	1	39	40
2.	Санхүүжилт татсан зээлийн гэрээ	-	-	-	-
3.	Зээлийн гэрээ	16	170	421	607
	Дижитал зээл	3,980	78,399	70,813	153,192
4.	Их эмжээний кэлцэл	-	-	-	-

²² Ашид капитал ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 05 сарын 04-ний өдрийн №08 тоот тогтоол.
²³ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль (2002).
 12 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хориглох зүйл
 12.3 Банк бус санхүүгийн байгууллага, түүний харилцагч болон гуравдагч этгээд нууц гэж үзсэн аливаа мэдээллийг Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд гаргаж өгөх, задлах, ашиглахыг Банк бус санхүүгийн байгууллагын хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх зөхиол ажилтанд хориглосон.



2023.08.18



Нууц баримт
Эх хувь

5.	Сонирхлын зөрчилтэй хэлцэл	-	3	7	10
6.	Бусад гэрээ	3	3	50	56
	НИЙТ	3,999	78,576	71,330	153,905

Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-аас Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэж ирүүлсэн зээлийн гэрээний жагсаалтаас санамсаргүй түүврийн аргаар гэрээг сонгон авч гэрээний хүчин төгөлдөр байдал буюу хуульд заасан агуулга болон хэлбэрийн шаардлага хангасан эсэхэд дүгнэлт өгөхдөө гэрээ байгуулах журам, гэрээний зүйл, гэрээгээр зохицуулж байгаа харилцаанаас хамааруулан дараах шалгуурыг удирдлага болголоо. Үүнд:

- (i) Ашид капитал ББСБ ХХК-ийн үндсэн үйл ажиллагаа эрхлэн явуулахад шаардагдах итгэлцлийн гэрээ нь Иргэний хуулийн 406 дугаар зүйлд³⁶ заасан нөхцөл болон итгэлцлийн гэрээнд тусгавал зохих бусад нөхцөлийг гэрээнд тусгасан эсэх, агуулга нь хуульд харшилсан эсэх, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх;
- (ii) Өрийн хэрэгсэл худалдах, худалдан авах гэрээний хувьд Иргэний хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны №165 тоот тогтоолоор баталсан "Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх, түүнд хяналт тавих журамд"-д заасан нөхцөлийг тусгасан эсэх, агуулга нь хуульд харшилсан эсэх, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх;
- (iii) Зээлийн гэрээний хувьд Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн дөрөвдүгээр бүлгийн 19-27 дугаар зүйл³⁷, Иргэний хуулийн 281-283 дугаар зүйл³⁸, 451-453 дугаар зүйл, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн

³⁶ Иргэний хууль (2002).

406 дугаар зүйл Хөрөнгө итгэмжлэх гэрээ

406.1 Хөрөнгө итгэмжлэх гэрээгээр итгэмжлэгч нь хөдлөх эд хөрөнгө буюу эрхийг итгэмжлэгдсэн өмчлөгчид шилжүүлэх, итгэмжлэгдсэн өмчлөгч нь итгэмжилсэн хөрөнгийг хүлээн авч итгэмжлэгчийн эрх, ашиг сонирхолд нийцүүлэн захиран зарцуулах үүрэг тус тус хүлээнэ.

406.2 Хуульд өөрөөр заагаагүй бол хөрөнгө итгэмжлэх гэрээг бичгээр хийнэ.

406.3 Итгэмжлэгдсэн өмчлөгч нь итгэмжилсэн хөрөнгийг өөрийн нэрийн өмнөөс, итгэмжлэгчийн зардал, эрсдэлээр захиран зарцуулах үүрэгтэй.

406.4 Итгэмжлэгдсэн өмчлөгч гуравдагч этгээдтэй харилцсанд орохдоо өмчлөгчийн бүрэн эрхийг хэргийг хэрэгжүүлж, үр дүгээр нь хариуцах бөгөөд итгэмжлэгчийн ашиг сонирхолд карш үйл ажиллагаа явуулсны улмаас түүнд учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

406.5 Гэрээнд өөрөөр заагаагүй бол итгэмжлэгдсэн өмчлөгч итгэмжилсэн хөрөнгөтэй холбоотой үйл ажиллагаа явуулсны төлөө итгэмжлэгчээс хөлс авахгүй.

406.6 Итгэмжилсэн хөрөнгөөс олсон орлого, үр шимийг итгэмжлэгч амчилно.

³⁷ Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (2021).

19 дүгээр зүйл Банк, эрх бүхий хуулийн этгээдийн зээлийн үйл ажиллагаа

20 дугаар зүйл Зээлийн гэрээ

21 дүгээр зүйл Зээлийн хүү

22 дугаар зүйл Зээлийн хувийн хэрэг

23 дугаар зүйл Зээлийн батлан даалт

24 дүгээр зүйл Зээлийн барьцаа

25 дугаар зүйл Зээлийг хугацаанаас нь өмнө буцаан төлөх

26 дугаар зүйл Зээл төлүүлэх

27 дугаар зүйл Зээлийг ангилах

³⁸ Иргэний хууль (2002).

281 дүгээр зүйл Зээлийн гэрээ

281.1 Зээлийн гэрээгээр зээлдүүлэгч нь зээлдэгчийн өмчлөлд мөнгө буюу төрлийн шинжээр тодорхойлогдох бусад эд хөрөнгө шилжүүлэх, зээлдэгч нь шилжүүлэн авсан эд хөрөнгөтэй ижил төсөл, тос, чанар, хэмжээний эд хөрөнгө буюу мөнгийг тохирсон хугацаанд буцаан өгөх үүргийг тус тус хүлээнэ.

282 дугаар зүйл Зээлийн гэрээний хүү

282.1 Зээлийн гэрээгээр талууд кээлэлцэн тохиролцож хүү тогтоож болно.

282.2 Хүүгийн хэмжээ нь зээлдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд илт хохиролтойгоор тогтоогдсон бол түүний хүсэлтээр шүүх зээлийн хүүг багасган болно.

282.3 Хуульд өөрөөр заагаагүй бол хүү тогтоосон бол зээлийн гэрээг бичгээр хийнэ. Энэ шаардлагыг хангаагүй бол хүү авах эрхээ алдана.

282.4 Мөнгө буюу эд хөрөнгийг зээлдэгчид шилжүүлэн өгснөөр зээлийн гэрээг байгуулсанд тооцно.

283 дугаар зүйл Зээлийн гэрээний хугацаа

283.1 Зээлийн гэрээгээр зээлийг буцааж төлөх хугацаа тогтоогоогүй бол зээлдүүлэгчийн шаардсанаар түүнийг буцааж төлөх бөгөөд ийнхүү шаардсанаас хойш нэг сарын дотор зээлдэгч үүргээ биелүүлнэ.

283.2 Зээлийн гэрээгээр хүү тогтоогоогүй бол зээлдэгч хугацаанаас нь өмнө зээлийг буцаан өгч болно.



2023.08.18

Нууц баримт
Эх хувь

- бус хөрөнгийн барьцааны тухай хуульд заасан зээлийн гэрээ болон зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар байгуулсан барьцааны гэрээний гол нөхцөлийг тусгасан эсэх, агуулга нь хуульд харшилсан эсэх, барьцааг холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн эсэх, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх, зээл олгох шийдвэр Ашид капитал ББСБ ХХК-ийн дотоод дүрэм, журамд заасны дагуу гарсан эсэх, холбогдох хууль тогтоомжид заасан хэлбэрийн шаардлага хангасан эсэх;
- (iv) Үл хөдлөх эд хөрөнгө түрээслэх гэрээний хувьд Иргэний хуулийн 318 дугаар зүйлийн 318.1 дэх хэсэгт³⁵ заасан түрээсийн гэрээний гол нөхцөл болон Үл хөдлөх эд хөрөнгө түрээслэх гэрээнд тусгавал зохих бусад нөхцөлийг гэрээнд тусгасан эсэх, агуулга нь хуульд харшилсан эсэх, бичгээр байгуулж, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх, эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн эсэх (үл хөдлөх эд хөрөнгийг хэсэгчлэн түрээслэх гэрээнд энэхүү шаардлага хамаарахгүй);
 - (v) Худалдах, худалдан авах гэрээний хувьд Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйлд заасан нөхцөл болон худалдах, худалдан авах гэрээнд тусгавал зохих бусад нөхцөлийг гэрээнд тусгасан эсэх, агуулга нь хуульд харшилсан эсэх, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх;
 - (vi) Ажил гүйцэтгэх гэрээний хувьд Иргэний хуулийн хуулийн 343 дугаар зүйлийн 343.1 дэх хэсэгт⁴⁰ заасан ажил гүйцэтгэх гэрээний гол нөхцөл болон ажил гүйцэтгэх гэрээнд тусгавал зохих бусад нөхцөлийг гэрээнд тусгасан эсэх, агуулга нь хуульд харшилсан эсэх, бичгээр байгуулж, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх;
 - (vii) Даатгалын гэрээний хувьд Иргэний хуулийн 431 дүгээр зүйлийн 431.4 дэх хэсэгт⁴¹ заасан нөхцөл болон холбогдох даатгалын хуулиудад заасан нөхцөлийг тусгасан эсэх, агуулга нь хуульд харшилсан эсэх, батлагдсан загварын дагуу бичгээр байгуулсан эсэх (батлагдсан загвараар байгуулах даатгалын гэрээний хувьд), талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх.

Нэг. Хөрөнгө итгэмжлэх буюу итгэлцлийн гэрээ болон Өрийн хэрэгсэл худалдах, худалдан авах гэрээ

Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-аас бусадтай байгуулсан хөрөнгө итгэмжлэх буюу итгэлцлийн гэрээ болон өрийн хэрэгсэл худалдах, худалдан авах гэрээнд дүн шинжилгээ хийхдээ Иргэний хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийг баримталлаа. Мөн Ашид капитал ББСБ ХХК-ийн зүгээс итгэлцэл болон үнэт цаасны үйл ажиллагаатай холбоотой баталсан дараах дүрэм, журмыг удирдлага болголоо. Үүнд:

283.3.Зээлийн гэрээгээр хүү тогтоосон бол гагцхүү талууд урьдчилан тохирсон буюу эзэлдүүлэгч зөвшөөрсөн тохиолдолд зээлийг хүүгийн хамт хугацаанаас өмнө буцаан өгч болно.

283.4.Гэрээнд өөрөөр заагаагүй бол зээлийн хүүг жил тутам төлнө.

³⁵ Иргэний хууль (2002).

318 дугаар зүйл Түрээсийн гэрээ

318.1 Түрээсийн гэрээгээр түрээслүүлэгч нь түрээслэгчийн эзэмшил, ашиглалтад аж ахуйн үйл ажиллагаа явуулах болон дүрэмд заасан зорилгоо биелүүлэхэд нь зориулж тодорхой хөрөнгө шилжүүлэх, түрээслэгч нь гэрээгээр тохирсон түрээсийн төлбөрийг төлөх үүргийг тус тус хүлээнэ.

⁴⁰ Иргэний хууль (2002).

343 дугаар зүйл Ажил гүйцэтгэх гэрээ

343.1 Ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэгч нь захиалагчийн бусад өөрийн материалаар гэрээнд заасан ажил гүйцэтгэх захиалагч нь уг ажлын үр дүнг хүлээн авч, хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ.

⁴¹ Иргэний хууль (2002).

431 дүгээр зүйл Даатгалын гэрээ

431.4. Даатгалын гэрээнд дараах нөхцөлийг тусгана:

- 431.4.1 даатгалын зүйл;
- 431.4.2 даатгалын эрсдэлийн төрөл;
- 431.4.3 даатгалын үнэлгээний хэмжээ;
- 431.4.4 даатгалын хугацаа, түүнийг дахин сунгах нөхцөл;
- 431.4.5 даатгалын хураамжийн хэмжээ, түүнийг төлөх хугацаа;
- 431.4.6 даатгагч, даатгуулагчийн эрх, үүрэг, харьцлага;
- 431.4.7 гэрээг дүгнэх, цуцлах, түүнд өөрчлөлт оруулах нөхцөл.



2023.08.18



Нүүц баримт
Эх хувь

- (i) Гүйцэтгэх захирлын 2023 оны №126/А/23 тоот тўшаалаар баталсан Итгэлцлийн үйл ажиллагааны журам;
- (ii) Бусад холбогдох дүрэм, журам.

Ашид капитал ББСБ ХХК-ийн иргэн болон хуулийн этгээдтэй байгуулсан (i) хөрөнгө итгэмжлэх буюу итгэлцлийн гэрээ; (ii) өрийн хэрэгсэл худалдах, худалдан авах гэрээ нь холбогдох хууль тогтоомж болон Үнэт цаас гаргагчийн дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дүрэм, журамд нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийлээ.

(i) Итгэлцлийн гэрээ

Ашид капитал ББСБ ХХК нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтад²² зааснаар иргэд болон аж ахуйн нэгжээс хадгаламж татан төвлөрүүлэх хориотой. Харин хувь хүн, хуулийн этгээдийн эд хөрөнгө, эрхийг түүний нэрийн өмнөөс өөрийн үйл ажиллагаанд нийцүүлэн итгэмжлэн удирдаж ашиг олж өгөх итгэлцлийн үйлчилгээ үзүүлэх боломжтой юм. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалтад итгэлцлийн үйлчилгээг "итгэл хүлээлгэгчийн актив (бэлэн мөнгө, зээл, бусад актив)-ыг үнэгүйдлээс хамгаалж, ашиг олж өгөх зорилгоор тэдгээртэй харилцан тохиролцсон гэрээний үндсэн дээр итгэл хүлээгчээс нэр бүхий активыг түр хугацаанд хянаж, ашиглах, захиран зарцуулах үйл ажиллагааг" хэлнэ гэж тодорхойлсон байна. Ашид капитал ББСБ ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 05 сарын 12-ны өдрийн №155 тоот тогтоолын дагуу итгэлцлийг үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг авсан байна.

Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК нь итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авснаас хойш Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хувь хүн, хуулийн этгээдтэй 38 (гучин найман) итгэлцлийн гэрээ байгуулсан байна. Хуулийн фирмийн зүгээс хувь хүн, хуулийн этгээдийн нүүцыг хангах, хамгаалах үүднээс итгэлцлийн гэрээтэй танилцаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчаас баталсан Итгэлцлийн гэрээний загвартай танилцсан болно. Итгэлцлийн гэрээний загварыг Ашид капитал ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны №126/А/23 тоот тогтоолын "Итгэлцлийн үйл ажиллагааны журам"-ын хавсралтаар баталсан байна.

Иргэний хуулийн 406 дугаар зүйлд²³ хөрөнгө итгэмжлэх гэрээний зохицуулалтыг тусгасан. Ашид капитал ББСБ ХХК нь иргэн, хуулийн этгээдтэй байгуулах итгэлцлийн гэрээнд хугацаа, итгэмжлэлээр шилжүүлэх мөнгөн хөрөнгийн хэмжээ, валютын төрөл, итгэмжилсэн мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах зориулалт, үр шимийн хэмжээ, үр шимээс хувь хүртэх гуравдагч этгээд байгаа бол түүний нэр, хүртэх үр шимийн хэмжээ, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах нөхцөл зэргийг тодорхойлж зохицуулсан байна. Мөн итгэмжлэл гаргасан этгээд болон үр шимийг хүртэгч гуравдагч этгээд нь хүртсэн үр шимээсээ хуульд заасан татварыг төлөх үүрэгтэй болохыг зааж оруулжээ. Үнэт цаас гаргагч нь итгэлцлийн дагуу шилжүүлэн авсан хөрөнгийг зөвхөн өөрийн үйл ажиллагаандаа ингэхдээ Санхүүгийн зохицуулах хорооноос

²² Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль (2002).

12 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хориглох зүйл

12.1. Банк бус санхүүгийн байгууллага дараахь үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

12.1.3. иргэн, хуулийн этгээдээс хадгаламж авах, хадгаламжийн данс нээх

²³ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль (2002).

406 дугаар зүйл Хөрөнгө итгэмжлэх гэрээ

406.1. Хөрөнгө итгэмжлэх гэрээгээр итгэмжлэгч нь хөдлөх эд хөрөнгө буюу эрхийг итгэмжлэгдсэн өмчлөгчид шилжүүлэх, итгэмжлэгдсэн өмчлөгч нь итгэмжилсэн хөрөнгийг хүлээн авч итгэмжлэгчийн эрх, ашиг сонирхолд нийцүүлэн, захиран зарцуулах үүрэгт тус хүлээнэ.

406.2. Хуульд өөрөөр заагаагүй бол хөрөнгө итгэмжлэх гэрээг бичгээр хийнэ.

406.3. Итгэмжлэгдсэн өмчлөгч нь итгэмжилсэн хөрөнгийг өөрийн нэрийн өмнөөс, итгэмжлэгчийн зардал, эрсдэлээ захиран зарцуулах үүрэгтэй.

406.4. Итгэмжлэгдсэн өмчлөгч гуравдагч этгээдтэй харилцаанд орлодоо өмчлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлж, үр дагаврыг нь харилцаа бөгөөд итгэмжлэгчийн ашиг сонирхолд харш үйл ажиллагаа явуулсны улмаас түүнд учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

406.5. Гэрээнд өөрөөр заагаагүй бол итгэмжлэгдсэн өмчлөгч итгэмжилсэн хөрөнгөтэй холбоотой үйл ажиллагаа явуулсны төлөө итгэмжлэгчээс хөлс авахгүй.

406.6. Итгэмжилсэн хөрөнгөс олсон орлого, үр шимийг итгэмжлэгч өмчилнө.



Нүүц баримт
Эх хувь

олгосон зөвшөөрлийн хүрээнд захиран зарцуулахаар гэрээнд тусгасан байна. Итгэмжлэгдэгч нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас хохирол учруулсан бол өөрийн хөрөнгөөс итгэмжлэгчийг хохиролгүй болгож өгөх заалтыг мөн тусгасан байна. Итгэлцлийн гэрээг талууд бичгээр байгуулан гарын үсэг зурж тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болохоор тусгасан нь Иргэний хуулийн холбогдох шаардлагыг хангаж байна гэж үзлээ.

(ii) Өрийн хэрэгсэл худалдах, худалдан авах гэрээ


Мөнгөний болон зохицуулалттай зах зээлд арилжихыг зөвшөөрсөн санхүүгийн хэрэгслийн нэг нь үнэт цаас юм. Өрийн хэрэгсэл нь үнэт цаасны нэг бөгөөд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтад өрийн хэрэгслийг "үнэт цаас гаргагчаас тогтоосон хугацаа дуусмагц үндсэн төлбөр болон хүүг мөнгөн хэлбэрээр, эсхүл тодорхой эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр тухайн үнэт цаасыг эзэмшигчид эргүүлэн төлөх үүргийг гэрчилсэн болон түүнтэй адилтгах бусад үнэт цаасыг" хэлнэ гэж заасан байна. Өөрөөр хэлбэл Ашид капитал ББСБ ХХК нь нээлттэй болон хаалттай хүрээнд өрийн бичиг (хэрэгсэл)-ийг хөрөнгө оруулагчид санал болгож худалдах ба заасан хугацааны дараа хүү, үндсэн төлбөрийг төлөх үүрэг хүлээнэ. Банк бус санхүүгийн байгууллага нь өрийн бичгийг худалдаж олсон орлогыг өөрийн үндсэн үйл ажиллагаанд зарцуулах үүрэгтэй байна. Харин өрийн бичиг худалдан авагч нь тухайн өрийн бичгийн бүсэд шилжүүлэх, худалдах зэрэг эрхтэй байдгаараа онцлогтой.

Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ээс Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж буй 2 (хоёр) Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ (хаалттай бонд гаргах)-г Хуулийн фирмд ирүүлсэн. Энэхүү гэрээг 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдөр андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгч компанитай байгуулсан байна. Тус гэрээнээс үзвэл Ашид капитал ББСБ ХХК-ийн бондыг биржийн бус зах зээлд санал болгож компанийн үйл ажиллагаанд хэрэгцээтэй мөнгөн хөрөнгө босгох, компани нь босгосон хөрөнгийн ашиглалт, эргэн төлөлтийн талаар хүсээн үүргээ хөрөнгө оруулагчдын өмнө хүлээхээр тохиролцсон байна. Гэрээнд өрийн бичгийн нийт үнэ, жилийн хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, өрийн бичгийн нийт үнийг төлж буцаан авах хугацаа зэргийг заасан байхаас гадна өрийн бичгээр төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг зөвхөн үнэт цаасны танилцуулгад заасны дагуу зарцуулах тухай нарийвчлан заасан байна. Энэхүү гэрээний дагуу 18 (арван найман) сар хүртэлх хугацаатай 35,000,000,000 (гучин таван тэрбум) төгрөг хүртэлх үнийн дүн бүхий биржийн бус хаалттай бонд гаргахаар харилцан тохиролцсон байна. Энэхүү гэрээний үүргийн гүйцэтгэлийн баталгаа болгож Барьцааны гэрээг 2021 оны 12 сарын 07-ны өдөр андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгч компанитай байгуулсан байна. Барьцааны зүйл нь 39,000,000,000 (гучин есөн тэрбум) төгрөгийн үнэлгээ бүхий хэвийн ангилалтай цалингийн цэвэр зээлийн багц байхаар заасан байна. Барьцааны гэрээний хувьд холбогдох хуулийн шаардлага хангасан хүчин төгөлдөр гэж Хуулийн фирмийн зүгээс үзлээ.

Ашид капитал ББСБ ХХК нь 2023 оны 06 сарын 07-ны өдөр андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгч компанитай "Бондын гэрээ"-г байгуулсан. Гэрээний дагуу Ашид капитал ББСБ ХХК нь нээлттэй бондыг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд санал болгож, компани нь босгосон хөрөнгөөр зээлийн багцаа нэмэгдүүлэн эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлэх зорилготой тавьсан байна. Гэрээний дагуу 12 сарын хугацаатай 20,000,000,000 (хорин тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаас гаргахаар тохиролцсон байна. Мөн гэрээнд өрийн бичгийн нийт үнэ, жилийн хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, өрийн бичгийн нийт үнийг төлж буцаан авах хугацаа зэргийг заасан байхаас гадна өрийн бичгээр төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг зөвхөн үнэт цаасны танилцуулгад заасны дагуу зарцуулах тухай нарийвчлан заасан байна. Энэхүү бондын онцлог нь барьцаагүй бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны №226 тоот тогтоолоор баталсан "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 2 дугаар зүйлийн 2.8 дахь хэсэгт заасны дагуу санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгосон байна. Өөрөөр хэлбэл Ашид капитал ББСБ ХХК нь энэхүү бондыг гаргахдаа Хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси ХХК-иар зээлжих зэрэглэлийн үнэлгээ гаргуулсан тул Санхүүгийн зохицуулах хорооны дээрх журмын зохицуулалтын дагуу эдийн болон эдийн бус хөрөнгө барьцаалахгүй байж болохоор байна.



2023.08.18



Нууц баримт
Эх хувь

Ашид капитал ББСБ ХХК нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор Симпл Ассет ТЗК ХХК-ийг үүсгэн байгуулж Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээг 2022 оны 06 сарын 23-ны өдөр байгуулсан байна. Энэхүү гэрээний дагуу ББСБ нь зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдэл нь 50,000,000,000 (тавин тэрбум) төгрөг хүртэлх цалингийн зээлийн хөрөнгө (багц) болон түүнд холбогдох эрхүүдийн хамтаар Симпл Ассет ТЗК ХХК-д худалдаж, Симпл Ассет ТЗК ХХК нь түүнийг барьцаалан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргасан байна. Симпл Ассет ТЗК ХХК нь Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу худалдан авсан зээлийн багц болон түүнтэй холбогдох эрхийн төлбөрийг мөнгөн хэлбэрээр ББСБ-д төлөхөөр заасан байна. Мөн дээрх гэрээтэй холбоотойгоор Ашид капитал ББСБ ХХК нь Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээг Симпл Ассет ТЗК ХХК болон хөрөнгө итгэмжлэн удирдагч Юнайтед айр файнэнс ХХК-тай 2022 оны 06 сарын 23-ны өдөр байгуулсан байна. Энэхүү гэрээний дагуу Ашид капитал ББСБ ХХК нь хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны төлбөрийг цаг хугацаанд нь цуглуулах, шилжүүлэх, зээлийн эрсдэлийг удирдах зэрэг үйлчилгээг үзүүлэхээр тохиролцсон байна. Энэхүү үйлчилгээг төлбөртэйгөөр үзүүлэх ба үйлчилгээний хөлс нь гэрээнд зээлийн эргэн төлөлтийн дүнгийн 1.5%-тай байхаар тусгасан байна.

Дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн итгэлцлийн гэрээ, өрийн хэрэгсэл худалдах, худалдан авах гэрээ, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбогдуулан байгуулсан гэрээ нь холбогдох хууль тогтоомж болон ББСБ-ын дотоод дүрэм, журамд нийцсэн байна гэж үзлээ. Өрийн хэрэгсэл гаргах гэрээнд Ашид капитал ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирал гарын үсэг зурж, тэмдэг даран баталгаажуулсан байх тул Иргэний хуулийн 62 дугаар зүйлийн 62.3 дахь хэсэг⁴⁴, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.8 дахь хэсэг⁴⁵ тус тус заасны дагуу хүчин төгөлдөр байна гэж дүгнэлээ.

Хоёр. Зээлийн гэрээ

Ашид капитал ББСБ ХХК-аас ирүүлсэн Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж буй гэрээ, хэлцлээс нягталж үзвэл Үнэт цаас гаргагч нь бусдаас авсан зээлгүй бөгөөд зээлийн гэрээ байгуулаагүй байна.

Монголбанкны Зээлийн мэдээллийн сангийн 2023 оны 08 сарын 11-ний өдрийн лавлагаанаас үзвэл Ашид капитал ББСБ ХХК нь Монголбанкны Зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэгч банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс авсан зээлгүй байна. Мөн Ашид капитал ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 08 сарын 15-ны өдрийн №01/3406 тоот Батламж хүргүүлэх тухай албан бичгээр гадаад улсын банк, санхүүгийн байгууллагаас санхүүжилт татсан зээлгүй болохоо тодорхойлж ирүүлсэн байна.

Иймд Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК нь бусдаас авсан зээлгүй бөгөөд зээлийн гэрээ байгуулаагүй байна гэж үзлээ.

Гурав. Үйл ажиллагаанд чухал ач холбогдол бүхий гэрээ

Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-аас бусадтай байгуулсан бүх төрлийн (i) зээлийн гэрээ, хэрэглээний зээлийн эрхийн гэрээ; (ii) барьцааны гэрээ; (iii) ипотекийн гэрээ; (iv) фидуцийн гэрээнд дүн шинжилгээ хийхдээ Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, дагалдан гарсан бусад дүрэм,

⁴⁴ Иргэний хууль (2002).

62 дугаар зүйл. Хэлцэлд төлөөлөх

62.3 Төлөөлөгчийн бүрэн эрх күүлийн дагуу бусу итгэмжлэлийн үндсэн дээр үүснэ

⁴⁵ Компанийн тухай хууль (2011).



83 дугаар зүйл. Гүйцэтгэх удирдлага

83.8 Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмээний хүрээнд хэлцэл хийж, гэрээ байгуулах, компанийн төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлтэйгээр үйл ажиллагаа явуулна.



Handwritten signature





Нүүц баримт
Эх хувь

журмуудыг баримталлаа, Мөн Ашид капитал ББСБ ХХК-ийн зүгээс зээлийн үйл ажиллагаатай холбоотой баталсан дараах дүрэм журмуудыг удирдлага болголоо, Үүнд:

- (i) Гүйцэтгэх захирлын 2023 оны №137/А/23 тоот тушаалаар батлагдсан Зээлийн бодлого;
- (ii) Гүйцэтгэх захирлын 2023 оны №149/А/23 тоот тушаалаар батлагдсан Зээлийн үйл ажиллагааны журам;
- (iii) Гүйцэтгэх захирлын 2023 оны №129/А/23 тоот тушаалаар батлагдсан Зээлийн хорооны ажиллах журам;
- (iv) Гүйцэтгэх захирлын 2020 оны №043/А/20 тоот тушаалаар батлагдсан Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний журам;
- (v) Гүйцэтгэх захирлын 2020 оны №013/А/20 тоот тушаалаар батлагдсан Факторингийн үйл ажиллагааны журам;
- (vi) Гүйцэтгэх захирлын 2021 оны №034/А/21 тоот тушаалаар батлагдсан Хэрэглээний зээлийн үйл ажиллагааны журам;
- (vii) Гүйцэтгэх захирлын 2023 оны №126/А/23 тоот тушаалаар батлагдсан Итгэлцлийн үйл ажиллагааны журам;
- (viii) Гүйцэтгэх захирлын 2020 оны №043/А/23 тоот тушаалаар батлагдсан Гадаад валютын арилжааны үйл ажиллагааны журам;
- (ix) Гүйцэтгэх захирлын 2022 оны №199/А/22 тоот тушаалаар батлагдсан Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тухай журам.

Энэхүү хэсэгт Ашид капитал ББСБ ХХК-ийн иргэн болон хуулийн этгээдтэй байгуулсан бүх төрлийн зээлийн гэрээг холбогдох хууль тогтоомж, ББСБ-ын дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дүрэм, журамд нийцсэн эсэхэд дүгнэлт өгөх болно.

Ашид капитал ББСБ ХХК-аас ирүүлсэн гэрээний жагсаалтаас үзвэл Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар 153,799 (нэг зүүн тавин гурван мянга долсон зүүн ерэн ес) зээлийн гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Зээлийн гэрээг зээлийн онцлогоор ангилан авч үзвэл дараах үзүүлэлттэй байна. Үүнд:

Хүснэгт №08. Сүүлийн 3 (гурван) жил дотор бусадтай бичгээр байгуулсан хүчин төгөлдөр зээлийн гэрээний ангилал, тоон үзүүлэлт.


№	Гэрээ	2020.05.01 - 2021.07.31	2021.08.01 - 2022.07.31	2022.08.01 - 2023.08.01	НИЙТ
1.	Дижитал зээл	3,980	78,399	70,813	153,192
2.	Бусад зээл	16	170	421	607
	НИЙТ	3,996	78,569	71,234	153,799

Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар байгуулсан хүчин төгөлдөр хэрэгжиж буй зээлийн гэрээний жагсаалтаас санамсаргүй түүврийн аргаар 37 (гучин долоон) гэрээг сонгон авч үзэж танилцлаа. Энэхүү гэрээний мэдээлэлтэй Хавсралт №02, "Ашид капитал ББСБ ХХК-ийн хуулийн этгээд, хувь хүнтэй байгуулсан зээлийн гэрээний мэдээлэл" хүснэгтээс дэлгэрүүлэн танилцана үү.

Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК нь бичил бизнес эрхлэгч, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч иргэн, хуулийн этгээд болон бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжиж, байгаль орчинд ээлтэй, экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл, тогтвортой санхүүжилтийг дэмжиж ажиллах тухай Зээлийн бодлогодоо тодорхой тусгасан байна. Зээлийн үйл ажиллагааг зориулалтаар нь бизнесийн болон хэрэглээний гэж ангилан ангилал бүрээр зээлийн бүтээгдэхүүнийг төрөлжүүлсэн байна. Ашид капитал ББСБ ХХК нь Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар 10 (арван) төрлийн зээлийн бүтээгдэхүүнийг санал болгож гэрээ байгуулсан ба гэрээ байгуулахдаа Зээлийн бодлогод тусгасан бичил, жижиг дунд бизнес эрхлэгч хувь хүн, хуулийн этгээдэд санал болгосон байна.



2023.08.18



VI. ХАВСРАЛТ

Нууц баримт
Эх хувь

Ашид капитал ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны №150/А/23 тоот тушаалаар ББСБ-ын хэмжээнд хийгдэж буй зээлийн гэрээ болон үүргийн гүйцэтгэлийг хангуулах гэрээний загварыг тус тус шинэчлэн баталсан байна.

(i) Зээлийн гэрээ

Иргэний хуулийн 281-285 дугаар зүйлд зээлийн гэрээний зохицуулалтыг хуульчилсан бөгөөд 451-453 дугаар зүйлд банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээний зохицуулалтыг нэмж тусгасан байдаг. Мөн Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 19-26 дугаар зүйлд зээлийн үйл ажиллагаа, зээлийн гэрээ, зээлийн хувийн хэргийн талаарх зохицуулалтыг илүү нарийвчлан заасан байна.

Ашид капитал ББСБ ХХК нь иргэн, хуулийн этгээдтэй байгуулах зээлийн гэрээгээр тодорхой хугацаа, хүү, үүргийн гүйцэтгэлийг хангах арга, зориулалттайгаар мөнгөн хөрөнгө зээлдүүлэх, зээлдэгч зээлийг хүү, тооцогдсон бол нэмэгдүүлсэн хүүгийн хамт эргэн төлөхтэй холбоотой талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлж зохицуулсан байна. Зээлийн хүүгийн хувь хэмжээ нь зээлийн бүтээгдэхүүнээс хамааран харилцан адилгүй байж болохоор ББСБ өөрөө тогтоосон байна. Нэмэгдүүлсэн хүүний хувьд үндсэн хүүгийн 20 (хорин) хувиар тооцож авахаар зээлийн гэрээнд тусгажээ. Дээрх заалтууд нь Иргэний хуулийн 282 дугаар зүйлийн 282.1 дэх хэсэг, 452 дугаар зүйлийн 452.1-2 дахь хэсэг, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2.5-7 дахь хэсэгтэй тус тус нийцэж байна.

Зээлийн гэрээнд зээлийн дүн, валютын төрөл, гэрээний хугацаа, зээлийн зориулалт, тухайн зээлийг хүлээн авах банк, данс, талуудын оршин байгаа, оршин суугаа газрын хаягийг мэдээлэл зэргийг оруулахаар заасан нь Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1-12 дахь заалтыг хангаж байна. Иргэний хуулийн 283 дугаар зүйлийн 283.3 дахь хэсгийг 2022 оны 11 сарын 04-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2023 оны 03 сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр зохицуулсан. Зээлийн гэрээнд зээлдэгч нь авсан зээлээ хугацаанаас нь өмнө төлж болохоор заасан хуулийн дээрх зохицуулалттай нийцэж байна.

Иргэний хуулийн 222 дугаар зүйлийн 222.5 дахь хэсэгт хүүгээс анз тооцохгүй байх тухай заасан. Өөрөөр хэлбэл зээлдэгч нь үүргээ гүйцэтгэх хугацаа хэтрүүлсэн тохиолдолд нэмэгдүүлсэн хүүг төлөх ба нэмж анз төлөхгүй. Зээлийн гэрээнд зөвхөн нэмэгдүүлсэн хүүгийн талаар заасан ба ямар нэгэн анзын талаар дурдаагүй нь хуулийн дээрх зохицуулалттай нийцэж байна. ББСБ нь зээлийн гэрээнд үүргийн гүйцэтгэлийг хангах арга болгож барьцааны гэрээ, ипотекийн гэрээ, фидуцийн гэрээ, батлан даалтын гэрээнээс аль нэгийг байгуулах эсхүл дүрдсэн бүх гэрээг байгуулж болохоор заасан байна. Эдгээр гэрээ нь тусдаа бие даасан зохицуулалттай бөгөөд зээлийн гэрээний салшгүй нэг хэсэг юм. Мөн зээлдэгч хүсвэл зээлийн гэрээг нотариатаар гэрчлүүлж болох ба дээрх дагалдах гэрээг төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, холбогдох хураамж болон гарах зардлыг зээлдэгч хариуцахаар зохицуулсан байна.

Ашид капитал ББСБ ХХК-ийн барьцаат зээлийн гэрээ нь зээлийн гэрээтэй ижил зохицуулалттай боловч зээлийн зориулалтын дагуу худалдан авсан хөрөнгөө барьцаалуулдаг онцлогтой. Энэхүү төрлийн гэрээг ихэвчлэн автомашин худалдан авахад зориулан зээл авах эсхүл автомашинаа барьцаалан зээл авахад байгуулдаг байна. Мөн барьцаа хөрөнгийг даатгуулж даатгалын хураамжийг зээлдэгч тал хариуцахаар барьцаат зээлийн гэрээнд заасан байна.

Хэрэглээний зээлийн эрхийн гэрээг дижитал зээлийн бүтээгдэхүүнд зориулан боловсруулсан байна. Энэхүү гэрээний онцлог нь зээлдэгч ББСБ-ын гар утасны аппликэйшн (application)-ыг ашиглан түүгээр дамжуулан зээл авахад зориулагдсан. Зээлдэгч уг гэрээг байгуулснаар гар утсанд суурилсан аппликэйшнаар дамжуулан зээл авах эрх нээгдэх ба зээлдэгчийн боломжид тулгүүрлан зээлийн эрхийн дээд хэмжээг тухай бүр тодорхойлдог байна.



Handwritten signature



2023.08.18

Нүүц баримт
Эх хувь

Өөрөөр хэлбэл энэ төрлийн зээлийн бүтээгдэхүүн нь зээлийн шугамтай ижил ба зээлдэгч өөрт олгогдсон хэмжээнд багтаан зээлээ гар утасны аппликэйшнаа дамжуулан шууд авах ба зээлээ төлж дууссанаар дахин зээл авах эрх нь нээгддэг байна. Мөн гар утсанд суурилсан аппликэйшнаар зээл авах бүрд тухай бүр зээлийн гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрөх байдлаар зохицуулалт хийсэн байна.

(ii) Батлан даалтын гэрээ

Батлан даалтын гэрээгээр зээлийн гэрээний дагуу төлбөрийн үүрэг хүлээсэн зээлдэгч үүргээ зөрчсөн буюу үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй эсхүл үүргээ гүйцэтгэж чадахгүй нь илт болсон тохиолдолд батлан даагч нь Ашид капитал ББСБ ХХК-ийн шаардлагын дагуу төлбөрийн үүргийг хамтран хариуцахтай холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна.

Иргэний хуулийн 459 дүгээр зүйлийн 459.3 дахь хэсэгт батлан даалтын гэрээнд батлан даагчийн хүлээх хариуцлагын дээд хэмжээг заана гэсэн байна. Мөн хуулийн 460 дугаар зүйлийн 460.4 дэх хэсэгт батлан даагч нь батлан даалтын гэрээнд заасан хэмжээгээр хариуцлага хүлээнэ гэсэн байна. Батлан даалтын гэрээнд зээлийн гэрээний үүргийг бүхэлд нь батлан даагч талаас шаардаж болохоор Ашид капитал ББСБ ХХК-ийн зүгээс оруулсан байна. Батлан даалтын гэрээнд батлан даагчийн хамтран хариуцах үүргийн хэмжээ нь зээлийн үндсэн төлбөр, хүүгийн төлбөр, нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр, барьцаа хөрөнгийг хадгалах, хамгаалах, засвар үйлчилгээ хийх, тээвэрлэх, худалдан борлуулахтай холбоотой ББСБ-ын гарсан зардал, зээлийн гэрээтэй холбоотой үүссэн маргааныг шүүхээр шийдвэрлүүлэхтэй холбоотойгоор Ашид капитал ББСБ ХХК-д учирсан хохирол, зардал, ББСБ-аас гарсан бусад зардлуудын нийлбэр дүнтэй тэнцүү байхаар заасан байна. Гэрээний энэхүү заалт нь Иргэний хуулийн 460 дугаар зүйлийн 460.5 дахь хэсэгт заасан зохицуулалттай зөрчилдөхгүй байна. Хэрэв зээлдэгч зээлийн гэрээний дагуу хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлээгүйн улмаас батлан даагч нь батлан даалтын гэрээний дагуу зээлдэгчийн хүлээсэн үүргийг бүрэн биелүүлсэн бол зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг зээлдэгчээс шаардах бүх эрх батлан даагчид шилжихээр байна.

Батлан даалтын гэрээнд зээлдэгч үндсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд батлан даагчид энэ тухай бичгээр мэдэгдэх үүргийг ББСБ хүлээхээр байна. Мөн батлан даагч нь ямар ч тохиолдолд зээлдэгчийн зээлийн гэрээний дагуу хүлээсэн үүргийн биелэлтийн талаар мэдээллийг ББСБ-аас авах эрхтэй. ББСБ нь зээлдэгчийн хүлээсэн үүрэг болон үүргийн биелэлтийн талаарх үнэн зөв мэдээллийг гаргаж өгөх үүрэг хүлээсэн байна. Энэ нь Иргэний хуулийн 462 дугаар зүйлийн 462.1-2 дахь заалтын дагуу байна гэж үзлээ.

Батлан даалтын гэрээгээр зохицуулагдаагүй, орхигдсон бусад асуудлыг Иргэний хуульд заасны дагуу зохицуулахаар гэрээнд тусгасан байна.

(iii) Барьцааны гэрээ (хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгө)

Барьцааны гэрээгээр ББСБ болон зээлдэгч нарын хооронд байгуулсан зээлийн гэрээний төлбөрийн үүргээ зээлдэгч тал нь гүйцэтгээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй бол барьцаалуулагч нь барьцааны хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хууль болон гэрээнд заасны дагуу хангахтай холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулдаг. Барьцааны гэрээг талууд бичгээр байгуулж гарын үсэг зурж тамга, тэмдэг даран баталгаажуулах ба зээлийн гэрээний нэг хэсэг байхаар заасан байна. Иргэний хуулийн 156 дугаар зүйлийн 156.1 дэх хэсэгт барьцааны гэрээг бичгээр байгуулна гэж заасан бол Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг болон 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт зааснаар барьцааны гэрээг бичгээр байгуулах ба талуудын хооронд байгуулсан гэрээнд үндэслэн барьцааны эрх үүснэ гэж зүйлчилсэн байна. Барьцааны гэрээнд харилцан тохиролцож нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах, дүүсгавар болгох, маргаан гарсан тохиолдолд харилцан тохиролцож шийдвэрлэх, маргаанаа шүүхээр шийдвэрлүүлэх эрх нь талуудад нээлттэй байхаар тусгасан байна.





Нүүц баримт
Эх хувь

Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.1 дэх хэсэг болон Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт барьцааны зүйлийг иргэний гүйлгээнээс хасагдаагүй бусдын өмчлөлд шилжүүлж болох бодитой байгаа эсхүл ирээдүйд бий болох эд хөрөнгө болон бусдын өмчлөлд шилжүүлж болох эд хөрөнгийн эрх байж болно гэж заасан. Тэгвэл ББСБ-ын зүгээс боловсруулсан барьцааны гэрээнд барьцааны зүйлийг зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар барьцаалсан хөдлөх эд хөрөнгө, түүний эрх, түүний бүрдэл хэсэг, дагалдах зүйлийг хамтад нь ойлгохоор тусгасан байна. Иргэний хуулийн 156 дугаар зүйл болон Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 10 дугаар зүйлд²⁵ барьцааны гэрээнд заавал тусгах агуулгыг заасан ба Үнэт цаас гаргагчийн байгуулж буй барьцааны гэрээнд дээрх бүх агуулга багтсан байна.

Барьцаа хөрөнгөөр хангагдах шаардлагын хэмжээг зээлийн гэрээний дагуу хүлээсэн үндсэн зээлийн хэмжээ, хүү, нэмэгдүүлсэн хүү, барьцаа хөрөнгийг худалдан борлуулахад гарсан зардал, улсын тэмдэгтийн хураамж, нөхөн төлүүлэх, шүүхийн зардал, барьцаа хөрөнгийг арчлан хамгаалахад гарсан зардал, уг эд хөрөнгөтэй холбоотой төлсөн татаар, хураамж болон ББСБ-аас гарсан зардал, хохирлын хэмжээ зэргийн нийлбэрээр хэмжигдэхээр барьцааны гэрээнд оруулсан байна. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтад барьцааны гэрээнд барьцаагаар хангагдах шаардах үүргийн хэмжээг тусгана гэж заасныг гэрээний дээрх заалт хангаж байна.

Барьцааны гэрээнд барьцаа хөрөнгийг барьцаалуулагч нь өөрийн эзэмшилд байлган бүрэн бүтэн байдал болоод засвар үйлчилгээг хариуцах ба барьцаа хөрөнгийг барьцааны гэрээний хугацаанд даатгуулах үүргийг хүлээлгэсэн байна. Харин ББСБ нь барьцаа хөрөнгийн барьцааны мэдэгдэл, тэмдэглэлийг цахим мэдээллийн санд бүртгүүлж барьцааг баталгаажуулах үүрэг хүлээсэн. Энэ тухай Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт зүйлчилсэн байна.


Зээлдэгч нь үүргээ гүйцэтгээгүй, зээлийн гэрээний хугацаа дууссан тохиолдолд ББСБ нь барьцаа хөрөнгөөс үүргийг хангуулах эрхтэй болох ба ингэхдээ холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гүйцэтгэнэ гэж заасан байна. Хуулийн фирмийн зүгээс Иргэний хуулийн 158 дугаар зүйл, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 47-49 дугаар зүйлд заасны дагуу зээлдэгчид зээлийн гэрээний үүргийг гүйцэтгэх хугацаа зааж, барьцаанаас үүргийн гүйцэтгэлийг хангуулах тухай мэдэгдлийг барьцаалуулагч талд мэдэгдэхтэй тухай заалтыг Барьцааны гэрээнд нэмж оруулахыг зөвлөж байна. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 50 дугаар зүйлд мэдэгдэлтэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан заасан ба гэрээнд энэ тухай тодорхой тусгавал цаашид гарах эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжтойг Хуулийн фирмийн зүгээс мөн зөвлөж байна.

²⁵ Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль (2015).

10 дугаар зүйл. Барьцааны гэрээний агуулга

- 10.1. Барьцааны гэрээг Иргэний хуулийн нийтлэг журам, энэ хуулийг баримтлан бичгээр байгуулах бөгөөд түүнд дараах зүйлийг тусгана:
 - 10.1.1. Барьцаалагч болон барьцаалуулагч нь иргэн бол эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, хуулийн этгээд бол өндөрсөн нэр, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаар, оршин байгаа газрын хаяг;
 - 10.1.2. Барьцаагаар хангах үүрэг, гэрээ байгуулах үед мэдэгдэж байгаа бол барьцаагаар хангагдах шаардлагын хэмжээ;
 - 10.1.3. Барьцаалагч, барьцаалуулагч талууд гэрээндээ барьцаагаар хангах үүргийг ирээдүйд үүсэх, эсхүл өөрчлөгдөж болохоор тохиролцсон бол түүнийг тодорхойлох журам, бүсэд нөхцөл;
 - 10.1.4. Барьцааны зүйлийн тодорхойлолт, түүний нэг бүрийн, эсхүл төрлийн шинжээр тодорхойлогдох байдал;
 - 10.1.5. Барьцааны гэрээний үргэлжлэх хугацаанд барьцааны зүйлийг эзэмшилдээ байлгах тал;
 - 10.1.6. Барьцааны гэрээ байгуулсан он, сар, өдөр.
- 10.2. Дараах этгээдийн талаар энэ хуулийн 10.1.1-д заасан мэдээллийг барьцааны гэрээнд тусгана:
 - 10.2.1. Үүрэг гүйцэтгэгч нь барьцаалуулагч биш бол үүрэг гүйцэтгэгчийн;
 - 10.2.2. Барьцааны зүйл нь дундын хөрөнгө бол дундаа өмчлөгчдийн;
 - 10.2.3. Үүрэг гүйцэтгүүлэгч буюу барьцаалагч нь хэд хэдэн этгээд бол үүрэг гүйцэтгүүлэгчдийн.
- 10.3. Барьцааны гэрээнд барьцаалагч, барьцаалуулагч, эсхүл тэдгээрийн төлөөлөгч гарын үсэг зурж, баталгаажуулсан байна.
- 10.4. Бичгээр байгуулаагүй барьцааны гэрээ хүчин төгөлдөр бус байна.





Нүүц баримт
Эх хувь

Иргэний хуулийн 156 дугаар зүйлийн 156.1 дэх хэсэгт барьцааны гэрээг нотариатаар гэрчлүүлж болно гэж заасны дагуу нотариатаар гэрчлүүлж холбогдон гарах зардлыг барьцаалуулагч тал хариуцахаар зохицуулжээ.

(iv) Ипотекийн гэрээ (үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа)

Ипотекийн гэрээгээр ББСБ болон зээлдэгч нарын хооронд байгуулсан зээлийн гэрээний төлбөрийн үүргээ зээлдэгч тал нь гүйцэтгээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй бол барьцаалуулагч нь барьцааны үл хөдлөх хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хууль болон гэрээнд заасны дагуу хангахтай холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулдаг. Ипотекийн гэрээг талууд бичгээр байгуулж гарын үсэг зурж тамга, тэмдэг даран баталгаажуулж улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болох ба зээлийн гэрээний нэг хэсэг байхаар заасан байна. Иргэний хуулийн 156 дугаар зүйлийн 156.1-2 дахь хэсэг болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан гэрээг заавал бичгээр байгуулж бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн байхыг шаардсан ба талуудын хооронд байгуулсан гэрээнд үндэслэн барьцааны эрх үүснэ гэж тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан байна. Ипотекийн гэрээнд харилцан тохиролцож нэмэлт, өөрчлөлт оруулах, дуусгавар болгох, маргаан гарсан тохиолдолд харилцан тохиролцож шийдвэрлэх, маргаанаа шүүхээр шийдвэрлүүлэх эрх нь талуудад нээлттэй байхаар тусгасан байна.

Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.1 дэх хэсэг болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт барьцааны зүйлийг барьцаалуулагчийн өмчлөлд байгаа Иргэний хуулийн 84 дүгээр зүйлийн 84.3 дахь хэсэгт заасан үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрх байна гэж заажээ. Тэгвэл ББСБ-ын зүгээс боловсруулсан ипотекийн гэрээнд барьцааны зүйлийг барьцаалуулагчийн хууль ёсны өмчлөлийн эрхийн болон биет байдлын доголдолгүй үл хөдлөх эд хөрөнгө, түүний бүрдэл хэсэг, дагалдах зүйл, засан сайжруулалтыг хамтад нь ойлгохоор тусгасан байна. Ипотекийн гэрээг байгуулах үед барьцаа хөрөнгийн хувьд гуравдагч этгээдийн эд хөрөнгийн эрх байгаа бол хамтран өмчлөгч тус бүрээс холбогдох зөвшөөрлийг авч баталгаажуулан ипотекийн гэрээнд хавсаргахаар зохицуулсан байна.

Иргэний хуулийн 156 дугаар зүйл болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 11 дүгээр зүйлд⁴⁷ ипотекийн гэрээнд заавал тусгах агуулгыг заасан ба ББСБ-ын байгуулж буй ипотекийн гэрээнд дээрх бүх агуулга багтсан байна.

Барьцаа хөрөнгөөр хангагдах шаардлагын хэмжээг зээлийн гэрээний дэгүү хүлээсэн үндсэн зээлийн хэмжээ, хүү, нэмэгдүүлсэн хүү, барьцаа хөрөнгийг худалдан борлуулахад гарсан зардал, улсын тэмдэгтийн хураамж, нөхөн төлүүлэх, шүүхийн зардал, барьцаа хөрөнгийг арчлан хамгаалахад гарсан зардал, үг эд хөрөнгөтэй холбоотой төлсөн татвар, хураамж болон ББСБ-аас

⁴⁷ Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай (2009).

11 дүгээр зүйл Барьцааны гэрээний агуулга

11.1 Барьцааны гэрээ /цаашид "гэрээ" гэх-г Иргэний хуулийн нийтлэг журам, энэ хуулийг баримтлан бичгээр байгуулах бөгөөд түүнд Иргэний хуулийн 156.2 т зааснаас гадна дараах зүйлийг тусгана:

11.1.1 Барьцаагаар хангагдах шаардлага, түүний хэмжээ, хэрэв үнэ буюу төлбөрийн хэмжээг урьдчилан тогтоогоогүй бол түүнийг тодорхойлох журам;

11.1.2 Барьцаагаар хангагдах үүргийг гүйцэтгэх хугацаа, үүрэг нь өөр гэрээнд үндэслэсэн бол үг гэрээний талууд, гэрээг байгуулсан сн, сар, өдөр, түүнтэй холбоотой бусад нөхцөл;

11.1.3 Барьцааны зүйлийн байршил, тухайн зүйл нь барьцаалуулагчийн өмч мөн болохыг нотлох баримт, эд хөрөнгийн өмчлөх эрхийг бүртгэсэн байгууллагын нэр, өмчлөх эрхийн гэрчилгээний дугаар;

11.1.4 Барьцааны зүйлийг өөр этгээдэд барьцаалуулсан эсэх тухай лавлагаа;

11.1.5 Барьцаагаар хангагдах үүргийг хэсэгчлэн гүйцэтгэх бол төлбөр гүйцэтгэх хугацаа, давтамж, хэмжээ, эсхүл тэдгээрийг тодорхойлох журам;

11.1.6 Барьцааны шаардлагыг хангах журам;

11.1.7 Барьцаалагчийн эрх нь барьцаалбагаар гэрчлэгдэх эсэх тухай зээлт;


11.1.8 Барьцааны зүйл нь үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой эрх бол тухайн эрхийг олж авсан гэрээний үндсэн нөхцөл, кутацаа;

11.1.9 Барьцааны зүйлтэй холбоотой гуравдагч этгээдийн эд хөрөнгийн эрх;

11.1.10 бусад

11.2 Хуульд заасан бөгөөд талууд гэрээгээр тохиролцсон бол барьцааны зүйлээс шаардлагыг шүүхээс гадуур хангаж болно.

11.3 Энэ хуулийн 11.2-т заасан гэрээнд барьцааны зүйлийг шүүхээс гадуур худалдах аргын талаар нарийвчлан заана



2023.08.18



Нүүц баримт
Эх хуль

гарсан зэрдал, хохирлын хэмжээ зэргийн нийлбэрээр хэмжигдэхээр ипотекийн гэрээнд оруулсан байна. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт барьцааны гэрээнд барьцаагаар хангагдах шаардах үүргийн хэмжээг тусгана гэж заасныг гэрээний дээрх заалт хангаж байна.

Ипотекийн гэрээнд барьцаа үл хөдлөх хөрөнгийг барьцаалуулагч нь өөрийн эзэмшилд байлган бүрэн бүтэн байдал болоод засвар үйлчилгээг хариуцах ба барьцаа үл хөдлөх хөрөнгийг барьцааны гэрээний хугацаанд даатгуулах үүргийг хүлээлгэсэн байна. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 22 дугаар зүйлд даатгалд даатгуулах эсэхийг талууд гэрээгээр тохиролцохоор нээлттэй үлдээсэн байна. Мөн ипотекийн гэрээ, барьцаалбар зэргийг бүртгэлийн байгууллагад бүртгүүлж барьцааг баталгаажуулах үүргийг барьцаалуулагч хүлээсэн. Энэ тухай Иргэний хуулийн 166 дугаар зүйл, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 12 дахь хэсэгт хуульчилсан.

Барьцаалуулагч нь барьцааны зүйлийг худалдах, арилжих, бэлэглэх зэргээр бусдын өмчлөлд шилжүүлэх мөн барьцааны зүйлийг бусдад давхар барьцаалах эрхтэй байх ба энэ тохиолдолд барьцаалагч талд заавал мэдэгдэх үүрэгтэй байхаар ипотекийн гэрээнд заажээ. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 20 дугаар зүйлд зааснаар "Барьцаалуулагч барьцааны зүйлийг зориулалтынх нь дагуу ашиглах эрхтэй" байна. Харин 30 дугаар зүйлд барьцааны зүйлийг гуравдагч этгээдэд түрээслэх, хөлслөх, үнэ төлбөргүйгээр түр ашиглуулах зорилгоор бусдын эзэмшилд шилжүүлэх эрхтэй байхаар заажээ. Хэрэв энэ эрхийг хязгаарласан гэрээний нөхцөл байгаа бол тухайн нөхцөл хүчин төгөлдөр бус байхаар зүйлчилсэн байна. Мөн хуулийн 28 дугаар зүйлд барьцааны зүйлийг өмчлөлдөө шилжүүлэн авсан этгээд өмнөх барьцаалуулагчийн эрх, үүргийг хэрэгжүүлэхээр зүйлчилсэн байна.

Эзэлдэгч нь үүргээ гүйцэтгээгүй, зээлийн гэрээний хугацаа дууссан тохиолдолд ББСБ нь барьцаа хөрөнгөөс үүргийг хангуулах эрхтэй болох ба ингэхдээ эзэлдэгчид зээлийн гэрээний үүргийг гүйцэтгэх хугацаа зааж, барьцаанаас үүргийн гүйцэтгэлийг хангуулах тухай мэдэгдлийг барьцаалуулагч талд мэдэгдэхээр ипотекийн гэрээнд заасан байна. Энэ нь Иргэний хуулийн 174 дугаар зүйл⁴⁸, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 41-42 дугаар зүйлтэй⁴⁹ нийцэж байна. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсэгт "Барьцаалагч нь тухайн эд хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар шаардахын өмнө бусад барьцаалагчид энэ тухай бичгээр мэдэгдэх үүрэгтэй" байхаар зүйлчилсэн байна. Хуулийн энэ зохицуулалтыг ипотекийн гэрээнд тусгаагүй ч ББСБ-ын зүгээс хуулийн хүрээнд ийнхүү мэдэгдэх

⁴⁸ Иргэний хууль (2002).

174 дүгээр зүйл, Үл хөдлөх эд хөрөнгийг худалдахыг шаардах

174.1 Ипотекийн шаардлагыг хангах хугацааг үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч нь үл хөдлөх эд хөрөнгийг худалдахыг шаардах эрхтэй.

174.4 Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмыг хуулиар тогтооно.

⁴⁹ Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль (2009).

41 дүгээр зүйл Үүргийн гүйцэтгэлийг шаардах

41.1 Үүрэг гүйцэтгэгч болон барьцаалуулагч нь үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол барьцаалагч нь үүргийн гүйцэтгэлийг шаардах эрхтэй.

41.2 Энэ хуулийн 41.1-д заасан барьцаалагчийн шаардлагыг биелүүлээгүй бол үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулахаар барьцааны зүйлийг худалдахыг шаардах эрхтэй.

41.3 Барьцааны зүйлийг давхар барьцаалсан бол барьцаалагч нь энэ хуулийн 41.2-т заасан эрхээ хэрэгжүүлэхдээ бусад барьцаалагч болон барьцаалуулагчид, барьцаалуулагч нь гуравдагч этгээд бол үүрэг гүйцэтгэгчид, барьцааны зүйл нь түрээсийн зүйл бол түрээслүүлэгчид үрвдчилэн мэдэгдэх үүрэгтэй.

42 дугаар зүйл Барьцаалуулагчид мэдэгдэл хүргүүлэх

42.1 Барьцаалагч нь энэ хуулийн 41.1-д заасны дагуу үүргийн гүйцэтгэлийг шаардах тухайгаа барьцаалуулагч болон үүрэг гүйцэтгэгчид бичгээр мэдэгдэнэ.

42.2 Барьцаалуулагч болон үүрэг гүйцэтгэгч нь мэдэгдэлд заасан хугацаанд хариу өгөөгүй бол барьцаалагч нь энэ тухай улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж барьцаалуулагч болон тухайн барьцааны зүйлтэй холбоотой эрхээ бүртгүүлсэн гуравдагч этгээдэд үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах тухайгаа бичгээр мэдэгдэнэ.

42.3 Энэ хуулийн 42.2-т заасан мэдэгдэлд 30 хоногийн дотор барьцаалуулагч хариу өгөөгүй буюу үүрэг биелүүлээгүй бол барьцаалагч нь барьцааны зүйлийг худалдах ажиллагааг эхлүүлнэ.

42.4 Энэ хуулийн 42.2-т заасан мэдэгдлийн мэдэгдэл болон мэдэгдлийг хүргүүлэх журмыг бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.



Нүүц баримт
Эх хувь

үүрэг хүлээх юм. Ипотекийн гэрээнд барьцааны зүйлээс үүргийг хангах дараах аргуудыг зааж талууд чөлөөтэй сонгож болохоор заажээ. Үүнд шүүхийн журмаар, шүүхээс гадуур шууд худалдах, шүүхээс гадуур дүүдлага худалдаагаар худалдах зэрэг юм. Ипотекийн гэрээнд барьцааны зүйлийг худалдах дээрх аргуудыг задлан арга түс бүрээр зохицуулалтыг тусгасан ба энэ нь Иргэний хуулийн 175-181 дүгээр зүйл, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 45-52 дугаар зүйлтэй нийцэж байгааг тэмдэглэж байна.

Иргэний хуулийн 156 дугаар зүйлийн 156.1 дэх хэсэгт барьцааны гэрээг нотариатаар гэрчлүүлж болно гэж заасан бол ипотекийн гэрээнд нотариатаар гэрчлүүлж холбогдон гарах зардлыг барьцаалуулагч тал хариуцахаар зохицуулжээ.

(v) Фидуцийн гэрээ

Үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргуудын нэг нь фидуцийн гэрээ юм. Фидуцийн гэрээгээр үүрэг гүйцэтгэгч нь мөнгөн хөрөнгө төлөх үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор хөдлөх эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлдэг онцлогтой. ББСБ-ийн хувьд фидуцийн зөвхөн автомашины өмчлөх эрхийг шилжүүлэн авдаг онцлогтой байна.

Ашид капитал ББСБ ХХК-ийн фидуцийн гэрээнд “үүрэг хүлээгч нь фидуцийн зүйлийг ББСБ-ын өмчлөлд шилжүүлэх, зээлийн гэрээний үргээ зохих ёсоор биелүүлсэн тохиолдолд уг фидуцийн зүйлийг үүрэг хүлээгчид буцаан өгөх үүрэг хүлээнэ” гэсэн байна. Энэ нь Иргэний хуулийн 235 дугаар зүйлийн 235.1 дэх хэсэгт⁵⁰ заасантай нийцэж байна.

Фидуцийн гэрээг талууд бичгээр байгуулж гарын үсэг зурж тамга, тэмдэг даран баталгаажуулах ба зээлийн гэрээний нэг хэсэг байхаар заасан байна. Иргэний хуулийн 235 дугаар зүйлийн 235.5 дахь хэсэгт фидуцийн гэрээг хуульд өөрөөр заагаагүй бол бичгээр байгуулна гэж зүйлчилсэн байна. Фидуцийн гэрээнд харилцан тохиролцож нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах, дуусгавар болгох, маргаан гарсан тохиолдолд харилцан тохиролцож шийдвэрлэх, маргаанаа шүүхээр шийдвэрлүүлэх эрх нь талуудад нээлттэй байхаар тусгасан байна.

Фидуцийн гэрээнд фидуцийн хөрөнгө гэж үүрэг хүлээгчийн хууль ёсны өмчлөлийн эрхийн болон биет байдлын доголдолгүй хөдлөх эд хөрөнгө /автомашин/ бөгөөд бусдад барьцаалуулаагүй, шилжүүлээгүй, гуравдагч этгээдийн эд хөрөнгийн эрх байхгүй байна гэж тодорхойлжээ. Фидуцийн хөрөнгийг дундаа хамтран өмчлөгч байгаа бол фидуцийн гэрээнд мөн гарын үсэг зуруулахаар заасан байна. Фидуцийн хөрөнгөөр хангагдах шаардлагын хэмжээг зээлийн гэрээний дагуу хүлээсэн үүргийн нийт дүн, барьцаа хөрөнгийг худалдан борлуулахад гарсан зардал, фидуцийн хөрөнгийг арчлан хамгаалахад гарсан зардал, болон зээлдүүлэгчээс гарсан зардал зэргийн нийлбэрээр хэмжигдэхээр фидуцийн гэрээнд оруулсан байна. Фидуцийн гэрээнд үүрэг хүлээгч нь зээлийн гэрээний дагуу зээл олгогдохоос өмнө фидуцийн хөрөнгийг зээлдүүлэгчийн өмчлөлд шилжүүлэх, эрх бүхий байгууллагад бүртгүүлж гэрчилгээ авах, даатгуулах зэрэг арга хэмжээг авч холбогдон гарах зардлыг хариуцахаар заасан байна. Фидуцийн гэрээний хугацаанд фидуцийн хөрөнгийг үүрэг хүлээгч тал нь эзэмших ашиглах эрхтэй байхаар заасан ба бүрэн бүтэн байдал болоод засвар үйлчилгээг хариуцах үүрэг хүлээнэ. Иргэний хуулийн 235 дугаар зүйлийн 235.2 дахь хэсэгт фидуцийн хөрөнгийг гэрээнд заасан бол үүрэг хүлээгч ашиглах эрхтэй байж болохоор заасан байна.

Зээлдэгч нь үүргээ гүйцэтгээгүй эсхүл гэрээний үүргээ ноцтой зөрчсөн тохиолдолд зээлдүүлэгчийн фидуцийн хөрөнгийг үл маргах журмаар захиран зарцуулж үүргийг хангуулахаар заасан байна.


⁵⁰ Иргэний хууль (2002).

235 дугаар зүйл Үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээ (фидуци)

235.1 Үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээгээр (цаашид “фидуци” гэх) үүрэг хүлээгч нь мөнгө төлөх үндсэн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор хөдлөх эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлэх, үүрэг хүлээгч үндсэн үүргээ хугацаанд гүйцэтгэсэн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч үг эд хөрөнгийг түүнд буцаан өгөх үүргийг тус тус хүлээнэ.



2023.08.18



Нүүц баримт
Эх хувь

Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн зээлийн гэрээ болон үүргийн гүйцэтгэлийг хангах бусад гэрээ нь Иргэний хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн хүчин төгөлдөр гэрээ байна гэж үзлээ. Эдгээр гэрээнд Ашид капитал ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирал гарын үсэг зурж баталгаажуулсан байх бөгөөд хэрэв орлон өөр этгээд гарын үсэг зурах бол тухай бүр Гүйцэтгэх захирал итгэмжлэл үйлдэн гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах эрхийг олгодог байна.

Дөрөв. Ашид капитал ББСБ ХХК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ

Үнэт цаас гаргагчийн зүгээс Гэрээг тасалбар болгох өдрийн байдлаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагатай байгуулсан хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад 69 (жаран есөн) гэрээний мэдээллийг ирүүлсэн ба Хуулийн фирмийн зүгээс эдгээр гэрээг үзэж танилцлаа. Эдгээр гэрээний мэдээлэлтэй Хавсралт №03. "Ашид капитал ББСБ ХХК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад хүчин төгөлдөр гэрээний мэдээлэл" хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Ашид капитал ББСБ ХХК-ийн зүгээс бусадтай байгуулсан үйл ажиллагаанд ач холбогдол бүхий бусад гэрээ гэдэгт (i) худалдах, худалдан авах гэрээ; (ii) үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээ; (iii) ажил гүйцэтгэх гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ; болон (iv) бусад гэрээнүүд багтах бөгөөд Хуулийн фирмийн зүгээс эдгээр гэрээнүүдийг хууль тогтоомж, Үнэт цаас гаргагчийн дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дүрэм, журамд нийцсэн эсэхэд дүгнэлт өгөх болно.

(i) Худалдах, худалдан авах гэрээ

Ашид капитал ББСБ ХХК-ийн бусадтай байгуулсан худалдах, худалдан авах гэрээний хувьд Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар 5 (таван) гэрээ хүчин төгөлдөр үйлчилж байна. Энэхүү гэрээний мэдээлэлтэй Хавсралт №03. "Ашид капитал ББСБ ХХК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад хүчин төгөлдөр гэрээний мэдээлэл" хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Ашид капитал ББСБ ХХК нь худалдах, худалдан авах гэрээнд дараах зохицуулалтуудыг оруулсан байна. Үүнд:

- (i) Эрхийн болон биет байдлын доголдолгүй барааг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх төлбөрийг гэрээнд заасны дагуу шилжүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах;
- (ii) Барааны шинж чанар, загвар, тоо ширхэг, үзүүлэлт, иж бүрдэл, бүрэн бүтэн байдал, баталгаа, үйлдвэрлэгчийн мэдээлэл, ашиглалтын байдал, элэгдэл зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг оруулж хавсаргах;
- (iii) Барааг нийлүүлэх хугацаа, хүргэх газар, барааны сав баглаа боодол, тээвэрлэх нөхцөл, барааг хүлээн авах, хүлээлгэн өгөх журам;
- (iv) Талуудын эрх, үүрэг;
- (v) Барааг нийлүүлэх үед болон хүлээн авсны дараа доголдолтой эсхүл гэрээнд заасан шаардлагыг хангахгүй болох нь илэрхий болсон үед талуудын авах арга хэмжээ;
- (vi) Баталгаат хугацааны явцад гарсан эвдрэл, гэмтлийг хэрхэн шийдвэрлэх тухай;
- (vii) Гэрээний үнэ, төлбөр төлөх журам;
- (viii) Талуудын хүлээх хариуцлага, хариуцлагын хэмжээ, анз;
- (ix) Гэрээг цуцлах нөхцөл болон бусад.

Талуудын эрх бүхий төлөөлөгчид гэрээнд гарын үсэг зурж тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болохоор худалдах, худалдан авах гэрээнд заасан бөгөөд Иргэний хуулийн 243-257 дугаар зүйлд худалдах худалдан авах гэрээний зохицуулалттай нийцэж байна.

(ii) Үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээ



Нүүц баримт
Эх хувь

Ашид капитал ББСБ ХХК-ийн бусадтай бичгээр байгуулсан бөгөөд Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэрээнээс үзвэл нийт 1 (нэг) түрээсийн гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Энэхүү түрээсийн гэрээний мэдээлэлтэй Хавсралт №03. "Ашид капитал ББСБ ХХК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад хүчин төгөлдөр гэрээний мэдээлэл" хүснэгтээс дэлгэрүүлэн танилцана уу.

Хуулийн фирмээс үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээг хуульд нийцсэн эсэхийг шалгахдаа Ашид капитал ББСБ ХХК-ийн түрээсэлж буй байр, талбайн хэмжээгээр үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гарсан тохиолдолд түрээсийн гэрээг Иргэний хуулийн 318 дугаар зүйлийн 318.3 дахь хэсэгт заасны дагуу улсын бүртгэлийн газрын бүртгүүлэх хуулийн зохицуулалтыг үндэслэл болгон авч үзлээ.

Ашид капитал ББСБ ХХК-ийн байгуулж буй үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээнд дараах зохицуулалтуудыг оруулсан байна. Үүнд:

- (i) Түрээслүүлэгчийн өөрийн өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийн нийт талбайгаас тодорхой талбайг албан тасалгаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж, ашиглуулахаар түрээслэгчид шилжүүлэх гэрээгээр тохирсон төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах;
- (ii) Түрээслүүлэх үл хөдлөх эд хөрөнгийн байрлал, хэмжээ, ашиглалтын нөхцөл;
- (iii) Гэрээний үргэлжлэх хугацааг тодорхой зааж гэрээний хугацаа дуусахад хэрхэн сунгах нөхцөл;
- (iv) Түрээсийн төлбөрийг тодорхой зааж, хэрхэн төлөх, үнэ өөрчлөгдөх тохиолдолд хэрхэн шийдвэрлэх;
- (v) Түрээсийн хөрөнгөтэй холбогдон гарах урсгал зардлыг хэрхэн хуваарилах, түрээсийн хөрөнгийн засан сайжруулсан тохиолдолд тухайн зардлыг хэрхэх;
- (vi) Талуудын эрх, үүрэг;
- (vii) Түрээсийн хөрөнгийг хүлээлгэн өгөх, хүлээн авах журам;
- (viii) Талуудын хүлээх хариуцлага, хариуцлагын хязгаарлалт, анз;
- (ix) Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах нөхцөл болон бусад.

Түрээсийн гэрээнд зааснаар түрээслүүлэгч тал нь гэрээг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх холбогдон гарах зардлыг хариуцах ба хэрэв энэ үүргээ хэрэгжүүлээгүй бол холбогдон гарах үр дагаврыг дангаар хариуцахаар заасан байна. Хэдийгээр түрээсийн гэрээг түрээслүүлэгч тал холбогдох төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэх үүрэг хүлээж байгаа боловч ийнхүү бүртгүүлээгүй бол гэрээ хүчин төгөлдөр бусад тооцогдох эрсдэлтэй. Ашид капитал ББСБ ХХК-ийн хувьд түрээсийн гэрээний холбогдох бүртгэлийг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн байна. Тус гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж тамга, тэмдэг даран баталгаажуулсан байх тул Иргэний хуулийн 318-320 дугаар зүйлд заасан зохицуулалттай нийцэж байна.

(iii) Ажил гүйцэтгэх гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ

Ашид капитал ББСБ ХХК-ийн бусадтай бичгээр байгуулсан бөгөөд Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй ажил гүйцэтгэх гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээний мэдээлэлтэй Хавсралт №03. "Ашид капитал ББСБ ХХК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад хүчин төгөлдөр гэрээний мэдээлэл" хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Ашид капитал ББСБ ХХК нь тухайн байгуулсан гэрээг Ажил гүйцэтгэх гэрээ, Үйлчилгээ үзүүлэх гэрээ, Хамтран ажиллах гэрээ гэж нэрлэсэн байх боловч гэрээний шинж чанар болон үүргээс хамаарч Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд⁵¹ заасан Хөлсөөр ажиллах гэрээний онцлогийг агуулсан байх тул түүгээр зохицуулагдах тохиолдол бий. Мөн зарим нэг төрлийн Хамтын ажиллагааны гэрээ, Хамтран ажиллах гэрээ нь Иргэний хуулийн 343 дугаар зүйлд⁵² заасан Ажил

⁵¹ Иргэний хууль (2002).

359 дүгээр зүйл Хөлсөөр ажиллах гэрээ

359.1. Хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллагч нь тохиролцсон ажил, үйлчилгээг гүйцэтгэх, ажилдүүлэгч хэсэг төлөх үүргийг тус тус хүлээнэ

359.2 Энэ гэрээний зүйл нь бүх төрлийн ажил, үйлчилгээ байж болно

⁵² Иргэний хууль (2002).


343 дугаар зүйл Ажил гүйцэтгэх гэрээ



Handwritten signature



2023.08.18



Ашид капитал ББСБ ХХК-ийн бусадтай бичгээр байгуулсан бөгөөд Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэрээнээс үзвэл нийт 1 (нэг) түрээсийн гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Энэхүү түрээсийн гэрээний мэдээлэлтэй Хавсралт №03. "Ашид капитал ББСБ ХХК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад хүчин төгөлдөр гэрээний мэдээлэл" хүснэгтээс дэлгэрүүлэн танилцана уу.

Хуулийн фирмээс үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээг хуульд нийцсэн эсэхийг шалгахдаа Ашид капитал ББСБ ХХК-ийн түрээсэлж буй байр, талбайн хэмжээгээр үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гарсан тохиолдолд түрээсийн гэрээг Иргэний хуулийн 318 дугаар зүйлийн 318.3 дахь хэсэгт заасны дагуу улсын бүртгэлийн газрын бүртгүүлэх хуулийн зохицуулалтыг үндэслэл болгон авч үзлээ.

Ашид капитал ББСБ ХХК-ийн байгуулж буй үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээнд дараах зохицуулалтуудыг оруулсан байна. Үүнд:

- (i) Түрээслүүлэгчийн өөрийн өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийн нийт талбайгаас тодорхой талбайг албан тасалгаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж, ашиглуулахаар түрээслэгчид шилжүүлэх гэрээгээр тохирсон төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах;
- (ii) Түрээслүүлэх үл хөдлөх эд хөрөнгийн байрлал, хэмжээ, ашиглалтын нөхцөл;
- (iii) Гэрээний үргэлжлэх хугацааг тодорхой зааж гэрээний хугацаа дуусахад хэрхэн сунгах нөхцөл;
- (iv) Түрээсийн төлбөрийг тодорхой зааж, хэрхэн төлөх, үнэ өөрчлөгдөх тохиолдолд хэрхэн шийдвэрлэх;
- (v) Түрээсийн хөрөнгөтэй холбогдон гарах урсгал зардлыг хэрхэн хуваарилах, түрээсийн хөрөнгийн засан сайжруулсан тохиолдолд тухайн зардлыг хэрхэх;
- (vi) Талуудын эрх, үүрэг;
- (vii) Түрээсийн хөрөнгийг хүлээлгэн өгөх, хүлээн авах журам;
- (viii) Талуудын хүлээх хариуцлага, хариуцлагын хязгаарлалт, анз;
- (ix) Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах нөхцөл болон бусад.

Түрээсийн гэрээнд зааснаар түрээслүүлэгч тал нь гэрээг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх холбогдон гарах зардлыг хариуцах ба хэрэв энэ үүргээ хэрэгжүүлээгүй бол холбогдон гарах үр дагаврыг дангаар хариуцахаар заасан байна. Хэдийгээр түрээсийн гэрээг түрээслүүлэгч тал холбогдох төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэх үүрэг хүлээж байгаа боловч ийнхүү бүртгүүлээгүй бол гэрээ хүчин төгөлдөр бусад тооцогдох эрсдэлтэй. Ашид капитал ББСБ ХХК-ийн хувьд түрээсийн гэрээний холбогдох бүртгэлийг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн байна. Тус гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж тамга, тэмдэг даран баталгаажуулсан байх тул Иргэний хуулийн 318-320 дугаар зүйлд заасан зохицуулалттай нийцэж байна.

(iii) Ажил гүйцэтгэх гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ

Ашид капитал ББСБ ХХК-ийн бусадтай бичгээр байгуулсан бөгөөд Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй ажил гүйцэтгэх гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээний мэдээлэлтэй Хавсралт №03. "Ашид капитал ББСБ ХХК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад хүчин төгөлдөр гэрээний мэдээлэл" хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Ашид капитал ББСБ ХХК нь тухайн байгуулсан гэрээг Ажил гүйцэтгэх гэрээ, Үйлчилгээ үзүүлэх гэрээ, Хамтран ажиллах гэрээ гэж нэрлэсэн байх боловч гэрээний шинж чанар болон үүргээс хамаарч Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд⁵¹ заасан Хөлсөөр ажиллах гэрээний онцлогийг агуулсан байх тул түүгээр зохицуулагдах тохиолдол бий. Мөн зарим нэг төрлийн Хамтын

⁵¹ Иргэний хууль (2002).

359 дүгээр зүйл. Хөлсөөр ажиллах гэрээ

359.1. Хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллагч нь тохиролцсон ажил, үйлчилгээг гүйцэтгэх, ажиллуулагч хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ.

359.2. Энэ гэрээний зүйл нь бүх төрлийн ажил, үйлчилгээ байж болно.



ажиллагааны гэрээ, Хамтран ажиллах гэрээ нь Иргэний хуулийн 343 дугаар зүйлд⁵² заасан Ажил гүйцэтгэх гэрээний хүрээнд зохицуулагдахаар байна. Өөрөөр хэлбэл холимог гэрээний хувьд тухайн гэрээний оноосон нэрээс илүүтэй гэрээний гүйцэтгэлд илүү төсөөтэй тухайн төрлийн гэрээг зохицуулсан хуулийн хэм хэмжээг анхаарах шаардлагатай. Энэ тухай Иргэний хуулийн 198 дугаар зүйлийн 198.5 дахь хэсэгт тодорхой заасан байна.

Эдгээр ажил гүйцэтгэх гэрээ нь Иргэний хуулийн 343 дугаар зүйл болон 359 дүгээр зүйлд заасан агуулгын шаардлагыг хангасан, бичгээр байгуулж, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулсан байх тул гэрээнд тавигдах агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хангасан байна гэж үзлээ.

(iv) Бусад гэрээ

Ашид капитал ББСБ ХХК-ийн бусадтай бичгээр байгуулсан бөгөөд Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бусад гэрээний мэдээлэлтэй Хавсралт №03. "Ашид капитал ББСБ ХХК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад хүчин төгөлдөр гэрээний мэдээлэл" хүснэгтээс дэлгэрүүлэн танилцана уу.

Бусад төрлийн гэрээнд нууц хадгалах гэрээ, хамтран ажиллах, төрийн байгууллагатай байгуулдаг тодорхой төрлийн гэрээ, санамж бичиг зэрэг гэрээ, хэлцэл багтаж байна.

Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан худалдах, худалдан авах гэрээ, зээлийн гэрээ, үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх гэрээ болон бусад гэрээ нь Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн хүчин төгөлдөр гэрээ байна. Эдгээр гэрээнд Ашид капитал ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирал гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

Ашид капитал ББСБ ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, тэдгээрийн хэрэгжилтийн тухайд:

Хуулийн фирм нь энэхүү асуудлын хүрээнд сүүлийн 3 (гурван) жилийн хугацаанд буюу 2020 оны 08 сарын 01-ний өдрөөс 2023 оны 08 сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд Ашид капитал ББСБ ХХК-ийн бусадтай бичгээр байгуулсан бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээг гаргуулан авч хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэрээг сонгон авч дүн шинжилгээ хийлээ. Компанийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт "Тухайн компаниас хувьцаа эзэмшигчдэд эзэмшүүлсэн буюу гаргасан нийт давуу эрхийн болон энгийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнг компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө гэх бөгөөд компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд тухайн компанийн зарласан болон эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа хамаарахгүй" гэж заасан байна.

Сүүлийн 3 (гурван) жилийн байдлаар Ашид капитал ББСБ ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 (таван) хувь нь дараах дүнтэй байна. Үүнд:

Хүснэгт №09. Ашид капитал ББСБ ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 (таван) хувь (төгрөгөөр).

№	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	2020.08.01 - 2021.07.31	2021.08.01 - 2022.08.31	2022.08.01 - 2023.08.01
1.	Хувь нийлүүлсэн хөрөнгө (төгрөг)	40,000,000,000	55,000,000,000	55,000,000,000
2.	Хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 хувь (төгрөг)	2,000,000,000	2,750,000,000	2,750,000,000

Үнэт цаас гаргагч нь гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа, ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн нийт 3 (гурван) гэрээний мэдээллийг Хуулийн фирмд гаргаж өгсөн.

⁵² Иргэний хууль (2002).
343 дугаар зүйл Ажил гүйцэтгэх гэрээ
343.1. Ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэгч нь захиалагчийн буюу өөрийн материалаар гэрээнд заасан ажил гүйцэтгэх, захиалагч нь уг зөвлөлийн үр дүнг хүлээн зөхи, хэлэлцэн тохирсон холс толох үүргийг тус тус хүлээнэ.



545

47



2023.08.18



Нүүц баримт
Эх хувь

Энэхүү гэрээний мэдээлэлтэй Хавсралт №04. “Ашид капитал ББСБ ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн хүчин төгөлдөр гэрээний мэдээлэл” хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Ашид капитал ББСБ ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ тус Ашид капитал ББСБ ХХК-аас гаргасан хаалттай бондын гэрээ байна. Энэхүү гэрээг 2021 оны 10 сарын 29-ний өдөр андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгч компанитай байгуулсан байна. Гэрээний зорилго нь Ашид капитал ББСБ ХХК-ийн бондыг биржийн бус зах зээлд санал болгож компанийн үйл ажиллагаанд хэрэгцээтэй мөнгөн хөрөнгө босгох, компани нь босгосон хөрөнгийн ашиглалт, эргэн төлөлтийн талаар хүсээн үүргээ хөрөнгө оруулагчдын өмнө хүлээх” гэж заажээ. Гэрээнд өрийн бичгийн нийт үнэ, жилийн хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, өрийн бичгийн нийт үнийг төлж буцаан авах хугацаа зэргийг заасан байхаас гадна өрийн бичгээр төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг зөвхөн үнэт цаасны танилцуулгад заасны дагуу зарцуулах тухай нарийвчлан заасан байна. Энэхүү гэрээний дагуу 18 (арван найман) сар хүртэлх хугацаатай 35,000,000,000 (гучин таван тэрбум) төгрөг хүртэлх үнийн дүн бүхий биржийн бус хаалттай бонд гаргахаар харилцан тохиролцсон байна. Энэхүү гэрээний үүргийн гүйцэтгэлийн баталгаа болгож Барьцааны гэрээг 2021 оны 12 сарын 07-ны өдөр андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгч компанитай байгуулсан байна. Барьцааны зүйл нь 39,000,000,000 (гучин есөн тэрбум) төгрөгийн үнэлгээ бүхий хэвийн ангилалтай цалингийн цэвэр зээлийн багц байхаар заасан байна. Барьцааны гэрээний хувьд холбогдох хуулийн шаардлага хангасан хүчин төгөлдөр гэж Хуулийн фирмийн зүгээс үзлээ.

Ашид капитал ББСБ ХХК нь 2023 оны 06 сарын 07-ны өдөр андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгч компанитай “Бондын гэрээ”-г байгуулсан. Гэрээний дагуу Ашид капитал ББСБ ХХК нь нээлттэй бондыг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд санал болгож, компани нь босгосон хөрөнгөөр зээлийн багцаа нэмэгдүүлэн эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлэх зорилготой тавьсан байна. Гэрээний дагуу 12 сарын хугацаатай 20,000,000,000 (хорин тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаас гаргахаар тохиролцсон байна. Мөн гэрээнд өрийн бичгийн нийт үнэ, жилийн хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, өрийн бичгийн нийт үнийг төлж буцаан авах хугацаа зэргийг заасан байхаас гадна өрийн бичгээр төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг зөвхөн үнэт цаасны танилцуулгад заасны дагуу зарцуулах тухай нарийвчлан заасан байна. Энэхүү бондын онцлог нь барьцаагүй бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны №226 тоот тогтоолоор баталсан “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын 2 дугаар зүйлийн 2.8 дахь хэсэгт заасны дагуу санхүүжих чадаахын зэрэглэл тогтоолгосон байна. Өөрөөр хэлбэл Ашид капитал ББСБ ХХК нь энэхүү бондыг гаргахдаа Хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси ХХК-аар зээлжих зэрэглэлийн үнэлгээ гаргуулсан тул Санхүүгийн зохицуулах хорооны дээрх журмын зохицуулалтын дагуу эдийн болон эдийн бус хөрөнгө барьцаалахгүй байж болохоор байна.

Үнэт цаас гаргагч нь 2023 оны 06 сарын 08-ны өдөр №3000000002 дугаартай Итгэлцлийн гэрээг байгуулсан байна. Тус гэрээний дагуу 3,000,000,000 (гурван тэрбум) төгрөгийг итгэмжлэн удирдах үүргийг Ашид капитал ББСБ ХХК хүлээсэн байна. Гэрээг байгуулахдаа Үнэт цаас гаргагчийн зүгээс баталсан гэрээний төслийг ашигласан ба гэрээг 1 (нэг) жилийн хугацаатай байгуулсан байна. Мөн гэрээний хугацаа дуусахад итгэлцлийн дагуу байршуулсан үндсэн төлбөр болоод гэрээгээр харилцан тохиролцсон хүүг цугт нь төлөх үүргийг үнэт цаас гаргагч хүлээсэн байна.

Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК нь хаалттай бондын болон барьцааны гэрээ, нээлттэй бондын гэрээ, итгэлцлийн гэрээ нь холбогдох хуулийн шаардлага хангасан хүчин төгөлдөр гэж Хуулийн фирмээс үзлээ.

Тав. Сүүлийн 3 (гурван) жилийн дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх:

Хуулийн фирм нь энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд 2020 оны 08 сарын 01-ний өдрөөс 2023 оны 08 сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд Ашид капитал ББСБ ХХК-ийн бусадтай бичгээр



Нүүц баримт
Эх хувь

байгуулсан гэрээ, хэлцэл дотор их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулагдсан эсэх, 2020 оны 08 сарын 01-ний өдрөөс өмнө байгуулагдсан хэдий ч 2023 оны 08 сарын 01-ний өдрийн байдлаар дуусгавар болоогүй хэрэгжиж байгаа их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгаа эсэх, байгаа нөхцөлд Компанийн тухай хуулийн дагуу хийгдсэн эсэх асуудлыг судалж үзлээ.

(i) Сүүлийн 3 (гурван) жилийн дотор хийгдсэн их хэмжээний хэлцэл нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх асуудлаар:

Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.1 дэх заалтад “хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шүүд холбоотой хэд хэдэн хэлцэл (компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй) болон 87 дугаар зүйлийн 87.1.2 дахь заалтад “компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шүүд холбоотой хэд хэдэн гаргалт”-ыг их хэмжээний хэлцэлд тооцохоор заасан байна.

Ашид капитал ББСБ ХХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.5.11 дэх заалтад “Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох” эрхийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд олгож тусгасан байна. Өөрөөр хэлбэл их хэмжээний хэлцэл хийх зөвшөөлийг олгоходоо Компанийн тухай хуулийн дагуу гүйцэтгэхээр дүрэмдээ тусгасан байна.

Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-аас Хуулийн фирмд ирүүлсэн аудитын байгууллагаар баталгаажсан санхүүгийн тайлангаас балансын нийт актив⁵³ болон балансын активын 25 хувийн дүнг тооцож үзвэл дараах хэмжээтэй байна. Үүнд:

Хүснэгт №10. Балансын активын 25%-ийн тоон үзүүлэлт.

№	Гэрээний нэр, төрөл	Тухайн улирлын балансын нийт актив (төгрөгөөр)	Тухайн улирлын балансын активын 25% (төгрөгөөр)
1.	2020 оны 2 улирал	9,356,388,540	2,339,097,140
2.	2020 оны 3 улирал	8,586,910,880	2,146,727,720
3.	2020 оны 4 улирал	38,507,916,270	9,626,979,070
4.	2021 оны 1 улирал	38,153,051,300	9,538,262,830
5.	2021 оны 2 улирал	53,426,586,800	13,356,646,700
6.	2021 оны 3 улирал	100,284,663,190	25,071,165,800
7.	2021 оны 4 улирал	129,754,908,200	32,438,727,050
8.	2022 оны 1 улирал	149,063,797,170	37,265,949,290
9.	2022 оны 2 улирал	159,326,672,830	39,831,668,210
10.	2022 оны 3 улирал	168,367,863,390	42,091,965,850
11.	2022 оны 4 улирал	172,172,512,430	43,043,128,110
12.	2023 оны 1 улирал	178,131,660,400	44,532,915,100

Дээрх хүснэгтэд тусгагдсан Үнэт цаас гаргагчийн хэлцэл хийхийн өмнөх балансын сүүлийн балансын активын 25 хувийн дүн болон ББСБ-аас ирүүлсэн гэрээ, хэлцэл, мэдээлэлд үндэслэж үзвэл Ашид капитал ББСБ ХХК нь дурдсан хугацааны дотор их хэмжээний 3 (гурван) хэлцэл байгуулсан байна.

Үнэт цаас гаргагч нь 2021 оны 06 сарын 02-ны өдөр М-Си-Эс холдинг ХХК-тай Хоёрдогч өглөг байршуулах гэрээг байгуулсан байна. Гэрээний дагуу үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, үндсэн үйл ажиллагааг дэмжих зорилгоор 30,000,000,000 (гучин тэрбум) төгрөгийг 5 (таван) жилийн хугацаатай байршуулсан бөгөөд жилийн 13%-ийн хүү төлөхөөр тохиролцсон байна. Гэрээний дагуу хүүг хагас жил тутам төлөх ба гэрээний хугацаа дуусахад үндсэн төлбөрийг тухайн

⁵³ “Балансын нийт ажил” гэдэгт Санхүү байдлын тайлангийн 2.4 дэх мөр (хэтгээ үзүүлэлт) буюу “Ор төлбөр ба Эвдийн өмг” гэсэн үзүүлэлтийн эцсийн үлдэгдэл гэсэн харгалзах баганад (босоо үзүүлэлт) байгаа мөнгөн хөрөнгийг тооцож ойлгосон болно. Хуулийн Фирм.



547



2023.08.18



2023
ГҮРТГЭВ-03

үеийн нэгж хувьцааны нэрлэсэн үнээр нь үнэт цаас гаргагчийн энгийн хувьцаанд хөрвүүлэх замаар төлж барагдуулахаар харилцан тохиролцсон байна. Мөн талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг болон хоёрдогч өглөгийг буцаан дуудах нөхцөл зэргийг гэрээгээр нарийвчлан тохирсон байна. Энэхүү гэрээг байгуулах зөвшөөрлийг Ашид капитал ББСБ ХХК-ийн ТУЗ-өөс 2021 оны 05 сарын №014 тоот тогтоолоор олгосон байна. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 07 сарын №184 дугаар тушаалаар энэхүү хоёрдогч өглөгийг татах зөвшөөрлийг авсан байна.

Үнэт цаас гаргагч нь мөн 2021 оны 09 сарын 17-ны өдөр М-Си-Эс холдинг ХХК-тай дахин Хоёрдогч өглөг байршуулах гэрээг байгуулсан байна. Энэхүү гэрээний дагуу 20,000,000,000 (хорин тэрбум) төгрөгийг 5 (таван) жилийн хугацаатай байршуулсан бөгөөд жилийн 13%-ийн хүү төлөхөөр тохиролцсон байна. Гэрээний дагуу хүүг хагас жил тутам төлөх ба гэрээний хугацаа дуусахад үндсэн төлбөрийг тухайн үеийн нэгж хувьцааны нэрлэсэн үнээр нь үнэт цаас гаргагчийн энгийн хувьцаанд хөрвүүлэх замаар төлж барагдуулахаар харилцан тохиролцжээ. Ашид капитал ББСБ ХХК-ийн ТУЗ-өөс 2021 оны 08 сарын №04 тоот тогтоолоор энэхүү гэрээг байгуулах зөвшөөрлийг олгосон байна. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 10 сарын №272 дугаар тушаалаар энэхүү хоёрдогч өглөгийг татах зөвшөөрлийг авсан байна.

Ашид капитал ББСБ ХХК нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор Симпл Ассет ТЗК ХХК-ийг үүсгэн байгуулж Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээг 2022 оны 06 сарын 23-ны өдөр байгуулсан байна. Энэхүү гэрээний дагуу ББСБ нь зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдэл нь 50,000,000,000 (тавин тэрбум) төгрөг хүртэлх цалингийн зээлийн хөрөнгө (багц) болон түүнд холбогдох эрхүүдийн хамтаар Симпл Ассет ТЗК ХХК-д худалдаж, Симпл Ассет ТЗК ХХК нь түүнийг барьцаалан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргасан байна. Симпл Ассет ТЗК ХХК нь Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу худалдан авсан зээлийн багц болон түүнтэй холбогдох эрхийн төлбөрийг мөнгөн хэлбэрээр ББСБ-д төлөхөөр заасан байна. Мөн дээрх гэрээтэй холбоотойгоор Ашид капитал ББСБ ХХК нь Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээг Симпл Ассет ТЗК ХХК болон хөрөнгө итгэмжлэн удирдагч Юнайтед айр фاینэнс ХХК-тай 2022 оны 06 сарын 23-ны өдөр байгуулсан байна. Энэхүү гэрээний дагуу Ашид капитал ББСБ ХХК нь хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны төлбөрийг цаг хугацаанд нь цуглуулах, шилжүүлэх, зээлийн эрсдэлийг удирдах зэрэг үйлчилгээг үзүүлэхээр тохиролцсон байна. Энэхүү үйлчилгээг гөлбөртэйгөөр үзүүлэх ба үйлчилгээний хөлс нь гэрээнд зээлийн эргэн төлөлтийн дүнгийн 1.5%-тай байхаар тусгасан байна. Ийнхүү гэрээ байгуулах эрхийг Ашид капитал ББСБ ХХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 06 сарын №09 тоот тогтоолоор зөвшөөрсөн байна.

Иймд Хуулийн фирмийн зүгээс нэгтгэн дүгнэж үзвэл гэрээ, хэлцлийг тасалбар болгосон өдрийн байдлаар Ашид капитал ББСБ ХХК-ийн бусадтай бичгээр байгуулсан их хэмжээний хэлцэл нь хуульд нийцсэн, хуульд заасан журам болон компанийн дүрэмд нийцсэн хүчин төгөлдөр гэрээ гэж дүгнэлээ.

(ii) Сүүлийн 3 (гурван) жилийн дотор хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх асуудлаар:

Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагчаас 2020 оны 08 сарын 01-ний өдрөөс 2023 оны 08 сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд бусадтай бичгээр байгуулсан нийт гэрээ, хэлцлийн дотор сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулагдсан эсэх, байгуулагдсан нөхцөлд Компанийн тухай хуулийн дагуу хийгдсэн эсэхийг судалж үзлээ.

Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэгт "Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай Компанийн тухай хуульд тодорхойлсон харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно" гэж тодорхой заасан байна.



Сонирхлын зөрчилтэй хэлцлийн хувьд Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасан журмын дагуу байгуулдаг бөгөөд тус хэсэгт “сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг үг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал)-ын гишүүдийн олонхын саналаар гаргана”, 92 дугаар зүйлийн 92.2 дахь хэсэгт “Сонирхлын зөрчилтэй хэлцлээр худалдах, худалдан авах, захиран зарцуулах эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрхийн зах зээлийн үнэ, үйлчилгээний хөлсний хэмжээг энэ хуулийн 55 дугаар зүйлд заасан журмын дагуу төлөөлөн удирдах зөвлөл тогтооно” гэж тодорхойлсон байна. Мөн сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох эрхийг Ашид капитал ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд олгосон нь ББСБ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.5.10 дахь заалтад зааснаар нотлогдож байна. Мөн энэ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалтад⁵⁴ заасантай нийцэж байна.

Компанийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.3 дахь хэсэгт⁵⁵ заасны дагуу компани нэгдмэл сонирхолтой этгээдийн бүртгэлийг тухай бүр хөтлөх үүрэгтэй бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд өөрийн хувийн байдлын талаар мэдээлэл өгөх хуулиар ногдуулсан үүрэгтэй байна. Хуулийн фирм нэгдмэл сонирхолтой этгээдийг тодорхойлохдоо Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-аас гаргаж өгсөн баримт материалд үндэслэсэн бөгөөд эдгээр баримт материал нь Компанийн тухай хуулийн 89.1 дэх хэсэгт⁵⁶ заасан шаардлагыг бүрэн хамарсан эсэх болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд хэлцэл хийхдээ сүүлийн 3 (гурван) жилийн хугацаанд компанид тухай бүр мэдээлэх үүргээ биелүүлсэн эсэх асуудлаар бие даан дүн шинжилгээ хийх, баталгаа гаргах боломжгүй байгааг анхаарна уу.

Ашид капитал ББСБ ХХК-ийн зүгээс 2020 оны 08 сарын 01-ний өдрөөс 2023 оны 08 сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд байгуулагдсан гэрээ, хэлцлийн жагсаалт болон ББСБ-аас ирүүлсэн мэдээлэлд үндэслэж үзвэл тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа нийт 10 (арван) сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл байна. Ашид капитал ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дараах тогтоолоор сонирхлын зөрчилтэй хэлцлийг байгуулах зөвшөөрөл олгосон байна. Үүнд:

- (i) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 06 сарын 07-ны өдрийн №03/01 тоот тогтоолоор М-Си-Эс Холдинг ХХК-тай байгуулах хэлцэл;
- (ii) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 09 сарын 13-ны өдрийн №06/01 тоот тогтоолоор М-Си-Эс Холдинг ХХК-тай байгуулах хэлцэл;
- (iii) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 07 сарын 28-ны өдрийн №126 тоот тогтоолоор М Армор ХХК-тай байгуулах хэлцэл;

⁵⁴ Компанийн тухай хууль (2011).

76 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх

76.1 Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ хууль болон компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

76.1.17 энэ хуулийн арван хоёрдугаар бүлэгт тодорхойлсон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

⁵⁵ 91 дүгээр зүйл.Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тавих шаардлага.

91.3 Компани өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтөлж, сонирхож этгээд үзэх боломжоор хангах үүрэгтэй.

⁵⁶ Компанийн тухай хууль (2011).

89 дүгээр зүйл.Сонирхлын зөрчил бүхий этгээд.

89.1 Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно:

89.1.1 хэлцлийн нөгөө тал, эсхүл хэлцэлд төлөөлөгч буюу зүүчлэгчээр оролцож байгаа;

89.1.2 хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл үг хэлцэлд төлөөлөгч буюу зүүчлэгчээр оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20-оос дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;

89.1.3 хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл төлөөлөгч буюу зүүчлэгчээр оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл үг компанийн энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;

89.1.4 хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа.



51



2023.08.18

Нууц баримт
Эх хувь

- (iv) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 сарын 02-ны өдрийн №02 тоот тогтоолоор М Банк ХХК-тай байгуулах хэлцэл;
- (v) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 сарын 02-ны өдрийн №01 тоот тогтоолоор М-Эс-Си Холдинг ХХК-тай байгуулах хэлцэл;
- (vi) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 сарын 02-ны өдрийн №02 тоот тогтоолоор М Банк ХХК-тай байгуулах хэлцэл;
- (vii) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 сарын 02-ны өдрийн №01 тоот тогтоолоор М-Эс-Си Холдинг ХХК-тай байгуулах хэлцэл;
- (viii) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 сарын 02-ны өдрийн №02/02 тоот тогтоолоор Шангри-Ла Улаанбаатар Хотел ХХК-тай байгуулах хэлцэл;
- (ix) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 07 сарын 26-ны өдрийн №12 тоот тогтоолоор 2021 онд М-Си-Эс Холдинг ХХК-тай байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хэлцэл;
- (x) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 07 сарын 26-ны өдрийн №13 тоот тогтоолоор М Банк ХХК-тай байгуулах хэлцэл.

Эдгээр хүчин төгөлдөр хэрэгжиж буй сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийн жагсаалт, гэрээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт №05. "Ашид капитал ББСБ ХХК-ийн хүчин төгөлдөр хэрэгжиж буй сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийн мэдээлэл" хүснэгтээс дэлгэрүүлэн үзэж танилцана уу.

Дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-аас нэгдмэл сонирхолтой этгээдтэй байгуулсан хүчин төгөлдөр хэрэгжиж буй 10 (арван) сонирхлын зөрчилтэй хэлцлийг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлөөс зөвшөөрөл авч байгуулсан байх тул Компанийн тухай хуульд заасан журмын дагуу хийгдсэн байна гэж үзлээ.

Зургаа. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой, сөргөөр нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх асуудлаар:

Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагчийн зүгээс үйл ажиллагаа эрхлэхдээ хууль тогтоомжид заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авахыг хуульчилсан буюу тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагааг тогтоосон хугацаа нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз гэсэн шалгуурын хүрээнд ойлгож дүн шинжилгээ хийлээ.

Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 02 сарын 12-ны өдрийн №68 тоот тогтоолоор Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл⁵⁷ авсны үндсэн дээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Хуулийн дүгнэлт гарах өдрийн байдлаар Ашид капитал ББСБ ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон дараах 5 (таван) тусгай зөвшөөрлийг⁵⁸ эзэмшиж байна. Үүнд:

⁵⁷ Санхүүгийн зохицуулах хороо

<http://www.frc.mn/co/190791>

Банк бус санхүүгийн байгууллага, Ашид капитал ББСБ ХХК-ийн тусгай зөвшөөрлийн талаарх нээлттэй мэдээлэл.

⁵⁸ 7 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа

7.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа гэж дараахь үйл ажиллагааг ойлгоно:

7.1.1. зээл;

7.1.2. факторингийн үйлчилгээ;

7.1.3. Энэ зарлыг 2006 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар хүчингүй болгонд тасалсан.

7.1.4. төлбөрийн баталгаа гаргах;

7.1.5. төлбөр тооцооны хэрэгсэл гаргах;

7.1.6. цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвүүлгын үйлчилгээ;

7.1.7. гадаад валютын арилжаа;

7.1.8. итгэлцлийн үйлчилгээ;

7.1.9. бигинг хугацаат санхүүгийн харагсалд хөрөнгө оруулалт хийх;

7.1.10. жишээ оруулалт, санхүүгийн ниглээгээр зөвлөгөө, мэдээлэл өгөх.

Энэ зарлыг 2023 оны 01 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар хүчингүй болгонд тасалсан.

7.1.11. үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа.

Энэ зарлыг 2023 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн.



Нүүц баримт
Эх хувь

Хүснэгт №11. Үнэт цаас гаргагчийн эзэмшиж буй үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн мэдээлэл.

№	Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа	СЭХ-ны зөвшөөрлийн огноо, дугаар	Хүчинтэй эсэх Тийм/Үгүй
1.	Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх	2020.02.12 №68	Тийм СЭХ 2023.08.16 №9/3212
2.	Факторингийн үйлчилгээ	2020.02.12 №68	
3.	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	2020.02.12 №68	
4.	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2022.09.21 №456	
5.	Итгэлцлийн үйлчилгээ	2023.05.12 №155	

Ашид капитал ББСБ ХХК нь хуулийн этгээд болохын хувьд эрх зүйн бүрэн чадамжтай, татвар төлөгчөөр бүртгүүлсэн байх зөвшөөрөл эзэмшигчид тавигдах нийтлэг шаардлага⁵⁹ хангаж байгаа бөгөөд эрхлэх үйл ажиллагаа нь 2022 оны 06 сарын 27-ны өдөр шинэчлэн батлагдсан Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг⁶⁰ буюу зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагаанд хамаарч байна.

Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээнээс үзвэл Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 02 сарын 12-ны өдөр №68 тоот тогтоолоор банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 02 сарын 12-ны өдрийн №68 тоот тогтоолоор банк бус санхүүгийн зээл олгох, факторингийн үйлчилгээ болон төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 09 сарын 21-ний өдрийн №456 тоот тогтоолоор богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 05 сарын 12-ны өдрийн №155 тоот тогтоолоор итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус авсан байна.

Иймд Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн эзэмшиж байгаа Санхүүгийн зохицуулах хорооноос олгогдсон 5 (таван) тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр бөгөөд тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох аливаа нөхцөл үүсээгүй байна гэж Хуулийн фирмийн зүгээс үзлээ.

Хуулийн фирмийн зүгээс Үнэт цаас гаргагч нь аливаа зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг эзэмшдэг эсэх, тэдгээр нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн асуудлаар Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн Ашид капитал ББСБ ХХК-ийн нэр дээр олгогдсон зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр бөгөөд тэдгээрийн хугацаа дуусах,

⁵⁹ Зөвшөөрлийн тухай хууль (2022).

Дөрөвдүгээр бүлэг Зөвшөөрөл хүсэгч, эзэмшигчид тавигдах нийтлэг шаардлага, зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг 4 дүгээр зүйл Зөвшөөрөл хүсэгч, эзэмшигчид тавигдах нийтлэг шаардлага

1.Энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан зөвшөөрлийн үйл ажиллагааг эрхлэх этгээд дараах нийтлэг нөхцөл, шаардлагыг хангасан байна:

- 1.1.иргэний эрх зүйн бүрэн чадамжтай байх;
- 1.2.хуульд заасан бол мэргэжил, мэргэшлийн шалгалтад тэнцсэн, зохих дүгнэлт гаргуулсан байх;
- 1.3.татвар төлөгчөөр бүртгүүлсэн байх.

⁶⁰ Зөвшөөрлийн тухай хууль (2022).


Наймдугаар бүлэг Зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагаа

8.1 дүгээр зүйл Тусгай зөвшөөрлийн жагсаалт

2.Банк, банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

- 2.8.Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ эрхлэх;
- 2.9.банк бус санхүүгийн зээл олгох үйл ажиллагаа эрхлэх;
- 2.10.банк бус санхүүгийн цахим төлбөр тооцоо, мангос гүйвүүлгын үйлчилгээ эрхлэх;
- 2.11.банк бус санхүүгийн факторингийн үйлчилгээ эрхлэх;
- 2.31.банк бус санхүүгийн богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх.





Нүүц баримт
Эх хувь

цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэх талаар дэлгэрүүлэн авч үзлээ.

Оюуны өмчийн газрын цахим мэдээллийн сангаас⁶¹ 2023 оны 08 сарын 15-ны өдрийн байдлаар хайлт хийж үзвэл Ашид капитал ББСБ ХХК-ийн нэр дээр 2 (хоёр) зохиогчийн эрх, 8 (найман) барааны тэмдэг бүртгэгдэж зохиогчийн эрх, барааны тэмдгийн гэрчилгээ авсан байна. Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэгдэж эрхийн хамгаалалт хийгдсэн зохиогчийн эрх болон барааны тэмдгийн мэдээллийг Хавсралт №06. "Ашид капитал ББСБ ХХК-ийн нэр дээр бүртгэгдсэн оюуны өмч, тохирлын гэрчилгээний талаарх мэдээлэл" хүснэгтээс дэлгэрүүлэн танилцана үү.

Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй зохиогчийн эрх болон барааны тэмдэг нь аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх асуудлын хувьд Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг⁶² заасны дагуу хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийн бүртгэх цахим мэдээллийн сангийн 2023 оны 08 сарын 15-ны өдрийн байдлаар бүртгэлээс хайлт хийж үзвэл Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй барааны тэмдгийн барьцаатай холбоотой мэдээлэл байхгүй болохыг дурдаж байна. Иймд Ашид капитал ББСБ ХХК-ийн нэр дээр бүртгэгдэж, эрхийн хамгаалалт хийгдсэн 2 (хоёр) зохиогчийн эрх, 8 (найман) барааны тэмдэг нь хүчин төгөлдөр бөгөөд аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээгээгүй байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК нь Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо-олон улсын ISO 27001:2013 стандартыг Бизнес Систем Сертификэйшн Птуая, ЭлТиДи (Business Systems Certification Pty.Ltd)-аар⁶³ 2023 оны 06 сарын 25-ны өдөр баталгаажуулж, үйл ажиллагаандаа мөрдөж байгаа болохыг дурдаж байна.

Нэгтгэн дүгнэж үзвэл Ашид капитал ББСБ ХХК-ийн нэр дээр олгогдсон үйл ажиллагааны түсгэй зөвшөөрөл, барааны тэмдэг нь хүчин төгөлдөр бөгөөд тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээгүй байна гэж дүгнэлээ.

Долоо. Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх асуудлаар:

Ашид капитал ББСБ ХХК нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн зохицуулалтын хүрээнд богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх буюу хөрөнгө оруулалтын үнэт цаас болон бүнтэй адилтгах санхүүгийн хэрэгсэлд хөрвүүлэх банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг. Үнэт цаас гаргагч нь Хуулийн дүгнэлт үйлдэх өдрийн байдлаар биржийн бус зах зээл дээр арилжаалагдсан дараах 5 (таван) богино хугацаат санхүүгийн хэрэгсэл эзэмшиж байна. Үүнд:

Хүснэгт №12. Үнэт цаас гаргагчийн эзэмшиж үнэт цаасны дэлгэрэнгүй мэдээлэл.

№	Үнэт цаасны нэр	Төрөл	Эхлэх	Дуусах	Нийт үнийн дүн (төгрөгөөр)	Санхүүгийн тайланд тусгагдсан эсэх
1.	Хан Алтай	Хаалттай өрийн бичиг	2023.07.27	2023.09.27	1,500,000,000	Тийм
2.	KAR1	Хаалттай өрийн бичиг	2023.07.27	2023.09.27	500,000,000	Тийм
3.	Мастер Түншлэл	Хаалттай өрийн бичиг	2023.07.27	2023.09.27	1,000,000,000	Тийм
4.	АБТС	Хаалттай өрийн бичиг	2023.01.13	2024.01.13	1,000,000,000	Тийм
5.	Бэрс бонд	Хаалттай өрийн бичиг	2023.01.06	2024.01.06	1,000,000,000	Тийм

⁶¹Оюуны өмчийн газар, Зохиогчийн эрхийн мэдээлэл
http://copyright.ipom.mn/copyright_info.aspx?id=1011200525120109397
http://www.ipom.mn/copyright_info.aspx?id=1011200525120241900

⁶² Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль (2015).
 7 дугаар зүйл. Барьцааны зүйл
 7.1. Иргэний гүйлгээнээс хасагдаагүй бусдын өмчлөлд шилжүүлж болох бодитой байгаа, эсхүл ирээдүйд бий болох хөдлөх эд хөрөнгө, бүх төрлийн хувицаа, үнэт цаас, шаардах эрх, шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүх төрлийн бүтээл, шинэ бүтээл, битээгдэхүүний загвар, барааны тэмдэг, ашигтай загвар болон бусад хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө нь барьцааны зүйл байж болно.

⁶³ <http://www.iso.org/iso/home/standards/bodies.htm>





Нүүц баримт
Эх хувь

өрийн бичгийн үндсэн төлбөр болон хүүгийн төлөгдөх хугацаа гэрээний хугацаандаа байх тул Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдын өмнө хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллаж байна гэж үзэх үндэслэлтэй байна.

Үнэт цаас гаргагчийн эзэмшиж буй үнэт цаас, санхүүгийн хэрэгсэлд аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх, барьцааны эрх үүсгэсэн эсэх талаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас⁶⁶ нягталж үзэхэд аливаа үүрэг ногдуулсан мэдээлэл байгаагүй.

Иймд төрийн эрх бүхий байгууллагын тодорхойлолт болон Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэлд Ашид капитал ББСБ ХХК-ийн нэр дээрх 6 (зургаан) үнэт цаас эзэмших эрх нь хүчин төгөлдөр бөгөөд үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн хэлцэл хийгдээгүй байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Үнэт цаас гаргагч Ашид капитал ББСБ ХХК-ийн өмчлөх болон эзэмших эрх бүхий 1 (нэг) тээврийн хэрэгслийг өөрийн үйл ажиллагаанд ашигладаг, үндсэн хөрөнгө мөн бөгөөд хөрөнгийн үнэлгээнд орсон гэсэн мэдээллийг Хуулийн фирмд ирүүлсэн. Мөн Үнэт цаас гаргагч нь банк бус санхүүгийн үйл ажиллагааны хүрээнд гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэх буюу фидуци⁶⁷ гэрээний дагуу 570 (таван зуун далан) тээврийн хэрэгслийг Ашид капитал ББСБ ХХК-ийн өмчлөлд шилжүүлж, Автовээрийн үндэсний төвд бүртгэл хийлгэсэн байна.

Үнэт цаас гаргагчийн тээврийн хэрэгслийн хувьд Автотээврийн үндэсний төвийн 2023 оны 08 сарын 10-ны өдрийн Тээврийн хэрэгслийн лавлагаанаас үзвэл Ашид капитал ББСБ ХХК-ийн нэр дээр 570 (таван зуун далан) тээврийн хэрэгсэл бүртгэлтэй болохыг тодорхойлсон байна.

Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй тээврийн хэрэгсэл нь аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх талаар Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийн бүртгэх цахим мэдээллийн сангийн бүртгэлээс⁶⁸ 2023 оны 08 сарын 15-ны өдрийн байдлаар шалгахад Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй тээврийн хэрэгслийн барьцаатай холбоотой мэдээлэл байхгүй болохыг дурдаж байна.

Иймд Үнэт цаас гаргагчаас гаргаж өгсөн мэдээлэл болон Авто тээврийн үндэсний төвөөс ирүүлсэн лавлагааг үндэслэн Ашид капитал ББСБ ХХК-ийн 1 (нэг) тээврийн хэрэгсэл өмчлөх эрх нь хүчин төгөлдөр бөгөөд Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн хэлцэл хийгдээгүй байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Ашид капитал ББСБ ХХК нь аливаа төрлийн үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрх байхгүй талаарх мэдээллийг Хуулийн фирмд ирүүлсэн.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Газрын нэгдмэл удирдлагын 2023 оны 08 сарын 15-ны өдрийн цахим системийн нээлттэй мэдээллээс үзвэл Үнэт цаас гаргагч нь газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх хэрэгжүүлдэг талаар мэдээлэл гарч ирээгүй болохыг дурдаж байна.

Иймд Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэл болон төрийн эрх бүхий байгууллагын лавлагаанд үндэслэн Ашид капитал ББСБ ХХК нь аливаа газар үл хөдлөх хөрөнгө өмчлөдөггүй болохыг дурдаж байна.

⁶⁶ <https://mnr.gov.mn>
Зөвхөн тодорхой өмчлөгчийн хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн хувьд барьцааны эрх үүсэнийг олон нийтэд нээлттэй мэдэгдэх болон барьцааны эрхийн даргааллыг тогтоох зорилго бүхий УБЕГ-ийн цахим сан.
⁶⁷ Иргэний хууль (2002).
⁶⁸ Дугаар зүйл Үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээ (фидуци)
/35.1.Үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээгээр /цаашид "фидуци" гэх/ үүрэг хүлээгч нь мөнгө тэнлэх үндсэн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор хөдлөх эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлэх, үүрэг хүлээгч үндэн үүргээ хугацаанд гүйцэтгэсэн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч үг эд хөрөнгийг түүнд буцаан өгөх үүргийг тус тус хүлээнэ.
⁶⁹ <https://mnr.gov.mn/search>



Хуулийн фирмийн зүгээс өмчлөх эрхийг баталгаажуулах боломжгүй бусад хөрөнгийн хувьд тусгайлан дүгнэлт хийгээгүй бөгөөд шалгуур асуултын хүрээнд Үнэт цаас гаргагчийн эзэмшиж байгаа эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх асуудлаар холбогдох баримт материал, төрийн эрх бүхий байгууллагын баримт материал дээр үндэслэн дүн шинжилгээ хийсэн болохыг дурдаж байна. Түүнчлэн өмчлөх эрхийг баталгаажуулах боломжгүй бусад хөрөнгө болон Хөрөнгийн үнэлгээний тайлан болон Үнэт цаас гаргагчийн санхүү байдлын тайланд тусгагдсан хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг баталгаажуулах боломжгүй тул хөрөнгөтэй холбоотой асуудлаар Үнэт цаас гаргагчаас тодруулж асууна уу.

Нэгтгэн дүгнэж үзвэл Ашид капитал ББСБ ХХК-ийн эзэмшил/өмчлөлд байгаа дурдсан хөрөнгө өмчлөх эрх хүчин төгөлдөр бөгөөд тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах нөхцөл байдал үүсээгүй бөгөөд үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээгээгүй байна гэж Хуулийн фирмээс дүгнэлээ.

Найм. Үнэт цаасыг бүртгүүлэх танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх асуудлын хувьд үзвэл:

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт “Үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг энэ хуулийн 33.2.1 дэх заалтад заасан хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэхийг энэ хуулийн 33.2.3 дахь заалтад заасан аудитын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр тус тус хянуулж, дүгнэлт гаргуулна” гэж заасны дагуу тус Хуулийн фирм нь Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээллийг нягталж нийтэд илэрхий мэдээ баримт, төрийн болон эрх бүхий байгууллагуудаас гаргаж өгсөн лавлагаа, тодорхойлолт, Үнэт цаас гаргагчийн зүгээс гаргаж өгсөн баримт бичигт харьцуулсан дүн шинжилгээ хийсэн.

Хуулийн фирм нь андеррайтер компани Голомт Капитал ҮЦК ХХК, туслах андеррайтер Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК-ийн бэлтгэсэн Үнэт цаасны танилцуулгатай танилцаж дүн шинжилгээ хийсэн бөгөөд Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий Үнэт цаас гаргагчийн оноосон нэр, оршин байгаа газрын хаяг, регистрийн дугаар, хувьцаа эзэмшигчийн мэдээлэл, хувь эзэмшлийн хэмжээ, хувь нийлүүлсэн хөрөнгийн хувь хэмжээ, Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл, гаргасан үнэт цаасны тоо, төрөл, нэрлэсэн үнэ болон өөрийн хөрөнгийн хэмжээ, нийтэд санал болгож байгаа өрийн бичгийн мэдээлэл, үнэт цаас гаргагчийн эзэмшиж байгаа тусгай зөвшөөрлийн мэдээлэл, төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үнэт цаас гаргах шийдвэр, хууль эрх зүйн орчин нийцэл нь Хуулийн фирмд Үнэт цаас гаргагчийн зүгээс гаргаж өгсөн баримттай нийцэж байх тул үнэн зөв тусгагдсан байна гэж үзлээ.

Эдгээр дурдсан хууль зүйн ач холбогдолтой мэдээллээс бусад Үнэт цаас гаргагчийн санхүүгийн мэдээлэл, шинжилгээ, санхүүгийн зохистой харьцааны шалгуур, эрсдэлийн удирдлага, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны тухай болон Үнэт цаас гаргагчийн зах зээлийн төлөвлөгөө, макро эдийн засгийн мэдээлэл, санхүүгийн төсөөлөл, салбарын үзүүлэлт, бизнес төлөвлөгөө, Үнэт цаас гаргагчийн талаар олон нийтэд ил, тодорхой үйл баримт, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тусгагдсан баталгаажуулах боломжгүй тоон үзүүлэлт болон хараат бус байгууллагуудын хийсэн дүн шинжилгээ, санхүүгийн тооцоолол, нийтэд санал болгож байгаа өрийн бичгийг арилжих нөхцөл, журам, Үнэт цаас гаргагчийн эзэлжих зэрэглэлийн үнэлгээ зэрэг мэдээлэлд Хуулийн фирмийн зүгээс дүн шинжилгээ хийгээгүй болохыг дурдаж байна.

Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагчийн үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр байна гэж Хуулийн фирм дүгнэж байна.

Ес. Үнэт цаас гаргагчийн толгой, охин, хараат, зэрэгцээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн Үнэт цаас гаргагчийн хяналтыг хэрэгжүүлэгч, эцсийн өмчлөгч этгээдийг тодорхойлох асуудлын хувьд авч үзвэл:





Нууц баримт
Эх хувь

Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 20-50 хувийг өөр (толгой) компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа тохиолдолд уг компанийг хараат компани гэнэ”, 6.3 дахь хэсэгт Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 50-аас дээш хувийг өөр (толгой) компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг бие даасан компанийг охин компани гэнэ”, 6.15 дахь хэсэгт “Нэг толгой компанийн хараат болон охин компаниуд, эсхүл нэг этгээд дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран хувьцааных нь хяналтын багцыг эзэмшдэг компаниудыг зэргэлдээ компани гэнэ” гэж тус тус хуульчилсан.

Компанийн тухай хуулийн зохицуулалтад үндэслэн Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн баримт материалаас үзвэл энэхүү Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Ашид капитал ББСБ ХХК нь аливаа хараат компанигүй бөгөөд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргасан тусгай зориулалтын компани болох Симпл Ассет ТЗК ХХК гэсэн 1 (нэг) охин компанитай байна. Үүнд:

Хүснэгт №13. Ашид капитал ББСБ ХХК-ийн охин компанийн мэдээлэл.

№	Охин компанийн нэр	Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны чиглэл	СЗХ-ны тусгай зөвшөөрөл олгосон шийдвэрийн огноо, дугаар	Хувь хэмжээ
1.	Симпл Ассет ТЗК ХХК	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах	2022.05.25 №273	100.00%

